

АЛСЫН ХАРАА
2050
МОНГОЛ УЛС

ЭЗХТ Бизнес
Ээлтэй
Монгол
Эдийн засгийн хөгжлийн төв-УТҮГ

ТЕХНОЛОГИЙН ШИЛЖИЛТ

НОГООН ШИЛЖИЛТ

ХҮНИЙ НӨӨЦИЙН ШИЛЖИЛТ

ХӨГЖЛИЙГ ХУРДАСГАХ СУДАЛГААНУУД

2026. №03

АЛСЫН ХАРАА
2050
МОНГОЛ УЛС

ЭЗХТ Бизнес
Ээлтэй
Монгол

ХЯНАЖ АЖИЛЛАСАН:

Галсангийн **АЛТАНСҮХ**
ЗАХИРАЛ
"ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТЭС"

Шилгарьдын **СОЛОНГО**
ЗАХИРАЛ
"ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ШИНЭЧЛЭЛИЙН ХӨТӨЛБӨР"

РЕДАКТОР:

Онгоогийн **МӨНХГЭРЭЛ**
ТӨСЛИЙН МЕНЕЖЕР
"МАРКЕТИНГИЙН ХӨТӨЛБӨР"

Эдийн засгийн хөгжлийн төв

Mongolia Economic
Development Board EDB

Хаяг: Улаанбаатар хот
Чингэлтэй дүүрэг
Нэгдсэн үндэстний гудамж –
Засгийн газрын 2 дугаар байр

Утас: 70116838
Facebook: EDB- Mongolia.mn

01  СӨРӨН ТЭСВЭРЛЭХ ЧАДВАРЫГ НЭМЭГДҮҮЛСЭН ХӨГЖЛИЙГ ХУРДАСГАХ ШИЛЖИЛТҮҮД хуудас 05-23	02  ХҮНИЙ КАПИТАЛЫН ШИЛЖИЛТ БА УР ЧАДВАРЫН ХӨГЖИЛ хуудас 25-39	03  НОГООН ХӨГЖЛИЙН ШИЛЖИЛТ хуудас 41-66	04  ЦАХИМ ШИЛЖИЛТ ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ БА ОЛОН УЛСЫН ИНДЕКСҮҮДЭД СУУРИЛСАН ХАРЬЦУУЛАЛТ хуудас 67-83	05  ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН СУДЛАХ СУДАЛГАА хуудас 85-121
06  ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ІРО-ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА хуудас 123-130	07  ЭРЧИМ ХҮЧНИЙ НҮҮРС, ГАЗ АШИГЛАДАГ ЭХ ҮҮСВЭРИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ хуудас 131-143	08  МОНГОЛ УЛСЫН ХАРИЛЦАА ХОЛБОО, ЦАХИМ ДЭД БҮТЦИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ хуудас 145-159	09  ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ТАТАХ ТҮЛХҮҮР ҮЗҮҮЛЭЛТҮҮД хуудас 161-170	10  “ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛ”- ИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА хуудас 171-177

Д.ЗОРИГТ

Эдийн засгийн
хөгжлийн төв УТҮГ
Гүйцэтгэх захирал



Эрхэм хүндэт уншигч Та бүхэнд энэ өдрийн мэндийг өргөн дэвшүүлэе.

Бодлого тодорхойлогчид, шийдвэр гаргагчид болон олон нийтэд нээлттэйгээр толилуулдаг “Хөгжлийг хурдасгах суурь судалгаа”-ны гутгаар хэвлэлийг Та бүхэнд хүргэж байгаадаа таатай байна.

Энэ удаагийн дугаарт Эдийн засгийн хөгжлийн төвийн судлаачид эдийн засгийн эрх чөлөөг дэмжих бодлогын орчин, ногоон хөгжлийн шилжилт, хиймэл оюун ухааны нөлөө, хүний нөөцийн бүтцийн өөрчлөлт, төрийн өмчит компаниудыг олон нийтэд нээлттэй болгох арга зам, эрчим хүчний салбарт аукционы механизмыг нэвтрүүлж хөрөнгө оруулалт татах олон улсын туршлага, мөн төрийн байгууллагуудын хөрөнгө оруулалт татах үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлэх аргачлал зэрэг цаг үеийн чухал сэдвүүдийг хамарсан судалгаануудыг хүргэж байна.

Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн гол хөдөлгүүр ойрын хугацаанд уул уурхай, түүхий эдийн боловсруулах үйлдвэрлэлийн салбар хэвээр байх нь тодорхой байна. Гэвч эдгээр салбар нь технологи, хөрөнгө оруулалтын агуулгаас өндөр хамааралтай бөгөөд өндөр цалинтай цөөн тооны ажлын байр шинээр бий болгодог онцлогтой. Харин ажиллах хүчний дийлэнх хэсэг нь бүтээмж багатай, дагаад тэр хэмжээгээр цалин орлого багатай салбарт ажилласан хэвээр байгааг статистикийн тоо харуулж байна. Энэ нь манай улсын хөдөлмөрийн бүтээмж олон улсын түвшнээс доогуур байгаа, мөн бүтээмж өндөр ахиу цалинтай салбарт ажиллагсдын эзлэх хувь хязгаарлагдмал хэвээр байгааг илтгэж байна.

Харин ажиллах хүчний дийлэнх хэсэг нь бүтээмж багатай, дагаад тэр хэмжээгээр цалин орлого багатай салбарт ажилласан хэвээр байна.

Иймээс орчин үеийн дэвшилтэт технологид суурилсан, байгаль орчинд ээлтэй ногоон хөрөнгө оруулалтыг татах, мэдлэг, ур чадвар шаардсан шинэ салбаруудыг хөгжүүлэх замаар эдийн засгийн бүтцийг өөрчлөх хэрэгцээ шаардлага урган гарч байна. Энэ шилжилт нь зөвхөн улсын өрсөлдөх чадварыг тодорхойлохоос гадна иргэдийн орлогын түвшин, өрхийн амьжиргаа, нийгмийн тэгш байдлыг хангах суурь нөхцөл болох юм.

Харин эсрэгээрээ, мэдлэг, ур чадвар бага шаардсан, технологийн агууламж сул, дэлхийн хөрөнгө оруулалтын ногоон чиг хандлагаас алсарсан салбарт ажиллах хүч төвлөрөх тусам тэр хэсгийн орлого өсөхгүй, нийгэм дэх орлогын ялгаа буурахгүй, харин ч нэмэгдэх эрсдэлтэй. Нийгмийн нэг хэсэг нь өндөр бүтээмж бүхий салбарт төвлөрч, нөгөө хэсэг нь бүтээмж багатай салбарт үлдвэл энэ нь эдийн засгийн төдийгүй нийгмийн эрсдэл дагуулах сөрөг үр дагавартай юм.

Тиймээс хиймэл оюун ухаан, автоматжуулалт, дрон, дэвшилтэт хагас дамжуулагч, AI, квант технологи, роботикийн нийлүүлэлтийн сүлжээ зэрэг шинэ үеийн салбарууд хурдацтай хөгжиж буй энэ цаг үед Монгол Улсын эдийн засгийг шинээр тодорхойлох, бүтээмжийг нэмэгдүүлэх хөгжлийн дараагийн үе шатыг бодлогоор тодорхойлох, төлөвлөх зайлшгүй шаардлагатай болж байна. Энэ хүрээнд бид эдийн засгийн “гурван шилжилт”-ийн асуудалд онцгой анхаарал хандуулан, энэ дугаарт төвлөрч авч үзлээ.

Мөн эдийн засгийн эрх чөлөөг бэхжүүлэх, төрийн байгууллагуудын хөрөнгө оруулалт татах үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлэх, эрчим хүчний салбарт аукционы тогтолцоог нэвтрүүлэх зэрэг судалгаанууд нь эдгээр шилжилтийг бодитоор хэрэгжүүлэхэд шаардлагатай зохицуулалтын орчныг бүрдүүлэхэд чиглэж буйгаараа онцлог юм. Мэдлэг, инновац, ногоон хөгжлийг тэргүүн эгнээнд тавьсан шинэ эдийн засгийн тогтолцоонд зоригтой шилжих үү гэдэг нь бодлого тодорхойлогч, бизнес эрхлэгч, судлаачдын өмнө тулгарч буй шинэ сорилт, хөгжлийн шинэ боломж гэж та бүхний ажилд бага ч гэсэн нэмэр болно гэж найдан эдгээр судалгааг толилуулж байна.



Л.ДАВААЖАРГАЛ

ШИНЭ СЭРГЭЛТ
ИННОВАЦИЙН ХӨТӨЛБӨР

Хөтөлбөрийн захирал

СӨРӨН ТЭСВЭРЛЭХ ЧАДВАРЫГ НЭМЭГДҮҮЛСЭН ХӨГЖЛИЙГ ХУРДАСГАХ ШИЛЖИЛТҮҮД



АГУУЛГА

НЭГ. УДИРТГАЛ	7
ХОЁР. ХҮНИЙ КАПИТАЛЫН ШИЛЖИЛТ	10
2.1. Хүний нөөц болон хүний капиталын тодорхойлолт	10
2.2. Хүний капиталын шилжилт	11
2.3. Хүний капиталын шилжилтийн найман тулгуур багана	11
2.4. Хүний капиталын шилжилтийг хэмжих шалгуур үзүүлэлтүүд	13
ГУРАВ. ХИЙМЭЛ ОЮУН УХААН БОЛОН ЦАХИМ ШИЛЖИЛТ	15
3.1. Хиймэл оюун ухаан болон цахим шилжилтийн тодорхойлолт	15
3.2. Хиймэл оюун ухаан болон цахим шилжилтийн есөн тулгуур багана	16
3.3. Хиймэл оюун ухаан болон цахим шилжилтийг хэмжих шалгуур үзүүлэлтүүд	18
ДӨРӨВ. НОГООН ШИЛЖИЛТ	19
4.1. Ногоон шилжилтийн тулгуур багана	19
4.2. Ногоон шилжилтийг хэмжих үзүүлэлтүүд	20
ТАВ. МАНАЙ УЛСАД ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ ШИНЭЧЛЭЛҮҮД	22
Ашигласан материал	22

ЗУРГИЙН ТАЙЛБАР

Зураг 1. 2025 онд Дэлхий дахинд үүсэж болзошгүй эрсдэлүүд	7
Зураг 2. 2026 онд Дэлхий дахинд үүсэж болзошгүй эрсдэлүүд	7
Зураг 3. ДЭЗФ-аас гаргасан богино болон урт хугацааны эрсдэлүүд	8
Зураг 4. 2025 онд Монгол Улсад үүсэж болзошгүй эрсдэлүүд	9
Зураг 5. 2026 онд Монгол Улсад үүсэж болзошгүй эрсдэлүүд	9
Зураг 6. Хүний капиталын шилжилтийн найман тулгуур багана	12
Зураг 7. Хиймэл оюун ухаан болон цахим шилжилтийн есөн тулгуур багана	17
Зураг 8. Ногоон шилжилтийн найман тулгуур багана	19

ХҮСНЭГТИЙН ТАЙЛБАР

Хүснэгт 1. Хүний капиталын шилжилтийг хэмжих шалгуур үзүүлэлтүүд	14
Хүснэгт 2. Хиймэл оюун ухаан ба цахим шилжилтийг хэмжих шалгуур үзүүлэлтүүд	18
Хүснэгт 3. Ногоон шилжилтийг хэмжих шалгуур үзүүлэлтүүд	21

СӨРӨН ТЭСВЭРЛЭХ ЧАДВАРЫГ НЭМЭГДҮҮЛСЭН ХӨГЖЛИЙГ ХУРДАСГАХ ШИЛЖИЛТҮҮД

Нэг. Удиртгал

Дэлхийн эдийн засгийн форум (ДЭЗФ) нь Marsh McLennan болон Zurich Insurance Group-тэй хамтран дэлхийн хэмжээний эрсдэлийн төлөв байдлыг тодорхойлон, үнэлэх зорилготой “Дэлхийн эрсдэлийн тайлан”-г жил бүрийн 1 дүгээр сард тухайн онын эрсдэлийг урьдчилан тодорхойлон гаргадаг байна. 2026 оны тайланд 1,300 гаруй олон улсын шинжээч, судлаачид, бизнес, улс төрийн төлөөлөөс богино, дунд, урт хугацаанд тулгарч болзошгүй гол эрсдэлүүдийг тодорхойлж, тэдгээрийн харилцан хамаарал, нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлжээ (World Economic Forum, 2026).

21 дахь удаагийн буюу 2026 оны Дэлхийн эрсдэлийн тайлангийн онцлох үр дүнгээс:

- “Гео-эдийн засгийн сөргөлдөөн” нь 2025 оны тайлантай харьцуулахад 8 байраар урагшилж, 2026 оны богино хугацааны хамгийн өндөр эрсдэл хэмээн үнэлэгдлээ. Тариф, хориг арга хэмжээ, хөрөнгө оруулалтын хяналт, хангамжийн сүлжээний хуваагдал эрчимжиж, олон улсын хамтын ажиллагаа болон дэлхийн эдийн засгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байгааг илтгэж байна. Судалгаанд оролцогчид өнөө үеийн геополитикийн хурцадмал байдал, худалдааны бодлого нь зах зээл, эдийн засгийн өсөлтөд ноцтой эрсдэл учруулж байгааг онцолсон байна.
- “Тэгш бус байдал” болон “албадан нүүлгэн шилжүүлэлт” нь ойрын хоёр жилийн хугацаанд эрсдэл хэвээр байна. Харин хиймэл оюун ухааны сөрөг үр дагавар нь богино хугацаанд харьцангуй доогуур үнэлэгдсэн байгаа бөгөөд 2025 онд 31/33-д эрэмбэлэгдэж байсан бол 2026 онд 30/33 болж, зөвхөн нэг байраар урагшилжээ.
- “Эдийн засгийн удаашрал”, “засгийн газрын өрийн өсөлт”, “үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн хөөсрөлт”, “инфляцийн сөрөг нөлөө” зэрэг эдийн засгийн хямралын дохио болсон эрсдэлүүд олон байраар урагшилсан байсан бөгөөд жагсаалтын эхэнд хүч түрэн орж ирсэн байна.
- Ирээдүйн 10 жилийн хугацаанд гарах магадлалтай эрсдэлийн жагсаалтад багтсан эхний есөн эрсдэл

нь өмнөх жилийнхтэй харьцуулахад өөрчлөгдөөгүй байгаа нь урт хугацааны эрсдэлүүд өөрчлөгдөхгүй болохыг харуулж байна.

2026 оны гол эрсдэлүүд:

- 2026 оныг нэг үгээр “Тодорхойгүй байдал” хэмээн тодорхойлов. Судалгаанд оролцогчдын үнэлгээгээр 2026 онд дэлхий дахинд хамгийн тулгамдаж болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлоход, “Гео-эдийн засгийн сөргөлдөөн” 18 хувь, “Улс хоорондын зэвсэгт мөргөлдөөн” 14 хувь, “Цаг уурын эрс тэс үзэгдлүүд” 8 хувь, “Санаатайгаар тараасан алдаатай, ташаа мэдээлэл” 7 хувь, “Нийгмийн туйлшрал” 7 хувь, “Эдийн засгийн удаашрал” 5 хувь тус тус эзэлж байна (Зураг 1 болон 2).

Зураг 1. 2025 онд Дэлхий дахинд үүсэж болзошгүй эрсдэлүүд



Эх сурвалж: Дэлхийн эрсдэлийн 2025 оны тайлангаас

Зураг 2. 2026 онд Дэлхий дахинд үүсэж болзошгүй эрсдэлүүд



Эх сурвалж: Дэлхийн эрсдэлийн 2026 оны тайлангаас

Богино хугацааны гол эрсдэлүүд (2026–2028):

- **"Хуурамч мэдээлэл ба төөрөгдүүлэлт":** Хиймэл оюун ухааны хурдацтай хөгжилтэй уялдан хуурамч мэдээлэл, төөрөгдүүлсэн агуулга түгээх эрсдэл огцом нэмэгдэж байна. Ялангуяа сонгуулийн мөчлөг идэвхэжсэн нөхцөлд (2024 онд 77 улс оронд сонгууль явагдсан) энэ нь олон нийтийн итгэл, ардчилсан тогтолцоонд бодитой заналхийлэл учруулж буйг судалгаанд онцолсон байна.
- **"Улс хоорондын зэвсэгт мөргөлдөөн":** Геополитикийн хурцадмал байдал даамжирч, бүс нутгийн болон олон улсын зэвсэгт мөргөлдөөн нэмэгдэх хандлага ажиглагдаж байгаа нь дэлхийн эдийн засгийн тогтвортой байдал, зах зээл, хангамжийн сүлжээнд сөргөөр нөлөөлөх өндөр эрсдэл дагуулж байна.
- **"Эдийн засгийн уналт":** Засгийн газрын өрийн түвшин өсөх, инфляц үргэлжлэх, хангамжийн сүлжээний тасалдал давтагдах зэрэг хүчин зүйлс нь эдийн засгийн тогтвортой байдалд ноцтой дарамт үүсгэж, богино хугацаанд уналт, удаашралын эрсдэлийг нэмэгдүүлж байна.

2025 оны тайлантай харьцуулахад "Гео-эдийн засгийн сөргөлдөөн" 8 байраар огцом урагшилж, богино хугацааны эрсдэлүүдийн жагсаалтыг тэргүүлсэн нь дэлхийн эдийн засгийн харилцаанд үүсэж буй хуваагдал, итгэлийн хямрал гүнзгийрч буйг илтгэнэ. Мөн түүнчлэн, 2025 онд харьцангуй бага жинтэй байсан эдийн засгийн эрсдэлүүд богино хугацааны эрсдэлийн бүлэгт нэмэгдэн орж, "Эдийн засгийн удаашрал", "Инфляци" тус бүр 8 байраар, "Үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн хөөсрөлт" 7 байраар урагшилсан нь макро эдийн засгийн эмзэг байдал улам гүнзгийрч буйг харуулж байна.

Байгаль орчны эрсдэлүүд нь ирэх 10 жилийн хугацаанд хамгийн ноцтой эрсдэлүүдийн бүлэгт хэвээр байгаа боловч ойрын ирээдүйд харьцангуй доогуур эрэмбэлэгдэж, цаг агаарын эрс тэс уур амьсгал, бохирдол, биологийн олон янз байдлын алдагдал зэрэг нь богино хугацааны жагсаалтад эрэмбэ бага зэрэг буурсан. Гэсэн хэдий ч эдгээр аюул буурсан гэсэн үг бус бөгөөд харин геополитикийн болон эдийн засгийн хурц хямралууд бодлогын анхаарал, хөрөнгийн нөөцийг байгаль орчны арга хэмжээнээс түр хугацаанд холдуулж байгааг шинжээчид онцолж байна. Түүнчлэн технологийн эрсдэлүүд, ялангуяа хиймэл оюун ухааны сөрөг үр дагавар урт хугацаанд огцом нэмэгдэж буй нь, зохистой зохицуулалт, хяналтгүй нөхцөлд хиймэл оюун ухаан нийгэм, эдийн засаг, аюулгүй байдалд ноцтой сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл нэмэгдэж байгааг харуулж байна (Зураг 3).

Зураг 3. ДЭЗФ-аас тодорхойлсон богино болон урт хугацааны эрсдэлүүд



Эх сурвалж: Дэлхийн эрсдэлийн 2026 оны тайлангаас

Урт хугацааны эрсдэлүүд (2036 он хүртэл):

- **"Уур амьсгалын өөрчлөлт ба байгаль орчны доройтол":** Цаг агаарын эрс тэс үзэгдэл, экосистемийн сүйрэл, дэлхийн байгалийн системийн доройтол өөрчлөлт зэрэг дэлхийн уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэлүүд ирэх арван жилд хамгийн

ноцтой, өндөр нөлөөтэй эрсдэлүүд хэвээр байна. Хэт халалт, ган, үер, ой хээрийн түймэр зэрэг нь хүнс, усны аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж, эдийн засгийн алдагдал, албадан нүүлгэн шилжүүлэлтийг өдөөх эрсдэлтэйг тайланд онцолсон байна.

- **"Хиймэл оюун ухааны сөрөг үр дагавар":** Хиймэл оюун ухааны зохицуулалтгүй, хурдацтай хөгжил нь урт хугацаанд эдийн засаг, хөдөлмөрийн зах зээл, үндэсний аюулгүй байдал, нийгмийн итгэлцэлд томоохон сорилт учруулж болзошгүйг онцгойлон тэмдэглэсэн. Хэрэв бодлогын зохистой зохицуулалт, олон улсын хамтын ажиллагаа сул байвал технологийн төвлөрөл, орлогын тэгш бус байдал, мэдээллийн аюулгүй байдал, автоматжуулалтаас үүдэлтэй нийгмийн тогтворгүй байдал гүнзгийрэх эрсдэлтэй гэж үзэж байна.
- **"Хүн ам зүйн хуваагдал":** Хүн амын өсөлтийн ялгаа, насжилтын хурдацтай өөрчлөлт, залуу болон өндөр настай хүн амын тэнцвэр алдагдах нь нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн зах зээл, төсвийн тогтвортой байдалд урт хугацааны дарамт үүсгэж байна. Дэлхийн зарим бүсэд хүн ам огцом өсөх бол бусад бүсэд хурдтай хөгшрөлт явагдаж буй нь эдийн засгийн өрсөлдөх чадвар, нийгмийн эв нэгдэлд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэйг тайланд онцолсон байна (Зураг 3).


Уур амьсгалын өөрчлөлт болон хүрээлэн буй орчны доройтол нь арван жилийн хугацаанд эрсдэлийн жагсаалтыг тогтмол тэргүүлж байгаа бөгөөд эдгээр нь тус тусдаа бус, харин хоорондоо уялдсан системийн эрсдэлүүд юм. Хэрэв дэлхийн хэмжээнд бууруулах, дасан зохицох бодлого сулрах аваас хүнс, ус, эрчим хүч, эдийн засаг, шилжилт хөдөлгөөний хямралууд зэрэг давхар, дам нөлөө бүхий эрсдэлүүд үүсэх магадлал өндөр байна. Байгаль орчин, технологийн эрсдэлүүдээс гадна нийгмийн туйлшрал, тэгш бус байдал зэрэг нь 2025, 2026 оны тайлангуудад урт хугацаандаа эрсдэлийг хурдасгах суурь хүчин зүйлс болж байна гэж онцолжээ. Тогтмол гүнзгийрч буй тэгш бус байдал нь нийгмийн хуваагдлыг нэмэгдүүлж, төрийн болон олон улсын байгууллагад итгэх итгэлийг сулруулан, улс төрийн тогтворгүй байдлыг өдөөх эрсдэлтэй. Энэ нь цаашлаад зэвсэгт мөргөлдөөн, эдийн засгийн уналт, уур амьсгалын хамтын арга хэмжээнд эсэргүүцэл үүсэх зэрэг бусад эрсдэлүүдийг улам бүр даамжруулах нөхцөл бүрдүүлж болзошгүй байна.

Дүгнэж хэлбэл, 2036 он хүртэлх урт хугацааны эрсдэлүүд нь дан ганц байгалийн эсвэл технологийн асуудал бус, харин нийгэм, эдийн засаг, байгаль орчны уялдаа холбоо бүхий системийн шинжтэй болж байгааг энэхүү тайлан тодорхой харуулж байна. Иймд урт хугацааны тогтвортой байдлыг хангахад салангид арга хэмжээнээс

илүүтэй нэгдсэн бодлого, олон улсын хамтын ажиллагаа, урьдчилан сэргийлэх арга хэмжээ зайлшгүй шаардлагатайг тайлан онцлон сануулж байна.

Монгол Улсад үүсэж болзошгүй эрсдэлүүд:

Зураг 4. 2025 онд Монгол Улсад үүсэж болзошгүй эрсдэлүүд



Эх сурвалж: Дэлхийн эрсдэлийн 2025 оны тайлангаас

Зураг 5. 2026 онд Монгол Улсад үүсэж болзошгүй эрсдэлүүд



Эх сурвалж: Дэлхийн эрсдэлийн 2026 оны тайлангаас

2025 оны тайланд Монгол Улсад хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэргүй байдал болох ажиллах хүчний нийлүүлэлт, чадварын зөрүү зэргээс үүдэлтэй ажиллах хүчний хомсдол хамгийн том эрсдэл байсан бөгөөд эрчим хүчний хангамжийн дутагдал, агаар, ус хөрсний бохирдол зэрэг эрсдэлүүд удаалсан байна (Зураг 4).

Дэлхийн Эрсдэлийн Тайлан 2026-д богино болон дунд хугацаанд (2026–2028) гео-эдийн засгийн сөргөлдөөн, улс хоорондын зэвсэгт мөргөлдөөн, эдийн засгийн удаашрал, уналт зэрэг хүндрэлүүд дэлхийн хэмжээнд анхаарал татаж байгаа нь Монгол Улсын эдийн засаг шууд болон шууд бус нөлөө үзүүлэх магадлалтайг харуулж байна. Тухайлбал, гадаад худалдаа, түүхий эдийн экспорт, эрчим хүчний импортын хамаарал өндөр манай улсын хувьд олон улсын зах зээлийн үнийн савлагаа, нийлүүлэлтийн сүлжээний доголдол нь инфляцийн өсөлт, эдийн засгийн удаашрал, ажилгүйдэл нэмэгдэх эрсдэлийг дагуулж болзошгүй байна. Үүнтэй зэрэгцэн агаар, ус, хөрсний бохирдол, төрийн үйлчилгээний хүртээмж, нийгмийн хамгааллын тогтолцооны хүрэлцээ зэрэг дотоод асуудлууд 2026 онд Монгол Улсын тулгарч болзошгүй гол эрсдэлүүдээр нэрлэгдэж байна (Зураг 5).

Эдгээр олон талт, харилцан уялдсан эрсдэлүүдэд урьдчилан сэргийлэх, системийн хандлагатай, нэгдсэн бодлогоор хариу үзүүлэх шаардлагатай. Үүнд Засгийн газар, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх, бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцад итгэлцэл, уялдааг бэхжүүлэхийг уриалсан байна.

Дэлхийн эдийн засгийн форумын зөвлөмжөөр, хөгжиж буй улс орнууд

- 1) Дижитал шилжилт ба хиймэл оюун ухааны бодлогын уялдааг сайжруулах,
 - 2) Ногоон хөгжлийн стратеги, уур амьсгалын дасан зохицлын хөтөлбөрүүдийг бодитоор хэрэгжүүлэх;
 - 3) Хүний капиталын хөгжлийн шинэ загварыг боловсруулж, боловсрол, хөдөлмөр, инновацийн бодлогыг уялдуулах;
 - 4) Эрсдэлийн үндэсний үнэлгээний систем бий болгож, олон улсын индексүүдтэй нийцүүлэх зэрэгт бодлогын түвшний шинэчлэл хийх шаардлагатай гэж үзэж байна.
- Дэлхий дахины хандлагаас харахад байгаль орчин, технологи, нийгмийн шинж чанартай эрсдэлүүд ирэх арван жилд давамгайлж, дэлхийн тогтвортой хөгжилд урт хугацааны сорилт үүсэх төлөвтэй байна. Өндөр хөгжилтэй орнууд 2000-аад оноос хүний нөөцийн шинэчлэл, технологийн дэвшил, ногоон шилжилтийг шат дараатайгаар хэрэгжүүлж, инноваци ба засаглалын уялдаатай бодлогоор эрсдэлийг даван туулах тэсвэртэй тогтолцоо бүрдүүлжээ.

Манай улсын хувьд эдгээр чиглэлүүдийг уялдуулан хэрэгжүүлснээр нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцсэн, өрсөлдөх чадвартай, дижитал ба ногоон эдийн засагт бүрэн шилжсэн улс болох суурийг тавих боломжтой юм.

2. Хүний капиталын шилжилт

Эдийн засаг, технологи, нийгмийн хурдацтай өөрчлөлтийн энэ эрин үед байгууллагуудын бүтэц, удирдлагын арга барил, ажиллах хүчний мөн чанар үндсээрээ өөрчлөгдөж байна. Хүний капиталын шилжилтэд хүний нөөц ба хүний капитал гэсэн хоёр үндсэн ойлголт байдаг. “Хүний нөөц” нь ажиллах хүчийг илэрхийлсэн захиргааны болон удирдлагын чиг үүргийг тодорхойлоход ашиглаж ирсэн боловч “хүний капитал” нь хүний мэдлэг, ур чадвар, туршлага, чадавхыг эдийн засгийн үнэ цэн бүхий хөрөнгө гэж үздэг илүү өргөн хүрээтэй онолын ойлголт юм.

2.1. Хүний нөөц болон хүний капиталын тодорхойлолт

Хүний нөөц гэдэг нь байгууллага, салбар эсвэл эдийн засгийг бүрдүүлж буй ажиллах хүч болон түүнийг удирдах захиргааны тогтолцоог илэрхийлдэг. Судлаач Жаханы (Jahan, 2018) тодорхойлсноор “хүний нөөц гэдэг нь байгууллага, бизнесийн салбар эсвэл эдийн засгийн ажиллах хүчийг бүрдүүлдэг хүмүүс” юм.

Үйл ажиллагааны түвшинд авч үзвэл, байгууллага дахь хүний нөөцийн (HR) үүрэг нь ажилд авах, сургалт явуулах, гүйцэтгэлийн менежмент, цалин хөлс, тэтгэмжийн бодлого, ажилчдыг тогтвор суурьшил, байгууллагын дотоод журам, хөдөлмөрийн харилцааг хамардаг (Kasir Pintar, 2024). Түүхийн талаас авч үзвэл, хөдөлмөрийг үйлдвэрлэлийн гол хүчин зүйл гэж үзэх хандлага бий болсноор хүний нөөцийн ойлголт анх гарч иржээ. Цаг хугацааны явцад энэ ойлголт тусдаа менежментийн чиглэл болон төлөвшиж, “боловсон хүчний менежмент” гэх нэршилтэй болжээ (The Economic Times, n.d.).

Бодлого боловсруулагчид болон байгууллагын удирдлагууд хүний нөөцийг гол төлөв ажиллах хүчний тоо, бүтэц, хөдөлмөрийн гэрээ, хууль эрх зүйн зохицуулалт, гүйцэтгэлийн хяналт зэрэг захиргааны хүрээнд авч үзэх нь түгээмэл байдаг.

Харин хүний капитал нь хүмүүсийн мэдлэг, ур чадвар, боловсрол, туршлага, эрүүл мэнд, бүтээлч сэтгэлгээ зэрэг биет бус нөөцийн нийлбэр бөгөөд эдгээр нь эдийн засгийн өсөлт, бүтээмж, инновацид шууд нөлөөлдөг. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD, 2025) хүний капиталын тодорхойлолтыг “хүмүүсийн бүтээмжийг дээшлүүлэхэд тусалдаг мэдлэг, ур чадвар, хувийн чанаруудын нөөц” гэж тодорхойлсон бол Судлаач Шарма (Sharma, 2024) үүнийг “байгууллагын ажилчдын нийт бүтээмж, амжилтад хувь нэмэр оруулж байгаа мэдлэг, ур чадвар, туршлага, чадварын цогц” гэж үзжээ.

Merriam-Webster толь бичигт “хүний капитал” гэсэн нэр томъёог 18-р зууны үед тухайн улсын хүн амыг үндэсний

баялаг гэж үзэхэд хэрэглэгдэж байсныг, хожим хувь хүн болон байгууллагын хөрөнгө оруулалтын хэмжүүр болгон хэрэглэж эхэлснийг онцолжээ (Merriam-Webster, n.d.).

Хүний капиталын үзэл баримтлалын гол чанарууд:

Хүмий капиталын үзэл баримтлал нь дараах үндсэн шинж чанараар тодорхойлогддог (Invest India, 2022), (OECD, 2025), (Majaski, 2024).

1. Хөрөнгө оруулалт: Боловсрол, мэргэжлийн сургалт, эрүүл мэндийн үйлчилгээ, ур чадварын хөгжил зэрэг нь хүний капиталд хийгдэж буй урт хугацааны хөрөнгө оруулалт юм.

2. Өгөөж: Эдгээр хөрөнгө оруулалт нь бүтээмжийн өсөлт, инновацийн эрчимжилт, өндөр орлого, эдийн засгийн тогтвортой өсөлт хэлбэрээр буцаан өгөөж өгдөг.

3. Биет бус чанар ба хуримтлал: Хүний капиталын биет хөрөнгөөс (машин, барилга байгууламж зэрэг) ялгаатай тал нь хүний биед болон оюун ухаанд хуримтлагддаг. Энэ нь цаг хугацааны явцад туршлага, мэдлэгээр өсөхийн хэрээр үнэ цэнэ нэмэгдэж, технологийн хөгжил, ур чадварын хуучралтаас шалтгаалан үнэ цэнээ бууруулах магадлалтай.

Дүгнэж хэлбэл, хүний нөөц нь ажиллах хүчийг удирдах байгууллагын функц, бүтэц, зохион байгуулалтыг илэрхийлдэг бол хүмүүн капитал нь тухайн ажиллах хүчний дотоод үнэ цэнэ, бүтээмж, мэдлэгийн нөөцийг илэрхийлдэг эдийн засгийн хөрөнгө юм. Тиймээс өнөөгийн мэдлэгт суурилсан эдийн засагт хөгжлийн бодлого, байгууллагын стратеги нь хүний нөөцийг зөвхөн “захиргааны нэгж” бус, үндэсний баялгийн гол эх үүсвэр болох хүмүүн капитал-аар харах шинэ парадигм руу шилжих шаардлагатай байна.

2.2. Хүний капиталын шилжилт

Орчин үеийн эдийн засаг, технологи, нийгмийн хурдацтай өөрчлөлтийн нөхцөлд хүний капиталын ач холбогдол улам бүр өсөн нэмэгдэж байна. “Хүний капиталын шилжилт” хэмээх нэр томъёо нь улс орны эдийн засаг, аж үйлдвэрийн салбарууд эсвэл байгууллагуудын түвшинд хүний капиталын доод түвшнээс (хязгаарлагдмал боловсрол, ур чадвартай, гар ажиллагаанд тулгуурласан ажиллах хүч) илүү өндөр түвшин рүү (өргөн цар хүрээтэй боловсрол, дэвшилтэт ур чадвар, инновацийн чадавх бүхий мэдлэгт суурилсан ажиллах хүч) шилжих бүтцийн өөрчлөлтийг илэрхийлдэг. Энэхүү шилжилт нь нийлүүлэлт (боловсрол, сургалт), эрэлт (өндөр ур чадвар шаардсан ажлын байр) болон институцийн хүрээ (бодлого, хууль тогтоомж, засаглал)-ний бүх өөрчлөлтөөр тодорхойлогдоно.

Лондонгийн Эдийн засгийн сургуулийн (LSE) Грант-хамын судалгааны хүрээлэнгийн судалгаанд хүний капиталын шилжилтийн ойлголт, үе шат, түүнд нөлөөлөх бодлогын хүчин зүйлсийг нарийвчлан судалжээ (Hirre & Fouquet, 2015). Судалгаанд дурдсанаар, хүний капиталын шилжилтийн эхний үе шатанд шилжилт нь технологийн шинэчлэл болон мэдлэгт суурилсан эдийн засгийн өсөн нэмэгдэж буй эрэлтээс үүдэлтэй нийлүүлэлт-эрэлтийн харилцан үйлчлэлээр эхэлдэг. Хоёр дахь үе шатанд, төрөөс боловсрол, сургалт, хүний хөгжилд томоохон хөрөнгө оруулалт хийж, олон нийтийн боловсролын тогтолцоог хөгжүүлснээр шилжилтийн хурдасгуур болдог. Судлаачдын үзэж буйгаар, сүүлийн хоёр зуун жилд өрнөсөн энэхүү хүний капиталын шилжилт нь орчин үеийн нийгэм, эдийн засгийн хамгийн гүнзгий өөрчлөлтүүдийн нэг болсон юм.

Хүний капиталын шилжилтийн үндсэн хөдөлгөгч хүч

- **Технологийн өөрчлөлт:** Шинэ техник, технологийн нэвтрэлт нь өндөр ур чадвартай ажиллах хүчний эрэлтийг нэмэгдүүлж, хөдөлмөрийг мэдлэг, мэдээлэлд тулгуурласан хэлбэрт шилжүүлдэг (Hirre & Fouquet, 2015).
- **Боловсрол ба сургалтын хөтөлбөрүүд:** Албан ёсны боловсрол, насанд хүрэгчдийн сургалт, мэргэжлийн боловсрол нь хүний капиталын нөөцийг нэмэгдүүлдэг. OECD-ийн судалгаагаар “хүний капиталын чанарт боловсролын чанарын нөлөө нь зөвхөн боловсролын хугацаанаас 3–4 дахин илүү” гэж дурдсан байдаг (OECD, 2025).
- **Бодлого ба институцийн орчин:** Засгийн газруудын боловсролын хөтөлбөрийн шинэчлэл, багшийн хөгжил, санхүүжилт, хууль эрх зүйн урамшууллын бодлого нь хүний капиталын шилжилтэд шийдвэрлэх үүрэгтэй.
- **Хөдөлмөрийн зах зээлийн бүтцийн өөрчлөлт:** Үйлдвэрлэлээс үйлчилгээ, мэдлэгийн эдийн засагт шилжих үйл явц нь биет бус хөрөнгийн (ур чадвар, бүтээлч байдал, дасан зохицох чадвар) үнэ цэнийг нэмэгдүүлдэг.

2.3. Хүний капиталын шилжилтийн найман тулгуур багана

Олон улсын байгууллагуудын туршлага, судалгаанаас харахад аливаа салбарын реформ, бүтцийн шилжилтийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд ганцхан бодлого эсвэл тусгаарласан арга хэмжээ хангалтгүй байдаг. Харин харилцан уялдаатай, үе шаттай, системийн түвшний цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй болохыг тэд онцолдог. Ийм уялдаа холбоотой бодлогын багц нь салбар хоорондын уялдааг бий болгож, шинэчлэлийн эрсдэлийг бууруулж, тогтвортой үр нөлөөг баталгаажуулах давуу талтай.

Энэхүү судалгаанд олон улсын тэргүүлэх байгууллагуудын (НҮБ, Дэлхийн банк, ILO зэрэг) хүний капиталын хөгжлийн талаарх зөвлөмж, бодлогын баримт бичгүүдийг нэгтгэн шинжилж, хүний нөөцийн шилжилтийн цогц тогтолцоог бүрдүүлэх үндсэн тулгуур багануудыг тодорхойлов (Зураг 4). Мөн эдгээр багана бүрийн хүрээнд хэрэгжүүлэх шаардлагатай бодлогын бүрэлдэхүүн арга хэмжээг нарийвчлан жагсаан боловсруулав. Энэ нь хүний нөөцөөс хүний капитал руу шилжих стратегийн өөрчлөлтийг илүү бодитой, хэрэгжихүйц, олон улсын чиг хандлагатай нийцсэн байдлаар төлөвлөхөд чухал үндэс болох юм.

1. Боловсролын системийн шинэчлэл

Боловсролын системийн шинэчлэлийн үндсэн зорилго нь дасан зохицох чадвар болон насан туршийн сургалтыг чухалчилсан, ирээдүйд бэлтгэх боловсролын тогтолцоог бий болгоход оршино (UNESCO, 2024), (OECD, 2018). Үүнд:

- Шүүмжлэх сэтгэлгээ, бүтээлч байдал, хамтын ажиллагаа зэрэг 21-р зуунд эрэлттэй ур чадваруудыг эзэмшүүлэх сургалтын хөтөлбөрийн шинэчлэл хийх
- Цахим ур чадвар, хиймэл оюун ухаан, тогтвортой байдлыг боловсролын бүх түвшинд нэвтрүүлэх
- Бага насны хүүхдийг хөгжүүлэх, чанартай боловсролыг тэгш хүртээмжтэй байлгах
- Багш нарт дижитал болон хувь хүнд тохирсон сургалтын аргуудын сургах зэрэг багтана.

2 Ажиллах хүчний чадварыг нэмэгдүүлэх, сайжруулах

Ажиллах хүчний чадварыг нэмэгдүүлж сайжруулснаар одоо бэлтгэгдсэн ажиллах хүчийг аливаа технологийн тэсрэлт, шинэ ажлын урсгалаас урьдчилан хамгаалах үндсэн зорилготой (WEF, 2018-2025), (ILO, 2019). Энэхүү зорилгод хүрэхийн тулд дараах үйл ажиллагааг шат дараатай хэрэгжүүлэх нэн шаардлагатай. Үүнд:

- Ур чадвар нэмэгдүүлэх үндэсний хөтөлбөрүүд, төрийн болон хувийн хэвшлийн сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх
- Дижитал ур чадварыг хөгжүүлэх (хиймэл оюун ухаан, өгөгдөл, кодчилал, автоматжуулалтын хэрэгслүүд)
- Ногоон ажлын байр ба тогтвортой аж үйлдвэрийн салбарт ашиглах ур чадваруудыг хөгжүүлэх
- Ажлын байран дээрх сургалт, дагалдан суралцах хөтөлбөр, сургалт, мэргэжлийн итгэмжлэлүүд багтана.

3. Насан туршийн боловсрол, үргэлжилсэн мэдлэг олгох процесс

Насан туршийн боловсрол, үргэлжилсэн мэдлэг олгох процессыг дэмжихийн тулд бүх насныханд зориулсан насан туршийн боловсролыг дэмжих дэд бүтэц, соёлыг түгээх нэн шаардлагатай (OECD, 2025), (World bank group, n.d.). Энэхүү зорилгод хүрэхийн тулд

дараах үйл ажиллагааг шат дараатай хэрэгжүүлэх нэн шаардлагатай. Үүнд:

- Хүртээмжтэй цахим болон хагас цахим сургалтын платформууд
- Ур чадварын гэрчилгээ болон өмнөх сургалтын үр дүнг хүлээн зөвшөөрөх (RPL)
- Компани болон хувь хүмүүсийг тасралтгүй боловсролд хөрөнгө оруулахад урамшууллын аргаар дэмжих
- Судалгааны байгууллагууд, Засгийн газар, ажил олгогчдыг холбосон сургалтын экосистем

4. Хөдөлмөрийн зах зээл, нийгмийн хамгааллын салбарын шинэчлэл

Байгууллагууд болон төрийн бодлогыг ажил эрхлэлтийн шинэ трендтэй уялдуулах нэн шаардлагатай (WEF, 2018-2025). Энэхүү зорилгод хүрэхийн тулд дараах үйл ажиллагааг шат дараатай хэрэгжүүлэх нэн шаардлагатай. Үүнд:

- Гиг, чөлөөт ажилтнууд, платформ ажилчдыг дэмжих уян хатан хөдөлмөрийн тухай хууль,
- Уламжлалт бус хөдөлмөр эрхлэлтийн хэлбэрүүдийг дэмжих нийгмийн хамгааллын бодлогууд,
- Зохистой хөдөлмөр, шударга цалин хөлс, хүйсийн тэгш байдлын бодлого
- Автоматжуулалт эсвэл нүүрстөрөгчийн ялгарлыг буурахтай үүдэлтэй салбарын ажилчдад зориулсан шилжилтийн дэмжлэг

Зураг 6. Хүний капиталын шилжилтийн найман тулгуур багана



5. Үндэсний хүний нөөцийн хөгжлийн стратеги боловсруулах

Үндэсний хүний нөөцийн хөгжлийн стратеги боловсруулснаар хүний нөөцийг үндэсний хөрөнгө хэмээн хүлээн зөвшөөрөх болно. Энэхүү зорилгод хүрэхийн тулд дараах үйл ажиллагааг шат дараатай хэрэгжүүлэх нэн шаардлагатай. Үүнд:

- Хүний капиталын хөгжлийн үндэсний стратегиуд
- Ур чадварын урьдчилсан тооцоо, төлөвлөлтийн төр-хувийн хэвшил-академик түншлэл
- Боловсролын технологи (EdTech) болон сургалтын дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийх
- Хүний капиталын үзүүлэлтүүд болон үр дүнг хянах

6. Инноваци, стартап, энтрепренершип

Орчин үед стартап экосистемийн үндсэн зорилго нь дэлхийн өртгийн сүлжээнд өрсөлдөх чадвар бүхий технологид суурилсан стартапыг гаргах, хөгжүүлэх билээ. Ингэхийн тулд дараах арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлэх нэн шаардлагатай. Үүнд:

- Стартапууд, залуучуудын инновацийн хөтөлбөрүүд болон судалгаа, хөгжлийн карьеруудыг дэмжих
- Дэлхийн авьяас чадварыг татах, Монголоос явсан оюунлагуудыг буцаан урих
- STEM, судалгаа, бүтээлч салбаруудыг дэмжих
- Салбар дундын инновацийн баг, инкубаторуудыг дэмжих

7. Тэгш байдал, хүртээмжтэй байдал, хүйсийн чадавхыг нэмэгдүүлэх

Эдийн засаг, технологийн шилжилтээс бүх бүлгүүд тэгш ашиг хүртэхэд үндсэн зорилго оршино (OECD, 2025). Энэхүү зорилгод хүрэхийн тулд дараах үйл ажиллагааг шат дараатай хэрэгжүүлэх нэн шаардлагатай. Үүнд:

- Боловсрол, дижитал болон манлайллын үүрэг дэх хүйсийн ялгааг арилгах
- Хөдөө орон нутгийн, уугуул болон хязгаар нутаг дэвсгэрийн хүн амыг хамруулах
- Хүртээмжтэй, боломжийн үнэтэй насан туршийн сургалт
- Автоматжуулалтыг нийгмийн тэгш байдалтай тэнцвэржүүлэх бодлого

8. Манлайлал ба институцийн чадавхийг бэхжүүлэх

Өөрчлөлтийг удирдан чиглүүлэх, тогтвортой байлгахын тулд бүх түвшинд манлайллыг бэхжүүлэхэд үндсэн зорилго оршино. Энэхүү зорилгод хүрэхийн тулд дараах үйл ажиллагааг шат дараатай хэрэгжүүлэх нэн шаардлагатай. Үүнд:

- Төрийн байгууллагуудын манлайлал, удирдлагын чадавхийг бэхжүүлэх
- Төрийн салбарын хүний нөөцийн системийг шинэчлэх
- Ирээдүйд чиглэсэн манлайлал, засаглалын ур чадварыг дэмжих
- Алсын хараа, инноваци, зохицуулалтын механизмыг институтчлэх

2.4. Хүний капиталын шилжилтийг хэмжих шалгуур үзүүлэлтүүд

Хүний капиталын шилжилтийг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг олон улсын тэргүүлэх байгууллагууд болох OECD, ILO, Дэлхийн Банк, Дэлхийн Эдийн Засгийн Форум (WEF)—ын аргачлал, хүрээ, үнэлгээний загваруудыг үндэслэн нягтлан боловсруулж, тэдгээрийг системтэйгээр ангилсан байдлаар Хүснэгт 1-т нэгтгэн үзүүлэв. Эдгээр үзүүлэлтүүд нь хөдөлмөрийн нөөцийн уламжлалт хэмжээсүүдээс (тоо хэмжээ, оролцоо, хөдөлмөрийн цаг) цааш өргөжиж, ур чадвар, бүтээмж, инноваци, дасан зохицох чадавх зэрэг хүний капиталын чанарын үзүүлэлтүүд рүү хэрхэн шилжиж байгааг илрүүлэхэд чиглэнэ. Ингэснээр хүний нөөц (labor input)-өөс хүний капитал (skills, productivity, innovation) руу чиглэсэн шилжилтийн цар хүрээ, хурдац, үр нөлөөг үндэсний түвшинд ч, байгууллагын түвшинд ч хэмжих боломж бүрддэг.

Шалгуур үзүүлэлтүүдийг хүний капиталын шилжилтийн тулгуур багануудын дагуу ангилж, тухайн баганын хүрээнд олон улсын байгууллагуудын тогтоодог зорилтот түвшин, түвшин бүрийн хэмжих аргачлал болон үндэсний түвшний бодлогын үндсэн үзүүлэлтүүдтэй уялдуулан боловсруулав. Мөн Монгол Улсын хөгжлийн бодлого, боловсрол, хөдөлмөр, инновацийн салбарын баримт бичгүүдэд тусгагдсан зорилт, үзүүлэлтүүдийг харгалзан үзэж, шинжилгээний хүрээнд нэгтгэн үнэлэх боломжтой загварт хөрвүүлэн тусгав.

Товчхондоо, хүний нөөц ба хүний капиталын ялгаа нь хөдөлмөрийг хэрхэн ойлгож, удирдаж буй философийн ялгааг илэрхийлдэг. Хүний нөөцийн үзэл баримтлал нь хөдөлмөрийг удирдах, хуваарилах, зохион байгуулахад чиглэж ирсэн бол хүний капиталын үзэл баримтлал нь хүн бүрийн мэдлэг, ур чадвар, туршлага, инновацийн чадавхийг хөрөнгө оруулалтын эх үүсвэр гэж үздэгт оршино. Иймээс хүний капиталын шилжилт нь хөдөлмөрийг “нөөц” байдлаар удирдахаас “капитал” байдлаар хөгжүүлж, хөрөнгө оруулах стратегийн шилжилтийг илэрхийлдэг. Энэ шилжилтийн үр дүнд боловсрол, ур чадвар, инноваци, мэдлэг зэрэг биет бус хүчин зүйлүүд нь хөдөлмөрийн тоо хэмжээ эсвэл ажиллах хүчнээс илүүтэйгээр эдийн засгийн өсөлт, бүтээмж, өрсөлдөх чадварын гол хөдөлгөгч хүчин болж хувирч байна.

Хүснэгт 1. Хүний капиталын шилжилтийг хэмжих шалгуур үзүүлэлтүүд

ҮЗҮҮЛЭЛТ	ТОДОРХОЙЛОЛТ
1. БОЛОВСРОЛЫН ХАМРАГДАЛТ БА УР ЧАДВАРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	
Боловсролын чанар	Ерөнхий боловсролын сургуульд хамрагдсан жил (Дэлхийн банкны Хүний капиталын индекс)
Сургуульд хамрагдсан байдлын түвшин	Бага, дунд, их, техник, мэргэжлийн боловсрол (TVET) хөтөлбөрт хамрагдсан байдал
Насанд хүрэгчдийн бичиг үсгийн болон тооны чадвар	Насанд хүрэгчдийн бичиг үсгийн чадвар, PISA үнэлгээ болон түүнтэй адил түвшний сургалтын үр дүн
Хүүхдийн эрт үеийн хөгжил	Чанартай цэцэрлэгийн боловсролд хамрагдсан хүүхдийн хувь
STEM & Дижитал боловсрол	Шинжлэх ухаан, технологи, инженер, математикийн чиглэлээр төгссөн оюутны нийт төгсөгчдийн тоонд эзлэх хувь
2. УР ЧАДВАР БА АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	
Ур чадвараа шинэчлэх болон насан туршийн боловсрол	Нэг жилийн хугацаанд ур чадвараа нэмэгдүүлэх сургалтад хамрагдсан хүмүүсийн нийт ажиллах хүчинд эзлэх хувь
Цахим болон ногоон ур чадварын бэлэн байдал	ХОУ, цахим, ногоон эдийн засгийн ур чадварт суралцсан ажилтны хувь
Техник, мэргэжлийн сургалт (TVET)	Итгэмжлэгдсэн мэргэжлийн хөтөлбөрт элссэн, хамрагдсан хувь
Ажиллах хүчний шилжилтийн хөтөлбөрүүд	"Ногоон шилжилт" буюу салбарын ур чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжиж буй хөтөлбөрүүд (жишээ: нүүрснээс сэргээгдэх эрчим хүч рүү гэх мэт)
Хөдөлмөрийн зах зээл дэх эмэгтэйчүүдийн оролцоо	Нийт ажиллах хүч болон удирдах албан тушаалд эмэгтэйчүүдийн эзлэх хувь
3. АЖЛЫН ЧАНАР БОЛОН БҮТЭЭМЖИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	
Хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт	Ажилтан тутмын ДНБ-д үзүүлэх нөлөө
Залуучуудын ажил эрхлэлтийн түвшин	15-24 насны залуучуудын сургуульд хамрагдсан байдал, ажил эрхлэлт, болон бусад төрлийн сургалтад оролцож байгаа хувь (NEET)
Албан бус ажил эрхлэлтийн хувь	Албан бус салбарт ажиллагсдын хувь
Үйлчилгээний ажил эрхлэлтийн индекс	Олон улсын хөдөлмөрийн байгууллагын (ILO) хэмжигдэхүүнээр үйлчилгээний салбарын ажилчдын цалин, ажил эрхлэлт, аюулгүй байдлын үнэлгээ
Ур чадвартай ажилчдын гадагшаа хийх шилжилт хөдөлгөөн / Ур чадвартай ажилчдыг татан төвлөрүүлэх хөдөлгөөн (Brain Drain vs. Brain Gain)	Ур чадвартай ажилтны шилжилт хөдөлгөөн
4. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ЗАСАГЛАЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	
Үндэсний ур чадварыг нэмэгдүүлэх стратегийн хэрэгжилт	Үндэсний хүний нөөц, ур чадварын стратегийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, гарсан үр дүн
Төр хувийн хэвшлийн уялдаа	Хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлсэн хүний нөөцийн хөгжлийн санаачилгын тоо
Бодлогын уялдаа, хамаарал	Боловсрол, хөдөлмөр, инновацийн бодлогын уялдаа нийцэл
Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн систем	Хөдөлмөрийн зах зээлийн тогтмол шинэчлэгддэг мэдээллийн платформууд
5. ОРОЛЦОО БА ТЭСВЭРТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ	
Шинжлэх ухаан, технологи, инженер, математикийн STEM хөтөлбөр болон удирдлагын түвшин дэх гендерийн тэгш оролцоо	Шинжлэх ухаан, технологи, инженер, математикийн STEM хөтөлбөр болон удирдлагын түвшинд эмэгтэйчүүдийн эзлэх хувь
Бүс нутгийн ур чадварын тэгш, хүртээмжтэй байдал	Хот ба хөдөөгийн ур чадварын ялгаа
Нийгмийн хамгааллын хамрах хүрээ	Ажилгүй иргэдийг хөдөлмөрийн зах зээлийн идэвхжүүлэх хөтөлбөрт хамруулсан хувь
Ирээдүйн ажлын байрны бэлэн байдал	Зайнаас ажиллах, уян хатан ажлын байрны зохицуулалт
6. ҮР ДҮН ГАРСАН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД	
Хүний капиталын индекс (Дэлхийн банк)	Ирээдүйн ажилтны бүтээмжийг хэмждэг
Инновацийн чадавх	Судалгаа хөгжүүлэлтэд зарцуулсан хөрөнгө (R&D), патент, стартапын экосистем бүрдүүлэлт
Дэлхийн авьяас чадварын өрсөлдөөний индекс (INSEAD)	Авьяас татах, хөгжүүлэх, хадгалах үзүүлэлтүүд
Ирээдүйн чиг баримжаатай салбарт эзлэх ажил эрхлэлтийн хувь	Технологи, ногоон, үйлчилгээний салбарын ажил эрхлэлт
Сэтгэл ханамж ба итгэлцэл	Иргэдийн боловсрол, хөдөлмөрийн байгууллагад итгэх итгэл

Бодлого боловсруулагчид болон байгууллагын удирдлагын хувьд энэхүү өөрчлөлтийг ухамсарлан хүлээн зөвшөөрөх нь стратегийн чухал алхам юм. Учир нь ирээдүйн тогтвортой хөгжил, байгууллагын өрсөлдөх чадвар, эдийн засгийн бүтээмж нь хүний капиталд чиглэсэн бодлого, хөрөнгө оруулалт, засаглалын шинэ хүрээтэй салшгүй уялдаатай байх болно.

3. Хиймэл оюун ухаан болон цахим шилжилт

3.1. Хиймэл оюун ухаан болон цахим шилжилтийн тодорхойлолт

Хиймэл оюун ухаан (ХОУ) болон цахим шилжилт нь мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологийг ашиглан төрийн үйлчилгээ, бизнесийн орчин, хөдөлмөрийн зах зээл, нийгмийн бүтэц, харилцааны хэлбэрийг бүхэлд нь өөрчилж буй бүтцийн өөрчлөлтийн үйл явц юм. Энэ шилжилтийн үндсэн хөдөлгөгч хүч нь интернет холболт, үүлэн технологи, өгөгдлийн платформ, хиймэл оюун ухаан, зүйлсийн интернэт (IoT), цахим үнэмлэх болон цахим төлбөрийн систем зэрэг технологиуд бөгөөд эдгээр нь бүтээмж, хүртээмж, засаглалын чанарыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ шинэ эрсдэлүүдийг дагуулдаг. Өөрөөр хэлбэл цахим шилжилт нь илүү үр ашигтай, ил тод, хүртээмжтэй систем бий болгох боломж олгож байгаа хэдий ч нөгөө талаас өгөгдлийн нууцлал, гадуурхал, ажлын байрны алдагдал, нийлүүлэлтийн гинжин хэлхээний доголдол зэрэг эрсдэлийг бий болгож байна.

Монгол Улсын хувьд цахим дэд бүтэц, өгөгдлийн засаглал, хүний нөөцийн цахим ур чадварыг хөгжүүлэхэд оновчтой хөрөнгө оруулалт хийж чадвал, түргэн, зохион байгуулалттай цахим шилжилт хийх бүрэн боломжтой. Энэ нь төрийн үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлж, эдийн засгийн төрөлжилтийг дэмжин, бүтээмжийг мэдэгдэхүйц нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.

Цахим шилжилт: Эдийн засаг, төр, нийгмийн бүх түвшинд дижитал технологи, өгөгдлийн хэрэглээг системтэйгээр нэвтрүүлж, институцийн өөрчлөлт, шинэ бизнес загвар, засаглалын шинэ хандлагыг бий болгох үйл явц юм.

ЭЗХАБ-ийн тодорхойлсноор: “Одоогийн болон ирээдүйн цахим технологи, их өгөгдлийн хэрэглээ нь Засгийн газар, хувийн хэвшил болон нийгмийн бүх түвшинд системийн өөрчлөлт бий болгож байна.” (OECD, 2018).

Хиймэл оюун ухааны шилжилт: Хиймэл оюун ухаан нь алгоритм, өгөгдлийн боловсруулалт, машин сургалт, автомат шийдвэр гаргалтад тулгуурлан хүний оюуны үйл ажиллагааг дуурайх, дэмжих технологи юм. Энэ нь таамаглал дэвшүүлэх, даалгаврыг

автоматжуулах, хүний шийдвэрийг дэмжих зэргээр өргөн хүрээнд ашиглагдаж байна. Хиймэл оюун ухаан нь цахим шилжилтийн хурдасгуур хүчин зүйл бөгөөд төрийн үйлчилгээний автоматжуулалт, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, үйлдвэрлэл зэрэг олон салбарт үр ашиг, инновацийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлдэг. Дэлхийн банкны тодорхойлсноор хиймэл оюун ухааныг зохистой засаглал, ёс зүйн хяналтын дор хөгжүүлбэл хөгжиж буй орнуудын тогтвортой хөгжил, нийгмийн оролцоог дэмжих чухал хэрэгсэл болж чадна.

Давуу талууд: Цахим шилжилт нь төрийн үйлчилгээг илүү хурдан, хямд, ил тод болох, шинэ цахим салбар, ажлын байр, гарааны бизнесийн өсөлт бий болох, уул уурхай, хөдөө аж ахуй, эрүүл мэндийн салбарын үр ашиг дээшлэх, хөдөлмөрийн зах зээл болон бизнесийн орчны хүртээмж сайжрах зэрэг давуу талуудтай.

Эрсдэл ба сорилтууд: Интернет холболтын хүртээмж дутмаг байснаас үүдэх нийгмийн гадуурхал, өгөгдлийн хамгаалалт, нууцлал, кибер аюулгүй байдлын сул засаглал, хиймэл оюун ухаанд хэт найдах, ёс зүйн зохицуулалтгүй хэрэглээ ажиллах хүчийг дахин ур чадваржуулах бодлогын дутмаг байдлаас үүдэх нийгмийн хуваагдал зэрэг эрсдэл, сорилтууд үүсэх боломжтой. Олон улсын туршлагаас харахад технологийн шилжилтийн амжилтын түлхүүр нь зөв дараалал, үр дүнтэй засаглал, ур чадварын дэмжлэг, хүний капиталын бодлого хоорондын уялдаа юм (Vespoli, 2021).

Бодлогын үр дагавар

Хиймэл оюун ухаан болон цахим шилжилтийн бодлого нь технологийн дэвшлийг зөв дараалал, зохистой зохицуулалттайгаар хэрэгжүүлэх шаардлагатайг олон улсын туршлага нотолж байна. Энэхүү шилжилтийн амжилт нь зөвхөн технологид бус, харин түүний суурь дэд бүтэц, өгөгдлийн засаглал, хүний ур чадвар, ёс зүйн тогтолцоонд тулгуурладаг. Иймээс дараах бодлогын чиглэлүүдийг онцлон авч үзэх нь зүйтэй.

1. Цахим дэд бүтцийг бүрдүүлэх: Юуны өмнө найдвартай өргөн зурвасын холболт, үндэсний цахим үнэмлэх (иргэдийн сайн дурын оролцоо, нууцлалын хамгаалалттай), үүлэн технологи болон харилцан уялдаа бүхий өгөгдлийн экосистем (API, стандарт, нээлттэй архитектур)-ийг хөгжүүлэх шаардлагатай. Эстони, Руанда зэрэг улсууд эдгээр суурь дэд бүтцэд урт хугацаанд системтэйгээр хөрөнгө оруулснаар цахим төрийн тогтолцоогоо амжилттай бүрдүүлсэн байдаг.

2. Хиймэл оюун ухааныг үе шаттайгаар нэвтрүүлэх: Хиймэл оюун ухааныг өндөр эрсдэлтэй салбарт (эрүүл мэнд, хууль, шүүхийн шийдвэр гаргах гэх мэт)

бус, эхний ээлжид бага эрсдэлтэй захиргааны болон техникийн үйл ажиллагаанд туршилтын журмаар нэвтрүүлэх нь зүйтэй. Туршилтын дүнг үндэслэн дараагийн шатны өргөтгөлийг хэрэгжүүлэх нь эрсдэлийг бууруулж, итгэлцлийг нэмэгдүүлнэ.

3. Өгөгдлийн засаглал ба нууцлалын хамгаалалт: Өгөгдлийн нэгдсэн системд шилжихийн өмнө өгөгдөл хамгаалах бодлого, зорилгын хязгаарлалт, зөвшөөрөл, өгөгдөл хуваалцах журам болон нөхөн төлбөрийн механизмыг хуульчилсан байх ёстой. Энэтхэгийн “Аадхаар” (Aadhaar) системийн туршлага нь өгөгдлийн хамгаалалт, иргэний нууцлалыг хангах нарийн зохицуулалтын ач холбогдлыг тод харуулдаг.

4. Хүртээмжтэй цахим ур чадвар ба жижиг, дунд үйлдвэрийн дэмжлэг: Цахим шилжилт нь нийгмийн тэгш бус байдлыг гүнзгийрүүлэх эрсдэлтэй тул ур чадварын ялгааг багасгах бодлого чухал. Иймээс цахим бичиг үсэг тайлагдалт, мэргэжлийн давтан сургалт, жижиг дунд үйлдвэрийн цахим чадавхыг дээшлүүлэх чиглэлд зэрэгцээ хөрөнгө оруулалт хийх шаардлагатай. Дэлхийн банкны Монгол дахь “Ухаалаг засаглал” хөтөлбөр нь энэ чиглэлд жижиг, дунд бизнесийн цахим замын зураг боловсруулахад чиглэж буй сайн туршлага юм.

5. Төр-хувийн хэвшлийн түншлэл ба дотоодын экосистемийг хөгжүүлэх: Цахим үйлчилгээ үзүүлэхэд төр-хувийн хэвшлийн түншлэл (PPP) чухал үүрэгтэй. Жишээлбэл Руандагийн “Irembo” загвар нь төрийн үйлчилгээг хувийн хэвшлийн дэмжлэгтэйгээр цахимжуулсан бодит туршлага юм. Гэвч үүнийг хэрэгжүүлэхдээ ил тод худалдан авалт, гүйцэтгэлийн хяналтыг хангах зохицуулалтыг хатуу мөрдөх шаардлагатай.

6. Ёс зүй ба зохицуулалтын хамгаалалтын хамрах хүрээ бий болгох: Инновацийг хязгаарлалгүйгээр учирч болох эрсдэлийг бууруулахын тулд “туршилтын зохицуулалтын хайрцаг” (regulatory sandbox) болон ёс зүйн хяналтын зөвлөл байгуулах хэрэгтэй. ЭЗХАХБ-ийн зөвлөмжид дурдсанаар, хиймэл оюун ухааны ашиг тус болон эрсдэлийг тэнцвэржүүлэхийн тулд төрийн бүх шатны байгууллагуудыг хамарсан, цогц бодлогын хандлагыг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

3.2. Хиймэл оюун ухаан болон цахим шилжилтийн есөн тулгуур багана

Хиймэл оюун ухаан болон цахим шилжилт нь зөвхөн техник, програм хангамжийн шинэчлэл бус эдийн засаг, засаглал, хөдөлмөрийн зах зээл, иргэний оролцоо болон байгууллагын үйл ажиллагааны бүтээмжийг бүхэлд нь өөрчлөх системийн өөрчлөлт

учраас хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг есөн тулгуур баганын дагуу ангилан тодорхойлов. Үүнд цахим дэд бүтэц, өгөгдлийн экосистем, хүний капитал ба ур чадвар, инноваци ба судалгаа, цахим засаглал, аюулгүй байдал, хувийн хэвшлийн зарим үйл ажиллагааг цахим болгох, иргэдийн цахим хүртээмж, тогтвортой хөгжлийг дэмжих цахим шийдлүүд зэрэг чиглэлүүд багтана.

Хиймэл оюун ухаан болон цахим шилжилтийн есөн тулгуур баганыг нэгтгэн Зураг 7-д үзүүлж байна. Эдгээр баганад тулгуурласан үзүүлэлтүүд нь улс орнуудын цахим болон ХОУ-н шинэчлэлийн явцыг чанарын (policy, governance) болон тоон (penetration rate, investment level, adoption index) үзүүлэлтүүдээр хослуулан хэмжих боломжийг олгодог. Мөн олон улсын байгууллагуудаас тогтоодог зорилтот түвшин жишиг үзүүлэлтийг тодорхойлов. Ингэснээр ХОУ болон цахим шилжилтийн үр нөлөөг” салбар байгууллага, үндэсний түвшинд системтэйгээр үнэлж цаашдын бодлого, хөрөнгө оруулалтын чиглэлийг нотолгоонд суурилан тодорхойлоход дэмжлэг болно.

1. Цахим дэд бүтэц ба холбогдсон байдал -

Суурь дэд бүтэц нь цахим хэрэглээ болон хиймэл оюун ухааны интеграцийг өргөн хүрээнд хангаж чадах эсэхийг үнэлэх үндсэн зорилготой (OECD, 2024).

- Улс даяарх өндөр хурдны интернет болон 5G хамрах хүрээ
- Үүлэн технологи болон дата төвийн дэд бүтэц
- Харилцан ажиллах боломжтой дижитал системүүд

2. Дата экосистем болон засаглал -

Дата экосистем болон засаглал нь хариуцлагатай, ёс зүйтэй, үр дүнтэй хиймэл оюун ухааны засаглалын бодлого, байгууллагын бэлэн байдлыг хянах үндсэн зорилготой (ПЕА, 2025).

- Үндэсний өгөгдлийн стратеги болон нээлттэй өгөгдлийн платформууд
- Өгөгдлийн нууцлал, хамгаалалт болон хэрэглээний ёс зүйн бодлого
- Салбар дундын өгөгдөл хуваалцах стандартууд
- Өгөгдлийн харилцан үйлчлэл ба бие даасан өгөгдлийн менежмент

3. ХОУ-ны судалгаа, инноваци, технологийн хөгжүүлэлт

Иргэд, ажиллах хүч нь цахим болон хиймэл оюун ухаанд суурилсан эдийн засагт хэр сайн бэлтгэгдсэнийг хэмжих үндсэн зорилготой (WEF,

2020).

- Үндэсний хиймэл оюун ухааны судалгааны төвүүд болон инновацийн төвүүд
- Засгийн газар, үйлдвэрүүд, судалгааны байгууллагын хамтын ажиллагаа
- Судалгаа, хөгжүүлэлт болон шинээр гарч ирж буй технологиуд (хиймэл оюун ухаан, робот техник, квант, биотехнологи)-д зориулсан санхүүжилт
- Оюуны өмчийн хамгаалалт болон инновацийн урамшуулал

4. Хүний нөөц, цахим ур чадварууд

Цахим салбар, инновацийн экосистем болон хиймэл оюун ухаанд суурилсан бүтээмжийн өсөлтийг үнэлэх үндсэн зорилготой (UNDP, 2021).

- Боловсролын салбарт хиймэл оюун ухаан болон цахим ур чадварын мэдлэг эзэмшүүлэх (ЕБ-ын сургуулиас их, дээд сургууль хүртэл)
- Ажиллах хүчний ур чадварыг дээшлүүлэх, дахин мэргэшүүлэх хөтөлбөрүүд
- STEM болон оюунлаг чадварыг дэмжих хөтөлбөр
- Насан туршийн сургалтын платформууд болон төр, хувийн хэвшлийн сургалтын түншлэл

5. Цахим засаглал ба төрийн цахим шилжилт

Дижитал хэрэгслүүд болон хиймэл оюун ухаан нь засгийн газрын үр ашиг, ил тод байдал, иргэдэд үзүүлэх үйлчилгээг хэрхэн сайжруулж байгааг үнэлэх үндсэн зорилготой (World Bank, 2020).

- Цахим засаглал ба ухаалаг төрийн үйлчилгээ
- Бодлого боловсруулахад хиймэл оюун ухаанаар удирдуулсан шийдвэр гаргах дэмжлэг
- Цахим үнэмлэх, цахим төлбөр тооцоо, иргэний нэгдсэн платформууд
- Нээлттэй инноваци ба өгөгдөлд суурилсан бодлого боловсруулах

6. Дижитал эдийн засаг

Дижитал эдийн засаг, инновацийн экосистем болон хиймэл оюун ухаанд суурилсан бүтээмжийн өсөлтийг үнэлэх гол зорилготой (McKinsey&Company, 2018).

- Жижиг дунд үйлдвэрүүд болон уламжлалт салбаруудыг цахимжуулах
- Аж үйлдвэрийн 4.0 технологи (IoT, робот техник, автоматжуулалт, блокчэйн, технологи)
- Стартапууд, технологийн кластерууд болон инновацийн экосистем
- Цахим худалдаа

Зураг 7. Хиймэл оюун ухаан болон цахим шилжилтийн өсөн тулгуур багана



- Цахим нэвтрүүлэлт болон инновацийн хөрөнгө оруулалтын урамшуулал

7. ХОУ засаглал ба ёс зүй – Хиймэл оюун ухааны шилжилт нь хүртээмжтэй, ёс зүйтэй, байгаль орчинд ээлтэй байхыг баталгаажуулах гол зорилготой (UNESCO, 2024).

- Үндэсний хиймэл оюун ухааны ёс зүйн удирдамж ба хариуцлагын хүрээ
- Алгоритмын ил тод байдал
- Хүний эрх
- Шинээр гарч ирж буй технологийн зохицуулалт (хиймэл оюун ухааны аюулгүй байдал, өгөгдөл ашиглах, бие даасан систем)
- Хиймэл оюун ухаанд олон нийтийн харилцаа итгэлцлийг бий болгох

8. Цахим аюулгүй байдал - Цахим аюулгүй байдлын бэлэн байдлыг үнэлэх зорилготой (OECD, 2024).

- Үндэсний кибер аюулгүй байдлын стратеги
- Кибер хамгаалалтын ба Олон улсын хамтын ажиллагаа
- Дижитал бүрэн эрхт байдал ба суурь дэд бүтэц

- Кибер мэдлэг, уян хатан байдлыг бий болгох

9. Инновацийн экосистем, Төр хувийн хэвшлийн хамтрал

- Дэлхийн цахим болон хиймэл оюун ухааны экосистемийн интеграцийг хэмжих үндсэн зорилготой (ПЕА, 2025).
- Засгийн газар хянагч биш, харин идэвхжүүлэгчийн үүрэг гүйцэтгэгч байх
 - Олон талын оролцогч талуудын инновацийн түншлэл
 - Венчур капитал, хурдасгуур болон дэмжих хөтөлбөрүүд
 - Эрдэм шинжилгээний байгууллагууд, стартапууд болон үйлдвэрлэлийн салбарын хамтын ажиллагаа

3.3. Хиймэл оюун ухаан болон цахим шилжилтийг хэмжих шалгуур үзүүлэлтүүд

Хиймэл оюун ухаан (ХОУ) болон цахим шилжилтийн хөгжлийг бодитой үнэлэх, олон улсын түвшинд харьцуулахад зориулсан хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг OECD, World Bank, ITU, WEF зэрэг байгууллагын аргачлал болон индексүүдэд тулгуурлан боловсруулж, Хүснэгт 2-т нэгтгэн харууллаа. Эдгээр үзүүлэлтүүд нь улс орон болон байгууллагын хүрээнд технологийн нэвтрэлт, цахим ур чадвар өгөгдлийн экосистемийн хөгжил, инновацийн хүртээмж, ХОУ-н хэрэглээ, дэд бүтцийн чанар болон тогтвортой хөгжлийн зорилтуудад үзүүлэх нөлөөг цогцоор нь үнэлэх боломжийг олгодог.

Хүснэгт 2. Хиймэл оюун ухаан ба цахим шилжилтийг хэмжих шалгуур үзүүлэлтүүд

ҮЗҮҮЛЭЛТ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ЭХ СУРВАЛЖ
1. ЦАХИМ ДЭД БҮТЭЦ БА ИНТЕРНЭТ ХОЛБОЛТ		
Интернет нэвтэрсэн хувь хэмжээ (Internet penetration)	Интернэт хэрэглээний хүн амд эзлэх хувь	ITU (2024), World Bank (2023)
Өргөн зурвасын хүртээмж (Reliable broadband access)	Найдвартай өргөн зурвасын холболтын хүн амд эзлэх хувь	ITU (2024), World Bank (2023)
4G/5G хамрах хүрээ (4G/5G coverage)	4G / 5G холболтын хүн амд эзлэх хувь	ITU Global Connectivity Index (2024)
МТ-ийн салбарын хөрөнгө оруулалтын хэмжээ (ICT investment)	Мэдээллийн технологийн салбарын хөрөнгө оруулалт	OECD Digital Economy Outlook (2023)
Дата төв ба үүлэн дэд бүтэц (Data Center & Cloud Capacity)	Дотоодын өгөгдлийн хадгалалт, үүлэн үйлчилгээний бэлэн байдал	-
Хот-орон нутгийн цахим хүртээмжийн зөрүүтэй байдал (Rural-urban digital divide)	Хот, хөдөөгийн интернэтийн хүртээмжийн ялгааг бууруулах	UNDP Digital Inclusion Index (2023)
2. ХИЙМЭЛ ОЮУН БА ЦАХИМ ЗАСАГЛАЛ		
Үндэсний ХО стратегийн хэрэгжилт (National AI Strategy implementation)	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн хувь	Oxford Insights (2023)

Өгөгдөл хамгаалалт ба нууцлал (Data protection & privacy laws)	Хувийн мэдээлэл хамгаалах хууль эрх зүйн байдал ба хэрэгжилт	UNCTAD Data Protection Tracker (2024)
Кибер аюулгүй байдлын бэлэн байдал (Cybersecurity readiness)	Кибер аюулгүй байдлын индексийн эрэмбэ	ITU Global Cybersecurity Index (2023)
ХОУ-н зарчим (AI ethics framework adoption)	ХОУ-н зарчмын хэрэгжилтийн ил тод байдал баримтлах	UNESCO AI Ethics Recommendations (2023)
3. ЦАХИМ УР ЧАДВАР БА ХҮНИЙ КАПИТАЛ		
Цахим ур чадвар (Digital literacy rate)	Насанд хүрэгчдийн дижитал ур чадвар эзэмшсэн хувь	ITU Digital Skills Index (2023)
Шинжлэх ухаан, технологи, инженер, математикийн STEM хөтөлбөрт хамрагдсан байдал (STEM participation)	Шинжлэх ухаан, технологи, инженер, математикийн STEM хөтөлбөрт хамрагдсан оюутны нийт оюутаны тоонд эзлэх хувь	OECD Skills Outlook (2023)
ХОУ судалгааны чадавхи (AI research capacity)	1 сая хүн тутамд ногдох ХОУ судлаачдын тоо	UNESCO Science Report (2023)
Ажиллах хүчийг дахин сургах, чадавхжуулах хөтөлбөр (Workforce reskilling)	Жил бүр дижитал чадвар эзэмшиж буй ажиллагчдын нийт ажиллагсдын тоонд эзлэх хувь	WEF (2023)
4. ДИЖИТАЛ ЭДИЙН ЗАСАГ БА ИННОВАЦИ		
Дижитал эдийн засгийн ДНБ-д эзлэх хувь (Digital economy contribution)	МТ болон дижитал үйлчилгээний ДНБ-д эзлэх хувь	World Bank (2023)
Цахим худалдаа нэвтэрсэн байдал (E-commerce penetration)	Нийт ААН дунд бараа, үйлчилгээ онлайн худалдаалдаг ААН-ийн эзлэх хувь	-
ХОУ ашиглалт (AI adoption in enterprises)	ХОУ ашиглаж буй байгууллагын хувь	WEF Future of Jobs (2023)
Судалгаа, инновацийн хөрөнгө оруулалт (R&D investment)	Инновацийн хөрөнгө оруулалтын хэмжээ	OECD Innovation Indicators (2024)
Стартап экосистемийн төлөвшил (Startup ecosystem maturity)	100,000 хүн тутамд ногдох технологийн стартапын тоо	Global Innovation Index (WIPO, 2023)
5. ЦАХИМ ЗАСАГЛАЛ БА ТӨРИЙН ЦАХИМ ШИЛЖИЛТ		
НҮБ-ын цахим засаглалын индекс (E-Government Development Index)	Улсын эрэмбэ	UN E-Government Survey (2024)
Засаглал дахь ХОУ-ы хэрэглээ (AI use in governance)	ХОУ суурилсан бодлогын шийдвэр гаргаж буй байгууллагын тоо	OECD Digital Government Index (2023)
Иргэдийн цахим үйлчилгээний хэрэглээ (Citizen uptake of e-services)	E-portal ашиглаж буй иргэдийн хувь	World Bank GovTech Index (2023)
Онлайн үйлчилгээний эзлэх хувь (Services available online)	Цахим төрийн үйлчилгээний хувь	UNDESA (2024)
6. ОРОЛЦОО, ЁС ЗҮЙ БА ТОГТВОРТОЙ БАЙДАЛ (INCLUSION, ETHICS & SUSTAINABILITY)		
Цахим хүртээмжийн зөрүү (Digital inclusion gap)	Хот, орон нутгийн орлого багатай бүлгийн цахим хүртээмжийн ялгаа	UNDP (2023)
Цахим хэрэглээний өртөг (Affordability of access)	Нийт өрхийн орлогын интернэтэд зарцуулах хувь	ITU (2024)
Ногоон мэдээллийн технологи (Green ICT share)	Сэргээгдэх эрчим хүчээр ажилладаг мэдээлэл, технологийн байгууллагын эзлэх хувь	UNEP (2023)
ХО-ийн шударга байдлын аудит (AI bias audits)	Эрсдэл өндөр системүүдэд хийсэн аудитын дүгнэлт	OECD AI Policy Observatory (2023)
8. ГЛОБАЛ ӨРСӨЛДӨХ ЧАДВАР БА ХАМТЫН АЖИЛЛАГАА (GLOBAL COMPETITIVENESS & COLLABORATION)		
ХОУ бэлэн байдлын индекс (AI Readiness Index rank)	Улсын эрэмбэ	Oxford Insights (2023)

ОУ-ын иновацийн индекс(Global Innovation Index)	Улсын эрэмбэ	WIPO (2023)
Олон улсын цахим худалдаа (Cross-border digital trade growth)	Дижитал экспортын жилийн өсөлт	WTO (2024)
Олон улсын ХОУ хамтын ажиллагаа (International AI cooperation projects)	Олон улсын хамтын ажиллагааны хөтөлбөрийн тоо	UNESCO, UNDP (2024)

4. Ногоон шилжилт

Дэлхий нийтэд тулгараад байгаа уур амьсгалын өөрчлөлт, эдийн засаг, хүн амын хурдацтай өсөлт, хэрэглээ, үйлчилгээний хэт өсөлт, байгалийн нөөцийн хомсдол нь дэлхийн оршин тогтнолд эрсдэл учруулж байна. Өнөөгийн үйлдвэрлэл, хэрэглээний экологийн ул мөрийг тооцоолж үзэхэд энэ хандлагаар цааш хөгжвөл 2030 он гэхэд дэлхийн нөөц боломжоос 2 дахин давахаар байна. Иймд дэлхийн улс орон, иргэн бүр өөрийн ахуй амьдрал, үйлдвэрлэл, хэрэглээнийхээ хэв маягийг эрс өөрчилж байгальд илүү ээлтэй, “ногоон” загварт шилжих шаардлагатай байна.

Нэгдсэн үндэстний байгууллагын 2012 оны тогтвортой хөгжлийн дээд хэмжээний уулзалтаар тулгамдаад байгаа дээрх асуудлыг хэлэлцэж, тогтвортой хөгжилд хүрэх, ядуурлыг бууруулах чухал арга хэрэгсэл болох ногоон эдийн засгийг улс орон бүр өөрийн үндэсний онцлогт тохируулан хөгжүүлэхийг зөвлөсөн юм. Улмаар түүний төрөлжсөн байгууллагаас байгалийн нөөцийг үр ашигтай ашиглаж орчны бохирдол, доройтлоос зайлсхийсэн, хүлэмжийн хийн ялгарал багатай эдийн засгийн тогтолцоог бий болгож хөгжүүлэхэд чиглэсэн ногоон эдийн засаг, ногоон үйлдвэрлэл, ногоон өсөлтийн үзэл баримтлалыг дэвшүүлж, дэлхийн эдийн засгийн харилцаанд үр ашигтай оролцох шинэ боломж бүрдүүлэхийг зорьж байна.

Ногоон шилжилт нь эдийн засаг болон нийгмийн хөгжлийг нүүрстөрөгчийн бага ялгаралттай, нөөцийн хэмнэлттэй, хүртээмжтэй, тогтвортой хөгжил рүү чиглүүлэх бүтцийн өөрчлөлт юм. Энэ шилжилт нь чулуужсан түлшний хамаарлыг бууруулж, цэвэр эрчим хүч, нөөцийн эргэлтийн хэрэглээ, экосистемийн сэргээн босголт, ногоон ажлын байр зэрэг тогтвортой шийдлүүдээр орлуулахад чиглэдэг. Иймээс ногоон шилжилт нь зөвхөн эдийн засгийн шинэчлэл төдийгүй амьжиргааг хамгаалах, нийгмийн тэгш байдлыг дэмжихийн зэрэгцээ хүлэмжийн хийн ялгарлыг бууруулж, байгалийн нөөцийг хамгаалах цогц зорилгыг агуулдаг нийгмийн өөрчлөлт юм (НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, UNEP).

4.1. Ногоон шилжилтийн тулгуур багана

Ногоон шилжилтийн хэрэгжилтийг бодитой үнэлэх, улс орнуудын ахицыг харьцуулах зорилгоор олон улсын байгууллагууд (OECD, UNEP, IEA, World Bank, WEF, FAO)-ын аргачлал, ногоон хөгжлийн үзүүлэлтүүд болон тогтвортой хөгжлийн индекс тулгуурлан ногоон шилжилтийн үндсэн бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлсон. Ногоон шилжилтийн тулгуур 8 баганыг Зураг 8-д үзүүлэв. Ногоон шилжилт нь зөвхөн байгаль орчны бодлогын хүрээ бус, харин эдийн засаг, эрчим хүч, хөдөө аж ахуй, хот төлөвлөлт, санхүүжилт, хүний капитал, үйлдвэрлэлийн системийг бүхэлд нь шинэчлэх системийн өөрчлөлт учраас хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг дараах найман тулгуур баганын хүрээнд ангилан тодорхойлов.

Зураг 8. Ногоон шилжилтийн найман тулгуур багана



1. Цэвэр эрчим хүчний шилжилт- Чулуужсан түлшийг сэргээгдэх болон бага нүүрстөрөгчийн эрчим хүчний эх үүсвэрээр солих үндсэн зорилготой (ЕЕВ, 2024).

- Сэргээгдэх эрчим хүч (нар, салхи, усан, газрын гүний дулаан, биомасс)
- Эрчим хүчний үр ашиг ба хэмнэлт
- Ухаалаг сүлжээ болон эрчим хүч хадгалах шийдлүүд
- Халаалт, аж үйлдвэр, тээврийн цахилгаанжуулалт

2. Ногоон тээврийн хэрэгсэл - Тээврийн хэрэгслээс ялгарч буй нүүрстөрөгчийн ялгарлын хэмжээг бууруулж, илүү цэвэр хувилбаруудыг олох үндсэн зорилготой (GGGI, 2021).

- Цахилгаан тээврийн хэрэгсэл (EV) болон EV дэд бүтэц
- Нийтийн тээвэр болон моторгүй хөдөлгөөн (дугуй, явган аялал)
- Тогтвортой агаарын нисэх хүчин
- Бага тойрогтой, дамжин өнгөрөх чиглэлтэй хөгжлийн хот төлөвлөлт

3. Ногоон үйлдвэрлэл ба тойрог эдийн засаг - Үйлдвэрлэл болон хэрэглээг илүү нөөцийн хэмнэлттэй, хаягдалгүй болгох үндсэн үүрэгтэй (United Nations, 2020).

- Тойрог эдийн засгийн зарчим (багасгах, дахин ашиглах, дахин боловсруулах, дахин үйлдвэрлэх)
- Ногоон үйлдвэрлэл ба эко дизайн
- Үйлдвэрлэлийн нүүрстөрөгчийн хэмжээг бууруулах
- Тогтвортой хангамжийн сүлжээ ба түүхий эдийн ур ашиг

4. Тогтвортой мал аж ахуй, хоолны систем - Уян хатан, бага нүүрс хүчлийн ялгаруулалттай, байгальд ээлтэй хүнсний үйлдвэрлэлийн системийг бий болгох зорилготой (World Bank Group, 2020).

- Нөхөн сэргээх болон органик газар тариалан
- Химийн бордоо, пестицидийн хэрэглээг багасгах
- Орон нутгийн болон тогтвортой хүнсний үйлдвэрлэл
- Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ухаалаг хөдөө аж ахуй, газрын нөхөн сэргээлт

5. Ногоон барилга байгууламж, хотууд - Эрчим хүч болон нөөцийн хэрэглээг багасгахын тулд хот суурин газрын зураг төслийг боловсруулж, шинэчлэн засварлах үндсэн зорилготой (IEA, 2021).

- Эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламж (дулаалга, ногоон дээвэр, идэвхгүй дизайн)
- Тогтвортой материал ба барилга байгууламж
- Хог хаягдал, усны менежментийн систем
- Хотын ногоон байгууламж ба уур амьсгалд тэсвэртэй төлөвлөлт

6. Байгалийн нөөц, биологийн олон талт байдлын хамгаалал

Экосистемийг хамгаалж, байгалийн капиталыг нөхөн сэргээх зорилготой (IEA, 2021).

- Ойн хамгаалал, ойжуулалт
- Газар, ус, далайн тогтвортой менежмент
- Биологийн олон янз байдлыг хамгаалах, экосистемийг сэргээх
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, гамшгийн эрсдэлийг бууруулах

7. Ногоон санхүүжилт, ногоон эдийн засаг - Ногоон хөрөнгө оруулалтын санхүүжилт болон урамшууллыг нэмэгдүүлэх зорилготой (WEF, 2025).

- Ногоон бонд ба тогтвортой санхүүгийн шийдлүүд
- Карбон татвар, карбон үнийн механизм
- Байгаль орчин, нийгэм, засаглалын (ESG) стандартууд ба тогтвортой хөрөнгө оруулалтын бодлого

8. Боловсрол, Инноваци ба Ногоон ур чадвар - Хувь хүмүүс болон байгууллагуудын ногоон шилжилтийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх зорилготой (WEF, 2025).

- Ногоон ажлын байрны сургалт болон дахин ур чадвар олгох
- Байгаль орчны боловсрол
- Судалгаа, инноваци, технологийн дэвшил
- Олон нийтийн мэдлэг, зан үйлийн өөрчлөлтийн кампанит ажил

Ийнхүү ногоон шилжилтийн найман тулгуур баганын дагуух үзүүлэлтүүд нь эдийн засгийн салбаруудын нүүрстөрөгчийн бууралт, хурд, экологийн тогтвортой байдал, инновацийн түвшин болон нийгэм-эдийн засгийн дасан зохицлын чадавхыг системтэйгээр үнэлж, цаашдын бодлого, хөрөнгө оруулалтын чиглэлийг нотолгоонд суурилан тодорхойлоход ашиглагдах боломжтой юм.

4.2. Ногоон шилжилтийг хэмжих үзүүлэлтүүд

Дээрх баганад суурилсан үзүүлэлтүүд нь улс орны ногоон хөгжлийн явцыг тоон (emission reduction rate, renewable capacity, land restoration index) болон чанарын (policy readiness, institutional capacity, governance quality) үзүүлэлтүүдээр хослуулан хэмжих боломжийг олгодог. Мөн олон улсын байгууллагуудаас тогтоодог зорилтот түвшин, хэмжих нэгжийг тодорхойлж, Хүснэгт 3-д нэгтгэв.

Хүснэгт 3. Ногоон шилжилтийг хэмжих шалгуур үзүүлэлтүүд

ҮЗҮҮЛЭЛТ	ТАЙЛБАР / НЭГЖ	ҮНДСЭН ЭХ СУРВАЛЖ
1. ЦЭВЭР ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТ		
Эрчим хүчний эцсийн хэрэглээ дэх сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь (%)	Эрчим хүчний нэгдсэн системд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь	UN SDG 7.2.1, IEA, World Bank
Эрчим хүчний салбарын чадамж (MJ/USD ДНБ)	Эрчим хүчний салбарын үр ашиг	IEA, World Bank (SE4ALL), OECD
Эрчим хүчнээс ялгарах нүүрс хүчлийн хийн CO ₂ хэмжээ (тонн/хүн эсвэл тонноор ДНБ-д)	Эрчим хүчний салбарын нүүрс хүчлийн хийг багасгах үзүүлэлт	IEA, IPCC, UNFCCC
Сэргээгдэх эрчим хүчний суурилагдах хүчин чадал (MW эсвэл хүн амд ногдох СЭХ-ний суурилагдах хүчин чадал)	Сэргээгдэх эрчим хүчний салбарын өсөлт	IRENA, IEA
Цахилгаан болон цэвэр түлшэнд нэвтрэх боломж (%)	Эрчим хүчний шилжилтийг хэмжих үзүүлэлт	World Bank SDG 7.1.1/7.1.2
2. НОГООН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ		
Тээврийн салбарын нүүрс хүчлийн хийн ялгарал (Mt CO ₂)	Бүх тээврийн хэрэгслийн нүүрсхүчлийн хийн ялгарал	IEA, IPCC
Цахилгаан тээврийн хэрэгслийн нийт тээврийн хэрэгсэлд эзлэх хувь (%)	Цахилгаан тээврийн хэрэгсэл	IEA Global EV Outlook
Нийтийн тээврийн хэрэглээ (нэг хэрэглэгч-км/хүн)	Нийтийн тээвэр рүү шилжих олон нийтийн хандлага	OECD, UNEP
Түлшний эдийн засаг (L/100 км эсвэл gCO ₂ /km)	Цахилгаан тээврийн хэрэгслийн үр ашиг	IEA, UNEP Global Fuel Economy Initiative
Хотын агаарын чанар (PM2.5 тоосонцор)	Агаарын бохирдол болон нийтийн эрүүл мэндийн хамаарал	WHO, UN SDG 11.6.2
3. НОГООН ҮЙЛДВЭРЛЭЛТ БА ТОЙРОГ ЭДИЙН ЗАСАГ		
Материалын үр ашиг (USD ДНБ / тонн материал)	Нөөц ашиглалт	OECD Green Growth Indicators
Хотын хог хаягдлын дахин боловсруулж буй хувь (%)	Тойрог эдийн засгийн хөгжлийг хэмжих	Eurostat, OECD
Үйлдвэрийн нүүрс хүчлийн хийн CO ₂ ялгарал (Mt CO ₂)	Үйлдвэрлэлийн нүүрсхүчлийн ялгарлыг бууруулах	UNFCCC, IEA
Ногоон патентуудын эзлэх хувь (%)	Эко-инновацийн үзүүлэлт	WIPO, OECD
Нөөцийн тойрог эдийн засагт орох хувь (%)	Эдийн засагт эргэж орох материалын хувь	Eurostat Circular Economy Indicators
4. ТОГТВОРТОЙ МАЛ АЖ АХУЙ, ХООЛНЫ СИСТЕМ		
Хөдөө аж ахуйн салбарын нүүрс хүчлийн хийн ялгарал (Mt CO ₂ e)	Газар ашиглалт, мал, бордооноос ялгарах нүүрс хүчлийн хий	FAO, IPCC
Тогтвортой/органик газрын нийт тариалангийн талбайд эзлэх хувь (%)	Эко системийг дэмжсэн практик туршилтууд	FAO, OECD
Хөдөө аж ахуйн ус ашиглалтын үр ашиг (м³/USD гаралт)	Нөөцийн үр ашгийг хэмжих	FAO AQUASTAT, SDG 6.4.1
Хоол хүнсний хаягдал (Үйлдвэрлэлд эзлэх хувь)	Нийлүүлэлтийн гинжин хэлхээний тогтвортой байдал	FAO, UNEP
Шороон хөрсний органик элементийн агууламж (тонн/га)	Хөрсний эрүүл ахуйн үзүүлэлт	FAO, UNCCD
5. НОГООН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ХОТУУД		
Барилгын эрчим хүчний хүчин чадал (kWh/m²/жил)	Ногоон барилгажилт	IEA, UNEP GlobalABC
Ногоон гэрчилгээтэй барилгуудын хувь (%)	Тогтвортой барилгын материалын зах зээлд нэвтэрсэн байдал	World Green Building Council
Хотын ногоон байгууламж (м²/хүн)	Дасан зохицох чадвар	UN-Habitat, SDG 11.7.1
Бохир ус цэвэрлэх хувь (%)	Усны тогтвортой байдал	World Bank, OECD
Хотын хүн амын агаар бохирдолд өртөх магадлал (PM2.5)	Хотын иргэдийн эрүүл мэндийг хэмжих	WHO, UN SDG 11.6.2
6. БАЙГАЛИЙН НӨӨЦ, БИОЛОГИЙН ОЛОН ТАЛТ БАЙДАЛ		
Хамгаалагдсан газар нутгийн хувь (%)	Биологийн олон талт байдлыг хамгаалах гол үзүүлэлт	UN SDG 14.5.1, 15.1.2
Нийт газар нутгийн хэмжээнд ой модны эзлэх талбай (%)	Ойн хамгаалалтыг хэмжих үзүүлэлт	FAO FRA, SDG 15.1.1
Улаан номонд орсон амьтдын индекс	Биологийн олон талт байдлын үзүүлэлт	IUCN, UN SDG 15.5.1
Цэвэр усны татан авалтын хувь (%)	Усны даралтын үзүүлэлт	FAO AQUASTAT, SDG 6.4.2
Экосистем сэргээх хувь (га/жил)	Биологийн нөхөн сэргээх ажлыг хэмжих үзүүлэлт	UNEP, CBD
7. НОГООН САНХҮҮЖИЛТ, ЭДИЙН ЗАСГИЙН ХӨШҮҮРЭГ		
Ногоон бондын хэмжээ (USD)	Ногоон санхүүгийн хэрэгсэл	Climate Bonds Initiative, OECD
Байгаль орчинд зарцуулж буй төсвийн зарцуулалт	Засгийн газрын тогтвортой байдлын хөрөнгө оруулалт	OECD, IMF
Нүүрс хүчлийн татвар эсвэл үр ашигтай байдлын үнэлгээ (USD/tCO ₂)	Нүүрсхүчлийн үнэлгээний систем	OECD, World Bank Carbon Pricing Dashboard
Чулуужсан түлшний татаас (% ДНБ эсвэл USD)	Чулуужсан түлшний дэмжлэг	IEA, IMF
ESG хөрөнгө оруулалтын хувь (% нийт хөрөнгө)	Байгаль орчин, нийгэм, засаглалын ил тод байдал	UN PRI, WEF
8. БОЛОВСРОЛ, ИННОВАЦИ БА НОГООН УР ЧАДВАР		
Ногоон ажлын байрны эзлэх хувь (%)	Ногоон ажлын байрууд	ILO, UNEP
Хичээлийн хөтөлбөрт байгаль орчин, тогтвортой байдлын боловсрол (%)	Боловсролын тогтолцоо	UNESCO SDG 4.7.1
Байгаль орчны технологид судалгаа хөгжүүлэлтийн зардал (% ДНБ)	Инновацийн зардал	OECD, UNESCO
Ногоон технологийн патентуудын тоо	Технологийн дэвшил	WIPO, OECD
Байгаль орчны хөтөлбөрт иргэний оролцох хувь (%)	Олон нийтийн оролцоо	UNEP, үндэсний статистик

5. Манай улсад хэрэгжүүлэх боломжтой шинэчлэлүүд

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, түүнчлэн хөгжлийн чиг хандлагад нийцсэн, өрсөлдөх чадвартай, дижитал болон ногоон шилжилтэд бүрэн шилжсэн улс болохын тулд цогц, системтэй шинэчлэл шаардлагатай байна. Үүний хүрээнд дараах гурван шилжилт нь үндэсний хөгжлийн шинэ загвар, хөгжлийн ирээдүйн чиг хандлагад нийцүүлэн шинэ түвшинд хүргэх, өрсөлдөх чадвар бүхий, мэдлэгт суурилсан, байгальд ээлтэй, хүний хөгжлийг дэмжсэн нийгэм, эдийн засгийн тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн цогц гурван шилжилтийг бодлогоор дэмжих, хэрэгжүүлэх явдал юм.

Үүнд:

- Хиймэл оюун ухаан ба технологийн шилжилт
- Ногоон шилжилт
- Хүний нөөцийн шилжилт багтана.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан шинжлэх ухаан, өндөр технологийн хурдтай хөгжил, хиймэл оюун ухаанд суурилсан аж үйлдвэрийн 5, 6 дугаар хувьсгалтай хөл нийлүүлэн алхаж, шинэ эдийн засгийн бүтцийг бий болгохын тулд дараах гурван шилжилтийг салбар бүрд хийх шаардлагатай. Үүнд:

Хиймэл оюун ухаан, өндөр технологийн шилжилт:

- Их өгөгдөлд суурилсан төлөвлөлт, хөрөнгө оруулалт, бизнесийн орчинг бүрдүүлэх
- Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүдийн бүтээмжийг нэмэгдүүлэх
- Төрийн бүтээмж, гүйцэтгэл, үнэлгээний уялдаа холбоог хангах
- Төрийн үйлчилгээний оновчтой, хүртээмжтэй байдлыг сайжруулах

Ногоон хөгжлийн шилжилт:

- Цэвэр эрчим хүч, сэргээгдэх эрчим хүчний шилжилт
- Цахилгаан автомашины хэрэглээний шилжилт
- Ногоон байгууламжийн стандарт, орчны бохирдлыг бууруулах
- Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, бэлчээр, усны нөөцийн асуудлыг шийдвэрлэх

Хүний нөөцийн шилжилт:

- Боловсролын салбар, хөдөлмөрийн зах зээлийн уялдааг сайжруулах
- Нийгмийн даатгал, татварын орчин, орон сууц, Үндэсний баялгийн сангийн уялдаа холбоог хангах
- Хөдөлмөрийн үнэлэмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зэрэг асуудлууд багтаж байна.

Ашигласан материал

EEB. (2024). The European Green Deal (EGD)., (хуудсд. 1-6).

GGGI. (2021). GREEN GROWTH INDEX 2021.

Hippe, R., & Fouquet, R. (2015 оны March 17). The human capital transition and the role of policy. www.lse.ac.uk: <https://www.lse.ac.uk/granthaminstitute/publication/the-human-capital-transition-and-the-role-of-policy>

IEA. (2021). Net Zero by 2050 - A Roadmap for the Global Energy Sector.

IIEA. (2025). Digital. www.iiea.com: https://www.iiea.com/digital?gad_source=1&gad_campaignid=22339636043&gbraid=0AAAAAD30q8BCp2_pe5-8GkG59WxyTKZyQ&gclid=Cj0KCQiAiebIBhDmARIsAE8PGNK835MPcOg7JXmj15YFNsiA6Tqoz3Ue3W9iOLR24RvzjQelBVbfBTAAaAhtQEALw_wcB-ээс Гаргасан

ILO. (2019). Skills for a greener future: A global view. Geneva.

Invest India. (2022 оны March 23). Understanding Human Resource Capital. investindia.gov.in: <https://www.investindia.gov.in/team-india-blogs/understanding-human-resource-capital>

human-resource-capital.com-ээс Гаргасан

Jahan, S. (2018). Human resource management practice. HRMP: <https://hrmppractice.com/human-resources/>-ээс гаргасан

Kasir Pintar. (2024 оны September 6). Human Resource VS Human Capital. Kasir Pintar: <https://kasirpintar.co.id/solusi/detail/human-resource-vs-human-capital-memahami-perbedaannya?>

Majaski, C. (2024 оны October 18). Human Capital vs. Physical Capital: What's the Difference? [investopedia.com](https://www.investopedia.com/ask/answers/062616/human-capital-vs-physical-capital-what-difference.com): <https://www.investopedia.com/ask/answers/062616/human-capital-vs-physical-capital-what-difference.com>-ээс Гаргасан

McKinsey&Company. (2018). Notes from the AI frontier insights from hundreds of use cases.

Merriam-Webster. (огноо байхгүй). 'Human Capital': More Than the Sum of Its Parts. <https://www.merriam-webster.com/>: <https://www.merriam-webster.com/wordplay/human-capital-definition.com>-ээс Гаргасан

- OECD. (2018). Education 2030. The future of education and skills.
- OECD. (2024). AI principles. [www.oecd.org: https://www.oecd.org/en/topics/ai-principles.html](https://www.oecd.org/en/topics/ai-principles.html)-ээс Гаграсан
- OECD. (2025). Human capital and educational policies. [www.oecd.org: https://www.oecd.org/en/topics/sub-issues/human-capital-and-educational-policies.html](https://www.oecd.org/en/topics/sub-issues/human-capital-and-educational-policies.html)-ээс Гаграсан
- Sharma, M. (2024). Difference Between Human Resources and Human Capital. [www.pw.live: https://www.pw.live/commerce/exams/human-resources-and-human-capital](https://www.pw.live/commerce/exams/human-resources-and-human-capital)
- The Economic Times. (огноо байхгүй). What is "Human Resources". [https://economictimes.indiatimes.com/: https://economictimes.indiatimes.com/definition/human-resources-ээс Гаграсан](https://economictimes.indiatimes.com/https://economictimes.indiatimes.com/definition/human-resources-ээс Гаграсан)
- UNDP. (2021). DIGITAL STRATEGY 2022 — 2025.
- UNESCO. (2024). Futures of Education 2050. [unesco.org: https://www.unesco.org/en/futures-education/publications?hub=81942](https://www.unesco.org/en/futures-education/publications?hub=81942)-ээс Гаграсан
- UNESCO. (2024). Recommendation on the Ethics of Artificial Intelligence.
- United Nations. (2020). Transforming our world: the 2030 Agenda for Sustainable Development. [www.sdgn.org: https://sdgs.un.org/2030agenda](https://sdgs.un.org/2030agenda)-ээс Гаграсан
- Vespoli, L. (2021). Where Watson went wrong. [mmm-online.com: https://www.mmm-online.com/home/channel/features/where-watson-went-wrong/](https://www.mmm-online.com/home/channel/features/where-watson-went-wrong/)-ээс Гаграсан
- WEF. (2018-2025). Futures of jobs.
- WEF. (2020). Global Competitiveness Report Special Edition 2020: How Countries are Performing on the Road to Recovery.
- WEF. (2025). Fostering Effective Energy Transition 2025. Geneva.
- World Bank. (2020). 2020 GovTech Maturity Index Findings - What are the Key Findings of 2020 GTMI? [www.worldbank.org: https://www.worldbank.org/en/programs/govtech/2020-gtmi](https://www.worldbank.org/en/programs/govtech/2020-gtmi)-ээс Гаграсан
- World Bank Group. (2020). Climate change action plan 2021-2025.
- World bank group. (огноо байхгүй). Human Capital Project. [www.worldbank.org: https://www.worldbank.org/en/publication/human-capital](https://www.worldbank.org/en/publication/human-capital)-ээс Гаграсан
- World Economic Forum . (2025). The Global Risks Report 2025 (20th Edition). Geneva: World Economic Forum .

ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ ЗУРГААС





Ц.ДОЛГОРМАА

СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭНИЙ
ХӨТӨЛБӨР

Мэргэжилтэн

ХҮНИЙ КАПИТАЛЫН ШИЛЖИЛТ БА УР ЧАДВАРЫН ХӨГЖИЛ



Ч.ГЭРЭЛЧУЛУУН

МАРКЕТИНГИЙН
ХӨТӨЛБӨР

Мэргэжилтэн

АГУУЛГА

ОРШИЛ.....	27
1. ХҮНИЙ КАПИТАЛЫН ШИЛЖИЛТ.....	27
1.1 Хүний капиталын шилжилтийн тодорхойлолт.....	27
1.2 Хүний капиталын шилжилтийн үндсэн төрлүүд.....	27
2. МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ШИЛЖИЛТ, ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.....	29
2.1. Монгол Улсын хүний нөөц ба хөдөлмөрийн зах зээл (2025).....	29
2.2. Монгол Улсын хүний нөөцийн шилжилт, ур чадварын үндэсний бодлого, хууль эрх зүй ба хэрэгжилтийн үнэлгээ.....	31
2.3. Монгол Улсын хүний нөөцийн шилжилтийн шалгуур үзүүлэлт ба боловсрол, ур чадвар ба хөдөлмөрийн зах зээлийн бэлэн байдлыг олон улстай харьцуулсан үнэлгээ.....	35
Дүгнэлт.....	39
Эх сурвалж.....	39

Хүснэгт 1. 2024–2025 оны III улирлын дундаж цалингийн өөрчлөлтийн дүгнэлт, харьцуулалт	29
Хүснэгт 2. Боловсролын салбарын хууль, дүрэм, бодлогын баримт бичгийн жагсаалт	31
Хүснэгт 3. Монгол Улсад ажиллах хүчний чадварыг нэмэгдүүлэх, сайжруулах чиглэлтэй салбарын хууль, дүрэм, бодлогын баримт бичгийн жагсаалт	32
Хүснэгт 4. Насан туршийн боловсрол, мэдлэг олгох процесст чиглэсэн хууль, бодлого, хөтөлбөрүүд	32
Хүснэгт 5. Хөдөлмөрийн зах зээл, нийгмийн хамгааллын салбарын шинэчлэлтэй холбоотой гол хууль, стратеги, бодлого	33
Хүснэгт 6. Үндэсний хүний нөөцийн хөгжлийн стратеги боловсруулахтай холбоотой гол хууль, стратеги, бодлого	33
Хүснэгт 7. Инноваци, стартап, энтерпренэршип холбоотой гол хууль, стратеги, бодлого	34
Хүснэгт 8. Тэгш байдал, хүртээмжтэй боловсрол, хүйсийн чадавхыг нэмэгдүүлэхтэй холбоотой гол хууль, стратеги, бодлого	34
Хүснэгт 9. Манлайлал ба институтийн чадавхыг бэхжүүлэхтэй холбоотой гол хууль, стратеги, бодлого	34
Хүснэгт 10. Боловсролын хамрагдалт ба ур чадварын үзүүлэлтүүд	35
Хүснэгт 11. Ур чадвар ба ажиллах хүчний шилжилтийн үзүүлэлтүүд	36
Хүснэгт 12. Ажлын чанар болон, бүтээмжийн үзүүлэлтүүд	37
Хүснэгт 13. Байгууллагын үйл ажиллагаа болон засаглалын үзүүлэлтүүд	37
Хүснэгт 14. Оролцоо ба тэсвэртэй байдлын үнэлгээ	38
Хүснэгт 15. Хүний капитал, ур чадвар, инновацийн үзүүлэлтүүд	38

ОРШИЛ

Дэлхийн эдийн засгийн өнөөгийн нөхцөлд улс орны өрсөлдөх чадвар нь байгалийн баялаг болон уламжлалт үйлдвэрлэлийн хүчин зүйлсээс илүүтэйгээр хүний капиталын чанар, инновацийн экосистемийн чадавх, хөдөлмөрийн зах зээлийн уян хатан байдалд тулгуурлаж байна.

Монгол Улсын эдийн засагт ажиллах хүч, хөрөнгө оруулалт, бодлого-зохицуулалт нэг салбарт хэт төвлөрөх байдал нь олон тулгуурт хөгжлийг сааруулж байна. Иймд эдийн засгийн бүтцийг төрөлжүүлэх зорилгоор бүтээлч үйлдвэрлэл, мэдээллийн технологи, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, боловсруулах үйлдвэрлэл зэрэг шинэ өсөлтийн салбаруудад чиглэсэн хөрөнгө оруулалт, хүний нөөцийн бодлогын нэгдсэн стратеги боловсруулах шаардлагатай байна.

2024 оны судалгаагаар Монгол Улсын хөдөлмөрийн насны хүн амын 58 хувь нь ажил эрхэлж байгаа бөгөөд

хөдөлмөрийн зах зээлд шаардлагатай ур чадварын зөрүү 20–30 хувьтай байгааг олон улсын байгууллагуудын үнэлгээ харуулдаг. (World Bank -Mongolia: Employment Diagnostic (2023–2024))

Сүүлийн жилүүдэд боловсролын тогтолцооны үр өгөөж болон мэргэжлийн боловсрол, сургалтын хүртээмж нэмэгдэж байгаа хэдий ч хөдөлмөрийн зах зээлд ажлын байранд шаардагдах ур чадварын түвшин хангалтгүй хэвээр байна. Олон улсын туршлагаас үзэхэд насан туршид үргэлжлэх сургалтын тогтолцоо, хувийн хэвшлийн оролцоонд тулгуурласан ур чадварын шилжилт нь энэхүү зөрүүг нөхөх гол хүчин зүйл болж байна. Иймд энэхүү судалгааны зорилго нь олон улсын сайн туршлага, хүний нөөцийн шилжилтийн шалгуур үзүүлэлт, боловсрол–ур чадвар–хөдөлмөрийн зах зээлийн уялдаа, бэлэн байдлыг харьцуулан үнэлж, Монгол Улсад хүний нөөцийн ур чадварын шилжилтийг хэрэгжүүлэх бодлогын шийдлийг санал болгоход оршино.

1. Хүний капиталын шилжилт

Судлагдсан байдал

Хүний капиталын шилжилт ба хүний нөөцийн шинэчлэл нь улс орон бүрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн гол хөдөлгөгч хүч болж болдог. Хөдөлмөрийн зах зээлийн хурдтай өөрчлөлт, технологийн дэвшил, хүн амын бүтцийн өөрчлөлт зэрэг сорилтуудад хариу өгөхийн тулд хүний нөөцөө оновчтой шилжүүлэн хөгжүүлэх бодлого хэрэгжүүлж иржээ.

McKinsey Global Institute-ийн 2023 “From poverty to empowerment: Raising the bar for sustainable and inclusive growth” тайланд дурдсанаар, ур чадварын шинэчлэл, дахин сургах бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлснээр аливаа улсын ДНБ-ний өсөлт жилд дунджаар 0.8-1.2 хувиар нэмэгдэх боломжтой гэжээ.

Дэлхийн эдийн засгийн форумаас эрхлэн гаргасан “Ажлын байрны ирээдүй 2025” тайланд дурдсанаар 2025 он гэхэд дэлхийн бүх ажилтны 50 хувь нь шинэ ур чадвар эзэмших шаардлагатай гэж тооцоолсон байна. Тус тайланд “Ажлын байр хадгалах, хөдөлмөрийн эрэлтэд нийцэх хамгийн гол хүчин зүйл нь тасралтгүй суралцах, ур чадвараа шинэчлэх (reskilling & upskilling) процесс” хэмээн тодорхойлжээ.

Мөн ЮНИСЕФ-ийн Монгол дахь төлөөлөгчийн газраас 2015–2030 оны Тогтвортой хөгжлийн зорилгуудын хүрээнд боловсруулсан баримт бичигт насан туршийн боловсролыг чанартай боловсрол олгох тогтолцооны салшгүй хэсэг гэж үзсэн байна.

1.1 Хүний капиталын шилжилтийн тодорхойлолт

Академик тодорхойлолт: Хүний нөөцийн шилжилт нь хөдөлмөрийн зах зээлийн бүтцийн өөрчлөлт, технологийн

дэвшил, нийгэм-эдийн засгийн шинэ шаардлагад нийцүүлэх зорилгоор хүний ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын хэлбэр, байгууллагын бүтэц зэрэгт гарч буй зохион байгуулалттай өөрчлөлт, дасан зохицох үйл явцыг хэлнэ.

Бодлогын хүрээнд: Энэ нь улс орны эдийн засгийн тогтвортой өсөлт, бүтээмжийн өсөлтийг хангахын тулд иргэдийн боловсрол, мэргэжил, ур чадварыг ирээдүйн хөдөлмөрийн эрэлттэй уялдуулах бодлогын шилжилт юм.

1.2 Хүний капиталын шилжилтийн үндсэн төрлүүд

Салбар хоорондын шилжилт: (Structural transition) Ажиллах хүч нэг салбараас нөгөөд шилжих (жишээ нь: хөдөө аж ахуй → үйлчилгээ → мэдээллийн технологи). Эдийн засгийн бүтцийн өөрчлөлттэй шууд холбоотой.

Технологийн шилжилт: (Technological transition): Автоматжуулалт, хиймэл оюун ухаан, зэрэг шинэ технологи нэвтрэхтэй холбоотой ур чадварын шинэчлэл. “Reskilling”, “Upskilling” үйл явц энд хамаарна.

Демографийн шилжилт: (Demographic transition): Насжилт, хүн амын бүтцийн өөрчлөлтөөс шалтгаалсан хөдөлмөрийн хүчний бүтэц, эрэлт өөрчлөгдөх.

Байгууллагын шилжилт: (Organizational transition): Байгууллагын менежмент, хүний нөөцийн удирдлагын арга барил шинэчлэгдэх (жишээ нь: уян хатан хөдөлмөр, алсын ажил, төслийн хэлбэрийн ажил).

Нийгэм-соёлын шилжилт: (Socio-cultural transition) Ажиллах хүчний хандлага, үнэт зүйл, хөдөлмөрийн соёл, ажил ба амьдралын тэнцвэрийн талаарх ойлголт өөрчлөгдөх.

Түүхэн талаасаа - Хүний нөөцийн шилжилтийн үе шат

Хүний нөөцийн шилжилтийн үе шат гэдэг ойлголт нь дэлхий дахинд байгууллагуудын ажиллах хүчний менежмент, бүтэц, чадварын хөгжил, ажлын байрны соёл зэрэгт гарч буй технологийн, нийгмийн, эдийн засгийн өөрчлөлтүүдтэй уялдан хувьсаж байгаа явцыг илэрхийлдэг.

Зураг 1-д хүний капиталын хөгжил болон хүний нөөцийн удирдлагын хувьслыг дэлхийн эдийн засгийн бүтцийн өөрчлөлт, технологийн дэвшилтэй уялдуулан таван үе шат болгон харуулсан байна. Эхний үе шат буюу Хүний капитал 1.0 нь аж үйлдвэржилтийн үед хамаарах бөгөөд хөдөлмөрийн гол үнэлэмж нь үйлдвэрлэлийн бүтээмж, физик хөдөлмөр байв. Харин Хүний капитал 2.0 үед мэдлэг, боловсрол, судалгаа, технологийн чадавх эдийн засгийн өсөлтийн гол хүчин зүйл болж, хүний нөөцийн удирдлага нь ажилтны ур чадвар хөгжүүлэх, байгууллагын стратегитай уялдах чиглэлд төвлөрсөн байна. 2000-аад оноос хойш дижитал технологийн эрчимтэй хөгжил нь Хүний капитал 3.0 үеийг бий болгож, мэдээллийн технологи, платформ эдийн засаг,


инновацын чадамж хөдөлмөрийн зах зээлийн бүтэц, байгууллагын үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлсэн. Үүний дараагийн үе шат болох Хүний капитал 4.0 нь хиймэл оюун ухаан, автоматжуулалт, робот технологийн нөлөөгөөр тодорхойлогдож, хүн ба технологийн хамтын ажиллагаа хөдөлмөрийн бүтээмжийн гол эх үүсвэр болж байна. Ирээдүйд Хүний капитал 5.0 нь хүний бүтээлч чадвар, стратегийн сэтгэлгээ, нийгмийн үнэ цэнтэй уялдуулан технологийн дэвшлийг ашиглах хүний төвтэй эдийн засгийн загварыг илэрхийлэх юм. Монгол Улсын хүний нөөцийн тогтолцооны өнөөгийн төлөв нь Хүний капитал 2.5–3.0 үеийн хоорондох шилжилтийн шат буюу уламжлалт бүтэц, сургалт, гүйцэтгэлийн үнэлгээнд суурилсан хүний нөөцийн удирдлага давамгайлж байгаа боловч дижитал технологийн хэрэглээ, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт, шинэ ур чадварын эрэлт нэмэгдэж байгааг харуулж байна. Энэ нь хүний нөөцийн тогтолцоог богино хугацаанд дижитал болон инновацад суурилсан шинэ шат руу шилжих боломж бүрдүүлж байна.

Зураг 1. Хүний капиталын шилжилт ба хүний нөөцийн шилжилтийн үе шат

Хүний капитал нь → улсын болон эдийн засгийн түвшний мэдлэг, ур чадвар, бүтээмж, инновацын чадавх .

Хүний нөөц (HR) нь → байгууллагын түвшний удирдлага, систем, гүйцэтгэл, соёл.

Хүний капитал нь макро түвшний өрсөлдөх чадвар, харин HR нь микро түвшний удирдлагын механизм юм.



Монгол Улсын хүний капитал ба хүний нөөцийн өнөөгийн байдлыг бодит тоон үзүүлэлтээр дүгнэсэн тойм

Үзүүлэлт	Тоо / Байдал	Огноо	Тайлбар
ДНБ (нийт)	~25 тэрбум ам.доллар	2025	Монгол Улс хөгжиж буй дундаас дээш орлоготой ангилалтай эдийн засагтай болсон.
Нэг хүнд ногдох ДНБ	~7,000 ам.доллар	2025	Нэг хүнд ногдох орлого нь дунджаас доогуур ч өсөлттэй хэвээр байна.
Ажилгүйдэл	~5–6%	2024–2025	Хөдөлмөрийн зах зээл тогтвортой.

Монгол Улсын өнөөгийн байдал Хүний капитал 2.5–3.0 түвшинд гэж дүгнэж болно.

- Ур чадварын бүтэц → 2.0–3.0 шилжилт
- Дижитал нэвтрэлт → 3.0 эхлэл
- Насан туршийн боловсрол → 4.0 шаардлагатай

Эх сурвалж: YCX

Эх сурвалж: WEF

2. Монгол улсын хүний нөөцийн шилжилт, өнөөгийн нөхцөл байдал

2.1. Монгол Улсын хүний нөөц ба хөдөлмөрийн зах зээл (2025)

Хүн амын бүтэц: Монгол Улс хүн ам зүйн хувьд залуу, ажиллах насны хүн ам давамгайлсан бүтэцтэй хэвээр байна. 2025 онд нийт 3.54 сая хүн амын 69 хувь нь хөдөлмөрийн насанд хүрсэн бөгөөд үүний 58 хувь нь ажил эрхэлж, 36 хувь нь хөдөлмөрийн зах зээлд оролцохгүй байгаа нь ашиглагдаагүй нөөц ихтэй, ажил эрхлэлтийн чанар, ур чадварын нийцлийг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

Хүснэгт 1. 2025 оны III улирлын байдлаар улсын дундаж цалин өмнөх оны мөн үеэс 9 хувиар өсөж, 2.7 сая төгрөгт хүрсэн нь нэрлэсэн орлогын өсөлт хадгалагдаж байгааг харуулж байна. Гэвч энэхүү өсөлт нь салбаруудын дунд жигд бус, эдийн засгийн бүтцийн тэнцвэргүй байдлыг гүнзгийрүүлж байна. Өндөр цалинтай салбарууд (уул уурхай, эрчим хүч, санхүү, үл хөдлөх) нь нийт ажиллах

хүчний 10 хүрэхгүй хувийг хамарч байгаа атлаа, заримд нь (ялангуяа уул уурхай, олон улсын байгууллага) цалин буурсан нь эдийн засгийн өсөлтийн тогтвортой эх үүсвэр биш байгааг илтгэнэ. Энэ нь эдгээр салбаруудын цалингийн давуу тал эдийн засгийг өргөн хүрээнд “чирэх” боломж хязгаарлагдмал хэвээр байгааг харуулж байна.

Нөгөө талд, ажиллагсдын дийлэнхийг (хөдөө аж ахуй, худалдаа, барилга, боловсрол, төрийн үйлчилгээ) шингээдэг салбаруудын цалин улсын дунджаас доогуур түвшинд хадгалагдаж, өсөлт нь 8–15 хувь орчим байгаа нь орлогын өсөлт өрхийн амьжиргаанд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхэд хангалтгүй байгааг харуулж байна. Ялангуяа хөдөө аж ахуй нийт ажиллагсдын дөрөвний нэгийг хамарч байгаа боловч цалингийн түвшин доогуур хэвээр байгаа нь орлогын тэгш бус байдлын гол эх үүсвэр болж байна. Эерэг дохио нь боловсруулах үйлдвэрлэл, дэд бүтэцтэй холбоотой салбаруудын (цахилгаан, ус, тээвэр) цалин харьцангуй хурдтай өссөн явдал юм. Ялангуяа боловсруулах үйлдвэрлэлд цалин 27 хувиар өссөн нь бүтээмжид суурилсан, илүү тогтвортой өсөлтийн боломжит тулгуур салбар болж байгааг харуулж байна.

Хүснэгт 1. 2024–2025 оны III улирлын дундаж цалингийн өөрчлөлтийн дүгнэлт, харьцуулалт

САЛБАР	2024-III ДУНДАЖ ЦАЛИН (МЯН.₮)	2025-III ДУНДАЖ ЦАЛИН (МЯН.₮)	ӨӨРЧЛӨЛТ (МЯН.₮)	ӨӨРЧЛӨЛТ (%)	АЖИЛЛАГСДЫН ТОО	АЖИЛЛАГСДЫН ЭЗЛЭХ ХУВЬ (%)
Улсын дундаж	2,480	2,714	234	9	1,393,668	100
Уул уурхай, олборлолт	5,197	4,871	-326	-6	95,803	7
Цахилгаан, хий, агааржуулалт	3,040	3,558	518	17	15,099	1
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	3,062	3,413	351	11	23,769	2
Үл хөдлөх хөрөнгийн үйлчилгээ	2,730	3,386	657	24	2,468	0
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техник	2,806	3,127	321	11	19,371	1
Тээвэр ба агуулахын үйлчилгээ	2,788	3,116	328	12	80,641	6
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	4,576	3,112	-1,464	-32	895	0
Хүн хөдөлсөн ажиллуулдаг ерөнхий үйлчилгээ	2,513	2,940	427	17	4,004	0
Төрийн удирдлага, батлан хамгаалах болон нийгмийн хамгаалал	2,591	2,919	329	13	97,599	7
Боловсруулсан үйлдвэрлэл	2,272	2,889	618	27	119,180	9
Мэдээлэл, холбоо	2,600	2,769	169	6	14,048	1
Ус хангамж; бохир ус зайлуулах систем, хог, цэвэрлэгээ	2,242	2,650	408	18	8,252	1
Хүний эрүүл мэнд, нийгмийн үйл ажиллагаа	2,444	2,641	198	8	60,567	4
Барилга	2,237	2,426	189	8	110,817	8
Үйлчилгээний бусад үйлчилгээ	2,172	2,417	245	11	28,457	2
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	2,239	2,394	155	7	16,554	1
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1,981	2,276	295	15	353,913	25
Боловсрол	1,990	2,240	250	13	116,083	8
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	1,995	2,162	167	8	174,885	13
Урлаг, үзвэр, тоглоом, наадам	2,045	2,159	113	6	9,576	1
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	1,612	1,830	218	14	41,687	3

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хөдөлмөрийн бүтээмж: Монгол Улсын хөдөлмөрийн бүтээмж нь эдийн засагт ажиллагч нэг хүний бий болгож буй ДНБ-ийн хэмжээгээр илэрхийлэгдэж, эдийн засгийн өсөлтийн чанар, иргэдийн орлогын тогтвортой өсөлтийг тодорхойлох үндсэн үзүүлэлт юм.

График 1. Нэг ажилчинд ногдох ДНБ 2024 он



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


2024 онд нэг ажилчинд ногдох ДНБ-ийн хэмжээ салбар хооронд ихээхэн ялгаатай байгааг уг график харуулж байна. Энэ нь Монгол Улсын эдийн засагт хөдөлмөрийн бүтээмж жигд бус хуваарилагдсан хэвээр байгааг илтгэнэ.

Салбар хоорондын хөдөлмөрийн бүтээмжийн зөрүү их байгаа нь эдийн засгийн өсөлтийн чанарыг сулруулж, орлогын тэгш бус байдлыг гүнзгийрүүлэх эрсдэлтэй. Иймд дундаж болон доогуур бүтээмжтэй салбаруудад технологи, менежмент, ур чадварын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, мөн өндөр бүтээмжтэй салбаруудаас мэдлэг, технологи дамжуулах бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хотжилт ба төвлөрөл: Нийслэл Улаанбаатар хотод хүн амын 47 хувь төвлөрч, жилд дунджаар 3.3 хувиар өсөж байна. Орон нутагт хүн амын төвлөрөл буурч, хөдөлмөрийн нөөцийн хомсдол үүсэж байгаа нь бүс нутгийн хөгжлийн ялгаа, нийслэл хот дахь зах зээлийн хэт өрсөлдөөн, орон нутгийн эдийн засгийн идэвх сулралттай холбогддог. Ажлын байрны тэнцвэрт байдалд дэд бүтэц, хөрөнгө оруулалт, орон сууц, сургалтын зээл, татварын урамшууллын бодлого шаардлагатайг харуулж байна.

2024 онд бизнесийн секторын хөдөлмөрийн бүтээмжийн өөрчлөлт салбар хооронд ихээхэн ялгаатай байгааг график харуулж байна. Зарим салбарт бүтээмж огцом өссөн бол нөгөө хэсэгт бодит уналт ажиглагдсан нь эдийн засгийн бүтцийн тэнцвэргүй байдлыг илтгэж байна.

График 2. Бизнесийн секторын хөдөлмөрийн бүтээмжийн жилийн өөрчлөлт 2024 он



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Боловсрол ба хөдөлмөрийн уялдаа: Залуучуудын ажилгүйдэл 14.7 хувь (насанд хүрэгчдийн дунджаас хоёр дахин их), мэргэжлийн боловсролын төгсөгчдийн 35 хувь нь нэг жилийн дотор ажилгүй үлдэж байгаа зэрэг нь боловсролын систем хөдөлмөрийн зах зээлийн бодит эрэлттэй бүрэн нийцэхгүй байгааг илтгэнэ.

Гадаад хөдөлмөрийн шилжилт: Ойролцоогоор 200,000 Монгол иргэн гадаадад ажиллаж, суралцаж байна (ихэнх нь 30 хүртэлх насны дээд боловсролтой залуучууд).

Дижитал хүртээмж: Өрхийн интернэт холболт хотод 84 хувь, хөдөө орон нутагт 58 хувьтай байна. Боловсролын салбарт 705 төрийн өмчит ерөнхий боловсролын сургууль 100 хувь интернэт холболттой ч, 20 сурагч тутамд 1 компьютер ногддог байна. Хот-хөдөөгийн дижитал ялгаа нь иргэдийн хөдөлмөрийн зах зээлд оролцох боломж, ур чадварын тэгш бус байдлыг нэмэгдүүлж байна.

Энэ нөхцөлд хүний нөөцийн шилжилтийг дэмжих найман чиглэл-боловсролын чанар, ур чадварын шинэчлэл, хөдөлмөрийн зах зээлийн өрсөлдөх чадвар, ажилтны сайн сайхан байдал, амьдралын чанар, инноваци ба R&D, дижитал шилжилт, институтын засаглал-нь бидний хэрэгжүүлэх ёстой стратегийн үндэс юм.

Иймээс хүний нөөцийн шилжилт нь зөвхөн нэг салбарын бус, харин боловсрол, хөдөлмөр, инноваци, нийгмийн хамгаалал, засаглалын тогтолцоог уялдуулсан, тогтвортой хөгжилд нийцсэн шинэчлэлийг бүхэлд нь хэрэгжүүлэх явдал юм.

2.2. Монгол Улсын хүний нөөцийн шилжилт, үр чадварын үндэсний бодлого, хууль эрх зүй ба хэрэгжилтийн үнэлгээ

Монгол Улсын хүний нөөцийн шилжилт нь боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, инноваци, дижитал шилжилт зэрэг суурь салбаруудад хэрэгжиж буй хууль, эрх зүйн зохицуулалт, бодлогын баримт бичиг, үндэсний хөтөлбөрүүдийн хүрээнд тодорхойлогдож байна.

Тайлбар: Судалгаанд хамрагдсан бодлогын баримт бичгүүдийн дийлэнх нь хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт нь (KPI) тодорхой тоон хэмжүүрээр илэрхийлээгүй, харин зорилтын түвшний ерөнхий тодорхойлолт давамгайлж байна. Хэмжигдэхүйц шалгуур бүхий жишээ нь сургууль төгсөгчдийн ажилд орох хувь, насан туршийн сургалтын хамрагдалт зэрэг хязгаарлагдмал байна. Иймээс доорх хүснэгтэд олон улсын туршлага, боловсролын хүртээмж ба чанарын үнэлгээ, үр чадварын өсөлтийн шалгуурыг харгалзан тоон үзүүлэлтүүдийг жишиг хувилбараар тодорхойлсон болно.

Хүснэгт 2. Боловсролын салбарын хууль, дүрэм, бодлогын баримт бичгийн жагсаалт

БАРИМТ БИЧИГ	ОН	ТӨРӨЛ	ДЭД ТӨРӨЛ	ЗОРИЛТ (ТОВЧ)	ХАРИУЦСАН БАЙГУУЛЛАГА	ХЭРЭГЖИЛТ ШАЛГУУР / KPI	ТАЙЛБАР / НЭМЭЛТ
Алсын хараа-2050	2020	Урт хугацааны бодлого	Үндэсний стратеги	Хүний капитал, боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх	ЗГ, БШУЯ	Хүний капиталын индекс ≥ 0.75 , боловсролд хамрагдсан хүүхэд $\geq 95\%$	Улс орон даяар боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх гол баримт бичиг
2025–2030 оны дунд хугацааны бодлого (шинэчлэгдсэн)	2025	Дунд хугацааны бодлого	Төлөвлөгөө	Боловсролын чанар, хүртээмжийг сайжруулж, багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих	ЗГ, БШУЯ	Багшийн МДХ ≥ 500 /жил; сургалтын чанарын үнэлгээ $\geq 80\%$	2021–2025 оны шинэчлэлийг дараагийн шатанд гаргах
Шинэ сэргэлтийн бодлого	2021	Макро бодлого	Эдийн засгийн хөгжлийн бодлого	Үр чадвар, инноваци, дижитал шилжилтийг дэмжих	ЗГ, БШУЯ	Инновацийн индекс $\geq 50/100$, дижитал боловсролд хамрагдсан сурагч $\geq 70\%$	Хүний капитал – эдийн засгийн өсөлтийн уялдаа
Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2024–2028)	2024	Засгийн газрын хөтөлбөр	Салбарын үйл ажиллагаа	СӨБ, ЕБС, Дээд боловсролын хөтөлбөр шинэчлэх	ЗГ, БШУЯ	Хөтөлбөрийн шинэчлэл $\geq 80\%$; СӨБ, ЕБС-ийн хүртээмж $\geq 90\%$	Боловсролын бүх түвшинд шинэчлэлийг хэрэгжүүлэх арга хэмжээ
Жилийн хөгжлийн төлөвлөгөөнүүд (2024–2026)	Жил бүр	Жилийн төлөвлөгөө	Салбарын үйл ажиллагаа	Багшийн хөгжил, кластер их сургууль, дижитал сургалтыг зохион байгуулах	ЗГ, БШУЯ	Багшийн сургалт $\geq 1,000$ хүн/жил, дижитал хичээл $\geq 1,500$ цаг/жил	Жил бүрийн хэрэгжилтийг тодорхойлох, дижитал боловсролыг дэмжих
Боловсролын тухай хууль	2002 (шинэчлэсэн) 2022)	Салбарын хууль	Үндсэн хууль	Боловсролын тогтолцоо, зарчим, бүтэц, эрх зүй орчинг бүрдүүлэх	БШУЯ	Сургалтын стандартын мөрдөлт $\geq 95\%$	Боловсролын үндсэн суурь, бодлогын эрх зүйн орчин
Сургуулийн өмнөх боловсролын хууль	2008	Салбарын хууль	СӨБ	СӨБ хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх	БШУЯ	СӨБ-д хамрагддаг хүүхдийн хувь $\geq 85\%$, багшийн тоо/хүүхэд $\geq 1:20$	Хүүхэд бүрийн хөгжлийг дэмжих, хүртээмжийг нэмэгдүүлэх
ЕБС-ийн шинэ стандарт	2023	Стандарт	Сургалтын стандарт	Компетенц суурьтай сургалт чанарыг сайжруулах	БШУЯ	Сургалтын үр дүнгийн үнэлгээ $\geq 80\%$, чадварын тест $\geq 75\%$	ЕБС-ийн сургалтын чанарыг сайжруулах
Мэргэжлийн боловсролын тухай хууль	2009	Салбарын хууль	МСҮТ	МСҮТ, ажил олгогчийн түншлэл чадварыг нэмэгдүүлэх	БШУЯ, ХНХЯ	Оролцогч аж ахуйн нэгж ≥ 50 , төгсөгчдийн ажилд орсон хувь $\geq 70\%$	Ажил мэргэжлийн үр чадварыг нэмэгдүүлэх
Дээд боловсролын тухай хууль	2002 (шинэчсэн) 2020)	Салбарын хууль	Их сургууль	Засаглал, санхүүжилт, чанарыг сайжруулах	БШУЯ	Их сургуулийн чанарын үнэлгээ $\geq 80\%$, санхүүгийн ил тод байдал $\geq 90\%$	Дээд боловсролын тогтолцоо, сургалтын чанарыг сайжруулах
Насан туршийн боловсролын үндэсний хөтөлбөр	2017	Хөтөлбөр	LLL	Иргэн бүрийн насан туршийн боловсролын оролцоог нэмэгдүүлэх	БШУЯ	Насан туршийн боловсролд хамрагдсан иргэд $\geq 40\%$	Иргэдийн тасралтгүй суралцах боломжийг нэмэгдүүлэх
Шинжлэх ухаан, технологийн тухай хууль	2006	Салбар хоорондын хууль	R&D	R&D, инновацийн суурь бүрдүүлэх	БШУЯ, ШУА	Судалгааны төсөл ≥ 200 /жил, патент ≥ 50 /жил	Шинжлэх ухаан, технологийн хөгжилд суурь бүрдүүлэх
Инновацийн тухай хууль	2015	Салбар хоорондын хууль	Инновацийн экосистем	Инновацийн экосистемийг хөгжүүлэх	ЗГ, БШУЯ	Стартап ≥ 100 /жил, инновацийн төсөл ≥ 150 /жил	Улсын инновацийн экосистемийг хөгжүүлэх

Хүснэгт 3. Монгол Улсад ажиллах хүчний чадварыг нэмэгдүүлэх, сайжруулах чиглэлтэй салбарын хууль, дүрэм, бодлогын баримт бичгийн жагсаалт

БАРИМТ БИЧИГ	ОН	ТӨРӨЛ	ДЭД ТӨРӨЛ	ЗОРИЛТ (ТОВЧ)	ХАРИУЦСАН БАЙГУУЛЛАГА	ХЭРЭГЖИЛТ ШАЛГУУР / KPI	ТАЙЛБАР / НЭМЭЛТ
Хөдөлмөрийн тухай хууль	2019	Хууль	Ажиллах хүчний эрх, хөдөлмөрийн харилцаа	Ажиллах хүчний эрхийг хамгаалах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах	ХНХЯ, Хөдөлмөрийн улсын байцаагч	Ажиллах хүчний аюулгүй байдлын үзүүлэлт $\geq 95\%$, ажилгүйдлийн түвшин $\leq 5\%$	Хөдөлмөрийн гэрээ, ажлын цаг, цалин, аюулгүй ажиллагааны стандартыг зохицуулна
Нийгмийн даатгалын тухай хууль	2018	Хууль	Эрүүл мэнд, тэтгэвэр, нийгмийн хамгаалал	Ажиллах хүчний нийгмийн баталгааг сайжруулах	ХНХЯ, Нийгмийн даатгалын ерөнхий газар	Даатгалд хамрагдсан ажилтны хувь $\geq 90\%$, нийгмийн халамжийн хүртээмж $\geq 85\%$	Нийгмийн хамгаалал, тэтгэврийн системийг зохицуулна
Боловсролын тухай хууль	2021	Хууль	Ерөнхий боловсрол, дээд боловсрол	Хүний нөөцийн хөгжлийн суурь бий болгох	БШУЯ	Боловсролын чанарын үнэлгээ $\geq 80\%$, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь $\geq 75\%$	Боловсролын хүртээмж, чанар, багшийн хөгжил
Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль	2017	Хууль	Мэргэжлийн үр чадвар	Ажиллах хүчний чадвар, мэргэжлийн бэлтгэл сайжруулах	БШУЯ	Мэргэжлийн сургалтын төгсөгчдийн ажилд орох хувь $\geq 70\%$	Стандартчилсан мэргэжлийн сургалтын хөтөлбөр
Үндэсний Хүний Нөөцийн Стратеги 2020–2030	2020	Бодлогын баримт бичиг	Үр чадвар, мэргэшил	Хүний нөөцийн чанарыг дээшлүүлэх	ЗГ, ХНХЯ, БШУЯ	Үр чадварын үзүүлэлт $\geq 75\%$, ажил эрхлэлт $\geq 85\%$	Урт хугацааны стратеги, дунд хугацааны төлөвлөгөөтэй уялдсан
Алсын хараа-2050	2020	Урт хугацааны бодлого	Хүний капитал	Ирээдүйн ажиллах хүчний чадавхийг бэхжүүлэх	ЗГ, БШУЯ	Хүний капиталын индекс ≥ 0.75 , боловсролын хүртээмж $\geq 95\%$	Ирээдүйн хөдөлмөрийн хэрэгцээ, үр чадварын чиглэл
Хөдөлмөрийн зах зээлийн дунд хугацааны стратеги (2021–2025)	2021	Дунд хугацааны бодлого	Ажиллах хүчний бүтээмж	Мэргэжлийн үр чадвар, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх	ЗГ, ХНХЯ	Мэргэжлийн сургалтанд хамрагдсан ажилтны хувь $\geq 70\%$, бүтээмжийн өсөлт $\geq 5\%$ жилд	Дунд хугацааны зорилтот бүлэг, салбарын шаардлагатай үр чадвар
Насан туршийн боловсролын бодлого	2022	Бодлогын баримт бичиг	Насан туршийн сургалт	Ажиллах хүчний тасралтгүй хөгжлийг хангах	БШУЯ, Орон нутгийн боловсролын байгууллага	Насан туршийн сургалтанд хамрагдсан иргэд $\geq 40\%$	Ахмад ажилтан, дунд насны ажиллагчдын сургалт
"Skills Development Program" / Үр чадвар хөгжүүлэх хөтөлбөр	2021	Хөтөлбөр	Үр чадвар хөгжүүлэх	Үр чадвар сайтай ажиллах хүч бэлтгэх	БШУЯ, ЗГ	Төгсөгчдийн ажилд орох хувь $\geq 75\%$, мэргэжлийн үр чадварын үнэлгээ $\geq 80\%$	Сургалт, дадлага, шалгалт, гэрчилгээ
Технологийн болон инновацийн хөгжлийн бодлого	2020	Бодлогын баримт бичиг	R&D, инноваци	Технологи, инновацид суурилсан ажиллах хүчийг хөгжүүлэх	ЗГ, ШУТИС, МУИС	R&D төсөл ≥ 200 /жил, патент ≥ 50 /жил, технологийн үр чадварын өсөлт $\geq 5\%$	Шинжлэх ухаан, инновацийн төсөл, патентжуулалт, технологийн дамжуулалт

Хүснэгт 4. Насан туршийн боловсрол, мэдлэг олгох процесст чиглэсэн хууль, бодлого, хөтөлбөрүүд

БАРИМТ БИЧИГ	ОН	ТӨРӨЛ	ДЭД ТӨРӨЛ	ЗОРИЛТ (ТОВЧ)	ХАРИУЦСАН БАЙГУУЛЛАГА	ХЭРЭГЖИЛТ ШАЛГУУР / KPI	ТАЙЛБАР / НЭМЭЛТ
Насан туршийн боловсролын бодлого	2022	Бодлогын баримт бичиг	Насан туршийн сургалт	Иргэдийн тасралтгүй боловсрол, мэргэжлийн үр чадварын хөгжлийг хангах	БШУЯ, Орон нутгийн боловсролын байгууллага	Насан туршийн сургалтад хамрагдсан иргэд $\geq 40\%$, сургалтын үр дүнгийн үнэлгээ $\geq 80\%$	Ахмад болон дунд насны ажиллах хүч, насан туршийн сургалтын төвүүд
Үр чадвар хөгжүүлэх хөтөлбөр (Skills Development Program)	2021	Хөтөлбөр	Мэргэжлийн үр чадварын сургалт	Ажиллах хүчний үр чадвар, мэргэжлийг сайжруулах	БШУЯ, ЗГ	Төгсөгчдийн ажилд орох хувь $\geq 75\%$, үр чадварын үнэлгээ $\geq 80\%$	Сургалт, дадлага, шалгалт, гэрчилгээ олголт
Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль	2017	Хууль	Насан туршийн сургалтын эрх зүйн зохицуулалт	Ажиллах хүчний мэргэжлийн үр чадварын тасралтгүй хөгжлийг дэмжих	БШУЯ	Мэргэжлийн сургалтад хамрагдсан иргэд $\geq 70\%$, ажилд орох хувь $\geq 70\%$	Үр чадварын стандарт, сургалтын агуулга, гэрчилгээ
Боловсролын тухай хууль	2021	Хууль	Насан туршийн боловсролын боломж	Иргэдэд насан туршийн суралцах боломж олгох	БШУЯ	Насан туршийн боловсролын хөтөлбөрт хамрагдсан иргэд $\geq 40\%$ хамрагдсан иргэдийн хувь	ЕБС, дээд боловсрол, мэргэжлийн сургалтын насан туршийн хөтөлбөртэй уялдсан
Үндэсний Хүний Нөөцийн Стратеги 2020–2030	2020	Бодлогын баримт бичиг	Хүний капитал, үр чадварын тасралтгүй хөгжлийн стратеги	Ажиллах хүчний чадавхийг насан туршид хөгжүүлэх	ЗГ, БШУЯ	Үр чадварын үзүүлэлт $\geq 75\%$, сургалтад хамрагдсан иргэд $\geq 50\%$	Насан туршийн сургалт, мэргэжлийн хөтөлбөр, сургалтын чанар
Технологийн болон инновацийн хөгжлийн бодлого	2020	Бодлогын баримт бичиг	R&D, мэргэжлийн үр чадвар	Шинжлэх ухаан, инновацид суурилсан ажиллах хүчийг хөгжүүлэх	ЗГ, ШУТИС, МУИС	R&D төсөл ≥ 200 /жил, технологийн үр чадварын өсөлт $\geq 5\%$ жилд	Шинэ технологи, дадлага, насан туршийн мэргэжлийн
Хөдөлмөрийн зах зээлийн дунд хугацааны стратеги (2021–2025)	2021	Дунд хугацааны бодлого	Ажиллах хүчний бүтээмж	Мэргэжлийн үр чадвар, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх	ЗГ, ХНХЯ	Мэргэжлийн сургалтанд хамрагдсан ажилтны хувь $\geq 70\%$, бүтээмжийн өсөлт $\geq 5\%$ жилд	Дунд хугацааны зорилтот бүлэг, салбарын шаардлагатай үр чадвар

Насан туршийн боловсролын бодлого	2022	Бодлогын баримт бичиг	Насан туршийн сургалт	Ажиллах хүчний тасралтгүй хөгжлийг хангах	БШУЯ, Орон нутгийн боловсролын байгууллага	Насан туршийн сургалтад хамрагдсан иргэд $\geq 40\%$	Ахмад ажилтан, дунд насны ажиллагчдын сургалт
"Skills Development Program" / Ур чадвар хөгжүүлэх хөтөлбөр	2021	Хөтөлбөр	Ур чадвар хөгжүүлэх	Ур чадвар сайтай ажиллах хүч бэлтгэх	БШУЯ, ЗГ	Төгсгөгчдийн ажилд орох хувь $\geq 75\%$, мэргэжлийн ур чадварын үнэлгээ $\geq 80\%$	Сургалт, дадлага, шалгалт, гэрчилгээ
Технологийн болон инновацийн хөгжлийн бодлого	2020	Бодлогын баримт бичиг	R&D, инноваци	Технологи, инновацид суурилсан ажиллах хүчийг хөгжүүлэх	ЗГ, ШУТИС, МУИС	R&D төсөл ≥ 200 /жил, патент ≥ 50 /жил, технологийн ур чадварын өсөлт $\geq 5\%$	Шинжлэх ухаан, инновацийн төсөл, патентжуулалт, технологийн дамжуулалт

Хүснэгт 5. Хөдөлмөрийн зах зээл, нийгмийн хамгааллын салбарын шинэчлэлтэй холбоотой гол хууль, стратеги, бодлого

БАРИМТ БИЧИГ	ОН	ТӨРӨЛ	ДЭД ТӨРӨЛ	ЗОРИЛТ (ТОВЧ)	ХАРИУЦСАН БАЙГУУЛЛАГА	ХЭРЭГЖИЛТ ШАЛГУУР / KPI	ТАЙЛБАР / НЭМЭЛТ
Хөдөлмөрийн тухай хууль	2019	Хууль	Хөдөлмөрийн харилцаа, эрх	Ажиллах хүчний эрхийг хамгаалах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах	ХНХЯ, Хөдөлмөрийн улсын байцаагч	Ажиллах хүчний аюулгүй байдлын үзүүлэлт $\geq 95\%$, ажилгүйдлийн түвшин $\leq 5\%$	Хөдөлмөрийн гэрээ, цалин, аюулгүй ажиллагааны стандартыг зохицуулна
Нийгмийн даатгалын тухай хууль	2018	Хууль	Эрүүл мэнд, тэтгэвэр, нийгмийн хамгаалал	Ажиллах хүчний нийгмийн баталгааг сайжруулах	ХНХЯ, Нийгмийн даатгалын ерөнхий газар	Даатгалд хамрагдсан ажилтны хувь $\geq 90\%$, нийгмийн халамжийн хүртээмж $\geq 85\%$	Тэтгэвэр, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын системийг шинэчлэхэд чиглэсэн
Хөдөлмөрийн зах зээлийн дунд хугацааны стратеги (2021–2025)	2021	Дунд хугацааны бодлого	Ажиллах хүчний бүтээмж, ур чадвар	Мэргэжлийн ур чадвар, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх	ЗГ, ХНХЯ	Мэргэжлийн сургалтанд хамрагдсан ажилтны хувь $\geq 70\%$, бүтээмжийн өсөлт $\geq 5\%$ жилд	Дунд хугацааны зорилтот бүлэг, салбарын шаардлагатай ур чадвар
Нийгмийн хамгааллын дунд хугацааны стратеги	2020	Дунд хугацааны бодлого	Нийгмийн халамж, хамгаалал	Эрүүл мэнд, халамж, тэтгэврийн системийг сайжруулах	ХНХЯ	Нийгмийн халамжийн хүртээмж $\geq 80\%$, тэтгэвэрийн хамрагдалт $\geq 90\%$	Баян, ядуу бүлгийн хүртээмжийг нэмэгдүүлэх
Үндэсний Хүний Нөөцийн Стратеги 2020–2030	2020	Бодлогын баримт бичиг	Ажиллах хүчний ур чадвар, нийгмийн хамгаалал	Хүний нөөцийн чанарыг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	ЗГ, ХНХЯ, БШУЯ	Ур чадварын үзүүлэлт $\geq 75\%$, ажил эрхлэлт $\geq 85\%$, нийгмийн хамгааллын хүртээмж $\geq 80\%$	Ажиллах хүчний чадавхи болон нийгмийн хамгааллыг уялдуулсан стратеги
Алсын хараа-2050	2020	Урт хугацааны бодлого	Хүний капитал, хөдөлмөрийн зах зээл	Ирээдүйн ажиллах хүчний чадавхийг бэхжүүлэх, нийгмийн хамгааллыг сайжруулах	ЗГ, БШУЯ	Хүний капиталын индекс ≥ 0.75 , хөдөлмөр эрхлэлтийн түвшин $\geq 90\%$, нийгмийн хамгааллын хүртээмж $\geq 85\%$	Урт хугацааны хөгжлийн зорилт, ажиллах хүчний ур чадвар, нийгмийн хамгааллыг хослуулсан

Хүснэгт 6. Үндэсний хүний нөөцийн хөгжлийн стратеги боловсруулахтай холбоотой гол хууль, стратеги, бодлого

БАРИМТ БИЧИГ	ОН	ТӨРӨЛ	ДЭД ТӨРӨЛ	ЗОРИЛТ (ТОВЧ)	ХАРИУЦСАН БАЙГУУЛЛАГА	ХЭРЭГЖИЛТ ШАЛГУУР / KPI	ТАЙЛБАР / НЭМЭЛТ
Үндэсний Хүний Нөөцийн Стратеги 2020–2030	2020	Бодлогын баримт бичиг	Ур чадвар, мэргэшил	Хүний нөөцийн чадавхи, ур чадвар, хөдөлмөрийн бүтээмжийг сайжруулах	ЗГ, БШУЯ, ХНХЯ	Ур чадварын үзүүлэлт $\geq 75\%$, ажил эрхлэлт $\geq 85\%$, мэргэшлийн түвшин $\geq 70\%$	Төсөл, хөтөлбөртэй уялдсан, дунд болон урт хугацааны зорилт
Алсын хараа-2050	2020	Урт хугацааны бодлого	Хүний капитал	Ирээдүйн ажиллах хүчний чадавхийг бэхжүүлэх	ЗГ, БШУЯ	Хүний капиталын индекс ≥ 0.75 , боловсролын хүртээмж $\geq 95\%$	Урт хугацааны хөгжлийн стратегитэй уялдсан, хүний нөөцийн хөгжилд чиглэсэн
Боловсролын тухай хууль	2021	Хууль	Боловсролын систем	Хүний нөөцийн суурь хөгжлийг бэхжүүлэх	БШУЯ	Боловсролын чанарын үнэлгээ $\geq 80\%$, төгсгөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь $\geq 75\%$	Ерөнхий, мэргэжлийн боловсролын хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх
Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль	2017	Хууль	Мэргэжлийн ур чадвар	Ажиллах хүчний чадвар, мэргэжлийн бэлтгэл сайжруулах	БШУЯ	Мэргэжлийн сургалтын төгсгөгчдийн ажилд орох хувь $\geq 70\%$	Ур чадварын стандарт, сургалтын агуулга, гэрчилгээ
Хөдөлмөрийн зах зээлийн дунд хугацааны стратеги (2021–2025)	2021	Дунд хугацааны бодлого	Ажиллах хүчний бүтээмж	Мэргэжлийн ур чадвар, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх	ЗГ, ХНХЯ	Мэргэжлийн сургалтанд хамрагдсан ажилтны хувь $\geq 70\%$, бүтээмжийн өсөлт $\geq 5\%$ жилд	Дунд хугацааны зорилтот бүлэг, салбарын шаардлагатай ур чадвар
Насан туршийн боловсролын бодлого	2022	Бодлогын баримт бичиг	Насан туршийн сургалт	Ажиллах хүчний тасралтгүй хөгжлийг хангах	БШУЯ, Орон нутгийн боловсролын байгууллага	Насан туршийн сургалтад хамрагдсан иргэд $\geq 40\%$	Ахмад болон дунд насны ажиллагчдын сургалт
Технологийн болон инновацийн хөгжлийн бодлого	2020	Бодлогын баримт бичиг	R&D, инноваци	Шинжлэх ухаан, технологид суурилсан ажиллах хүчийг хөгжүүлэх	ЗГ, ШУТИС, МУИС	R&D төсөл ≥ 200 /жил, патент ≥ 50 /жил, технологийн ур чадварын өсөлт $\geq 5\%$ жилд	Шинжлэх ухаан, инновацийн төсөл, насан туршийн мэргэжлийн сургалттай уялдсан

Хүснэгт 7. Инноваци, стартап, энтэрпренэршип холбоотой гол хууль, стратеги, бодлого

БАРИМТ БИЧИГ	ОН	ТӨРӨЛ	ДЭД ТӨРӨЛ	ЗОРИЛТ (ТОВЧ)	ХАРИУЦСАН БАЙГУУЛЛАГА	ХЭРЭГЖИЛТ ШАЛГУУР / КРІ	ТАЙЛБАР / НЭМЭЛТ
Инновацийн тухай хууль	2018	Хууль	Шинжлэх ухаан, инноваци	Инновацийн үйл ажиллагааг дэмжих, шинэ технологи хөгжүүлэх	ЗГ, ШУТИС, МУИС	Инновацийн төсөл ≥ 100/жил, патент ≥ 50/жил, R&D хөрөнгө оруулалт ≥ 5% өсөлт жилд	Судалгаа, хөгжүүлэлт, технологийн дамжуулалт
Стартап хөгжүүлэх хөтөлбөр	2020	Хөтөлбөр	Энтэрпренэршип	Шинэ бизнес санааг дэмжих, стартап экосистемийг хөгжүүлэх	ЗГ, ШУТИС, Санхүүгийн зохицуулах хороо	Шинэ стартап компанийн тоо ≥ 50/жил, хөрөнгө оруулалтын хэмжээ ≥ 10 сая USD/жил	Бизнес сургалт, менторшип, хөрөнгө оруулалт
Технологийн болон инновацийн хөгжлийн бодлого	2020	Бодлогын баримт бичиг	R&D, стартап	Технологи, инновацид суурилсан ажиллах хүчийг хөгжүүлэх	ЗГ, ШУТИС, МУИС	R&D төсөл ≥ 200/жил, стартап тоо ≥ 50/жил, технологийн үр чадварын өсөлт ≥ 5%	Шинжлэх ухаан, инновацийн төсөл, стартап экосистемийн дэмжлэг
Үндэсний энтэрпренэршип хөгжлийн стратеги	2021	Бодлогын баримт бичиг	Стартап, бизнес хөгжлийн дэмжлэг	Энтэрпренэршип, стартап, бизнесийн инновацийг дэмжих	ЗГ, ББС, Санхүүгийн зохицуулах хороо	Стартап-д хөрөнгө оруулалт ≥ 20 сая USD/жил, төслийн амжилт ≥ 70%, бизнесийн өсөлт ≥ 10%	Бизнес сургууль, инкубатор төв, хөрөнгө оруулалтын платформ
"Startup Mongolia" / Инкубатор, акселератор хөтөлбөр	2019	Хөтөлбөр	Стартап дэмжлэг	Шинэ бизнес санааг амжилттай хэрэгжүүлэх, зах зээлд гаргах	ЗГ, ШУТИС, Санхүүгийн зохицуулах хороо	Инкубатор төвд хамрагдсан стартап ≥ 100, амжилттай төслийн хувь ≥ 70%	Сургалт, менторшип, хөрөнгө оруулалтын дэмжлэг
Дижитал эдийн засгийн хөгжлийн бодлого	2021	Бодлогын баримт бичиг	Инноваци, энтэрпренэршип	Дижитал бизнес, стартап, инновацийн экосистемийг хөгжүүлэх	ЗГ, МХЕГ, ШУТИС	Дижитал стартап тоо ≥ 50, инновацийн төсөл ≥ 100/жил	Цахим эдийн засгийн орчинд стартап, технологийн хөгжлийг дэмжих

Хүснэгт 8. Тэгш байдал, хүртээмжтэй боловсрол, хүйсийн чадавхыг нэмэгдүүлэхтэй холбоотой гол хууль, стратеги, бодлого

БАРИМТ БИЧИГ	ОН	ТӨРӨЛ	ДЭД ТӨРӨЛ	ЗОРИЛТ (ТОВЧ)	ХАРИУЦСАН БАЙГУУЛЛАГА	ХЭРЭГЖИЛТ ШАЛГУУР / КРІ	ТАЙЛБАР / НЭМЭЛТ
Эрэгтэй, эмэгтэй тэгш байдлын тухай хууль	2011	Хууль	Хүйсийн эрх, тэгш боломж	Эрэгтэй, эмэгтэй ажилтан, иргэдийн тэгш эрх, боломжийг хангах	ХНХЯ, Хүний эрхийн үндэсний комисс	Ажилд авах, дэвшүүлэх, цалинд эмэгтэйчүүд ≥ 50%, хүйсийн тэнцвэртэй оролцоо	Ажилд авах, дэвшүүлэх, цалин, нийгмийн хамгааллын тэгш байдал
Хүний эрх, эрх чөлөөний үндсэн хууль	1992	Үндсэн хууль	Эрх, тэгш байдал	Бүх иргэдийн тэгш эрх, ялгаварлан гадуурхалтыг хязгаарлах	ЗГ, УИХ	Ялгаварлан гадуурхалтад өртсөн иргэдийн тоо ≤ 5%, эрхийн хамгаалалт ≥ 90%	Хүний эрх, тэгш байдлын үндэсний зохицуулалт
Хүйсийн тэгш байдлын дунд хугацааны стратеги	2020	Бодлогын баримт бичиг	Эрэгтэй, эмэгтэй	Хүйсийн чадавхийг нэмэгдүүлэх, шийдвэр гаргалтанд оролцоог дэмжих	ЗГ, ХНХЯ, БШУЯ	Удирдах түвшний эмэгтэйчүүдийн хувь ≥ 30%, хүйсийн тэгш оролцоо ≥ 50%	Удирдах түвшний эмэгтэйчүүдийн хувь, хүйсийн тэгш оролцоо
Хүртээмжтэй боловсролын хөтөлбөр	2021	Хөтөлбөр	Боловсролын хүртээмж	Эрэгтэй, эмэгтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх	БШУЯ	Хөтөлбөрт хамрагдсан хүүхэд ≥ 95%, насан туршийн сургалтанд хамрагдсан иргэд ≥ 40%	Сургууль, дунд боловсрол, мэргэжлийн сургалтын хүртээмж
Хүний нөөцийн хөгжлийн стратеги 2020–2030	2020	Бодлогын баримт бичиг	Тэгш боломж, чадварын хөгжлийн стратеги	Хүний нөөцийн тэгш боломж, чадавхийг нэмэгдүүлэх	ЗГ, БШУЯ, ХНХЯ	Үр чадварын индекс ≥ 75%, ажил эрхлэлт ≥ 85%, хүйсийн оролцоо ≥ 50%	Нас, хүйс, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулсан стратеги

Хүснэгт 9. Манлайлал ба институтийн чадавхыг бэхжүүлэхтэй холбоотой гол хууль, стратеги, бодлого

БАРИМТ БИЧИГ	ОН	ТӨРӨЛ	ДЭД ТӨРӨЛ	ЗОРИЛТ (ТОВЧ)	ХАРИУЦСАН БАЙГУУЛЛАГА	ХЭРЭГЖИЛТ ШАЛГУУР / КРІ	ТАЙЛБАР / НЭМЭЛТ
Монгол Улсын Засаглалын хөтөлбөр	2020	Бодлогын баримт бичиг	Манлайлал, институцийн хөгжил	Төрийн алба, байгууллагын чадавхийг сайжруулах	ЗГ, Төрийн албаны зөвлөл	Байгууллагын бүтээмж ≥ 80%, төрийн үйлчилгээний чанар ≥ 85%	Засаглалын шинэчлэл, манлайллын бэхжүүлэлт
Төрийн албаны тухай хууль	2015	Хууль	Институцийн чадавхи	Төрийн албаны мэргэшлийг дээшлүүлэх, хүний нөөцийн тогтвортой байдал	Төрийн албаны зөвлөл	Төрийн албан хаагчдын мэргэшлийн сургалтад хамрагдсан хувь ≥ 90%, тогтвортой байдал ≥ 95%	Хүний нөөцийн менежмент, мэргэшлийн сургалт
Үндэсний институцийн хөгжлийн стратеги	2020	Бодлогын баримт бичиг	Байгууллагын бүтээмж	Төрийн болон төрийн бус байгууллагын институцийн чадавхыг нэмэгдүүлэх	ЗГ, ТББ	Байгууллагын бүтээмжийн индекс ≥ 80%, үйлчилгээний хүртээмж ≥ 85%	Институцийн бүтэц, процесс, хариуцлагын тогтолцоо

Манлайллын хөгжлийн хөтөлбөр	2019	Хөтөлбөр	Удирдлага	Удирдах чадвар, манлайллыг бэхжүүлэх	БШУЯ	Хөтөлбөрт хамрагдсан хүүхэд $\geq 95\%$, насан туршийн сургалтанд хамрагдсан иргэд $\geq 40\%$	Сургууль, дунд боловсрол, мэргэжлийн сургалтын хүртээмж
	ЗГ, ШУТИС, Удирдлагын академи	Удирдах түвшний сургалтад хамрагдсан хүмүүс ≥ 200 , манлайллын чадварын үнэлгээ $\geq 80\%$	Манлайллын сургалт, менторшип, дадлага	Хүний нөөцийн тэгш боломж, чадавхийг нэмэгдүүлэх	ЗГ, БШУЯ, ХНХЯ	Ур чадварын индекс $\geq 75\%$, ажил эрхлэлт $\geq 85\%$, хүйсийн оролцоо $\geq 50\%$	Нас, хүйс, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулсан стратеги
Засгийн газрын үйл ажиллагааны стратеги 2021–2025	2021	Дунд хугацааны бодлого	Төрийн үйлчилгээ, институцийн чадавхи	Төрийн институцийг хүчирхэгжүүлэх, шийдвэр гаргалтанд манлайллыг сайжруулах	ЗГ, Төрийн албаны зөвлөл	Үйлчилгээний чанар $\geq 85\%$, иргэдийн сэтгэл ханамж $\geq 80\%$	Төрийн институцийн үйл ажиллагааны үр дүн, тогтвортой байдал
Институцийн чадавх хөгжүүлэх хөтөлбөр	2020	Хөтөлбөр	Менежмент, бүтэц	Байгууллагын бүтэц, процесс, хүний нөөцийг сайжруулах	ЗГ, ТББ, Орон нутгийн засаг захиргаа	Байгууллагын бүтэц, процессын үр ашиг $\geq 80\%$, хүний нөөцийн чадавхи $\geq 85\%$	Үндэсний болон орон нутгийн түвшинд институцийн шинэчлэл

2.3. Монгол Улсын хүний нөөцийн шилжилтийн шалгуур үзүүлэлт ба боловсрол, ур чадвар ба хөдөлмөрийн зах зээлийн бэлэн байдлыг олон улстай харьцуулсан үнэлгээ

Хүний нөөцийн шилжилтийг хэмжих гол шалгуур үзүүлэлтүүд нь боловсрол, ур чадвар, хөдөлмөрийн зах зээл, инноваци, нийгмийн оролцооны чиглэлээр хүний капитал хэрхэн шинэ түвшинд шилжиж байгааг үнэлдэг. Энэхүү үнэлгээ нь эдийн засгийн бүтцийн өөрчлөлт, технологийн хөгжил, ногоон болон дижитал шилжилтийн үед хөдөлмөрийн зах зээлийн бэлэн байдал, өрсөлдөх чадварыг тодорхойлох суурь үзүүлэлт болдог.

Доорх хүснэгтүүдэд Монгол Улсын боловсролын салбарын гол үзүүлэлтүүдийг эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн гишүүн орнуудын (OECD) дундаж, бүс нутгийн орнууд болон ижил түвшний орнуудтай харьцуулан харуулсан болно. Энэхүү харьцуулалт нь:

1. Сургалтын хамрагдалт, чанар
2. Суралцах үр дүн, ур чадварын бүтэц
3. Насан туршийн боловсрол гэсэн хүний капиталын хөгжлийн үндсэн хэмжигдэхүүнүүдийг олон улсын түвшинд үнэлэхэд чиглэгддэг.

Эдгээр үзүүлэлтүүд нь боловсролын системийн тэгш хүртээмж, чанар, бүтээмжийн уялдаа, мөн хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй нийцэх байдал зэрэг бодлогын гол асуудлыг тодорхойлох суурь мэдээлэл болж өгдөг.

Хүснэгт 10. Боловсролын хамрагдалт ба ур чадварын үзүүлэлтүүд

ҮЗҮҮЛЭЛТ	ТОДОРХОЙЛОЛТ	OECD ДУНДАЖ	КАЗАХСТАН	ГҮРЖ	ВЬЕТНАМ	ЛАТВИ	МОНГОЛ УЛС
Боловсролын чанар (Effective Years of Schooling)	Хүүхэд суралцсан үр дүнтэй жил – Дэлхийн банкны Хүний капиталын индекс	12–13 жил	~11.2	~10.8	12.3	12.5	9.7
Бага боловсролын хамрагдалт (GER, Primary)	6–11 насны хамрагдалт (%)	98–99%	99%	99%	98%	97%	95–97%
Дунд боловсролын хамрагдалт (GER, Secondary)	Бүрэн дунд боловсролын хамрагдалт	90%+	97%	95%	88–90%	95%	95–99%
Дээд боловсролын хамрагдалт (Tertiary GER)	Их, дээд сургуульд хамрагдалт	~70%	56%	64–68%	29%	60–65%	65.3%
Эрт үеийн боловсрол (ECE enrolment, age 5)	5 настай хүүхдийн цэцэрлэгийн хамрагдалт (%)	85–90%	~70%	~78%	~75%	~88%	62–70%
Насанд хүрэгчдийн бичиг үсэг / суурь чадвар	Literacy rate, суурь уншлага–тоон чадвар (%)	>95%	~99%	~99%	~97%	~99%	97–98%
PISA (Математик) — Суурь чадвар	15 настнуудын суурь чадварын шалгалтын оноо	472 оноо	430 орчим	390 орчим	470+	485	425 ОРЧИМ
STEM төгсөгчдийн эзлэх хувь	ШУ, инженер, технологи, математикийн чиглэлийн төгсөгчдийн хувь	30–35%	~28–30%	~25%	35–40%	32–33%	~28–30%
Насанд хүрэгчдийн суралцах идэвх (Lifelong learning)	25–64 насныхны өнгөрсөн 12 сард сургалтад хамрагдсан хувь	~40% (EU/OECD)	~20%	~15%	~12–15%	~30%	10–12%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Монгол Улсын боловсролын хамрагдалтын түвшин бүс нутгийн улсуудаас өндөр боловч сургалтын чанар, үр дүнтэй боловсролын жил 9.7 жилээр хэмжигдэж, эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн гишүүн орнуудын (OECD) 12–13 жилтэй харьцуулахад мэдэгдэхүйц доогуур байна. Эрт боловсролын хамрагдалт 62–70%-тайгаар бүсийн хамгийн сул түвшинд байгаа нь хүүхдийн суурь чадварын ялгаа сургуулийн өмнөх наснаас эхлэн тогтдог нөхцөл бүрджээ. Дээд боловсролын хамрагдалт 65%-д хүрсэн боловч төгсөгчдийн ур чадвар-ажлын байрны зөрүү өндөр хэвээр байгаа нь хөдөлмөрийн зах зээлд бүтээмжийн алдагдал үүсгэж байна. Насан туршийн сургалтын оролцоо 10-12%-тайгаар эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн гишүүн орнуудын (OECD) дунджаас гурав дахин доогуур байгаа нь ур чадварын шинэчлэлийн систем сул байгааг харуулж байна. Иймд

боловсролын чанар, багшийн мэргэжлийн хөгжил, эрт боловсролын хүртээмж, насан туршийн сургалтын тогтолцоог шинэчлэх нь хүний капиталын өсөлт, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх боломжтой юм.

Олон улсын туршлагаас үзвэл Финландын суурь боловсролын чанарт суурилсан, багшийн мэргэжлийн хөгжлийг тэргүүнд тавьсан тогтолцоо нь суралцах бодит үр дүн, ур чадварын тэгш байдлыг сайжруулсан бол Эстонийн дижиталд суурилсан эрт боловсрол болон насан туршийн сургалтын систем нь суурь чадварын ялгааг багасгаж, хөдөлмөрийн зах зээлийн уян хатан байдлыг нэмэгдүүлсэн. Үүний зэрэгцээ Сингапурын ур чадвар-ажил олгогчийн уялдаа бүхий дээд болон мэргэжлийн боловсролын загвар нь төгсөгчдийн ажил эрхлэлтийн үр ашиг, бүтээмжийг бодитоор нэмэгдүүлсэн туршлагатай.

Хүснэгт 11. Ур чадвар ба ажиллах хүчний шилжилтийн үзүүлэлтүүд

ҮЗҮҮЛЭЛТ	ТОДОРХОЙЛОЛТ	ОЕСД ДУНДАЖ	КАЗАХСТАН	ГҮРЖ	ВЬЕТНАМ	ЛАТВИ	МОНГОЛ УЛС
Насан туршийн боловсролд хамрагдалт (ур чадвараа шинэчлэх)	Нэг жилийн хугацаанд ур чадвар дээшлүүлэх сургалтад хамрагдсан ажиллах хүчний хувь	14–15%	9–10%	~7%	~6%	7–8%	4–6%
Цахим ур чадвар (Digital skills)	Дижитал суурь ур чадвартай насанд хүрэгчдийн эзлэх хувь	55–60%	~40%	~40%	45%	63%	~35%
Ногоон ур чадвар	Ногоон эдийн засгийн чиглэлийн ур чадвар эзэмшсэн ажиллах хүчний хувь	25%+	10–12%	~8%	10–12%	20%	5–7%
TVET хамрагдалт	Итгэмжлэгдсэн техник, мэргэжлийн боловсролын хөтөлбөрт хамрагдсан суралцагчдын хувь	30–35%	18–20%	15%	20%	27%	10–12%
Ажиллах хүчний шилжилтийн хөтөлбөрүүд (green transition, skills transition)	Салбар шилжилтийг дэмжих үндэсний хөтөлбөрийн бодлогын түвшний хэрэгжилт	Бүрэн тогтолцоотой	Хэрэгжиж буй	Хязгаарлагдмал	Хэрэгжиж буй	Дунд зэрэг	Эхний шат (салбарын төсөл түвшин)
Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо	Эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээлд оролцох хувь	65%+	62%	58%	72%	63%	57–59%
Эмэгтэйчүүд удирдах түвшинд	Удирдах албан тушаалд ажиллаж буй эмэгтэйчүүдийн хувь	~40%	38%	35%	32%	45%	~32%

Эх сурвалж: UNESCO (United Nations Educational, Scientific and Cultural Organization)

Насанд хүрэгчдийн суралцах идэвх 4-6%-тай бөгөөд энэ нь Казахстан, Латвиас хоёр-гурав дахин, эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн гишүүн орнуудын (OECD) дунджаас дөрөв дахин бага үзүүлэлт юм. Дижитал ур чадвартай хүн амын эзлэх хувь 35% орчим, ногоон ур чадвар 5-7%-тайгаар бүсийн хамгийн доод түвшинд байгаа нь хөдөлмөрийн зах зээл, технологийн нэвтрэлтийн хурд, ногоон шилжилтийн хэрэгцээтэй уядахгүй байна. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын TVET (Technical and Vocational Education and Training) хамрагдалт 10-12% бөгөөд бүсийн дунджаас доогуур хэвээр байна. Ажиллах хүчний шилжилтийг дэмжих бодлого эхний шатандаа байгаа бол бүсийн зарим оронд тогтолцооны түвшин бүрэлдээд байна. Хүйсийн тэгш байдлын үзүүлэлтүүд мөн сул, эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо 57-59%, удирдах түвшний оролцоо 32% орчим байна.

Дэлхийн улс орнууд насан туршийн боловсрол, дахин ур чадвар олголт, мэргэжлийн сургалтын хүртээмжийг нэмэгдүүлэх үндэсний хөтөлбөрүүдийг хөгжүүлж, ажиллах хүчний ур чадварын бүтцэд дасан зохицох, ажлын байрны шаардлагыг хангах, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг уялдуулах стратеги баримталж байна. Жишээ нь Сингапур улс нь хүний нөөцийн хөгжлийг тусдаа бодлого бус, эдийн засаг, технологи, засаглалтай уялдсан нэгдсэн стратегийн тогтолцоо болгон хэрэгжүүлснээр ажиллах хүчний өрсөлдөх чадвар, дасан зохицох чадамжийг тогтвортой нэмэгдүүлж чадсан жишиг улс юм.

Насан туршийн боловсрол, ур чадварын хөгжлийн үндэсний тогтолцоо нь (Skills Future) иргэдийг ур чадвараар хангахад чиглэж байхад, дижитал, инновацийн үндэсний стратеги (Smart Nation) нь тухайн ур чадварыг бодит технологи, дижитал орчин, инновацийн экосистемд ашиглах боломжийг бүрдүүлдэг байна.

Хүснэгт 12. Ажлын чанар болон, бүтээмжийн үзүүлэлтүүд

ҮЗҮҮЛЭЛТ	ТОДОРХОЙЛОЛТ	ОЕСД ДУНДАЖ	КАЗАХСТАН	ГҮРЖ	ВЬЕТНАМ	ЛАТВИ	МОНГОЛ УЛС
Хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт	Нэг ажилтанд ногдох ДНБ-ийн жилийн өсөлт	1.5-2.0%	~2.1%	~3%	~3.5%	~2%	1-1.5%
NEET – Залуучууд боловсрол, ажил, сургалтад хамрагдаагүй хувь	15-24 нас	~12%	~7%	~22%	~9%	~8%	~17%
Албан бус хөдөлмөр эрхлэлтийн хувь	Албан бус салбарт ажиллагсдын эзлэх хувь	<15%	~23%	~38%	~55%	~18%	~45%
Үйлчилгээний ажил эрхлэлтийн индекс	ILO-ийн үнэлгээгээр үйлчилгээний салбарын ажлын чанарын индекс (цалин, хамгаалалт, тогтвортой байдал)	Өндөр	Дунд	Дунд	Дунд	Өндөр	Дунд-бага
Ур чадвартай ажилтны шилжилт (Brain Drain / Brain Gain)	Ур чадвартай ажиллах хүчний цэвэр шилжилт	Эерэг	Саармаг	Сөрөг	Эерэг	Эерэг	Сөрөг
Ажил эрхлэлтийн бүтцийн шилжилт	Аж үйлдвэр → үйлчилгээ; бага ур чадвар → дунд/өндөр ур чадвар	Хурдацтай	Дунд	Удаан	Дунд	Хурдацтай	Удаан

Эх сурвалж: ILO (International Labour Organization)

Монгол Улсын хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт 1-1.5%-тайгаар эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн гишүүн орнуудын (OECD) болон Зүүн Европын орнуудаас мэдэгдэхүйц доогуур, залуучуудын сурч боловсрохгүй, ажил эрхлэхгүй, сургалтад хамрагдахгүй NEET (Not in Education, Employment or Training) түвшин 17%-д хүрч, Латвийн 8% болон Казахстаны 7%-аас хоёр дахин өндөр байна. Албан бус хөдөлмөр эрхлэлт 45% орчимд хадгалагдаж, бүсийн дунджийг давсан нь хөдөлмөрийн баталгаат байдлыг бууруулж байна. Үйлчилгээний салбарын ажлын чанарын индекс “дунд-бага” түвшинд байгаа нь ажлын байрны тогтвортой байдал сул байгааг илтгэнэ. Ур чадвартай ажиллах хүчний шилжилт сөрөг хэвээр, ажил эрхлэлтийн

бүтцийн шилжилт бусад орнуудаас удаан яваа нь дунд болон өндөр ур чадвартай ажлын байрны өсөлт хангалтгүй байгааг харуулж байна. Эдгээр үзүүлэлтүүд нь Монгол Улсад хөдөлмөрийн зах зээлийн бүтцийн шинэчлэл, ур чадварын бодлого, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц арга хэмжээ шаардлагатайг харуулж байна.

NEET өндөр байгаа нь боловсролын бус, сургууль-ажлын хоорондын шилжилтийн асуудал юм.

Олон улсын туршлагаас харахад Герман болон Латви улсын Youth Guarantee, дуал сургалт, богино хугацааны ур чадварын хөтөлбөрүүд нь NEET-ийг богино хугацаанд мэдэгдэхүйц бууруулах хамгийн үр дүнтэй бодлогын хэрэгсэл болж байна.

Хүснэгт 13. Байгууллагын үйл ажиллагаа болон засаглалын үзүүлэлтүүд

ҮЗҮҮЛЭЛТ	ТОДОРХОЙЛОЛТ	ОЕСД ДУНДАЖ	КАЗАХСТАН	ГҮРЖ	ВЬЕТНАМ	ЛАТВИ	МОНГОЛ УЛС
Хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт	Нэг ажилтанд ногдох ДНБ-ийн жилийн өсөлт	1.5-2.0%	~2.1%	~3%	~3.5%	~2%	1-1.5%
Албан бус хөдөлмөр эрхлэлтийн хувь	Албан бус салбарт ажиллагсдын эзлэх хувь	<15%	~23%	~38%	~55%	~18%	~45%
Үйлчилгээний ажил эрхлэлтийн индекс	ILO-ийн үнэлгээгээр үйлчилгээний салбарын ажлын чанарын индекс (цалин, хамгаалалт, тогтвортой байдал)	Өндөр	Дунд	Дунд	Дунд	Өндөр	Дунд-бага
Ур чадвартай ажилтны шилжилт (Brain Drain / Brain Gain)	Ур чадвартай ажиллах хүчний цэвэр шилжилт	Эерэг	Саармаг	Сөрөг	Эерэг	Эерэг	Сөрөг
Ажил эрхлэлтийн бүтцийн шилжилт	Аж үйлдвэр → үйлчилгээ; бага ур чадвар → дунд/өндөр ур чадвар	Хурдацтай	Дунд	Удаан	Дунд	Хурдацтай	Удаан
Ажил эрхлэлтийн бүтцийн шилжилт	Аж үйлдвэр → үйлчилгээ; бага ур чадвар → дунд/өндөр ур чадвар	Хурдацтай	Дунд	Удаан	Дунд	Хурдацтай	Удаан

Эх сурвалж: ILO (International Labour Organization)

Монгол Улсын үйлчилгээний салбарын ажлын байрны чанар “дунд-бага” үнэлгээтэй бөгөөд ур чадвартай ажиллах хүчний шилжилт сөрөг хэвээр байна. Мөн ажил эрхлэлтийн бүтцийн шилжилт удаан явагдаж буй нь эдийн засгийн төрөлжилт, өндөр ур чадвартай ажлын байрны өсөлт хангалтгүй байгааг харуулж байна. Энэ нь хөдөлмөрийн бүтээмж, ажлын байрны чанар, ур чадварын системийг шинэчлэх стратегийн шаардлага өндөр байгааг тодотгож байна.

Олон улсын туршлагаас харахад үйлчилгээний салбарын ажлын чанар сул, ур чадвартай ажиллах хүчний шилжилт сөрөг, ажил эрхлэлтийн бүтцийн шилжилт удаан явагдаж буй орнуудад хөдөлмөрийн бүтээмжийг өсгөх гол шийдэл нь ур чадвар-ажлын байр-бүтцийн уялдаа бүхий цогц шинэчлэл байдаг. Монгол Улсын хувьд ажлын байрны чанар, өндөр ур чадвартай үйлчилгээ, насан туршийн суралцах тогтолцоог зэрэг шинэчлэх стратегийн шаардлага өндөр байна.

Хүснэгт 14. Оролцоо ба тэсвэртэй байдлын үнэлгээ

ҮЗҮҮЛЭЛТ	ТОДОРХОЙЛОЛТ	ОЕСД ДУНДАЖ	КАЗАХСТАН	ГҮРЖ	ВЬЕТНАМ	ЛАТВИ	МОНГОЛ УЛС
STEM ба удирдах түвшин дэх жендерийн оролцоо	STEM чиглэлийн хөтөлбөр болон удирдах түвшинд эмэгтэйчүүдийн эзлэх хувь	35-40%	~32%	~28%	~36%	~42%	~30%
Бүс нутгийн ур чадварын ялгаа (хот- хөдөө)	Ур чадвар, дижитал хүртээмж, боловсролын чанарын ялгаа	<10%	~15%	~20%	~18%	~8%	~20-25%
Нийгмийн хамгааллын хамрах хүрээ	Ажилгүй иргэдийг хөдөлмөрийн зах зээлийн идэвхжүүлэх хөтөлбөрт хамруулсан эзлэх хувь	~70%	~45%	~35%	~30%	~65%	~25-30%
Ирээдүйн ажлын байрны бэлэн байдал	Уян хатан, зайны ажил, дижитал ажил эрхлэлтийн түвшин, өсөлт	Өндөр өсөлт (жилд +5-8%)	+2-3%	+1-2%	+3-4%	+5%	+2% орчим
Хөдөлмөрийн зах зээлийн тэсвэртэй байдал	Эдийн засгийн шок, ажилгүйдлийн хэлбэлзэлд тэсвэртэй байдал	Өндөр	Дунд	Дунд	Дунд	Өндөр	Дунд-бага
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажил эрхлэлтийн оролцоо	Хөдөлмөрийн зах зээлд оролцох хувь	~50%	~30%	~25%	~28%	~45%	~20%

Эх сурвалж: ILO (International Labour Organization)

Энэ харьцуулалт нь Монгол Улсын хүний нөөцийн шилжилтийг олон улсын түвшинд тодорхойлон, боловсрол, ур чадвар, хөдөлмөрийн зах зээл, нийгмийн оролцоо, дижитал болон инновацийн чадавх зэрэг чиглэлээр бодлого боловсруулах суурь мэдээлэл болдог.

Монгол Улсад STEM болон удирдах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо харьцангуй доогуур, хот-хөдөөгийн ур чадварын ялгаа өндөр, нийгмийн хамгаалал ба ирээдүйн ажлын байрны бэлэн байдал сул, хөдөлмөрийн зах зээлийн тэсвэртэй байдал болон

хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоо дунд-бага түвшинд байгаа нь хөдөлмөрийн зах зээлийн оролцоо, тэгш байдал, дасан зохицох чадварыг цогцоор нь шинэчлэх бодлогын шаардлага өндөр байгааг харуулж байна. Энэхүү хөдөлмөрийн зах зээлийн оролцоо, тэгш байдал, тэсвэртэй байдлыг сайжруулахад Швед-Финландын жендер ба институтгийн бодлого, Эстониин дижитал хүртээмж, Сингапурын ирээдүйн ур чадвар, Германы идэвхжүүлэх хөдөлмөрийн зах зээлийн загварыг хослуулсан цогц шинэчлэл хамгийн тохиромжтой.

Хүснэгт 15. Хүний капитал, ур чадвар, инновацийн үзүүлэлтүүд

ҮЗҮҮЛЭЛТ	ТОДОРХОЙЛОЛТ	ОЕСД ДУНДАЖ	КАЗАХСТАН	ГҮРЖ	ВЬЕТНАМ	ЛАТВИ	МОНГОЛ УЛС
Хүний капиталын индекс (HCI)	Ирээдүйн ажиллах хүчний бүтээмжийг хэмждэг (0-1 хооронд)	0.72-0.75	0.63	0.57	0.67	0.71	0.62
Инновацийн чадавх (R&D + инновацийн экосистем)	R&D-д зарцуулсан ДНБ-ний хувь, патентын хэмжээ, стартапын орчин	2.4% (R&D)	~0.17%	~0.3%	~0.5%	0.7%	0.14-0.2%
Дэлхийн авьяас чадварын өрсөлдөөний индекс (GTCI - INSEAD)	Авьяасыг татах, хөгжүүлэх, хадгалах чадвар	Дээд 30	~61	~62	~59	~32	~68-70
Ирээдүйн чиг баримжаатай салбарт ажиллаж буй хувь	Технологи, ногоон, дижитал үйлчилгээний салбар дахь ажил эрхлэлт	~25-30%	~18%	15%	20%	27%	~15%
Ажил, боловсролын институцид итгэх иргэдийн итгэлцлийн түвшин	Сэтгэл ханамж, байгууллагад итгэх итгэл (судалгааны индекс)	Өндөр	Дунд	Дунд	Дунд	Өндөр	Дунд-бага

Эх сурвалж: INSEAD

Монгол Улсын хүний капиталын индекс, инноваци, авьяасын өрсөлдөх чадвар, ирээдүйн ажлын байрны бэлэн байдал зэрэг 5 үзүүлэлтийн ихэнхэд бүс нутаг болон эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн гишүүн орнуудын (OECD) доогуур үнэлгээтэй, хүний нөөцийн тогтолцооны

суурь сул байгааг харуулж байна. Энэхүү үзүүлэлтийг сайжруулахад Финландын суурь боловсрол, Эстониин дижитал ур чадвар, Сингапурын ирээдүйн ур чадвар, Германы дуал TVET-ийг хослуулсан цогц шинэчлэл хамгийн тохиромжтой.

Дүгнэлт

Боловсролын үр дүн ба хүний капиталын сорилтууд – Монгол Улс (2025)

Монгол Улсад бага, дунд боловсролын хамрагдалт харьцангуй өндөр боловч сургалтын чанар, суралцах үр дүн, бодит ур чадварын түвшин олон улсын жишгээс доогуур байна. Үр дүнтэй боловсролын жилийн тоо 9.7 жил байгаа нь эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн гишүүн орнуудын (OECD) дунджаас 2.5–3 жилээр бага бөгөөд энэ нь хүний капиталын хуримтлал хангалтгүй байгааг илтгэнэ.

Эрт үеийн боловсролын хамрагдалт (62–70%) нь эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн гишүүн орнуудын (OECD) болон бүс нутгийн дунджаас доогуур бөгөөд хүүхдийн суурь чадвар бага наснаас сул хөгжиж буй нь цаашдын суралцах чадвар, амжилтад сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

Олон улсын PISA-ийн үзүүлэлтээр Монгол сурагчдын математик чадварын оноо (~425) нь эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн гишүүн орнуудын (OECD) дунджаас доогуур байгаа нь чадамжид суурилсан сургалт бодит үр дүнд бүрэн хүрээгүйг харуулж байна.

STEM салбарт төгсөгчдийн дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь (~28–30%) бага байгаа нь инноваци, технологид суурилсан эдийн засгийн шилжилтийг удаашруулж байна.

Насан туршийн сургалтад хамрагдах түвшин 10–12% нь эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн гишүүн орнуудын (OECD) дунджаас гурав дахин бага бөгөөд дижитал болон ногоон шилжилтийн үед ажиллах хүч

шинэ ур чадварт дасан зохицох боломжийг хязгаарлаж байна.

Хүний нөөц, ур чадварын бодлогын хэрэгжилт – Монгол Улс (2025)

Монгол Улс хүний нөөц, ур чадварыг хөгжүүлэх олон хууль, стратеги, бодлогын баримт бичиг боловсруулж, хэрэгжүүлж байна. Гэсэн хэдий ч эдгээрийн бодит хэрэгжилт, үр нөлөө олон улсын жишгээс дунд буюу доогуур түвшинд байна.

Боловсрол, ур чадвар, насан туршийн сургалтын гол үзүүлэлтүүдээр Монгол Улс эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн гишүүн орнуудын (OECD) болон бүс нутгийн дунджаас 2–4 дахин доогуур байгаагаар хүний капиталын хуримтлал хангалтгүй, хөдөлмөрийн зах зээлд шинэ ур чадварт дасан зохицох чадвар хязгаарлагдмал байгааг харуулж байна.

Насан туршийн боловсрол, ур чадварын тогтолцоо – Монгол Улс (2025)

Олон улсын сайн туршлагаас (жишээ нь Сингапур) харахад, насан туршийн боловсрол, ур чадварын нэгдсэн тогтолцоо нь ажиллах хүчний бүтцийг амжилттай шинэчилж чадсан байна.

Монгол Улс энэ туршлагад тулгуурлан ур чадварт суурилсан бодлогыг дижитал шилжилттэй уялдуулах, хэрэгжилтийг эрчимжүүлэх, институтын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр катализаторын үүрэг гүйцэтгэх техникийн туслалцаа, хөгжлийн түншийн дэмжлэг авах шаардлагатай байна. уялдуулж, ур чадварын ваучер, ажил-сургалтыг хослуулсан тогтолцоо, дижитал суурь ур чадварын үндэсний стандартуудыг үе шаттайгаар нэвтрүүлэх боломжтой юм.

Эх сурвалж

1. World Bank. (2023–2024). Mongolia: Employment Diagnostic Report. Дэлхийн Банкны хөдөлмөрийн зах зээлийн үнэлгээ.
2. McKinsey Global Institute. (2023). From Poverty to Empowerment: Raising the Bar for Sustainable and Inclusive Growth. Ур чадварын шинэчлэлийн эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөөллийн судалгаа.
3. World Economic Forum (WEF). (2020). The Future of Jobs Report 2025. Ажлын байрны ирээдүй, дэлхийн ур чадварын эрэлт, автоматжуулалтын чиг хандлага.
4. UNICEF Mongolia. (2015–2030). Sustainable Development Goals – Education and Lifelong Learning Framework. Монголын насан туршийн боловсролын бодлогын үнэлгээ.
5. Forbes Magazine. (2018). The Gig Economy Workforce Report. АНУ-ын gig workforce-ийн статистик мэдээлэл.
6. Business Research Insights. (2024). Global Gig Economy Market Size and Forecast 2025–2034. Gig эдийн засгийн дэлхийн зах зээлийн таамаг.
7. McKinsey & Company. (2025). State of AI Report 2025. Байгууллагуудын AI ашиглалт, агентын нэвтрүүлэлт, эрсдэлийн үнэлгээ.
8. Stanford University — Human-Centered AI Institute. (2024). Global AI Vibrancy Tool. Хиймэл оюуны хөгжил, патент, хөрөнгө оруулалтын индекс.
9. World Economic Forum. (2023). Green Future Index 2023. Ногоон шилжилт, нүүрстөрөгч багатай хөгжилд тэргүүлэгч улс орнуудын үнэлгээ.
10. OECD & German Federal Ministry for Economic Affairs. (2019–2023). Industry 4.0 and Human Capital Transformation Reports. Германы аж үйлдвэрийн дижитал шилжилт ба хүний нөөцийн бодлогын судалгаа.
11. New Zealand Treasury. (2020–2024). Wellbeing Approach to Governance. Шинэ Зеландын сайн сайхан байдалд суурилсан засаглалын стратеги.



О.БАДРАЛ

ШИНЭ СЭРГЭЛТ ИННОВАЦИЙН
ХӨТӨЛБӨР

Ахлах шинжээч

НОГООН ХӨГЖЛИЙН ШИЛЖИЛТ



Б.АНУЖИН

ШИНЭ СЭРГЭЛТ ИННОВАЦИЙН
ХӨТӨЛБӨР

Судлаач

Гарчиг

1. НОГООН ХӨГЖЛИЙН ШИЛЖИЛТ	45
2. ЦЭВЭР ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТ	45
2.1. Цэвэр эрчим хүчний шилжилтийн хамрах хүрээ	45
2.2. Цэвэр эрчим хүчний шилжилтийн олон улсын шалгуур үзүүлэлтүүд	46
2.3. Эрчим хүчний олон улсын үнэлгээ, индекс	46
2.3.1. World Energy Trilemma 2024 Report	46
2.3.2. WEF Fostering Effective Energy Transition 2025 Report	47
2.4. Монгол Улсын эрчим хүчний салбарын бодлогын баримт бичгүүд	47
2.5. Бодлогын баримт бичигт тусгагдсан шалгуур үзүүлэлтүүд	48
3. НОГООН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ	48
3.1. Ногоон тээврийн хэрэгслийн шилжилтийн хамрах хүрээ	49
3.2. Ногоон тээврийн хэрэгслийн олон улсын шалгуур үзүүлэлтүүд	50
3.3. Монгол Улсын тээврийн салбарын бодлогын баримт бичгүүд	50
3.4. Бодлогын баримт бичигт тусгагдсан шалгуур үзүүлэлтүүд	50
4. НОГООН ҮЙЛДВЭРЛЭЛ БА ТОЙРОГ ЭДИЙН ЗАСАГ	51
4.1. Ногоон үйлдвэрлэл ба тойрог эдийн засгийн шилжилтийн хамрах хүрээ	51
4.2. Ногоон үйлдвэрлэл ба тойрог эдийн засгийн олон улсын шалгуур үзүүлэлтүүд	52
4.3. Монгол Улсын хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүд	52
4.4. Бодлогын баримт бичигт тусгагдсан шалгуур үзүүлэлтүүд	53
5. ТОГТВОРТОЙ МАЛ АЖ АХУЙ, ХҮНСНИЙ СИСТЕМ	53
5.1. Тогтвортой мал аж ахуй, хүнсний системийн шилжилтийн хамрах хүрээ	53
5.2. Тогтвортой мал аж ахуй, хүнсний системийн олон улсын шалгуур үзүүлэлтүүд	54
5.3. Монгол Улсын мал аж ахуй, хүнсний салбарын бодлогын баримт бичгүүд	54
5.4. Бодлогын баримт бичигт тусгагдсан шалгуур үзүүлэлтүүд	55
6. НОГООН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ХОТУУД	56
6.1. Ногоон барилга байгууламж, ногоон хотын шилжилтийн хамрах хүрээ	56
6.2. Ногоон барилга байгууламж, ногоон хотын олон улсын шалгуур үзүүлэлтүүд	56
6.3. Монгол Улсын салбарын хууль, бодлогын баримт бичгүүд	56
6.4. Бодлогын баримт бичигт тусгагдсан шалгуур үзүүлэлтүүд	58
7. БАЙГАЛИЙН НӨӨЦ, БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ХАМГААЛАЛ	58
7.1. Байгалийн нөөц, биологийн олон янз байдлын хамгааллын шилжилтийн хамрах хүрээ	59
7.2. Байгалийн нөөц, биологийн олон янз байдлын хамгааллын олон улсын шалгуур үзүүлэлтүүд	59
7.3. Монгол Улсын байгалийн нөөц, биологийн олон янзбайдлын хамгааллын салбарын бодлогын баримт бичгүүд	59
7.4. Бодлогын баримт бичигт тусгагдсан шалгуур үзүүлэлтүүд	61
8. НОГООН САНХҮҮЖИЛТ, НОГООН ЭДИЙН ЗАСАГ	61
8.1. Ногоон санхүүжилт, ногоон эдийн засгийн шилжилтийн хамрах хүрээ	61
8.2. Ногоон санхүүжилт, ногоон эдийн засгийн олон улсын шалгуур үзүүлэлтүүд	62
8.3. Монгол Улсын салбарын хууль, бодлогын баримт бичгүүд	62

8.4. Бодлогын баримт бичигт тусгагдсан шалгуур үзүүлэлт	63
9. БОЛОВСРОЛ, ИННОВАЦИ БА НОГООН УР ЧАДВАР	63
9.1. Боловсрол, Инноваци ба Ногоон ур чадварын шилжилтийн хамрах хүрээ	64
9.2. Боловсрол, инноваци ба ногоон ур чадварын олон улсын шалгуур үзүүлэлтүүд	64
9.3. Монгол Улсын салбарын хууль, бодлогын баримт бичгүүд	65
9.4. Бодлогын баримт бичигт тусгагдсан шалгуур үзүүлэлтүүд	65
10. ДҮГНЭЛТ	66
11. ЭХ СУРВАЛЖ	66

Хүснэгтийн тайлбар

Хүснэгт 1. Цэвэр эрчим хүчний шилжилтийн олон улсын шалгуур үзүүлэлтүүд	46
Хүснэгт 2. World Energy Trilemma 2024 (2023 оны дата мэдээлэл)	46
Хүснэгт 3. Монгол Улс ба Energy Transition Index Emerging Asia Ranking	47
Хүснэгт 4. Эрчим хүчний салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүд	48
Хүснэгт 5. Монгол Улсын цэвэр эрчим хүчний шилжилтийн шалгуур үзүүлэлтүүд	48
Хүснэгт 6. Ногоон тээврийн хэрэгслийн шилжилтийн олон улсын шалгуур үзүүлэлтүүд	50
Хүснэгт 7. Тээврийн салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүд	50
Хүснэгт 8. Монгол Улсын ногоон тээврийн хэрэгслийн шилжилтийн шалгуур үзүүлэлтүүд	50
Хүснэгт 9. Ногоон үйлдвэрлэл ба тойрог эдийн засгийн шилжилтийн олон улсын шалгуур үзүүлэлтүүд	52
Хүснэгт 10. Ногоон үйлдвэрлэл ба тойрог эдийн засгийн салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүд	52
Хүснэгт 11. Монгол Улсын ногоон үйлдвэрлэл ба тойрог эдийн засгийн шилжилтийн шалгуур үзүүлэлтүүд	53
Хүснэгт 12. Тогтвортой мал аж ахуй, хүнсний системийн шилжилтийн олон улсын шалгуур үзүүлэлтүүд	54
Хүснэгт 13. Тогтвортой мал аж ахуй, хүнсний системийн салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүд	54
Хүснэгт 14. Монгол Улсын тогтвортой мал аж ахуй, хүнсний системийн шилжилтийн шалгуур үзүүлэлтүүд	55
Хүснэгт 15. Ногоон барилга байгууламж, ногоон хотын олон улсын шалгуур үзүүлэлтүүд	56
Хүснэгт 16. Ногоон барилга байгууламж, хотын салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүд	56
Хүснэгт 17. Монгол Улсын ногоон барилга байгууламж, хотын шилжилтийн шалгуур үзүүлэлтүүд	58
Хүснэгт 18. Байгалийн нөөц, биологийн олон янз байдлын хамгааллын шилжилтийн олон улсын шалгуур үзүүлэлтүүд	59
Хүснэгт 19. Байгалийн нөөц, биологийн олон янз байдлын хамгааллын салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүд	59
Хүснэгт 20. Монгол Улсын байгалийн нөөц, биологийн олонянз байдлын шилжилтийн шалгуур үзүүлэлтүүд	61
Хүснэгт 21. Ногоон санхүүжилт, ногоон эдийн засгийн олон улсын шалгуур үзүүлэлтүүд	62
Хүснэгт 22. Ногоон санхүүжилт, ногоон эдийн засгийн салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүд	62
Хүснэгт 23. Монгол Улсын ногоон санхүүжилт, эдийн засгийн шилжилтийн шалгуур үзүүлэлтүүд	63
Хүснэгт 24. Боловсрол, инноваци ба ногоон ур чадварын олон улсын шалгуур үзүүлэлтүүд	64
Хүснэгт 25. Боловсрол, инноваци ба ногоон ур чадварын салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүд	65
Хүснэгт 26. Монгол Улсын боловсрол, инноваци ба ногоон ур чадварын шилжилтийн шалгуур үзүүлэлтүүд	65

Зургийн тайлбар

Зураг 1. Трилемма индексийн тэнцвэр – Ази	46
Зураг 2. Эрчим хүчний шилжилтийн индексийн хүрээ	47
Зураг 3. Эрчим хүчний шилжилтийн индексийн эрэмбэлэгдсэн хүснэгт	47
Зураг 4. Монгол Улсын эх үүсвэрүүдийн суурилагдсан хүчин чадал	48
Зураг 5. Дэлхийн цахилгаан тээврийн хэрэгслийн борлуулалт	49
Зураг 6. Монгол Улсын тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн төрөл	49
Зураг 7. Тойрог эдийн засаг, үйлдвэрлэлийн загварчлал	51
Зураг 8. 2025-2026 оны бэлчээрийн даац	54
Зураг 9. Дэлхийн агаарын чанарын тайлан 2024	57
Зураг 10. Жилийн дундаж PM2.5 агууламжид үндэслэсэн улс, бүс нутгийн бохирдлын зэрэглэл	58
Зураг 11. Дэлхийн хамгийн их агаарын бохирдолтой томоохон хотуудын зэрэглэл	58
Зураг 12. Улаанбаатар хотын агаарын бохирдлын дундаж	58
Зураг 13. Аюулт үзэгдэл, осол	60
Зураг 14. Ногоон бонд	63
Зураг 15. Ногоон зээл	63
Зураг 16. Байгаль орчны салбарын ногоон ажлын байрыг тодорхойлох схем	65
Зураг 17. Байгаль орчны бүтээгдэхүүн үйлдвэрлэл	65

Графикийн тайлбар

График 1. Монгол Улсын цахилгаан автомашины тоо хэмжээ	49
График 2. Хог хаягдлын дахин боловсруулалт	52
График 3. Малын тоо, толгой	55
График 4. Инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд амьдардаг өрх	57
График 5. Улаанбаатар хотын агаарынбохирдлын жилийн дундаж агууламж	57
График 6. Ойн нөхөн сэргээлтийн хэмжээ	61

1. Ногоон хөгжлийн шилжилт

Ногоон шилжилт гэдэг ойлголт нь эдийн засаг болон нийгмийн хөгжлийг нүүрстөрөгчийн бага ялгаралттай, нөөцийн хэмнэлттэй, хүртээмжтэй, тогтвортой хөгжил рүү чиглүүлэх бүтцийн өөрчлөлт юм. Энэ шилжилт нь чулуужсан түлшний хамаарлыг бууруулж, цэвэр эрчим хүч, нөөцийн эргэлтийн хэрэглээ, экосистемийн сэргээн босголт, ногоон ажлын байр зэрэг тогтвортой шийдлүүдээр орлуулахад чиглэдэг. Иймээс ногоон шилжилт нь зөвхөн эдийн засгийн шинэчлэл төдийгүй нийгмийн өөрчлөлт юм. Ногоон шилжилтийг дараах 8 тулгуур баганын хүрээнд авч үзнэ:

1. Цэвэр эрчим хүчний шилжилт
2. Ногоон тээврийн хэрэгсэл
3. Ногоон үйлдвэрлэл ба тойрог эдийн засаг
4. Тогтвортой мал аж ахуй, хоолны систем
5. Ногоон барилга байгууламж, хотууд
6. Байгалийн нөөц, биологийн олон янз байдлын хамгаалал
7. Ногоон санхүүжилт, ногоон эдийн засаг
8. Боловсрол, инноваци ба ногоон ур чадвар

2. Цэвэр эрчим хүчний шилжилт

XXI зууны эхэн үеэс дэлхийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг тодорхойлох хамгийн гол үзүүлэлтүүдийн нэг нь эрчим хүчний хүрэлцээтэй байдал болж байна. Дэлхийн улс орнууд аж үйлдвэрийн эрин үед хөдөлмөр, түүхий эдэд тулгуурлан хөгжиж байсан бол өнөөдөр эрчим хүчинд тулгуурласан үйлдвэрлэл, үйлчилгээ, мэдээлэл, инноваци, технологийн хөгжилд шилжлээ. Өөрөөр хэлбэл улс орнуудын эдийн засгийн өсөлт, технологийн дэвшил, нийгмийн тогтвортой байдал нь эрчим хүчний хангалт, найдвартай байдалтай шууд хамааралтай юм.

Сүүлийн арван жилд дэлхий дахинд өрнөж буй дижитал шилжилт нь эрчим хүчний хэрэглээний бүтэц, хэмжээг эрс өөрчилсөн. Дата төвүүд, үүлэн тооцоолол, хиймэл оюун ухаан, блокчэйн, өндөр хүчин чадалтай тооцоолох системүүд нь асар их хэмжээний цахилгаан эрчим хүчийг тасралтгүй, найдвартай хэлбэрээр шаарддаг. Нэг дата төв нь дунд хэмжээний хотын цахилгааны хэрэглээтэй тэнцэх тохиолдол ч бий. Үүн дээр аж үйлдвэрийн автоматжуулалт, роботжуулалт, ухаалаг үйлдвэр, ухаалаг цахилгаан хэрэгслүүд, цахилгаан тээврийн өсөлт эрчимтэй нэмэгдэхийн хэрээр эрчим хүчний эрэлт огцом өсөх шинэ шатанд орж байна.

Гэвч эрчим хүчний хэрэглээ ингэж нэмэгдэж буй энэ үед, уур амьсгалын өөрчлөлтийн бодит хямралтай нүүр тулж байна. Эдийн засгийн өсөлтийг тэтгэж

ирсэн нүүрс, нефть, байгалийн хий зэрэг шатах түлш нь хүлэмжийн хийн ялгарлын гол эх үүсвэр болсоор ирсэн. Үүний үр дагаварт дэлхийн дундаж температур нэмэгдэж, цаг уурын эрс тэс үзэгдэл олширч, хүнс, ус, экосистем, хот суурин газрын аюулгүй байдалд системийн эрсдэл үүсээд байна. Энэ нөхцөлд дэлхийн улс орнууд, олон улсын санхүүгийн байгууллагууд, бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагууд цэвэр эрчим хүчний үйлдвэрлэлийг нэн тэргүүний стратегийн зорилт болгон тодорхойлж эхэллээ. Эрчим хүчний салбарт чулуужсан, шатах түлшинд суурилсан одоогийн эх үүсвэрүүдийг сэргээгдэх болон бага нүүрстөрөгчийн эх үүсвэрүүдийг шат дараатай солин хүлэмжийн хийг бууруулах зорилтыг голлох болсон.

Нар, салхи, ус зэрэг сэргээгдэх эрчим хүчний технологийн өртөг сүүлийн хорин жилд эрс буурч олон бүс нутагт хамгийн хямд цахилгааны эх үүсвэр болсон. Харин чулуужсан түлшний хувьд олон улсын хөрөнгө оруулалтын хязгаарлалт, хоригт орсноор өртөг нэмэгдэх, хөрөнгө оруулагч олдохгүй байх гэх мэт хүндрэлтэй нөхцөл байдлыг дагуулж эхлээд байна.

Эрчим хүч гэдэг ойлголт зөвхөн “цахилгаан үйлдвэрлэл” асуудлаас хальж, дижитал эдийн засаг, технологийн өрсөлдөх чадвар, үндэсний аюулгүй байдал, уур амьсгалын бодлогын огтлолцол дээр төвлөрөх боллоо. Цэвэр эрчим хүчний шилжилт нь улс орнуудын ирээдүйн хөгжлийг тодорхойлох тэргүүлэх хүчин зүйл болсон.

2.1. Цэвэр эрчим хүчний шилжилтийн хамрах хүрээ

Цэвэр эрчим хүчний шилжилт нь дараах үндсэн 4 хэсгийг хамаарна.

- 1) **Сэргээгдэх эрчим хүч:** Байгалийн хязгаарлагдмал нөөцийг ашиглан чулуужсан болон шингэн түлшинд түшиглэсэн эрчим хүчний үйлдвэрлэлээс шавхагдашгүй нөөц буюу нар, салхи, усны сэргээгдэх эрчим хүч рүү шилжихэд дараах давуу талууд үүснэ:

- Уур амьсгалын өөрчлөлт / байгальд ээлтэй технологи
- Эрүүл, аюулгүй орчин / хорт бодис ялгаруулахгүй
- Эдийн засгийн үр ашиг өндөр / СЭХ-ийн задрал буурсан.

Сэргээгдэх эрчим хүчийг орлуулах бус үндсэн эрчим хүчний эх үүсвэр болгон хөгжүүлсээр байна.

- 2) **Эрчим хүчний хэмнэлт:** Эрчим хүчний эрэлт нэмэгдсэнээр улам бүр үнэ цэнэ нь нэмэгдэж “Хэмнэсэн эрчим хүч бол үйлдвэрлэсэн эрчим хүчтэй адил үнэ цэнтэй” гэх үзэл санаа бий болсон. Өөрөөр хэлбэл эрчим хүчний хэрэглээг багасгах, илүү үр ашигтай болгох нь шинэ цахилгаан станц барихаас ч дутахааргүй ач холбогдолтой бодлого болжээ.

- 3) **Ухаалаг сүлжээ болон хадгалах шийдлүүд:** Цэвэр эрчим

хүчний шилжилт нь зөвхөн сэргээгдэх эрчим хүчний ойлголт биш юм. Сэргээгдэх эрчим хүч нь тогтвортой бус нийлүүлэлттэй байдаг тул илүү үр ашигтай ашиглахад ухаалаг сүлжээ, хуримтлуур, хадгалах шийдлүүд зайлшгүй шаардагдах дэд бүтэц болон хөгжиж байна.

- 4) **Халаалт, дулааны эх үүсвэр:** Барилга, хот суурин газрыг дулаанаар хангах асуудал олон арван жилийн турш нүүрс, нефть, хийд тулгуурласан хэвээр байв. Гэвч энэ

уламжлалт ойлголт эрс өөрчлөгдөж, дулаан хангамж шинэ шатанд гарч байна. Цахилгаан эрчим хүчийг ашиглан дулааны эх үүсвэр болгон ашиглах, хувиргах технологиуд илүү хурдацтай хөгжсөнөөр дулаан хангамж нь шатах түлшнээс хамаарлаа бууруулж илүү цэвэр, хүлэмжийн хийн ялгаралгүй дулааны эх үүсвэртэй болох боломжийг нээсэн.

2.2. Цэвэр эрчим хүчний шилжилтийн олон улсын шалгуур үзүүлэлтүүд

Хүснэгт 1. Цэвэр эрчим хүчний шилжилтийн олон улсын шалгуур үзүүлэлтүүд

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ХЭМЖИХ НЭГЖ	ОН	КАЗАХСТАН	ЭНЭТХЭГ	ХЯТАД	КАМБОЖ	МОНГОЛ
Эрчим хүчний эцсийн хэрэглээ дэх сэргээгдэх эрчим хүч	Хувь	2021	2.00	34.90	15.20	52.40	3.00
Эрчим хүчний салбарын чадамж (MJ/\$2021 PPP GDP)	Мегажоуль / ДНБ	2021	6	4	6	5	7
Нүүрсэн эрчим хүчнээс ялгарах нүүрс хүчлийн хий (CO ₂)-ийн хэмжээ	Тонн/хүн	2023	7.2	1.4	6.0	0.26	12.0
Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл дэх суурилагдсан хүчин чадал	Вт/хүн	2022	261	115	814	110	82
Цахилгаан болон хоол хийх цэвэр түлшэнд нэвтрэх боломж (нийт хүн амын %)	Хувь	2023	94	77	89	58	56
Эрчим хүч үйлдвэрлэл дэх сэргээгдэх эрчим хүч	Хувь	2021	3.0	9.2	12.9	5.0	9.9

Эх сурвалж: World Bank Data


2.3. Эрчим хүчний олон улсын үнэлгээ, индекс

2.3.1. World Energy Trilemma 2024 Report

Гурвалсан индекс буюу Trilemma score индексийн оноо нь эрчим хүчний аюулгүй байдал, эрчим хүчний тэгш байдал, байгаль орчны тогтвортой байдал гэсэн гурван хэмжээсийн дундаж үзүүлэлт юм. Хамгийн өндөр оноо 100, хамгийн бага нь 0 байна.

- Эрчим хүчний аюулгүй байдал (Energy security) нь улсын эрчим хүчний одоогийн болон ирээдүйн эрэлт хэрэгцээг найдвартай хангах чадвар, системийн доголдлыг даван туулах болон богино хугацаанд сэргээн хэвийн ажиллуулах чадварыг хэлнэ.
- Эрчим хүчний тэгш байдал (Energy equity) нь улс орон бүх

Зураг 1. Трилемма индексийн тэнцвэр – Ази



Эх сурвалж: World Bank Data

Хүснэгт 2. World Energy Trilemma 2024 (2023 оны дата мэдээлэл)

УЛС	ДЭЛХИЙД ЭЗЛЭХ ЭРЭМБЭ	АЗИД ЭЗЛЭХ ЭРЭМБЭ	ТЭНЦВЭРИЙН ЗЭРЭГ	ГУРВАЛСАН ИНДЕКСИЙН ОНОО	ЭРЧИМ ХҮЧНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ОНОО	ЭРЧИМ ХҮЧНИЙ ТЭГШ БАЙДЛЫН ОНОО	БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ОНОО
Латви	19	-	ABAa	76.3	72.1	86.5	74.8
Орос	39	-	ABCd	66.1	69.6	77.6	58.6
Хятад	47	9	ABDb	64.4	66.3	73	56.4
Казахстан	51	-	BBDc	63.4	62.4	79.8	52.5
Энэтхэг	74	17	BDDc	55.6	61.7	49.5	56.5
Монгол	76	18	DCDc	52.7	48.1	68.9	43.3
Камбож	80	19	CDCd	47.7	53.2	31.8	59.4
Балба	91	23	DDDd	40.5	32.7	30.9	57.2

Эх сурвалж: World Energy Trilemma 2024


иргэд, аж ахуйн нэгжид найдвартай, боломжийн үнэтэй, хүртээмжтэй эрчим хүч нийлүүлэх чадварыг үнэлнэ.

- Байгаль орчны тогтвортой байдал (Environmental sustainability) нь уур амьсгалын өөрчлөлт болон байгаль орчны сөрөг нөлөөг бууруулах зорилгоор эрчим хүчний системд хийгдэх шилжилт, өөрчлөлтийг илэрхийлнэ.

2.3.2. WEF Fostering Effective Energy Transition 2025 Report

Дэлхийн эдийн засгийн форумаас жил бүр бэлтгэн гаргадаг “Fostering Effective Energy Transition 2025” тайлан нь дэлхийн улс орнуудын эрчим хүчний шилжилтийн хурд болон өнөөгийн байдлыг харуулдаг. Энэхүү тайлангийн гол үзүүлэлт болох эрчим хүчний шилжилтийн индексийн оноо (ETI score) нь тухайн улсын эрчим хүчний системийн одоогийн түвшин болон шилжилт хийх нөхцөл, боломж, байдлыг нэгтгэн харуулсан ерөнхий үзүүлэлт юм. Эрчим хүчний системийн үйл ажиллагааны үзүүлэлтээр (System performance) нь эрчим хүчний системийн одоогийн бодит үр дүн болох эрчим хүчний хүртээмж, найдвартай, тогтвортой байдал, байгаль орчны нөлөөллийг хэлнэ. Харин шилжилтийн бэлэн байдлын үзүүлэлтээр (Transition readiness) нь тухайн улс ирээдүйд цэвэр, тогтвортой эрчим хүчний системд шилжих боломж, бэлтгэл ямар байгааг хэмжинэ.

Зураг 2. Эрчим хүчний шилжилтийн индексийн хүрээ



Эх сурвалж: WEF Fostering Effective Energy Transition 2025

Энэхүү үзүүлэлтээр Монгол Улс 118 улсаас 115-р байранд эрэмбэлэгдэж, дэхийн улс орнуудын сүүлд байгаа нь манай эрчим хүчний системийн шинэчлэл, шилжилтийн явц маш удаан байгааг харуулж байна (Зураг 3).

Зураг 3. Эрчим хүчний шилжилтийн индексийн эрэмбэлэгдсэн хүснэгт

101	Pakistan		48.5	55.5	38.1
102	Iran, Islamic Rep.		47.6	58.8	30.8
103	Brunei Darussalam		47.6	57.9	32.1
104	Nepal		47.5	55.1	36.2
105	Bahrain		47.2	54.3	36.6
106	Mozambique		47.1	56.1	33.6
107	Nicaragua		46.8	56.1	32.9
108	Honduras		46.5	57.5	30.0
109	Zambia		46.3	51.8	38.1
110	Senegal		46.1	56.3	30.7
111	Tanzania		46.0	57.3	29.1
112	Ethiopia		45.9	58.3	27.2
113	Zimbabwe		44.8	53.3	32.2
114	Jamaica		44.5	50.8	35.0
115	Mongolia		44.2	53.7	29.9
116	Trinidad and Tobago		44.0	55.2	27.0
117	Botswana		42.8	49.4	32.8
118	Congo, Dem. Rep.		42.4	50.3	30.4

Эх сурвалж: WEF Fostering Effective Energy Transition 2025

Хүснэгт 3. Монгол Улс ба Energy Transition Index Emerging Asia Ranking

УЛС	ДЭЛХИЙН ЭРЭМБЭ	ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТИЙН ИНДЕКСИЙН ОНОО 2025	ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА 2025	ШИЛЖИЛТИЙН БЭЛЭН БАЙДАЛ 2025
Хятад	12	67.5	65.1	71.3
Энэтхэг	71	53.3	60.4	42.7
Камбож	73	53.1	61.0	41.2
Казахстан	94	50.3	58.8	37.5
Тажикистан	95	50.2	61.3	33.5
Лаос БНАЛАУ	98	49.6	54.0	43.0
Балба (Непал)	104	47.5	55.1	36.2
Монгол	115	44.2	53.7	29.9

Эх сурвалж: WEF Fostering Effective Energy Transition 2025

2.4. Монгол Улсын эрчим хүчний салбарын бодлогын баримт бичгүүд

Эрчим хүчний салбарт МУ-ын УИХ-ын 2015 оны дугаар 63 тогтоолоор “Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого 2015-2030” бие даасан бодлогын баримт бичиг 5 бүлэг, 94 зүйл заалт, 9 тулгуур зарчим, 39 зорилго, зорилт, 2 үе шатны 16 зорилтот үр дүн, бодлогын хэрэгжилтийг үнэлэх шалгуур бүхий 9 үзүүлэлтийг багтаасан байдаг. 2018 онд Засгийн газрын 325 дугаар тогтоолоор “Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны үндэсний хөтөлбөр 2018-2023” баталсан. Тус хөтөлбөрт 27 зорилт, 97 төсөл, арга хэмжээг тусган үндсэн 9 шалгуураар үнэлэхээр туссан. 2021 онд УИХ-ын 89 дугаар тогтоолоор хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн уялдаа холбоо, нийцлийг хангаж, давхардал, зөрчлийг арилгах зорилгоор тухайлсан салбарын бодлогын баримт

бичгийг хүчингүй болгон урт, дунд, богино хугацааны нэгдсэн бодлого төлөвлөгөөнд уягдан явах болж эрчим хүчний салбар бие даасан бодлогогүй болсон. Эрчим хүчний салбарт дараах бодлогын баримт бичгүүд, олон улсын зорилт хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Хүснэгт 4. Эрчим хүчний салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүд

1. ЦЭВЭР ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТ	БАТЛАГДСАН ОГНОО	ТАЙЛБАР
Эрчим хүчний салбарын хуулиуд		
Эрчим хүчний тухай хууль	2001	Эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлтийн зохицуулалт
Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль	2007	СЭХ-ийг дэмжих, хөрөнгө оруулалт татах
Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль	2015	Эрчим хүчний хэрэглээг бууруулах
Цөмийн энергийн тухай хууль	2009	Цөмийн эрчим хүчний эх үүсвэр
Усны тухай хууль (УЦС, ус ашиглалттай холбоотой)	2012	УЦС ус ашиглах зөвшөөрөл
Зөвшөөрлийн тухай хууль	2022	Тусгай зөвшөөрөл олгох
Агаарын тухай хууль	2012	Агаарын чанарыг сайжруулах, цахилгаан, дулааны хэрэглээг хянах, урамшуулах
Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль (PPP)	2023	Төр, хувийн хэвшлийн түншлэлээр төсөл хэрэгжүүлэх
Бодлогын баримт бичиг		
Алсын хараа-2050	2020	Эрчим хүчний аюулгүй байдал, ногоон шилжилт, бүс нутгийн хөгжил
Шинэ сэргэлтийн бодлого	2021	Дэд бүтэц, эрчим хүчний төслүүд
Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал (2024-2050)	2024	Бүсчилсэн хөгжил
Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	2025	Дэд бүтэц, эрчим хүчний төсөл, арга хэмжээнүүд
Хөтөлбөр, төлөвлөгөө		
Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр	2024	Эх үүсвэрийг нэмэгдүүлэх, СЭХ дэмжих, сүлжээний шинэчлэл
Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө	2025	Эх үүсвэрийг нэмэгдүүлэх, сүлжээний шинэчлэл
Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр	2017	Агаар, орчны бохирдлыг бууруулж эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх
Олон улсын хэлцэл		
Парисын хэлцэл – Уур амьсгалын өөрчлөлтийн конвенц	2017	Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндэсний зорилт

Эх сурвалж: Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем

Бодлогын баримт бичгүүдэд:

- Сэргээгдэх эрчим хүчний экспортлогч болох
- 2030 онд суурилагдсан хүчин чадлын 30%-д сэргээгдэх эрчим хүч эзлэх
- Ухаалаг систем нэвтрүүлэх
- Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилтууд туссан байна.

2024 оны байдлаар Бөөрөлжүүтийн 150МВт-ын нүүрсэн цахилгаан станцыг оруулан тооцоход сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь 18.6%-тай байна.

Зураг 4. Монгол Улсын эх үүсвэрүүдийн суурилагдсан хүчин чадал

МВт	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
Суурилагдсан хүчин чадал	1,514	1,549	1,564	1,564	1,664
Үүнээс: ДЦС-ууд	1,234	1,269	1,269	1,269	1,319
Эзлэх хувь	81.5%	81.9%	81.1%	81.1%	79.2%
СЭХ үүсгүүрүүд	271.2	271.2	286.8	286.8	336.8
Эзлэх хувь	17.9%	17.5%	18.3%	18.3%	20.2%
Дизель үүсгүүр	8.6	8.6	8.6	8.6	8.6
Эзлэх хувь	0.6%	0.6%	0.5%	0.5%	0.5%
ДЦС-уудын СХЧ ашиглалтын цаг	5,262	5,602	5,854	6,111	6,249
СЭХ-үүдийн СХЧ ашиглалтын цаг	2,394	2,960	2,611	2,640	2,893
СЭХ-үүдийн СХЧ ашиглалтын хувь	27.3%	33.8%	29.8%	30.8%	33.0%

Тайлбар: Бөөрөлжүүтийн 150 МВт-ын цахилгаан станцыг оруулахад 1,814 МВт болно.

Эх сурвалж: Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны статистик тайлан

2.5. Бодлогын баримт бичигт тусгагдсан шалгуур үзүүлэлтүүд

Хүснэгт 5. Монгол Улсын цэвэр эрчим хүчний шилжилтийн шалгуур үзүүлэлтүүд

ҮЗҮҮЛЭЛТ	ХЭМЖИХ НЭГЖ	СУУРЬ		АХ 2050, 2026-2030	АХ - 2050
1. Цэвэр эрчим хүчний шилжилт		Он	Түвшин	2030 он	2050 он
Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын эзлэх хувь	Хувь	2015	-	100	100
Оргил ачаалалд тохируулгын эх үүсвэрийн чадал/үйлдвэрлэл	МВт / МВт.ц	2024	120.6	386.6	-
Эрчим хүчний үйлдвэрлэлийн хүлэмжийн хийн ялгарлын бууралт	Мян.тн CO2	2024	1,042.40	5,399.30	-
Сэргээгдэх эрчим хүчний суурилагдсан хүчин чадалд эзлэх хувь	Хувь	2024	20.2	30	-
Цахилгаан эрчим хүчний дамжуулалтын алдагдал	Хувь	2024	3.8	3.9	-
Цахилгаан түгээлтийн алдагдал	Хувь	2024	8.7	7.2	-
Үүрэг хүлээсэн хэрэглэгчдийн эрчим хүчний нийт хэрэглээнд эзлэх эрчим хүчний хэмнэлт	Хувь	2024	0.86	1.3	-
ДНБ, анхдагч эрчим хүчээр хэмжсэн эрчим хүчний үр ашиг	ГДЖ/ сая.төг	2022	38.6	32.2	-
Барилга, байгууламжийн дулаан хамгаалал, чанар, аюулгүй байдал, гамшигт тэсвэртэй байдал	Хувь	2024	10	30	-

3. Ногоон тээврийн хэрэгсэл

Тээврийн хэрэгсэл нь орчин үеийн эдийн засгийн өсөлт, худалдаа, хотжилт, хүний өдөр тутмын хэрэглээний хамгийн том орон зайг эзэлдэг бүтээгдэхүүн болжээ. Автомашин нь үйлдвэрлэл, худалдаа, хөдөлмөрийн зах зээлийг холбож, хотуудын хэлбэр дүрс, иргэдийн амьдралын хэв маягийг тодорхойлсоор ирсэн. Тээврийн хэрэгсэл нь аль ч цаг үед нийгмийн болон эдийн засгийн сорилт, шаардлагыг даван туулсаар зогсолтгүй хөгжсөөр ирсэн.


Одоогийн нөхцөлд автомашины тоо олшрох тусам хотуудын агаар утаанд дарагдаж, замын түгжрэл хэвийн үзэгдэл болж, нефть, шатахууны импорт улс орнуудын эдийн засгийн аюулгүй байдалд нөлөөлөх хэмжээнд хүрч байна. Тээврийн салбар нь өнөөдөр хүлэмжийн хийн ялгарлын томоохон эх үүсвэрүүдийн нэг болж, уур амьсгалын өөрчлөлтийг хурдасгах нэгэн хүчин зүйл болсон. Тээврийн салбарын шатах түлш ашигладаг уламжлалт хөгжил нь түүхий эдийн хамаарлыг нэмэгдүүлж байгаль орчин, эрүүл мэнд, хотын амьдрах орчинд өндөр өртөг дагуулж эхэлсэн юм. Энэ нөхцөл байдлыг зайлшгүй өөрчилж эдийн засаг, байгаль орчны уялдааг хангасан системийг ногоон тээврийн хэрэгсэл хэмээх шинэ ойлголтоор өөрчилж байна. Ногоон тээвэр нь зөвхөн утаа багатай автомашин үйлдвэрлэх тухай бус, харин эрчим хүчний хэрэглээ, хотын төлөвлөлтийг бүхэлд нь шинэчлэх хөгжлийн шинэ чиг хандлага болсон юм.

Сүүлийн жилүүдэд энэхүү шилжилтийг бодит болгоход батарей-хуримтлуурын технологийн үсрэнгүй хөгжил нь голлох үүрэг гүйцэтгэж байна. Батарейн багтаамж нэмэгдэж, өртөг огцом буурч, ашиглалтын хугацаа уртассан нь цахилгаан тээврийн хэрэгслийг өргөн хэрэглээнд нэвтрүүлэх үндэс болжээ. Үүний үр дүнд цахилгаан автомашин нь:

- шатах түлш шаарддаггүй,
- ашиглалтын явцад утаа ялгаруулдаггүй,
- үнийн өрсөлдөх чадвар сайжирсан,
- хотын орчинд илүү тохиромжтой гэсэн бодит давуу талуудыг бий болгож байна.

Үүнээс гадна үйлдвэрлэгчид хэрэглэгчийн хэрэгцээнд нийцсэн олон төрлийн загвар, үнийн сонголтыг санал болгож эхэлсэн нь ногоон тээврийн хэрэгслийг зөвхөн байгальд ээлтэй шийдэл бус, эдийн засгийн хувьд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн болгон хувиргасаар байна.

Зураг 5. Дэлхийн цахилгаан тээврийн хэрэгслийн борлуулалт



Эх сурвалж: Global EV Outlook 2025

Цахилгаан тээврийн хэрэгслийн борлуулалт 2020 онд нийт борлуулалтын дундаж 5%-тай байсан бол 2025 оны хагас жилд гэхэд 25%-д хүрсэн байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд цахилгаан автомашины борлуулалт жилд дунджаар 34%-аар өссөн.

График 1 Монгол Улсын цахилгаан автомашины тоо хэмжээ



Эх сурвалж: Зам, тээврийн салбарын статистикийн эмхэтгэл

Зураг 6. Монгол Улсын тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн төрөл



Эх сурвалж: Зам, тээврийн салбарын статистикийн эмхэтгэл 2024

Манай улсын хувьд цахилгаан автомашин сүүлийн 5 жилийн хугацаанд дунджаар 45%-аар өссөн. Тээврийн хэрэгслийг хөдөлгүүрийн төрлөөр ангилбал, 34.8%-ийг бензин, 37.5%-ийг хосолсон, 26.2%-ийг дизель, 1.3%-ийг хийн түлштэй, 0.1%-ийг цахилгаан тээврийн хэрэгсэл эзэлж байна.

3.1. Ногоон тээврийн хэрэгслийн шилжилтийн хамрах хүрээ

Ногоон тээврийн шилжилт нь дараах үндсэн 4 хэсгийг хамаарна:

- 1) **Цахилгаан тээврийн хэрэгсэл (EV) болон EV дэд бүтэц:** Тээврийн хэрэгсэл нь цахилгаанд шилжсэнээр байгаль орчинд сөргөөр нөлөөлөх нөлөөллийг бууруулж ухаалаг хэрэглээг дэмжиж байна. Цахилгаан тээврийн хэрэгслийн үндэс нь дэд бүтцийн цогц шийдлийг хамтад нь авч үзэх шаардлагатай.
- 2) **Нийтийн тээвэр болон моторгүй хөдөлгөөн (дугуй, явган аялал):** Хотын хөгжил бол зөвхөн барилга, замын асуудал биш юм. Энэ бол хүмүүс орон зайгаа хэрхэн хуваалцаж буй ойлголт юм. Автомашинд суурилсан

хотжилт дэлхий даяар давамгайлж, хувь хүний хөдөлгөөнийг хялбарчилсан ч замын түгжрэл, агаарын бохирдол, дуу чимээ, хотын орон зайн алдагдал гэх мэт хүндрэлүүд нь нийтийн тээвэр болон моторгүй хөдөлгөөнийг хотын хөгжлийн төлөвлөлтөд гол байр сууринд авчрах шалтгаан болж байна. Иймд цахилгаан нийтийн тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх замаар хүндрэлтэй нөхцөл байдлыг даван туулах юм.

3) Тогтвортой нисэх хүчин болон тээврийн түлш: Аялал жуулчлал, олон улсын худалдаа, бизнесийн хөдөлгөөн, хүмүүнлэгийн ажиллагаа гээд орчин цагийн олон үйл ажиллагаа агаарын тээврээс шууд хамааралтай болсон. Нисэх онгоцны ихэнх нь өнөөдөр шатах түлшинд бүрэн тулгуурлаж байгаа нь салбарын нүүрсхүчлийн хийн ялгарлыг бууруулах явцыг удаашруулж байна. Нисэх онгоц нь хүнд жинтэй, урт зайд нисдэг, өндөр аюулгүй байдлын шаардлагатай учраас автомашин шиг хурдан цахилгаан шилжилт хийх боломжгүй байна. Иймээс нисэх хүчинд түлшийг сайжруулах, устөрөгчийн түлш гэх мэт олон хувилбараар хөгжүүлэлт идэвхтэй хийгдсээр байна.

4) Бага тойрогтой, дамжин өнгөрөх чиглэлтэй хөгжлийн хот төлөвлөлт: Хотын хөгжил нь төвөөс зах руу тэлсэн орон сууц, хол зайн ажил, үйлчилгээ, автомашинд тулгуурласан хөдөлгөөн нь иргэдийн зорчилтын хугацааг уртасгаж замын түгжрэл, агаарын бохирдол гэх мэт асуудлууд хотыг амьдрахад улам төвөгтэй болгож байна. Хот төлөвлөлт нь иргэдийг богино зайнд үйлчилгээ авах цогц төвтэй холбосноор эдгээр хүндрэлтэй асуудлуудыг арилгахад туслах юм.

3.2. Ногоон тээврийн хэрэгслийн олон улсын шалгуур үзүүлэлтүүд

Хүснэгт 6. Ногоон тээврийн хэрэгслийн шилжилтийн олон улсын шалгуур үзүүлэлтүүд

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ХЭМЖИХ НЭГЖ	ОН	КАЗАХСТАН	ЭНЭТХГ	ХЯТАД	КАМБОЖ	МОНГОЛ
Тээврийн салбарын нүүрс хүчлийн хийн ялгарал	Сая тонн CO ₂	2023	29.5	353.9	1048.4	7.3	3.6
Нийт тээврийн хэрэгсэл дэх цахилгаан тээврийн хэрэгсэл	Хувь	2024	-	0.5	11	-	-
Нийтийн тээврийн хэрэглээ	Нэг хэрэглэгч-км/хүн	-	-	-	-	-	-
Түлшний эдийн засаг	Л/100 км эсвэл гCO ₂ /км	-	-	-	-	-	-
Хотын агаарын чанар (PM2.5 тоосонцор)	мкг/м3	2019	38.4	55.6	39.1	19.8	58.2

Эх сурвалж: IEA, Our World in Data, WHO

3.3. Монгол Улсын тээврийн салбарын бодлогын баримт бичгүүд

Хүснэгт 7. Тээврийн салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүд

2. НОГООН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ	БАТЛАГДСАН ОГНОО	ТАЙЛБАР
Тээврийн салбарын хуулиуд		
Авто тээврийн тухай хууль	1999	Замын хөдөлгөөн, тээвэрлэлтийн суурь
Авто замын тухай хууль	2017	Улсын болон орон нутгийн зам
Усан замын тээврийн тухай	2017	
Төмөр замын тээврийн тухай хууль	2007	Хувийн хэвшлийн оролцоо
Улсын нисэхийн тухай хууль	2003	Агаарын хөлгөөр нислэг үйлдэх, нисэхийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдал
Иргэний нисэхийн тухай хууль	2023	Олон улсын нислэг, аюулгүй байдал
Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль	2015	Хүний амь нас, эрүүл мэндтэй шууд холбоотой
Далай ашиглах тухай	2022	
Тээврийн хэрэгслийн албан татварын тухай хууль	2012	Цахилгаан тээврийн хэрэгслийг дэмжих
Агаарын бохирдлын тухай хууль	2012	Тээврийн ялгарлын хяналт
Бодлогын баримт бичиг		
Алсын хараа-2050	2020	Ногоон хөгжил, нүүрстөрөгч багатай эдийн засаг
Шинэ сэргэлтийн бодлого	2021	Дэд бүтэц, тээврийн салбарын төслүүд
Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал (2024-2050)	2024	Бүсчилсэн хөгжил
Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2024-2028)	2024	Дэд бүтэц, тээврийн салбарын төслүүд
Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	2025	
Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө	2025	Бүсчилсэн хөгжил, дэд бүтэц, тээврийн салбарын төслүүд

Дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд 2030 он гэхэд цахилгаан болон хосолмол хөдөлгөөр бүхий тээврийн хэрэгслийг 50%-д хүргэх, технологид суурилсан авто замын сүлжээ байгуулах, салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахаар тусгасан байна.

3.4. Бодлогын баримт бичигт тусгагдсан шалгуур үзүүлэлтүүд

Хүснэгт 8. Монгол Улсын ногоон тээврийн хэрэгслийн шилжилтийн шалгуур үзүүлэлтүүд

ҮЗҮҮЛЭЛТ	ХЭМЖИХ НЭГЖ	СУУРЬ		АХ-2050, 2026-2030	АХ - 2050
2. Ногоон тээврийн хэрэгсэл		Он	Түвшин	2030 он	2050 он
Тээврийн салбарын хүлэмжийн хийн ялгарлын бууралт	Мян.тн CO2	2024	227.7	2,762.20	-
Цахилгаан болон хосолмол хөдөлгүүр бүхий тээврийн хэрэгслийн эзлэх хувь	Хувь	2024	37.6	50	-
Төвлөрсөн дулаан хангамжийн суурилагдсан чадал	МВт	2024	3500	4,013	-

4. Ногоон үйлдвэрлэл ба тойрог эдийн засаг

Дэлхийн эдийн засаг үйлдвэрлэл, хэрэглээг хурдацтай тэлэх зорилгоор байгалийн нөөцийг их хэмжээгээр олборлон ашиглаж хөгжиж ирсэн. Энэхүү “олборлолт – үйлдвэрлэл – хэрэглээ – хаягдал” гэсэн хэлбэр нь богино хугацаанд эдийн засгийн өсөлтийг дэмждэг боловч байгаль орчны доройтол, нөөцийн хомсдол, уур амьсгалын өөрчлөлт зэрэг урт хугацааны сөрөг үр дагаврыг бий болгодог. Энэ нөхцөлд үйлдвэрлэлийн хөгжлийг илүү тогтвортой, нөөцийн хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй байдлаар шинэчлэх шаардлага бодитойгоор тавигдаж байна. Үүний нэг шийдэл нь ногоон үйлдвэрлэлт ба тойрог эдийн засгийн үзэл баримтлал юм.

Ногоон үйлдвэрлэлт гэдэг нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд зарцуулагдах эрчим хүч, түүхий эд, ус, бусад нөөцийг оновчтой ашиглах, бохирдол, хаягдлыг бууруулах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг багасгахад чиглэсэн үйлдвэрлэлийн загвар юм. Энэхүү ойлголт нь зөвхөн байгаль хамгаалах зорилготой бус, харин үйлдвэрлэлийн үр ашиг, эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх бодлогын хэрэгсэл юм. Эрчим хүчний үр ашигтай тоног төхөөрөмж, дижитал удирдлага, процессын оновчлол, байгальд ээлтэй материал ашиглалт нь нэгж бүтээгдэхүүнд ногдох зардлыг бууруулж, үйлдвэрлэлийн тогтвортой байдлыг хангах боломж олгодог.

Ногоон үйлдвэрлэлийн үзэл санааг системийн түвшинд өргөжүүлсэн ойлголт нь тойрог эдийн засаг юм. Тойрог эдийн засаг нь нөөцийг нэг удаа ашиглаад хаях бус, аль болох удаан хугацаанд ашиглах, үнэ цэнийг нь хадгалах, үйлдвэрлэлийн хаягдлыг дахин ашиглах, дахин боловсруулах, дахин үйлдвэрлэх замаар эдийн засгийн эргэлтэд буцаан оруулахад чиглэдэг. Үйлдвэрлэлийн нэг салбарын хаягдал нөгөө салбарын түүхий эд болох аж үйлдвэрийн харилцан ашигтай ажиллах нь тойрог эдийн засгийн бодит хэрэгжилтийн жишээ юм.

Зураг 7. Тойрог эдийн засаг, үйлдвэрлэлийн загварчлал



Сүүлийн жилүүдэд технологийн дэвшил ногоон үйлдвэрлэлт, тойрог эдийн засгийг бодит хэрэгжилтийн түвшинд гаргаж байна. Үйлдвэрлэлийн дижиталчлал, автоматжуулалт, хиймэл оюун ухаанд суурилсан удирдлага нь нөөцийн хэрэглээг нарийвчлалтай хянах, алдагдлыг бууруулж ашгийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлж байна. Үүний нэг тод жишээ нь 3D хэвлэл нь материалын хаягдлыг багасгаж, захиалгат үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломж олгож байна. Мөн дахин боловсруулалтын дэвшилтэт технологи, нүүрстөрөгчийг барих, ашиглах шийдлүүд нь үйлдвэрлэлийн нүүрстөрөгчийг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэж байна.

Зах зээлийн түвшинд ногоон үйлдвэрлэлт, тойрог эдийн засаг нь компанийн өрсөлдөх чадварыг тодорхойлох хүчин зүйл болсон. Олон улсын зах зээлд тогтвортой ханган нийлүүлэлтийн сүлжээ, байгаль орчны стандарт, нүүрстөрөгчийн ил тод байдал нь экспорт, хөрөнгө оруулалтын гол шалгуур болон хувирч байна. Иймд ногоон үйлдвэрлэлд эрт шилжсэн байгууллагууд нь зах зээлийн эрсдэлийг бууруулж, урт хугацааны тогтвортой худалдаа, хөрөнгө оруулалтыг татсаар байна.

Ногоон үйлдвэрлэл, тойрог эдийн засагт шилжих үйл явц нь тодорхой сорилтуудтай тулгардаг. Анхны хөрөнгө оруулалтын зардал, технологийн хүртээмж, хүний нөөцийн чадавх, стандарт, зохицуулалтын уялдааны дутмаг байдал нь бодлогын хэрэгжилтийг сааруулж болзошгүй. Иймээс төрөөс урт хугацааны стратеги, зохицуулалтын тогтвортой орчин, санхүүгийн болон инновацийн дэмжлэгийг бодлогын түвшинд бүрдүүлэх шаардлагатай.

4.1. Ногоон үйлдвэрлэл ба тойрог эдийн засгийн шилжилтийн хамрах хүрээ

Ногоон үйлдвэрлэлт ба тойрог эдийн засаг нь дараах үндсэн 2 хэсгийг хамаарна:

- 1) Тойрог эдийн засгийн зарчим: Үйлдвэрлэлийн шатанд түүхий эдийн хэрэглээг багасгах, дахин ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагаанд суурилдаг. Үйлдвэрлэл, хэрэглээний бүх үе шатанд хаягдал үүсгэхээс зайлсхийж, зайлшгүй үүссэн хаягдлыг дахин ашиглах боломжтой нөөц болгон ашиглах нь онцлог юм. Хаягдал нь асуудал

бус, эдийн засгийн үнэ цэнтэй орц материал болох боломжтой.

- Ногоон үйлдвэрлэл ба эко дизайн: Аж үйлдвэрийн салбарыг илүү үр ашигтай, уян хатан, тогтвортой болгох шинэ үеийн үйлдвэрлэлийн стандарт юм. Үйлдвэрлэлийн үйл явцыг байгаль орчинд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, урт хугацаанд тогтвортой байдлаар зохион байгуулах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө багатайгаар төлөвлөх, материалын хэрэглээг багасгах, ашиглалтын хугацааг уртасгах, засварлах, дахин ашиглах, дахин боловсруулах боломжийг нэмэгдүүлэх загвар юм.


4.2. Ногоон үйлдвэрлэл ба тойрог эдийн засгийн олон улсын шалгуур үзүүлэлтүүд

Хүснэгт 9. Ногоон үйлдвэрлэл ба тойрог эдийн засгийн шилжилтийн олон улсын шалгуур үзүүлэлтүүд

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ХЭМЖИХ НЭГЖ	ОН	КАЗАХСТАН	ЭНЭТХЭГ	ХЯТАД	КАМБОЖ	МОНГОЛ
Материалын үр ашиг	Мян. ам.доллар ДНБ/тонн материал	2024	1.1	1.2	0.8	0.8	0.3
Хотын хог хаягдлын дахин боловсруулалт	Хувь	-	-	-	-	-	-
Үйлдвэрийн нүүрс хүчлийн хийн CO ₂ ялгарал	Сая тонн CO ₂	2023	24.9	666.3	2677.9	2.9	2.9
Нийт патент дахь ногоон патентууд	Хувь	-	-	-	-	-	-
Нөөцийн тойрог эдийн засагт орох хувь	Хувь	-	-	-	-	-	-
Хотын хог хаягдал	кг/хүн/жил	-	-	-	-	-	-

Эх сурвалж: OECD, Our World in Data, IEA

График 2. Хог хаягдлын дахин боловсруулалт



Эх сурвалж: Хатуу хог хаягдлын данс 2020-2023

4.3. Монгол Улсын хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүд

Хүснэгт 10. Ногоон үйлдвэрлэл ба тойрог эдийн засгийн салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүд

3. НОГООН ҮЙЛДВЭРЛЭЛТ БА ТОЙРОГ ЭДИЙН ЗАСАГ	БАТЛАГДСАН ОГНОО	ТАЙЛБАР
Салбарын хуулиуд		
Байгаль орчныг хамгаалах тухай	1995	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх
Хог хаягдлын тухай	2017	Хог хаягдлыг дахин боловсруулах зохицуулалт
Барилгын тухай	2016	Барилгын үйл ажиллагаанд ногоон хөгжлийн бодлого, ногоон барилгын шаардлагыг хэрэгжүүлэх
Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай	2022	Хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйлдвэрлэлийг хөгжүүлэх
Шинжлэх ухаан, технологийн тухай	2024	Шинжлэх ухаан, технологийг хөгжүүлж байгальд ээлтэй үр ашигтай ногоон эдийн засгийг дэмжих
Бодлогын баримт бичиг		
Алсын хараа-2050	2020	Ногоон хөгжил, нүүрс төрөгч багатай эдийн засаг
Шинэ сэргэлтийн бодлого	2021	Дэд бүтэц, тээврийн салбарын төслүүд
Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал (2024-2050)	2024	Ногоон үйлдвэрлэл, экосистемийн тэнцвэрт байдлыг хангах
Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	2025	Бүсчилсэн хөгжил, эдийн засаг, дэд бүтцийн хөгжил
Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө	2025	Бүсчилсэн хөгжлийн бодлого
Хөтөлбөр, төлөвлөгөө		
Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2024-2028)	2024	Засгийн газрын хөтөлбөр
Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөр	2025	Салбарын хөтөлбөр
Аймгийн засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр	2025	Аймгийн хөтөлбөр
Нийслэлийн засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр	2025	Нийслэлийн хөтөлбөр
Бусад		
Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт	2019	Хүлэмжийн хийг бууруулах зорилт
Аймаг, сумын бүсчилсэн, ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр	2023	Гол нэрийн 19 нэр төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд шаардлагатай дэд бүтэц, санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх

Аж үйлдвэрийн үйл ажиллагаанд техник, технологийн шинэчлэл хийх, түүхий эдийн найдвартай хангамжийн сүлжээг бий болгох замаар байгаль орчинд үзүүлж буй хор, хөнөөлийг багасгах боломжтой.

Бодлогын баримт бичгүүдэд боловсруулсан хог хаягдлын хэмжээг 2030 онд 40% хүргэхээр зорьж байна.

4.4. Бодлогын баримт бичигт тусгагдсан шалгуур үзүүлэлтүүд

Хүснэгт 11. Монгол Улсын ногоон үйлдвэрлэл ба тойрог эдийн засгийн шилжилтийн шалгуур үзүүлэлтүүд

ҮЗҮҮЛЭЛТ	ХЭМЖИХ НЭГЖ	СҮҮРЬ		АХ-2050, 2026-2030	АХ - 2050
3. Ногоон үйлдвэрлэл ба тойрог эдийн засаг		Он	Түвшин	2030 он	2050 он
Нэгж ам.долларын дотоодын нийт бүтээгдэхүүнд ногдох дотоодын материалын хэрэглээ		2018	15	6	3
Дахин боловсруулсан хог хаягдлын эзлэх хувь	Хувь	2024	12	40	50
Автомашинаас үүссэн аюултай хог хаягдлыг (шингэн болон хатуу) дахин боловсруулах шинээр байгуулах үйлдвэрийн тоо	Тоо	2024	0	9	-

5. Тогтвортой мал аж ахуй, хүнсний систем

Тогтвортой мал аж ахуй, хүнсний системийн шилжилт нь хүнсний үйлдвэрлэл, боловсруулалт, түгээлт, хэрэглээний системийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт, байгалийн нөөцийн хязгаарлалттай холбон зохистой менежментэд шилжих үйл явц юм.

Монгол Улсын хувьд мал аж ахуй нь эдийн засаг, амьжиргаа, соёлын салшгүй хэсэг бөгөөд хүн ам, хэрэглээ, үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэхийн хэрээр газар, ус, бэлчээрийн хэрэглээ өсөж байна. Үүний үр дүнд бэлчээрийн даац хэтрэх, хөрсний доройтол, усны нөөцийн хомсдол, биологийн олон янз байдлын тэнцвэр алдагдах зэрэг байгаль орчны асуудлууд үүсэж байна. Мөн мал аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн салбар нь хүлэмжийн хийн ялгарлын тодорхой хувийг бүрдүүлдэг бөгөөд байгалийн нөөцийг хэт ашиглах нь хөрс, ус, экосистемийн тогтвортой байдал болон хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлийг бий болгож байна.

Монгол Улсын нөхцөлд тогтвортой мал аж ахуйд шилжинэ гэдэг нь уламжлалт нүүдлийн аж ахуйг орхих, үйлдвэрлэлийн фермийн хэлбэрт бүрэн шилжихийг биш, харин бэлчээрийн зохистой ашиглалт, уламжлалт мал аж ахуйн мэдлэгүүдийг орчин үеийн шинжлэх ухаан, бодлоготой уялдуулан хөгжүүлэхийг хэлнэ.

Сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө тод ажиглагдаж, ган, зуд, хур тунадасны хэлбэлзэл, усны нөөцийн өөрчлөлт нь мал аж ахуйн тогтвортой байдалд нөлөөлөх болсон бөгөөд энэ нь малын хорогдол, бэлчээрийн нөхөн сэргэлт, экосистемийн тэнцвэрт байдалд сөргөөр нөлөөлж байна.

Мөн мал аж ахуйн үйлдвэрлэл нь зөвхөн байгаль орчны хүчин зүйлсээс гадна зах зээлийн эрэлт, бүтээгдэхүүний

үнэ, хэрэглээний өөрчлөлт зэрэг эдийн засгийн хүчин зүйлсээс хамаардаг бөгөөд хөдөө орон нутгийн хүн амын амьжиргааны үндсэн эх үүсвэр хэвээр байна.

5.1. Тогтвортой мал аж ахуй, хүнсний системийн шилжилтийн хамрах хүрээ

Тогтвортой мал аж ахуй, хоолны системийн шилжилт нь дараах үндсэн 4 хэсгийг хамарна:

- 1) Нөхөн сэргээгдэх органик газар тариалан:** Хөрсний үржил шимийг хамгаалах, байгалийн шим тэжээлийг сэргээх, химийн бодисын хэрэглээг багасгах үйл ажиллагаанд суурилдаг. Хөрсийг доройтуулахгүйгээр урт хугацаанд тогтвортой ашиглах, биологийн олон янз байдлыг хадгалах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах онцлогтой бөгөөд хүнсний аюулгүй байдал, эрүүл бүтээгдэхүүн үйлдвэрлэх нөхцөлийг бүрдүүлдэг.
- 2) Химийн бордоо, пестицидийн хэрэглээг багасгах:** Химийн бордоо, пестицидийн хэт хэрэглээ нь хөрс, ус, экосистемд сөргөөр нөлөөлөхөөс гадна хүнсний чанар, аюулгүй байдал, хүний эрүүл мэндэд эрсдэл үүсгэдэг. Иймээс химийн бордоо, пестицидийн хэрэглээг бууруулж, биологийн болон байгальд ээлтэй аргуудыг нэвтрүүлэх, хөрсний үржил шимийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх нь тогтвортой хүнсний үйлдвэрлэлийн чухал хэсэг болдог.
- 3) Орон нутгийн тогтвортой хүнсний үйлдвэрлэл:** Хүнсний бүтээгдэхүүнийг орон нутагт үйлдвэрлэх, нийлүүлэлтийн сүлжээг богиносгох замаар бүс нутгийн эдийн засаг болон байгаль орчныг хамгаалах нэгэн арга юм.
- 4) Уур амьсгалын ухаалаг хөдөө аж ахуй, газрын нөхөн сэргээлт:** Уур амьсгалын өөрчлөлтөөс ган, зуд, цаг агаарын эрс тэс нөхцөл нэмэгдэж байгаа өнөөгийн нөхцөлд ус, бэлчээр, хөрсний нөөцийг зохистой ашиглах, газрын доройтлыг бууруулах, уур амьсгалын эрсдэлд дасан зохицох технологи, арга хэмжээг сонгон хэрэгжүүлэх шаардлагатай болж байна. Энэ нь байгаль орчныг хамгаалахын зэрэгцээ хүнсний үйлдвэрлэлийг урт хугацаанд тогтвортой хадгалах нөхцөлийг бүрдүүлнэ.

5.2. Тогтвортой мал аж ахуй, хүнсний системийн олон улсын шалгуур үзүүлэлтүүд


Хүснэгт 12. Тогтвортой мал аж ахуй, хүнсний системийн шилжилтийн олон улсын шалгуур үзүүлэлтүүд

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ХЭМЖИХ НЭГЖ	ОН	КАЗАХСТАН	ЭНЭТХЭГ	ХЯТАД	КАМБОЖ	МОНГОЛ
Хөдөө аж ахуйн салбарын нүүрс хүчлийн хийн ялгарал	Сая тонн CO ₂	2023	1.9	38.2	98.0	0.5	0.3
	Тонн CO ₂ экв/хүн	2023	1.18	0.56	0.48	1.47	9.53
Нийт тариалангийн талбайд эзлэх тогтвортой/органик газар	Хувь	2023	0.1	2.5	0.7	0.6	0.001
Хөдөө аж ахуйн үс ашиглалтын үр ашиг	Ам.доллар/м ²	2022	0.07	0.53	2.56	0.41	0.55
Хоол хүнсний хаягдал (Үйлдвэрлэлд эзлэх хувь)	кг/хүн/жил		88	55	76	85	18
Шороон хөрсний органик элементийн агууламж	Тонн/га		17.09	27.88	35.27	40.03	55.07
Нэг малд ногдох ялгарал	CO ₂ экв/толгой	-	-	-	-	-	-
Нийт газар нутгийн хөдөө аж ахуйд ашиглаж байгаа хувь	Хувь	2023	79.4	60.1	55.4	34.9	69.0

Эх сурвалж: FAO, FiBL, UNEP, FAO GLOSIS, World Bank

Урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд органик болон байгальд ээлтэй үйлдвэрлэлийг дэмжих, хүнсний аюулгүй байдлыг хангах, хөрс болон газрын доройтлыг бууруулах, мал аж ахуй болон газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх зорилтууд тусгагдсан. Үүний хүрээнд 2030 он гэхэд газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, үр тарианы ургацыг 14.5 ц/га-д хүргэх, мөн олон улсын стандарт, чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн хүнсний үйлдвэрийн тоог 58-д хүргэхээр зорьж байна.

Зураг 8. 2025-2026 оны бэлчээрийн даац



Эх сурвалж: <https://weather.gov.mn/agro>

5.3. Монгол Улсын мал аж ахуй, хүнсний салбарын бодлогын баримт бичгүүд

Хүснэгт 13. Тогтвортой мал аж ахуй, хүнсний системийн салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүд

4. ТОГТВОРТОЙ МАЛ АЖ АХУЙ, ХООЛНЫ СИСТЕМ	БАТЛАГДСАН ОГНОО	ТАЙЛБАР
Салбарын хуулиуд		
Органик бүтээгдэхүүний тухай	2024	Органик үйлдвэрлэл, бүтээгдэхүүн, гэрчилгээ, лого, маркетинг, үйлдвэрлэлийг дэмжих, урамшуулал олгох
Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай	2012	Хүнсний сүлжээний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах
Хүнсний тухай	2012	Иргэдийг чанартай, аюулгүй хүнсээр хангах
Тариалангийн тухай	2016	Тариалан эрхлэх, тариалангийн бүс тогтоох, газрыг зохистой ашиглах, хөрс хамгаалах, сайжруулах, тариалан болон мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх
Газрын тухай	2002	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулах
Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай	2012	Байгалийн нөөц ашигласны төлбөр ногдуулах, төлбөрийн орлогоор байгаль орчныг хамгаалах, нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай	2012	Байгалийн тэнцвэр алдагдахаас сэргийлэх, сөрөг нөлөө багатайгаар нөөц ашиглах
Бодлогын баримт бичиг		
Алсын хараа-2050	2020	Тогтвортой мал аж ахуй, хөрс хамгаалалт, байгалийн нөөцийн зохистой ашиглалт, хүнсний аюулгүй байдал, орон нутгийн хүнсний үйлдвэрлэлийг дэмжих
Шинэ сэргэлтийн бодлого	2021	Мал аж ахуйн түүхий эдийн анхан шатны боловсруулалт, үйлдвэрлэл, логистик, экспортын зах зээл хөгжүүлэх
Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал (2024-2050)	2024	Үндэсний соёлоо дээдэлсэн, байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан, ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлэх
Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	2025	Экосистемийн тэнцвэрийг хангаж, байгалийн нөөц баялгийн нөхөн сэргэлт, зохистой ашиглалтыг дэмжих
Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө	2025	Эдийн засгийн бодлого, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хүнсний хангамж, аюулгүй байдал
Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого батлах тухай	2003	Байгальд ээлтэй, үүр амьсгалд дасан зохицсон мал аж ахуй, газар тариалан, хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх
Хөтөлбөр, төлөвлөгөө		
Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2024-2028)	2024	Засгийн газрын хөтөлбөр
Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөр	2025	Салбарын хөтөлбөр
Аймгийн засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр	2025	Аймгийн хөтөлбөр
Нийслэлийн засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр	2025	Нийслэлийн хөтөлбөр
Бусад		
Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт	2019	Хүлэмжийн хийг бууруулах зорилт


Манай орны бэлчээрийн даацад тохирсон малын тоо 57649,7 мянга байх ёстой. Гэвч 2016-2023 оны хооронд нийт малын тоо 57 саяас байнга давсан. 2025-2026 оны өвөл, хаврын бэлчээрийн даацыг баг бүрийн бэлчээрийн ургац, малын тоо, бэлчээрийн талбайн хэмжээ, бэлчээр ашиглах хугацаа зэрэг мэдээлэлд тооцсон зуншлагын байдал 8 дугаар сарын 20-ны байдлаар нийт нутгийн 54 хувьд хэвийн, нутгийн 46 хувьд гантай болон гандуу байна.

- 39.8 хувь нь бэлчээрийн нөөцтэй
- 19.0 хувь нь бэлчээр хүрэлцээтэй
- 24.6 хувь нь даац 1-3 дахин хэтэрсэн
- 6.3 хувь нь даац 3-5 дахин хэтэрсэн
- 10.3 хувь нь даац олон дахин хэтэрсэн судалгааг “Цаг уур, орчны шинжилгээний газар” 2025 оны 9 сард мэдээлсэн.

Бэлчээр доройтсоноор үүсэх сөрөг нөлөөллүүд:

- Харшлын өвчлөл нэмэгдэх
- Шороон шуурга гэх мэт байгалийн гамшигт үзэгдлийн давтамж нэмэгдэх
- Малын өвчлөл нэмэгдэх
- Өвсөн тэжээлт амьтад хүнсний хомстолд орох
- Шавж болон оготны нүүдэл ихсэх
- Хотын төвлөрөл нэмэгдэх

График 3. Малын тоо, толгой



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

5.4. Бодлогын баримт бичигт тусгагдсан шалгуур үзүүлэлтүүд

Хүснэгт 14. Монгол Улсын тогтвортой мал аж ахуй, хүнсний системийн шилжилтийн шалгуур үзүүлэлтүүд

ҮЗҮҮЛЭЛТ	ХЭМЖИХ НЭГЖ	СУУРЬ		АХ-2050, 2026-2030	АХ - 2050
4. Тогтвортой мал аж ахуй, хүнсний систем		Он	Түвшин	2030 он	2050 он
Бэлчээрийн 100 га талбайд ногдох малын тоо	Тоо	2024	101	95	-
Хонин толгойд шилжүүлсэн нэг малд ногдох тэжээлийн хэмжээ	Кг	2024	8	13	-
Жилд дунджаар сайжруулж, нөхөн сэргээсэн талбайн хэмжээ	Сая га	2024	3.1	3	-

6. Ногоон барилга байгууламж, хотууд



Түүхэн хөгжлийн явцад хот бол соёл иргэншлийн төв байсаар ирсэн. Анхны хотууд ус, худалдаа, аюулгүй байдалд тулгуурлан үүссэн бол аж үйлдвэрийн хувьсгалын дараагаар хотжилт үйлдвэрлэл, эрчим хүч, хөдөлмөрийн төв болон эрчимтэй тэлсэн. Өнөөдрийн байдлаар хотын хөгжил нь автомашин, төвлөрсөн эрчим хүч, их хэмжээний барилга байгууламжид суурилсан бөгөөд энэ нь эдийн засгийн өсөлтийг дэмжсэн ч байгаль орчин, хүний амьдрах орчинд урт хугацааны дарамт үүсгэсэн. Барилга, хот суурин газар нь эрчим хүчний хэрэглээ, хүлэмжийн хийн ялгарлын томоохон хувийг бүрдүүлдэг. Дулаан алдагдал ихтэй барилгууд, үр ашиг багатай халаалт, хөргөлтийн систем, хотын тэлэлтээс үүдэлтэй урт зорчилт, автомашинд тулгуурласан амьдралын хэв маяг нь уур амьсгалын өөрчлөлтийг хурдасгах бодит хүчин зүйл болсоор байна. Ийм нөхцөлд хотын хөгжлийг илүү ухаалгаар төлөвлөж, илүү үр ашигтай ашиглах шаардлага үүсэж ногоон барилга байгууламж, ногоон хотын ойлголт бий болсон.

Ногоон барилга гэдэг нь зураг төсөл, барилга угсралт, ашиглалт, засвар үйлчилгээ, ашиглалтын дараах үе шат хүртэл эрчим хүч, ус, материалын хэрэглээг багасгаж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг хамгийн доод түвшинд барихад чиглэсэн барилга байгууламжийг хэлнэ.

Гэвч барилга, байгууламж нь дангаараа ногоон хотыг бий болгож чадахгүй. Иймээс хотын төлөвлөлт, тээвэр, дэд бүтэц, нийтийн орон зай, байгалийн системийн уялдааг бүхэлд нь хамаарсан цогц ойлголтыг бий болгож байна. Бага тойрогтой хотын бүтэц нь урт зайны зорчилтыг багасгаж, нийтийн тээвэр, явган алхалт, унадаг дугуйн хөдөлгөөнийг дэмжсэн байх нь ногоон хотын үзэл баримтлал болно. Хотын төвлөрөл, орон сууцны үнэ өсөх, нийгмийн хүртээмж алдагдах эрсдэлүүдийг бууруулахын тулд ногоон хотын бодлогыг нийгэм, эдийн засгийн бодлоготой уялдуулах шаардлагатай.

Ногоон барилга байгууламж, хотууд нь уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, эрчим хүчний аюулгүй байдлыг хангах, иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах

орчныг бүрдүүлэх үндсэн суурь болно. Энэ шилжилтэд бэлтгэхийн тулд бодлогын тогтвортой орчин, санхүүгийн урамшуулал, мэргэжлийн чадавх, иргэдийн оролцоог зэрэг хөгжүүлэх шаардлагатай.

6.1. Ногоон барилга байгууламж, ногоон хотын шилжилтийн хамрах хүрээ

Ногоон барилга байгууламж, ногоон хотын шилжилт нь дараах үндсэн 4 хэсгийг хамаарна:

- 1) Эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламж (дулаалга, ногоон дээвэр, идэвхгүй дизайн):** Орон сууц, барилгын халаалт, хөргөлтөд зарцуулагдаж буй эрчим хүч нь хүлэмжийн хийн ялгарлын томоохон нэг шалтгаан болдог. Барилгын салбарыг шинэчлэх хамгийн үр дүнтэй гарц нь эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламж юм. Барилгын байршил, нарны тусгал, салхины чиглэл, байгалийн гэрэлтүүлэг, дулаан хуримтлуулах материалын сонголтыг зөв төлөвлөснөөр нэмэлт эрчим хүч зарцуулахгүйгээр эдийн засгийн хэмнэлттэй бүтээн байгуулалт хийх боломжтой.
- 2) Тогтвортой материал ба барилга байгууламж:** Технологийн ахиц, ололтууд нь барилгын материалыг шинэ шатанд гаргаж байна. Био суурьтай материал, нүүрстөрөгч шингээдэг бетон, дижитал зураг төсөл зэрэг шийдлүүд нь тогтвортой барилгын үндэс болж байна. Ирээдүйд барилга байгууламж нь нүүрстөрөгчийн бага ялгаруулалттай бус, харин шингээгч систем болох чиглэлд хөгжиж байна.
- 3) Хог хаягдал, усны менежментийн систем:** Хотжилт эрчимжихийн хэрээр хог хаягдал, усны хэрэглээ огцом өсөж хотуудын даацад хүрэхээ больж байгаа. Хог хаягдлын менежмент нь ангилан ялгалт, дахин ашиглалт, дахин боловсруулалт, органик хаягдлыг био хий, бордоо болгон хувиргах шийдэлд суурилдаг. Харин усны менежмент нь ундны ус, бохир ус, борооны усыг нэг системээр бус, ялган саарал усыг дахин ашиглах, бохир усыг цэвэршүүлэн үйлдвэрлэл, ногоон байгууламжид ашиглах шийдлүүд юм.
- 4) Хотын ногоон байгууламж ба уур амьсгалд тэсвэртэй төлөвлөлт:** Хотуудад цэцэрлэг, ногоон тохижилт нь харагдах үзэмж, амралтын зориулалттай байсан бол хот тэлэхийн хэрээр шахагдаж барилга, авто зам давамгайлах болсон. Энэ нь хот суурин газрын агаарын температур ойролцоох бүсүүдээс мэдэгдэхүйц өндөр байх шалтгаан болдог. Ногоон байгууламжийг хөгжүүлснээр хэт халалт, үер усны аюул, агаарын бохирдол зэрэг хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэх өндөр ач холбогдолтой.

2024 онд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 153 дугаар тушаалаар “Ногоон барилгын Best-ger гэрчилгээ олгох журам” батлагдсан. Стандартын хэрэгжилтийг бодит ажил болгох институцийн

чадавх, аудит /үнэлгээний хүний нөөц, өгөгдөл-тайлагналын чанар, мөн анхны хөрөнгө оруулалтын өртгийг санхүүжилтээр хэмжих механизм юм. Гэхдээ зах зээл дээр BestGER гэрчилгээтэй төслүүдийг ногоон санхүүжилттэй холбох арга хэмжээ идэвхжиж байна.

6.2. Ногоон барилга байгууламж, ногоон хотын олон улсын шалгуур үзүүлэлтүүд

Хүснэгт 15. Ногоон барилга байгууламж, ногоон хотын олон улсын шалгуур үзүүлэлтүүд

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ХЭМЖИХ НЭГЖ	ОН	КАЗАХСТАН	ЭНЭТХЭГ	ХЯТАД	КАМБОЖ	МОНГОЛ
Барилгын эрчим хүчний хүчин чадал	кВт.ц/ м²/ жил	-	-	-	-	-	-
Нийт барилгуудад эзлэх ногоон гэрчилгээтэй барилгууд	Хувь	-	-	-	-	-	-
Хотын ногоон байгууламж	м²/хүн	2020	10.27	1.37	-	28.61	-
Бохир ус цэвэршүүлэлт	Хувь	2024	30	29	64	-	53
Хотын хүн амын агаар бохирдолд өртөх магадлал (PM2.5)		-	-	-	-	-	-

Эх сурвалж: UN-Habitat, WHO

6.3. Монгол Улсын салбарын хууль, бодлогын баримт бичгүүд


Хүснэгт 16. Ногоон барилга байгууламж, хотын салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүд

5. НОГООН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ХОТУУД	БАТЛАГДСАН ОГНОО	ЗОРИЛТ
САЛБАРЫН ХУУЛИУД		
Барилгын тухай	2016	Барилгын үйл ажиллагаанд ногоон хөгжлийн бодлого, ногоон барилгын шаардлагыг хэрэгжүүлэх
Хог хаягдлын тухай	2017	Хог хаягдлыг дахин боловсруулах зохицуулалт
Байгаль орчныг хамгаалах тухай	1995	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх
Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль	2015	Эрчим хүчний хэрэглээг бууруулах
Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай	2022	Хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйлдвэрлэлийг хөгжүүлэх
Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай	2011	Байгаль орчныг хамгаалах, хяналт тавих, стандарт, норм, шаардлагад нийцүүлэх
Усны тухай	2012	Усны нөөц, түүний сав газрыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх
Хот байгуулалтын тухай	2008	Ногоон байгууламж, байгалийн нөхцөл, нөөц, экологийн тэнцвэрт байдлын шаардлагыг хангах
Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай	2021	Ногоон хөгжлийг дэмжих сан, хөрөнгө оруулалтын зохицуулалт
Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай	2020	Ногоон байгууламж, нөхөн сэргээлт

Газрын тухай	2002	Ногоон байгууламжийн зохион байгуулалт
Ойн тухай	2012	Нийслэл, хотын ногоон бүсийн тодорхойлолт
БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ		
Алсын хараа-2050	2020	Амьдралын хэрэгцээг хангасан таатай, байгаль орчинд ээлтэй хот, ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн хөгжүүлэх
Шинэ сэргэлтийн бодлого	2021	Дэд бүтцийг сайжруулах, хотын хөгжлийг дэмжих
Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал (2024-2050)	2024	Хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоо, бүсийг тэнцвэртэйгээр хөгжүүлэх
Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	2025	Эрүүл аюулгүй амьдрах орчин, хүртээмжтэй орон сууц, хэрэглээнээс үүсэх бохирдол, хаягдлыг бууруулах
Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө	2025	Эрчим хүчний хэмнэлттэй, байгальд ээлтэй орон сууц барих таатай орчин бүрдүүлэх
ХӨТӨЛБӨР, ТӨЛӨВЛӨГӨӨ		
Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2024-2028)	2024	Засгийн газрын хөтөлбөр
Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөр	2025	Салбарын хөтөлбөр
Аймгийн засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр	2025	Аймгийн хөтөлбөр
Нийслэлийн засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр	2025	Нийслэлийн хөтөлбөр
БУСАД		
Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт	2019	Хүлэмжийн хийг бууруулах
Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл	2022	Гэр хорооллын 100 га газарт 10.000 айлын эрчим хүчний хэмнэлттэй ногоон орон сууц бүхий эко хорооллыг байгуулах


Монгол Улсын нийт өрхийн тоо 2010 оноос 2020 оны хооронд 42.9%-аар, инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд амьдардаг өрх 89%-аар өсжээ. 2010 онд нийт өрхийн 36.2% нь инженерийн бүрэн хангамжтай орон сууцаар хангагдсан байсан бол 2020 онд 47.9% болж өссөн байна.

График 4. Инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд амьдардаг өрх



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

График 5. Улаанбаатар хотын агаарын бохирдлын жилийн дундаж агууламж (мг/м3)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Үндэсний статистикийн хорооны “Агаар дахь ялгаруулалтын данс 2023” тайланд тайланд тусгаснаар агаарын бохирдлын жилийн дундаж агууламж 2020 оноос 2023 оны хооронд агаар дахь PM10 болон PM2.5 тоосонцор тус тус 0.008 мг/м3-аар багассан байхад SO2 хий 0.009 мг/м3-аар, NO2 хий 0.002 мг/м3-аар ихэссэн байна.


Агаарын бохирдлын жилийн дундаж хүлцэх агууламж нь тус тус 0.050, 0.025, 0.020, 0.040 мг/м3 байдаг.

Дэлхийн агаарын чанарын тайланд тусгаснаар зүүн Азийн бүс нутагт долоон улс орон, нутаг дэвсгэрийн 1279 хотын агаарын чанарын мэдээлэлд хийгдсэн судалгааны үр дүнд Хятад, Тайвань, Өмнөд Солонгос, Япон улсуудад жилийн дундаж PM2.5 агууламж буурсан бол Монгол, Макао, Хонконг улсуудад өссөн байна. Монголд хамгийн их өсөлт бүртгэгдсэн буюу 2023 оны 22.5 мкг/м3-аас 2024 онд 25.6 мкг/м3 болж өссөн байна. Жилийн дундаж үзүүлэлтээр 121 улсын нийслэл хотуудын үзүүлэлтээр 27 дугаарт эрэмбэлэгдэж бохирдол өндөртэй нийслэлийн тоонд багтаж байна.

Зураг 9. Дэлхийн агаарын чанарын тайлан 2024



Зураг 10. Жилийн дундаж PM2.5 агууламжид үндэслэсэн улс, бүс нутгийн бохирдлын зэрэглэл



Эх сурвалж: Дэлхийн агаарын чанарын тайлан 2024

Зураг 11. Дэлхийн хамгийн их агаарын бохирдолтой томоохон хотуудын зэрэглэл



Эх сурвалж: IQAir

Манай улсын хувьд агаарын бохирдлын өсөлт нь улирлын шинж чанартай бөгөөд өвлийн улиралд өндөр идэвхжил үзүүлдэг. 2026 оны 2 дугаар сарын 17:00-18:00 цагийн үзүүлэлтээр хамгийн бохирдолд өндөртэй хотоор эрэмбэлэгдсэн байна.

Зураг 12. Улаанбаатар хотын агаарын бохирдлын дундаж



Эх сурвалж: IQAir

6.4. Бодлогын баримт бичигт тусгагдсан шалгуур үзүүлэлтүүд

Хүснэгт 17. Монгол Улсын ногоон барилга байгууламж, хотын шилжилтийн шалгуур үзүүлэлтүүд

ҮЗҮҮЛЭЛТ	ХЭМЖИХ НЭГЖ	СУУРЬ		АХ-2050, 2026-2030	АХ - 2050
5. Ногоон барилга байгууламж, хотууд		Он	Түвшин	2030 он	2050 он
Инженерийн бүрэн хангамжтай орон сууцаар хангагдсан өрхийн нийт өрхөд эзлэх хувь	Хувь	2015	25.3	35.8	49.8
Хотын хөгжлийн үзүүлэлт	Индекс	-	0.504	0.626	0.931
Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцрын хүйтний улирлын дундаж агууламж	мкг/м3	2024	53	38	-
Улаанбаатар хотын агаар дахь PM10 тоосонцрын хүйтний улирлын дундаж агууламж	мкг/м3	2024	100	84	-
Хүйтний улирлын азотын давхар исэл (NO2)	мкг/м3	2024	54	50	-
Хүйтний улирлын хүхэрлэг хий (SO2)	мкг/м3	2024	80	74	-
Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын эзлэх хувь	Хувь	2024	69.6	75	90
Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн ам	Хувь	2024	83.6	87	90
Барилгын салбарын хүлэмжийн хийн ялгарлын бууралт	Мян.тн CO2	2024	353.9	633.5	-
Нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээ	м2	2024	5.1	6	-
Хот, суурин газрын нийт талбайд эзлэх олон нийтийн хэрэгцээнд зориулсан ногоон/цэнхэр бүсийн эзлэх хувь	Хувь	2020	15	30	-

7. Байгалийн нөөц, биологийн олон янз байдлын хамгаалал

Эдийн засгийн өсөлт, үйлдвэрлэл, хотжилт, эрчим хүчний хэрэглээ нэмэгдэхийн хэрээр байгалийн нөөцийг их хэмжээгээр ашиглах болсон. Аж үйлдвэрийн хувьсгал, нүүрс, газрын тос зэрэг түлшинд суурилсан хөгжлийн үеэс эхлэн ой модыг их хэмжээгээр тайрах, бэлчээр, газар тариалангийн талбай тэлэх, ашигт малтмал олборлох, ан амьтныг хэт агнах зэрэг үйл ажиллагаа эрчимжиж, байгалийн нөөц шавхагдах, экосистемийн тэнцвэр алдагдах нөхцөл бүрдсэн. Олон тохиолдолд байгалийн нөөцийг ашиглахдаа урт хугацаанд ямар үр дагавар гарах, тухайн экосистемд ямар өөрчлөлт бий болох талаар хангалттай тооцоолол хийдэггүй байсан нь ой, ус, хөрс, биологийн олон янз байдал доройтож, зарим ургамал, амьтны төрөл зүйл устахад хүргэсэн.



Өнөөгийн нөхцөлд уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтол, цөлжилт, усны нөөцийн хомсдол зэрэг асуудлууд улам эрчимжиж байгаа нь байгалийн нөөцийг зөв зохистой ашиглах, экосистемийг хамгаалах, байгалийн капиталыг нөхөн сэргээх шаардлагыг улам тодорхой болгож байна. Ой модыг хамгаалах, ойжуулах, доройтсон газар нутгийг нөхөн сэргээх, усны нөөцийг хамгаалах, ан амьтан, ургамлын төрөл зүйлийг хамгаалах зэрэг нь байгаль орчныг хамгаалах төдийгүй ирээдүйд хэрэглэх нөөцийг хадгалах, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг сааруулах, гамшгийн эрсдэлийг бууруулах ач холбогдолтой.

Уур амьсгалын өөрчлөлтийг одоогоор бүрэн зогсоох боломжгүй боловч байгалийн нөөцийг хамгаалах, экосистемийг сэргээх, дасан зохицох арга хэмжээг хэрэгжүүлэх замаар түүний сөрөг нөлөөг сааруулах, иргэдийн аюулгүй байдал, амьдрах орчны тогтвортой байдлыг хангах боломжтой. Иймээс ногоон шилжилтийн хүрээнд байгалийн нөөц, биологийн олон янз байдлын хамгаалал нь экосистемийн тэнцвэрийг хадгалах, байгалийн капиталыг нөхөн сэргээх, ирээдүй үеийн хэрэгцээг хангах чиглэлүүдийн нэг болж байна.

7.1. Байгалийн нөөц, биологийн олон янз байдлын хамгааллын шилжилтийн хамрах хүрээ

- 1) **Ойн хамгаалалт, ойжуулалт:** Ойн хамгаалалт нь байгалийн ойг доройтлоос сэргийлэх, ашиглалтыг зохистой түвшинд барих, экосистемийн тогтвортой байдлыг хадгалах зорилготой. Харин ойжуулалт нь доройтсон, цөлжсөн газар нутгийг нөхөн сэргээж, урт хугацаанд нүүрстөрөгч шингээх, орон нутгийн бичил уур амьсгалыг сайжруулах чухал хэрэгсэл юм. Эдгээр хоёр бодлого нь хоорондоо салшгүй уялдаатай бөгөөд дангаараа өндөр үр дүн өгөх боломжгүй.
- 2) **Газар, ус, далайн тогтвортой менежмент:** Технологийн ололт, хөгжил нь тогтвортой менежментийг илүү үр дүнтэй болгож байна. Хиймэл дагуулын зураг, газарзүйн мэдээллийн систем, ухаалаг усны тоолуур, далайн мониторингийн дэвшилтэт төхөөрөмжүүд нь нөөцийн ашиглалт, өөрчлөлтийг бодит цагт хянах боломжийг олгож байна.
- 3) **Биологийн олон янз байдлыг хамгаалах, экосистемийг сэргээх:** Биологийн олон янз байдал нь экосистемийн тогтвортой байдал, хүнсний аюулгүй байдал, уур амьсгалын зохицуулалт, эдийн засгийн урт хугацааны хөгжлийн үндэс суурь болдог. Ургамал, амьтан, бичил биетний олон төрөл зүйл нь байгалийн өөрийгөө нөхөн сэргээх чадварыг бүрдүүлж, хүн төрөлхтний амьдралд зайлшгүй шаардлагатай экосистемийн үйлчилгээ

үзүүлдэг.

- 4) **Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, гамшгийн эрсдэлийг бууруулах:** Уур амьсгалын өөрчлөлт нь зөвхөн дулаарлын дундаж өсөлтөөр хэмжигдэхгүй. Харин ган, үер, шуурга, ойн түймэр, хэт халалт, зуд зэрэг байгалийн үзэгдлийн давтамж, хүч зэрэг бодит эрсдэлийн хүчин зүйл юм. Гамшгийн эрсдэлийг бууруулах нь эрсдэлийг таних, бууруулах, бэлэн байдлыг хангах, шуурхай хариу арга хэмжээ болон сэргээн босголтыг нэгтгэсэн цогц тогтолцоо юм. Хиймэл дагуулын ажиглалт, цаг уурын өндөр нарийвчлалтай таамаглал, эрт сэрэмжлүүлэх систем, дижитал газрын зураг, ухаалаг мэдрэгчүүд нь гамшгийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх боломжийг нэмэгдүүлж байна.

7.2. Байгалийн нөөц, биологийн олон янз байдлын хамгааллын олон улсын шалгуур үзүүлэлтүүд

Хүснэгт 18. Байгалийн нөөц, биологийн олон янз байдлын хамгааллын шилжилтийн олон улсын шалгуур үзүүлэлтүүд

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ХЭМЖИХ НЭГЖ	ОН	КАЗАХСТАН	ЭНЭТХЭГ	ХЯТАД	КАМБОЖ	МОНГОЛ
Нийт газар нутаг дахь хамгаалагдсан газар нутаг	Хувь	2024	11.9	4.5	14.7	31.8	19.80
Нийт газар нутгийн хувьд ой модны эзлэх талбай	Хувь	2023	1.3	24.5	24	43.1	9.10
Улаан номд орсон амьтдын тоо	Тоо	2025-II	97	1690	1763	475	45
Цэвэр усны татан авалт	Хувь	2022	34.63	66.49	41.52	1.04	3.40
Экосистем сэргээх хувь	Га/жил		-	-	-	-	-
Бэлчээрийн доройтол	Хувь		-	-	-	-	-

Эх сурвалж: World Bank, IUCN Red List

7.3. Монгол Улсын байгалийн нөөц, биологийн олон янз байдлын хамгааллын салбарын бодлогын баримт бичгүүд

Хүснэгт 19. Байгалийн нөөц, биологийн олон янз байдлын хамгааллын салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүд

6. БАЙГАЛИЙН НӨӨЦ, БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ХАМГААЛАЛ	БАТЛАГДСАН ОГНОО	ТАЙЛБАР
САЛБАРЫН ХУУЛИУД		
Ойн тухай	2012	Ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, эзэмших, ашиглах, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх

Байгаль орчныг хамгаалах тухай	1995	Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй үйлдүүлэх, өнөө болон ирээдүйн үеийнхний ашиг сонирхлын үүднээс байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, жам ёсны боломжтойг нь нөхөн сэргээхтэй холбогдож төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино
Газрын тухай хууль	2002	Ой, ус, хийн мандлын агаар, ургамал, амьтан, байгалийн бусад баялгийг ашиглах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохих хууль тогтоомжоор зохицуулна
Усны тухай	2012	Усны нөөц, түүнийг сав газрыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх
Газрын хэвлийн тухай	1988	Газрын хэвлийг ашиглах үйл ажиллагааг байгаль орчинд сөрөг нөлөө багатайгаар хэрэгжүүлэхэд хяналт тавих
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай	2012	Байгаль орчныг хамгаалах, хүний үйл ажиллагааны улмаас байгаль орчны тэнцвэрт байдал алдагдахаас сэргийлэх
Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль	1994	Байгалийн бүс, бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, ховор, ховордсон ургамал, амьтан бүхий газар, түүх, соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалах, хувьсаж өөрчлөгдөх зүй тогтлыг судлах, танин мэдэх зорилгоор газар нутгийг тусгай хамгаалалтад авах, ашиглах, түүний унаган төрхийг хадгалах, хамгаалах
Амьтны тухай	2012	Амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, түүний нөөцийг зохистой ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулах
Байгалийн ургамлын тухай	1995	Ой болон таримал ургамлаас бусад ургамлыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулах
Гамшгаас хамгаалах тухай	1997	Аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, шуурхай арга хэмжээ авах
Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай	2012	Хөрсийг доройтлоос хамгаалах, нөхөн сэргээх, цөлжилтөөс сэргийлэх
БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ		
Алсын хараа-2050	2020	Байгаль хамгаалал, экосистемийн тэнцвэрт байдал, нөөцийг хэмнэх, хаягдалгүй эдийн засаг
Шинэ сэргэлтийн бодлого	2021	Тэрбум мод үндэсний хөдөлгөөн, усны нөөц хамгаалал
Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал (2024-2050)	2024	Байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах
Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	2025	Байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах
Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө	2025	Хүлэмжийн хийг бууруулах, ойжуулалт, цөлжилтийг бууруулах, биологийн олон янз байдлын тархац нутгийг хамгаалах

ХӨТӨЛБӨР, ТӨЛӨВЛӨГӨӨ		
Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2024-2028)	2024	Засгийн газрын хөтөлбөр
Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөр	2025	Салбарын хөтөлбөр
Аймгийн засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр	2025	Аймгийн хөтөлбөр
Нийслэлийн засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр	2025	Нийслэлийн хөтөлбөр
Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө	2016	Байгаль орчинд ээлтэй, хүний эрүүл мэнд болон биологийн олон янз байдалд сөрөг нөлөөгүй дэд бүтэц, тээврийн сүлжээг хөгжүүлэх
БУСАД		
Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт ²	2019	Хүлэмжийн хийг бууруулах
Биологийн олон янз байдлын тухай конвенц	1994	Биологийн олон янз байдлыг хамгаалах, бүрэлдэхүүн хэсгийг тогтвортой ашиглах, генетикийн нөөцийг ашиглуулах, холбогдох технологийг дамжуулан эзэмшүүлэх, санхүүжүүлэх, нөөцийг хамтран үр ашигтай ашиглах
Уур амьсгалын өөрчлөлтийн тухай нэгдсэн үндэстний байгууллагын суурь конвенц	1992	Хүлэмжийн хийг тогтворжуулах

Аюулт үзэгдэл, ослын тохиолдол 2025 оны эхний 3 сард 1220 удаа бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 132 (9.8%)-аар буурсан байна. Тохиолдсон аюулт үзэгдэл, осолд 2025 оны эхний 3 сарын байдлаар 1345 хүн нэрвэгдсэн байна. Аюулт үзэгдэл, ослын улмаас 2025 оны эхний 3 сард 16.9 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.

Зураг 13. Аюулт үзэгдэл, осол

ҮЗҮҮЛЭЛТ	ЖИЛ			САР			ӨӨРЧЛӨЛТ	
	2022	2023	2024	2023 I-III	2024 I-III	2025 I-III	Дүн	Хувь
Аюулт үзэгдэл, ослын тохиолдол	4299	4484	5118	1087	1352	1220	-132	-9,8
Амь насаа алдсан хүний тоо	247	320	336	49	68	47	-2,1	-30,9
Учирсан хохирол, тэрбум төгрөг	33,2	52,1	41,7	11,1	16,5	16,9	0,4	2,3

² Корона вирус халдварын тохиолдлын тоо болон түүнтэй холбоотой гарсан зардлыг оруулаагүй

Эх сурвалж: Байгаль орчны статистикийн мэдээллийн сан

Биологийн олон янз байдлыг хамгаалах, экосистемийг сэргээх хүрээнд ойн нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ 1,744.71 га талбайд хүрч өмнөх оноос 38%-аар нэмэгдсэн байна. Гэвч ойгоор бүрхэгдсэн газрын хэмжээ төдийлөн өсөлт үзүүлж чадахгүй байна.

График 6. Ойн нөхөн сэргээлтийн хэмжээ



Эх сурвалж: Байгаль орчны статистикийн мэдээллийн сан

7.4. Бодлогын баримт бичигт тусгагдсан шалгуур үзүүлэлтүүд

Хүснэгт 20. Монгол Улсын байгалийн нөөц, биологийн олон янз байдлын шилжилтийн шалгуур үзүүлэлтүүд

ҮЗҮҮЛЭЛТ	ХЭМЖИХ НЭГЖ	СУУРЬ		АХ-2050, 2026-2030	АХ - 2050
		Он	Түвшин	2030 он	2050 он
6. Байгалийн нөөц, биологийн олон янз байдал					
Байгаль орчны гүйцэтгэлийн үзүүлэлт EPI	Оноо	2018	57.2	59	61+
Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн эзлэх хувь	Хувь	2024	20.8	30	35
Тусгай хамгаалалтад авсан усны эхийн эзлэх хувь	Хувь	2024	49.9	60	75
Ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хувь	Хувь	2024	8.45	9	10.5
Газрын доройтлын хувь	Хувь	2018	22.9	22.9	-
Тусгай хамгаалалтад авсан ойн сан бүхий газрын эзлэх хувь	Хувь	2024	42.3	50	-
Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн үр ашгит байдлын үнэлгээний улсын дундаж	Хувь	2021	61.9	95	-
Усны чанарын индексээр маш бохир, бохир зэрэглэлтэй цэгийн тоо, бууралт	Тоо	2024	6	0	-
Хөрсний хүнд металлын бохирдол стандартаас давж илэрсэн цэг	Хувь	2024	17.2	9	-
Нэн хүчтэй, хүчтэй доройтсон газар нутгийн эзлэх хувь	Хувь	2020	23.3	22	-
Ойжуулалт хийсэн талбай, өссөн дүн	Мянган га	2024	10	93	-
Дахин ашигласан усны эзлэх хувь	Хувь	2024	17	30	-
Тарьсан модны амьдралтын хувь	Хувь	2024	75	84	-
Ойн хөнөөлт шавьжтай тэмцсэн талбай	Мянган га	2024	341	250	-
Урсцыг сайжруулах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлсэн нуур, гол	Тоо	2024	2	12	-
Хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлсэн нэн ховор, ховор амьтан	Тоо	2024	10	20	-
Хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлсэн нэн ховор, ховор ургамал	Тоо	2024	15	28	-
Цөлжилтийг бууруулах, хамгаалах арга хэмжээ авсан газар нутгийн хэмжээ, тухайн жилд	Га	2024	200	200	-
Уул уурхайн нөхөн сэргээлт (техникийн, тухайн жилд)	Га	2024	2189	1500	-
Уул уурхайн нөхөн сэргээлт (биологийн, тухайн жилд)	Га	2024	773	500	-

8. Ногоон санхүүжилт, ногоон эдийн засаг

Эдийн засгийн өсөлт нь байгалийн нөөцийг эрчимтэй олборлох, эрчим хүч их зарцуулсан үйлдвэрлэл, хотжилтод тулгуурласнаар үр дүнд нь уур амьсгалын өөрчлөлт, экологийн доройтол үүсэж хуримтлагдсаар байна. Иймд тэнцвэртэй хөгжлийг бий болгохын тулд ногоон санхүүжилт буюу байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэх, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, нөөцийн үр ашгийг нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөр, үйл ажиллагаанд чиглэсэн санхүүгийн урсгалыг бий болгосон. Тус санхүүжилт нь зөвхөн өгөөжөөр бус, урт хугацааны эрсдэл, нийгэм, байгаль орчны үр нөлөөтэй нь хамтатган авч үнэлэх шинэ үзэл баримтлалд суурилдаг. Ногоон санхүүжилт дэлхийн санхүүгийн зах зээлд эрчимтэй тэлж, ногоон бонд, тогтвортой санхүүгийн зээл, ESG (environmental, social, governance)-д тулгуурласан хөрөнгө оруулалтууд нь санхүүгийн нэг хэлбэр болон хөгжсөөр байна. Ногоон санхүүжилт нь ногоон эдийн засаг хэлбэрээр нийгэмд илэрдэг.

Ногоон эдийн засаг нь ажлын байр, инноваци, өрсөлдөх чадвар, байгальд ээлтэй шийдлүүд дээр суурилж санхүү болон нөөцийг үр ашигтайгаар ашиглах, салбаруудын уялдаа холбоог сайжруулах замаар байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах юм. Ногоон төслүүд нь эхний санхүүжилт өндөр хэдий ч урт хугацаандаа эдийн засгийн болон байгаль хамгааллын өндөр үр ашгитай.

8.1. Ногоон санхүүжилт, ногоон эдийн засгийн шилжилтийн хамрах хүрээ

- 1) Ногоон бонд ба тогтвортой санхүүгийн хүрээ:** Эрчим хүч, дэд бүтэц, хотжилт зэрэг салбаруудад их хэмжээний урт хугацааны хөрөнгө оруулалт шаардлагатай болсон өнөө үед санхүүгийн зах зээл байгаль орчны зорилттой уялдах нь зайлшгүй хэрэгцээ болж байна. Байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэх тодорхой төслүүдийг санхүүжүүлэх зорилгоор гаргасан ногоон бонд нь сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний үр ашиг, ногоон барилга, тээвэр, ус, хог хаягдлын менежмент зэрэг төслүүдийг санхүүжүүлдэг. Энэ нь хөрөнгө оруулагчдад санхүүгийн өгөөжөөс гадна байгаль орчны бодит үр нөлөөг дэмжих боломжийг бий болгодог онцлогтой санхүүгийн хэрэгсэл юм.
- 2) Нүүрстөрөгчийн үнэ, татвар, ялгаруулалтын арилжааны систем:** Чулуужсан, шатах түлшинд суурилсан үйлдвэрлэл, эрчим хүч, тээвэр нь байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг тооцолгүй орхигдуулснаар эдийн засаг богино хугацааны ашиг хүртэх боломжтой ирсэн. Урт хугацаанд байгаль орчны доройтол, иргэдийн эрүүл мэндийн үзүүлэлт буурах гэх мэт нийгмийн сөрөг үр дагаврууд бий болсоор байна. Энэ зөрчлийг засах зорилгоор дэлхий даяар нүүрстөрөгчийн

үнэ тогтоох бодлого буюу нүүрстөрөгчийн татвар, ялгаруулалтын арилжааны систем (ETS)-ийг хөгжүүлсэн. Нүүрстөрөгчийн татвар нь ялгаруулсан CO₂ тутамд тогтсон үнийн дагуу татвар ногдуулах замаар бохирдлыг шууд өртөгтэй болгодог бол нүүрстөрөгчийн ялгаруулалтын арилжааны систем нь нийт ялгарлын дээд хязгаарыг тогтоож, зөвшөөрлийг зах зээл дээр арилжих боломж олгодог.

3) Татаасны шинэчлэл (чулуужсан түлшний татаасыг аажмаар зогсоох): Чулуужсан түлшний татаас нь олон арван жилийн турш эрчим хүчний үнийг тогтвортой байлгах, өрхийн зардлыг бууруулах, үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дэмжих зорилгоор ашиглагдаж ирсэн. Уур амьсгалын өөрчлөлт эрчимжихийн хэрээр чулуужсан түлшинд суурилсан татаасыг шинэчлэх, аажмаар зогсоох бодлого хэрэгжүүлэх шаардлагатай. Татаасыг зогсоох замаар бусад ногоон технологийг зах зээл дээр өрсөлдөх боломжийг нээх юм.

4) ESG стандартууд ба тогтвортой хөрөнгө оруулалтын бодлого: Санхүүгийн зах зээлийн хандлага нь сүүлийн жилүүдэд компанийн гүйцэтгэлийг зөвхөн ашиг, орлогоор хэмжихээс гадна байгаль орчин, нийгэм, засаглалын (ESG) шалгуурыг шийдвэр гаргалтын түвшинд авч үзэх болсон. ESG стандартууд нь компанийн урт хугацааны тогтвортой байдлыг үнэлэх нийтлэг шалгуур болж, тогтвортой хөрөнгө оруулалтын бодлогын суурь болж байна. ESG стандартууд нь байгууллагын байгаль орчинд үзүүлэх нөлөө (ялгаруулалт, нөөцийн хэрэглээ), нийгмийн хариуцлага (хөдөлмөрийн аюулгүй байдал, эрх тэгш байдал, нийлүүлэлтийн сүлжээ), засаглалын чанар (ил тод байдал, эрсдэлийн удирдлага, ТУЗ-ийн хараат бус байдал)-ыг хэмжих, тайлагнах зарчмыг тогтоодог.

8.2. Ногоон санхүүжилт, ногоон эдийн засгийн олон улсын шалгуур үзүүлэлтүүд

Хүснэгт 21. Ногоон санхүүжилт, ногоон эдийн засгийн олон улсын шалгуур үзүүлэлтүүд

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ХЭМЖИХ НЭГЖ	ОН	КАЗАХСТАН	ЭНЭТХЭГ	ХЯТАД	КАМБОЖ	МОНГОЛ
Ногоон бондын хэмжээ	Ам.доллар	-	-	-	-	-	-
Төрөөс байгаль орчинд гаргаж байгаа зардал (% ДНБ)	Хувь	2021	0.357	-	-	-	0.46
Нүүрс хүчийн татвар эсвэл үр ашигтай байдлын үнэлгээ	Ам.доллар/тонн CO ₂	-	-	-	-	-	-
Чулуужсан түлшний татаас	% ДНБ	2022	15	2	1	-	-
Нийт хөрөнгө оруулалтаас ESG-д хөрөнгө оруулалт	Хувь	-	-	-	-	-	-

Эх сурвалж: IMF, IEA


8.3. Монгол Улсын салбарын хууль, бодлогын баримт бичгүүд

Хүснэгт 22. Ногоон санхүүжилт, ногоон эдийн засгийн салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүд

7. НОГООН САНХҮҮЖИЛТ, НОГООН ЭДИЙН ЗАСАГ	БАТЛАГДСАН ОГНОО	ЗОРИЛТ
САЛБАРЫН ХУУЛИУД		
Хөрөнгө оруулалтын тухай	2013	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа нь хэрэглэгчийн эрх ашгийг дээдэлж, байгаль орчинд ээлтэй байж, хүний хөгжлийг дэмжих
Үнэт цаасны зах зээлийн тухай	2013	Ногоон бонд, ногоон санхүүжилт
Банкны тухай	2010	Ногоон зээл, ногоон эдийн засаг санхүүжилт
Агаарын тухай	2012	Хүрээлэн байгаа агаарыг хамгаалах, бохирдохоос урьдчилан сэргийлэх, агаар бохирдуулах бодисын хаягдлыг бууруулж хяналт тавих, агаарын бохирдлын төлбөр, нөхөн төлбөр
Байгаль орчныг хамгаалах тухай	1995	Байгаль орчинтой холбоотой ашиглалтын, бохирдуулсны, учруулсан хохирлын төлбөр мөн эдийн засгийн хөшүүрэг, санхүүжилтийн хэлбэрүүд
Эрчим хүчний тухай хууль	2001	Сэргээгдэх эрчим хүчийг дэмжих зорилгоор эрчим хүчний үнэд шингээсэн тариф - дэмжих тариф
Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль	2007	Сэргээгдэх эрчим хүчийг дэмжих, төсөл хэрэгжүүлэх
БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ		
Алсын хараа-2050	2020	Үндэсний ногоон санхүүгийн тогтолцоо, олон улсын санхүүжилтийг нэмэгдүүлж үр өгөөжтэй ашиглана.
Шинэ сэргэлтийн бодлого	2021	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ногоон төсөл, ногоон зээлийн үр өгөөжийг нэмэгдүүлсэн байна
Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал (2024-2050)	2024	Улаанбаатарын бүс нь олон улсын банк, санхүү, бизнесийн хөгжлийн төв болно
Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	2025	Олон талт санхүүгийн үйлчилгээг хөгжүүлэх
Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө	2025	Ногоон санхүүжилтийг нэмэгдүүлж, байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжлийг дэмжсэн хөрөнгө оруулалт, санхүүгийн механизмыг хөгжүүлнэ.
ХӨТӨЛБӨР, ТӨЛӨВЛӨГӨӨ		
Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2024-2028)	2024	"Монголын ногоон санхүүгийн корпорац"-ыг төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагын түншлэлд үндэслэн байгуулна
Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөр	2025	Дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, түүхий эдийг эцсийн бүтээгдэхүүн болгон худалдаалах
Аймгийн засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр	2025	Үйлдвэрлэл, үйлчилгээ, ногоон зээлийн санхүүжилтийг дэмжих
Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө	2016	Ногоон зээлийн сан бий болж, байгаль орчин, нийгэмд ээлтэй хөрөнгө оруулалтыг дэмжих тогтолцоо бий болно. ногоон бизнес эрхлэгчдэд зориулсан хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл олгох механизм бий болно.
Ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай УИХ 57-р тогтоол	2025	Хот, суурин газрыг орон сууцжуулахад ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, ногоон санхүүжилтийн зээлийн чиглэл, хяналт

Дэхийн банкнаас бэлтгэн гаргасан тогтвортой бондын 2024 оны тайланд дурдсанаар 2024 онд гаргасан бондын хэмжээ 1.1 их наяд ам.долларт хүрч 2023 оноос 5% өсөлттэй гарсан байна. Ногоон бондын гаралт нь нийт бондын 57%-ийг эзэлж байна. Шинжээчдийн үзэж байгаагаар нийгэм, эдийн засаг, геополитикийн нөхцөл байдлаас үл хамааран бондын гаргалтын хэмжээ өсөх төлөвтэй гэж дурдсан.

Зураг 14. Ногоон бонд



Эх сурвалж: World Bank based on data from Bloomberg Terminal

Санхүүгийн зохицуулах хорооноос бэлтгэн гаргасан “Санхүүгийн салбарын тойм” 2024 оны 4 дүгээр улирлын тайланд ногоон бонд, ногоон зээлийн үзүүлэлтүүдийг тусгасан байна. Ногоон зээлийн үлдэгдэл 2024 онд 7,227 эзэлдэгчийн 12 нэр төрлийн ногоон зээлд 115.3 тэрбум төгрөгийн зээл олгосон нь салбарын нийт зээлийн үлдэгдлийн 2.0 хувийг эзэлж байна. Нийт зээлд нүүрс хүчлийн хийн ялгарал багатай тээвэр 55.4%, тогтвортой хот төлөвлөлт ба барилга 19.4%, хүртээмжтэй дэд бүтэц 7.4%, тогтвортой хөдөө аж ахуй 5.8%, эрчим хүчний хангамж, дэд бүтэц 5.7%, боловсрол, соёл 2.6%, эрчим хүчний үр ашиг 1.9%-ийг тус тус эзэлж байна.

Зураг 15. Ногоон зээл

	Ногоон зээл (үнийг)	Зээлдэгчийн тоо	Нийт зээлийн үлдэгдэл /Аж төгрөг/
Эрчим хүчний хангамж, дэд бүтэц	5.7%	3,073	6,616.0
Эрчим хүчний үр ашиг	1.9%	71	2,246.6
Тогтвортой хот төлөвлөлт ба барилга	19.4%	907	22,384.3
Бохирдлыг бууруулах ба сэргийлэх	0.1%	1	111.6
Тогтвортой ус, хог хаягдал	0.6%	4	725.7
Тогтвортой хөдөө аж, ахуй	5.8%	425	6,665.8
Тогтвортой газар ашиглалт ба биологийн олон янз байдал	0.5%	8	617.6
Нүүрс хүчний хийн ялгарал багатай тээвэр	55.4%	2,724	63,821.7
Мэдээлэл, харилцаа холбоо, технологи	0.0%	1	3.4
Эрүүл мэнд	0.5%	6	621.9
Боловсрол, Соёл	2.6%	4	2,969.4
Хүртээмжтэй дэд бүтэц	7.4%	3	8,480.6

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хорооны, Санхүүгийн салбарын тойм

8.4. Бодлогын баримт бичигт тусгагдсан шалгуур үзүүлэлт

Хүснэгт 23. Монгол Улсын ногоон санхүүжилт, эдийн засгийн шилжилтийн шалгуур үзүүлэлтүүд

ҮЗҮҮЛЭЛТ	ХЭМЖИХ НЭГЖ	СУУРЬ		АХ-2050, 2026-2030	АХ - 2050
7. Ногоон санхүүжилт, эдийн засгийн хөшүүрэг		Он	Түвшин	2030 он	2050 он
Засгийн газрын ногоон худалдан авалтын эзлэх хувь	Хувь	-		20	50

9. Боловсрол, инноваци ба ногоон ур чадвар

Ногоон шилжилт нь зөвхөн технологи, хөрөнгө оруулалтаар хэмжигдэх процесс бус, харин хүний мэдлэг, ур чадвар, инновацийн чадавхаар бодитоор урагшилдаг өөрчлөлт юм. Аж үйлдвэрийн салбар нь хөгжлийн бүхий л шатандаа мэдлэг, боловсролыг сууриа болгодогтой адил, уур амьсгалын сорилт, ногоон эдийн засгийн хөгжил нь боловсрол, ур чадварын шинэчлэлийг зайлшгүй шаардаж байдаг.

Өмнөх үеийн боловсролын системүүд нь ихэвчлэн салбар тусгаарласан, тогтвортой бус үйлдвэрлэлд чиглэсэн ур чадварыг бий болгож ирсэн. Харин өнөөдөр эрчим хүч, үйлдвэрлэл, барилга, тээвэр, хөдөө аж ахуй зэрэг салбарууд зэрэгцэн ногоон технологид шилжиж, олон талт, уян хатан, дижитал суурьтай ур чадвар шаардлагатай болж байна. Үүнийг ногоон ур чадвар гэж нэрлэдэг бөгөөд үүнд эрчим хүчний үр ашиг, сэргээгдэх эх үүсвэр, нөөцийн менежмент, байгаль орчны үнэлгээ, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт зэрэг мэдлэг, чадварууд багтана.

Өнөөгийн нөхцөлд дэлхий даяар “ур чадварын зөрүү” тод ажиглагдаж байна. Ногоон технологи, тогтвортой үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж байгаа ч тэдгээрийг хэрэгжүүлэх мэргэжилтэн, инженер, техникч, бодлого боловсруулагчийн хүрэлцээ хангалтгүй хэвээр байна. Үүний зэрэгцээ уламжлалт салбарын ажиллах хүч шинэ шаардлагад дасан зохицох боломж хязгаарлагдмал байгаа нь нийгмийн шилжилтийн эрсдэлийг нэмэгдүүлж байна. Инноваци нь энэ зөрүүг нөхөх чухал гүүр болж байна. Дижитал боловсрол, онлайн сургалт, хиймэл оюун ухаанд суурилсан сургалтын платформууд нь мэдлэгийг хурдан түгээх, дахин сургах, мэргэжил дээшлүүлэх боломжийг өргөжүүлж байгаа. Их, дээд сургууль, судалгааны байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа нь ногоон технологийн судалгаа, туршилт, бизнесийн инновацийг уялдуулахад чухал үүрэг гүйцэтгэж байна.

Ногоон ур чадвар нь тухайлсан салбарын бус, бүх мэргэжлийн суурь чадамж болж төлөвших чиг хандлагатай байна. Үүнд бэлтгэхийн тулд боловсролын бодлого, хөдөлмөрийн зах зээл, инновацийн экосистемийг уялдуулсан, шат дараатай шинэчлэл нь ногоон шилжилтийн амжилтыг тодорхойлох гол хүчин зүйл болно.

9.1. Боловсрол, инноваци ба ногоон үр чадварын шилжилтийн хамрах хүрээ

1) Ногоон ажлын байрны сургалт болон дахин үр чадвар олгох: Сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний үр ашиг, ногоон барилга, тогтвортой хөдөө аж ахуй, хог хаягдал, усны менежмент зэрэг салбарууд эрчимтэй хөгжихийн хэрээр шинэ төрлийн ажлын байр бий болж, уламжлалт салбарын зарим мэргэжил аажмаар хумигдах хандлага ажиглагдаж байна. Ийм нөхцөлд ногоон ажлын байрны сургалт, дахин үр чадвар олгох бодлого нь шилжилтийг нийгмийн хувьд шударга, хүртээмжтэй болгох гол нөхцөл болж байна. Ногоон ажлын байрны сургалт гэдэг нь байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэх салбаруудад шаардлагатай мэдлэг, чадварыг системтэй олгох үйл явцыг хэлнэ. Харин дахин үр чадвар олгох нь уламжлалт салбарын ажиллах хүчийг шинэ технологи, шинэ ажлын байрны шаардлагад нийцүүлэн бэлтгэхийг зорьдог. Энэ нь ажилгүйдлийг бууруулахын зэрэгцээ хүний капиталыг хадгалж, эдийн засгийн шилжилтийн зардлыг багасгах ач холбогдолтой.

2) Байгаль орчны боловсрол: Байгаль орчны боловсрол нь хүн ба байгаль хоорондын харилцааг ойлгуулж, нөөцийг хариуцлагатай ашиглахад чиглэсэн боловсролын чухал салбар юм. Байгаль орчны доройтол, бохирдол, уур амьсгалын өөрчлөлт эрчимжихийн хэрээр байгаль орчны асуудлыг зөвхөн технологи, бодлогоор бус, иргэдийн мэдлэг, хандлага, зан төлөвөөр шийдэх шаардлага тодорхой болсон. Ийнхүү байгаль орчны боловсрол нь тогтвортой хөгжлийн салшгүй хэсэг болон хөгжиж ирсэн. Байгаль орчны боловсрол нь экологи, байгаль хамгааллын суурь ойлголтыг дамжуулахад төвлөрч байсан бол өнөөдөр илүү өргөн хүрээтэй, салбар хоорондын ойлголт болжээ. Энэ нь уур амьсгалын өөрчлөлт, нөөцийн менежмент, тогтвортой хэрэглээ, ногоон эдийн засаг, иргэний оролцоо зэрэг сэдвийг хамарч, суралцагчдыг мэдлэгтэй болгохоос гадна шийдвэр гаргах, оролцох чадварт сургахыг зорьдог.

3) Судалгаа, инноваци, технологийн дамжуулалт: Шинэ санааг лабораториос үйлдвэрлэл, зах зээл, бодлогын түвшинд нэвтрүүлэх үүргийг судалгаа, инноваци, технологийн дамжуулалт нь гүйцэтгэдэг. Өнөөгийн нөхцөлд судалгаа, инноваци нь улам илүү нээлттэй, хамтын шинжтэй болж байна. Дижитал технологи, өгөгдөлд суурилсан шийдлүүд, хиймэл оюун ухаан нь судалгааны үр ашгийг нэмэгдүүлж, инновацийн мөчлөгийг богиносгож байна. Судалгааг хөгжлийн бодлоготой, зах зээлтэй уялдуулах, туршилтаас хэрэгжилт рүү шилжих шат дараалал, хугацааг богиносгох нь ногоон шилжилтийн амжилтыг тодорхойлох гол хүчин зүйл болно.

4) Олон нийтийн мэдлэг, зан үйлийн өөрчлөлт: Иргэдийн

өдөр тутмын сонголт, хэрэглээ, шийдвэр гаргалтаар олон нийтийн мэдлэг, зан үйлийн өөрчлөлтийг тодорхойлдог. Мэдлэг, зан үйлийн өөрчлөлтөд чиглэсэн арга хэмжээнүүд нь анх мэдээлэл түгээх, уриалах хэлбэртэй байсан бол орчин үеийн хандлага нь зан үйлийн шинжлэх ухаанд тулгуурласан, бодит сонголтыг хялбарчлах арга барилд шилжиж байна. Эрчим хүч, ус хэмнэх, хог ангиалан ялгах, тогтвортой тээвэр сонгох зэрэг зан үйлийг дэмжихэд зөвхөн ухамсарт бус, нийгмийн стандарт, урамшуулал чухал үүрэгтэй болжээ. Мөн дижитал орчинд нийгмийн сүлжээ, гар утасны аппликейшн, платформууд нь идэвхтэй өрнөж, зорилтот бүлэгт тохирсон, бодит цагийн мэдээлэл, санал хүсэлт өгөх боломжийг бүрдүүлж байна. Мөн иргэдийн оролцоотой мониторинг, урамшууллын системүүд нь хамтын хариуцлагыг бэхжүүлдэг. Олон нийтийн мэдлэг, зан үйлийн өөрчлөлтийн ажил нь нэг удаагийн уриалга бус, урт хугацааны нийгмийн инноваци болж төлөвших шаардлагатай. Үүнд бэлтгэхийн тулд бодлого, технологи, соёлын онцлогийг уялдуулсан, үр нөлөөг хэмжих тодорхой үе шаттай арга хэмжээ нь голлох хүчин зүйл болно.

9.2. Боловсрол, инноваци ба ногоон үр чадварын олон улсын шалгуур үзүүлэлтүүд

Хүснэгт 24. Боловсрол, инноваци ба ногоон үр чадварын олон улсын шалгуур үзүүлэлтүүд

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ХЭМЖИХ НЭГЖ	ОН	КАЗАХСТАН	ЭНЭТХЭГ	ХЯТАД	КАМБОЖ	МОНГОЛ
Нийт ажлын байранд дахь ногоон ажлын байр	Хувь	-	-	-	-	-	-
Хичээлийн хөтөлбөрт байгаль орчин, тогтвортой байдлын боловсрол	Хувь	-	-	-	-	-	-
Нийт ДНБ-д эзлэх R&D зардал	Хувь	2022	0.12	-	2.56	-	0.08
Ногоон технологийн патентууд	Тоо	2024	3	80	1433	7	4
Нийт патент дахь байгаль орчны технологийн патентууд	Хувь	2020	13.8	11	13.8	-	26
Байгаль орчны хөтөлбөрт иргэний оролцох хувь (%)	Хувь	-	-	-	-	-	-
Ногоон сургалттай МСҮТ / их сургуулийн тоо	Тоо	-	-	-	-	-	-


Эх сурвалж: World Bank, OECD, Wikipedia, WIPO GREEN

Монгол Улсын ногоон ажлын байрны мэдээллийг ҮСХ-ны “Ажиллах хүчний болон ногоон ажлын байрны судалгааны үндсэн тайлан 2023”-г байгаль орчны салбарын хөдөлмөр эрхлэлт, ногоон ажлын байрны статистикийн ойлголт, тодорхойлолтын дагуу судалгааны үр дүнг дараах байдлаар тооцоолсон байна.

Улсын хэмжээнд 2023 онд нийт ажиллагчдын 11.1 (144.0

мянга) хувь нь байгаль орчны бүтээгдэхүүн үйлдвэрлэлд, 23.5 (303.7 мянга) хувь нь байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаанд оролцсон байна. 2023 оны байдлаар байгаль орчны салбарын ажиллагчдын 65.1 мянга (20.7%) нь цалин хөлстэй ажиллагчид байгаагийн 52.0 (79.9%) мянга нь нийгмийн даатгалд хамрагдсан буюу ногоон ажлын байранд ажилласан байна.

Зураг 16. Байгаль орчны салбарын ногоон ажлын байрыг тодорхойлох схем



Эх сурвалж: Ажиллах хүчний болон ногоон ажлын байрны судалгааны үндсэн тайлан 2023

Зураг 17. Байгаль орчны бүтээгдэхүүн үйлдвэрлэл

Хугацаа	Нийт ажиллагчид	Байгаль орчны бүтээгдэхүүн үйлдвэрлэлд хамаарах хөдөлмөр эрхлэлт	Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаанд хамаарах хөдөлмөр эрхлэлт	Байгаль орчны салбарын хөдөлмөр эрхлэлт	Ногоон ажлын байр
2014 IV	1,040.7	206.7	260.3	292.2	58.7
2016 I	1,089.3	225.5	342.1	372.0	96.2
2016 II	1,131.8	233.5	341.5	374.1	112.3
2023 I	1,253.9	166.9	304.3	320.0	57.9
2023 II	1,279.1	168.5	336.0	349.8	66.8
2023 III	1,326.2	146.0	308.0	317.9	43.0
2023 IV	1,322.4	103.8	278.8	285.1	40.7
2023	1,294.7	144.0	303.7	315.2	52.0

Эх сурвалж: Ажиллах хүчний болон ногоон ажлын байрны судалгааны үндсэн тайлан 2023

9.3. Монгол Улсын салбарын хууль, бодлогын баримт бичгүүд

Хүснэгт 25. Боловсрол, инноваци ба ногоон ур чадварын салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүд

8. БОЛОВСРОЛ, ИННОВАЦИ БА НОГООН УР ЧАДВАР	БАТЛАГДСАН ОГНОО	ТАЙЛБАР, АГУУЛГА, ЗОРИЛТ
САЛБАРЫН ХУУЛИУД		
Боловсролын ерөнхий хууль	2023	Салбарын үндсэн хууль
Дээд боловсролын тухай	2023	Салбарын хууль, нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах, дэвшилтэт шинэ санаа, судалгаа, инновацийг хөгжүүлэх
Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай	2023	Салбарын хууль, нийгмийн хөгжил, эдийн засгийн бүтээмжийг дэмжих, хөдөлмөрийн зах зээл, ур чадварын эрэлт, шаардлагад нийцсэн мэргэжлийн ур чадвар бэлтгэх, мэргэшлийн түвшин ахиулах, тасралтгүй хөгжих
Шинжлэх ухаан, технологийн тухай	2024	Салбарын хууль, шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх замаар үндэсний өрсөлдөх чадварыг сайжруулах, эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх
Инновацийн тухай	2012	Төрөөс шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын талаар баримтлах бодлогыг инновацийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг хангах
БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ		
Алсын хараа-2050	2020	Улс орон даяар боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх
Шинэ сэргэлтийн бодлого	2021	Улсын макро эдийн засгийн бодлого, ур чадварын хөгжлийг дэмжих
Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал (2024-2050)	2024	Бүс, орон нутагт өндөр технологи, инновацийг нэвтрүүлэх
Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	2025	Шинжлэх ухаан, технологи, инновацийн хувь нэмрийг дээшлүүлэх
Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө	2025	Оюуны бүтээлийн үнэлэмжийг нэмэгдүүлж, шинэ бүтээл, оюуны өмч, судалгаа шинжилгээ, патент, шинэ технологийг эдийн засгийн эргэлтэд оруулж, салбаруудын бүтээмжийг нэмэгдүүлэх
ХӨТӨЛБӨР, ТӨЛӨВЛӨГӨӨ		
Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2024-2028)	2024	Засгийн газрын хөтөлбөр
Аймгийн засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр	2025	Аймгийн хөтөлбөр
Нийслэлийн засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр	2025	Нийслэлийн хөтөлбөр
Насан туршийн боловсролын үндэсний хөтөлбөр	2017	Иргэдийн тасралтгүй суралцах боломжийг нэмэгдүүлэх

9.4. Бодлогын баримт бичигт тусгагдсан шалгуур үзүүлэлтүүд

Хүснэгт 26. Монгол Улсын боловсрол, инноваци ба ногоон ур чадварын шилжилтийн шалгуур үзүүлэлтүүд

ҮЗҮҮЛЭЛТ	ХЭМЖИХ НЭГЖ	СУУРЬ	АХ 2050, 2026-2030	АХ - 2050
8. Боловсрол, инноваци ба ногоон ур чадвар	Он	Түвшин	2030 он	2050 он

10. Дүгнэлт

Ногоон шилжилт нь Монгол Улсын хөгжлийн дараагийн шатанд зайлшгүй хэрэгжих шаардлага болж байна. Эрчим хүч, тээвэр, үйлдвэрлэл, хотжилт, хөдөө аж ахуй, байгалийн нөөцийн ашиглалт зэрэг салбар бүрд хуримтлагдсан бүтцийн асуудлууд нь уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтол, эдийн засгийн эмзэг байдлыг улам гүнзгийрүүлж байгаа өнөөгийн нөхцөлд ногоон шилжилт нь эдгээр сорилтыг нэгэн зэрэг, уялдаа холбоотойгоор шийдэх цогц шийдэл юм.

Энэхүү баримт бичигт авч үзсэн цэвэр эрчим хүчний шилжилт, ногоон тээвэр, ногоон үйлдвэрлэл ба тойрог эдийн засаг, тогтвортой мал аж ахуй, ногоон хотууд, байгалийн нөөцийн хамгаалал, ногоон санхүүжилт, боловсрол ба ногоон ур чадвар зэрэг чиглэлүүд нь тус тусдаа салангид бодлого бус, харин нэг зорилгын төлөө уялдан ажиллах цогц систем гэдгийг тодорхой харуулж байна. Аль нэг салбарын хоцрогдол нь бусад салбарын шилжилтийг удаашруулах эрсдэлтэй тул бодлого, хэрэгжилт, хөрөнгө оруулалтыг нэгдмэл байдлаар төлөвлөх шаардлагатай.

Олон улсын харьцуулсан үзүүлэлтүүдээс харахад Монгол Улсын ногоон шилжилтийн бэлтгэл, гүйцэтгэлийн түвшин хангалтгүй байгаа нь бодлогын тогтвортой

байдал, санхүүжилт, институцийн чадавх, хүний нөөцийн дутагдалтай шууд холбоотой. Гэсэн хэдий ч байгалийн асар их нөөц, сэргээгдэх эрчим хүчний боломж, мал аж ахуй, газар нутгийн онцлог зэрэг өрсөлдөх давуу талууд нь зөв бодлого, зөв хөрөнгө оруулалтаар ногоон шилжилтийг хурдасгах боломж байгааг харуулж байна.

Цаашид ногоон шилжилтийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд:

- Бодлогын баримт бичгүүдийн уялдаа, хэрэгжилтийн явцыг тодорхой болгох,
- Ногоон санхүүжилт, зах зээлийн хөшүүргийг ашиглах,
- Боловсрол, дахин ур чадвар олгох тогтолцоог эрчимжүүлэх,
- Олон нийтийн оролцоо, зан үйлийн өөрчлөлтийг тогтвортой дэмжих шаардлагатай байна.

Ногоон шилжилт нь зардал нэмэх, хязгаарлалт тавих тухай ойлголт бус, харин эдийн засгийн тогтвортой өсөлт, нийгмийн шударга байдал, байгалийн капиталыг хамгаалах боломж юм. Өнөөдрийн шийдвэрүүд нь ирээдүйн хөгжлийн чиглэлийг тодорхойлох тул Монгол Улс ногоон шилжилтийг зөв төлөвлөлт, хүн төвтэй бодлогоор хэрэгжүүлэх нь урт хугацааны хөгжлийн хамгийн зөв хөрөнгө оруулалт болно.

11. Эх сурвалж

1. World Bank, <https://data.worldbank.org>
2. IEA, <https://www.iea.org/countries>
<https://www.iea.org/topics/fossil-fuel-subsidies>
3. Our World in Data, <https://ourworldindata.org>
4. World Health Organization (WHO), <https://data.who.int/indicators> <https://data.who.int/indicators/i/6EFF579/A37BDD6>
5. OECD, <https://www.oecd.org/en/data.html>
6. FAO, <https://www.fao.org/faostat/en/#data/EM> <https://www.fao.org/sustainable-development-goals-data-portal/data/indicators/641-change-in-water-use-efficiency-over-time/en>
7. FiBL, <https://www.fibl.org/en/shop-en/1797-organic-world-2025>
8. UNEP, <https://wedocs.unep.org/items/dbe2cd4c-8384-4636-8359-5847f42b9711>
9. FAO GLOSIS, <https://data.apps.fao.org/glosis/?lang=en&share=f-5ed4c679-a2a8-481b-b734-09c9a4ce7310>
10. IUCN Red List <https://www.iucnredlist.org/statistics>
11. Wikipedia, https://en.wikipedia.org/wiki/World_Intellectual_Property_Indicators
12. WIPO GREEN, https://wipogreen.wipo.int/wipogreen-database/search?query=&type=BASIC&pagination.page=0&pagination.size=10&sort.0.field=CREATED_AT&sort.0.direction=DESC&queryFilters.0.field=CREATED_AT_AFTER&queryFilters.0.value=2024-01-01T00:00:00.000Z&queryFilters.1.field=CREATED_AT_BEFORE&queryFilters.1.value=2024-12-31T23:59:59.999Z
13. Зам тээврийн яам – Зам тээврийн салбарын 2024 оны жилийн эцсийн статистикийн эмхэтгэл <https://mrt.gov.mn/i/4401>
14. UN-Habitat, <https://data.unhabitat.org/pages/open-spaces-and-green-areas>
15. IMF, https://climatedata.imf.org/datasets/d22a6dcd9b147fd9040f793082b219b_0/explore



Б.ОЮУНДЭЛГЭР
ШИНЭ СЭРГЭЛТ
ИННОВАЦИЙН ХӨТӨЛБӨР
Мэргэжилтэн

ЦАХИМ ШИЛЖИЛТ
ХИЙМЭЛ
ОЮУН УХААНЫ
ӨНӨӨГИЙН
БАЙДАЛ БА
ОЛОН УЛСЫН
ИНДЕКСҮҮДЭД
СУУРИЛСАН
ХАРЬЦУУЛАЛТ



Оршил

Орчин үеийн улс орнуудын хөгжлийн түвшин, эдийн засгийн өрсөлдөх чадвар, төрийн институцийн үр ашиг нь мэдээлэл, харилцаа холбооны технологид суурилсан цахим шилжилтийн явц, чанар, үр дүнтэй шууд хамааралтай болсон байна. Дэлхий хэмжээнд дижитал технологийн хурдацтай хөгжил нь үйлдвэрлэл, үйлчилгээ, боловсрол, эрүүл мэнд, санхүү, төрийн удирдлагын тогтолцоонд гүнзгий өөрчлөлт авчирч, эдийн засгийн бүтцийн шинэчлэл, инновацийн чадавх, нийгмийн оролцооны шинэ хэлбэрүүдийг бий болгож байна. Ийм нөхцөлд цахим шилжилт нь зөвхөн мэдээллийг цахим хэлбэрт хөрвүүлэх техникийн үйл явц бус харин институцийн шинэчлэл, бодлогын уялдаа, хүний нөөцийн чадавх, дижитал соёлын төлөвшил зэрэг олон талт хүчин зүйлсийг хамарсан цогц стратегийн өөрчлөлт юм.

Сүүлийн жилүүдэд олон улсын индекс үнэлгээний системүүд тухайлбал цахим засаглалын индекс, сүлжээний бэлэн байдлын индекс, дэлхийн дижитал өрсөлдөх чадварын үнэлгээ зэрэг нь улс орнуудын дижитал хөгжлийн түвшинг харьцуулан хэмжих, бодлогын үр нөлөөг үнэлэх чухал хэрэгсэл болж байна. Эдгээр үзүүлэлтүүд нь дэд бүтцийн хүртээмж, хүний капитал, технологийн хэрэглээ, инновацийн экосистем, зохицуулалтын орчин, цахим оролцоо, өрсөлдөх чадвар, цахим ур чадвар зэрэг олон хэмжигдэхүүнийг хамарч,

цахим шилжилтийн бодит ахиц дэвшил, сул талыг тодорхойлох боломжийг олгодог.

Монгол Улсын хувьд цахим шилжилтийг үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэл болгон тодорхойлж, “Цахим үндэстэн” зэрэг бодлогын баримт бичгүүдийг батлан хэрэгжүүлж байна. Гэсэн хэдий ч цахим дэд бүтцийн тэгш бус хүртээмж, хүний нөөцийн ур чадварын зөрүү, инновацийн экосистемийн сул хөгжил, кибер аюулгүй байдлын сорилт зэрэг асуудлууд нь цахим шилжилтийн үр өгөөжийг бүрэн ашиглахад тодорхой хэмжээнд саад болж байна. Иймд цахим шилжилтийн өнөөгийн байдал, олон улсад эзлэх байр суурь, бодлогын хэрэгжилтийн үр нөлөөг системтэйгээр судлан шинжлэх шаардлага үүсэж байна.

Энэхүү судалгааны зорилго нь Монгол Улсын цахим шилжилтийн өнөөгийн түвшин, хүчин зүйлс, олон улсын индекс дэх байр суурийг задлан шинжилж, тулгамдаж буй асуудал, боломжийг тодорхойлох замаар бодлогын оновчтой шийдлийн санал боловсруулахад оршино. Судалгаанд тоон болон чанарын аргыг хослуулан ашиглаж, олон улсын харьцуулсан мэдээлэл, статистик үзүүлэлт, бодлогын баримт бичигт дүн шинжилгээ хийх замаар дүгнэлт гаргана.

Ийнхүү цахим шилжилтийн бодит нөхцөл байдал, сорилт, хөгжлийн чиг хандлагыг онол, практикийн түвшинд авч үзэх нь Монгол Улсын тогтвортой хөгжил, эдийн засгийн бүтээмж, нийгмийн оролцоог нэмэгдүүлэх бодлогын үндэслэлийг бэхжүүлэхэд ач холбогдолтой юм.

1. Цахим шилжилтийг амжилттай хэрэгжүүлж буй улс орнуудын туршлага

Дэлхий нийтийн хэмжээнд цахим шилжилт нь төрийн засаглалын үр ашиг, ил тод байдал, иргэдийн оролцоо, эдийн засгийн өрсөлдөх чадварыг тодорхойлогч үндсэн хүчин зүйл болж байна. Цахим шилжилтийг амжилттай хэрэгжүүлсэн улс орнуудын туршлагаас харахад уг үйл явц нь зөвхөн мэдээллийн технологийн шинэчлэл бус харин төрийн институц, бодлого, үйлчилгээний философийг бүхэлд нь шинэчлэх засаглалын цогц реформ байна. Одоогоор Эстони Улс, Сингапур Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс зэрэг орнууд цахим шилжилтийг амжилттай хэрэгжүүлж, энэ үзүүлэлтээр дэлхийд тэргүүлэх байр суурь эзэлж байна.

1.1 Эстони Улс: E-Estonia - Үндэсний цахим засаглалын загвар

E-Estonia нь Эстони Улсын төрийн засаглал, эдийн засаг, нийгмийн үйлчилгээг бүрэн цахим орчинд шилжүүлсэн үндэсний хэмжээний цахим экосистем юм. Энэхүү санаачилга нь 1994 онд “Tiger Leap (Tiigri-hüpe)” үндэсний хөтөлбөрөөр эхэлж мэдээлэл, харилцаа холбооны технологийг төрийн бодлогын гол тулгуур

болгон хөгжүүлснээр E-Estonia суурийг тавьсан гэж үздэг.

Улмаар цахим шилжилтийг үндэсний хэмжээний засаглалын реформ болгон хэрэгжүүлж бүх иргэн, байгууллагыг хамарсан E-Estonia дижитал экосистемийг бүрдүүлжээ. Үндэсний цахим үнэмлэх (Digital ID) болон өгөгдөл солилцооны нэгдсэн платформ (X-Road)-д суурилсан уг систем нь “мэдээллийг нэг удаа цуглуулах” зарчмыг хэрэгжүүлж төрийн бүх үйлчилгээг иргэн төвтэй, аюулгүй, тасралтгүй хүргэх боломжийг бүрдүүлсэн. Түүнчлэн цахим гарын үсэг нь хууль зүйн бүрэн хүчинтэй бөгөөд төр хувийн бүх үйлчилгээний суурь болж иргэд төрийн үйлчилгээг 24/7 цахимаар авах нөхцөлийг хангаж байна. Өнөөдөр Эстони улсын иргэд гэрлэлт цуглуулахаас бусад бүх төрлийн үйлчилгээг 100 хувь цахимаар авч байна. Үүний үр дүнд төрийн зардал эрс буурч, ил тод байдал, иргэдийн итгэлцэл, улсын дижитал өрсөлдөх чадвар мэдэгдэхүйц нэмэгдсэн. Иймд E-Estonia загвар нь хөгжиж буй орнуудад төрийн үйлчилгээний үр ашгийг нэмэгдүүлэх цахим шилжилтийг хурдасгах бодлогын жишиг кейс болж байна.

Мөн Эстони Улсын Засгийн газар анх 2019 онд Үндэсний хиймэл оюун ухааны стратегийг “Estonia’s National AI Strategy 2019- 2021” баталсан. Энэ стратеги нь богино

хугацааны стратеги байсан бөгөөд дараагийнх нь 2022-2023 оны стратеги болж үргэлжилж байна.

1.2 Сингапур Улс: Smart Nation – Цахим, ухаалаг төрийн загвар

Smart Nation нь Сингапур Улсын үндэсний дижитал стратеги бөгөөд 2014 оноос хэрэгжиж эхэлсэн. Энэхүү санаачилга нь иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, төрийн үйлчилгээг илүү үр ашигтай болгох, дижитал эдийн засаг, инновацийг дэмжих зорилготой. Smart Nation нь Сингапурын иргэн төвтэй, өгөгдөлд суурилсан засаглалын загварын гол жишээ болсон. SingPass нэг нэвтрэх цахим таних систем, My-Info өгөгдөл солилцооны механизмд суурилан иргэн, бизнес, төрийн үйлчилгээг нэг цонхоор, саадгүй авах нөхцөлийг бүрдүүлсэн. Мөн “Virtual Singapore” цахим платформоор дамжуулан өгөгдөлд суурилсан хот төлөвлөлт, эрсдэлийн удирдлага, бодлого боловсруулах чадавхыг бэхжүүлж, төрийн шийдвэр гаргалтын чанар, үр ашгийг мэдэгдэхүйц сайжруулсан.

Сингапур Улс анх Үндэсний хиймэл оюун ухааны стратегиа (National AI Strategy) 2019 онд албан ёсоор нээлттэй зарлагдсан бөгөөд хиймэл оюун ухааныг эдийн засаг, нийгэм, төрийн үйлчилгээнд өргөн ашиглах үндэсний төлөвлөгөөний суурь болгож баталсан байдаг. 2023 онд “National AI Strategy 2.0” (NAIS 2.0) шинэчлэн гаргаж, хиймэл оюун ухааны хөгжлийг илүү өргөн хүрээнд хөгжүүлэх шинэчлэл, зорилтуудтай стратегийг хэрэгжүүлж эхэлсэн.

1.3 Солонгос Улс: Government 3.0 – Иргэн төвтэй, өгөгдөлд суурилсан засаглал

Government 3.0 нь БНСУ-ын төрийн үйлчилгээг иргэн төвтэй, нээлттэй, өгөгдөлд суурилсан болгох стратеги бөгөөд 2012 оноос хэрэгжиж эхэлсэн. Энэ хөтөлбөр нь Government 1.0 (зөвхөн хууль, дүрмийн засаглал), Government 2.0 (интернет, цахим үйлчилгээ)-ээс илүү хөгжсөн, иргэдийн оролцоо, өгөгдлийн интеграци, цахим шийдэл дээр суурилсан үе юм. Энэхүү бодлого нь нээлттэй өгөгдөл, уялдаа холбоонд суурилсан төрийн үйлчилгээ, төр хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих замаар төрийн шийдвэр гаргалтын ил тод байдал, үр ашгийг сайжруулж, иргэдийн хэрэгцээнд нийцсэн интеграцчилсан үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн. Үүний үр дүнд төрийн үйлчилгээний чанар ахиж, инноваци, дата-д суурилсан засаглалын экосистем тогтвортой бүрэлдсэн.

Солонгос Улс үндэсний хиймэл оюун ухааны стратеги буюу “National AI Strategy Policy Direction” Үндэсний хиймэл оюун ухааны стратегийн бодлогын чиглэл гэж 2024 онд батлан БНСУ-ыг дэлхийн гурван том хиймэл оюун ухааны тэргүүлэгчийн нэг болгох зорилго тавьжээ.

2. Монгол улсын цахим шилжилтийн өнөөгийн байдал: олон улсын индексүүдэд суурилсан харьцуулалт

Олон улсын түвшинд цахим шилжилт, цахим засаглалын хөгжлийг төрөл бүрийн индекс, үнэлгээний тогтолцоонд тулгуурлан хэмжиж, харьцуулан үнэлдэг. Тухайлбал IMD World Digital Competitiveness Ranking (WDCR), Government AI Readiness Index 2025, Global Connectivity Report 2025, Network Readiness Index 2024, Global Innovation Index (GII) 2025, Global Cybersecurity Index 2024 зэрэг индексүүд нь цахим дэд бүтэц, төрийн цахим үйлчилгээний хүртээмж, кибер аюулгүй байдал, институцийн бэлэн байдлыг цогцоор нь үнэлэх олон улсын түгээмэл шалгуур үзүүлэлтүүд юм.

Эдгээр олон улсын индексүүдэд суурилан дэлхийд цахим засаглал, төрийн цахим үйлчилгээний хөгжлөөр тэргүүлэгч Эстони Улс, хиймэл оюун ухаан болон цахим эдийн засгийн хөгжлөөр Азид тэргүүлж буй Хятад Улс, мөн газарзүйн байрлал, соёл, хөгжлийн үе шат, эдийн засгийн бүтэц, хөгжлийн түвшнээрээ Монгол Улстай харьцангуй ойролцоо Казахстан, Киргистан улсуудыг сонгон харьцуулсан нь Монгол Улсын цахим шилжилтийн өнөөгийн байдал, олон улсын хэмжээнд эзлэх байр суурийг тодорхойлох, цаашдын бодлого боловсруулахад ашиглах туршлага судлахад онолын болон практикийн ач холбогдолтой юм.

2.1 Дэлхийн дижитал өрсөлдөх чадварын зэрэглэл / IMD World Digital Competitiveness Ranking 2025/

IMD World Digital Competitiveness Ranking (WDCR) гэдэг нь Швейцарьт төвтэй Олон Улсын Менежментийн Хөгжлийн Институт (IMD)-ийн жил бүр гаргадаг дэлхийн улс орнуудын цахим өрсөлдөх чадварын үнэлгээ юм. Энэ нь эдийн засаг, технологи, ирээдүйн бэлтгэл байдлыг цахим шилжилт, инноваци, судалгаа хөгжүүлэлтэд тулгуурлан салбар бүрээр нь 69 улс орныг хамран үнэлсэн олон улсын индекс юм.

Хүснэгт 1. IMD World Digital Competitiveness Ranking /Rank-69 орон/

/1-саян 69-мүү/

УЛС	КАЗАХСТАН	ЭСТОНИ	ХЯТАД	МОНГОЛ
Дижитал өрсөлдөх чадварын зэрэглэл	39	26	12	67

Хүснэгт 2. IMD World Digital Competitiveness Ranking / Үзүүлэлтүүдээр Rank-69 орон/

/1-сэйн 69-мүү/

УЛС		КАЗАХСТАН	ЭСТОНИ	ХЯТАД	МОНГОЛ	
Үндсэн үзүүлэлт	Knowledge - Цахим технологи, шинэ санаа, үр чадвар бий болгох чадвар	34	27	14	64	
	Technology - Цахим технологийн хөгжлийг дэмжих орчин ба боломжууд	42	33	15	63	
	Future readiness - ирээдүйн цахим шилжилт, технологи хүлээн авах чадвар, хурдтай дасан зохицох чадварыг	36	20	18	66	
мэдлэг	Авьяас чадвар	PISA боловсролын үнэлгээ - Математик	41	7	1	42
		Олон улсын туршлага	36	54	52	67
		Хотын менежмент	29	42	5	68
		Дижитал/технологийн үр чадвар	44	29	17	65
		Өндөр үр чадвартай гадаадын мэргэжилтэн	33	36	52	62
		Олон улсын оюутны цэвэр урсгал	59	32	53	61
		Эмэгтэй судлаачид	3	22	55	1
		Шинжлэх ухаан техникийн ажил эрхлэлт	47	28	41	55
	Сургалт боловсрол	Ажилтны сургалт	11	14	21	35
		Боловсролын салбарт чиглэсэн төсвийн нийт зардал	34	8	57	38
		Дээд боловсролын гүйцэтгэл	1	35	10	26
		Оюутан/багшийн харьцаа (дээд боловсрол)	37	11	44	52
		Шинжлэх ухааны төгсөгчид	20	22	-	56
		Дипломтой эмэгтэйчүүд	1	18	55	22
		Компьютерийн шинжлэх ухааны боловсролын индекс	58	32	3	60
	Шинжлэх ухааны төвлөрөл Сургалт боловсрол	Шинжлэх ухаан, технологийн судалгаа хөгжүүлэлтэд хийсэн нийт зардал	60	19	14	-
		Нэг хүнд ноогдох судалгаа, хөгжүүлэлтийн ажилтнуудын тоо	50	28	34	44
		Нийтлэлээр хэмжих судалгаа, хөгжүүлэлтийн бүтээмж	20	60	1	-
		Өндөр технологийн патент олголт	62	11	7	61
		ХОУ-тай холбоотой нийтлэл	45	52	1	-
		Боловсрол, судалгаа хөгжүүлэлтийн салбар дахь роботжуулалт	-	49	1	-
		ХОУ-тай холбоотой нийтэлсэн өгүүллийн тоо	54	17	49	59
ТЕХНОЛОГИ	Зохицуулалтын хүрээ	Бизнес эхлүүлэх	11	7	16	43
		Гэрээ хэрэгжүүлэх	4	8	5	47
		Цагаачлалын хууль	17	62	50	65
		Технологийн хөгжил, хэрэглээ	23	25	22	69
		Шинжлэх ухааны судалгааны хууль тогтоомж	27	47	23	68
		Оюуны өмчийн эрх	38	27	39	68
		Хиймэл оюун ухааны бодлогыг хууль болгон баталсан	66	12	30	66
		Мэдээллийн технологи, хэвлэл мэдээллийн зах зээлийн капиталжуулалт	-	52	24	-
	Капитал	Технологийн хөгжлийн санхүүжилт	23	34	18	68
		Банк, санхүүгийн үйлчилгээ	37	22	24	66
		Улсын зээлийн үнэлгээ	46	27	28	63
		Эрсдэлийн капитал	35	28	31	68
		Харилцаа холбооны салбар дахь хөрөнгө оруулалт	68	41	33	5
		Хиймэл оюун ухаанд хувийн хөрөнгө оруулалт	57	40	2	-
		Технологийн зохион байгуулалт	Холбооны технологи	40	39	13
	Үүрэн холбооны хэрэглэгч		61	55	1	67
	Утасгүй өргөн зурвасын интернэт		60	4	13	49
	Интернэт хэрэглэгчид		30	28	60	55
	Интернэтийн зурвасын өргөн ба хурд		60	40	23	63
	Өндөр технологийн экспорт (%)		9	31	14	10
	Аюулгүй интернэт серверүүд		44	10	52	50

ИРЭЭДҮҮД БЭЛЭН БАЙДАЛ	Дасан зохицох хандлага	Цахим оролцоо	23	6	11	32
		Интернэт худалдаа	43	18	20	59
		Таблет эзэмшилт	53	5	40	-
		Ухаалаг гар утас эзэмшилт	13	7	52	62
		Даяаршлын талаарх олон нийтийн үзэл бодол	19	40	10	64
		Уян хатан байдал, дасан зохицох чадвар	21	27	20	41
	Бизнесийн боломж	Боломж ба аюул занал	18	25	12	67
		Дэлхийн роботын тархалт	-	47	1	-
		Компаниудын шалгамж	14	15	21	66
		Өгөгдлийн аналитик хэрэглээ	12	47	11	66
		Мэдлэгийн шилжилт	25	45	24	69
		Үйлдвэрлэгчдийн бүтэлгүйтлийн айдас	43	21	49	-
	Мэдээллийн технологийн интеграциал	Цахим засгийн газар	23	2	31	39
		Төрийн болон хувийн хэвшлийн түншлэл	17	65	14	69
		Кибер аюулгүй байдал	43	21	14	69
		Програм хангамжийн хулгай	61	29	58	-
		Засгийн газрын кибер аюулгүй байдлын чадавх	35	1	2	58
		Нүүцлалыг хуулиар хамгаалах	59	18	64	56

Эх сурвалж: IMD World Digital Competitiveness Ranking (WDCR)

2.2 Засгийн газрын хиймэл оюун ухаанд бэлэн байдлын зэрэглэл /Government AI Readiness Index 2025/

Government AI Readiness Index 2025 гэдэг нь Oxford Insights байгууллагаас жил бүр гаргадаг, улс орнуудын Засгийн газар хиймэл оюун ухааныг (AI) ашиглах, удирдах, нэвтрүүлэх бэлтгэл байдлын түвшинг үнэлсэн олон улсын индекс юм. Энэ нь дэлхий даяар 195 орны

засгийн газрын хиймэл оюун ухааны бэлтгэл байдлыг харьцуулж үнэлдэг цор ганц индекс юм. Энэхүү индексээр Монгол Улс 195 орноос 94-т жагсаж байна.

Хүснэгт 3. Government AI Readiness Index /Rank-195 орон/

/1-сэйн 195-мүү/

УЛС	ЭСТОНИ	ХЯТАД	КИРГИСТАН	КАЗАХСТАН	МОНГОЛ
Цахим засаглалын индекс	21	8	119	58	94

Хүснэгт 4. Government AI Readiness Index /Үзүүлэлтүүдээр 1-100 оноогоор үнэлдэг/

/0-мүү 100-сэйн/

УЛС		ЭСТОНИ	ХЯТАД	КИРГИСТАН	КАЗАХСТАН	МОНГОЛ
Нийт оноо /0-100 /		69.6	76.3	33.3	56.7	40.9
Үндсэн үзүүлэлт	Policy Capacity - Засгийн газрын хиймэл оюуны тухай стратеги, бодлого боловсруулах чадвар.	96.0	92.5	16.0	88.0	35.0
	AI Infrastructure - Техник, өгөгдөл, тооцоолох дэд бүтэц	54.3	78.4	43.9	53.9	44.4
	Governance - Засгийн газар нь AI-ийг хариуцлагатай, аюулгүй, ил тод хэрэглэж чаддаг эсэхийг харуулна.	90.0	91.1	31.0	64.6	49.0
	Public Sector Adoption - Засгийн газрын AI-ийг бодит үйл ажиллагаанд нэвтрүүлэх чадвар	99.6	49.0	46.9	73.6	69.4
	Development & Diffusion - AI-ийн хөгжил, инноваци ба тархалт	46.0	74.7	22.2	39.9	20.5
	Resilience - AI-тай холбоотой эрсдэлүүдээс хамгаалах, зохицуулах, аюулгүй байдлыг хангах чадварыг хэмждэг.	64.4	77.3	34.8	37.4	33.8
Бодлогын алсын хараа (Policy vision)	Бодлогын алсын хараа (Policy vision)	90.0	100.0	40.0	70.0	50.0
	Бодлогын үйл ажиллагаа (Policy commitment)	100.0	87.5	0.0	100.0	25.0
	Тооцооллын хүчин чадал (Compute capacity)	7.7	80.7	4.2	7.9	5.8
	Боломж бүрдүүлэгч техникийн дэд бүтэц (Enabling technical infrastructure)	67.2	69.2	57.6	74.4	59.0
	Өгөгдлийн чанар (Data quality)	88.0	85.2	70.1	79.4	68.3
	Засаглалын зарчим (Governance principles)	100.0	100.0	17.3	75.0	48.0
	Хууль, дүрэм журмын хяналт хэрэгжүүлэлт (Regulatory compliance)	80.0	82.3	44.7	54.3	50.0
	Цахим засаглалын бодлого (Government digital policy)	99.4	41.7	12.1	61.2	60.0
	Цахим Засгийн газрын үйлчилгээ (e-Government delivery)	99.9	56.4	81.7	86.0	78.8
	Хүний нөөц (Human capital)	60.7	81.4	43.5	72.1	28.8
	Хиймэл оюун ухааны салбарын боловсронгуй байдал (AI sector maturity)	26.8	67.3	3.3	11.1	1.4
	ХОУ-ын технологийн нэвтрэлт, түгээлтийн түвшин (AI technology diffusion)	57.0	77.7	25.9	45.9	37.7
	Нийтийн шилжилт (Societal transition)	62.1	54.7	36.3	41.4	41.3
	Аюулгүй байдал, хамгаалалт (Safety and security)	66.7	100.0	33.3	33.3	26.3

Эх сурвалж: Government AI Readiness Index 2025

2.3 Дэлхийн холболтын тайлан /Global Connectivity Report 2025/

Global Connectivity Report 2025 нь Олон Улсын Цахилгаан Холбоо (ITU)-с гаргасан дэлхийн холболтын хөгжлийг үнэлсэн хамгийн сүүлийн тайлан юм. Энэ нь интернэт холболт, цахим хүртээмж, чанар, боломжийн байдал, ур чадвар, аюулгүй байдал, хэрэглэгчийн төхөөрөмж зэрэг олон талаас нь дэлхий даяар цахим холболтын байдлыг 164 улсын харьцуулалттайгаар гүнзгий судалсан томоохон тайлан юм. Тус тайланд дурдсанаар Монгол Улс мэдээлэл харилцаа холбооны технологийн хөгжлийн үзүүлэлтээр судлагдсан нийт орнуудаас харьцангуй өндөр буюу 100-аас 88.4 оноо, хүртээмжтэй байдлын үзүүлэлтээр 84.5, хурд, чанар, бодит хэрэглээ талаас 92.2 оноог тус тус авчээ. Үндсэн үзүүлэлтийг дүгнэсэн дэлгэрэнгүй харьцуулалтыг доорх /хүснэгт 5/ үзүүлэлтээс харж болно.

Хүснэгт 5. Global Connectivity Report /Үндсэн үзүүлэлт 0-100 оноогоор үнэлдэг/

/0-мүү 100-сайн/

	ЭСТОНИ	ХЯТАД	КИРГИСТАН	КАЗАХСТАН	МОНГОЛ
ICT Development Index (IDI) Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжлийн индекс	98.5	91.2	85.9	90.5	88.4
Universal Connectivity Pillar - Улс орны нийт хүн ам, бүс нутагт интернэт болон мэдээлэл харилцаа холбооны технологийн дэд бүтцийг хүртээмжийг үнэлнэ.	98.7	89.6	79.8	86.3	84.5
Meaningful Connectivity Pillar - Дэд бүтцээс гадна интернэт болон мэдээлэл харилцаа холбооны технологийн хурд, чанар, найдвартай байдал, үнэ, бодит хэрэглээг хангаж байгаа эсэхийг үнэлнэ.	98.3	92.8	92.0	94.7	92.2

Эх сурвалж: Global Connectivity Report 2025

Хүснэгт 6. Global Connectivity Report /Дэд үзүүлэлт 0-100 оноогоор үнэлдэг/

/0-мүү 100-сайн/

Улс	ЭСТОНИ	ХЯТАД	КИРГИСТАН	КАЗАХСТАН	МОНГОЛ
Интернэт хэрэглэгчдийн эзлэх хувь	98.1	95.4	93.1	97.8	87.4
Гэрийн интернэт холболттой өрхийн эзлэх хувь	98.1	87.9	84.9	100.0	86.1
Идэвхтэй үүрэн холбооны хэрэглэгч (100 хүнд ногдох)	100.0	85.5	61.4	61.1	80.1
4G/LTE үүрэн сүлжээний хүн амын эзлэх хувь	99.4	100.0	99.4	92.6	99.4
Үүрэн холбооны нэг хэрэглэгчийн дундаж DATA хэрэглээ	93.4	81.2	91.4	92.5	81.8
Суурин интернэтийн нэг хэрэглэгчийн дундаж DATA хэрэглээ	n.p.	86.8	81.7	87.5	83.1
Үүрэн холбооны багцын үнэ (ДНБ/хүнд ногдох орлогын %)	100.0	100.0	94.6	98.4	97.3
Суурин интернэтийн багцын үнэ (ДНБ/хүнд ногдох орлогын %)	100.0	100.0	88.3	99.8	93.6
Гар утас эзэмшдэг хүмүүс	100.0	88.9	96.8	97.7	97.9

Эх сурвалж: Global Connectivity Report 2025

2.4 Сүлжээний бэлэн байдлын индекс /Network Readiness Index 2024/

Network Readiness Index (NRI) нь улс орнуудын дижитал бэлтгэлбайдал, мэдээлэл, харилцаа холбооны технологийн (ICT) нэвтрэлт, ашиглалт, мөн тэдгээрийн нийгэм, эдийн засагт үзүүлж буй нөлөөг хэмждэг жил бүрийн дэлхийн хэмжээний индекс юм. Энэхүү индексийг Portulans Institute болон University of Oxford-ийн Saïd Business School хамтран боловсруулан нийтэлдэг. 4 үндсэн үзүүлэлтэд тулгуурлан 54 дэд үзүүлэлтээр 133 улс орнуудын дунд харьцуулан эрэмбэлдэг индекс юм.

Хүснэгт 7. Network Readiness Index /Дөрвөн үндсэн тулгуур үзүүлэлт Rank-133 орон/

/1-сайн 133-мүү/

улс	КАЗАХСТАН	ЭСТОНИ	ХЯТАД	КИРГИСТАН	МОНГОЛ
Сүлжээний бэлэн байдлын индекс	61	18	17	86	88
Технологи - Улс орны цахим сүлжээ, технологийн бэлэн байдал	81	32	12	97	88
Хүмүүн капитал - Иргэд, бизнес, төрийн байгууллагын цахим ур чадвар	53	13	6	80	96
Засаглал - Цахим шилжилтийн бодлого зохицуулалтын орчин	53	5	36	89	63
Нийгэм, эдийн засгийн нөлөөлөл - Эдийн засаг, инноваци, олон улсын өрсөлдөх чадвар	66	21	19	55	109

Эх сурвалж: Network Readiness Index 2024

Энэхүү судалгааны хамгийн сүүлийн тайланд дурдсанаар Монгол Улс технологийн бэлэн байдал, хүний капиталын үзүүлэлтээр 133 орноос 88 дугаар байр, цахим шилжилтийн бодлого зохицуулалт буюу засаглалын үзүүлэлтээр 63, харин нийгэм, эдийн засгийн нөлөөллөөр хангалтгүй буюу 109-т жагсаж байна. Судалгаанд харьцуулсан төв азийн болон хөгжиж буй, орлогын түвшин ойролцоо орнуудтай харьцуулахад эдийн засгийн нөлөөлөл инноваци, өрсөлдөх чадвар сул байгааг сайжруулах шаардлага байна.

Орлогын бүлэг болон бүс нутгийн хүрээнд үзүүлж буй гүйцэтгэл

Монгол Улс нь дээд дунд орлоготой орнуудын бүлэгт хамаардаг. Тус бүлгийн хамгийн өндөр гүйцэтгэлтэй улс нь БНХАУ, харин Ази, Номхон далайн бүсийн тэргүүлэгч улс нь Сингапур юм.

Хүснэгт 8. Network Readiness Index /Орлогын бүлэг болон бүс нутгийн дундажтай харьцуулалт/

/0-мүү 100-сайн/

улс	КАЗАХСТАН	ЭСТОНИ	ХЯТАД	КИРГИСТАН	МОНГОЛ	Өндөр орлоготой улс	Дээд-дунд орлоготой улс	Бага орлоготой улс	Европ	Ази, Номхон далайн бүс	Тусгай улсуудын хамтын нөхөрлөл
NRI 2024	50.5	67.9	68.7	44.2	43.9	62.5	47.5	39.7	60.8	54.3	48.5
Технологи	38.3	53.6	65.3	31.5	35.8	55.8	39.5	32.7	53.5	49.3	40.9
Хүмүүн капитал	44.6	60.4	66.3	39.0	35.8	51.8	41.7	34.1	49.5	48.6	42.3
Засаглал	65.1	88.3	73.8	49.7	59.7	76.6	56.7	44.1	75.8	60.9	55.7
Нийгэм, эдийн засгийн нөлөөлөл	54.2	69.1	69.3	56.4	44.3	65.7	52.2	47.5	64.6	58.3	55.0

Эх сурвалж: Network Readiness Index 2024

Хүснэгт 9. Network Readiness Index /дэлгэрэнгүй тайлбар Rank-133 орон/

/1-сэйн 133-мүү/

УЛС	КАЗАХСТАН	ЭСТОНИ	ХЯТАД	КИРГИСТАН	МОНГОЛ
A. Технологийн түлгүүр	81	32	12	97	88
1-р дэд түлгүүр: Хандалт	56	37	1	89	73
1.1.1 Гар утасны тариф	17	40	38	96	47
1.1.2 Гар утасны үнэ	62	15	40	99	111
1.1.3 Өндөр хурдны интернэт холбогдсон барилгын хамрагдалт	41	95	1	39	56
1.1.4 3G сүлжээгээр хамрагдсан хүн ам	87	1	29	52	1
1.1.5 Олон улсын интернэт зурвасын өргөн	30	112	3	65	91
1.1.6 Сургууль дахь интернэтийн хамрагдалт	n/a	1	40	67	54
2-р дэд түлгүүр: Контент	85	21	16	90	100
1.2.1 GitHub-д оруулсан хувь нэмэр	70	10	n/a	61	68
1.2.2 Интернэт домэйн бүртгэл	77	26	63	104	82
1.2.3 Гар утасны хөгжүүлэлт	66	6	n/a	70	92
1.2.4 Хиймэл оюун ухаантай холбоотой шинжлэх ухааны нийтлэл	72	92	1	96	103
3-р дэд түлгүүр: Ирээдүйн технологи	100	56	26	115	95
1.3.1 Шинэ технологи нэвтрүүлэлт	91	30	n/a	97	95
1.3.2 Шинэ технологид оруулах хөрөнгө оруулалт	73	35	33	119	89
1.3.3 Роботын нягтрал	n/a	36	3	n/a	n/a
1.3.4 Компьютерийн программ хангамжийн зардал	125	92	29	106	86
B. Хүмүүсийн түлгүүр	53	13	6	80	96
1-р дэд түлгүүр: Иргэд	34	35	6	58	52
2.1.1 Дотоодын үүрэн холбооны интернэтийн урсгал	27	70	1	49	79
2.1.2 Боловсролын систем дэх мэдээлэл, харилцаа холбооны технологийн үр чадвар	109	35	n/a	85	101
2.1.3 Виртуал нийгмийн сүлжээний хэрэглээ	49	23	36	96	47
2.1.4 Насанд хүрэгчдийн бичиг үсгийн түвшин	6	5	42	11	18
2.1.5 Хиймэл оюун ухааны чадварлаг хүний нөөцийн нягтрал	n/a	14	8	n/a	n/a
2-р дэд түлгүүр: Бизнес	99	20	9	57	109
2.2.1 Вэбсайттай компаниуд	75	31	52	47	103
2.2.2 Хиймэл оюун ухаанд чиглэсэн венчур хөрөнгө оруулалтын тоо	68	1	24	n/a	n/a
2.2.3 Харилцаа холбооны үйлчилгээний жилийн хөрөнгө оруулалт	83	95	2	88	98
2.2.4 Үүлэн тооцооллын зах зээлийн хэмжээ	50	87	2	112	96
3-р дэд түлгүүр: Засгийн газар	36	10	22	96	93
2.3.1 Төрийн цахим үйлчилгээ	8	1	15	80	78
2.3.2 Өгөгдөл боловсруулах чадвар	25	1	26	75	67
2.3.3 Шинэ технологийг төрөөс дэмжих бодлого	41	47	n/a	51	61
2.3.4 Төрөөс дэмжих дээд боловсролын судалгаа ба хөгжүүлэлтийн зардал	101	22	14	106	99

C. Засаглалын түлгүүр	53	5	36	89	63
1-р дэд түлгүүр: Итгэлцэл	47	8	23	97	61
3.1.1 Аюулгүй интернэт сервер	52	8	65	77	60
3.1.2 Кибер аюулгүй байдал	38	2	40	96	111
3.1.3 Санхүүгийн онлайн дансанд нэвтрэх	34	7	17	90	20
3.1.4 Интернэт худалдаа	49	15	3	88	44
2-р дэд түлгүүр: Зохицуулалт	106	9	88	111	96
3.2.1 Зохицуулалтын чанар	71	14	93	105	86
3.2.2 Мэдээлэл, харилцаа холбооны технологи зохицуулалтын орчин	129	31	119	106	77
3.2.3 Шинэ технологийн зохицуулалт	72	11	7	91	88
3.2.4 Цахим худалдааны хууль	1	1	1	87	87
3.2.5 Хувийн мэдээлэл хамгаалах хууль	119	24	123	89	82
3-р дэд түлгүүр: Хүртээмж	39	3	19	58	54
3.3.1 Цахим оролцоо / иргэд цахимар дамжуулан төрийн шийдвэр гаргалт, бодлого, нийтийн үйлчилгээнд идэвхтэй оролцож буй түвшинг илэрхийлдэг	5	3	3	78	57
3.3.2 Цахим төлбөрийн хэрэглээний нийгэм эдийн засгийн зөрүү	9	13	51	29	6
3.3.3 Дотоодын цахим контентын хүртээмж / иргэд өөрийн хэл дээр, өөрийн хэрэгцээнд нийцсэн, найдвартай цахим мэдээлэл, үйлчилгээг саадгүй авах боломж	71	20	3	98	97
3.3.4 Интернэт хэрэглээний явдгийн ялгаа	70	13	47	n/a	72
3.3.5 Цахим төлбөрийн хэрэглээний хот, хөдөөгийн зөрүү	58	14	63	40	32
D. Нөлөөллийн түлгүүр	66	21	19	55	109
1-р дэд түлгүүр: Эдийн засаг	95	25	7	107	120
4.1.1 Мэдээлэл, харилцаа холбооны технологи патентын хэрэглээ	68	29	17	n/a	79
4.1.2 Дотоодын зах зээлийн хэмжээ	40	104	1	114	110
4.1.3 Гиг эдийн засгийн тархалт	76	27	1	93	90
4.1.4 Мэдээлэл, харилцаа холбооны технологи үйлчилгээний экспорт	94	7	52	95	104
2-р дэд түлгүүр: Амьдралын чанар	34	4	58	29	93
4.2.1 Аз жаргал	45	38	55	66	83
4.2.2 Хувь хүний амьдралын сонголтоо чөлөөтэй хийх боломж	27	18	78	5	111
4.2.3 Орлогын тэгш бус байдал	7	31	63	8	27
4.2.4 Төрөх үеийн эрүүл амьдралын дундаж наслалт	86	36	3	76	89
3-р дэд түлгүүр: Тогтвортой хөгжлийн зорилт (SDG)	90	16	47	59	100
4.3.1 SDG 3 - Эрүүл мэнд	37	41	34	80	90
4.3.2 SDG 4 - Чанартай боловсрол	52	6	1	n/a	54
4.3.3 SDG 5 - Эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоо ба боломж	101	5	96	98	41
4.3.4 SDG 7 - Хямд өртөгтэй, цэвэр эрчим хүч	103	64	106	95	114
4.3.5 SDG 11 - Тогтвортой хот, суурин газар	56	35	119	70	101

Эх сурвалж: Network Readiness Index 2024

2.5 Дэлхийн инновацийн индекс /Global Innovation Index (GII) 2025/

Global Innovation Index-GII 2025 нь дэлхийн инновацийн чадавх, бүтээлч байдал, шинэлэг технологи, эрдэм шинжилгээ, бодлого болон эдийн засгийн чадамжийг дэлхий даяар харьцуулан үнэлдэг олон улсын боловсрол, судалгааны бодлого боловсруулах чухал тайлан юм. Энэ индексийг Дэлхийн Зохиогчийн Эрхийн Байгууллага WIPO-World Intellectual Property Organization гаргадаг бөгөөд 139 орны эдийн засгийн үндсэн 8 үзүүлэлт болон 106 дэд үзүүлэлтээр задлан үнэлдэг.

Хүснэгт 10. Global Innovation Index /Үндсэн үзүүлэлт Rank-139 орон/

/1-сайн 139-муу/

УЛС	ЭСТОНИ	ХЯТАД	КИРГИСТАН	КАЗАХСТАН	МОНГОЛ
Инновацийн индекс	16	10	96	81	78
Институци	18	44	119	77	98
Хүний капитал ба судалгаа	36	20	58	68	87
Дэд бүтэц	10	6	89	64	70
Зах зээлийн боловсронгуй байдал	7	13	82	93	95
Бизнесийн боловсронгуй байдал	26	8	117	82	84
Мэдлэг ба технологийн үр дүн	19	1	103	87	93
Бүтээлч үр дүн	12	14	89	82	54

Эх сурвалж: Global Innovation Index

Хүснэгт 11. Global Innovation Index /Дэд үзүүлэлт Rank-139 орон/

/1-сайн 139-муу/

УЛС	КАЗАХСТАН	ЭСТОНИ	ХЯТАД	КИРГИСТАН	МОНГОЛ
Институци (Institutions)	18	44	119	77	98
1.1 Институцийн орчин (Institutional Environment)	19	44	127	75	87
1.1.1 Бизнесийн үйл ажиллагааны тогтвортой байдал	12	47	127	79	73
1.1.2 Засгийн газрын үр нөлөө	20	43	122	64	99
1.2 Зохицуулалтын орчин	19	80	123	81	78
1.2.1 Зохицуулалтын чанар	17	94	107	73	84
1.2.2 Хуулийн дэглэм	17	64	130	92	81
1.3 Бизнесийн орчин	39	16	91	69	115
1.3.1 Бизнес эрхлэх бодлогын тогтвортой байдал	72	17	97	83	118
1.3.2 Бизнес эрхлэх үйл ажиллагааны бодлого ба соёл	11	13	n/a	30	n/a
Хүний капитал ба судалгаа (Human Capital and Research)	36	20	58	68	87
2.1 Боловсрол	21	4	15	68	67
2.1.1 Боловсролын зардал, ДНБ-д эзлэх (%)	19	76	5	43	89
2.1.2 Нэг сурагчид ногдох төрийн санхүүжилт (дүнд боловсрол), ДНБ-д эзлэх (%)	49	n/a	n/a	40	n/a
2.1.3 Сургуульд хамрагдах дундаж хугацаа, жил	44	n/a	93	73	76

2.1.4	PISA үнэлгээ (унших, математик, шинжлэх ухаан)	6	1	n/a	54	56
2.1.5	Сурагч багшийн харьцаа (дүнд боловсрол)	19	64	63	32	37
2.2	Дээд боловсрол (Tertiary Education)	29	90	49	67	85
2.2.1	Дээд боловсролын хамрагдалт, нийт (%)	47	38	70	68	48
2.2.2	Шинжлэх ухаан, инженерийн чиглэлийн төгсөгчид, (%)	32	n/a	97	51	95
2.2.3	Дээд боловсролын гадаад оюутны урсгал, (%)	23	107	11	48	73
2.3	Судалгаа хөгжил (R&D)	45	16	114	59	96
2.3.1	Судалгааны ажилтнууд, сая хүнд ногдох бүтэн цагийн ажилтан	24	42	n/a	65	72
2.3.2	Судалгаа, хөгжүүлэлтэд зарцуулсан нийт зардал / ДНБ-д эзлэх (%)	20	14	108	95	105
2.3.3	Дэлхийн корпорацийн судалгаа хөгжлийн хөрөнгө оруулалт, топ3/ сая ам.\$	44	3	44	44	44
2.3.4	QS их сургуулийн эрэмбэ, (top 3)	56	4	80	36	80
Дэд бүтэц (Infrastructure)		10	6	89	64	70
3.1	Мэдээлэл, харилцаа холбооны технологи (МХХТ)	1	25	82	27	54
3.1.1	МХХТ хандалт	24	57	75	53	73
3.1.2	МХХТ хэрэглээ	2	28	70	42	45
3.1.3	Төрийн цахим үйлчилгээ	3	11	87	10	41
3.2	Ерөнхий дэд бүтэц	34	7	123	69	59
3.2.1	Цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл, ГВт.ц / 1 сая хүн	55	30	81	39	77
3.2.2	Логистикийн гүйцэтгэл	25	18	107	76	90
3.2.3	Нийт үндсэн хөрөнгийн хуримтлал, ДНБ-д эзлэх (%)	34	2	93	35	9
3.3	Экологийн тогтвортой байдал (Ecological Sustainability)	21	22	56	127	121
3.3.1	Эрчим хүчний нэгж тутамд ногдох ДНБ	59	102	103	99	110
3.3.2	Нүүрстөрөгч багатай эрчим хүчний хэрэглээ (%)	83	70	14	113	120
3.3.3	ISO 14001 байгаль орчны менежментийн тогтолцоо/ ДНБ (PPP\$, тэрбум)	5	3	138	111	60
Зах зээлийн боловсронгуй байдал (Market Sophistication)		7	13	82	93	95
4.1	Зээл (Credit)	31	27	95	96	51
4.1.1	Стартап болон тэлж буй аж ахуйн нэгжүүдийн санхүүжилт	17	22	n/a	62	n/a
4.1.2	Хувийн хэвшилд олгосон дотоодын зээл, ДНБ-д эзлэх (%)	55	3	116	105	79
4.1.3	Бичил санхүүгийн байгууллагуудаас олгосон зээл, ДНБ-д эзлэх (%)	8	43	14	30	6
4.2	Хөрөнгө оруулалт (Investment)	2	19	n/a	90	117
4.2.1	Хөрөнгийн биржийн үнэлгээ, ДНБ-д эзлэх хувь (%)	n/a	24	n/a	56	n/a
4.2.2	Венчур капиталгаар авсан хөрөнгө, хэлцлийн тоо/ ДНБ (PPP\$, тэрбум)	1	36	n/a	112	102
4.2.3	Хожуу шатны венчур капиталгаар хийгдсэн хэлцлийн тоо, дэлхийн VC-д эзлэх хувь	38	2	n/a	74	98
4.2.4	Венчур капиталгаар санхүүжүүлсэн хөрөнгө, хэлцлийн тоо / ДНБ (PPP\$, тэрбум)	4	52	n/a	92	102

4.2.5	Венчур капиталын хөрөнгө оруулагчдын хамтарсан оролцоо/ ДНБ (PPP\$, тэрбум)	1	36	n/a	85	104
4.3	Худалдаа, төрөлжилт ба зах зээлийн хэмжээ (Trade, Diversification and Market Scale)	55	2	114	73	107
4.3.1	Жинлэсэн дундаж хэрэглээний тарифын хувь (%)	24	75	89	77	95
4.3.2	Дотоодын аж үйлдвэрийн төрөлжилт	27	5	108	91	102
4.3.3	Дотоодын зах зээлийн хэмжээ/ ДНБ (PPP\$, тэрбум)	109	1	118	38	106
Бизнесийн боловсронгуй байдал (Business Sophistication)		26	8	117	82	84
5.1	Мэдлэгт суурилсан ажиллах хүч (Knowledge Workers)	25	19	106	62	74
5.1.1	Мэдлэг их шаардсан салбар дахь ажил эрхлэлт, (%)	19	n/a	75	n/a	56
5.1.2	Дээд түвшний боловсролтой эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт, (%)	11	n/a	66	n/a	35
5.1.3	Хөдөлмөрийн зах зээлд залуучуудын эзлэх хувь (%)	113	105	36	47	42
5.1.4	Бизнесийн салбарт гүйцэтгэсэн GERD (судалгаа, хөгжүүлэлтийн нийт зардал) / ДНБ-д эзлэх (%)	22	11	76	69	82
5.1.5	Бизнесийн салбараас санхүүжүүлсэн GERD (судалгаа, хөгжүүлэлтийн нийт зардал) / (%)	27	2	77	31	75
5.2	Инновацийн уялдаа холбоо (Innovation Linkages)	43	4	115	95	108
5.2.1	Олон нийтийн судалгаа, аж үйлдвэрийн хамтарсан нийтлэлүүд / нийт нийтлэлд эзлэх (%)	57	4	121	73	62
5.2.2	Их сургууль, аж үйлдвэрийн судалгаа хөгжүүлэлт хамтын ажиллагаа	43	11	108	115	102
5.2.3	Их сургууль, аж үйлдвэр ба олон улсын хамтын ажиллагаа, (top 5)	46	19	n/a	51	88
5.2.4	Кластер хөгжлийн байдал	55	2	96	112	115
5.2.5	Патентийн гэр бүл/ ДНБ (PPP\$, тэрбум)	31	22	100	83	100
5.3	Мэдлэг шингээлт (Knowledge Absorption)	10	21	84	80	59
5.3.1	Оюуны өмчийн төлбөр, нийт худалдаанд эзлэх (%)	92	25	107	76	90
5.3.2	Өндөр технологийн импорт, нийт худалдаанд эзлэх (%)	63	11	26	46	104
5.3.3	МХХТ-ийн үйлчилгээний импорт, нийт худалдаанд эзлэх (%)	3	83	106	90	86
5.3.4	Гадаадын шууд хөрөнгө оруулалтын цэвэр орлого, ДНБ-д эзлэх (%)	7	110	85	82	6
5.3.5	Судалгааны боловсон хүчин, бизнесийн салбарт эзлэх (%)	31	16	n/a	n/a	n/a
Мэдлэг ба технологийн үр дүн (Knowledge and Technology Outputs)		19	1	103	87	93
6.1	Мэдлэг бүтээлт (Knowledge Creation)	33	1	87	67	60
6.1.1	Үүсэл гаралтай патент/ ДНБ (PPP\$, тэрбум)	36	2	37	55	47
6.1.2	РСТ патент (зохион бүтээгчийн гарал үүсэл) / ДНБ (PPP\$, тэрбум)	29	13	82	79	109

6.1.3	Ашигтай загвар (utility model), гарал үүслээр/ ДНБ (PPP\$, тэрбум)	27	1	35	8	12
6.1.4	Шинжлэх ухаан, техникийн өгүүлэл/ ДНБ (PPP\$, тэрбум)	12	32	109	119	67
6.1.5	Ишлэлтэй баримт бичгийн H-индекс	49	8	120	93	106
6.2	Мэдлэгийн нөлөө (Knowledge Impact)	16	3	120	100	110
6.2.1	Хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт, %	119	2	42	40	36
6.2.2	Юникорн компанийн үнэлгээ, ДНБ-д эзлэх (%)	1	13	-	-	-
6.2.3	Программ хангамжийн зардал, ДНБ-д эзлэх (%)	88	33	106	136	93
6.2.4	Өндөр технологийн үйлдвэрлэл, %	48	11	110	73	104
6.3	Мэдлэгийн түгээлт (Knowledge Diffusion)	17	9	91	84	119
6.3.1	Оюуны өмчийн орлого, нийт худалдаанд эзлэх (%)	25	34	85	101	107
6.3.2	Үйлдвэрлэл ба экспортын төгөвшил	29	17	60	83	125
6.3.3	Өндөр технологийн экспорт, нийт худалдаанд эзлэх (%)	33	5	60	36	97
6.3.4	МХХТ-ийн үйлчилгээний экспорт, нийт худалдаанд эзлэх (%)	6	50	105	90	114
6.3.5	ISO 9001 чанарын менежментийн тогтолцоо/ ДНБ (PPP\$, тэрбум)	15	6	136	125	42
Бүтээлч үр дүн (Creative Outputs)		12	14	89	82	54
7.1	Биет бус хөрөнгө (Intangible Assets)	37	1	118	84	23
7.1.1	Биет бус хөрөнгийн эрчимжилт (top 15)	49	29	n/a	69	n/a
7.1.2	Барааны тэмдэг, гарал үүслээр/ ДНБ (PPP\$, тэрбум)	20	1	87	62	3
7.1.3	Дэлхийн брэндийн үнэ цэнэ (top 5,000), ДНБ-д эзлэх (%)	55	18	81	68	81
7.1.4	Аж үйлдвэрийн загвар, гарал үүслээр/ ДНБ (PPP\$, тэрбум)	27	1	103	106	8
7.2	Бүтээлч бараа ба үйлчилгээ (Creative Goods and Services)	1	26	31	61	114
7.2.1	Соёлын болон бүтээлч үйлчилгээний экспорт, нийт худалдаанд эзлэх (%)	8	49	42	61	84
7.2.2	Үндэсний уран сайхны кино / 15-69 насны хүн амд ногдох (сая хүн)	1	76	6	29	n/a
7.2.3	Үзвэр, энтертейнмент ба медиа зах зээл/15-69 насны хүн амд ногдох (сая хүн)	n/a	34	n/a	69	n/a
7.2.4	Бүтээлч барааны экспорт, нийт худалдаанд эзлэх (%)	38	1	65	66	124
7.3	Онлайн бүтээлч байдал (Online Creativity)	17	131	84	74	92
7.3.1	Дээд түвшний домэйн (TLD)/15-69 насны хүн амд ногдох (сая хүн)	25	64	108	79	86
7.3.2	GitHub-ийн commit/15-69 насны хүн амд ногдох (сая хүн)	11	n/a	73	76	69
7.3.3	Мобайл аппликейшн бүтээлт/ ДНБ (PPP \$, тэрбум)	6	n/a	73	70	95

2.6 Олон улсын кибер аюулгүй байдлын индекс / Global Cybersecurity Index 2024/

Global Cybersecurity Index (GCI) 2024 бол Нэгдсэн Үндэстний Байгууллагын Олон Улсын Харилцаа Холбооны Байгууллага (ITU)-аас гаргасан цахим аюулгүй байдлын хандлагыг, улс орнуудын түвшинг хэмжсэн дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн индекс юм. Энэ нь улс төр, бизнес, иргэдийн цахим орчныг хамгаалах чадвар, бодлого үйл ажиллагааны түвшинийг 194 улс орон хамруулан үнэлдэг.

- **Үндэсний бодлого, хөтөлбөрүүдийг үнэлнэ:** Улс орон цахим аюулгүй байдалд хэр их анхаарал хандуулж байгааг хэмждэг.
- **Олон улсын харьцуулалт:** Гурван жил тутамд шинэчлэгдсэн байдлаар гарч бусад улс орнуудын туршлагаас суралцах боломж олгоно.
- **Тогтвортой хөгжлийн зорилтууд (SDG)-тай холбоотой:** Цахим хүртээмж, аюулгүй байдал, төрийн үйлчилгээний найдвартай байдал зэрэг олон салшгүй асуудлуудыг уялдуулна

Global Cybersecurity Index-ийн үнэлгээ

GCI 2024 нь улс орнуудын цахим аюулгүй байдлын бэлэн байдал, бодлого хэрэгжилтийн түвшинг ерөнхий оноогоор нь 5 шатлалтай (Tier) ангилж үнэлдэг. Энэ нь “хэн сайн, муу” гэдгийг бус ямар хөгжлийн шатанд явж байгааг харуулах зорилготой.

- 1. Tier 1 – Role Modelling** /Оноо:95–100/ - Цахим аюулгүй байдлын тогтолцоо бүрэн төлөвшсөн, дэлхийд үлгэрлэх түвшин
- 2. Tier 2 – Advancing** /Оноо:85–95/ - Манлайлагч түвшинд ойртож буй, бодит ахицтай
- 3. Tier 3 – Establishing** /Оноо:55–85/ - Цахим аюулгүй байдлын систем бүрэлдэж байгаа шат
- 4. Tier 4 – Evolving** /Оноо:20–55/ - Цахим аюулгүй байдлыг хөгжүүлэх шаардлага ихтэй шат
- 5. Tier 5–Building** /Оноо:0–20/ - Цахим аюулгүй байдлын суурийг шинээр тавьж буй шат

Хүснэгт 10. Хүснэгт 12 Global Cybersecurity Index

/1-сайн 139-муу/

TIER	ОНОО		
Tier 1 – Role Modelling	95–100	Эстони	
Tier 2 – Advancing	85–95	Хятад	Казахстан
Tier 3 – Establishing	55–85	Монгол	Киргистан
Tier 4 – Evolving	20–55		
Tier 5 – Building	0–20		

Эх сурвалж: Global Cybersecurity Index

Global Cybersecurity Index улс орны үнэлгээний оноо

1. Legal Measures – Хууль, эрх зүйн орчин

Кибер аюулгүй байдлын хууль, журам, Кибер гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зохицуулалт, Хувийн мэдээлэл хамгаалах хууль байгаа эсэхээр хэмждэг. Өндөр оноо авна гэдэг нь хууль тогтоомж бүрэн, шинэчлэгдсэн, хэрэгжилт бодитой байгааг харуулна.

2. Technical Measures – Техникийн чадавх

Үндэсний CERT (Computer Emergency Response Team)/ CSIRT (Computer Security Incident Response Team) -ийн үйл ажиллагаа, Кибер халдлагад хариу арга хэмжээ авах техник, Кибер эрсдэлийн мониторинг, хамгаалалтын систем байгаа эсэхээр хэмждэг. Өндөр оноо авна гэдэг нь кибер халдлагыг илрүүлэх, сэргийлэх, шуурхай хариулах чадвартай байгааг илтгэнэ.

3. Organizational Measures – Байгууллагын зохион байгуулалт

Үндэсний кибер аюулгүй байдлын стратеги, Хариуцсан төрийн байгууллага, зохицуулалтын бүтэц, Салбар хоорондын уялдаа байгаа эсэхээр хэмждэг. Өндөр оноо авна гэдэг нь төрийн түвшинд удирдлага, зохион байгуулалт тодорхой, тогтвортой байгааг харуулна.

4. Capacity Development – Чадавх, хүний нөөц

Кибер аюулгүй байдлын мэргэжилтэн бэлтгэх тогтолцоо, Сургалт, судалгаа, R&D, Олон нийтийн мэдлэг, ойлголт өндөр байгаа эсэхээр хэмждэг. Өндөр оноо авна гэдэг нь хүний нөөц хангалттай, мэдлэгт суурилсан хөгжил тогтвортой гэсэн үг юм.

5. Cooperation Measures – Хамтын ажиллагаа

Олон улсын кибер аюулгүй байдлын хамтын ажиллагаа, Төр хувийн хэвшил олон улсын байгууллагын уялдаа, Мэдээлэл солилцох механизм байгаа эсэхээр хэмждэг. Өндөр оноо авна гэдэг нь дотоод болон гадаад хамтын ажиллагаа идэвхтэй, нээлттэй гэдгийг илтгэнэ.

Хүснэгт 13. Global Cybersecurity Index /улс орны үнэлгээний оноо 0-20 оноогоор үнэлдэг/

	ЭСТОНИ	ХЯТАД	КИРГИСТАН	КАЗАХСТАН	МОНГОЛ
Хууль, эрх зүйн орчин	20	20	16.71	20	19.18
Техникийн чадавх	15.3	17.14	14.87	19.38	6.64
Байгууллагын зохион байгуулалт	20	18.34	16.32	18.3	13.62
Чадавх, хүний нөөц	19.74	18.46	5.53	16.36	10.43
Хамтын ажиллагаа	20	17.7	12.16	20	6.49

Эх сурвалж: Global Cybersecurity Index

3. Цахим шилжилт ба хиймэл оюун ухааны хэмжих шалгуур үзүүлэлтүүд

Цахим шилжилт болон хиймэл оюун ухааны өнөөгийн нөхцөл байдлыг бодитоор үнэлэх, олон улсын түвшинд харьцуулах зорилгоор олон улсын тайлан, индексүүдийн аргачлалд тулгуурласан хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулж, тэдгээрийг цахим шилжилтийн есөн тулгуур баганын үндсэн зорилготой уялдуулан нэгтгэн боловсруулсан.

Цахим шилжилтийн есөн тулгуур багана нь цахим дэд бүтэц, интернэтийн хүртээмж, хиймэл оюун ухааны ашиглалт, институцийн орчин, хүний капитал, цахим ур чадвар, цахим үйлчилгээ, стартап болон инновацийн экосистем зэрэг үндсэн чиглэлүүдийг хамарч, засаглалын шинэчлэлийг хэмжих, үнэлэх, өнөөгийн бодит байр суурийг тодорхойлох нэгдсэн суурь тогтолцоо болж байна.

Эдгээр тулгуур багана нь цахим шилжилтийн ахиц дэвшлийг тогтмол үнэлэх, бодлогын давуу болон сул талыг илрүүлэх, улмаар шийдвэр гаргалтыг өгөгдөлд суурилан сайжруулах боломжийг бүрдүүлнэ. Ингэснээр цахим хөрөнгө оруулалт нь төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, ил тод байдал, институцийн үр ашиг, иргэдийн итгэлцлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодит үр дүнтэй стратегийн суурь болох нөхцөлийг бүрдүүлнэ.

Уг тулгуур баганад суурилсан үзүүлэлтүүдийг олон улсын индексүүдтэй харьцуулан шинжилснээр Монгол Улсын цахим шилжилтийн явц, түвшин, олон улсын харьцангуй байр суурийг тодорхойлох боломж бүрдэнэ.

3.1 Цахим дэд бүтэц ба интернэт холболт

Энэхүү үнэлгээний үндсэн зорилго нь суурь дэд бүтэц болон цахим хэрэглээг өргөн хүрээнд нэвтрүүлсэн эсэхийг тодорхойлоход оршино.

Шалгуур үзүүлэлтүүд нь ‘Global Connectivity Report’-ын үзүүлэлтүүдийг агуулсан бөгөөд 0 нь хамгийн доод, 100 нь хамгийн дээд үзүүлэлт болно.

Монгол Улс мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжлийн индексээр дэлхийн улсуудтай харьцуулахад харьцангуй дээгүүр буюу 100 онооноос 88.4 оноогоор

жагсаж байна. Интернэт дэд бүтцийн хүртээмж, хурд, найдвартай холболт, хэрэглэгчдийн эзлэх хувь хэмжээ зэрэг голлох үзүүлэлтээр 80-92 оноо буюу төв азийн орнуудтай ижил түвшинд байна.

Хүснэгт 14. Тулгуур багана нэг /Цахим дэд бүтэц ба интернэт холболт/

/0-мүү 20-сэйн/						
ҮЗҮҮЛЭЛТ	ЭСТОНИ	ХЯТАД	КИРГИСТАН	КАЗАХСТАН	МОНГОЛ	INDEX
Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжлийн индекс	98.5	91.2	85.9	90.5	88.4	GCR- /0-100/
Интернэт дэд бүцийн хүртээмж	98.7	89.6	79.8	86.3	84.5	GCR- /0-100/
Интернэтийн хурд болон найдвартай холболт	98.3	92.8	92	94.7	92.2	GCR- /0-100/
Интернэт хэрэглэгчдийн эзлэх хувь	98.1	95.4	93.1	97.8	87.4	GCR- /0-100/
Гэрийн интернэт холболттой өрхийн эзлэх хувь	98.1	87.9	84.9	100	86.1	GCR- /0-100/
Идэвхтэй үүрэн холбооны хэрэглэгч (100 хүнд ногдох)	100	85.5	61.4	61.1	80.1	GCR- /0-100/
4G/LTE үүрэн сүлжээний хүн амын эзлэх хувь	99	100	99	93	99	GCR- /0-100/
Үүрэн холбооны нэг хэрэглэгчийн дундаж DATA хэрэглээ	93.4	81.2	91.4	92.5	81.8	GCR- /0-100/
Суурин интернэтийн нэг хэрэглэгчийн дундаж DATA хэрэглээ	n.p.	86.8	81.7	87.5	83.1	GCR- /0-100/
Үүрэн холбооны багцын үнэ (ДНБ/хүнд ногдох орлогын %)	100	100	94.6	98.4	97.3	GCR- /0-100/
Суурин интернэтийн багцын үнэ (ДНБ/хүнд ногдох орлогын %)	100	100	88.3	99.8	93.6	GCR- /0-100/
Гар утас эзэмшдэг хүмүүс	100	88.9	96.8	97.7	97.9	GCR- /0-100/

Global Cybersecurity In GCR- Global Connectivity Report 2025 dex

3.2 Хиймэл оюун ухаан ба цахим засаглал

Энэхүү үнэлгээний үндсэн зорилго нь цахим засаглалд хиймэл оюун ухаанд суурилсан бүтээмж болон ашиглалтын түвшинг тодорхойлоход оршино.

Шалгуур үзүүлэлтүүд нь “Government AI Readiness Index /GARI/, IMD World Digital Competitiveness Ranking /

WDCR/, Network Readiness Index /NRI/” үзүүлэлтүүдийг агуулсан. GARI үнэлгээгээр 100 нь хамгийн дээд, 0 нь хамгийн доод үзүүлэлт болно. IMD WDCR үнэлгээгээр 1 нь хамгийн дээд, 69 нь хамгийн доод үзүүлэлт болно, NRI үнэлгээгээр 1 нь хамгийн дээд, 133 нь хамгийн доод үзүүлэлт болно.

Хүснэгт 15. Тулгуур багана хоёр /Хиймэл оюун ухаан ба цахим засаглал/

ҮЗҮҮЛЭЛТ	ЭСТОНИ	ХЯТАД	КИРГИСТАН	КАЗАХСТАН	МОНГОЛ	INDEX
Үндэсний ХОУ стратеги байгаа эсэх	Байгаа	Байгаа	Байхгүй	Байгаа	Байхгүй	
Policy Capacity - Засгийн газрын хиймэл оюуны тухай стратеги, бодлого боловсруулах чадвар.	96.0	92.5	16.0	88.0	35.0	GCR- /0-100/
AI Infrastructure - Техник, өгөгдөл, тооцоолох дэд бүтэц	54.3	78.4	43.9	53.9	44.4	GCR- /0-100/
Governance - Засгийн газар нь AI-ийг хариуцлагатай, аюулгүй, ил тод хэрэглэж чаддаг эсэхийг харуулна.	90.0	91.1	31.0	64.6	49.0	GCR- /0-100/
Public Sector Adoption - Засгийн газрын AI-ийг бодит үйл ажиллагаанд нэвтрүүлэх чадвар	99.6	49	46.9	73.6	69.4	GCR- /0-100/
Development & Diffusion - AI-ийн хөгжил, инноваци ба тархалт	46	74.7	22.2	39.9	20.5	GCR- /0-100/
Resilience - AI-тай холбоотой эрсдэлүүдээс хамгаалах, зохицуулах, аюулгүй байдлыг хангах чадварыг хэмждэг.	64.4	77.3	34.8	37.4	33.8	GCR- /0-100/
Хиймэл оюун ухааны бодлогыг хууль болгон баталсан	12	30	-	66	66	IMD WDCR /1-69/
Хиймэл оюун ухаанд хувийн хөрөнгө оруулалт	40	23	-	57	-	IMD WDCR /1-69/
Хиймэл оюун ухааны чадварлаг хүний нөөцийн нягтрал	14	8	n/a	n/a	n/a	NRI /1-133/
Хиймэл оюун ухаанд чиглэсэн венчур хөрөнгө оруулалтын тоо	1	24	n/a	68	n/a	NRI /1-133/

GARI - Government AI Readiness Index

IMD WDCR - IMD World Digital Competitiveness Ranking

NRI - Network Readiness Index

Дэлхий дахинд өөрийн үндэсний хэмжээний хиймэл оюун ухааны стратегия батлаж, даган мөрдөж буй 70 гаруй улс /OECD/ байна. Харин Монгол Улс үндэсний хиймэл оюун ухааны стратегия боловсруулсан ч батлах, дагаж мөрдөж шатны ажлууд дутуу байна. Өөрөөр хэлбэл Засгийн газрын хиймэл оюуны тухай стратеги, бодлого боловсруулах чадвараар сул буюу 35 оноо авч төв азийн орнуудаас 10 нэгж оноогоор дутуу байна.

Мөн Хиймэл оюун ухаанд оруулах хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын хэмжээ, хүний нөөцийн нягтрал, салбарт чиглэсэн томхоон хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын хэмжээг тодорхойлох, тогтоох боломжгүй буюу мэдээлэл дата хомс байгааг дээрх индексээс харж болно.

3.3 Цахим ур чадвар ба хүний капитал

Энэхүү үнэлгээний үндсэн зорилго нь иргэдийн мөн ажиллах хүчний цахим ур чадавхын түвшинг тодорхойлоход оршино.

Шалгуур үзүүлэлтүүд нь “IMD World Digital Competitiveness Ranking /WDCR/, Network Readiness Index /NRI/, Global Innovation Index /GII/ ” үзүүлэлтүүдийг агуулсан. IMD WDCR үнэлгээгээр 1 нь хамгийн дээд, 69 нь хамгийн доод үзүүлэлт болно. NRI үнэлгээгээр 1 нь хамгийн дээд, 133 нь хамгийн доод үзүүлэлт болно. GII үнэлгээгээр 1 нь хамгийн дээд, 139 нь хамгийн доод үзүүлэлт болно.

Хүснэгт 15. Хүснэгт 16 Тулгуур багана гурав /Цахим ур чадвар ба хүний капитал/

ҮЗҮҮЛЭЛТ	ЭСТОНИ	ХЯТАД	КИРГИСТАН	КАЗАХСТАН	МОНГОЛ	INDEX
Хиймэл оюун ухааны чадварлаг хүний нөөцийн нягтрал	20	9	57	-	109	NRI /1-133/
Компьютерийн шинжлэх ухааны боловсролын индекс	32	3	-	58	60	IMD WDCR /1-69/
Боловсролын систем дэх мэдээлэл, харилцаа холбооны технологийн ур чадвар	35	n/a	85	109	101	NRI /1-133/
PISA үнэлгээ (унших, математик, шинжлэх ухаан)	6	1	n/a	54	56	GII /1-139/
Сурагч багшийн харьцаа (дунд боловсрол)	19	64	63	32	37	GII /1-139/
Насанд хүрэгчдийн бичиг үсгийн түвшин	5	42	11	6	18	NRI /1-133/

IMD WDCR - IMD World Digital Competitiveness Ranking

NRI - Network Readiness Index

GII- Global Innovation Index

Компьютерийн шинжлэх ухааны боловсролын индексээр Монгол Улс 69 орноос 60-д эрэмбэлэгдсэн байна. Нийт насанд хүрэгчдийн бичиг үсэг тайлагдалтын түвшинээр 133 орноос 18-д байгаа нь өндөр үзүүлэлт боловч цахим ур чадвар харилцан адилгүй түвшинд байна. 2021 онд хийгдсэн иргэдийн интернэтийн хэрэглээний талаарх суурь судалгаагаар нийт хүн амын 43.3 хувь нь цахим ур чадвартай байна.

Мөн боловсролын систем дэх мэдээлэл, харилцаа холбооны технологийн ур чадвар 133 орноос 101-д байгаа нь боловсролд цахим ур чадвар нэмэгдүүлэх системийг нэвтрүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

3.4 Инновацийн экосистем ба төр хувийн хэвшлийн хамтрал

Энэхүү үнэлгээний үндсэн зорилго нь цахим эдийн засагт инновацийн экосистем болон хиймэл оюун ухаанд суурилсан бүтээмжийн өсөлтийн түвшинг тодорхойлоход оршино. Шалгуур үзүүлэлтүүд нь “Network Readiness Index /NRI/, Global Innovation Index /GII/” үзүүлэлтүүдийг агуулсан. NRI үнэлгээгээр 1 нь хамгийн дээд, 133 нь хамгийн доод үзүүлэлт болно. GII үнэлгээгээр 1 нь хамгийн дээд, 139 нь хамгийн доод үзүүлэлт болно.

Хүснэгт 17. Тулгуур багана дөрөв /Инновацийн экосистем ба төр хувийн хэвшлийн хамтрал/

ҮЗҮҮЛЭЛТ	ЭСТОНИ	ХЯТАД	КИРГИСТАН	КАЗАХСТАН	МОНГОЛ	INDEX
Инновацийн индекс	16	10	96	81	78	GII /1-139/
Дотоодын зах зээлийн хэмжээ/ ДНБ (PPP\$, тэрбум)	109	1	118	38	106	GII /1-139/
Цахим худалдааны нэвтрэлт	15	3	88	49	44	NRI /1-133/
Судалгаа, хөгжүүлэлтэд зарцуулсан нийт зардал / ДНБ-д эзлэх (%)	20	14	108	95	105	GII /1-139/
Нийгэм, эдийн засгийн нөлөөлөл - Эдийн засаг, инноваци, олон улсын өрсөлдөх чадвар	21	19	55	66	109	NRI /1-133/

NRI - Network Readiness Index
GII- Global Innovation Index

Цахим эдийн засагт инновацийн экосистем болон хиймэл оюун ухаанд суурилсан бүтээмжийн өсөлтийг тодорхойлдог “Инновацийн индекс”-ийн үнэлгээгээр Монгол Улс 139 орноос 78-д жагсаж байна. Бүс нутгийн 17 орноос 13-д эрэмбэлэгдэж байна. Харин эдийн засаг, инноваци, олон улсын өрсөлдөх чадварын нийлмэл үнэлгээгээр 133 орноос 109-д жагсаж байна. Дээрх жагсаалтаас харвал цахим индексийн голлох үзүүлэлтээ сайжруулах, ингэхдээ салбарын хөрөнгө оруулалт, хүний нөөцийн чадавхыг бүс нутгийн хэмжээнд хүргэх шаардлага байна.

3.5 Төрийн цахим үйлчилгээ ба цахим аюулгүй байдал

Энэхүү үнэлгээний үндсэн зорилго нь төрийн цахим үйлчилгээний хүртээмж болон кибер аюулгүй байдлын чадавхын түвшинг тодорхойлоход оршино. Шалгуур үзүүлэлтүүд нь “Network Readiness Index /NRI/, Government AI Readiness Index /GARI/, Global Cybersecurity Index /GCI/” үзүүлэлтүүдийг агуулсан. NRI үнэлгээгээр 1 нь хамгийн дээд, 133 нь хамгийн доод үзүүлэлт болно. GARI үнэлгээгээр 100 нь хамгийн дээд, 1 нь хамгийн доод үзүүлэлт болно. GCI үнэлгээгээр 20 нь хамгийн дээд, 0 нь хамгийн доод үзүүлэлт болно.

Хүснэгт 18. Тулгуур багана тав /Төрийн цахим үйлчилгээ ба цахим аюулгүй байдал/

ҮЗҮҮЛЭЛТ	ЭСТОНИ	ХЯТАД	КИРГИСТАН	КАЗАХСТАН	МОНГОЛ	INDEX
Төрийн цахим үйлчилгээ	1	15	80	8	78	NRI /1-133/
Аюулгүй интернэт сервер	8	65	77	52	60	NRI /1-133/
Кибер аюулгүй байдал	2	40	96	38	111	NRI /1-133/
Засгийн газрын кибер аюулгүй байдлын чадавх	1	2	-	35	56	GARI /1-100/
Хууль, эрх зүйн орчин	20	20	16.71	20	19.18	GCI /0-20/
Техникийн чадавх	15.3	17.14	14.87	19.38	6.64	GCI /0-20/
Байгууллагын зохион байгуулалт	20	18.34	16.32	18.3	13.62	GCI /0-20/
Чадавх, хүний нөөц	19.74	18.46	5.53	16.36	10.43	GCI /0-20/
Хамтын ажиллагаа	20	17.7	12.16	20	6.49	GCI /0-20/

NRI - Network Readiness Index
GARI - Government AI Readiness Index
GCI- Global Cybersecurity Index

Төрийн цахим үйлчилгээний үнэлгээгээр 133 орноос 78-д жагсаж байна. Харин кибер аюулгүй байдлын үнэлгээг бусад орнуудтай харьцуулахад сул үзүүлэлттэй бөгөөд ялангуяа техникийн чадавх болон хамтын ажиллагааны үзүүлэлтүүд хамгийн доогуур үнэлгээтэй байна. Үүн дотор шинэ тутам хувьсан өөрчлөгдөж буй кибер аюулгүй байдлын индексийг сайжруулах, батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдлын нэг чухал үзүүлэлт болгох хэрэгцээ бий болжээ.

3.6 Иргэдийн оролцоо

Энэхүү үнэлгээний үндсэн зорилго нь иргэдийн төрийн шийдвэр гаргалт болон бодлого боловсруулах үйл явцад цахим орчноор дамжуулан оролцох оролцооны түвшинг тодорхойлоход оршино. Шалгуур үзүүлэлтүүд нь “Network Readiness Index /NRI/” үзүүлэлтүүдийг агуулсан. NRI үнэлгээгээр 1 нь хамгийн дээд, 133 нь хамгийн доод үзүүлэлт болно.

Хүснэгт 19. Тулгуур багана зургаа /Иргэдийн оролцоо/

ҮЗҮҮЛЭЛТ	ЭСТОНИ	ХЯТАД	КИРГИСТАН	КАЗАХСТАН	МОНГОЛ	INDEX
Төрийн бодлогод иргэдийн цахим оролцоо	3	3	78	5	57	NRI /1-133/
Цахим төлбөрийн хэрэглээний нийгэм эдийн засгийн зөрүү	13	51	29	9	6	NRI /1-133/
Дотоодын цахим контентын хүртээмж /иргэд өөрийн хэл дээр, өөрийн хэрэгцээнд нийцсэн, найдвартай цахим мэдээлэл, үйлчилгээг саадгүй авах боломж	20	3	98	71	97	NRI /1-133/
Интернэт хэрэглээний жендерийн ялгаа	13	47	n/a	70	72	NRI /1-133/
Цахим төлбөрийн хэрэглээний хот, хөдөөгийн зөрүү	14	63	40	58	32	NRI /1-133/

NRI - Network Readiness Index

Иргэд цахим орчноор дамжуулан төрийн шийдвэр гаргалт, бодлого боловсруулах үйл явцад идэвхтэй оролцож буй түвшинээр 133 орноос 57-д жагсаж байна. Бүс нутагтаа төдийгүй дэлхийн бусад орнуудтай харьцуулахад банк санхүүгийн төлбөр тооцооны цахимжилт, дижитал үйлчилгээний хөгжил өндөр буюу 6-г жагсаж байна.

3.7 Технологийн экспорт ба нэмүү өртөг

Энэхүү үнэлгээний үндсэн зорилго нь өндөр технологийн дотоодын үйлдвэрлэл, технологийн экспорт, төрөөс технологи зохицуулалтын орчны дэмжлэгийн түвшинг тодорхойлоход оршино. Шалгуур үзүүлэлтүүд нь “Network Readiness Index /NRI/, Global Innovation Index /GII/” үзүүлэлтүүдийг агуулсан. NRI үнэлгээгээр 1 нь хамгийн дээд, 133 нь хамгийн доод үзүүлэлт болно. GII үнэлгээгээр 1 нь хамгийн дээд, 139 нь хамгийн доод үзүүлэлт болно.

Монгол Улсын хувьд өндөр технологи, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспорт хангалтгүй бөгөөд дотоодоос экспорт хийж буй бараа бүтээгдэхүүний солонгорол нэр төрөл харьцангуй цөөн, энэ төрлийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх шаардлага байгааг дээрх индексээс харж болно. Мөн шинэ технологи, шинэ нээлт, оюуны өмчийн шинэ бүтээгдэхүүний тоо хэмжээ, нэр төрөл нь бүс нутгийн орнуудтай харьцуулахад хангалтгүй байгааг дээрх судалгаа баталж байна.

Хүснэгт 20. Тулгуур багана долоо /Технологийн экспорт ба нэмүү өртөг/

ҮЗҮҮЛЭЛТ	ЭСТОНИ	ХЯТАД	КИРГИСТАН	КАЗАХСТАН	МОНГОЛ	INDEX
Өндөр технологийн экспорт, нийт худалдаанд эзлэх (%)	33	5	60	36	97	GII /1-139/
МХХТ-ийн үйлчилгээний экспорт, нийт худалдаанд эзлэх (%)	6	50	105	90	114	GII /1-139/
Өндөр технологийн үйлдвэрлэл, (%)	48	11	110	73	104	GII /1-139/
Дотоодын аж үйлдвэрийн төрөлжилт	27	5	108	91	102	GII /1-139/
Мэдээлэл, харилцаа холбооны технологи патентын хэрэглээ	29	17	n/a	68	79	NRI /1-133/
Мэдээлэл, харилцаа холбооны технологи зохицуулалтын орчин	31	119	106	129	77	NRI /1-133/
Шинэ технологийн зохицуулалт	11	7	91	72	88	NRI /1-133/
Шинэ технологид төрөөс дэмжлэг үзүүлэх бодлого	47	n/a	51	41	61	NRI /1-133/

GII - Global Innovation Index

NRI - Network Readiness Index

3.8 Өрсөлдөх чадвар ба цахим шилжилт

Энэхүү үнэлгээний үндсэн зорилго нь төрийн цахим шилжилтийн технологийн хөгжил, хөгжлийг дэмжих орчин ба боломжууд болон ирээдүйн цахим шилжилтийн түвшинг тодорхойлоход оршино. Шалгуур үзүүлэлтүүд нь “IMD World Digital Competitiveness Ranking /WDCR/” үзүүлэлтүүдийг агуулсан. IMD WDCR үнэлгээгээр 1 нь хамгийн дээд, 69 нь хамгийн доод үзүүлэлт болно.

Хүснэгт 21. Тулгуур багана найм /Өрсөлдөх чадвар ба цахим шилжилт/

ҮЗҮҮЛЭЛТ	ЭСТОНИ	ХЯТАД	КИРГИСТАН	КАЗАХСТАН	МОНГОЛ	INDEX
Өрсөлдөх чадварын индекс	26	12	-	39	67	IMD WDCR /1-69/
Knowledge - Цахим технологи, шинэ санаа, үр чадвар бий болгох чадвар	27	14	-	34	64	IMD WDCR /1-69/
Technology - Цахим технологийн хөгжлийг дэмжих орчин ба боломж	33	15	-	42	63	IMD WDCR /1-69/
Future readiness - Ирээдүйн цахим шилжилт, технологи хүлээн авах чадвар, хурдтай дасан зохицох чадвар	20	18	-	36	66	IMD WDCR /1-69/

IMD WDCR - IMD World Digital Competitiveness Ranking

Монгол Улс Өрсөлдөх чадварын индексээр 69 орноос 67-д жагсаж байгаа нь дижитал өрсөлдөх чадварын түвшин харьцангуй сул байгааг илтгэж байна. Энэхүү үзүүлэлт нь технологи хөгжүүлэх орчныг сайжруулах, цахим ур чадварыг дээшлүүлэх, ирээдүйн цахим шилжилтийг хүлээн авах чадавхийг бэхжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

3.9 Стартап экосистем ба институци

Энэхүү үнэлгээний үндсэн зорилго нь Монгол Улсын стартап экосистетийн хөгжлийн түвшинг тодорхойлоход оршино. Шалгуур үзүүлэлтүүд нь “Global Innovation Index /GII/” үзүүлэлтүүдийг агуулсан. GII үнэлгээгээр 1 нь хамгийн дээд, 139 нь хамгийн доод үзүүлэлт болно.

Хүснэгт 22. Тулгуур багана ес /Стартап экосистем ба институци/

ҮЗҮҮЛЭЛТ	ЭСТОНИ	ХЯТАД	КИРГИСТАН	КАЗАХСТАН	МОНГОЛ	INDEX
Кластер хөгжлийн байдал	55	2	96	112	115	GII /1-139/
Венчур капиталаар авсан хөрөнгө оруулалт / ДНБ (PPP\$, тэрбум)	1	36	n/a	112	102	GII /1-139/
Хожуу шатны венчур капиталаар хийгдсэн хөрөнгө оруулалт, дэлхийн VC-д эзлэх хувь	38	2	n/a	74	98	GII /1-139/
“Венчур капиталаар санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт / ДНБ (PPP\$, тэрбум)	4	52	n/a	92	102	GII /1-139/
Венчур капиталын хөрөнгө оруулагчдын хамтарсан оролцоо/ ДНБ (PPP\$, тэрбум)	1	36	n/a	85	104	GII /1-139/
Стартап болон тэлж буй аж ахуйн нэгжүүдийн санхүүжилт	17	22	n/a	62	n/a	GII /1-139/
Хувийн хэвшилд олгосон дотоодын зээл, ДНБ-д эзлэх (%)	55	3	116	105	79	GII /1-139/
Бичил санхүүгийн байгууллагуудаас олгосон зээл, ДНБ-д эзлэх (%)	8	43	14	30	6	GII /1-139/

GII- Global Innovation Index

Монгол Улс Кластер хөгжлийн индексээр 139 орноос 115-д жагсаж байгаа нь стартап, инновацийн экосистемийн дэд бүтэц болон хамтын ажиллагааны орчин хангалтгүй, кластерын хөгжил удаан байгааг харуулж байна. Венчур капиталаар авсан хөрөнгө оруулалтын түвшин харьцангуй бага бөгөөд стартапын санхүүжилт, өрсөлдөөн, тэлэлт зэрэг үзүүлэлтийг үнэлэхэд шаардлагатай мэдээлэл дутмаг байна. Энэ нь системчилсэн мэдээллийн дутагдалтай холбоотой болохыг илтгэж байна.

4. Монгол Улсад мөрдөж байгаа мэдээлэл харилцаа холбооны хууль, дүрэм, бодлогын баримт бичгүүд ба хөтөлбөрүүд

Монгол Улсын тогтвортой хөгжил, төрийн үйл ажиллагааны үр ашиг, ил тод байдлыг дээшлүүлэхэд төр-иргэний харилцааг цахим хэлбэрт үе шаттайгаар шилжүүлэх нь өнөө үеийн цахим шилжилтийн чиг хандлага, сорилт, боломжуудтай нийцсэн үндэсний стратегийн тэргүүлэх чиглэл болж байна. Цахим шилжилт нь зөвхөн шинэ технологи нэвтрүүлэх төдийгүй төрийн үйлчилгээг иргэн, байгууллага, бизнесийн хүсэлтэд нийцүүлэн ил тод, хүртээмжтэй, түргэн шуурхай болгох суурь механизм бөгөөд нийгэм эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих чухал хүчин зүйл юм. Монгол Улсын Засгийн газар энэ чиглэлийг Алсын хараа-2050 урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Цахим үндэстэн” дунд хугацааны хөтөлбөр зэрэг үндэсний баримт бичгүүдээр тодорхойлон хэрэгжүүлж байна. Цахим шилжилтийн эрх зүйн орчин нь төрийн мэдээллийн нэгдсэн систем, иргэний өгөгдлийн хамгаалал, цахим гарын үсэг, кибер аюулгүй байдал зэрэг олон салбарт хуулийн тогтолцоог бүрдүүлэн, төр иргэн хоорондын харилцааг цахим хэлбэрт шилжүүлэх зохицуулалт, хяналтын механизмыг бүрдүүлэхэд чиглэгдэж байна. Түүнчлэн E-Mongolia нэгдсэн цахим платформ, төрийн байгууллагын өгөгдлийн солилцоо, автоматжуулсан үйлчилгээний механизм зэрэг бодит хэрэгжилтийн бүтээн байгуулалтууд нь төрийн үйлчилгээг цахимжуулах практик алхмууд болж байна. Гэсэн ч цахим хүртээмж, хүний нөөцийн чадавх, эрх зүйн уялдаа, өгөгдлийн засаглалын нарийвчилсан зохицуулалт зэрэг тулгамдсан асуудлууд стратегийн шинэ сорилтуудыг тодорхойлно.

4.1 Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлого төлөвлөлтөнд МХХС-т тусгагдсан төсөл хөтөлбөр, арга хэмжээ

Хүснэгт 23. Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлого төлөвлөлт

АЛСЫН ХАРАА 2050 2 ЗОРИЛГО 3 ЗОРИЛТ 14 ҮЙЛ АЖИЛЛАГАА	ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО 1 ЗОРИЛТ	МУ-ЫГ 2026-2030 ОНД ХӨГЖҮҮЛЭХ 5 ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ 3 ЗОРИЛГО 11 АРГА ХЭМЖЭЭ
2.4 II үе шат	6.1	5.8
2.4 III үе шат		5.8.1
5.1 III үе шат		5.8.1.1 5.8.1.2
5.8.1.2		7.3.7
5.3 I үе шат		7.3.7.1 7.3.7.2 7.3.7.3
5.3 II үе шат		10.2.1
		10.2.1.1 10.2.1.2

4.2 Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлого төлөвлөлтөнд МХХС-т тусгагдсан төсөл хөтөлбөр, арга хэмжээний шалгуур үзүүлэлтүүд

Хүснэгт 24. Төсөл хөтөлбөр, арга хэмжээний шалгуур үзүүлэлтүүд

Үзүүлэлт		Хэмжих / нэгж	Суурь		2030 он	2050 он
Цахим шилжилт			Он	Түвшин		
АХ - 2050	Цахим засгийн хөгжлийн үзүүлэлт	нэгж	2024	0.5824	0.8	0.9
МУХТ-2026-2030	Мэдээлэл харилцаа холбооны хөгжлийн индекс	Индекс	2024	87	91	92
	Интернэт ашигладаг хувь хүмүүсийн эзлэх хувь (15, түүнээс дээш насны хүмүүс)	Хувь	2024	77.7	82.7	85
	Үүрэн холбооны дэд бүтэцтэй баг	Хувь	2024	90.8	94.5	95.7
	Шуудангийн хөгжлийн индекс	Түвшин	2024	5	7	8
	Цахим засаглалын хөгжлийн индекс	Индекс	2024	0.846	-	0.9
	Иргэнээс гарах зардлын хэмнэлт	Тэрбум төгрөг	2024	368	610	640
	Иргэдийн цахим ур чадварын түвшин	Хувь	2024	43.8	-	62
	Олон Улсын Кибер аюулгүй байдлын индекс	Индекс	2024	56.36	-	81
	Засгийн газрын хиймэл оюуны бэлэн байдлын индекс	Индекс	2024	42.36	60	65
	Мэдээллийн технологийн салбарын ДНБ-д эзлэх хувь	Хувь	2024	0.12	0.34	0.4
МУЗГУАХ 2024-2028	Хиймэл оюуны ёс зүйн бэлэн байдлын үзүүлэлт	Индекс	2024	2.5	4.2	-
	Дэлхийн инновацийн үзүүлэлт	Индекс	2023	68	58	-
	Ур чадварын индекс	Индекс	2023	64	56	-

4.3 Мэдээлэл, харилцаа холбооны салбарын бодлогын баримт бичгүүд

Хүснэгт 25. Бодлогын баримт бичиг

№	НЭРС	ДУГААР	БАТЛАГДСАН ОГНОО
1	"Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратеги"	№ 18	2025.09.24
2	"Цахимаар нэн тэргүүнд" бодлогын зөвлөмж	№ 108	2025.09.24
3	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Стратеги төлөвлөгөө (2024-2028)	№ А/05	2025.01.15
4	"Цахим аймаг" бодлогын зөвлөмж	№ А/53	2023.06.06
5	Монгол Улсад сансар судлалыг хөгжүүлэхэд баримтлах чиглэл	№ А/93	2022.12.22
6	"Цахим Үндэстэн" (2022-2027) баримтлах чиглэл	№ А/24	2022.05.18
7	Монгол Улсад нам орбитын хиймэл дагуулын сүлжээ ашиглахад баримтлах чиглэл	№ А/16	2022.04.11
8	Монгол Улсад телевизийн нэвтрүүлэг, аудио, видео санг интернэтээр дамжуулах үйлчилгээ эрхлэхэд баримтлах чиглэл	№А/112	2020.09.14
9	Цахим орчинд хүүхэд хамгаалах үйл ажиллагаанд баримтлах чиглэл	№ А/68	2020.05.15
10	Монгол Улсад дараа үеийн хөдөлгөөнт холбооны системийг нэвтрүүлэхэд баримтлах бодлогын чиглэл	№ А/45	2020.04.21
11	Төрөөс нээлттэй өгөгдлийн талаар баримтлах бодлогын чиглэл	№ А/25	2019.02.02
12	Монгол Улсад харилцаа холбооны үйлчилгээний үнэ тариф, өрсөлдөөний талаар баримтлах бодлогын чиглэл	№ А/65	2017.06.22
13	Монгол Улсад интернэт протоколд суурилсан телевиз (IPTV)-ийн үйлчилгээг нэвтрүүлэхэд баримтлах чиглэл	№ 111	2009.09.29

4.4 Мэдээлэл, харилцаа холбооны салбарын хууль тогтоомж

Хүснэгт 26. Хууль тогтоомж

№	НЭРС	БАТЛАГДСАН ОГНОО	НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН ОГНОО
1	Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль	2024 онд	-
	"Цахимаар нэн тэргүүнд" бодлогын зөвлөмж	№ 108	2025.09.24
2	Кибер аюулгүй байдлын тухай хууль	2021 онд	2023 онд
3	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль	2021 онд	-
4	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль	2021 онд	2024 онд
5	Цахим гарын үсгийн тухай хууль	2021 онд	2024 онд
6	Өргөн нэвтрүүлгийн тухай хууль	2019 онд	2024 онд
7	Хаягжуулалтын тухай хууль	2013 онд	2022 онд
8	Инновацийн тухай хууль	2012 онд	2024 онд
9	Шуудангийн тухай хууль	2003 онд	2023 онд
10	Харилцаа холбооны тухай хууль	2001 онд	2024 онд

4.5 Мэдээлэл, харилцаа холбооны салбарын журам ба тогтоол

Хүснэгт 27. Журам ба тогтоол

№	НЭРС	ДУГААР	БАТЛАГДСАН ОГНОО
1	Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн ажиллах журам, Виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд татварын болон татварын бүс дэмжлэг үзүүлэх журам	№98	2025.09.17
2	Инновацийн төслийг улсын төсвөөс санхүүжүүлэх журам, Инновацийн үйл ажиллагаанд оролцогчид грант олгох журам	№224	2025.05.07
3	Мэдээллийн технологийн үйлдвэрлэл дэвшилтэт технологийг хөгжүүлэх Үндэсний зөвлөлийн ажиллах журам	№97	2024.10.25
4	Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх журам, аргачлал	№А/30, А/148	2024.10.16
5	Эрүүл мэндийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, аюулгүй байдлыг хангах журам		2024.03.06
6	Хүний эмзэг мэдээлэл, генетик болон биометрик мэдээлэл боловсруулахад баримтлах технологийн Аюулгүй байдлын шаардлага, журам	№ А/90	2023.09.11
7	Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөр тогтоох журам	№А/37	2022.07.22
8	Төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагаас үйлчилгээ үзүүлэх журам	№А/35	2022.07.06
9	Тоон гарын үсгийн гэрчилгээний үндэсний санг бүрдүүлэх ашиглах журам	№А/30	2022.06.22
10	Онц чухал дэд бүтэцтэй байгууллагын жагсаалт	№207	2022.05.25
11	Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам	№196	2022.05.11
12	Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн системийн үйл ажиллагааны журам	№200	2022.05.18
13	Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журам	№200	2022.05.18
14	Нээлттэй өгөгдлийн төлбөр тооцох аргачлал	№202	2022.05.18
15	Радио давтамжийн зурвасыг төлөвлөх, дахин төлөвлөх, хуваарилах, ашиглах журам	№ А/48	2020.04.21
16	Радио давтамжийн нэгдсэн бүртгэлийн журам	№ А/47	2020.04.21

Дүгнэлт

Энэхүү судалгаагаар Монгол Улсын цахим шилжилтийн өнөөгийн түвшинг олон улсын индексүүдийн (IMD World Digital Competitiveness Ranking, Government AI Readiness Index, Global Connectivity Report, Network Readiness Index, Global Innovation Index, Global Cybersecurity Index) үр дүнд тулгуурлан цогц байдлаар үнэлэв. Судалгааны үр дүнгээс харахад Монгол Улс цахим холболтын суурь дэд бүтэц, төрийн цахим үйлчилгээний хүртээмжийн хувьд тодорхой ахиц гаргасан боловч хүний капитал, инноваци, хиймэл оюун ухаан болон өгөгдөлд суурилсан эдийн засгийн хөгжлийн түвшин харьцангуй сул хэвээр байна.

Нийлмэл үнэлгээгээр Монгол Улс цахим шилжилтийн суурь шат болох дэд бүтэц болон цахим үйлчилгээг амжилттай хэрэгжүүлсэн ч өгөгдөл, хиймэл оюун ухаанд суурилсан бүтээмж, инновацийн шатанд бүрэн шилжээгүй завсрын түвшинд байгааг судалгааны үр дүн харуулж байна. Цахим шилжилтийн бодлого нь голчлон төрийн үйлчилгээний цахимжилтад төвлөрсөн байгааг судалгааны дүгнэлтүүд харуулжээ. Нөгөө талаас хувийн хэвшлийн эдийн засгийн бүтээмж, өрсөлдөх

чадварыг нэмэгдүүлэх институцийн болон инновацийн шинэчлэл хангалттай түвшинд хүрээгүй байна.

Олон улсын харьцуулалтаар Монгол Улс Төв Азийн зарим улсаас цахим үйлчилгээний хүртээмжийн хувьд харьцангуй давуу боловч Эстони, БНХАУ зэрэг цахим засаглал, хиймэл оюун ухаан, инновацийн экосистем өндөр хөгжсөн орнуудаас хүний капитал, өгөгдөлд суурилсан засаглалын чадавхаар ихээр хоцорч байна. Энэ нь цахим шилжилтийг технологийн нэвтрэлтээс цааш институцийн шинэчлэл, эдийн засгийн бүтцийн өөрчлөлттэй уялдуулах шаардлагатайг тодотгож байна. Судалгааны дүнд үндэслэн цаашдын бодлого нь цахим шилжилтийг зөвхөн цахим үйлчилгээгээр бус, өгөгдөл ба хиймэл оюун ухаанд суурилсан эдийн засгийн өсөлт, инноваци, бүтээмжийг дэмжих стратегийн хэрэгсэл болгон дахин тодорхойлох шаардлагатай гэж үзэв. Үүнд хиймэл оюун ухааны хариуцлагатай хэрэглээний эрх зүйн орчныг бүрдүүлэх, өгөгдлийн дахин ашиглалт болон өгөгдөл эдийн засгийг дэмжих зохицуулалтыг хөгжүүлэх, хүний капиталын цахим ур чадварыг системтэй сайжруулах, төр хувийн хэвшил судалгааны байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлэх шаардлагатай байна.



Ө.БАЯСГАЛАН

ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ
ШИНЭЧЛЭЛИЙН ХӨТӨЛБӨР

Төслийн менежер

ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН СУДЛАХ СУДАЛГАА



М.ЖАРГАЛМАА

ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ
ШИНЭЧЛЭЛИЙН ХӨТӨЛБӨР

Ахлах мэргэжилтэн

ГАРЧИГ

Нэг. Асуудалд дүн шинжилгээ хийх	88
1.1. Шийдвэрлэх гэж байгаа асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоох	88
1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдийг тодорхойлох	90
1.3. Асуудал үүссэн шалтгаан, нөхцөлийг тодорхойлох	92
1.3.1. Эдийн засгийн эрх чөлөө ба аж ахуйн үйл ажиллагаа явуулах эрх чөлөө	92
1.3.2. Монгол Улсын эдийн засгийн эрх чөлөөний индекс – 2025 он	93
1.4. Индексүүдийн дүн шинжилгээ	93
1.4.1. Хамгийн доод үзүүлэлттэй индекс	94
1.4.1.1. Засгийн газрын шударга байдал	94
1.4.1.2. Өмчийн эрх	97
1.4.1.3. Шүүхийн үр нөлөө	102
1.4.2. Дунджаас доогуур үзүүлэлттэй индекс	103
1.4.2.1. Худалдааны эрх чөлөө	103
1.4.2.2. Хөрөнгө оруулалтын эрх чөлөө	104
1.4.2.3. Санхүүгийн эрх чөлөө	106
1.4.3. Дундаж үнэлгээтэй индекс	106
1.4.3.1. Бизнесийн эрх чөлөө	106
1.4.3.2. Хөдөлмөрийн эрх чөлөө	110
1.4.3.3. Мөнгөний эрх чөлөө	110
1.4.4. Дээгүүр үнэлгээтэй индекс	113
1.4.4.1. Татварын ачаалал	113
1.4.4.2. Засгийн газрын зарцуулалт	114
1.4.4.3. Төсвийн зохистой байдал	114
Хоёр. Асуудлыг шийдвэрлэх зорилго	115
Гурав. Бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа	115
Дөрөв. Зөвлөмж	120
Ном зүй	121

Товчилсон үгийн жагсаалт

АНУ	Америкийн нэгдсэн улс
АТГ	Авлигатай тэмцэх газар
АТИ	Авлигын төсөөллийн индекс
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
МҮХАҮТ	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим
ТББ	Төрийн бус байгууллага
ЭЗЭЧИ	Эдийн засгийн эрх чөлөөний индекс
ЭСЯ	Элчин сайдын яам

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Эдийн засаг, аж ахуйн үйл ажиллагаанд хамаарах хуулийн ангилал, тоо	89
Хүснэгт 2. ЭЗЭЧИ-ийн үнэлгээ, ангилал	93
Хүснэгт 3. ЭЗЭЧИ-ийн дөрвөн бүлэг	93
Хүснэгт 4. Монгол Улсын авлигын эрсдэлийн TRACE матриц	95
Хүснэгт 5. Монгол Улсад нийтлэг ашиглагдаж буй эрхийн төрөл	98
Хүснэгт 6. ЭЗЭЧИ-ийн хөрөнгө оруулалтын орчныг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд	104
Хүснэгт 7. ЭЗЭЧИ-ийн санхүүгийн эрх чөлөөний үзүүлэлт	105
Хүснэгт 8. Бизнесийн эрх чөлөөг тоон үзүүлэлтээр үнэлэх дэд хүчин зүйлс	107
Хүснэгт 9. МҮХАҮТ – Монголын бизнесийн орчны үзүүлэлт	107
Хүснэгт 10. Бизнесийн үйл ажиллагаанд нийтлэг үйлчлэх хуулиуд	109
Хүснэгт 11. Аж ахуй эрхлэгчид үзүүлэх дэмжлэг	109
Хүснэгт 12. ЭЗЭЧИ-ийн хөдөлмөрийн эрх чөлөөний үзүүлэлтүүд	110
Хүснэгт 13. Өрсөлдөөний тухай хуульд заасан төр өрсөлдөөнд "оролцох" үндэслэл буюу зорилго, салбар, зохицуулалтын арга	110
Хүснэгт 14. Төсвийн зарлагын эдийн засгийн дэлгэрэнгүй ангиллаас	111

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. Монгол Улсын ЭЗЭЧИ-ийн үзүүлэлтүүд	93
График 2. Монгол Улсын ЭЗЭЧИ-ийн үзүүлэлт (1995-2025 он)	93
График 3. Монгол Улсын авлигын хяналтын үзүүлэлт: 1996-2024	96
График 4. Монгол Улсын хуулийн засаглалын үзүүлэлт: 1996-2024	101
График 5. Хуулийн засаглал бүлэг	103
График 6. Зах зээлийн нээлттэй байдал бүлэг	106
График 7. Зохицуулалтын үр ашиг бүлэг	113
График 8. Сүүлийн таван жилийн Засгийн газрын өрийн мэдээлэл	114
График 9. Засгийн газрын зохицуулалт бүлэг	115

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэл	91
Зураг 2. Монгол Улсын сүүлийн 6 жилийн авлигын индекс	94
Зураг 3. Кредендо групп: Монгол Улсын эрсдэлийн үнэлгээ	97
Зураг 4. Эрчим хүчний яамны цахилгаан болон дулааны техникийн нөхцөлийн хүсэлтийн шийдвэрлэлтийн 2025 оны эхний хагас жилийн мэдээлэл	108
Зураг 5. Монгол Улсын сүүлийн 5 жилийн инфляцын түвшин	111
Зураг 6. Гүрж Улсын татварын шинэчлэлийн дараах татварын орлого	116

ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН СУДЛАХ СУДАЛГАА

Тойм судалгаа

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн хэрэгцээ, шаардлага, ерөнхий хүрээг гаргах зорилгоор Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалыг удирдлага болгон Эдийн засгийн эрх чөлөөний үзүүлэлтүүдийн дагуу энэхүү суурь судалгааг гүйцэтгэлээ.

1. Асуудалд дүн шинжилгээ хийх

1.1. Шийдвэрлэх гэж байгаа асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоох

Манай улс 1992 онд баталсан Үндсэн хуулиндаа¹ “дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна” гэж хуульчлан хувийн өмч², иргэний хувиараа аж ахуй эрхлэх³ үндсэн эрхүүдийг баталгаажуулсан.

Түүнчлэн “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэж эдийн засгийн талаар төрийн гүйцэтгэх чиг үүргийг Үндсэн хуульд зааж өгсөн.

- Үндсэн хуулийн энэ заалтыг эрдэмтэн судлаачид тайлбарласнаас үзэхэд:
- “Чөлөөт зах зээлийн эдийн засгийн зарчмыг хүлээн зөвшөөрсний илэрхийлэл;
- Эдийн засагт төрөөс нөлөөлөх бодлого, цогц арга

хэмжээг эдийн засгийн зохицуулалт гэнэ. Төр энэ зохицуулалтаа хууль тогтоох, биелүүлэх, хэрэглэх замаар хэрэгжүүлдэг;

- Төрөөс эдийн засгийг зохицуулахдаа зөвхөн “үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах” зорилгод чиглэсэн “зохицуулалт” хийхээ тунхаглаж, үүнээс бусад оролцоо зохицуулалтаас татгалзаж буйг хуульчилсан гэж ойлгоно”⁴;

“Эдийн засаг дахь төрийн оролцоо, зохицуулалтын анхдагч үүрэг бол эдийн засгийн зохистой, зөв эрх зүйн орчныг бүрдүүлэх явдал бөгөөд тэрхүү эрх зүйн хэм хэмжээг бүхэлд нь эдийн засгийн эрх зүй гэнэ. Эдийн засгийн эрх зүй нь эдийн засгийн харилцаанд оролцогчдын (үйлдвэрлэгч/нийлүүлэгч болон хэрэглэгч/худалдан авагч) үйл ажиллагааг төрөөс зохицуулах (удирдан чиглүүлэх, дэмжих, төлөвлөх, хянах) нийтийн эрх зүйн хэм хэмжээ, түүнчлэн эдийн засгийн харилцаанд оролцогчид үйл ажиллагаагаа өөрсдөө зохицуулах хувийн эрх зүйн хэм хэмжээнээс бүрдэнэ” гэжээ⁵.

Чөлөөт зах зээлийн эдийн засгийн үндсэн зарчимтай уялдуулж “зохицуулах” гэдгийг төрийн оролцоог хамгийн бага байлгах, хөндлөнгийн байх агуулгаар тайлбарлах, түүнчлэн дээр дурдсанчлан “үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах”-аас бусад тохиолдолд зохицуулахгүй гэж хязгаарлах байдлаар тайлбарлах нь бий.

Нөгөө талаар, төр (Үндсэн хуулийн гуравдугаар бүлгийн Монгол Улсын төрийн байгуулалд хамаарах

¹ Монгол Улсын Үндсэн хууль (1992)-ийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг

² Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.”

³ Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг “Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:

4/ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй;”

⁴ Нанзаддоржийн Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар, Н.Лүндэндорж, (Улаанбаатар: Адмон, хэвлэлийн компани, 2022) 73, 74, 75 дугаар тал. “Энэ хэм хэмжээ нийгэм, эдийн засгийн амьдралд төрийн оролцох хувь хэмжээг тодорхойлоход оршино. Дарангуй төр бүхнийг хянаж, бүгдийг заадаг бол ардчилсан, хязгаарлагдмал засаг төр бүхнийг зааж, хянадаггүй, харин зохицуулдаг. Энэ номлол улс төрийн либерал онолын тулгуур үзэл санаа бөгөөд түүний нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн гурвал: (1) хувь хүний эрх чөлөө, (2) чөлөөт худалдаа, өмчлөх эрх, (3) хязгаарлагдмал засаг төр болно. Тийм учраас энэ

заалтыг тайлбарлах, ойлгох онолын үндэс нь либерализм юм. Нөгөө талаас энэ хэм хэмжээ чөлөөт зах зээлийн эдийн засгийн зарчмуудыг хүлээн зөвшөөрсний илэрхийлэл мөн.

Эдийн засагт төрөөс нөлөөлөх бодлого, цогц арга хэмжээг эдийн засгийн зохицуулалт гэнэ. Төр энэ зохицуулалтаа хууль тогтоох, биелүүлэх, хэрэглэх замаар хэрэгжүүлдэг. Төрөөс эдийн засагт нөлөөлөх бодлого, төлөвлөгөө зэрэг олон цогц арга хэмжээ авдаг ч төр нь зөвхөн хуульд үндэслэсэн, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх ёстой. Төр эдийн засгийг хуулиар зохицуулахдаа

1. Мөнгөний бодлого тодорхойлох,
2. Улсын төсөв батлах, татвар тогтоох,
3. Эдийн засгийн харилцааны эрх зүйн зохицуулалтын суурийг бий болгох, тогтмол боловсронгуй болгох,
4. Шударга өрсөлдөөнийг дэмжих, эдийн засгийг монополоос хамгаалах,
5. Нийгэмд ашиг тустай салбарыг (боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухаан, батлан хамгаалах гэх мэт) дэмжин хөгжүүлэх,
6. Эдийн засгаас байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтөд үзүүлэх нөлөөг хянах, багасгах,
7. Нийгмийн эмзэг бүлгийг дэмжих зэрэг зохицуулалтын нийтлэг аргыг хэрэглэдэг.

субъектууд) буюу хууль тогтоох, гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч өөр өөрийн чиг үүргийг гүйцэтгэх байдлаар “зохицуулалт” хийх (эрх олгосон, зөвшөөрсөн, хориглосон, хязгаарласан гэх зэрэг зохицуулалтын бүх хэлбэрийг агуулах), “эдийн засгийн зохицуулалт” нь “үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах”-д чиглэнэ гэж өргөн утгаар ойлгож болох юм.

Үндсэн хуульд “эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцдуулан хөгжүүлэх” эрхэм зорилго тунхагласнаас хойш 34 жил өнгөрч төр дээрх заалтын дагуу эдийн засгийн харилцааг зохицуулсаар ирсэн.

Гэхдээ Үндсэн хуульд эдийн засаг, аж ахуйн үйл ажиллагааны талаар дээрх 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 16 дугаар зүйл дэх иргэний үндсэн эрх, эрх чөлөөнд хувийн аж ахуй эрхлэх эрхтэй гэснээс өөр тухайлсан зохицуулалтгүй байна. Энэ нь тухайн үеийн хувийн хэвшил буюу аж ахуйн үйл ажиллагаа, зах зээлийн эдийн засгийн талаар туршлага, мэдээлэл дутмаг байсан нөхцөл байдалтай холбоотой байж болно. Үндсэн хуульд төрийн байгууллын бүтэц, сонгох болон томилох зарчим зэрэг харилцааны талаар дэлгэрэнгүй зохицуулалтууд байгаатай харьцуулахад эдийн засгийн харилцааны талаар тодорхой, дэлгэрэнгүй зохицуулалт байхгүй байгаа нь Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг илэрхийлж байна.

Одоогоор манай улсад 933 хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж⁶ байгаагаас эдийн засаг, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой харилцаанд хамаарах давхардсан тоогоор 226 хуулийг дараах байдлаар ангилж болохоор байна. (Хүснэгт 1)

Жишээ нь, тухайн иргэн хуулийн этгээд байгуулж, Ашигт малтмалын тухай хуулийн үйлчлэлд хамаарах үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд дунджаар 30 хуулийн үйлчлэлд шууд хамаарах, эдгээр хуулиудыг дагалдсан хэм хэмжээний акт, захиргааны акт, шийдвэрүүд үүнээс багагүй байхаар байна.

Төрөөс эдийн засгийн харилцаанд дээрх хуулиудаар зохицуулалт хийхдээ, тухайлан аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд баримтлах зарчим тодорхой бус, олон хууль, журмаар тархаан зохицуулсан байна.

Хүснэгт 1. Эдийн засаг, аж ахуйн үйл ажиллагаанд хамаарах хуулийн ангилал, тоо

№	Ангилал	Хууль
1	Үйл ажиллагааны зөвшөөрөл, хориглолт	4
2	Нийтийн өмчийн ашиглалт	11
3	Хувийн өмч	6
4	Бүртгэл, баталгаажуулалт	5
5	Ажиллах хүч, хөдөлмөрийн харилцаа	7
6	Өрсөлдөөн, хэрэглэгчийн эрхийг хамгаалах	6
7	Иргэн, хуулийн этгээдээс гомдол гаргах, маргаан шийдвэрлүүлэх	10
8	Эрх зүйн байдлыг тогтоох	5
9	Аюулгүй байдал, үйл ажиллагаа, үйлчилгээний стандарт, төрийн хяналт шалгалт	15
10	Төлөвлөлт, төсөв, сан, шийдвэр гаргалт, зарцуулалт – худалдан авалт, ил тод байдалтай холбоотой	16
11	Татвар, төлбөр, хураамж	23
12	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх	3
13	Дэмжлэг, урьдчилан сэргийлэлт	15
14	Үйл ажиллагааны салбар: Тээвэр – 5, Үйлчилгээ – 12, Боловсрол – 3, Санхүү – 26, Барилга – 3, Үйлдвэр, шинжлэх ухаан – 9, Хүнс, хөдөө аж ахуй – 15, Мэдээллийн технологи – 5, Эрүүл мэнд – 2, Эрчим хүч – 4	84
15	Хөрөнгө оруулалт	4
16	Хувийн эрх зүйн	11

Өөрөөр хэлбэл, аж ахуй эрхлэгч ашгийн төлөө үйл ажиллагаа явуулахад баримтлах (төрөөс хүлээгдэж буй баталгаа, төрийн оролцооны чиг үүрэг, хязгаар, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн үүрэг, хариуцлага) үндсэн зарчмыг нэгтгэн тодорхойлсон, төр болон аж ахуй эрхлэгчийн хооронд харилцан үнэнч шударгаар, хууль ёс болон итгэлцлийг хамгаалах зарчмыг тогтоосон, эдийн засгийн үйл ажиллагаа чөлөөтэй байх, урьдчилан таамаглаж болохуйц байдлыг бий болгоход чиглэсэн хууль манай улсад дутмаг байна. Иймд зарим судлаачид⁷ “эдийн засгийн эрх зүйг бий болгох, тогтолцоог бүрдүүлэх” хэрэгтэй байгааг дурджээ.

Төрийн зохицуулалт буюу эдийн засгийн талаарх хуулиуд эдийн засгийн, тэр дундаа аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх эрх чөлөөг хангах эрх зүйн орчныг

Төрөөс ...эдийн засгийг зохицуулахдаа зөвхөн “үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах” зорилгод чиглэсэн “зохицуулалт” хийхээ тунхаглаж, үүнээс бусад оролцоо зохицуулалтаас татгалзаж буйг хуульчилсан гэж ойлгоно.

⁵ Гочоогийн Банзрагч, “Эдийн засгийн харилцаан дахь төрийн зохицуулалтын нийтийн эрх зүйн үндэс, анхаарах асуудлууд”, legaldata.mn, 2017, 1 дэх тал, (Сүүлд үзсэн: 2025.09.04) “Хүний хязгааргүй хэрэгцээг хязгаарлагдмал нөөц баялгаар хамгийн оновчтойгоор хангах арга замыг эрэлхийлэх, хүн ардынхаа амьдрах таатай орчинг бүрдүүлэх, улмаар улс орныхоо эдийн засгийн өсөлтийг хангахад санаа тавих нь төрийн чиг үүрэг болох нь маргаангүй юм. Иймээс төрөөс эдийн засгийн харилцааг зохицуулах гол зорилго нь хязгаарлагдмал нийгмийн нөөц баялгийг дээд зэргээр үр ашигтайгаар ашиглах, баялгийг хамгийн

боломжит хэмжээгээр бүтээх, үр өгөөжгүй зардлыг багасгахад орших бөгөөд ингэхдээ нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, нийгмийн баялгийн зохистой хуваарилалтыг хэрэгжүүлэх, шударга бус өрсөлдөөнийг зохицуулж зах зээлийг хамгаалах, өмчийн болон аж ахуй эрхлэх эрхийг баталгаажуулах зайлшгүй шаардлагатай болдог. Эдийн засаг дахь төрийн оролцоо, зохицуулалтын анхдагч үүрэг бол эдийн засгийн зохистой, зөв эрх зүйн орчинг бүрдүүлэх явдал бөгөөд тэрхүү эрх зүйн хэм хэмжээг бүхэлд нь эдийн засгийн эрх зүй гэнэ. Эдийн засгийн эрх зүй нь эдийн засгийн харилцаанд оролцогчдын (үйлдвэрлэгч/нийлүүлэгч болон хэрэглэгч/худалдан авагч) үйл ажиллагааг төрөөс зохицуулах (удирдан чиглүүлэх, дэмжих, төлөвлөх, хянах) нийтийн эрх зүйн хэм хэмжээ, түүнчлэн эдийн засгийн харилцаанд оролцогчид үйл ажиллагаагаа өөрсдөө зохицуулах хувийн эрх зүйн хэм хэмжээнээс бүрдэнэ.

⁶ Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn>

сайн бүрдүүлж өгөөгүй байна гэдгийг олон улсын болон дотоодын байгууллагын үнэлгээ харуулж байна. Олон улсын Хэритэж сан (Heritage foundation)-ийн “Эдийн засгийн эрх чөлөөний индекс”⁷ -ээр манай улсын зэрэглэл “дундаж” үнэлгээтэй, сүүлийн 30 жилийн дундаж үнэлгээ 58.4 оноотой, тодорхой ахицгүй байсаар байна. Мөн МҮХАҮТ-ын 2020 болон 2023 оны Бизнесийн орчны судалгааны тайлангаас харвал засаглал, хууль эрх зүйн орчны 3 бүлэг үзүүлэлт болох 1) засгийн газрын институтийн тогтолцоо, уялдаа холбоо, 2) засгийн газрын үйл ажиллагаа, 3) бизнесийн эрх зүйн бүлэг үзүүлэлтүүд нь бүгд бага гэж үнэлэгдсэн хэвээр байна. Монголбанкны Монголын эдийн засаг – 30 жил судалгаанд⁸ “сүүлийн 20 жилд Монгол Улсын институцийн капитал/хөгжил (тухайлбал, авилгалд тавих хяналт, эрх зүйт ёсыг дээдлэх байдал) сайнгүй байна. Байгалийн баялагт хэт түшиглэсэн эдийн засгийн хөгжлөөсөө шалтгаалан Монгол Улс институцийн чанарын хувьд бусад жишиг улс орнуудаас доогуур үзүүлэлттэй байна” гэжээ.

Иймд эдийн засгийн харилцааг зохицуулсан хуулиудад дүн шинжилгээ хийж, аж ахуйн үйл ажиллагааны эрх чөлөөний суурь зарчмуудыг бататгахад чиглэсэн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Ажахуйн үйл ажиллагаа хуульдааснаас бусад тохиолдолд хориглоогүй, хязгаарлалтгүй, нээлттэй байх, харилцаанд баримтлах эрх зүйн орчин тодорхой, тогтвортой байх нь эдийн засаг урт хугацаанд хүртээмжтэй, өсөлттэй байх нөхцөлийг хангана.

1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдийг тодорхойлох

Эдийн засаг, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой эрх зүйн орчин сайтар ойлгомжгүй, тодорхой бус, аж ахуйн үйл ажиллагааны эрх чөлөөт байдал бүрэн хангагдаагүй байх нь уг харилцаанд оролцогч, тухайлан ашиг олох зорилготой үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээд (Монгол Улсын хуулийн этгээд, гадаадын компани, гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд), гадаадын иргэн, харьяалалгүй хүнд сөрөг нөлөөтэй.

1.2.1. Иргэн

Дээр дурдсанчлан Монгол Улсын иргэний “хувийн аж ахуй эрхлэх” Үндсэн хуулиар баталгаажсан эрхээ эдлэх

хууль зүйн боломж сайтар хангагдаагүй, зохих ёсоор зохицуулагдаагүй байх нь уг эрх хязгаарлагдах, зөрчигдөх үндэслэл бүрдэнэ.

1.2.2. Хуулийн этгээд

Хувийн эрх зүйн суурь болох Иргэний хуульд “хуулийн этгээд” гэх нэр томъёоллыг тодорхойлж¹⁰, зорилгын хувьд ашгийн төлөө (нөхөрлөл, компани) болон ашгийн төлөө бус (холбоо, сан, хоршоо), өмчлөлийн хэлбэрийн хувьд нийтийн, хувийн, холимог өмчийн байхаар заасан. Харин Үндсэн хуульд дурдагдсан “аж ахуй эрхлэгч”, “аж ахуйн үйл ажиллагаа” гэх нэршил Иргэний хуульд ашиглагдсан байх боловч тодорхойлолт байхгүй байна.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд “аж ахуйн нэгж” гэж улсын бүртгэлд бүртгэгдэж, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа компани, нөхөрлөл, хоршоо, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, тэдгээртэй адилтгах орлогын албан татвар төлөх үүрэг бүхий хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй этгээд болон үндсэн үйл ажиллагаа нь ашгийн бус боловч бараа борлуулах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлж орлого олсон дотоод, гадаадын хуулийн этгээдийг” гэж, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд “аж ахуйн үйл ажиллагаа” гэж ашиг олох зорилготой болон тийм зорилгогүй, бүхэлд нь буюу хэсэгчлэн бараа борлуулах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг” гэж тус тус Иргэний хуульд заасан хуулийн этгээдийн төрөл, хэлбэрээс үл хамааран “орлого” олсон хуулийн этгээд, орлого олох зорилготой эсэхээс үл хамааран бараа, ажил, үйлчилгээ борлуулах үйл ажиллагааг тус тус ойлгохоор тодорхойлжээ. Мөн Өрсөлдөөний тухай хуульд “аж ахуй эрхлэгч” гэж Монгол Улсад бүртгэлтэй, аж ахуй эрхэлж байгаа ашгийн төлөө болон ашгийн төлөө бус хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага, хувь хүнийг хэлнэ гэсэн тодорхойлолт тусгагджээ.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд хуулийн этгээдийн 12 төрлийг тусгасан бөгөөд Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс хийсэн хуулийн этгээдийн нэр томъёоны талаарх судалгаанд¹¹ “хууль тогтоомжид эрх зүйн харилцааны субъектуудыг олон янзаар томъёолон хэрэглэж байна. Тухайлбал, “иргэн, хуулийн этгээд”, “төрийн болон төрийн бус байгууллага”, “иргэн, аж ахуйн нэгж, байгууллага”, “албан тушаалтан, хувь хүн, хуулийн этгээд”, “банк, бусад хуулийн этгээд, иргэн”, “төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд” гэж замбараагүй ангилан хэрэглэжээ” гэсэн байна.

⁷ Гочоогийн Банзрагч, “Эдийн засгийн захиргааны эрх зүй нь захиргааны эрх зүйн тусгай ангийн бүрэлдэхүүн хэсэг болох нь”, legaldata.mn, 2017, 9 дэх тал, (Сүүлд үзсэн: 2025.09.04) Эдийн засгийн эрх зүй хэмээх ойлголтыг бий болгож, түүний тогтолцоог бүрдүүлэх нь төрөөс эдийн засгийн харилцаанд оролцох үндсэн зорилго, бодлого, зарчим, чиг үүрэг, арга хэлбэр зэргийг тодорхойлох, нэгдсэн үзэл баримтлалтай болох, эрх зүй ба эдийн засгийн харилцан уялдаа


холбоог хангах (тухайлбал эрх зүйт төрийн зарчим, тэгш байх зарчим, төрийн социал бодлого нь эдийн засгийн онол, бодлоготой хэрхэн нийцэх вэ гэдгийг тодруулах), улмаар эрх зүйн бүтцийн харилцан хамаарлыг тогтоох, зөрчлийг арилгах зэрэг ач холбогдолтой юм.

⁸ Энэ судалгааны 10 дугаар талд дэлгэрэнгүй оруулав.

Дээрхээс гадна, “хуулийн этгээдийн нэгдэл”, “корпорац”, “групп”, “гадаад болон дотоодын хөрөнгө оруулагч”, “гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж”, “гадаадын төрийн өмчит хуулийн этгээд” зэргээр хууль тогтоомжид тусгагдсан бусад нэршил, субъектууд байгаагаас авч үзвэл эдийн засгийн харилцаанд оролцдог хуулийн этгээд буюу илүү өргөн цар хүрээтэй ашиглагдаж буй “аж ахуй эрхлэгч, аж ахуйн үйл ажиллагаа” гэх нэр томъёоны асуудлыг цэгцлэх, нэг мөр ойлгож хэрэглэх, хууль хоорондын уялдаатай байдлыг хангах шаардлага үүссэн байна. Эдгээр өөр өөр нэр томъёог дагалдан эрх зүйн байдлын ялгамжтай байдал, давуу тал үүсгэх, нөгөө талдаа нэр томъёоны тодорхойлолтын дагуу үл хамаарагдах байдлаар зохицуулалтын гадна үлдэх зөрчлийг дагуулж, тэгш бус байдлыг үүсгэдэг.

Үндэсний статистикийн хорооны 2025 оны 1 дүгээр сард гаргасан мэдээллээр¹² 2024 оны жилийн эцсийн байдлаар “бизнес регистрийн сан”-д нийт 261.2 мянган хуулийн этгээд бүртгэлтэй байна.

Зураг 1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэл



Үйл ажиллагаагаа идэвхтэй явуулж байгаа эсэхээс үл хамааран аж ахуй эрхлэхээр бүртгэгдсэн хуулийн этгээдийг эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх этгээд гэж үзнэ.

Дээрхээс гадна хувиараа аж ахуй эрхэлж буй гадаад болон дотоодын иргэн, хуулийн этгээдээр бүртгүүлээгүй өрхийн, түүнтэй адилтгах жижиг бүлгүүдийн талаар албан ёсны бүртгэл, статистик тоон мэдээлэл байхгүй байна.

1.2.3. Гадаадын иргэн

Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэний эрх, үүргийг Монгол Улсын хууль, уул иргэнийг харьяалсан улстай байгуулсан гэрээгээр тогтооно” гээд, уул иргэнийг харьяалсан улстай энэ талаар харилцан адил байх зарчим баримтална гэж заасан. Мөн тэнд “Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөг тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнд эдлүүлэхдээ Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний салшгүй эрхээс бусад эрхийн хувьд үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд хуулиар зохих хязгаарлалт тогтоож болно” гэсэн ба хувийн аж ахуй эрхлэх нь салшгүй үндсэн эрх биш тул “үндэсний болон хүн амын аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хамгаалах” зорилгоор хуулиар хязгаарлалт тавьж болно.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд аж ахуйн үйл ажиллагааны талаар “зөвшөөрөлтэй эрхлэхээр заасан үйл ажиллагааг зөвшөөрөлгүй явуулах”-ыг хориглосноос өөрөөр тодорхой хориглолт, хязгаарлалт тавиагүй байна.

Хуульд нийцүүлэн хориглосноос бусад байдлаар аж ахуйн үйл ажиллагаа явуулах боломжтой тул эрх ашиг нь хөндөгдөх этгээд мөн байна.

1.2.4. Харьяалалгүй хүн

Үндсэн хуулийн 18 дугаар зүйлийн 3-т “Монгол Улс нутаг дэвсгэртээ байгаа харьяалалгүй хүний эрх, үүргийг өөрийн хуулиар тогтооно” гэж заасан. Мөн зүйлийн 5-т Монгол Улсын иргэний эдлэхээр заасан үндсэн эрхийг харьяалалгүй хүнд эдлүүлэхдээ Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний салшгүй эрхээс бусад эрхийн хувьд үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд хуулиар зохих хязгаарлалт тогтоож болно гэж гадаад улсын иргэний нэгэн адил заасан.

Хувийн аж ахуй эрхлэх нь салшгүй үндсэн эрх биш тул “үндэсний болон хүн амын аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хамгаалах” зорилгоор хуулиар хязгаарлалт тавьж болно. Тухайлсан хуулиар хязгаарлалт тогтоосноос

⁹ Монголбанк, Монголын эдийн засаг - 30 жил сургаж ба шийдэл (Хөгжлийн загвараа эргэн харах нь), 34 дэх нүүр,

¹⁰ Иргэний хууль, (2002), 25 дугаар зүйлийн 25.1. Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг

зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ.

¹¹ Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Монгол улсын хууль тогтоомж дахь хуулийн этгээдийн ойлголт, нэр томъёоны хэрэглээ”, 2021, 195-196 дахь тал

¹² Үндэсний статистикийн хорооны цахим хуудас, https://downloads.1212.mn/3_9EVFcYv1EnlKskj2Pq-N-W8_4jocj_OSw5rYce.pdf

бусад тохиолдолд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх эрхтэй тул эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх этгээд байна.

Монгол Улсад аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд засаглал, хууль, эрх зүйн орчин сайнгүй байгаа нь шууд байдлаар ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж байгаа нийт “иргэн, гадаад улсын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн”-д сөргөөр нөлөөлнө гэж үзнэ.

Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээд нь аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй дээр дурдсан этгээдүүд боловч эдийн засаг, аж ахуйн үйл ажиллагааны эрх чөлөө, эрх зүйн зохицуулалт хангалттай биш байхын үр дагавар, нөлөөлөл илүү өргөн цар хүрээг хамарч улс орны эдийн засаг, иргэдийн амьдрах орчны нөхцөлтэй шууд холбогдоно.

1.3. Асуудал үүссэн шалтгаан, нөхцөлийг тодорхойлох

Монгол Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлогод “Ардчилсан нийгэм дэх зах зээлийн эдийн засгийн харилцааны нөхцөлд Засгийн газар үүргээ гүйцэтгэж чаддаг болохын зэрэгцээ бие даан амьдрах чадвартай хувийн хэвшил бий болгон хөгжүүлэх, ийнхүү хөгжих нөхцөл бүрдүүлэхэд Засгийн газар үйл ажиллагаагаа чиглүүлнэ” гэж хэрэгцээ шаардлагаа тодорхойлсон.

Гэсэн хэдий боловч манай улсын эдийн засаг, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой үзүүлэлтүүд, эдийн засгийн эрх чөлөөт байдлын үнэлгээ дотооддоо хийгдсэн болон олон улсын судалгаа, үнэлгээгээр дундаж түвшинд байсаар байна.

Энэхүү шалтгаан, нөхцөлийг тодорхойлохоор олон улсын байгууллагаас гаргасан манай улсын эдийн засгийн эрх чөлөөт байдлын үзүүлэлтүүдийн дэд шалгуур, үнэлгээг судлан үзлээ.

1.3.1. Эдийн засгийн эрх чөлөө ба аж ахуйн үйл ажиллагаа явуулах эрх чөлөө

Эдийн засгийн эрх чөлөө гэдэг нь хүн бүр өөрийн хөдөлмөр, өмч хөрөнгөө удирдах үндсэн эрх юм. Эдийн засгийн эрх чөлөөтэй нийгэмд хүн хүссэнээрээ ажиллах, үйлдвэрлэх, хэрэглэх, хөрөнгө оруулах эрхтэй байдаг. Ийм нийгэмд Засгийн газар хөдөлмөр, хөрөнгө, бараа бүтээгдэхүүн чөлөөтэй шилжих боломжийг олгож, эрх чөлөөг хамгаалахад шаардлагатай хэмжээнээс

хэтрүүлэхгүйгээр хязгаарлалт тавьдаг гэжээ. Эдийн засгийн эрх чөлөө нь аж ахуйн үйл ажиллагааны эрх чөлөөтэй харьцуулахад өргөн цар хүрээг хамарч байгаа ба аж ахуйн үйл ажиллагааны чөлөөт байдал ердөө нэг үзүүлэлт нь болж байгаа юм. Аж ахуйн үйл ажиллагааны эрх чөлөөг Бизнесийн эрх чөлөө бүлэгт оруулсан болно.

АНУ-д үүсгэн байгуулагдсан Хэритэж сан нь 1973 оноос бодлогын судалгаа хийж эхэлсэн бөгөөд 1995 оноос хойш жил бүр дэлхийн улс орнуудын эдийн засгийн эрх чөлөөний өсөлт, бууралтын түвшнийг тогтоож ирсэн. Эдийн засгийн эрх чөлөөний индексийг /цаашид ЭЗЭЧИ гэх/ тухайн улсын эдийн засгийн өсөлт, ядуурлын хэмжээ, амьдралын чанар болон байгаль хамгаалах үзүүлэлтүүдтэй уялдуулан судалдаг ажээ. Судалгааны урт хугацааны үр дүнгээс харахад хуулийн засаглал (Rule of law), санхүүгийн сахилга бат, нээлттэй зах зээл болон зохистой зохицуулалтын орчин дээр тулгуурласан эдийн засгийн эрх чөлөөний индекс нь өндөр, эдийн засгийн хөгжлийн үндсэн үзүүлэлт нь дэлхийд дээгүүр ордог.

2025 оны ЭЗЭЧИ-ийн судалгаанд нийт 184 орныг хамруулан авч үзсэн ба дараах гол дүгнэлт гаргасан байна. Үүнд:

- Дэлхий даяар төсвийн тогтвортой байдал мэдэгдэхүйц муудсан. Олон оронд төсвийн алдагдал нэмэгдэж, улсын өр өссөн нь нийт бүтээмжийн өсөлтийг сааруулж, улмаар эдийн засгийн идэвхжил буурч, удаашралд хүргэх магадлалтай.
- Эдийн засгийн эрх чөлөөг сайжруулах нь эдийн засгийн идэвхжил, нийт иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэхтэй салшгүй холбоотой байна. Хөгжлийн аль ч түвшинд байгаа улс орнууд татварыг бууруулах, зохицуулалтын орчныг оновчтой болгох, эдийн засгийг өрсөлдөөнд илүү нээлттэй болгох, авлигатай тэмцэх бодлого хэрэгжүүлснээр эдийн засгийн өсөлт, эрх чөлөөг мэдэгдэхүйц нэмэгдүүлэх боломжтой.
- Амьжиргааны түвшин буюу нэг хүнд ногдох орлого /income per capita/ нь эдийн засгийн хувьд илүү эрх чөлөөтэй орнуудад хамаагүй өндөр үзүүлэлттэй байна. 2025 оны индексээр “эрх чөлөөтэй,” “ихэвчлэн эрх чөлөөтэй”, эсвэл “дунд зэрэг эрх чөлөөтэй” гэж үнэлэгдсэн орнуудын орлого нь бусад орны дундаж түвшнээс хоёр дахин, эдийн засгийн хувьд “дарлагдсан” ангиллын орнуудын орлогоос гурав дахин өндөр байна.
- 2025 оны индексээр эдийн засгийн эрх чөлөө нь эрүүл мэнд, боловсрол, байгаль орчин, инноваци, нийгмийн хөгжил, ардчилсан засаглал зэрэг нийтийн сайн сайхан байдлын олон үзүүлэлттэй нягт холбоотой нь дахин нотлогдсон.

¹³ Монгол Улсын Үндсэн хуулийн 18 дугаар зүйлийн 1, 2, 5 дугаар хэсэг

¹⁴ Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Гадаадын иргэнийг хуульд харшилсан, улс төр, сонгууль, үндэсний эв нэгдлийн эсрэг, хүмүүнлэг бус шашин, садар самуун, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг түгээх,

сурталчлах, хэрэглэх болон зөвшөөрөлгүйгээр хөдөлмөр эрхлэхийг хориглосон.

¹⁵ The Heritage Foundation, 2025 Index of Economic Freedom, 2025, 11 дэх тал

¹⁶ The Heritage Foundation, 2025 Index of Economic Freedom, 2025, 1-2 дахь тал

Энэхүү судалгаагаар улс орнуудыг 1) хуулийн засаглал, 2) засгийн газрын зохицуулалт, 3) зохицуулалтын үр ашиг, 4) зах зээлийн нээлттэй байдал гэсэн дөрвөн бүлгийн 12 дэд үзүүлэлтээр 0-ээс 100 хүртэлх оноогоор үнэлж үр дүнг тооцон гаргадаг бөгөөд оноо ихсэх тусам эдийн засгийн эрх чөлөө сайн хангагдсан гэж үздэг байна. Оноог ихээх бага руу эрэмбэлж тухайн улсын олон улстай харьцуулах зэрэглэлийг тогтоодог ба нийт улс орныг дараах 5 ангилалд хуваасан. Үүнд:


Хүснэгт 2 Монгол Улсын ЭЗЭЧИ-ийн үнэлгээ, ангилал

Оноо	Ангилал	Тухайн ангилалд багтсан улсуудын нийт тоо
80 – 100	эрх чөлөөтэй	3
70 – 79.9	ихэвчлэн эрх чөлөөтэй	26
60 – 69.9	дунд зэрэг эрх чөлөөтэй	58
50 – 59.9	ихэвчлэн эрх чөлөөгүй	60
0 – 49.9	дарлагдсан	29

1.3.2. Монгол Улсын эдийн засгийн эрх чөлөөний индекс – 2025 он

Монгол Улс ЭЗЭЧИ-ээр 100 онооноос 62.6 оноо авч 184 орноос 74 дүгээрт эрэмбэлэгдэж байна. Энэ нь Ази-Номхон далайн бүсийн 39 орноос 13 дугаарт бичигдсэн байгаа бөгөөд эдийн засгийн эрх чөлөөний ангиллаар “дунд зэрэг эрх чөлөөтэй” гэж үнэлэгдсэн.

График 1. Монгол Улсын ЭЗЭЧИ-ийн үзүүлэлтүүд¹⁸




ЭЗЭЧИ-ийн дээрх 12 үзүүлэлтийг эерэг үр нөлөө үзүүлэхэд бүгд тэнцүү чухал гэж үздэг бөгөөд улс орнуудын оноог тооцоолохдоо бүх үзүүлэлтийг ижил жинтэйгээр тооцоолол хийдэг. Иймд эдийн засгийн шинэчлэл хийхээр төлөвлөж буй орнууд хамгийн бага оноо авсан үзүүлэлтүүд дээр анхаарал хандуулан, эдийн засгийн

гүйцэтгэлээ сайжруулах боломжийг эрэлхийлэхийг зөвлөдөг.

2025 оны ЭЗЭЧИ-ийн үзүүлэлт нь 2023 оны хоёрдугаар хагасаас 2024 оны эхний хагасыг хамарсан үеийн мэдээлэлд үндэслэсэн байх бөгөөд өөрөөр хэлбэл тухайн үзүүлэлтийн бодит хугацаа нэг жил хагасын өмнөх гүйцэтгэлийг харуулж байна гэсэн үг юм.

Монгол Улс 1995 оноос эхлэн энэхүү судалгаанд хамрагдсан бөгөөд 30 жилийн хугацаанд эдийн засгийн эрх чөлөөний үзүүлэлтээр “ихэвчлэн эрх чөлөөгүй” эсвэл “дундаж эрх чөлөөтэй” гэх ангилалд багтсаар ирсэн бөгөөд төдийлөн өндөр ахиц гараагүй байна. (График. ¹⁹)

График 2. МУ-ын эдийн засгийн эрх чөлөөний индекс (1995-2025 он)



Монгол Улс 1995-аас 2025 оны хооронд ЭЗЭЧИ дээр хамгийн багадаа 47.4 оноо, хамгийн ихдээ 63.9 оноо авч байсан байна.

1.4. Индексүүдийн дүн шинжилгээ

ЭЗЭЧИ нь 12 үзүүлэлтийг өргөн хүрээтэй, цогц байдлаар хэмждэг бөгөөд 4 үндсэн бүлгээр авч үздэг.

Хүснэгт 3. Эдийн засгийн эрх чөлөөний индексийн дөрвөн бүлэг

Хуулийн засаглал	Засгийн газрын хэмжээ (санхүүгийн сахилга бат)	Зохицуулалтын үр нөлөө	Зах зээлийн нээлттэй байдал
Өмчийн эрх	Татварын ачаалал	Бизнес эрхлэх эрх чөлөө	Худалдааны эрх чөлөө
Засгийн газрын шударга байдал	Засгийн газрын зарцуулалт	Хөдөлмөрийн эрх чөлөө	Хөрөнгө оруулалтын эрх чөлөө
Шүүхийн үр нөлөө	Төсвийн зохистой байдал	Мөнгөний эрх чөлөө	Санхүүгийн эрх чөлөө

¹⁷ The Heritage Foundation, 2025 Index of Economic Freedom, 2025, 16 дахь тал
¹⁸ “Economic freedom country profile – Mongolia”, 2025, [https://www.her](https://www.heritage.org/index/pages/country-pages/mongolia)

itage.org/index/pages/country-pages/mongolia, (Сүүлд үзсэн: 2025.11.25)
¹⁹ “Economic freedom country profile – Mongolia”, 2025, [https://www.her](https://www.heritage.org/index/pages/country-pages/mongolia)
itage.org/index/pages/country-pages/mongolia, (Сүүлд үзсэн: 2025.11.25)

Дээрх 12 дэд үзүүлэлтээс засгийн газрын шударга байдал 33.5, өмчийн эрх 49.7 оноогоор үнэлэгдэж хамгийн бага үзүүлэлтийг, шүүхийн үр нөлөө 55.4, хөрөнгө оруулалтын болон санхүүгийн эрх чөлөө тус бүр 50 оноотой байгаа нь дунджаас доогуур үзүүлэлттэй байна. Эдгээр 4 бүлэг, 12 дэд үзүүлэлтийг хамгийн бага оноотойгоос нь эхэлж дэлгэрүүлэн авч үзлээ.

1.4.1. Хамгийн доод үзүүлэлттэй индекс

1.4.1.1. Засгийн газрын шударга байдал

Монгол Улсын хувьд засгийн газрын шударга байдлын үзүүлэлтээр 100-аас 35.5 оноо авсан нь дэлхийн дунджаас 5.8 оноогоор бага байна. Энэ нь ЭЗЭЧИ-ийн үзүүлэлтээс хамгийн бага оноотой нь болж нийт индексийн үнэлгээг доош нь татаж байгаа юм.

“Авлига нь эдийн засгийн харилцаанд найдваргүй байдал (insecurity) болон албадлага (coercion) авчирснаар эдийн засгийн эрх чөлөөг алдагдуулдаг. Төрийн байгууллагууд болон шийдвэр гаргах үйл явцын системийн авлигал нь төрийн шударга байдлыг алдагдуулж, олон нийтийн итгэлийг бууруулж, эдийн засгийн идэвхийг сааруулдаг. Энэ нь хахууль (bribery), албадлага шантааж (extortion), танил талын оролцоо (nepotism, cronyism), давуу эрх олгох (patronage), мөнгө завших (embezzlement), хууль бус ашиг олох (graft) зэрэг олон хэлбэртэй” гэж Хэритэж сангийн ЭЗЭЧИ-ийн үнэлгээний дүгнэлтэд дурджээ.

ЭЗЭЧИ-ийн Засгийн газрын шударга байдлын үнэлгээнд 1) авлигын талаарх ойлголт, 2) хээл хахуулийн эрсдэл болон 3) авлигал, тэр дундаа нөлөө бүхий этгээдүүд болон хувийн ашиг сонирхлоор төрийг олзолж авах/ашиглахад тавих хяналт гэсэн шалгуур үзүүлэлтийг харгалздаг байна.

1) Авлигын талаарх ойлголт

ЭЗЭЧИ-д авлигын талаарх ойлголтыг Транспэрэнси Интернэшнл -ээс гаргадаг авлигын төсөөллийн индекс (Corruption perception index)-ээр хэмждэг бөгөөд энэ үзүүлэлт нь тухайн улс орны төрийг иргэд болон мэргэжилтнүүд хэр зэрэг авлигад өртөмтгий гэж үзэж байгаагаар нь оноо өгч эрэмбэлдэг үзүүлэлт юм. Энэ нь олон улсын нэр хүндтэй байгууллагуудаас, жишээлбэл, Дэлхийн банк, Дэлхийн эдийн засгийн форумас авсан судалгаа, үнэлгээнүүдийг нэгтгэсэн нийлмэл индекс бөгөөд авлигын талаарх дэлхий нийтэд хамгийн өргөн хэрэглэгддэг хэмжүүр юм.

Транспэрэнси Интернэшнлээс авлигын төсөөллийн индекс /цаашид АТИ гэх/-ийг боловсруулах буюу үнэлгээ хийхэд ашигласан эх сурвалжид дараах төрлийн

өгөгдлүүдийг /manifestation/ үндэслэл болгосон байна. Үүнд:

- Хахууль авах, өгөх;
- Төрийн хөрөнгийг буруу зориулалтаар ашиглах;
- Төрийн албан тушаалаа ямар нэг хариуцлага хүлээхгүйгээр хувийн ашиг сонирхолд ашиглах;
- Засгийн газрын авлигатай тэмцэх чадвар;
- Төрийн хэт хүнд суртал, бюрократ дарамт нь авлигын боломжийг нэмэгдүүлэх байдал;
- Төрийн албанд хамаатан садан, танил талын томилгоо хийх (мерит зарчмын эсрэг);
- Авлига авсан албан тушаалтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг эсэх;
- Төрийн албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлэг болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ил тод болгох талаар хуульчилсан байдал;
- Авлига, хээл хахуулийг илчилсэн иргэд, сэтгүүлч, мөрдөн шалгагчдыг хамгаалах хууль эрх зүйн баталгаа;
- Хязгаарлагдмал ашиг сонирхол бүхий бүлэглэлүүд төрийг өөртөө ашигтай байдлаар хянах (state capture);
- Засгийн газар болон төрийн байгууллагуудын үйл ажиллагааны талаар мэдээлэл авах боломж, хүртээмж зэрэг юм.

Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ-ын цахим хуудаст “2024 оны АТИ-ээр Монгол Улс 100-аас 33 оноо авч, төрийн байгууллагын авлигын түвшин харьцангуй өндөр байна гэж үнэлэгдлээ. Энэ нь Монгол Улсыг 180 улсаас 114-р байр эзлэхэд хүргэсэн бөгөөд дэлхийн дундаж болох 43 онооноос доогуур үзүүлэлт юм. 2012 оноос хойш Монголын оноо хамгийн өндөр нь 39 (2014), хамгийн бага нь 33 (сүүлийн жилүүдэд) байжээ.” гэж мэдээлсэн байна.

Зураг 2. Монгол Улсын сүүлийн 6 жилийн авлигын индекс



Эх сурвалж: Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ-ын цахим хуудас

²⁰ Төр, хувийн хэвшил, иргэний нийгэм болон хүмүүсийн өдөр тутмын амьдрал авлигаас ангид орших нэг зорилгын дор нэгдсэн олон улсын олон нийтийн байгууллага

²¹ “Авлигын төсөөллийн индекс (АТИ) гэж юу вэ?, 2025,” <https://www.transparency.mn/avliga-gezhi-yuu-ve>, (Сүүлд үзсэн: 2025.11.17)

²² “Авлигын төсөөллийн индекс 2024”, 2025, <https://www.transparency.mn/post/авлигын-төсөөллийн-индекс-2024>, (Сүүлд үзсэн: 2025.11.17)

²³ Asia Corruption Barometer – Results of Mongolia, 2021, <https://www.transparency.org/en/gcb/asia/asia-2020>, (Сүүлд үзсэн: 2025.11.17)

Мөн Транспэрэнси Интернэшнл олон улсын байгууллагаас 2020 онд хийсэн “Дэлхийн Авлигын Барометр – Ази тив” судалгааны үр дүнг харвал Монгол Улсыг төлөөлөх түүврийн 69% нь төрийн авлигыг томоохон асуудал гэж үзсэн, 22% нь сүүлийн 12 сард төрийн үйлчилгээнд хахууль төлсөн, 29% нь төрийн үйлчилгээ авахад хувийн харилцаа, танил талаа ашигласан болон 14% нь сүүлийн 5 жилд сонгуулийн үеэр саналаа худалдах санал ирж байсан гэжээ.

АТИ-ийн үзүүлэлтээр авлигын түвшин харьцангуй өндөр байгаа нь Засгийн газрын шударга байдлын оноог бууруулах нэг нөхцөл болж байна.

2) Авлига, хээл хахуулийн эрсдэл

Засгийн газрын шударга байдлыг үнэлэх хоёр дахь хүчин зүйл буюу авлига, хээл хахуулийн эрсдэлийг TRACE интернэшнлийн Авлигын эрсдэлийн матриц үнэлгээний оноог ашиглан гаргадаг. Энэ матриц үнэлгээ нь дэлхийн 194 улсад бизнесийн үйл ажиллагаа явуулахад тулгарч болох авлигын эрсдэлийг 2014 оноос 2024 оны хооронд хэмжин гаргасан бөгөөд Монгол Улс 2024 онд матрицын ерөнхий үнэлгээгээр 50 оноо авч дундаж эрсдэлтэй улсын тоонд орсон. Энэ нь нийт 194 орноос 99-д эрэмбэлэгдэж байгаа үзүүлэлт юм.

Матриц нь дараах 4 бүлэг хүчин зүйлийг үндэслэн нийт эрсдэлийн үнэлгээг тооцон гаргадаг бөгөөд оноо ихсэх тусам эрсдэл өндөр байна гэж үзнэ. Монгол Улсын нарийвчилсан үнэлгээг харуулбал:

Хүснэгт 4. Монгол Улсын авлигын эрсдлийн TRACE матриц

№	Бүлэг	Бүлгийн оноо	Дэд хүчин зүйлс	Дэд хүчин зүйлсийн оноо
1.	Төр, хувийн хэвшил хоорондын харилцаанд тохиолдох авлигын эрсдэл /жин: 0.400/	58	Төрийн байгууллагатай харилцах /Interaction/	39
			Авлигын хүлээлт /Expectation/	63
			Зохицуулалтын дарамт /Regulatory burden – Leverage/	66
2.	Авлигаас урьдчилан сэргийлэх, хууль сахиулах /жин: 0.150/	56	Авлигын эсрэг нийгмийн хандлага /Disapproval/	62
			Авлигаас урьдчилан сэргийлэх, хууль сахиулах байдал /Deterrence and Enforcement/	48
3.	Засгийн газар, төрийн байгууллагын ил тод байдал /жин: 0.225/	46	Засгийн газрын төсөв олон нийтэд нээлттэй эсэх /Government transparency/	41
			Төрийн албан хаагчдын ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах журам байгаа эсэх /Conflicts Interests/	49
4.	Хэвлэл, мэдээлэл, иргэний нийгмийн хяналтын чадавх /жин: 0.225/	36	Хэвлэлийн эрх чөлөө /Freedom of media/	34
			Иргэний нийгмийн оролцооны түвшин /Civil society engagement/	37

Олон улсын компаниудад TRACE матрицийн үр дүн тухайн улсын бизнесийн хээл хахуулийн нийт эрсдэл болон ямар хүчин зүйлд эрсдэл илүү өндөр байгааг таамаглах боломжийг олгодог.

3) Авлигын хяналт

Дэлхийн засаглалын үзүүлэлтүүд нь /Worldwide Governance Indicators, WGI/ нь Дэлхийн банкнаас боловсруулан гаргадаг судалгаанд суурилсан хэмжүүрүүд бөгөөд 200 гаруй улс орны засаглалын чанарыг доор дурдсан 6 бүлэг үзүүлэлтээр илэрхийлдэг байна.

- **Дуу хоолой ба хариуцлага:** Иргэд засгийн газраа сонгох эрх чөлөө, үзэл бодлоо илэрхийлэх, иргэний нийгмийн байгууллагад нэгдэх, хэвлэлийн эрх чөлөө;
- **Улс төрийн тогтвортой байдал ба хүчирхийлэлгүй байдал:** Улс төрийн тогтворгүй байдал, хүчирхийлэл гарах магадлал;
- **Засгийн газрын үр ашиг:** Төрийн үйлчилгээний чанар, төрийн алба, бодлогын хэрэгжилт;
- **Зохицуулалтын чанар:** Засгийн газар зөв бодлого, зохицуулалт боловсруулах, хэрэгжүүлэх чадвар;
- **Хууль ёсны засаглал:** Хуульд итгэх итгэл, өмчийн эрх, шүүх, гэрээний хэрэгжилт;
- **Авлигын хяналт:** Төрийн эрх мэдлийг хувийн ашиг сонирхолд ашиглах түвшин.

Дээрх засаглалын 6 бүлэг үзүүлэлтээс сүүлийн бүлэг буюу авлигын хяналтаар төрийн эрх мэдлийг хувийн ашиг сонирхолд ашиглаж буй түвшнийг хэмждэг байна. Үүнд авлигын бүх төрлийг хамааруулан үздэг бөгөөд нөлөө бүхий этгээдүүд хувийн ашиг сонирхлоор төрийг “өөртөө ашигтайгаар олзолж авах”-ад /state capture/ тавих хяналтыг тоон үзүүлэлтээр хэмжиж гаргадаг.

Авлигын хяналтын үзүүлэлтийн үнэлгээнд ашигладаг эх сурвалжууд нь:

- Төрийн албан тушаалтнуудын авлига ;
- Төрийн хөрөнгийг зувчуулах;
- Экспорт, импортод гардаг хууль бус төлбөрүүд /irregular payment/;
- Олон нийтийн үйлчилгээний салбарт гарах хууль бус төлбөрүүд;
- Татварын албанд тохиолдох хууль бус төлбөрүүд;
- Төрийн албаны гэрээ хэлцэлд тохиолдох хууль бус төлбөрүүд;
- Шүүхийн шийдвэрт тохиолдох хууль бус төлбөрүүд;
- Засгийн газарт авлига тархсан байдал ;
- Төр болон иргэдийн хоорондох “жигжиг” авлигын түвшин ;


²⁴ Авлигын эсрэг арга хэмжээ, хууль тогтоомжийн хэрэгжилт болон сайн засаглалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ашгийн бус олон улсын бизнесийн холбоо

²⁵ The 2024 TRACE Bribery Risk Matrix – Country risk comparison, 2025, <https://www.traceinternational.org/trace-matrix#99>, (Сүүлд үзсэн: 2025.11.27)

- Төр болон дотоодын бизнесүүдийн хоорондын авлигын түвшин;
- Төр болон гадаадын компаниудын хоорондын авлигын түвшин;
- Авлигын индекс

Монгол Улс 2023 оны авлигын хяналтын үзүүлэлтээр 35,38 оноотойгоор (percentile rank буюу хувиар илэрхийлсэн байрлал нь 35,38%) нийт 215 улс орноос 138-р байранд эрэмбэлэгдэж байгаа бөгөөд үзүүлэлтийн үнэлгээг он цагийн дарааллаар харуулав.

График 3. Монгол Улсын авлигын хяналтын үзүүлэлт: 1996-2024



4) Дотоодын эрх зүйн зохицуулалт, нөхцөл байдал

ЭЗЭЧИ-ийн засгийн газрын шударга байдлын үнэлгээний 3 дэд хүчин зүйлүүд бүгд авилгын үзүүлэлт буюу авлигын нөхцөл байдал, эрсдэл, хяналт гэсэн 3 бүлэг, давхардсан агуулгаар нийт 32 үзүүлэлтээр үнэлэгддэг байна.

Манай улсын хувьд Авлигын эсрэг хуульд авлигын эрсдэлийн үнэлгээний талаар аливаа зохицуулалтгүй байна. Хэдий хуульд тодорхой зохицуулалтгүй боловч АТТ-аас төрийн байгууллагуудыг сонгон авлигын эрсдэлийн үнэлгээг гүйцэтгэж 2015 оноос хойш 62 байгууллагад эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийг бууруулах ажил, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хэрэгжүүлбэл зохих ажлыг төлөвлөгөөнд тусгуулах арга хэмжээ авсан талаар тайланд дурджээ.

Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-т “авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгааныг 2 жилд нэгээс доошгүй удаа судлан авлигын индексийг гаргаж олон нийтэд мэдээлэх”, 18.1.7-д “төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн

байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх” гэж тус тус заасан. Хуулийн дээрх заалтын дагуу АТТ-аас дотооддоо шударга байдлын үнэлгээг 92 үзүүлэлт бүхий дараах 4 үндсэн, 8 дэд бүлгээр гүйцэтгэж, 0-100 хүртэлх оноогоор үнэлж, оноо өндөрсөх тусам шударга байдал сайн гэж үнэлдэг байна.

Гадаад шударга байдлын үнэлгээ

- Авлигын индекс
- Ил тод байдлын индекс
- Хариуцлагатай байдлын индекс

Дотоод шударга байдлын үнэлгээ

- Соёлын индекс
- Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс

Бодлогод оролцогчдын үнэлгээ

- Авлигын талаарх төсөөлөл, бодит тохиолдол
- Авлигыг хянах механизм
- Удирдлагын хүсэл эрмэлзэл

Авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээ

Энэхүү шударга байдлын үнэлгээний дагуу төрийн байгууллагуудын дундаж үнэлгээ 2022 онд 73.9, 2023 онд 76.6, 2024 оны 72.6 хувиар тус тус үнэлэгджээ.

Үнэлгээний шалгуур, аргачлал ижил биш боловч ойролцоо агуулгаар хийгдсэн төрийн байгууллагын шударга байдлын талаарх дотоодын үнэлгээ болон Хэритэж сангийн гаргасан Засгийн газрын шударга байдлын үнэлгээгээр манай улсын авлигын индексийн үзүүлэлт ихээхэн ялгаатай байна.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 3-р хавсралтад хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тодорхойлсон. “Алсын хараа-2050”-ын “Засаглал” бүлгийн хүрэх үр дүнгийн нэг үзүүлэлтэд Дэлхийн банкны авлигын хяналтын үнэлгээг авч үзсэн бөгөөд 2018 оны үзүүлэлт болох 39.9-ийг суурь түвшин болгож доорх түвшинд хүрэх зорилт тавьжээ:

2025 он	2030 он	2050 он
47.2	58.3	96.5

Хэдийгээр 2025 онд авлигын хяналтын үнэлгээгээр 47.2 оноо авч, сайжрах зорилт тавьсан боловч бодит байдал дээр 35.38 болж суурь түвшингээс буурсан үзүүлэлттэй байна.

²⁶ Worldwide governance indicators, 2024, <https://www.worldbank.org/en/publication/worldwide-governance-indicators> (Сүүлд үзсэн: 2025.11.20)

²⁷ Control of corruption, 2024, <https://www.worldbank.org/content/dam/sites/govindicators/doc/cc.pdf>, (Сүүлд үзсэн: 2025.11.20)

²⁸ EIU report - Democracy index, 2025, <https://www.eiu.com/n/campaigns/>

democracy-index-2024/ (Сүүлд үзсэн: 2025.11.20)

²⁹ GWP – Gallup World Poll

³⁰ IDP – International Drivers of Corruption

³¹ PRC – Political risk services

Зураг 3. Кредендо групп: Монгол Улсын эрсдлийн үнэлгээ



1.4.1.2. Өмчийн эрх

Тухайн улсын хууль эрх зүйн тогтолцоо нь хувь хүмүүст хувийн өмчийг худалдан авах, эзэмших, ашиглах боломжийг хэр зэрэг олгодог, мөн эдгээр эрхүүдийг хууль ёсоор хамгаалж, засгийн газар үр дүнтэй хэрэгжүүлдэг эсэхийг үнэлдэг. Энэхүү үнэлгээг судалгааны мэдээлэл болон хараат бус үнэлгээнүүдийн хослолоор хийж тоон үзүүлэлт болгон хэмждэг гэжээ.

Монгол Улсын өмчийн эрхийн оноо 100 онооноос 49.7 байгаа нь дэлхийн дунджаас бага бөгөөд энэ үзүүлэлтдээ “дарлагдсан” эрх чөлөөний ангилалд байна. Өмчийн эрхийн баталгааг сайжруулах нь хөрөнгө оруулалт татах, бизнесийн орчныг тогтвортой болгох, эдийн засгийн өсөлтийг дэмжих чухал нөхцөл болдог.

Өмчийн эрхийн баталгааны үнэлгээнд 1) өмч хураах эрсдэл, 2) оюуны өмчийн хүлээн зөвшөөрөгдөх байдал, 3) өмчийн эрх, гэрээ болон хуулийн хэрэгжилтийн байдал гэсэн дэд шалгуур үзүүлэлтүүдийг харгалздаг байна.

1) Өмч хураах эрсдэл

Кредендо групп нь дэлхий даяар зээлийн даатгалын үйл ажиллагааг явуулдаг бөгөөд “Улс орнуудын эрсдэлийн үнэлгээ”-г хийдэг. Тухайн эрсдэлийн үнэлгээний 7

үзүүлэлтүүдийн 6-р хэсэгт өмч хураах эрсдэлийг үнэлдэг бөгөөд Хэритэж сан тухайн өгөгдлөөр энэ бүлгийг үнэлдэг байна.³⁶

Өмч хураах эрсдэл гэдэг ойлголт нь тухайн улсын засгийн газар зохих нөхөн төлбөргүйгээр хувийн өмчийг хорогдуулахад хүргэдэг бүх төрлийн үйл ажиллагааг хамардаг бөгөөд үүнд хориг арга хэмжээ, хууль эрх зүйн орчны өөрчлөлт, шударга ёсыг үгүйсгэх /denial of justice/ зэрэг багтдаг. Энэ эрсдэлийг үнэлэхийн тулд өмч хураан авахтай холбоотой нийт хүчин зүйлсээс гадна тухайн улсын хуулийн байгууллагуудын үйл ажиллагаа, гадаадын хөрөнгө оруулалтад хандах сөрөг хандлага зэрэг бусад нөхцөлийг ч мөн авч үздэг. Монгол Улс энэхүү эрсдэлийн үнэлгээгээр 7 онооноос 4 оноо авч “дундаж эрсдэлтэй” улсаар үнэлэгдэж байна.³⁷

Манай улсын хувьд Үндсэн хуулиар хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглож, төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө гэж өмчийн эрхийн хамгаалалтыг бататгасан.

Энэ зарчим Хөрөнгө оруулалтын тухай хууль, Дайчилгааны тухай хууль, Гамшгаас хамгаалах болон

³³ Авлигатай тэмцэх газрын 2022, 2023, 2024 оны тайлангаас

³⁴ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=211059&showType=1>

³⁵ The Heritage Foundation, 2025 Index of Economic Freedom, 2025, 12 дахь тал

³⁶ Credendo's country risk assessment, 2025, <https://credendo.com/en/credendos-country-risk-assessment#p3>, (Сүүлд үзсэн: 2025.11.20)

³⁷ Country risk – Mongolia, 2025, <https://credendo.com/en/country-risk/mongolia>, (Сүүлд үзсэн: 2025.11.28)

Онцгой байдлын тухай хуулиудад тусгагдсан бөгөөд хуульд заасны дагуу хувийн өмч, хөрөнгийг дайчилсан бол нөхөх төлбөр олгох учиртай.

“Хөрөнгө хураах” гэх ойлголт Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлийн 1-т “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг, эсхүл бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор гэмт хэргийн улмаас учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хувьд ногдох хөрөнгө, орлогоос албадан гаргуулна” гэж эрүүгийн хариуцлагын шүүхээс оногдуулах албадлагын арга хэмжээний нэг болж тусгагдсан. Энэ албадлагын арга хэмжээ авагдах хүртэл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуух ажиллагаа хийгдэж, гэм буруутай нь шүүхээр тогтоогдон “гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг эсхүл гэмт хэргийн хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах зорилгоор” хураах тул олон улсад хэрэглэдэг “due process” явагдсан гэж үзэж болох юм.

Дээр дурдсанаас бусад тохиолдолд “хувийн өмч”-ийг хууль бусаар, тухайлан төрөөс хураах, дайчлан авахгүй бөгөөд “хууль дээдлэх” зарчмыг баримтлах байдал өндөр байх тохиолдолд хувийн өмч хураагдах эрсдэл бага гэж үзэхээр байна.

Гэсэн хэдий ч шууд бусаар хөрөнгө хураах олон улсын нийтлэг хэлбэрүүдээс ашигт малтмалтай холбоотой эрх олгох зохицуулалтын тодорхойгүй байдал, эрүүгийн хэрэгт гуравдагч этгээдээр хязгаарлагдмал байдлаар

оролцож эрх, лицензээ хураалгах, татварын маргааны үед үнийн дүнгээр мөнгөн хөрөнгө байршуулах, татварын маргаан шийдвэрлэх процесс удаашралтай байдал зэргийг гадны хөрөнгө оруулагч, ажиглагчид дурдсаныг АНУ-ын Төрийн департаментын цахим хуудаст (Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчны талаарх мэдэгдэлд) онцолжээ. Олон улсад хөрөнгө хураах нийтлэг хэлбэрүүдийг тухайлсан зохицуулалттай буюу хэсэг бүлэг этгээдэд чиглэсэн татвар ногдуулах, лиценз болон зөвшөөрлийг тодорхой үндэслэлгүйгээр сунгахгүй байх, хуулиар тогтоосон хамгаалалтад гэнэт эсхүл тэгш бус агуулгатай өөрчлөлт оруулж хэсэг бүлэгт хохиролтой нөхцөл байдал үүсгэх, хүнд суртал гаргаж шийдвэр, зөвшөөрөл, төлбөр, төсөл хөтөлбөрийг удаашруулж бизнесийг боомилох болон бусад гэж тодорхойлдог байна.

Хөрөнгө гэдэг ойлголт өргөн цаг хүрээтэй бөгөөд эзэмшигч этгээддээ ашиг өгч байгаа эрх буюу “эдийн бус хөрөнгө” хамаарах, энэ эрхийг “төрөөс” үндэслэлгүй хүчингүй болгох, хугацааг сунгахгүй байх, чирэгдэл учруулах тохиолдол хөрөнгө хураах шууд бус хэлбэрт хамаарахаар байна.

Төрөөс олгож буй “эрх, зөвшөөрөл” нь Иргэний хуулийн 83.1, 84.5-д заасны дагуу эзэмшигч этгээддээ ашиг өгөх, эсхүл бусдаас шаардах эрх олгох эрх буюу шаардлага болж эдийн бус хөрөнгөд хамаарна. Манай улсад нийтлэг ашиглагдаж буй эрхүүдийн ойлголт, эрх үүсгэж буй хэлбэр дараах байдалтай байна.

Хүснэгт 5. Монгол улсад нийтлэг ашиглагдаж буй эрхийн төрөл

№	Эрхийн төрөл	Нэр томьёоны тодорхойлолт	Эрх олгож буй хэлбэр
1	Газар эзэмших	Газрын тухай хууль, 3.1.3. "газар эзэмших" гэж газрыг гэрээнд заасан зориулалт, нөхцөл, болзлын дагуу хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгахыг;	-Гэрээ -Хууль (хуулиар зөвшөөрсөн хүрээнд)
2	Газар ашиглах	Газрын тухай хууль, 3.1.4. "газар ашиглах" гэж хуулиар зөвшөөрсөн хүрээнд газар өмчлөгч, эзэмшигчтэй байгуулсан гэрээнд заасны дагуу газрын аль нэг ашигтай чанарыг нь гаргаж хэрэглэхийг;	-Гэрээ -Хууль (хуулиар зөвшөөрсөн хүрээнд)
3	Хайгуулын тусгай зөвшөөрөл	Ашигт малтмалын тухай хууль, 4.1.15. "хайгуулын тусгай зөвшөөрөл" гэж энэ хуулийн дагуу ашигт малтмал эрэх, хайх эрх олгосон баримт бичгийг;	-Тусгай зөвшөөрөл -Хууль
4	Ашиглалтын тусгай зөвшөөрөл	Ашигт малтмалын тухай хууль, 4.1.16. "ашиглалтын тусгай зөвшөөрөл" гэж энэ хуулийн дагуу ашигт малтмал ашиглах эрх олгосон баримт бичгийг;	-Тусгай зөвшөөрөл -Хууль
5	Зөвшөөрөл	Зөвшөөрлийн тухай хууль, 1.1. "зөвшөөрөл" гэж зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдээс хуульд заасан хугацаа, нөхцөл, шаардлагын дагуу тодорхой үйл ажиллагааг эхлүүлэх, эсхүл байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглуулахаар олгосон эрхийг;	- Зөвшөөрөл -Хууль

³⁸ АНУ-ын Төрийн департаментын цахим хуудас: <https://2021-2025.state.gov/reports/2024-investment-climate-statements/mongolia/>

³⁹ Иргэний хууль, 83.1. Аливаа этгээд нь хуулиар хориглоогүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлахгүйгээр эдийн баялаг болох эд юмс болон эдийн бус баялаг болох оюуны үнэт

зүйлс, эрхийг олж авч болох бөгөөд энэ тохиолдолд дээрх баялаг нь хөрөнгө болно.

⁴⁰ Иргэний хууль, 84.5. Эзэмшигч этгээддээ ашиг өгөх, эсхүл бусдаас шаардах эрх олгох эрх буюу шаардлага, оюуны үнэт зүйл нь эдийн бус хөрөнгөд хамаарна.

Дээрх эрх, зөвшөөрлүүд нь хөрөнгийн нэг төрлийн хувьд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчид үйл ажиллагаагаа явуулах нөхцлийг бүрдүүлж, зарим тохиолдолд “гол” эх үүсвэр нь болж байгаа ба төрөөс эрхийг олгож буй гэрээ, төр болон аж ахуй эрхлэгчийн хооронд “гэрээ”-ний нэгэн адил тухайн харилцаанд баримталж буй “хууль тогтоомж”-оо дагаж мөрдөхгүй байх, эсхүл хууль тогтоомж тодорхойгүйн улмаас эдгээр “эрх, зөвшөөрөл”-ийн найдвартай байдал, урт хугацаанд эх үүсвэр болох байдал баталгаагүй болно. Нэг жишээ дурдахад, Газрын тухай хуульд газар ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээдэд нөхөх олговор хамаарахгүй гэж заасан нь баталгаа хангагдахгүй байхыг хуульчилсан болж байна.

2) Оюуны өмчийн эрхийг хүндэтгэх байдал

АНУ-ын Худалдааны танхим болон Олон улсын инновагийн бодлогын төвөөс хамтран “Олон улсын оюуны өмчийн индекс” тайланг гаргадаг бөгөөд 2025 онд дэлхийн 55 орныг нийт 10 бүлэг 53 индикатор үзүүлэлтээр үнэлж, оюуны өмчийг хүндэтгэх байдлаар эрэмбэлэн гаргасан. Үнэлгээний үзүүлэлтийн нарийвчилсан задаргааг харуулбал:

Бүлэг 1: Патентын эрх болон хязгаарлалтууд

1. Патентын хамгаалалтын хугацаа
2. Патентын шаардлага
3. Компьютер дээр суурилсан бүтээлийн патентлагдах боломж
4. Ургамлын сортын хамгаалалт
5. Эмийн салбарт холбогдох патентын эрхүүд
6. Патентын хэрэгжилтийн механизм
7. Эмийн салбарт холбогдох патентын эрхүүд, хэрэгжилт
8. Patent Prosecution Highway-ын гишүүнчлэлд байдаг эсэх
9. Патентын эсэргүүцэл

Бүлэг 2: Зохиогчийн эрх болон хязгаарлалтууд

10. Хамгаалалтын хугацаа
11. Онцгой эрхүүд
12. Хууль ёсны арга хэмжээ авч зөрчилтэй контентыг онлайнаар хаах
13. Онлайн хулгайн эсрэг хамтын ажиллагаа
14. Хязгаарлалтууд болон онцгой тохиолдлууд
15. Технологийн хамгаалалтын арга /TRM/ болон дижитал эрхийн менежмент
16. Засгийн газрын лицензтэй программ хангамжийн хэрэглээ

Бүлэг 3: Барааны тэмдгийн эрх ба хязгаарлалтууд

17. Хамгаалалтын хугацаа
18. Олонд танигдсан тэмдгийн /well-known marks/ хамгаалалт
19. Онцгой эрхүүд, барааны тэмдэг
20. Онлайнаар хуурамч бараа борлуулалтын эсрэг зохицуулалт

Бүлэг 4: Дизайны эрх ба хязгаарлалтууд

21. Үйлдвэрлэлийн дизайны хамгаалалтын хугацаа
22. Онцгой эрх, үйлдвэрлэлийн дизайны эрх

Бүлэг 5: Худалдааны нууц болон нууцлалтай мэдээллийн хамгаалалт

23. Худалдааны нууцын хамгаалалт (иргэний арга хэмжээ)
24. Худалдааны нууцын хамгаалалт (эрүүгийн хориг)
25. Нууцлалтай мэдээллийг хамгаалах хугацаа

Бүлэг 6: Оюуны өмчийн хөрөнгийг арилжаалах

26. Зах зээлд нэвтрэх саад
27. Технологи дамжуулах саад
28. Лицензийн гэрээний бүртгэл болон нууцлалын шаардлага
29. Лицензийн нөхцөлийг тогтоох төрийн шууд оролцоо
30. Оюуны өмчийг эдийн засгийн хөрөнгө гэж үзэх
31. Оюуны өмчийн хөрөнгө бий болгоход үзүүлэх татварын урамшуулал

Бүлэг 7: Хууль, эрх зүйн хэрэгжилт

32. Биет хуурамч барааны түвшин
33. Программ хангамжийн хулгайн түвшин
34. Иргэний болон процессын арга хэмжээ
35. Урьдчилан тогтоосон хохирлын нөхөн төлбөр
36. Эрүүгийн стандартууд
37. Үр дүнтэй хил гаалийн арга хэмжээ
38. Гаалийн байгууллагын ил тод байдал, олон нийтэд тайлагнах

Бүлэг 8: Системийн үр ашиг

39. Оюуны өмчийн эрхийн хэрэгжилтийн уялдаа холбоо
40. Оюуны өмчийг хамгаалах бодлого боловсруулахад оролцогч талуудтай зөвшилцөх
41. Боловсролын кампанит ажлууд болон мэдлэг, мэдээлэл түгээх
42. ЖДҮ оюуны өмчийн хөрөнгө бий болгох, ашиглахад

³⁸ АНУ-ын Төрийн департаментын цахим хуудас: <https://2021-2025.state.gov/reports/2024-investment-climate-statements/mongolia/>

³⁹ Иргэний хууль, 83.1.Аливаа этгээд нь хуулиар хориглоогүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлахгүйгээр эдийн баялаг болох эд юмс болон эдийн бус баялаг болох оюуны үнэт

зүйлс, эрхийг олж авч болох бөгөөд энэ тохиолдолд дээрх баялаг нь хөрөнгө болно.

⁴⁰ Иргэний хууль, 84.5.Эзэмшигч этгээддээ ашиг өгөх, эсхүл бусдаас шаардах эрх олгох эрх буюу шаардлага, оюуны үнэт зүйл нь эдийн бус хөрөнгөд хамаарна.

зориулсан урамшуулал

43. Оюуны өмчид суурилсан салбаруудын эдийн засгийн нөлөөллийн шинжилгээ

Бүлэг 9: Шинэлэг инновацийн урамшуулал

44. Ховор эмийн бүтээгдэхүүн хөгжүүлэхэд зориулсан оюуны өмчийн урамшуулал

45. Ховор эмийн бүтээгдэхүүн хөгжүүлэхэд зориулсан оюуны өмчийн урамшууллын хамгаалалтын хугацаа

46. Ховор эмийн бүтээгдэхүүн хөгжүүлэхэд зориулсан одоогийн оюуны өмчийн урамшууллыг ашиглах хязгаарлалт

Бүлэг 10: Олон улсын гэрээний гишүүнчлэл ба батламж

47. WIPO интернэтийн гэрээ

48. Барааны тэмдгийн тухай Сингапурын гэрээ ба Мадридын протокол

49. Патентын тухай хууль болон Патентын хамтын ажиллагааны гэрээ

50. Ургамлын шинэ сортыг хамгаалах олон улсын конвенц (1991 оны акт)

51. Кибер гэмт хэргийн тухай конвенц (2001)

52. Аж үйлдвэрийн дизайны олон улсын бүртгэлийн тухай Гаагийн гэрээ

53. TRIPS дараах Чөлөөт худалдааны хэлэлцээр

Дээрх үнэлгээнд хамрагдсан 55 улсын дунд Монгол Улс багтаагүй бөгөөд оюуны өмчийг хүндэтгэх байдлын олон нийтэд нээлттэй оноо байхгүй байна.

Монгол Улс Дэлхийн оюуны өмчийн байгууллагын гишүүн бөгөөд оюуны өмчтэй холбоотой Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай, Зохиогчийн эрхийн тухай, Оюуны өмчийн тухай, Патентын тухай, Инновацийн тухай болон Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулиуд хүчин төгөлдөр үйлчилж байна.

Европын холбоо, АНУ-ын хамтарсан мэдээлэл солилцох хамтарсан хөтөлбөрийн цахим хуудаст⁴³ 2017 оны байдлаар дотоодын зах зээлийн 85 хувь нь албан ёсны эрхгүй программ хангамж ашигладаг, хулгайн медиа, уран бүтээлийн худалдаа ихтэй, орон нутгийн телевизүүд нь зөвшөөрөлгүй контент түгээдэг гэсэн байна. Энэ нь 8 жилийн өмнөх мэдээлэл бөгөөд сүүлийн үед манай улсад албан ёсны эрхтэй программ хангамжийн ашиглалт, кино, дэлгэцийн уран бүтээлийг албан ёсны эрхтэй этгээд, платформ ашиглан үзэх хандлага нэмэгдэж байгаа.

Гэсэн хэдий ч оюуны өмч, өмчийн эрхийг хүндэтгэх олон нийтийн хандлага, хэрэглээний талаар хийгдсэн дотоодын үндэслэл бүхий судалгаа, мэдээлэл хомс байна.

3) Өмчийн эрх, гэрээний хэрэгжилт, хуулийн хэрэгжилт

Энэ хүчин зүйлийг Дэлхийн банкны засаглалын үзүүлэлт (энэ судалгааны 19 дүгээр талд дурдсан)-ийн 5-р бүлэг болох “Хуулийн засаглал”-ын оноогоор хэмждэг. Хуулийн засаглал нь нийгэм буюу иргэд хууль дүрмийг мөрдөх, тэдгээрт итгэх түвшний талаарх ойлголтыг илэрхийлдэг. Ялангуяа гэрээний хэрэгжилтийн чанар, өмчийн эрх, цагдаа болон шүүхийн байгууллагын чадавх, мөн гэмт хэрэг, хүчирхийлэл гарах магадлалыг хамааруулан судалдаг.

Энэхүү өмчийн эрх, гэрээ болон хуулийн хэрэгжилтийг бүлгийг дараах 5 байгууллагуудын тус бүрт дурдсан үнэлгээ, судалгаа, мэдээллийг нэгтгэн дүн шинжилгээ хийж гаргадаг байна.

EIU (Economist Intelligence Unit) ⁴⁴

- Хүчирхийллийн гэмт хэрэг
- Зохион байгуулалттай гэмт хэрэг
- Шүүхийн шударга байдал
- Гэрээний хэрэгжилт
- Шүүх ажиллагааны хурд
- Өмч хураан авах
- Оюуны өмчийн эрхийн хамгаалалт
- Хувийн өмчийн хамгаалалт

Дэлхийн өрсөлдөх чадварын судалгаа (Global Competitiveness Survey)

- Гэмт хэрэг, хүчирхийллээс үүдэх бизнесийн зардал
- Зохион байгуулалттай гэмт хэрэг
- Шүүхийн хараат бус байдал
- Зохицуулалтад нөлөөлөх хууль эрх зүйн тогтолцооны үр ашиг
- Оюуны өмчийн хамгаалалт
- Өмчийн эрх

GWP (Gallup World санал асуулга):

- Цагдаагийн байгууллагад итгэх итгэл
- Шүүхийн тогтолцоонд итгэх итгэл
- Өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хулгайд өртсөн байдал
- Дээрэмдүүлэх болон халдлагад өртсөн байдал

IPD (Institutional Profiles Database):

- Бараа бүтээгдэхүүн болон хүний аюулгүй байдлын түвшин
- Зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн хүчирхийллийн үйл ажиллагаа (хар тамхи, зэвсэг, биеэ үнэлэлт...)

⁴¹ Газрын тухай хууль, 43.6.Нөхөх олговор нь газар ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хамаарахгүй.

⁴² U.S Chamber of Commerce, “International IP Index 2025 Thirteenth Edition”, 2025, 73 дахь тал

⁴³ Европын холбоо, АНУ-ын хамтарсан мэдээлэл солилцох хамтарсан

хөтөлбөрийн цахим хуудас: <https://www.privacyshield.gov/ps/article?id=Mongolia-Protection-of-Property-Rights>

⁴⁴ Rule of Law, 2024, <https://www.worldbank.org/content/dam/sites/govindicators/doc/r1.pdf>, (Сүүлд үзсэн: 2025.11.20)

- Шүүхийн төрөөс хараат бус байдлын түвшин
- Шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх түвшин
- Шүүхийн шийдвэрийн цаг хугацааны баримтлал
- Гадаадын иргэдтэй хуульд үндэслэн дотоод иргэдтэй адил тэгш хандах байдал
- Татварын зөрчлийг хязгаарлах захиргааны бодит чадвар
- Хувийн өмчийн эрхийг хамгаалах хууль эрх зүйн хэрэгслийн үр ашиг (хувийн хэвшлийн талуудын хооронд)
- Төр хувийн өмчид дур мэдэн дарамт үзүүлэх байдал (хэт их бичиг цаас...)
- Дотоодын хөрөнгө оруулагч/ талууд дунд гэрээний нөхцөлийг мөрдөх түвшин
- Дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагч/ талууд дунд гэрээний нөхцөлийг мөрдөх түвшин
- Худалдааны нууц, аж үйлдвэрийн патенттай холбоотой оюуны өмчийн эрхийг хүндэтгэх байдал
- Хуурамч бүтээгдэхүүнтэй холбоотой оюуны өмчийн эрхийг хүндэтгэх байдал
- Төр газар өмчлөх системийн олон янзын байдлыг албан ёсоор хүлээн зөвшөөрдөг эсэх


WMO (World Meteorological Organization)

- **Өмч хураах:** Төр эсвэл бусад улс төрийн эрх бүхий байгууллага дотоодын болон гадаадын хувийн бизнесийн хөрөнгийг хураах, улсын болгох, өмч хураах эрсдэл.
- **Төрийн гэрээний өөрчлөлт.** Засгийн газар эсвэл төрийн байгууллага хувийн талуудтай байгуулсан гэрээний нөхцөлийг өөрчлөх, бүрэн цуцлах, эсвэл хууль ёсны журмыг баримтлахгүйгээр удаашруулж саад хийх эрсдэл
- **Гэрээний хэрэгжилт.** Шүүхийн тогтолцоо дотоодын болон гадаадын хувийн талуудын хооронд байгуулсан гэрээг үр дүнтэй хэрэгжүүлэхгүй байх эрсдэл (үр ашиггүй байдал, авлига, хандлага, шийдвэрийг цаг тухайд нь хэрэгжүүлэх чадваргүй байдал) зэрэг олон талын эх сурвалжуудыг ашиглан оноо өгч эрэмбэлдэг байна.

Монгол Улс хуулийн засаглалын үзүүлэлтээр 2023 онд 43.87 оноо авч 215 улсаас 120-р байранд эрэмбэлэгдэж байна. Хуулийн засаглалын үзүүлэлтийг он цагийн дарааллаар харуулахад оноо буурч байгаа нь анзаарагдаж байна.

Манай улсын өмчийн эрх, хамаарах эрх зүйн зохицуулалтын хувьд Үндсэн хуулиар оюуны өмч,

График 4. Монгол Улсын хуулийн засаглалын үзүүлэлт: 1996-2024



түүний үр шимийг хүртэх, төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрөх, иргэн хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй зэргээр бүх төрлийн өмчийн хэлбэр (өмчлөгч)-ийг хүлээн зөвшөөрч, хуулиар хамгаалах зарчмыг тунхагласан. Манай улсад иргэн, хуулийн этгээд шударгаар өмч, хөрөнгө олж авах, бүтээх, эзэмших, ашиглах эрхтэй.

Эдийн болон эдийн бус хөрөнгөтэй холбоотой, иргэн, хуулийн этгээд өмч хөрөнгө олж авах, өмчлөх, эзэмших, ашиглах эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцаанд Иргэний хууль тэргүүтэй Компанийн тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай, Нотариатын тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай болон хувийн эрх зүйн хуулиуд үйлчилж байна. Мөн Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийг 2022 онд шинэчлэн баталж бүх төрлийн хөрөнгөд үнэлгээ хийх харилцааг, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийг 2015 онд баталж эдийн бус буюу оюуны өмчийг барьцаалах харилцааг зохицуулж эдийн засгийн үр шимийг хүртэж эхэлсэн.

Дээр дурдсанчлан Үндсэн хуулиар өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална гэж үндсэн зарчмыг тодорхойлсон бөгөөд энэ эрхийг баталгаажуулж Иргэний хуулиар эдийн болон эдийн бус хөрөнгө, хөрөнгийн үр шим, эзэмшил, өмчлөл, өмчлөх эрхийн зохицуулалт, иргэний журмаар эрхээ хамгаалах заалтууд тусгагдсан. Эрүүгийн хуульд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргүүдийг хулгайлах, дээрэмдэх, залилах, завших, заналхийлэх, устгах, эвдэх болон шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын патент эзэмшигчийн эрхийг зөрчих болон бусад байдлаар зүйлчилж зохицуулсан. Мөн Зөрчлийн тухай хуулиар өмчлөх эрхийн эсрэг эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй зөрчилд хариуцлага ногдуулахаар заасан.

⁴⁵ УХ, “Иргэний туурвисан оюуны үнэт зүйл бол зохиогчийнх нь өмч”, “төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрөх”, “иргэн хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах,

эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй.”; “соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй. Зохиогч, шинэ бүтээл, нээлтийн эрхийг хуулиар хамгаална;

Хөрөнгө шилжүүлэхэд төрөөс хамааралтай бүртгэлийн болон баталгаажуулалт (нотариат)-ын шаардлага үл хөдлөх эд хөрөнгө, тээврийн хэрэгсэл болон эдийн бус хөрөнгө буюу зарим “эрх, хувьцаа”-ны хувьд хуулиар тавигдаж, тодорхой хэмжээний шаардлага, үйлчилгээний хураамж, хугацаа шаарддаг боловч энэ нь дэлхий дахинаа нийтлэг явдал юм. Хөрөнгийн шилжүүлгийн хувьд төрийн үйлчилгээний чанарын болон албан татвар (орлогын)-ын асуудал хөндөгддөг.

Өмчийн харилцааны талаарх манай улсын нэг онцлог нь Манай Улсын Үндсэн хуульд “нийтийн өмч” гэх ойлголт байх ба “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн” гэж заасан. Үүнийг дагалдаад нийтийн өмч, түүний ашиглалт, зөвшөөрөлтэй холбоотой 12 хууль үйлчилж байна. Байгалийн баялаг ихтэй манай улсын хувьд ашигт малтмалын салбарт дотоодын төдийгүй гадаадын хөрөнгө оруулагчид ихээр татагддаг бөгөөд эдгээр нийтийн өмчийг ашиглах эрхтэй холбоотой харилцааны зохицуулалт тогтворгүй, улс төрийн нөлөөлөл, оролцоо ихтэй байсаар ирсэн. Энэ үйл явцын үр дүнд 2019 онд Үндсэн хуулинд “Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ. Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэсэн нэмэлтийг оруулж дагалдах хуулиудыг 2024 оноос батлан мөрдөж эхлээд байна.

Үүний зэрэгцээ Үндсэн хууль дахь “аж ахуйн бүх хэвшил” гэх ойлголт, Иргэний хуульд хуулийн этгээд нь нийтийн, хувийн, холимог өмчийн байж болохыг заасны дагуу “төрийн өмчит хуулийн этгээд”-үүд манай улсын эдийн засгийн банк, эрчим хүч, ашигт малтмал зэрэг салбарт оролцдог. Манай улсын эдийн засгийн дийлэнх хэсгийг бүрдүүлдэг “ашигт малтмал, түүнд хамаарах эрх”-ийн өмчлөгч төр өөрөө байхаас гадна ашигт малтмалын салбарт төрийн өмчийн компаниуд үйл ажиллагаагаа явуулж дотоодын нийт бүтээгдэхүүний 40-50 хувийг бүрдүүлж байгаа тохиолдолд төр Үндсэн хуульд заасны дагуу эдийн засгийн харилцаанд зохицуулалт хийж байгаа гэхээсээ илүүтэй оролцож байна гэж үзэхээр байна.

1.4.1.3. Шүүхийн үр нөлөө

Шүүхийн үр нөлөө гэдэг нь хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлж, зөрчлийг зохих ёсоор шийдвэрлэх үр ашигтай, шударга шүүхийн тогтолцоог тоон утгаар илэрхийлдэг. 1) Шүүхийн хараат бус байдал, 2) шүүх үйл явцын чанар, 3) төрийн үйлчилгээний чанар болон 4) төрийн албаны хараат бус байдал гэсэн дэд бүрэлдэхүүн хэсгээр үнэлгээг өгдөг.

Шүүхийн хараат бус байдлыг үнэлэхдээ Freedom house байгууллагын “Дэлхийн эрх чөлөө” тайлангийн үнэлгээнээс дараах 5 үзүүлэлтийг авч үздэг байна.⁴⁶ Үүнд:

- Шүүх нь гүйцэтгэх засаглал болон улс төр, эдийн засаг, шашны нөлөөллөөс ангид ажиллаж чадаж байгаа эсэх
- Шүүгчдийг шударга, хөндлөнгийн нөлөөгүйгээр томилж, чөлөөлдөг эсэх
- Шүүгчид авлига, улс төрийн дарамт, ашиг сонирхлын зөрчилгүйгээр шийдвэр гаргадаг эсэх
- Засгийн газрын байгууллагууд шүүхийн шийдвэрийг хүндэтгэж, хэрэгжүүлдэг эсэх
- Өрсөлдөх чадвартай, тэргүүлэх аж ахуй нэгж, компаниуд шүүхийн шийдвэрийг дагаж мөрддөг эсэх юм.

Шүүхийн үр нөлөөг хэмжих бусад дэд хүчин зүйлсийг Дэлхийн банкны засаглалын үзүүлэлтийн мэдээлэл дээр үндэслэн үнэлдэг. “Дэлхийн эрх чөлөө” тайлангийн үнэлгээгээр манай улс 100 онооноос 84 оноо авч “Эрх чөлөөтэй” ангилалд багтсан хэдий ч шүүхийн шударга байдлын үнэлгээнд 4 онооноос 2 оноо авч бусад үзүүлэлтүүдээс доогуур үнэлэгдсэн байна.

Хөгжиж буй орнуудын хувьд, шүүхийн үр нөлөө нь эдийн засгийн өсөлтийн суурийг тавих хамгийн чухал үзүүлэлт байдаг бол хөгжингүй орнуудад шүүхийн үр нөлөөнөөс хазайх нь эдийн засгийн уналт руу хөтлөх ноцтой асуудлын эхлэл болж болдог гэж Хэритэж сангийн ЭЗЭЧИ-д дүгнэсэн байна. Мөн тэнд олон улсын жишгээр шударга, эрх тэгш, үр нөлөөтэй шүүхийн тогтолцоо нь иргэн, хуулийн этгээдийг чадавхжуулах, ялгаварлан гадуурхалтыг таслан зогсоох, өрсөлдөөнийг нэмэгдүүлэхэд чухал хүчин зүйлс болдог гэжээ.


Монгол Улсын ЭЗЭЧИ-ийн шүүхийн үр нөлөөтэй байдлын үзүүлэлтээр 55.4 оноогоор үнэлэгдэж “ихэвчлэн эрх чөлөөгүй” ангилалд орж байна.

Бүлгийн явцын дүгнэлт:

Дээрх 3 дэд үзүүлэлт бүхий Хуулийн засаглал бүлгийн эдийн засгийн эрх чөлөөний индексийн үзүүлэлтүүдийг сүүлийн 30 жилийн өөрчлөлтөөр графикийн дагуу харууллаа.

⁴⁶ Freedom in the World 2025 Methodology Questions, 2025, <https://freedomhouse.org/reports/freedom-world/freedom-world-research-methodology>, (Сүүлд үзсэн: 2025.12.02)

График 5. Хуулийн засаглал бүлэг



Heritage Foundation-аас “Монгол Улсад хууль эрх зүйн орчин сул, тогтолцооны авлига, шүүхийн хараат бус байдал хангалтгүй зэрэг шалтгаанаар энэ үзүүлэлт дэлхийн дунджаас доогуур, хуулийн засаглалын ерөнхий тогтолцоо сул байна. Өмчийн эрхийн оноо дэлхийн дунджаас доогуур, шүүхийн үр нөлөө дэлхийн дунджаас дээгүүр, засгийн газрын шударга байдлын оноо дэлхийн дунджаас доогуур үзүүлэлттэй байна” гэсэн ерөнхий дүгнэлт гаргажээ.

1.4.2. Дунджаас доогуур үзүүлэлттэй индекс

1.4.2.1. Худалдааны эрх чөлөө

Худалдааны эрх чөлөө гэдэг нь тухайн улсын тарифын болон тарифын бус саад тотгорууд нь бараа, үйлчилгээний импорт, экспортод хэрхэн нөлөөлж байгааг хэмждэг нийлмэл үзүүлэлт юм. Тарифын бус саад нь худалдааг хязгаарлах дүрэм журам, бодлого, зохицуулалт юм. Үүнд:

а. Тоо хэмжээний хязгаарлалт: Импортын квот, экспортын хязгаарлалт, сайн дурын экспортын хязгаарлалт, импорт/экспортын хориг, хориглосон бараа, харилцан худалдаа гэх мэт,

б. Зохицуулалтын хязгаарлалт: Зөвшөөрөл /лиценз/, импортын бүтээгдэхүүнд дотоодын орц, материал, хөдөлмөр, технологи ашиглах шаардлага, Эрүүл ахуй, ургамал хамгааллын стандарт (SPS), Аюулгүй байдал, үйлдвэрлэлийн стандарт, Сав баглаа боодол, шошго, барааны тэмдэг, Зар сурталчилгаа, медиа зохицуулалт,

в. Гаалийн хязгаарлалт: Урьдчилсан төлбөрийн шаардлага, гаалийн үнэлгээний журам, гаалийн ангиллын журам, гаалийн бүрдүүлэлтийн журам,

г. Төрийн шууд оролцоо: Татаас, тусламж, үйлдвэрлэлийн бодлого, төрөөс санхүүжүүлсэн судалгаа, технологийн бодлого, өрсөлдөөний бодлого, төрийн худалдан авалт, төрийн худалдаа, төрийн монополь, онцгой эрх зэрэг багтана.

Худалдааны эрх чөлөөг импортын жингээр тооцсон дундаж тарифын хувь, тарифын бус саадад хийсэн чанарын үнэлгээгээр тооцдог.

Манай улсад худалдааны асуудал хариуцсан төрийн байгууллагын хувьд хамгийн сүүлд Засгийн газрын 2025 оны 7 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан яамдын зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн дагуу Эдийн засаг, хөгжлийн яаманд Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газартай, Гадаад харилцааны яаманд олон улсын худалдаа, эдийн засгийн хэлтэстэй байхаар тус тус баталж, Эдийн засаг, хөгжлийн яамны үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлд “хоёр болон олон талт эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, гадаад, дотоод худалдааны бодлогыг тодорхойлж, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар хангах, эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийг тодорхойлох, тохиролцох” гэжээ.

Өргөн хүрээг хамрах худалдааны харилцаа Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Гаалийн тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай, Онцгой албан татварын тухай, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай, Чөлөөт бүсийн тухай хууль болон бусад салбар хууль, УИХ, ЗГ-ын тогтоол, стандартуудаар зохицуулагдаж байна. Түүнчлэн Монгол Улсын байгуулсан олон улсын гэрээнүүд хамаарна. Худалдааны тухай бие даасан хуультай болох эсхүл энэ салбарт баримтлах зарчмуудыг Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуульд тусгах боломжтой юм.

Дэлхийн банкны Монгол Улсын гадаад худалдааны өрсөлдөх чадварын шинжилгээ 2024 оны тайланд дурдсанаар ижил төстэй улс орнуудтай харьцуулахад худалдааны харьцангуй нээлттэй дэглэмтэй хэдий ч далайд гарцгүй, газарзүйн хувьд алслагдсан, өргөн уудам нутагтай Монгол Улс худалдааг хөгжүүлэх чиглэлд өвөрмөц сорилтуудтай тулгардаг. Үүнээс гадна дэд бүтцийн болон логиستيкийн чиглэлээр үүсэх хязгаарлалтууд, олон улсын бараа, бүтээгдэхүүнд тавигдах стандарт шаардлагын хангалт сул байгаа зэрэг нь эдгээр сорилтуудыг улам гүнзгийрүүлж байна гэжээ.

Монгол Улсын худалдааны эрх чөлөөний үзүүлэлт нь 74.4 оноогоор үнэлэгдэж “ихэвчлэн эрх чөлөөтэй” ангилалд багтаж байна.

⁴⁷ The Heritage Foundation, 2025 Index of Economic Freedom, 2025, 401 дэх тал

1.4.2.2. Хөрөнгө оруулалтын эрх чөлөө

Эдийн засгийн эрх чөлөөтэй оронд хөрөнгө оруулалтын капиталын урсгалд ямар ч хязгаарлалт байхгүй. Хувь хүн, аж ахуйн нэгжүүд дотоод болон гадаадын зах зээлд чөлөөтэй хөрөнгө оруулалт хийх, татах, шилжүүлэх боломжтой байдаг.

Ихэнх улс орнууд хөрөнгө оруулалтад янз бүрийн хязгаарлалт тавьдаг. Үүнд:

- Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын ялгаатай зохицуулалт,
- Гадаад валютын орох, гарах урсгалын хязгаарлалт,
- Төлбөр, шилжүүлэг, капиталын гүйлгээний хяналт,
- Зарим салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг хориглох зэрэг багтана.

Хөрөнгө оруулалтын эрх чөлөөг үнэлэх хүчин зүйлс нь гадаадын хөрөнгө оруулагчид хандах зарчим, хөрөнгө оруулалтын хууль журам, газар өмчлөх хязгаарлалт, салбарын хөрөнгө оруулалтын хязгаарлалт, шударга нөхөн олговоргүй хөрөнгө хураах, гадаад валютын хяналт, хөрөнгийн зохицуулалт, төрийн бодлогоос үүдэлтэй тогтворгүй байдал зэргийг үнэлж тооцоолдог.

Хөрөнгө оруулалтын эрх чөлөөний үр өгөөжийг зөвхөн хөрөнгө оруулагч компаниуд бус нийгэм бүхэлдээ хүртдэг. Энэ нь бусад хүчин зүйлсээс илүү эдийн засгийн идэвхийг өргөжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэн, ажлын байруудыг бий болгодог.

Үр дүнтэй хөрөнгө оруулалтын тогтолцоо нь ил тод, шударга, томоохон эсвэл стратегийн ач холбогдолтой компаниудаас гадна бүх төрлийн бизнесийг дэмждэг, инноваци, өрсөлдөөнийг урамшуулдаг.

Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын урсгалыг

хязгаарлах нь нөөцийн үр ашигтай хуваарилалтыг алдагдуулж, бүтээмжийг бууруулж, эдийн засгийн үндэслэлтэй шийдвэр гаргалтыг гажуудуулдаг. Харин хувь хүн, аж ахуй нэгж хаана, хэрхэн хөрөнгө оруулахаа чөлөөтэй сонгох боломжтой үед хөрөнгө хамгийн үр ашигтай салбар, үйл ажиллагаанд чиглэж зах зээлийн зарчмаар хөгжих боломжийг олгодог.

Монгол Улсын хөрөнгө оруулалтын эрх чөлөөний үзүүлэлт нь 50 оноогоор үнэлэгдэж “ихэвчлэн эрх чөлөөгүй” ангилалд багтсан байна. (Хүснэгт 6)

Монгол Улс дахь АНУ-ын ЭСЯ-аас “Монгол Улс хууль эрх зүйн хувьд хөрөнгө оруулагчдад нээлттэй, эрх тэгш орчин бүрдүүлэхийг зорьж байгаа ч бодит хэрэгжилт, захиргааны тогтолцоо, шүүхийн үр ашиг, улс төрийн тогтворгүй байдал зэрэг хүчин зүйлс хөрөнгө оруулагчдын итгэлд нөлөөлж байна. Хөрөнгө оруулагчдад тулгардаг практик сорилтууд нь:

1. Шүүхийн шийдвэрлэлт удаан, маргаан шийдвэрлэх тогтолцоо сул,
2. Захиргааны байгууллагуудын хяналт, шалгалт урьдчилан таамаглах боломжгүй, зарим тохиолдолд дарамт үүсгэдэг,
3. Татварын хяналт өндөр, төлбөр тооцоог албадан гаргуулах эрсдэлтэй,
4. Төрийн өмчит компаниудад давуу тал үүсгэх хандлага ажиглагддаг,
5. Засгийн газар газар гадаадын хөрөнгө оруулалтын төсөл дээр батлан даалт гаргах, хамтран санхүүжүүлэх боломжтой байдаг ч практик дээр хэрэгжүүлдэггүй” зэргийг дурджээ.

Дээрхээс гадна манай улсын хөрөнгө оруулалтын орчинд сөргөөр нөлөөлж буй нэг асуудал нь “гадаадын хөрөнгө

Хүснэгт 6. ЭЗЭЧИ-ийн хөрөнгө оруулалтын орчныг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд:

№	Шалгуур үзүүлэлт	Хуулийн зохицуулалт
1	Хөрөнгө оруулалтын хязгаарлалт	Хөрөнгө оруулагч нь Монгол Улсын хууль тогтоомжоор хориглосноос бусад салбар, үйлдвэрлэл, үйлчилгээнд хөрөнгө оруулалт хийж болно.
2	Гадаадын хөрөнгө оруулалтад үзүүлэх үндэсний таатай нөхцөл	Хөрөнгө оруулалтын тухай хуулиар гадаад болон дотоодын хөрөнгө оруулалт ижил зохицуулалттай. Татварын болон татварын бус дэмжлэгийг Хөрөнгө оруулалтын гэрээ, Тогтворжуулах гэрчилгээний дагуу эдэлнэ.
3	Газартай холбоотой хязгаарлалт	Зөвхөн Монгол Улсын иргэн өмчлөх эрхтэй бөгөөд хуулийн этгээд, гадаадын улсын иргэн, харьяалалгүй этгээд газрыг тодорхой төлбөр, хугацаатайгаар ашиглах эрхтэй байхаар Үндсэн хуульд заасан.
4	Хөрөнгө оруулалтын салбарын хязгаарлалт	Гадаадын төрийн өмчит хуулийн этгээдийн хувьд дээр дурдсан салбаруудад зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа эрхэлнэ.
5	Зохих ёсны нөхөн төлбөргүйгээр хөрөнгө оруулалтыг хураах	Хөрөнгө оруулалтын тухай хууль
6	Валют арилжааны хяналт	Хөрөнгө оруулалтын тухай хууль
7	Хөрөнгийн хяналт	Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу, жишээлбэл, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хүрээнд гүйлгээ, хөрөнгийн эх үүсвэрийг нягтлах зэргээс бусдаар тухайлсан хөрөнгө оруулагчийн хөрөнгийг хянах зохицуулалт байхгүй.

⁴⁸ Дэлхийн банкны цахим хуудас: <https://www.worldbank.org/mn/news/press-release/2024/01/22/mongolia-can-spur-economic-diversification-by-removing-trade-constraints>

⁴⁹ The Heritage Foundation, 2025 Index of Economic Freedom, 2025, 402 дахь тал

оруулагч”-ийг гэмт хэрэгт холбогдуулан мөрдөн шалгах, цаашлаад шүүхээр ял ногдуулах, нэгдүгээр бүлэгт дурдсан өмчийн эрхийн хамгаалалт гадаадын хөрөнгө оруулагчид үйлчлээгүй, эрх нь зөрчигдсөн тохиолдлын тухай мэдээлэл юм. Энэ талаар “Гадаадын иргэн, хуулийн

этгээдээс Монголд хөрөнгө оруулж, хохирсон нийт 57 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 20 хэргийг хааж, 15 хэргийг хэрэгсэхгүй болгож, гурван хэрэг шүүхийн шатанд, дөрвөн хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэн байна” гэсэн албан бус мэдээлэл гарчээ.

Хүснэгт 7. ЭЗЭЧИ-ийн санхүүгийн эрх чөлөөний үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Тайлбар
1	Санхүүгийн салбарын төрийн зохицуулалтын хүрээ	Банк, санхүүгийн салбарт одоогоор 26 хууль үйлчилж байна. Төвбанк, арилжааны банк, Хөгжлийн банк болон арилжааны банк, тэдгээрийн үйл ажиллагаатай холбоотой - 9, даатгалын салбарын - 5, санхүүгийн зохицуулах хороо, хөрөнгийн зах зээлтэй холбоотой - 12 хууль байна. Төвбанк /Монголбанк/-ны тухай хуулиар Монголбанк үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангах үндсэн чиг үүрэгтэй. Мөнгөний бодлого, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангахаас гадна Засгийн газрын санхүүгийн зуучлагч, гадаад валютын улсын нөөцийг удирдаж макро зохистой бодлого хэрэгжүүлэх чиг үүрэгтэй. Санхүүгийн салбарын дээрх хуулиудад “Төрийн байгууллагын чиг үүрэг” гэсэн бүлэгтэй 10 хууль байна. Эдгээр нь ихэвчлэн санхүүгийн салбартаа хяналт шалгалт, зохицуулалт, арга хэмжээний талаарх зохицуулалтууд юм. Санхүүгийн салбарт Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам, Хадгаламжийн даатгалын корпораци, төрийн өмчийн оролцоотой байхаар заасан давхар даатгал, биржүүдээр дамжуулан бодлого, хяналт, удирдлага зохион байгуулалт хийхээр хуулиудад заасан. Оролцох хэлбэр нь зах зээлд оролцогчид тавигдах шаардлагыг тодорхойлох, тухайлан дүрмийн сан, өөрийн хөрөнгийн хэмжээг тогтоох, зөвшөөрөл олгох, нарийвчилсан харилцааг журмаар зохицуулах, хяналт тавих, хяналтын үр дүнд авах (албадлагын) арга хэмжээ гэсэн байдлаар тусгагджээ.
2	Банк болон бусад санхүүгийн байгууллагад шууд, шууд бусаар өмчлөлд оролцох байдлаар төрийн зохицуулалтын байдал/зэрэг	Санхүүгийн салбарын зохицуулах байгууллага буюу Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо нь төрийн байгууллага бөгөөд салбарын оролцогчдын өмчлөл, үйл ажиллагаанд шууд оролцдоггүй. Санхүүгийн зах зээлд оролцогч этгээдүүд болох банк болон бусад этгээдүүдийн өмчлөлд төр оролцохоор хуулиар зохицуулсан тохиолдол даатгал, биржийн харилцаанаас бусад тохиолдолд байхгүй. Гэхдээ төрийн өмчит “хуулийн этгээд” санхүүгийн зах зээлд оролцох эрх нь нээлттэй. Банкны салбарт нэг хувьцаа эзэмшигч 20 хувиас хэтрэхгүй хэмжээний хувьцаа эзэмших, нэг этгээд хоёр банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байж болохгүй гэсэн хязгаарлалт хийгдсэн. Гэсэн хэдий боловч Төрийн банкны 49.26 хувийг Сангийн яам, 45.03 хувийг Хадгаламжийн даатгалын корпораци эзэмшдэг.
3	Нөөцийн хуваарилалт (эх үүсвэрийн байршуулалт) дахь Засгийн газрын нөлөөлөл	Мөнгөний бодлогыг Монголбанк хэрэгжүүлэх бөгөөд уг чиг үүргээ хараат бусаар хэрэгжүүлнэ гэж хуульд заасан. Үндэсний мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдлыг хангах зорилгын хүрээнд арилжааны банкны мөнгөн хөрөнгийн нөөц, зохистой харьцаа, зээлийн үлдэгдэлд зохицуулалт хийх, тэдгээрт зээл олгох, бодлогын хүү, нээлттэй захын үйл ажиллагаагаар дамжуулан зохицуулалт хийдэг. Даатгалын салбарт албан журмын даатгалын 2 хууль (Жолоочийн хариуцлагын, Үрийн тариалангийн), сайн дурын 1 (Малын индексжүүлсэн даатгалын) хууль батлагдсан нь төрөөс бодлогоор уг салбарт чиглэсэн арга хэмжээ гэж үзэхээр байна. Үндэсний эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах тэргүүлэх салбаруудад хэрэгжих төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх, импортыг орлох, экспортын орлогыг нэмэгдүүлэх үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилготой, тухайлсан хуультай Хөгжлийн банктай. Санхүүгийн салбарт зохицуулалт хийж буй Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо нь хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулах, мэргэжлийн байх чиг үүрэгтэй боловч тэдгээрийн удирдлагыг УИХ, ЗГ-аас томилох тул шууд бус нөлөөлөл эх үүсвэрийн байршуулалтад огт байхгүй гэж үзэх боломжгүй. Монголбанк орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж 10 орчим их наяд төгрөгийн санхүүжилт олгоод байгаа нь Засгийн газар нөөцийн хуваарилалтад оролцож байгаа жишээ юм.
4	Санхүүгийн болон хөрөнгийн зах зээлийн хөгжил	2024 онд СЗХ-ны зохицуулалтад хамаарах салбарын ДНБ (үйлдвэрлэлийн аргаар тооцсон)-д эзлэх хувь 26.5 хувьд хүрчээ. Санхүүгийн болон санхүүгийн бус бизнесийн 11 салбарын 7000 орчим зохицуулалттай этгээд оролцож байна. Мөн хөрөнгийн зах зээлийн үнэлгээ түүхэн дээд түвшинд буюу 13.0 их наяд төгрөгт хүрч, үнэт цаасны арилжаа өмнөх оноос 2 дахин нэмэгдэж, компанийн бонд, хувьцаа, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасууд арилжаалагдаж байна. Хувьцааны хоёрдогч зах зээлийн хөрвөх чадвар 2.5 хувь гэжээ. Олон улсын хэмжээнд хөрөнгийн зах зээлийн индексийн тооцоо, судалгааны чиглэлээр тэргүүлэгч “FTSE Russell” группээс 2022 оны 9-р сарын 29-ний өдөр Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг FTSE Russell-ийн “Хөгжиж буй” (Frontier Market) зах зээлийн зэрэглэлийн шалгуурыг бүрэн хангасан тул 2023 оны 9 дүгээр сараас эхлэн тус ангилалд оруулахыг зөвшөөрсөн байна.
	Гадаад өрсөлдөөнд нээлттэй байдал ⁵⁵	Хөрөнгө оруулалтын тухай хуулиар гадаадын төрийн өмчит хуулийн этгээд “банк, санхүү”-гийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа Монгол Улсын хуулийн этгээдийн 33 буюу түүнээс дээш хувийг эзэмших тохиолдолд хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авахаар заасан.

⁵⁰ АНУ-ын ЭСЯ-ын цахим хуудас: <https://mn.usembassy.gov/mn/2024-investment-climate-statement-mn/> (Сүүлд үзсэн: 2025.09.03)

⁵¹ Гадаадын хөрөнгө оруулагчийн гомдлын үг буюу “Монгол Хьюндай”-гийн дээрмийг анхан шатны шүүх ингэж шийджээ, Polit.

mn, (Сүүлд үзсэн: 2025.09.04)

⁵² The Heritage Foundation, 2025 Index of Economic Freedom, 2025, 403 дахь тал

Хөрөнгө оруулалтын орчин, түүнд хамаарах эрх зүйн зохицуулалт зөвхөн Хөрөнгө оруулалтын тухай хуулиар хязгаарлагдахгүй юм. Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан баталгааг хангахад чиглэсэн уялдааг бусад хуулиудад тусгах, зөрчлүүдийг арилгах, эсхүл хөрөнгө оруулагчид үйлчлэх хуулийн эрэмбэ дараалал, зарчмыг тодорхой болгохоос гадна “хөрөнгө оруулагч”-ид учирч буй бодит бэрхшээлүүдийг шийдвэрлэхэд чиглэсэн бусад хуулиудын өөрчлөлт, сайжруулалтуудыг хийх саналыг хувийн хэвшил, хөрөнгө оруулагчдын төлөөлөл гаргадаг.

1.4.2.3. Санхүүгийн эрх чөлөө

Санхүүгийн эрх чөлөө гэдэг нь тухайн улсын банкны үр ашигтай байдал, мөн санхүүгийн салбар дахь төрийн хяналт, оролцооны түвшинг илэрхийлдэг үзүүлэлт юм. Төрөөс банкууд болон санхүүгийн байгууллагуудыг эзэмших нь өрсөлдөөн бууруулж, зээл авах боломжийг хязгаарладаг.

Санхүүгийн эрх чөлөөг үнэлэх дэд хүчин зүйлс нь санхүүгийн үйлчилгээний зохицуулалтын түвшин, төрийн шууд болон шууд бус оролцоо /эзэмшил/, зээлийн хуваарилалтад төрийн нөлөө, санхүү, капиталын зах зээлийн хөгжлийн түвшин, гадаадын өрсөлдөөнд нээлттэй байх зэргийг үнэлж тооцоолдог.

Нээлттэй, хүртээмжтэй санхүүгийн тогтолцоо нь хувь хүн, бизнес эрхлэгч санхүүгийн олон төрлийн үйлчилгээ авах боломжтой байдал бөгөөд банкны салбар өрсөлдөөнтэй, инновацид нээлттэй байдаг. Зээлийн хүртээмж сайжирснаар бизнес эрхлэлт, хөрөнгө оруулалт нэмэгддэг.

Засгийн газрын үүрэг нь ил тод байдал, мэдээллийн найдвартай байдлыг хангахад чиглэсэн байх бөгөөд хяналт, аудит, мэдээллийг ил болгох шаардлага нь зах зээлийн шударга байдлыг хангадаг.


Санхүүгийн салбарт төрийн хэт их оролцоо нь санхүүжилтийн зардлыг нэмэгдүүлж, бизнес эрхлэгчдийн боломжийг хязгаарлан, зах зээлийн үнэ тогтоох үйл явцад саад болдог.

Монгол Улсын санхүүгийн эрх чөлөөний үзүүлэлт нь сүүлийн жилүүдэд тогтмол 50 оноогоор үнэлэгдэж байгаа бөгөөд энэ нь “дундаж эрх чөлөөтэй” ангилалд багтаж байна. (Хүснэгт 7)

Бүлгийн явцын дүгнэлт:

Зах зээлийн нээлттэй байдал бүлгийн үзүүлэлтүүдийг Монгол Улсын хувьд сүүлийн 30 жилийн өөрчлөлтөөр графикын дагуу харууллаа.

График 6. Зах зээлийн нээлттэй байдал бүлэг



Хэритэж сангийн дүгнэлтэд манай улсын хувьд жинлэсэн дундаж худалдааны тариф 5.3%, тарифын бус саад тотгорууд (лиценз, стандарт, хяналт шалгалт) нь худалдааны урсгалыг бууруулах нөлөөтэй. Хөрөнгө оруулалтыг татах зорилгоор зах зээлийг либералчлах чиглэлд тодорхой алхмууд хийж байгаа ч үр дүн жигд бус, зарим салбарт нөлөө үзүүлэхгүй байна гэжээ.

Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийг илэрхийлдэг Зах зээлийн нээлттэй байдлын 3 дэд үзүүлэлтээс хөрөнгө оруулалтын болон санхүүгийн эрх чөлөө тус бүртээ 100 онооноос 50 оноотой, дундаж үнэлгээтэй байна. Хөрөнгө оруулалтын орчны хувьд бизнесийн үйл ажиллагаанд оролцох захиргааны тогтолцооны цэгцтэй, ойлгомжтой байдлыг бий болгох буюу яам, агентлаг, орон нутгийн байгууллагуудын үйл ажиллагаа, оролцоог тодорхой болгож сайжруулах, хөрөнгө оруулалтын тухай хуулиар олгогдох баталгааг хангахад чиглэсэн бусад хуулиудын уялдааг хангах, эсхүл хөрөнгө оруулагчид үйлчлэх хуулийн хүчин чадлын эрэмбэ дарааллын зарчмыг хуульчлах, шүүхийн шударга байдлыг нэмэгдүүлэх, улс төрийн тогтворгүй байдал бизнесийн орчинд бага нөлөөлөлттэй байлгахад чиглэсэн зохицуулалт, зохион байгуулалт үгүйлэгдэж байна. Түүнчлэн татварын болон татварын бус дэмжлэгийн бодитоор хэрэгжүүлэхэд чиглэсэн татварын хуулиудад тусгах (хөрөнгө оруулалтын гэрээнд тусгасан боловч татварын хуульд тусгагдаагүй гэх үндэслэлээр хэрэгждэггүй), нэг мөр байдлыг хангахад чиглэсэн сайжруулалт хэрэгтэй байгааг аж ахуй эрхлэгчид илэрхийлсэн байна.

1.4.3. Дундаж үнэлгээтэй индекс

1.4.3.1. Бизнесийн эрх чөлөө

Бизнес эрхлэх эрх чөлөө гэдэг нь тухайн улсын хууль, зохицуулалтын орчин болон дэд бүтцийн нөхцөл байдал

⁵³ Санхүүгийн зохицуулах хорооны цахим хуудас: <https://www.frc.mn/resources/Image/Document/202504/GfGys/AR2024-mgl.pdf>, (Сүүлд үзсэн: 2025.09.04)

⁵⁴ Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас: <https://mse.mn/uploads/2024%20Annual%20report.pdf>, (2025.09.04)

⁵⁵ Санхүүгийн салбарын гадаад өрсөлдөөнд нээлттэй байдал гэдэг нь

тухайн улсын санхүүгийн зах зээл гадаадын тоглогчдод хэр боломж нээлттэй, өрсөлдөөнд оролцох эрх тэгш байдал хангагдсан эсэхийг илэрхийлдэг ойлголт юм. Энэ нь тухайн улсын эдийн засгийн либералчлал, хөрөнгө оруулалтын орчин, санхүүгийн системийн бэлэн байдлыг илтгэдэг чухал хэмжүүрүүдийн нэг гэж үздэг.

нь бизнес үр ашигтай ажиллах боломжийг хэр зэрэг хязгаарлаж байгааг хэмждэг үзүүлэлт юм. Энэ оноо нь бизнес эхлүүлэх, эрхлэх, хаах зэрэг үйл ажиллагааны шат бүрт хялбар байдалд нөлөөлдөг олон хүчин зүйлсийг үнэлсний үндсэн дээр тооцогддог. Үнэлгээ хийх дэд хүчин зүйлс нь 1) цахилгаан эрчим хүчний хүртээмж, 2) бизнесийн орчны эрсдэл, зохицуулалтын чанар болон эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоог хэмжиж гаргадаг. Монгол Улс бизнесийн эрх чөлөөний үзүүлэлтээр 67.9 оноогоор үнэлэгдэж “дунд зэрэг эрх чөлөөтэй” ангилалд багтаж байна.

Олон улсад нийтлэг байдлаар бизнесийн эрх чөлөө, бизнес эрхлэх үйл явцыг дараах үзүүлэлтүүдийг авч үнэлдэг.

Хүснэгт 8. Бизнесийн эрх чөлөөг тоон үзүүлэлтээр үнэлэх дэд хүчин зүйлс

Бүлэг	Бүрэлдэхүүн
Цахилгаан эрчим хүчний хүртээмж	Цахилгаанд холбогдох дундаж хугацаа (өдөр)
	Цахилгаан холболтын өртөг
	Цахилгаан хангамжийн найдвартай байдал
Бизнесийн орчны эрсдэл	Улс төрийн тогтвортой байдал ба хүчирхийлэлгүй байдал
	Дэлхийн банкны засгийн газрын үр ашгийн үзүүлэлтүүд
	Дэлхийн банкны зохицуулалтын чанар
	Бизнесийн орчны эрсдэл /Кредендогийн эрсдэлийн үнэлгээ/
Зохицуулалтын чанар	Бизнес эхлүүлэхэд шаардагдах журам, хугацаа, өртөг.
	Барилгын зөвшөөрөл авахад хялбар байдал
	Үл хөдлөх хөрөнгө бүртгэх хялбар байдал
	Гэрээ хэрэгжүүлэх хялбар байдал
Эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоо	Эмэгтэйчүүдийн бизнес болон хөдөлмөр эрхлэх хууль эрх зүйн орчин
	Гэрээ байгуулах, бизнесээ бүртгүүлэх, өмч эзэмших боломж
	Зээл болон санхүүгийн үйлчилгээнд тэгш хамрагдах боломж

Дээрх дэд үзүүлэлтүүдийн дагуу судлахад Монгол Улс эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоогоор дэлхийд дээгүүр үнэлэгдэж байгаа бөгөөд 100 онооноос 90.6 оноо авч 48-р байранд эрэмбэлэгдэж байна. Энэ нь нийт үнэлгээнд эергээр нөлөөлж, бизнесийн эрх чөлөөний оноог нэмэгдүүлж байх боломжтой.

Аж ахуй эрхлэх эрх чөлөөтэй холбогдуулан МҮХАҮТ-аас хийсэн хувийн хэвшлийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, төр хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх, хууль эрх зүйн орчныг сайжруулах тодорхой зорилтын хүрээнд “Монголын бизнесийн орчны судалгаа”-г 3 жил тутам хийдэг бөгөөд 3 удаагийн судалгааны үр дүнг харьцуулан харууллаа.⁶¹

Судалгаагаар бизнесийн орчныг 5 дэд орчны 12 хүчин зүйлсээр 0-5 хүртэлх оноогоор үнэлдэг бөгөөд үзүүлэлтийн оноо 5 руу ойртох тусам сайн байна гэж үздэг.

Хүснэгт 9. МҮХАҮТ – Монголын бизнесийн орчны үзүүлэлт

№	Дэд орчин	Хүчин зүйлс – Үзүүлэлт	2017	2020	2023
1	Эдийн засгийн орчин	Хүний нөөц, ажиллах хүч - 5	2.57	2.91	2.68
		Татварын орчин - 13	2.39	2.62	2.5
		Санхүүгийн зах зээл - 14	2.25	2.51	2.31
2	Засаглал, хууль эрх зүйн орчин	ЗГ-ын институтийн тогтолцоо, уялдаа холбоо - 9	2.18	2.6	2.26
		Засгийн газрын үйл ажиллагаа - 10	1.81	2.61	2.61
		Бизнесийн хууль, эрх зүйн орчин – 15	2.48	2.75	2.53
3	Нийгэм, соёлын орчин	Хүн ам зүйн орчин – 4	2.18	2.51	2.37
		Нийгмийн хандлага – 6	2.57	3.26	2.78
4	Дэд бүтэц, технологийн орчин	Технологи, харилцаа холбоо – 6	2.39	3.28	2.87
		Үндсэн дэд бүтэц – 8	2.69	3.19	2.59
5	Байгууллагын бизнесийн үйл/а	Байгууллагын үр ашиг, бүтээмж – 5	2.59	2.94	3.12
		Удирдлага, зохион байгуулалт – 8	2.66	3.34	3.25
Ерөнхий үнэлгээ		2.40	2.88	2.66	

⁵⁶ The Heritage Foundation, 2025 Index of Economic Freedom, 2025, 399 дэх тал

⁵⁷ World Bank – Government Effectiveness, 2025, <https://www.worldbank.org/content/dam/sites/govindicators/doc/ge.pdf>, (Сүүлд үзсэн: 2025.11.28)

⁵⁸ World Bank – Regulatory Quality, 2025, <https://www.worldbank.org/content/dam/sites/govindicators/doc/rq.pdf>, (Сүүлд үзсэн: 2025.11.28)

⁵⁹ World Bank – “Women, Business and the Law 2024”, 2024, 5 дахь тал

⁶⁰ World Bank – “Women, Business and the Law 2024”, 2024, 5 дахь тал

Дээрх судалгааны үр дүнгээс үзэхэд Монгол Улсын хувьд бизнесийн орчны оноог бууруулж буй хүчин зүйлс нь:

- Зохицуулалтын үр ашиггүй байдал, хэт их хүнд суртал,
- Хуулийн тогтворгүй орчин, бизнест нөлөөлөх гэнэтийн шийдвэрүүд,
- Зөвшөөрөл олгох дамжлага их, ил тод байдал дутмаг,
- Бизнесийн зохицуулалтад улс төрийн нөлөө ордог зэрэг шалтгаанууд тайлан мэдээлэлд дурдагдсан байдаг

Зураг 4. Эрчим хүчний яамны цахилгаан болон дулааны техникийн нөхцөлийн хүсэлтийн шийдвэрлэлтийн 2025 оны эхний хагас жилийн мэдээлэл⁶³

Цахилгаан

Шийдвэрлэлтийн төлөв		Улаанбаатар хотод			Орон нутагт		
		Хүсэлтийн тоо	Хүссэн чадал (Гкал/ц)	Олгосон чадал 2027 он (Гкал/ц)	Хүсэлтийн тоо	Хүссэн чадал (Гкал/ц)	Олгосон чадал 2027 он (Гкал/ц)
Техникийн нөхцөл олгосон	Шинэ	9	23.5	7	5	26.3	7.8
	Сунгалт	22	82.8	24.8	-	-	-
Шийдвэрлээгүй хүсэлт		58	143.60	0	34	83	0
Нийлбэр		89	249.9	31.8	39	109.4	7.8

1. Улаанбаатар хотод 89 хүсэлт ирүүлснээс 15.7% буюу 14 хүсэлтэд техникийн нөхцөл олгогдож, 84.3% буюу 58 хүсэлтэд олгох боломжгүй хариу гарсан байна.

2. Орон нутагт 39 хүсэлт ирүүлснээс 12.8% буюу 5 хүсэлтэд техникийн нөхцөл олгогдож, 87.2% буюу 34 хүсэлтэд олгох боломжгүй хариу гарсан байна.

Дулаан

Шийдвэрлэлтийн төлөв		Улаанбаатар хотод			Орон нутагт		
		Хүсэлтийн тоо	Хүссэн чадал (Гкал/ц)	Олгосон чадал 2027 он (Гкал/ц)	Хүсэлтийн тоо	Хүссэн чадал (Гкал/ц)	Олгосон чадал 2027 он (Гкал/ц)
Техникийн нөхцөл олгосон	Шинэ	8	23.74	7.07	7	32.82	17.5
	Сунгалт	3	11.87	3.96	-	-	-
Шийдвэрлээгүй хүсэлт		146	398.26	-	18	94.0	-
Нийлбэр		157	433.67	11.03	25	126.82	17.5

1. Улаанбаатар хотод 157 хүсэлт ирүүлснээс 7.0% буюу 11 хүсэлтэд техникийн нөхцөл олгогдож, 93.0% буюу 146 хүсэлтэд олгох боломжгүй хариу гарсан байна.

2. Орон нутагт 25 хүсэлт ирүүлснээс 28% буюу 7 хүсэлтэд техникийн нөхцөл олгогдож, 72.0% буюу 18 хүсэлтэд олгох боломжгүй хариу гарсан байна.

1) Цахилгааны хүртээмжтэй байдал

Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны тайланд манай улсын цахилгаан эрчим хүчний хэрэглээ жил тутам нэмэгдэж 2024 онд өнгөрсөн оныхоос 5.9%-иар нэмэгдсэн нь 11,619.0 сая кВт.ц бөгөөд үүнээс дотооддоо 8,754.7 сая кВт.ц, импортоор 2,863.4 8,754.7 сая кВт.ц авсан байна.

Дээрх мэдээллээс авч үзвэл, 2025 оны эхний хагас жилийн байдлаар цахилгаан эрчим хүчний нийт 249.9 МВт-ын чадал бүхий 128 хүсэлт ирүүлсний 36-г нь хэсэгчлэн 33.6 МВт чадлыг олгож, 226.6 МВт чадлын 92 хүсэлтийг шийдвэрлээгүй байна. Улаанбаатар хотод дулааны нийт 433.87 гкал/ц чадлын 157 хүсэлтийн 11 хүсэлтийн дагуу 7.07 гкал/ц чадлыг олгож, үлдсэн 93 хувийн хүсэлт 398.26 гкал/ц чадлыг олгоогүй байна.

Цахилгаан, дулааны эрчим хүчний хүртээмж 2027 он хүртэл хүндрэлтэй байх төлөвтэй байна.

2) Бизнесийн орчны зохицуулалт

Манай улсад бизнесийн буюу аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх харилцаанд нийтлэг байдлаар нэн түрүүнд хамаарах хуулиудыг авч үзэхэд дараах 19 хууль, тэдгээрийг дагалдах “гадагшаа” чиглэсэн нийт 145 журам байна. (Хүснэгт 10)

Дээрхээс гадна аж ахуйн үйл ажиллагааны салбар, чиглэлээс хамааран баримтлах хууль тогтоомж, журам нэмэгдэнэ. Бизнесийн үйл ажиллагаанд хамаарах хууль тогтоомжийн тоо олон байхын хирээр бизнес эрхлэхэд хязгаарлалт болох, төвөгшил учруулах, хуулиудын давхардал, хийдэл, зөрчил үүсгэдэг.

Иймд эдгээр олон хууль тогтоомжийн хэрэглээний эрэмбэ дараалал эсхүл аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн зохицуулалтыг баримтлах зарчмыг хуульчилж асуудлыг шийдвэрлэх зарчим манай улсын хууль тогтоомжид тусгагдаагүй байна. Мөн бизнесийн орчинд хамаарах аливаа хууль тогтоомжийн зохицуулалт нь эдийн засгийн үндэслэл бүхий байх шаардлагыг, зорилго болон хязгаарлалтыг Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан “үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод” чиглэсэн байх шаардлагыг хангах, хяналт хийхэд чиглэсэн зохицуулалт хэрэгтэй байна.

Бизнесийн үйл ажиллагаанд төрөөс үзүүлэх дэмжлэгийн хувьд жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийг дэмжих тухай Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуультай. Уг хуулиар аж ахуйн нэгжийг дараах байдлаар ангилж, төрөөс үзүүлэх санхүүгийн болон санхүүгийн бүс 10 төрлийн дэмжлэгийг заасан. (Хүснэгт 11)

⁶¹ МҮХАҮТ, Монголын бизнесийн орчин 2017, 2020, 2023 оны судалгааны тайлан

⁶² <https://online.fliphtml5.com/seigx/bmpe/#p=7>

Эрчим хүчний яамны цахим хуудас: <https://www.energy.gov.mn/p/120>,

⁶³ (Сүүлд үзсэн: 2025.09.04)

Хүснэгт 10. Бизнесийн үйл ажиллагаанд нийтлэг үйлчлэх хуулиуд

№	Хууль	Тайлбар
1	Компанийн тухай	Компани үүсгэн байгуулах, бүртгүүлэх, өөрчлөн байгуулах, компанийн удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтэц, хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг тогтоох, компани татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулна. Дагалдах журам - 5
2	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль	Үүсгэн байгуулсан компанийг улсын бүртгэлд бүртгүүлэх харилцаа (ажлын 2-5 өдөр)
3	Зөвшөөрлийн тухай хууль	254 төрлийн тусгай, 122 төрлийн энгийн үйл ажиллагааны зөвшөөрөл авах шаардлагатай. Энэ хуульд заасан зөвшөөрөлтэйгээс бусад үйл ажиллагааг шууд эрхэлж болно. (ажлын 5-10 өдөр) Дагалдах журам - 4
4	Газрын тухай хууль	Газар эзэмших, ашиглах эрхийн зөвшөөрөл (ажлын 15 - 30 хоног) Дагалдах журам - 18
5	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль	Хөрөнгийн бүртгэлийн асуудал Дагалдах журам - 6
6	Хөдөлмөрийн тухай хууль	Ажилтан, ажил олгогчийн хоорондын хөдөлмөрийн харилцаа Дагалдах журам - 15
7	Зар сурталчилгааны тухай хууль	Аж ахуйн үйл ажиллагаанд хэрэглэгчийн эрхийг хамгаалах, өрсөлдөөнийг хамгаалах болон зар сурталчилгаатай холбоотой Дагалдах журам - Өрсөлдөөний тухай хууль - 3
8	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай	
9	Өрсөлдөөний тухай хууль	
10	Гаалийн тухай	Бараа, бүтээгдэхүүн хилээр нэвтрүүлэх, гарах харилцаа Дагалдах журам - 25
11	Төрийн хяналт шалгалтын тухай	Төрийн хяналт шалгалт Дагалдах журам - 3
12	Нягтлан бодох бүртгэлийн тухай	Санхүү, бүртгэлийн стандарт, данс хөтлөлт, тайлагнал Дагалдах журам - 5
13	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай	Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой харилцаа Дагалдах журам - 6
14	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай	Төрийн байгууллагад өргөдөл, гомдол гаргах харилцаа Дагалдах журам - 0
15	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар Дагалдах журам - 6
16	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай	Нэмэгдсэн өртгийн албан татвар Дагалдах журам - 8
17	Нийгмийн даатгалын ерөнхий хууль	Нийгмийн даатгалын шимтгэл төлөх (албан журмын) Дагалдах журам - 17
18	Татварын ерөнхий хууль	Татварын харилцаа Дагалдах журам - 8
19	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, тэдгээрийн чиг үүрэг Дагалдах журам - 10

Хүснэгт 11. Аж ахуй эрхлэгчид үзүүлэх дэмжлэг

№	Үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн ангилал	Шалгуур үзүүлэлт	Дэмжлэг
1	Бичил	10 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, жилийн 300.0 сая төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгж	1. жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний зах зээлийн эрэлт, хэрэгцээ шаардлагыг үндэслэн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний салбарын хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх, сургах, даван сургах тогтолцоог хөгжүүлэх; 2. санхүүгийн дараах дэмжлэгийг үзүүлэх; 2.а.хөнгөлөлттэй зээл олгох; 2.б.шинээр бий болгосон ажлын байрны тоо, борлуулалтын орлогын хэмжээг харгалзан зээлийн хүүгийн хэмжээг бууруулах; 2.в.зээлийн давхар батлан даалт гаргах; 2.г.зээлийн хүүгийн татаас олгох;
2	Жижиг	10-50 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, жилийн 300.0 сая-1.0 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгж	2.д.тоног төхөөрөмжийн санхүүгийн түрээсийн үйлчилгээ, түрээсийн хүүгийн дэмжлэг үзүүлэх. 3.татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх; 4.экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих; 5. бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтад төрийн худалдан авалтаар дэмжлэг үзүүлэх; 6.бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх; 7.шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх судалгааг дэмжих; 8.техник, технологийн дэвшлийг дамжуулах, нутагшуулах, шинжлэх ухаан, технологийн судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх; 9. кластерын хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийг тухайн орон нутаг дахь түүхий эдийн болон ажиллах хүчний нөөц, чадавх бусад онцлогоос хамааран дэмжих; 10. гадаад, дотоод зах зээлд нэвтрэхэд дэмжлэг үзүүлэх.
3	Дунд	50-200 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, жилийн 1.0-2.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгж	

Зах зээлээс гарах буюу хуулийн этгээдийг татан буулгах 5 үндэслэлийг Иргэний хуульд заасан бөгөөд уг хуулиас гадна Компанийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Дампуурлын тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиудаар зохицуулагдаж байна.

Дампуурлын эрх зүй нь чөлөөт зах зээлд үйл ажиллагаагаа явуулж чадахгүй иргэн, хуулийн этгээдэд зөв аргаар татан буугдах (шүүлтүүр, хамгаалалт) нөхцлийг бүрдүүлж өгдөг эдийн засгийн эрүүл тогтолцоог хангах чухал салбар гэж олон улсад үздэг.

Одоо үйлчилж буй Дампуурлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээнд үндэслэн хуулийн шинэчилсэн найруулгыг Хууль зүйн яамнаас боловсруулж, санал авч байна ⁶⁴.

Хүснэгт 12. ЭЗЭЧИ-ийн хөдөлмөрийн эрх чөлөөний үзүүлэлтүүд

№	Шалгуур үзүүлэлт	Зохицуулалт
1	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ	Нэг цагт 4715 төгрөг буюу сард 792000 төгрөг (CNY/Month - 2690, KZT/Month - 85000, JPY/Hour - 1054) БНХАУ - сарын 1,358,450 төгрөг, БНКУ - сарын 562,700 төгрөг, Япон улс - цагийн 25,591 төгрөгтэй тэнцэж байна. Манай улсын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ БНХАУ-аас 2 дахин бага, Япон улсаас 6 дахин бага, Казахстан улсаас 30%-иар их байна.
2	Эвлэлдэн нэгдэх эрх	Хөдөлмөрийн тухай хууль болон Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн дагуу иргэд хөдөлмөрлөх эрхээ хэрэгжүүлэх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлоо хамтран хамгаалах зорилгоор сайн дураараа чөлөөтэй эвлэлдэн нэгдэж үйл ажиллагаа явуулах эрхтэй.
3	Ээлжийн амралтын цалин	Ээлжийн амралтын цалинг ажилтны тухайн ажлын жилийн дундаж цалин хөлснөөс тооцож олгоно.
4	Ээлжийн амралтын цалин	Ажил олгогчийн санаачилгаар хуульд заасан үндэслэлээр ажилтныг ажлаас халах тохиолдолд 30 хоногийн өмнө мэдэгдэнэ
5	Ажлаас халагдсаны тэтгэмж	Ажил олгогчийн санаачилгаар ажлаас халагдсан тохиолдолд ажилласан жилээс хамааран 1-4 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж авах эрхтэйгээс гадна нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөөс хамааран ажилгүйдлийн тэтгэмж авна.
6	Хөдөлмөрийн бүтээмж Хөдөлмөрийн бүтээмж	ҮСХ-оос гаргасан мэдээллээр 2025 оны 2 дугаар улирлын байдлаар хөдөлмөрийн бүтээмж нэг ажилтанд ногдох ДНБ 6.2 сая төгрөг байна. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын цахим хуудаст манай улсын хөдөлмөрийн бүтээмжийг 19.6 ам.доллар/цаг гэж үнэлсэн байна. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын цахим хуудаст манай улсын хөдөлмөрийн бүтээмжийг 19.6 ам.доллар/цаг гэж үнэлсэн ббайна. Казахстан 39.3 ам.доллар/цаг, БНХАУ 19.8 ам.доллар/цаг, Япон улс 53.7 ам.доллар/цаг байна.
7	Ажиллах хүчний оролцооны хувь (нийт ажиллах хүч болон ажил хийж буй иргэдийн харьцаа)	2025 оны 5 дугаар сарын байдлаар манай улсын ажиллах хүчний оролцооны хувь 57.6 хувьтай байгаа нь Азийн улс орнуудын дундаж түвшинд байна.
8	Илүү цагаар ажиллах хязгаар	Жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй ажилтан өөрөө зөвшөөрөөгүй бол, мөн насанд хүрээгүй ажилтныг илүү цагаар ажиллуулахыг хориглосон. Хуульд заасан үндэслэл бүхий нөхцөл байдал үүссэн тохиолдолд илүү цагаар ажиллуулж болно гэж заасан.
9	Ажлаас халахыг хуулиар зөвшөөрөх байдал	Ажил олгогчийн санаачилгаар ажлаас халах тохиолдлыг хуульд тухайлан заасан бөгөөд үүнээс бусад тохиолдолд ажлаас халахыг үндэслэлгүйгээр ажлаас халсан гэж үзнэ.

1.4.3.2. Хөдөлмөрийн эрх чөлөө

Хөдөлмөр эрхлэх эрх чөлөө гэдэг нь тухайн улсын хууль эрх зүйн болон зохицуулалтын орчин нь хөдөлмөрийн зах зээлд хэрхэн нөлөөлж байгааг тоон үзүүлэлтээр хэмждэг. Эдгээр нь ажлын байрны боломж, ажилд авах, ажлаас халах хялбар байдал, ажлын цагийн зохицуулалт зэргийг авч үздэг.

Цалингийн доод хэмжээ, холбоо байгуулах эрх, цалинтай жилийн амралт, ажлаас халах мэдэгдлийн хугацаа, ажлаас халах нөхөн олговор, хөдөлмөрийн бүтээмж, хөдөлмөрийн зах зээлд оролцох хувь, илүү цагаар ажиллах хязгаар, халах эрхийг хууль ёсоор зөвшөөрсөн эсэхийг тооцож тоон үзүүлэлтээр гаргадаг.

Монгол Улс хөдөлмөрийн эрх чөлөөний үзүүлэлтээр 68.1 оноогоор үнэлэгдэж “дундаж эрх чөлөөтэй” оронд тооцогдож байна. (Хүснэгт 12)

Манай улсад хөдөлмөрийн харилцаатай холбоотой Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль болон Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулиуд үйлчилж байна.

Хөдөлмөрийн зах зээлд тулгамдаж буй асуудал нь ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтийн зөрүү, залуучуудын ажилгүйдэл, ижил төстэй хөдөлмөрийн зах зээлтэй харьцуулахад хөдөлмөрийн бүтээмж харьцангуй доогуур, ажиллах хүчний ур чадварын чанар болон ажлын байрны шаардлагын зөрүү их зэрэг асуудлуудыг тодорхойлсон байна.

Мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас хамтран гаргасан Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн дунд хугацааны эрэлт, нийлүүлэлтийн таамаглалд хөдөлмөрийн зах зээлд Улаанбаатар хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн их, бодит цалин сүүлийн 10 жил дорвитой өсөөгүй, бодит цалингийн ДНБ-д эзлэх хувь ойролцоо улсуудаас 8.7-13.3 нэгжээр доогуур, албан бус хөдөлмөр эрхлэлт нэмэгдэж байна, энгийн ажил мэргэжлийн эрэлт хангагдахгүй байна зэрэг дүгнэлт гаргасан байна.

1.4.3.3. Мөнгөний эрх чөлөө

Мөнгөний эрх чөлөө гэдэг нь инфляцийн түвшин болон төрөөс үнийн тогтворгүй байдалд нөлөөлж буй үйл ажиллагаануудыг хамтад нь үнэлдэг үзүүлэлт юм. Үнийн тогтвортой байдал, микро эдийн засгийн хөндлөнгөөс оролцоогүйгээр хадгалагдаж байвал зах зээл хамгийн эрх чөлөөтэй гэж үздэг.

Мөнгөний эрх чөлөөг хэмжих дэд хүчин зүйлс нь 1)

⁶⁴ Хууль зүй, дотоод хэргийн яамны цахим хуудас: <https://mojha.gov.mn/content/67f48b2e9fea4ca6d59bd023>, (Сүүлд үзсэн: 2025.09.04)

⁶⁵ Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны цахим хуудас: <https://mlsp.gov.mn/content/detail/3459>, (Сүүлд үзсэн: 2025.09.04)

⁶⁶ Трэйдинг экономикс цахим хуудас: <https://tradingeconomics.com/country-list/minimum-wages?continent=asia>, (Сүүлд үзсэн: 2025.09.04)

⁶⁷ Үндэсний статистикийн хорооны цахим хуудас: <https://www.1212.mn/mn/dissemination/92570457>, (Сүүлд үзсэн: 2025.09.04)

сүүлийн 3 жилийн жинлэсэн дундаж инфляцийн хувь болон 2) төрөөс үнийн хяналт, татаас зэрэг арга хэмжээг авч буй түвшин /чанарын үнэлгээг/-г үнэлж тооцдог. Өөрөөр хэлбэл тогтвортой мөнгөний ханш, зах зээлийн зарчмаар тогтсон үнэ нь мөнгөний эрх чөлөө сайн байгааг илтгэнэ.


Монгол Улсын мөнгөний эрх чөлөөний үнэлгээ нь 68.8 буюу “дундаж эрх чөлөөтэй” ангилалд багтаж байна.

Макро эдийн засгийн зохицуулалтгүй үнийн тогтвортой байдал нь чөлөөт зах зээлийн хамгийн сайн зүйл гэсэн шалгуурыг харгалздаг байна.

1) Инфляц

Сүүлийн 3 жилийн инфляцын дундаж хэмжээ 10.8 бөгөөд Ковидын дараах үеийн инфляцын өсөлт нөлөөлсөн. Сүүлийн 2 жил инфляц эргэн тогтворжиж байна. Манай улсын инфляц Ковидоос буюу 2020 өмнөх сүүлийн 5 жилд дунджаар 4.58, 1.3 – 8.1 хооронд хэлбэлзэж байсан. Хөгжиж буй, тухайлбал Казахстан улсын сүүлийн 3 жилийн инфляц 12.8 байгаатай харьцуулахад ойролцоо байна.

Зураг 5. Монгол Улсын сүүлийн 5 жилийн инфляцын түвшин



2) Засгийн газраас хийгдэж буй үнийн зохицуулалт (татаас, шууд хяналт)

Манай улсад эдийн засгийн аль салбарт төрөөс ямар оролцоотой байх, тухайлан татаас, дэмжлэгийн талаарх зарчмыг тогтоосон хууль байхгүй. Өрсөлдөөний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3, 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгээс төрөөс өрсөлдөөнд “оролцох” үндэслэл буюу зорилго, салбар, зохицуулалтын аргыг тодруулж үзвэл:

Хүснэгт 13. Өрсөлдөөний тухай хуульд заасан төр өрсөлдөөнд “оролцох” үндэслэл буюу зорилго, салбар, зохицуулалтын арга

Төрөөс зах зээлийн өрсөлдөөнд оролцох зорилго	Эдийн засгийн хямралыг даван туулах
	Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас учирсан хохирлыг нөхөх
	Стратегийн гол бараа бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлтийн зохистой байдлыг бүрдүүлэн хэрэглэгчийн амьжиргааны түвшний тогтвортой байдлыг хангах
Зохицуулалтын арга	Зохицуулалт хийх
	Зээл олгох
	Тусламж үзүүлэх
Зохицуулалт хийх салбар Зохицуулалттай салбарт хийх зохицуулалт	Хуулийн дагуу тусгай зөвшөөрөл олгож, тарифын зохицуулалт хийгддэг, зохицуулах байгууллагатай салбар
	Зах зээлд нийлүүлж байгаа тухайн бараа бүтээгдэхүүний тоо, хэмжээний өөрчлөлтийн талаар хүчин чадалтай нь уялдуулан хянах
	Бодит зардлыг нь харгалзан тухайн бараа бүтээгдэхүүнийг борлуулах үнийн өөрчлөлтийг хянан зөвшөөрөл олгох

Аль салбарт, ямар үндэслэл, шаардлагын дагуу ямар төрлийн зохицуулалт хийхийг тодорхойлон заасан хуулийн зохицуулалт байхгүй тул салбаруудыг харахын тулд улсын төсвийн зардлын татаасын ангиллыг авч үзэж болох юм.

Сангийн сайдын 2014 оны 5 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн зарлагын эдийн засгийн дэлгэрэнгүй ангилалд Татаас хэсэгт дараах татаасын төрлийг тусгасан байна.

Хүснэгт 14. Төсвийн зарлагын эдийн засгийн дэлгэрэнгүй ангиллаас

212	ТАТААС
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас
212101	Эрчим хүч, дулааны алдагдлын татаас
212102	Хотын нийтийн тээврийн татаас
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас
212201	Бусад татаас шилжүүлэг
212202	Улаанбуудай, махны татаас
212203	Хувийн хэвшлийн байгууллагад үйлдвэрлэл нэмэгдүүлэх зорилгоор олгох татаас, тусламж
212204	ЭМД-ын сангаас санхүүжих эмийн үнийн хөнгөлөлт

⁶⁸ Олон улсын хөдөлмөрийн байгууллагын цахим хуудас: <https://ilostat ilo.org/topics/labour-productivity/>, (Сүүлд үзсэн: 2025.09.04)

⁶⁹ YCX-ны цахим уудас: https://www21212mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_0400_035V3&13999001_select_all=0&13999001SingleSelect=_T1&SOUSelect_all=0&SOUSelect=_0&Sex_select_all=0&SexSingleSelect=_1&YearQ_select_all=0&YearQSingleSelect=_202501&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2024&viewtype=linechart, (Сүүлд үзсэн: 2025.09.04)

⁷⁰ Дэлхийн банк, “Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн дүн шинжилгээ: Эдийн засгийг сэргээх, төрөлжүүлэх зорилгоор илүү идэвхтэй, хүртээмжтэй хөдөлмөрийн зах зээлийн бий болгох нь”, <https://documentsworldbankorg/en/publication/documents-reports/documentdetail/099030101132312478>, (Сүүлд үзсэн: 2025.09.04)

⁷¹ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн дунд хугацааны эрэлт, нийлүүлэлтийн таамаглал судалгааны тайлан, 2024, 112-115 дахь тал

⁷² Инфляция в Республике Казахстан (Декабрь 2023г.)

Аль салбар, ямар зохицуулалттай байхыг тодруулахын тулд тухайн салбарын хууль тогтоомжийг судлах шаардлагатай байна.

Эрчим хүчний тухай хуульд Эрчим хүчний зохицуулах хороо үнэ тарифыг тогтоох, хэрэглэгчид ирэх ачааллыг зохистой хэмжээнд хөнгөлөх зорилгоор тусгай зөвшөөрөл эзэмшигчид эрчим хүчний үнэ тарифын алдагдалтай холбоотой татаасыг улсын төсвөөс олгох асуудлыг Засгийн газарт оруулах чиг үүрэгтэй байхаар заажээ.

Автотээврийн тухай хуульд “таксинаас бусад нийтийн тээврийн үйлчилгээний төлбөрийн хувь хэмжээг энэ хуулийн 6.1.7-д заасан жишиг тарифт нийцүүлэн аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно. Мөн хуулийн 5 дугаар зүйлд заасан Засгийн газрын бүрэн эрхэд “хүн амын нутагшил, байршлын онцлог, зорчигч ба шуудан тээвэрлэлтийн хэрэгцээнээс шалтгаалан өрсөлдөх боломжгүй чиглэлд хот хоорондох зорчигч, шуудан тээвэрлэлтийг зохих нөхөн төлбөр олгох нөхцөлтэйгөөр тээвэрлэгчтэй гэрээ хийж гүйцэтгүүлэх.” гэжээ. Харин улсын төсөвт нөхөн төлбөрийг тусгуулах тухай хуулийн зохицуулалт байхгүй байна.

Тариалангийн тухай хуульд “Тариалангийн үйлдвэрлэлд төрөөс мөнгөн болон мөнгөн бус дэмжлэг үзүүлж болно.”, “Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал олгох, мөнгөн бус дэмжлэг үзүүлэх журмыг тариалангийн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.”, “Мөнгөн урамшуулал олгох, дэмжлэг үзүүлэхэд техник, технологийн шинэчлэл хийсэн, хөрсний үржил шимийн хэвийн байдлыг хадгалсан, ургацын чанарыг тогтвортой дээшлүүлсэн, орон нутгийн иргэдийг ажлын байраар хангасан байдлыг харгалзана.” гэсэн байна.

Хүнсний тухай хуульд төрөөс дэмжлэг, урамшуулал үзүүлж болох хүнсний салбарыг заасан нь:

- Стратегийн хүнсний үйлдвэрлэл ("стратегийн хүнс" гэж монгол хүний физиологийн хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай малын мах, сүү, тарианы үр, улаан буудай, гурил, ундны усыг);
- Дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжгүй өргөн хэрэглээний хүнсний импорт;
- Хүүхдийн хоол тэжээлийн үйлдвэрлэл;
- Хүний бие махбодийг бүхэлд нь, эсхүл тодорхой эрхтний үйл ажиллагааг дэмжих шаардлагатай бодис, илчлэгийг нөхөх үйлчилгээ бүхий биологийн идэвхт бодис, баяжуулсан, ашигтай бичил биетэн агуулсан зохицуулах үйлчилгээтэй хүнсний

үйлдвэрлэл;

- Үйл ажиллагаандаа зохистой дадал, аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналтыг нэвтрүүлсэн;
- Монгол Улсын нутаг дэвсгэрт төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалсан;
- Дотоодын түүхий эд ашиглан шинэ технологиор импортыг орлох хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн.
- Мал төхөөрөх болон сүү боловсруулах үйлдвэр, цехэд гарал үүсэл нь баталгаажсан эрүүл мал, техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн түүхий сүүт нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгож болно.

Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуульд бараа, түүхий эдийг биржийн арилжаанд оролцож худалдан авсан тухай тодорхойлолтыг үндэслэн хоршоо, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчид урамшуулал олгох журмыг хөдөө аж ахуй, худалдааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэжээ.

Бусад хууль тогтоомж, журам:

- Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай Улсын их хурлын 2012 оны 74 дүгээр тогтоол,
- Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал олгох, мөнгөн бус дэмжлэг үзүүлэх журам, (дотоодын үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэсэн буюу худалдааны)
- Хонь, тэмээний ноос бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам,
- Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгох журам.

Хөдөө аж ахуйн салбарт үзүүлж буй дэмжлэгийг мөнгөн ба мөнгөн бус гэж ангилах, мөнгөн хэлбэрийн дэмжлэгт урамшуулал, хүүгийн хөнгөлөлт, мөнгөн бус дэмжлэгт зээлийн дэмжлэг, техник төхөөрөмж, бордоо, үр, түлш шатахуун, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх гэх зэргээр олон төрөлтэй байна.

Хөдөө аж ахуйн салбарт төрөөс үзүүлж буй татаас, урамшууллын талаар “Хөдөө аж ахуйн дэмжлэг, урамшууллын судалгааны тайланд “Анх 2007 онд улаан буудайн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хүн амын хэрэгцээг дотоодын улаан буудайгаар үйлдвэрлэсэн

⁷³ https://www.undp.org/sites/g/files/zskgke326/files/2023-04/%D0%A5%D0%90%D0%90%20%D0%B4%D1%8D%D0%B-C%D0%B6%D0%BB%D1%8D%D0%B3%20%D1%83%D1%80%D0%B0%D0%BC%D1%88%D1%83%D1%83%D0%B-%D0%BB%D1%8B%D0%BD%20%D1%81%D1%83%D0%B4%D0%B0%D0%B-%D0%B3%D0%B0%D0%B0%D0%BD%D1%8B%20%D1%82%D0%B0%D0%B9%D0%BB%D0%B0%D0%BD%202023_final%20%282%29.pdf

B%D0%BB%D1%8B%D0%BD%20%D1%81%D1%83%D0%B4%D0%B0%D0%B-%D0%B3%D0%B0%D0%B0%D0%BD%D1%8B%20%D1%82%D0%B0%D0%B9%D0%BB%D0%B0%D0%BD%202023_final%20%282%29.pdf

гурилаар хангах зорилтын хүрээнд зохих шаардлага хангасан иргэд, ААН-ийн хураан авсан улаан буудайн тонн тутамд 80.0 мянган төгрөгийн урамшууллыг улсын төсвөөс олгож эхэлсэн байна. Түүнчлэн 2011 оноос ноос, 2013 оноос нөөцийн мах бэлтгэл, 2014 оноос арьс, шир, 2020 оноос сүүний үйлдвэрлэлд тус тус урамшуулал улсын төсвөөс олгож эхэлжээ. Мөн 2020 онд малчид, мал бүхий иргэдэд бэлтгэсэн ноолуурын кг тутамд 20.0 мянган төгрөгийн урамшууллыг улсын төсвөөс мөнгөн шилжүүлэг хэлбэрээр олгосон байна.” гэжээ.

Дээрхээс гадна орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөр, шатахуун зэрэг бүтээгдэхүүн, үйл ажиллагаа төрийн татаас, зохицуулалттай байгаа билээ.


Мөн дээрх татаас, дэмжлэгүүд нь Өрсөлдөөний тухай хуульд заасан “хэрэглэгчийн амьжиргааны түвшний тогтвортой байдлыг хангах” зэрэг зорилгод чиглэсэн байх шаардлагыг хангаж байгаа эсэх нь тодорхойгүй байна.

Дээрх байдлаас авч үзэхэд манай улсын эрчим хүчний салбар бүтэн зохицуулалттай, нийтийн тээврийн салбарт төрөөс нөхөн төлбөртэй, хөдөө аж ахуй, хүнсний салбарт мөнгөн болон мөнгөн бус дэмжлэгүүд үзүүлдэг байна. Эдгээр салбарын бүтээгдэхүүний үнэ зах зээлийн чөлөөт байдлаар тогтоогддоггүй байна.

Бүлгийн явцын дүгнэлт

Зохицуулалтын үр ашиг бүлгийн үзүүлэлтүүдийг Монгол Улсын хувьд сүүлийн 30 жилийн өөрчлөлтөөр графикийн дагуу харууллаа.

График 7. Зохицуулалтын үр ашиг бүлэг



Хэритэж сангаас “Монгол Улс зохицуулалтын үр ашгийн үзүүлэлтээр дунджаас дээгүүр үнэлэгдэж байна. Ерөнхий зохицуулалтын орчин албан ёсны тогтолцоонд шилжсэн ч /институтчилэгдсэн/, үр ашиг муутай хэвээр байна” гэж дүгнэсэн байна.

Манай улсад бизнесийн үйл ажиллагаанд хамаарах хууль, журмын тоо олон байна гэж үзэхээр байна. Иймд эдгээр

олон хууль тогтоомжийн хэрэглээний эрэмбэ дараалал эсхүл аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн зохицуулалтыг баримтлах зарчмыг хуульчилж асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй бөгөөд одоогоор энэ зарчим манай улсад хуульд тусгагдаагүй. Мөн бизнесийн орчинд хамаарах аливаа хууль тогтоомжийн зохицуулалт нь эдийн засгийн үндэслэл бүхий байх шаардлагыг, зорилго болон хязгаарлалтыг Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан “үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод” чиглэсэн байх шаардлагыг хангах, хяналт хийхэд чиглэсэн зохицуулалт хэрэгтэй байна.

Засгийн газраас эдийн засгийн аль салбарт ямар бодлого, зарчим баримтлах, ямар төрлийн дэмжлэг үзүүлж хэрхэн оролцох талаар тодорхой зохицуулалт байхгүйгээс улсын төсөвт тусгагдаж буй татаасыг ямар шалгуур үзүүлэлт, үндэслэлээр олгох нь тодорхойгүй гэж үзэхээр байна.

1.4.4. Дээгүүр үнэлгээтэй индекс

1.4.4.1. Татварын ачаалал

Татварын ачаалал гэдэг нь хувь хүн болон аж ахуйн нэгжийн орлогыг хязгаарлах татварын хувь, мөн нийт татварын хэмжээ (шууд болон шууд бус татварууд)-ийг дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-д эзлэх хувиар илэрхийлсэн нийлмэл үзүүлэлт юм.

Монгол Улс татварын ачааллын үзүүлэлтээр 85.7 оноогоор үнэлэгдэж “эрх чөлөөтэй” ангилалд багтаж байна. Судалгааны тайланд Монгол Улсад татварын хувь хэмжээ харьцангуй бага, татварын орлого ДНБ-д бага хувь эзэлдэг гэжээ.

Татварын харилцаанд манай улсад Татварын ерөнхий хуулиас гадна 22 бие даасан хууль үйлчилж байна.

МҮХАҮТ-аас 2023 оны 12 дугаар сард УИХ-ын даргын ажлын албатай хамтран зохион байгуулсан "Татварын цогц шинэчлэл" хэлэлцүүлэг, 2025 оны 1 дүгээр сард УИХ-ын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн гишүүдтэй хамтарсан "Татварын багц хуулийг шинэчлэх хэрэгцээ шаардлага, асуудал шийдвэрлэх арга зам" хэлэлцүүлгийн үеэр бизнес эрхлэгч аж ахуйн нэгжүүдээс гаргасан 12 төрлийн хууль тогтоомжид хамаарах 178 санал гаргасныг ангилж үзвэл:

- Татварын хууль тогтоомж, холбогдох дүрэм, журам, маягтууд нь нийтэд ойлгомжгүй, уялдаа холбоо муутай, салаа утга агуулсан, зарим маягт, загвар батлагдаагүй, зарим журмын зохицуулалт хуулиас давсан. Хэт ерөнхий нэр томъёо олонтой. Үүнээс болж татварын байцаагч хууль, журмыг өөрийн үзэмжээр тайлбарлах, хэрэглэх, хүнд суртал, чирэгдлийг үүсгэдэг,

⁷⁴ Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын цахим хуудас: https://www.mongolchamber.mn/a/2070#_ftnref1, (Сүүлд үзсэн: 2025.09.04)

- Татварын байцаагчид татвар төлөгчидтэй хамтран ажиллахгүй, мэргэжил арга зүйгээр хангаагүй, эсрэгээрээ дарамталдаг, олон дахин очиж тайлбар, баримт өгч байж тайлангаа баталгаажуулдаг,
 - Татварын хууль тогтоомж бүх аж ахуй эрхлэгчид жигд үйлчлэхгүй, зарим этгээдэд давуу байдал олгосон,
 - Хөрөнгө оруулалтын тухай хуульд итгээд хөрөнгө оруулалт хийхээр татварын хуулиар хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх заалт байхгүй,
 - Хяналт хэрэгжүүлэх хугацаа тодорхойгүй, татварын тайлан хоорондын гарах дараалал, хугацаа, уялдаа холбоонд нийцүүлээгүй тайлан авах хугацаа заадаг, татвар төлөгчид урьдчилан мэдэгдэлгүйгээр татварын харьяаллыг шилжүүлдэг,
 - Төрийн байгууллагууд уялдаа холбоогүй, систем, программ хангамжийн алдаанаас болж мэдээлэл хоцрох, буруу тодорхойлогдох зэргээр татвар төлөгчид хүндрэл учруулдаг, энэ мэт татвар төлөгчөөс үл хамаарах алдаанд татвар төлөгчийн эрсдэлийн үнэлгээ буурдаг,
 - Зах зээлийн үнэ тодорхойлоход ашиглах эх сурвалжаа нэрлэх, эсхүл ийм мэдээлэл, боломжоор хангах,
 - Байгаль орчинд ээлтэй болон тэргүүлэх салбарт хөрөнгө оруулалт, үйл ажиллагаа явуулсан тохиолдолд татварын хөнгөлөлт, дэмжлэг үзүүлдэг болох,
 - Хуулийн этгээд буюу ажил олгогчийн зүгээс ажилтны тогтвор суурьшилтай ажиллах, нийгмийн баталгааг хангах, нэмэгдүүлэх зорилгоор ажилтанд зориулан компанийн хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэхэд татвар болон нийгмийн даатгалын өндөр зардлаас үүдэн хүндрэл учирч байна. Тодорхой хязгаар зааж татвар ногдох,
 - Аливаа шинэ бизнес хөрөнгө оруулалтын хүлээсэн бодит алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцохдоо хугацааны болон дүнгийн хязгаарлалт тавьдаг нь бизнес эрхлэгчийг дэмжээгүй, тухайн бизнесийг хурдан хугацаанд хөл дээрээ босох боломжийг хязгаарласан хэтэрхий хатуу, бодит бус зохицуулалт тул хязгаарлалтгүй болгож, ашигтай ажилласан жилээсээ эхлэн өмнөх алдагдлаа бүрэн нөхдөг байхаар өөрчлөх,
 - Цахим, дижитал ажил, гүйлгээний татварын зохицуулалт, холдинг компани, мөнгөн хөрөнгийн удирдлагын татварын орчин бүрдүүлэх.
- Татварын хууль тогтоомжийн талаар олон хууль, журам, заавартай боловч уялдаа холбоогүй, нэр томьёо ерөнхий, ялгамжтай зохицуулалттай, дэмжлэг туслалцаа үзүүлдэггүй гэсэн саналууд дийлэнх хувийг эзэлсэн байна.

1.4.4.2. Засгийн газрын зарцуулалт

Монгол Улс Засгийн газрын зарцуулалтын үзүүлэлтээр 72.6 оноогоор үнэлэгдэж “ихэвчлэн эрх чөлөөтэй” ангилалд багтаж байна.

Энэ хэсгийн үнэлгээнд “Засгийн газрын зардал тэг” байхыг жишиг (benchmark) гэж үзэн үнэлдэг байна. Засгийн газрын зардал бол зайлшгүй, харин ДНБ-ий 30%-иас хэтэрсэн тохиолдолд үнэлгээ муудаж эхэлдэг байна. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувиас хэтрэхгүй байх шаардлагыг тусгасан.


1.4.4.3. Төсвийн зохистой байдал

Эдийн засгийн эрх чөлөөний индексийн төсвийн зохистой байдлын үзүүлэлт нь сүүлийн 3 жилийн төсвийн алдагдлын дундаж (ДНБ-д эзлэх хувь) онооны 80%-ийг, нийт улсын өр (ДНБ-д эзлэх хувь) нь онооны 20%-ийг жинлэж тооцдог.

Монгол Улсын төсвийн зохистой байдлын үзүүлэлт нь 73.5 оноогоор үнэлэгдэж, улсын өр ДНБ-д 46.8%-ийг эзэлж байгаа нь оптимал харьцаанаас (Дэлхийн банкны зөвлөмжөөр хөгжиж буй улсын өрийн ДНБ-д эзлэх оновчтой харьцаа нь 40%) өндөр байна.

Өрийн удирдлагын тухай хуулиар Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх шаардлагыг заасан.

График 8. Сүүлийн таван жилийн Засгийн газрын өрийн мэдээлэл (ҮСХ-ны мэдээлэлд үндэслэв ^{76 77}. Хэмжих нэгж: тэрбум.төг)



⁷⁵ <https://g24.org/wp-content/uploads/2024/06/G24-Policy-Brief-65-04-09-2012-.pdf>

⁷⁶ https://www2.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_0500_001V1&13999001_select_all=0&13999001SingleSelect=T1&ISIC_I_select_all=0&ISIC_ISingleSelect=0&YearY_select_all=0&YearYS-


[ingleSelect=_2024_2023_2022_2021_2020&viewtype=linechart](#)

⁷⁷ https://www2.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_0700_028V1&DEBT_select_all=0&DEBTSingleSelect=_1&YearQ_select_all=0&YearQSingleSelect=_202501_202404_202304_202204_202104_202004&viewtype=linechart

Бүлгийн явцын дүгнэлт:

Засгийн газрын хэмжээ бүлгийн үзүүлэлтүүдийг Монгол Улсын хувьд сүүлийн 30 жилийн өөрчлөлтөөр графикийн дагуу харууллаа.

График 9. Засгийн газрын зохицуулалт бүлэг



Хэритэж сангаас “Монгол Улсын хувь хүний орлогын албан татварын дээд хэмжээ 20 хувь, аж ахуйн нэгжийн татварын дээд хэмжээ 25 хувь байна. Татварын ачаалал ДНБ-ий 20.2 хувьтай тэнцэж байна. Гурван жилийн төсвийн зарлага ДНБ-ий 30.2%, төсвийн тэнцлийн дундаж нь ДНБ-ий 3.7%-тай тэнцэж байна. Улсын өр ДНБ-ий 46.8 хувьтай тэнцэж байна” гэсэн ерөнхий дүгнэлтийг хийжээ.

2. Асуудлыг шийдвэрлэх зорилго

Монгол Улсын Үндсэн хуульд “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.” гэж эдийн засгийн талаар төрийн гүйцэтгэх чиг үүргийг тусгаснаас өөр эдийн засгийн харилцааны талаар тодорхой зохицуулалтгүй байгаа нь Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг илэрхийлж байна.

Манай улсад 933 хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаагаас эдийн засаг, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой харилцаанд хамаарах давхардсан тоогоор 226, бизнесийн буюу аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх харилцаанд нийтлэг байдлаар нэн түрүүнд хамаарах 19 хууль, дагалдах 145 журам байна. Төрөөс эдийн засгийн харилцаанд зохицуулалт хийхдээ, тухайлан аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд баримтлах зарчим тодорхой бус, олон хууль, журмуудаар тархаан зохицуулахдаа ерөнхий зарчим алдагдсан, өөр хоорондоо зөрчилдсөн байдал түгээмэл байна.

Мөн ЭЗЭЧИ, бусад судалгаанаас харахад бизнес эрхлэхэд шударга, эрх тэгш байдал, хувийн өмчийн эрх хангагдаж баталгаажсан байдал, хөрөнгө оруулалтын болон санхүүгийн эрх чөлөө хэрэгжиж буй байдал, шүүх засаглалын үр нөлөө, бие даасан байдал нь олон улсад өрсөлдөх түвшнээс доогуур байна.

Иймд эдийн засаг, аж ахуйн үйл ажиллагааны эрх чөлөөний суурь зарчмуудыг бататгах, аж ахуй эрхлэгч ашгийн төлөө үйл ажиллагаа явуулахад баримтлах (төрөөс хүлээгдэж буй баталгаа, төрийн оролцоо, чиг үүрэг, хязгаар, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн үүрэг, хариуцлага) үндсэн зарчмыг нэгтгэн тодорхойлсон, төр болон аж ахуй эрхлэгчийн хооронд харилцан үнэнч шударгаар, хууль ёс болон итгэлцлийг хамгаалах зарчмыг тогтоосон, эдийн засгийн үйл ажиллагаа чөлөөтэй байх, урьдчилан таамаглаж болохуйц байдлыг бий болгоход чиглэсэн хууль баталж асуудлыг шийдвэрлэх шаардлага тавигдаж байна. Тус хуулийг баталж, эдийн засгийн эрх чөлөөг тогтмол, гуравдагч бие даасан байгууллагаар үнэлүүлж, ололт амжилт, алдаа дутагдлыг Улсын их хурал, Засгийн газар, нийгмийн түвшинд хэлэлцэж байх нь цаашид эрх чөлөөний баталгааг өргөжүүлэхэд чухал ач холбогдолтой байна.

3. Бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа

Олон улсын туршлагаас харахад бизнес эрхлэх эрх чөлөөг хуульд тусгаж, төрийн оролцоог хязгаарлах нь бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчдад шийдвэр гаргалтад эерэг нөлөө үзүүлэхээс гадна төр болон хувийн хэвшлийн албан ёсны зөвшилцлийн тогтолцоотой, тодорхой зарчимтай байх нь төрөөс эдийн засгийн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд бодлого нь иргэд, олон нийт болон бизнес эрхлэгчдийн итгэлийг төрүүлсэн, залгамж чанартай, урьдчилан тооцоолох бололцоотой, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх, цаашлаад эдийн засаг, хөрөнгө оруулалтын өсөлтийг хангах, тогтвортой байдлыг хадгалахад чухал нөлөөтэй.

Манай улсын эдийн засаг, нийгмийн нөхцөл байдалтай адил төстэй орнуудад бизнес эрхлэх эрх чөлөөг хамгаалах, хэт их хяналт, бичиг баримтын шаардлагыг бууруулах, төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хуульчилж, хэрэгжүүлсэн байна. Тухайлбал Бүгд Найрамдах Казахстан Улс, Гүрж Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс, Бүгд Найрамдах Киргиз Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын эдийн засгийн эрх чөлөөг хангах эрх зүйн зохицуулалтыг сонгон судаллаа.

⁷⁵ <https://g24.org/wp-content/uploads/2024/06/G24-Policy-Brief-65-04-09-2012-.pdf>

⁷⁶ https://www2.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_0500_001V1&13999001_select_all=0&13999001SingleSelect=_T1&ISIC_I_select_all=0&ISIC_ISingleSelect=_0&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2024_2023_2022_2021_2020&viewtype=linechart


https://www2.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_0700_028V1&DEBT_select_all=0&DEBTSingleSelect=_1&YearQ_select_all=0&YearQSingleSelect=_202501_202404_202304_202204_202104_202004&viewtype=linechart

3.1. Гүрж Улс

Гүрж улс 2005 онд “Rose Revolution”-ыг хийж эдийн засгийн хууль эрх зүйн тогтолцоогоо бүхэлд нь шинэчилсэн. Энэ шинэчлэл нь татварын хууль, бизнесийн зохицуулалт, засаглалын тогтолцоонд төвлөрсөн байв.

Энэ шинэчлэлийн хүрээнд 2005 онд эдийн засгийн өсөлтийг дэмжих, хөрөнгө оруулалтад ээлтэй орчныг бүрдүүлэх, бизнесийн орчныг сайжруулах болон татварын соёл, сахилга батыг нэмэгдүүлэх зорилгоор Татварын хуулийг шинэчлэн баталсан. Хуулийн гол өөрчлөлтүүд нь олон төрлийн татварын тоог (22 төрлийн татвар байсныг) цөөрүүлж (7 болгон багасгасан), татвар хураах захиргааны үйл явцыг хялбаршуулж, хамрагдалтыг нэмэгдүүлсэн.⁷⁸ Шинэчилсэн татварын зохицуулалт гайхалтай санхүүгийн үр дүнд хүрсэн бөгөөд гаалийн татвараас бусад бүх төрлийн татварын орлого өссөн байна. Үүнд: НӨАТ 7 дахин, ХХОАТ 8 дахин, ашгийн татвар 10 дахин өсжээ. Гүрж Улсын татварын шинэчлэл амжилттай хэрэгжсэн энэ жишээ нь эдийн засгийн хямралын үед ч чөлөөт зах зээлийн шийдлээр асуудлыг шийдэж чадна гэдгийг нотолж байна.⁷⁹

Зураг 6. Гүрж Улсын татварын шинэчлэлийн дараах татварын орлого



Эдийн засгийн эрх зүйн орчныг дэмжих өргөн хүрээний шинэчлэл нь бизнесийн бүртгэлийг хялбаршуулж, зөвшөөрлийн шаардлагыг эрс багасгасан. Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийг хувьчлах хууль болон Төрийн худалдан авалтын тухай хуулийг баталсан бөгөөд Авилгын эсрэг хуулийг чангатгаж өөрчлөлтүүд орсон.

Rose revolution-ы өөр нэг гол өөрчлөлт нь Зөвшөөрөл, лицензийн хуулийг баталсан бөгөөд зөвшөөрөл шаардлагатай үйл ажиллагааны тоог 909-өөс 159 болтол багасгасан. Ингэхдээ хэрэгцээгүй, хуучирсан зөвшөөрлүүдийг халж, шаардлагатай зөвшөөрлүүдийг

хялбаршуулсан. Мөн “нэг цэгийн үйлчилгээ”-г нэвтрүүлж, “төрийн байгууллага хуулийн хугацаанд хариу өгөхгүй байвал” зөвшөөрсөнд тооцно гэсэн зарчим үйлчилж эхэлсэн.

Дээрх цогц арга хэмжээ, реформуудын үр дүнд Гүрж Улс бүсийнхээ хамгийн бизнест ээлтэй улс болсон бөгөөд авилгыг бууруулж, ил тод байдлыг нэмэгдүүлж, хөрөнгө оруулагчдыг татаж чадсан. Тухайн реформ хэрэгжсэн 8 жилийн хугацаанд тус улсын дотоодын нийт бүтээгдэхүүн 3 дахин нэмэгдсэн байна. Дэлхийн банкны “Doing Business” тайланд Гүрж Улс аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд хамгийн ээлтэй улсын жагсаалтын 7-д бичигдэж байна.

Гүрж Улс реформын ололт амжилтаа хуульчлан баталгаажуулах зорилгоор Эдийн засгийн эрх чөлөөний хуулийг 2011 онд баталсан. Тухайн хуулиар бага татвар, хязгаарлагдмал төрийн зардал, төрийн хамгийн бага оролцоотой зохицуулалтын зарчмыг баталгаажуулсан. Хуульд зааснаар шинэ татвар нэвтрүүлэх, эсвэл татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх (онцгой болон орон нутгийн татварыг эс тооцвол) тохиолдолд заавал үндэсний санал асуулга авах шаардлагатай болсон. Энэ нь эдийн засгийн эрх чөлөөг хамгаалж, авилга, үр ашиггүй засаглалаас сэргийлэх зорилготой.

Санхүүгийн сахилга батын хувьд:

- Засгийн газрын зардал ДНБ-ий 30%-аас хэтрэхгүй.
- Төсвийн алдагдал ДНБ-ий 3%-аас хэтрэхгүй.
- Улсын өр ДНБ-ий 60%-аас доош байна гэсэн шалгууруудыг тогтоосон.

2015 онд Гүрж Улс шинэчлэлийн хандлагыг тогтвортой хадгалах, хөрөнгө оруулагчидтай харилцан зөвшилцөх зорилгоор Хөрөнгө оруулагчдын зөвлөлийг байгуулсан. Тухайн зөвлөлд төрийн албан тушаалтнууд, дотоод, гадаадын аж ахуй эрхлэгчдийн төлөөлөгчдийг оролцуулсан. Зөвлөл нь Ерөнхий сайд даргалсан хурлуудыг тогтмол зохион байгуулж, хөрөнгө оруулагчдын тулгамдаж буй асуудлыг хэлэлцэж, бизнесийн орчныг сайжруулах бодит арга хэмжээг авдаг.

Дэлхийн банкны “Doing Business” тайланд Гүрж Улс нь аж ахуй үйл ажиллагаа эрхлэхэд хялбар байдлаараа 190 орноос 7-д, Хэритэж сангийн Эдийн засгийн эрх чөлөөний индексээр 184 улсаас 35-д эрэмбэлэгддэг.

3.2. Бүгд найрамдах Казахстан улс

Бүгд найрамдах Казахстан Улсын парламент “Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн кодекс” -ыг 2015 оны 10 дугаар сарын 29-нд баталж, 2016 оны 01 дүгээр сарын 01-нээс хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү кодекс нь Бүгд

⁷⁸ <https://www.imf.org/external/np/seminars/eng/2011/revenue/pdf/rusu-da.pdf>

⁷⁹ Tax Foundation байгууллагын цахим хуудас <https://taxfoundation.org>.

[org/research/all/global/tax-reforms-in-georgia-2004-2012/](https://www.taxfoundation.org/research/all/global/tax-reforms-in-georgia-2004-2012/) (Сүүлд үзсэн: 2025.10.15) ⁷⁹ Tax Foundation байгууллагын цахим хуудас <https://taxfoundation.org/research/all/global/tax-reforms-in-georgia-2004-2012/> (Сүүлд үзсэн: 2025.10.15)

Найрамдах Казахстан Улсад бизнес эрхлэх эрх чөлөөг хангах хууль зүйн, эдийн засгийн болон нийгмийн нөхцөлүүдийг тодорхойлж, бизнесийн субъектүүд болон төрийн хооронд үүсэх нийгмийн харилцааг зохицуулах бөгөөд үүнд төрөөс бизнесийг зохицуулах, дэмжих арга хэмжээнүүд багтана. Кодекс нь 7 хэсэг, 31 бүлэг, 324 зүйлээс бүрдэнэ.

Бизнесийн субъектүүд болон төр хоорондын харилцаа нь Бүгд Найрамдах Казахстан Улсад бизнес эрхлэлт болон нийгмийн хөгжилд таатай нөхцөл бүрдүүлэх, бизнесийн санаачилгыг дэмжих зорилготой. Иймээс төр болон хувийн хэвшлийн хоорондын харилцааны ерөнхий зарчмуудыг маш тодорхой зааж өгсөн байдаг. Үүнд:

1. хууль дээдлэх;
2. аж ахуйн үйл ажиллагааны эрх чөлөө;
3. аж ахуйн үйл ажиллагаанд оролцогчдын эрх тэгш байдал;
4. өмчийн халдашгүй байдал;
5. шударга өрсөлдөөн;
6. хэрэглэгч, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч болон төрийн ашиг сонирхлын тэнцвэртэй байдал;
7. төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал болон мэдээллийн хүртээмжтэй байдал;
8. аж ахуйн үйл ажиллагааны төрийн зохицуулалтын үр нөлөөтэй байдал;
9. аж ахуйн нэгж эрх, хууль ёсны ашиг сонирхлоо бие даан хамгаалах чадварыг нэмэгдүүлэх;
10. гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд тэргүүлэх ач холбогдол өгөх;
11. аж ахуй нэгж үйл ажиллагаагаа шударга явуулж байгааг урьдчилан хүлээн зөвшөөрөх, төр болон аж ахуйн нэгж харилцан хариуцлага хүлээх;
12. авлигаас ангид байх байдал;
13. аж ахуйн үйл ажиллагааг идэвхжүүлэн дэмжих, түүнийг хамгаалах;
14. дотоодын үйлдвэрлэгчид, бараа, ажил, үйлчилгээг дэмжих;
15. аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд төрөөс хууль бусаар хөндлөнгөөс оролцохыг хориглох;
16. хувийн хэвшлийг эрх зүйн акт боловсруулахад оролцуулах;
17. аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх;
18. аж ахуйн үйл ажиллагааны төрийн оролцоог хязгаарлах. Тус хуулийн 1.4-т “Хэрэв Бүгд Найрамдах Казахстан Улсын аж ахуйн үйл ажиллагаа эрхлэлттэй холбоотой хууль

тогтоомжуудын хооронд зөрчил, зөрүү, эсвэл хийдэл илэрвэл энэхүү Кодексийн заалтыг давуу эрхтэйгээр хэрэглэнэ” гэжээ.

Энэ хуульд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч болон төр хоорондын харилцааг зохицуулсан бөгөөд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн хууль тогтоох үйл ажиллагаанд оролцох оролцоог тодорхой зааж өгсөн байдаг. Казахстан Улсын Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн тухай кодексыг баталж хэрэгжүүлснээр тус улсын эрх зүйн болон эдийн засгийн орчинд хэд хэдэн чухал үр нөлөө гарсан. Үүнд:

1. Энэхүү кодексээр дараах 6 хуулийн зохицуулалтыг нэгтгэж, эдгээр хуулиуд нь 2016 оны 1-р сарын 1-нээс эхлэн бие даасан эрх зүйн актын хувьд хүчин төгөлдөр бус болсон:

- Хувийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн тухай хууль
- Өрсөлдөөний тухай хууль
- Хөрөнгө оруулалтын тухай хууль
- Төрийн хяналт, шалгалтын тухай хууль
- Аж үйлдвэрийн болон инновацийн үйл ажиллагааг төрөөс дэмжих тухай хууль
- Тариаланч, фермерийн аж ахуйн тухай хууль.
- Ингэснээр бизнесийн эрх зүйн орчныг цэгцтэй, давхардалгүй, ойлгомжтой болгож өгсөн. ⁸¹

2. Төр ба хувийн хэвшлийн харилцаанд тодорхой зарчмуудыг нэвтрүүлсэн бөгөөд энэ нь төрийн оролцоог хязгаарлах, аж ахуй эрхлэгч өөрийгөө зохицуулах тогтолцоог дэмжих, нийгмийн хариуцлагыг урамшуулах, ил тод байдал, хариуцлагатай байдлыг идэвхжүүлсэн. Мөн шинжээчдийн зөвлөл, зохицуулалтын нөлөөллийн шинжилгээ зэрэг механизмыг бий болгож, хувийн хэвшлийн дуу хоолойг хууль тогтоох үйл явцад тусгах нөхцөлийг бүрдүүлсэн. ⁸²

3. Аж ахуйн үйл ажиллагааны эрхийг хамгаалах Омбудсмен-ийг нэвтрүүлж, аж ахуй эрхлэгч төрийн байгууллагын үйлдлийг давж заалдах эрх олгосон. Мөн төрийн албан тушаалтны хууль бус оролцоонд хариуцлага хүлээлгэх зохицуулалт тодорхой болсон.

4. Өрсөлдөөний тухай хууль шинэчлэгдэж зах зээлд давамгай байдалтай этгээдийн хүрээг нарийсгасан. Мөн эвлэрлийн комисс-ыг нэвтрүүлж, шүүхээс өмнөх шатад маргаан шийдвэрлэх боломжийг нээсэн. Үнэ тогтоох зохицуулалтаас зах зээлийн өрсөлдөөний арга хэрэгсэлд шилжсэн.

5. Кодексийн хэрэгжилтийн нөлөөнд бизнесийн орчин сайжирч, хөрөнгө оруулалтын сонирхол нэмэгдсэн.

⁸⁰ Казахстан Улсын аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн тухай хууль, https://track.unodc.org/uploads/documents/BRI-legal-resources/Kazakhstan/9_-_Commercial_Entrepreneurial_Code_EN.pdf

⁸⁰ Казахстан Улсын аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн тухай хууль, https://track.unodc.org/uploads/documents/BRI-legal-resources/Kazakhstan/9_-_Commercial_Entrepreneurial_Code_EN.pdf

Зохицуулалтын бодлого олон улсын стандартад ойртсон. Дэлхийн банкны “Doing Business” тайланд Казахстан Улс нь аж ахуй үйл ажиллагаа эрхлэхэд хялбар байдлаараа 190 орноос 25-д, Хэритэж сангийн Эдийн засгийн эрх чөлөөний индексээр 184 улсаас 68-д эрэмбэлэгддэг.

3.3. Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс

Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс стратегийн салбарт төрийн хяналтыг хадгалахын зэрэгцээ хувийн хэвшил, аж ахуйн үйл ажиллагааг дэмжих чиглэлээр бизнесийн хууль тогтоомжоо шат дараатай шинэчилж ирсэн. Энэ шинэчлэлийн эхний суурь нь 2000 онд батлагдсан “Аж ахуй нэгжийн тухай хууль” бөгөөд тус хуулиар иргэн, аж ахуй нэгж хуульд хориглоогүй бол аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх эрхтэй гэж тодорхой зарчмыг тусгасан.

Практикт Вьетнам Улс аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд олон төрлийн урьдчилсан зөвшөөрөл авах шаардлагатай тогтолцооноос сөрөг жагсаалтын тогтолцоо руу шилжсэн. Хуульд хориглосон салбарууд (жишээ нь, хууль бус мансууруулах бодис, зэрлэг ан амьтдын худалдаа) болон хязгаарлалттай салбаруудыг (банк, боловсрол гэх мэт тодорхой ур чадвар, хөрөнгө шаарддаг) тодорхой зааж өгсөн. Эдгээр жагсаалтад ороогүй бүх салбаруудад аж ахуйн үйл ажиллагаа чөлөөтэй эрхлэх боломжтой болохыг хуульчилсан.

Энэ өөрчлөлт нь Вьетнам Улсад аж ахуй эрхлэлтийг ихээхэн дэмжсэн бөгөөд иргэн, аж ахуй нэгжүүд Засгийн газрын төлөвлөгөөний дагуу батлагдсан тодорхой салбаруудаас бусад салбарт үйл ажиллагаа явуулахдаа зөвшөөрөл хүсэх шаардлагагүй болсон.

Мөн Вьетнам улс хууль, дүрэм боловсруулах үйл явцыг нээлттэй болгож “Хууль эрх зүйн баримт бичгийг нийтлэх тухай” хуулийг баталж, хууль журмын төслийг олон нийтийн санал асуулгад 60 хоногийн турш нээлттэй байршуулж, эцэслэн батлахаас өмнө аж ахуй эрхлэгч, иргэд саналаа өгч хэлэлцүүлэг явуулах боломжийг олгосон.

Дэлхийн банкны “Doing Business” тайланд Вьетнам Улс нь аж ахуй үйл ажиллагаа эрхлэхэд хялбар байдлаараа 190 орноос 70-д, Хэритэж сангийн Эдийн засгийн эрх чөлөөний индексээр 184 улсаас 61-д эрэмбэлэгддэг.

3.4. Киргиз Улс

Төв Азийн шилжилтийн эдийн засагтай орнуудын нэг болох Киргиз Улс нь 2001 онд “Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн эрхийг хамгаалах тухай хууль”-ийг

баталсан. Энэ хуулиар аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх гэдгийг өргөн утгаар нь тодорхойлж, аж ахуй нэгжүүдийг хэт их зохицуулалтаас хамгаалах үндсэн зарчмуудыг хуульчилсан. Хуулийн гол агуулга нь:

- Шударга байдалд итгэх зарчим (good faith) буюу аж ахуй эрхлэгч анхнаасаа хуулийг сахин биелүүлэх хүсэлтэй гэж үзэн, сэжиглэн хандах ёсгүй.
- Хууль тогтоомжийн зөрчил, хийдлийг аж ахуй эрхлэгчийн эсрэг тайлбарлахыг хориглоно. Хэрэв хууль тодорхойгүй бол төрийн байгууллагууд аж ахуй эрхлэгчдэд эрх ашигтайгаар тайлбарлах үүрэгтэй.
- Төрийн байгууллагын үндэслэлгүй оролцоо, нэмэлт шаардлагыг хориглоно. Хуульд заагаагүй нэмэлт бичиг баримт, төлбөр, нөхцөл шаардахыг хориглоно.
- Дээрх заалтууд нь аж ахуй эрхлэгчийг гэнэтийн шалгалт, албан бус хураамж зэрэг нийтлэг зөрчлөөс хамгаалах хууль эрх зүйн хамгаалалт болж өгсөн.
- Үүнээс гадна Киргиз Улс Засгийн газрын тогтоолоор Бизнес хөгжлийн болон хөрөнгө оруулалтын зөвлөл байгуулсан бөгөөд энэ Зөвлөл нь Засгийн газар болон хувийн хэвшлийн харилцан зөвшилцөх платформ болж ажилласан. Зөвлөлийн үйл ажиллагааны үр дүн Засгийн газрын оролцоо, хүсэл эрмэлзлээс болж өөр өөр байсан.

Дэлхийн банкны “Doing Business” тайланд Киргиз Улс нь аж ахуй үйл ажиллагаа эрхлэхэд хялбар байдлаараа 190 орноос 80-д, Хэритэж сангийн Эдийн засгийн эрх чөлөөний индексээр 184 улсаас 115-д эрэмбэлэгддэг.

3.5. БНХАУ

БНХАУ-ын эдийн засгийн эрх чөлөө, бизнесийн орчин нь ээдрээтэй бөгөөд зөрчилтэй дүр зургийг харуулдаг. Тус улс нь дэлхийн эдийн засгийн хүчирхэг гүрэн боловч зохицуулалт, улс төрийн бүтэц нь дотоодын болон гадаадын аж ахуй эрхлэгчдэд ихээхэн хязгаарлалт тавьдаг. Эдийн засгийн эрх чөлөөний индекс 2025 үзүүлэлтээр БНХАУ нь 49 оноо авч 184 улсаас 151-т эрэмбэлэгдэж байгаа бөгөөд эрх чөлөөний хувьд “дарлагдсан” ангилалд байгаа.

БНХАУ 2025 оны 4-р сард Хувийн эдийн засгийг хамгаалах тухай хууль (Private economy promotion law)-ийг баталж, 2025 оны 05-р сарын 20-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Нийт 9 бүлэг, 78 зүйл бүхий тус хууль нь шударга өрсөлдөөн, хөрөнгө оруулалт, санхүүжилтийг дэмжих, шинжлэх ухаан технологийн инноваци, аж ахуйн үйл

⁸¹ Entrepreneurial Code Of The Republic Of Kazakhstan: Key Novelities, 2015, <https://www.mondaq.com/corporate-and-company-law/453856/entrepreneurial-code-of-the-republic-of-kazakhstan-key-novelities>, (Сүүлд үзсэн:2025.09.15)

⁸² Information Memorandum Entrepreneurial Code of the Republic of Kazakhstan, https://aequitas.kz/upload/files/Information%20Memorandum_Entrepreneurial%20Code%20of%20the%20Republic%20of%20Kazakhstan.pdf (Сүүлд үзсэн:2025.09.15)

ажиллагаа эрхлэх зохицуулалт /regulatory guidance/ болон төрөөс үзүүлэх үйлчилгээний дэмжлэг, эрх ашиг сонирхлыг хамгаалах, хуулийн өмнө хүлээх хариуцлага зэрэг өргөн цар хүрээг хамарна.

Хятад улс Хувийн эдийн засгийг хамгаалах тухай хуулийг баталснаар хувийн хэвшлийг дэмжих, шударга өрсөлдөөнийг хангах, хууль зүйн хамгаалалт бий болгох, инноваци, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, бизнес эрхлэгчдийн итгэлийг сэргээх зорилгыг дэвшүүлсэн.

Хятадын хууль тогтоогчид “хувийн эдийн засгийн хөгжлийг дэмжих эрх зүйн баталгааг бэхжүүлэх, зах зээлийн шударга өрсөлдөөнд оролцох, хөрөнгө оруулалт, санхүүжилтийн дэмжлэг авах, хууль ёсны эрх ашгаа хамгаалах зэрэг асуудлыг шийдвэрлэх шаардлагатай” гэж мэдэгдэж байсан бөгөөд энэ хуулиар “төр хувийн хэвшлийг тууштай дэмжих, чиглүүлэх бодлогыг хуульчилж, хувийн хэвшлийн байр суурийг улам бататгасан” гэж тунхагласан.

Хувийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчид нь Хятадын ДНБ-ий 60%-аас дээш, технологийн инновацийн 70%, хотын ажил эрхлэгчдийн 80%-ийг бүрдүүлдэг бөгөөд эдийн засгийн тогтвортой байдал, ажлын байр бий болгоход чухал үүрэгтэй. Энэ хуульд хувийн хэвшлийн эрх зүйн байдлыг тодорхойлж, хувийн хэвшлийн хөгжил нь урт хугацааны үндэсний зорилт гэдгийг хуульчилсан.⁸³

Хувийн аж ахуй нэгжүүд нь төрийн өмчит аж ахуйн нэгжүүдтэй харьцуулахад зээл авах, тодорхой салбаруудад оролцох боломж багатай зэрэг ялгавартай байдалтай тулгарсаар ирсэн. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд энэхүү хуульд “салбарын бодлого нь өрсөлдөөний бодлогыг зөрчиж болохгүй; орон нутгийн хамгаалалт, үйлдвэрлэлийн монополь зэрэг далд саад бэрхшээлүүдийг тогтмол хянаж, арилгах талаар” тусгасан. Мөн сонгон шалгаруулалтын хяналт, ялгавартай зохицуулалтыг хориглож, эдийн засгийн бүх салбарт нэг стандарт үйлчлэхийг баталгаажуулсан.⁸⁴

Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийг тогтвортой, өндөр чанартай хөгжихөд /энэ нь зөвхөн эдийн засгийн өсөлтөөс гадна бүтээмжтэй, инновацийн суурилсан, байгаль орчинд ээлтэй, нийгмийн тэгш байдлыг хангах хөгжлийн загвар/ эрх зүйн баталгаагаар хангаж, институтын дэмжлэг үзүүлэх бөгөөд бизнесийн орчныг илүү шударга, ил тод, таамаглах боломжтой болгох зорилгыг тавьсан. Мөн орон нутгийн засаг захиргаанаас хууль бусаар хөрөнгө хураах, бизнес эрхлэгчдийг үндэслэлгүйгээр (шүүхээс гадуур) баривчлах зэрэг эрсдэлээс хамгаална гэдгийг хуульчилсан.

Шинжээчид энэ хуулийг эдийн засгийн өсөлтийг хангаж,

ажлын байр нэмэгдүүлэх, бизнесийн орчныг тогтвортой болгоход чухал гэдгийг онцолсон бөгөөд Хятадын хууль тогтоогчид “төр хувийн хэвшлийг тууштай дэмжих, чиглүүлэх бодлогыг хуульчилж, хувийн хэвшлийн байр суурийг улам бататгасан” гэж мэдэгдсэн.

Явцын дүгнэлт: Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийг баталсан улсууд нь хуучин төвлөрсөн төлөвлөгөөт, нэг намын удирдлагын тогтолцоотой байсан, шилжилтийн үеийг туулж буй улс орнууд байна. Иймд эдгээр орнуудын туршлагыг Монгол Улсын нөхцөл байдалд тохируулан хэрэгжүүлэх боломжтой.

Казахстан Улсын хувьд төрийн оролцоог хязгаарлах, хувийн хэвшлийн зах зээлийн зохицуулалтыг дэмжих, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд хувийн хэвшлийн оролцоотойгоор дүрэм журам боловсруулах гол зарчмуудыг тунхагласан нь хувийн хэвшлийн төлөөллийн оролцоог баталгаажуулсан.

Гүрж Улсын хувьд зохицуулалтыг хялбаршуулах нь бизнесийн орчныг эрс сайжруулдаг гэдгийг баталсан. Манай улс ч мөн адил зөвшөөрөл, лиценз олгохдоо шаардлагагүй саад тотгорыг арилгах зарчим баримталснаар эдийн засгийн эрх чөлөөг нэмэгдүүлэх боломжтой. Мөн Гүрж улс Хөрөнгө оруулагчдын зөвлөл байгуулж өндөр түвшний улс төрийн дэмжлэг, тусгайлан нөөцөөр ханган ажилласнаар бизнес, хөрөнгө оруулалтын орчинд бодит өөрчлөлтүүдийг авчирч татварын орчныг сайжруулан, гаалийн журмыг хялбаршуулж чадсан. Гүрж Улсын туршлагаас авч үзэхэд хэт эрчимтэй шинэчлэл нь барилгын аюулгүй байдлын хяналт зэрэг зарим хамгаалалтын тогтолцоог түр хугацаанд доголдуулсан. Иймээс зөвшөөрлийг хялбаршуулахдаа хамгаалалтын механизмыг хадгалж үлдэх шаардлагатай болохыг харуулсан.

Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын туршлагаас үзэхэд “сөрөг жагсаалт” бүхий систем нэвтрүүлсэн нь аж ахуй эрхлэгчдэд ойлгомжтой, тодорхой бизнесийн орчныг бүрдүүлж өгсөн. Оролцогч талуудад нөлөөлж болох шийдвэрүүдийг олон нийтэд танилцуулж, санал авах механизм бүрдүүлснээр тохиолдож болзошгүй асуудлыг эрт илрүүлж, арга хэмжээ авахад тусалсан гэж харахаар байна. Вьетнам улсын хувьд хуулийн хэрэгжилт орон нутагт саатах тохиолдол гарч байсан бөгөөд сургалт, хяналт, гомдол хүлээн авах механизм зэрэг дагалдах арга хэмжээг төлөвлөх шаардлагатай болсон.

Киргиз Улсын туршлагаас хуульд заагаагүй төлбөр, зөвшөөрлийг хориглох, шинэ зохицуулалтуудыг аж ахуй эрхлэгчдэд цаг тухайд нь мэдэгдэх зарчмуудыг онцолж болно. Тус улсад хуулийн хэрэгжилт сул, авлига,

⁸³ БНХАУ-ын Хууль зүйн яамны цахим хуудас: http://en.moj.gov.cn/2025-05/07/c_1090846.htm

⁸⁴ “China's First Law to Promote Private Enterprise: What Does It Mean?”,

2025, <https://thediplomat.com/2025/05/chinas-first-law-to-promote-private-enterprise-what-does-it-mean/>

орон нутгийн албан тушаалтнуудын хэт оролцоо ихтэй тул албан тушаалтнуудыг сургах, гомдол хүлээн авах шугам нээх зэрэг дагалдах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай болсон.

Дээрх олон улсын жишиг, туршлагуудад үндэслэн дараах дүгнэлтийг хийлээ.

- Бизнес эрхлэх эрх чөлөөг хуульчилж, төрийн оролцоог хязгаарлах нь хөрөнгө оруулагчдад эерэг дохио болдог байна.
- Тогтмол, албан ёсны харилцааны механизм (танхим, зөвлөл, олон нийтийн санал авах) нь төрийн хариуцлагыг нэмэгдүүлж, шинэчлэлийг тогтвортой байлгадаг. Зөвлөлдөх механизмын үр дүнтэй байдал

нь улс төрийн дэмжлэг, зөвшилцлийн харилцааны хууль, зохицуулалтаас шууд хамаардаг. Тодорхойгүй байдал, улс төрийн сул дэмжлэг нь ахиц сааруулах эрсдэлтэй тул ихэвчлэн зөвлөлийг Ерөнхий сайдын дэргэд байгуулдаг байна.

- Төрийн албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулж, гомдол хүлээн авах, гомдол гаргагчийг хамгаалах механизмыг бүрдүүлэхийн зэрэгцээ бодлогын хүрэх үр дүнг тодорхойлж, үнэлэх шалгуур үзүүлэлтийг тогтоож, түүний дагуу тогтмол үнэлж, сайжруулах арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх нь үр дүнд эергээр нөлөөлдөг байна.

4. Зөвлөмж

Аж ахуйн үйл ажиллагаанд хамаарах, эдийн засгийн эрх чөлөөг хангахтай холбоотой дараах санал, дүгнэлт урьдчилсан тандан судалгааны үр дүнд гарч байна. Үүнд:

1. Төрөөс ямар салбарт, хэрхэн оролцож зохицуулах үндсэн зарчим, бодлого, арга хэмжээний төрлийг тодорхойлох,
2. Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаас бусад зорилгоор төрөөс эдийн засгийн эрх чөлөөг хязгаарласан, хориглосон хууль тогтоомж, захиргааны шийдвэр батлахгүй байх зарчмыг хуульчлах (эдийн засгийн салбарын хууль тогтоомж Үндсэн хуулийн дээрх заалтад нийцсэн эсэхийг нягтлах талаар заалт, дагалдах зохицуулалт), энэ хуулийн зарчим, зохицуулалтад нийцээгүй хууль тогтоомж, эрх зүйн актыг иргэн, хуулийн этгээд мөрдөхгүй байх эрхийг тусгах,
3. Төрийн зүгээс аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн эрх ашгийг хөндсөн бодлого боловсруулах, хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт санаачлахдаа иргэн, аж ахуйн нэгж, мэргэжлийн холбоодын оролцоог хангах, санал авах,
4. Аж ахуй эрхлэгчийн нэр томьёо, тодорхойлолтыг цэгцлэн тусгах,
5. Төр өөрийн өмчит хуулийн этгээдээр оролцох салбар, үндэслэл, хязгаарыг тогтоох,
6. Өмчийн хэлбэрээс үл хамааран аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчид тэгш хандах,
7. Төрөөс үзүүлэх дэмжлэгийн төрөл, салбарыг тодорхой тусгах,
8. Манай улсад хориглох үйл ажиллагааны салбарын жагсаалтыг нэг хуулиар зохицуулж, ийнхүү хориглосноос бусад аж ахуйн үйл ажиллагааг чөлөөтэй эрхлэх эрхийг тусгах,
9. Өмчийн эрхийн хамгаалалтыг өмчийн төрөл, хэлбэрээр бүрэн хангах зарчим,
10. Хууль тогтоомж хооронд давхардал, хийдэл, зөрчил үүссэн тохиолдолд хөрөнгө оруулагч, аж ахуйн үйл ажиллагаа

эрхлэгчийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн зохицуулалтыг баримтлах зарчим,

11. Төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус шийдвэр, үйлдэл, эс үйлдэхүйн улмаас аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчид хохирол учруулсан тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээлгэх, эрхийг сэргээх.

Арга хэмжээний санал:

12. Авлигатай тэмцэх тухай хуульд авлигын эрсдэлийн үнэлгээний талаарх зохицуулалтыг оруулах, эрх зүйн орчин бүрдүүлэх,
13. Оюуны өмчийн эрхийн хамгаалалт, эрхийн зөрчлийн хариуцлага, хяналтын тогтолцоонд анхаарах шаардлагатай. Оюуны өмчийн байгууллагыг зөвхөн бүртгэл хийхээс гадна оюуны өмчийг хүндэтгэх талаар олон нийтэд мэдээлэл түгээх, судалгаа хийх, хуулийн хэрэгжилтийг хангуулах, зөрчлийг илрүүлэх, арилгах, үүрэгжүүлэх,
14. Иргэний гэрээ, хэлцлийн маргааныг залилах болон бусад гэмт хэргээс ялгах, Эрүүгийн хуулийн эдийн засгийн гэмт хэргийн болон бизнесийн үйл ажиллагаа, харилцаанд хамаарах зохицуулалтуудыг субъектив байдлаар тайлбарлагдахааргүй, хэрэглэхгүй байхаар туйлын тодорхой тусгагдсан байх, хэрэглээг нэг мөр болгоход чиглэсэн судалгаа хийх, холбогдох арга хэмжээ авах,
15. Татварын хууль тогтоомжийн уялдааг сайжруулах, нэр томьёог нэг мөр болгох, татварын албаны хүнд суртлыг бууруулах,
16. Өмчийн эрхийн зөрчил, хамгаалагдаж буй байдал, гэрээний үүргийн зөрчилтэй холбоотой шүүхийн шийдвэрийн статистик тоон мэдээлэл, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах талаар дүн шинжилгээ хийхэд шаардлагатай мэдээллийн бааз бүрдүүлэх,
17. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн хэрэгжилтэд үр дагаврын үнэлгээг хийх, энэ хуульд заасан аж ахуйн нэгжийн ангиллаар хуулийн этгээдэд зөвшөөрөл, баримт бичиг шаардахгүйгээр үйл ажиллагаа

эхлүүлэх боломжийг олгох.

Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэсний дагуух зарчим бүхий Эдийн засгийн салбарын суурь хуулийг боловсруулах нь зүйтэй байна. Ингэхдээ эдийн засгийн эрх чөлөө болон бизнесийн эрх чөлөө нь цар хүрээний хувьд харьцангуй ялгаатай тул хуулийн төслийн агуулга, зохицуулалт, хамрах хүрээ, нэрийг анхаарах шаардлагатай.

Улс орнуудын эдийн засгийн эрх чөлөөний индексийн үзүүлэлтүүдийг гаргаж, дэлхий нийтээрээ баримжаа болгон, шийдвэр, үйл ажиллагаандаа ашиглаж буй үзүүлэлтүүд дээр манай улсын бага үнэлгээ авсан бүлгүүдэд хөндлөнгийн гуравдагч этгээдээр үнэлгээ хийлгэж, Засгийн газар, Улсын Их Хурал тогтмол хэлэлцэж, авах арга хэмжээний төлөвлөгөө батлаж байх нь зүйтэй гэж үзэж байна.

Түүнчлэн бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчдын гомдлыг шүүх, арбитрын маргаанаас өмнө хэлэлцэн шийдвэрлэх тогтолцоо дутагдалтай байгааг анхаарахаар байна.

Ном зүй

1. Монгол хэл дээрх эх сурвалж

А. Эрх зүйн эх сурвалж

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль,

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль,

Иргэний хууль,

Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль,

Өрсөлдөөний тухай хууль,

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль,

Хөрөнгө оруулалтын тухай хууль

Б. Ном, сурах бичиг

1. Нанзаддоржийн Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар, 2022 он

В. Эрдэм шинжилгээний бүтээл

1. Гочоогийн Банзрагч, “Эдийн засгийн харилцаан дахь төрийн зохицуулалтын нийтийн эрх зүйн үндэс, анхаарах асуудлууд”, 2017 он,

2. Гочоогийн Банзрагч, “Эдийн засгийн захиргааны эрх зүй нь захиргааны эрх зүйн тусгай ангийн бүрэлдэхүүн хэсэг болох нь”, 2017 он,

3. Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Монгол улсын хууль тогтоомж дахь хуулийн этгээдийн ойлголт, нэр томъёоны хэрэглээ”, 2021 он,

Г. Бусад

1. Авлигатай тэмцэх газар, “Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлтгын ерөнхий нөхцөл байдал, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт”, 2022 он,

2. Дэлхийн банк, Монгол Улсын гадаад худалдааны өрсөлдөх чадварын шинжилгээ тайлан, 2024 он

2. Гадаад хэл дээрх эх сурвалж

1. The Heritage Foundation, 2025 Index of Economic Freedom, 2025 он.

2. U.S Chamber of Commerce, “International IP Index 2025 Thirteenth Edition”, 2025 он

3. World Bank, “Women, Business and the Law 2024”, 2024 он

4. Economist Intelligence, “Democracy Index 2024”, 2025 он

3. Цахим эх сурвалж

1. АНУ-ын Төрийн департментын цахим хуудас:

<https://2021-2025.state.gov/reports/2024-investment-climate-statements/mongolia/>

2. АНУ-ын ЭСЯ-ын цахим хуудас: <https://mn.usembassy.gov/mn/2024-investment-climate-statement-mn/>

3. БНХАУ-ын Хууль зүйн яамны цахим хуудас: http://en.moj.gov.cn/2025-05/07/c_1090846.htm

4. Дэлхийн банкны цахим хуудас: <https://www.worldbank.org/en/publication/worldwide-governance-indicators>

5. Монголбанк, Монголын эдийн засаг - 30 жил сургамж ба шийдэл (Хөгжлийн загвараа эргэн харах нь) <https://www.mongolbank.mn/file/files/documents/1>

6. Казахстан Улсын аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн тухай хууль, https://track.unodc.org/uploads/documents/BRI-legal-resources/Kazakhstan/9_-_Commercial_Entrepreneurial_Code_EN.pdf

7. Транспаренси интернэшнл олон улсын байгууллагын цахим хуудас: <https://www.transparency.org/en/countries/mongolia>

8. Санхүүгийн зохицуулах хорооны цахим хуудас: <https://www.frc.mn/resources/Image/Document/202504/GfGys/AR2024-mgl.pdf>

9. Үндэсний статистикийн хорооны цахим хуудас, https://downloads.1212.mn/3_9EVFcYv1EnlKsk-j2Pq-N-W8_4jocj-OSw5rYce.pdf

10. Европын холбоо, АНУ-ын хамтарсан мэдээлэл солилцох хамтарсан хөтөлбөрийн цахим хуудас: <https://www.privacyshield.gov/ps/article?id=Mongolia-Protection-of-Property-Rights>

8. Хэритэж сангийн цахим хуудас: <https://www.heritage.org/index/pages/country-pages/mongolia>

9. TRACE Интернэшнл байгууллагын цахим хуудас: <https://www.traceinternational.org/trace-matrix#99>

11. Tax Foundation байгууллагын цахим хуудас <https://taxfoundation.org/research/all/global/tax-reforms-in-georgia-2004-2012/>

12. The Diplomats цахим хуудас: <https://thediplomat.com/2025/05/chinas-first-law-to-promote-private-enterprise-what-does-it-mean/>

12. Freedom House байгууллагын цахим хуудас: <https://freedomhouse.org/reports/freedom-world/freedom-world-research-methodology>



Я.БУДДАЯН -ОЧ

ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Мэргэжилтэн

ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ІРО-ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА



Оршил

Төрийн өмчит компанийн (ТӨК) анхдагч хувьцааг олон нийтэд санал болгох (Initial Public Offering – IPO)-ыг олон улсын туршлагаас харахад зөвхөн санхүүгийн эх үүсвэр татах арга хэмжээ бус, харин төрийн өмчийн удирдлагын тогтолцоог шинэ шатанд гаргах стратегийн шийдвэр гэж харагдаж байна. ТӨК-ийн IPO-г өмчийн тодорхой хувийг зах зээлд гаргах хэлбэрээр тайлбарлах нь хангалтгүй бөгөөд уг процесс нь олон үе шаттай, харилцан уялдаатай нарийн зохион байгуулалт шаардсан цогц институцийн шинэчлэл юм. Үүнд компанийн засаглалын, санхүүгийн үнэлгээ, салбарын бодлого, стратеги төлөвлөлт, улс төрийн мандат, хууль эрх зүйн шинэчлэл зэрэг тодорхой шалгуур, шаардлагыг хангасан бэлтгэл ажилд тулгуурладаг. Иймээс ТӨК-ийн IPO-г амжилттай хэрэгжүүлэх нь зөвхөн хөрөнгийн бирж дээр нээлттэй арилжаалах үйл явц биш, харин нарийн төлөвлөлт, сахилга баттай хэрэгжилт, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх замаар компанийн урт хугацааны стратегийн зорилгыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ нийтийн өмчийн үнэ цэнийг нэмэгдүүлэхэд оршино.

Дэлхийн банк, ЭЗХАХБ зэрэг олон улсын байгууллагын харьцуулсан судалгаануудаас хархад ТӨК-ийн IPO-г үндсэн таван зорилтын хүрээнд төлөвлөж хэрэгжүүлдэг байна.

I. Хөрөнгө татах замаар төсвийн ачааллыг бууруулах.

IPO-оор дамжуулан төрийн өмчийн тодорхой хэсгийг хөрөнгийн зах зээлд санал болгож, төсвийн дарамтыг бууруулах замаар санхүүгийн тогтвортой байдлыг сайжруулах боломж бүрддэг. Жишээлбэл, Норвегийн Statoil (одоогийн Equinor)-ийн 2001-д хийсэн IPO нь компанийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ төсвийн ачааллыг бууруулах, урт хугацааны тогтвортой байдлыг хангах зорилготой байв. Үүнээс хархад бусад улсын туршлагаудад IPO-оос төвлөрсөн орлогыг төсвийн урсгал зардалд зарцуулах бус, стратегийн хөрөнгө оруулалт, баялгийн сангийн хуримтлал зэрэг урт хугацааны зорилгод чиглүүлэх нь нийтлэг байдаг.

II. Үр ашиг болон ашигт ажиллагааг нэмэгдүүлэх зорилт

Төрийн өмчит компани хөрөнгийн биржид бүртгэлтэй болсноор ашигт үйл ажиллагаа, хөрөнгийн өгөөж, гүйцэтгэлийн үзүүлэлтүүд ил тод болж, зах зээлийн үнэлгээ нь компанийн гүйцэтгэлийн бодит хэмжүүр болдог. Үүний үр дүнд зардлын хяналт сайжирч, үр ашиггүй хөрөнгө оруулалт, нөөцийн хуваарилалт илүү оновчтой болдог.

III. Ил тод байдал болон компанийн засаглалыг сайжруулах

Олон улсын практикт IPO хийсэн төрийн өмчит компаниуд санхүүгийн тайлангаа олон улсын стандарт (IFRS)-ын дагуу боловсруулж, хөндлөнгийн аудитад хамруулдаг. Мөн компанийн засаглалыг бэхжүүлэх зорилгоор төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн оролцоог нэмэгдүүлж, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах зохицуулалтыг бүрдүүлдэг. Ийнхүү сайн засаглалын зарчмуудыг хэрэгжүүлэх нь улс төрийн шууд нөлөөллийг хязгаарлаж, шийдвэр гаргалтын ил тод байдал болон хариуцлагын тогтолцоог бэхжүүлдэг.

IV. Мэргэжлийн чадавх болон стратегийн хөрөнгө оруулалтыг татах

Олон улсын жишээнээс харахад IPO-г стратегийн хөрөнгө оруулагчийн оролцоотойгоор хэрэгжүүлэх нь компанийн технологийн чадавх, удирдлагын арга зүй, үйл ажиллагааны стандартыг сайжруулан олон улсын зах зээлд гарах боломжийг бүрдүүлдэг байна. Энэ нь зөвхөн хөрөнгө төвлөрүүлэхээр хязгаарлагдахгүй бөгөөд байгууллагын соёл, гүйцэтгэлийн менежмент, санхүүгийн сахилга бат, дотоод хяналтын тогтолцоонд чанарын өөрчлөлтийг бий болгодог.

V. Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх болон олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх.

ТӨК-ийн IPO нь хөрөнгийн зах зээлийн багтаамж, хөрвөх чадварыг нэмэгдүүлэхээс гадна дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэхэд нөлөөлдөг. Үүний зэрэгцээ иргэд хувьцаа эзэмших замаар үндэсний томоохон компанийн хувьчлалд оролцох боломж бүрдэж, хөрөнгийн зах зээл идэвхжиж хувь хөрөнгө оруулагчдын оролцоо нэмэгддэг.


Иймээс олон улсын жишигт ТӨК-ийн IPO-г дээрх таван зорилтыг уялдуулсан хэрэгжүүлэх хандлага давамгайлж байдаг.

Нийтлэг шинж нь:

- (i) Төр стратегийн эзэмшлийн хяналтаа тодорхой түвшинд хадгалах;
- (ii) Засаглал, институцийн шинэчлэлийг IPO-оос өмнө хэрэгжүүлэх;
- (iii) Хөрөнгийн зах зээлийг идвэхжүүлэх
- (iv) IPO-оос төвлөрсөн орлогыг урт хугацааны хөгжлийн зорилттой уялдуулах.


Эдгээрээс харвал IPO нь өмчийн энгийн нэг шилжилт бус, харин төрийн өмчийн удирдлагын тогтолцоог ил тод, хариуцлагатай, зах зээлийн зарчмаар ажиллах боломжийг бүрдүүлдэг. Үүний үр дүнд компанийн үр өгөөжийг нэмэгдүүлэх замаар нийтийн өмчийн үнэ цэнэ нэмэгддэг.

Бодит нөхцөл байдал: Төрийн хэт оролцоо болон компанийн засаглалын гажуудал нь төрийн өмчит компанийн гүйцэтгэлийг тогтмол сулруулж байна



Эх сурвалж: Mongolian State Property Policy and Coordination Agency 2022-24 reports for SOE performance; EDB research; additional research e.g. Natural Resource Governance Institute reports; news reports re SOE challenges.

Урьдчилсан байдлаар зөвлөгөө өгч болох хүрээ: Өнөөг хүртэл хамгийн ээдрээтэй үе шат



ТӨК-ийн өмчийн удирдлагыг сайжруулах, байгууллагын шинэчлэлийг хэрэгжүүлэх олон арга хэрэгсэл байдаг бөгөөд зөвхөн олон нийтийн хувьцаа гаргахаар хязгаарлагдахгүй

Төрийн өмчийн шинэчлэл хийх хувилбарууд



Менежментийг мэргэжлийн болгох



Гадаадын менежментийн гүйцэтгэх захирлуудыг томилж, бизнесийн үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд хүргэх.

Жишээ: **Maurice Flanagan** 1985 онд **Emirates** компанийн анхны Гүйцэтгэх захирлаар томилогдож, арав хүрэхгүй жилийн дотор дунджаар 30%-ийн өсөлттэй ажилласан.

Тус танилцуулга нь ЕТТ-ийн IPO-ийн боломж бололцооны талаар өгүүлсэн боловч, ЕТТ-ийн IPO-г хийх шийдвэр гаргахын өмнө шинэчлэлийн стратеги, дараалал болон тус компанийн цаашдын үйл ажиллагааны төлөвлөгөөний бүх боломжийг сайтар судлах шаардлагатай.

Төрийн өмчийн оролцоог бууруулах



Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт



ТӨК-ийг хувийн хөрөнгө оруулагчдад хэсэгчлэн эсвэл бүрэн худалдаж, улсын санхүүгийн ачааллыг бууруулах.

Жишээ: **British Telecom** 1984 онд хувьчлагдаж, ойролцоогоор 50%-ийн хувьцааг хөрөнгө оруулагчдад зарснаар үр ашиггүй байдлыг багасгаж, улсын санхүүгийн дарамтыг бууруулсан



Олон нийтэд хувьцааг нээлттэй болгох



Төрийн өмчит компанийн тодорхой хувийн хувьцааг хөрөнгийн бирж дээр арилжаалж, төр хяналтын багцаа авч үлдэх.

Жишээ: **Saudi Aramco** 2019 онд хэсэгчлэн хувьцаагаа гаргаж, олон тэрбум ам.долларын хөрөнгө татан төвлөрүүлж, компанийн засаглалын ил тод байдлыг сайжруулсан.

Бүтцийг нэгтгэх



Нэгтгэх



ТӨК-үүдийг нэгтгэн, давхардлыг арилгах, уялдаа холбоог бэхжүүлэх, цар хүрээг тодорхойлох замаар хэмнэлт бий болгох.

Жишээ: 2014 онд Солонгосын KDB нь KDB Санхүүгийн Бүлэг болон Korea Finance Corp-той нэгтгэгдэж, илүү тогтвортой, олон улсын өрсөлдөх чадвартай болсон.



Татан буулгах



Ашиггүй, тогтвортой бус ТӨК-үүдийг татан буулгаж, хувьчлах замаар, олон нийтийн нөөцийг дахин хуваарилах.

Жишээ: **Филиппиний National Steel Corp** нь 2000 онд бүтцийн өөрчлөлтийн оролдлого амжилтгүй болж, татан буугдсан.

Footnotes: [1] Emirates history [2] British Telecoms privatization; [3] KDB merger details [4] Aramco prospectus; [5] Record of liquidation process

Засгийн газраас ТӨК-үүдийг хөрөнгийн зах зээлд нэвтрүүлэх бодлогын үндэслэлүүд



Хөрөнгө татах замаар төсвийн ачааллыг бууруулах

- ТӨК-ийн хувьцааг олон нийтэд санал болгох (IPO) замаар төр нь төсвийн дарамтыг бууруулж, өрийн дарамтыг багасгах санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлдэг.
- Үлдсэн хувьцаанаас ногдол ашиг хүртэх нь төрийн хувьд тогтвортой орлогын эх үүсвэр болж өгдөг.



(ОУВС) судалгаагаар төрийн байгууллагууд IPO-оос олсон орлогыг ихэвчлэн хэрэглэж урх бус, харин хуримтлуулж, улсын санхүүгийн үзүүлэлтийг сайжруулах чиглэлд ашигладаг болохыг онцолжээ.



Үр ашиг болон ашигт ажиллагааг нэмэгдүүлэх

- IPO хийснээр ТӨК нь зах зээлийн хяналт, ОУ-ын санхүүгийн тайлагналын стандартыг (IFRS) мөрдөх, цөөнх хувьцаа эзэмшигчдийн хяналтыг нэмэгдүүлдэг.
- Зах зээлийн оролцоо болон өрсөлдөөнийг бий болгож, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх хөшүүрэг болдог.



Дэлхийн банкны олон улсын харьцуулсан судалгааны үр дүнгээр хөрөнгийн зах зээлд бүртгэлтэй ТӨК-үүд нь IPO хийснээс хойш гурван жилийн дотор бүрэн төрийн өмчит ижил төрлийн компаниудаасаа илүү үр ашигтай ажиллах хандлагатай байдаг.



Ил тод байдал ба компанийн засаглалыг сайжруулах

- ТӨК-ийг хөрөнгийн биржид бүртгүүлэх нь санхүүгийн тайланг аудитлуулах, хараат бус Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-тэй байх, хөрөнгө оруулагчдын эрхийг тэгш хангах зэрэг институтын тогтолцоог бүрдүүлдэг.
- Ил тод мэдээллийн орчин нь улс төрийн оролцоог хязгаарлаж, авлигын эрсдэлийг бууруулахын зэрэгцээ компанийн засаглалын стандартыг өргөн хүрээнд дээшлүүлдэг.



Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (OECD) ТӨК-ийн удирдамжид: ТУЗ-ийн түвшинд ил тод байдал, урамшууллын бодлого, өмчлөлийн үүргийн тодорхой хуваарилалт нь IPO хийхийн өмнөх гол нөхцөл гэж тодорхойлсон байдаг.



Мэргэжлийн чадавх ба стратегийн хөрөнгө оруулалтыг татах

- IPO-г олон улсын болон дотоодын томоохон хөрөнгө оруулагчидтай хамтран хэрэгжүүлснээр технологийн (ноу-хау) арга аргачлал, төслийн менежмент, олон улсын зах зээлд нэвтрэх боломжийг бүрдүүлэх стратегийн ач холбогдолтой.
- Гадаад болон дотоодын хөрөнгө оруулагчдыг түншлэлийг бүрдүүлснээр улс төрийн оролцог бууруулахад чухал нөлөөтэй.

Индонезийн PGE компани 2023 онд хувьцааны 25%-ийг хөрөнгийн зах зээлд гаргаж, АНЗУ-ын Masdar болон Индонезийн INA хөрөнгө оруулалтын санг үндсэн хөрөнгө оруулагч болгон татсанаар санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлээд зогсохгүй сэргээгдэх эрчим хүчний чиглэл мэргэжлийн мэдлэг, туршлага авсан.



Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх ба олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх

- Төрийн өмчит компанийн IPO нь тухайн улсын хөрөнгийн зах зээлд хөрвөх чадварыг нэмэгдүүлж, хувийн компаниудад "жишиг нөлөө"-г бий болгодог "демонстрацийн нөлөө"
- Иргэд жижиглэнгийн багцаар хувьцаа худалдан авснаар улсын стратегийн өмчид шууд оролцож, хувьцаа эзэмших соёлыг төлөвшүүлэх боломж олгодог.

Колумбын **Ecopetrol** компанийн 2007 оны IPO нь 500 мянган иргэнийг хувьцаа эзэмшигч болгож, тус улсын хамгийн том компани болж, 2017 он гэхэд Колумбын хөрөнгийн биржийн (BVC) нийт зах зээлийн үнэлгээний ~20.5%-ийг дангаар бүрдүүлж байв.

Footnotes: [1] IMF research; [2] World Bank report; [3] OECD Guidelines; [4] Pertamina Geothermal Energy listing details; [5] Ecopetrol's listing details

Бодлогын үндэслэл: Хөрөнгө босгох болон төсвийн ачааллыг бууруулах



Кейс судалгаа

Юу нөлөөлсөн бэ

Үр дүн



Saudi Arabia¹
Aramco-ийн 1.5%-ийг олон нийтэд санал болгосон.

• 2014 оны газрын тосны үнийн огцом уналт болон төсвийн алдагдлын дараа Саудын Араб улсын зүгээс төрийн өрийн өсөлтийг хязгаарлах, мөн эдийн засгийн төрөлжилтийг хангах шаардлага гарсан. Энэ хүрээнд төрийн өмчит нефтийн компани болох **Aramco**-ийн 1.5%-ийг олон нийтэд санал болгож, IPO болон бондын арилжааг эхлүүлэх замаар компанийн санхүүгийн тайланг олон нийтэд нээлттэй болгож, хараат бус аудитын дүгнэлтийг гаргуулж үйл ажиллагааны ил тод байдлыг эрс нэмэгдүүлэв.

- ❑ 2019 онд нийт 29.4 тэрбум ам.долларын орлого төвлөрүүлсэн нь дэлхийн хамгийн том IPO болж түүхэнд тэмдэглэгдсэн.
- ❑ 2024 онд дахин 11.2 тэрбум ам.долларын хувьцаа борлуулж, Vision 2030 хөтөлбөрийн хэрэгжилтийг санхүүжүүлэхэд ашигласан.
- ❑ IPO-ын тайлан, санхүүгийн баримт бичгүүд нь Aramco-ийн түүхэнд анх удаа олон нийтэд нээлттэй, хараат бус аудитлагдсан мэдээлэл болсон.



Poland^{2,3}
1990–2010 он хүртэл ТӨК-нь IPO хийсэн.

• Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн дараах шилжилтийн үед (1990-ээд он) болон дэлхийн санхүүгийн хямралын дараа (2010-аад он) Польш улс ТӨК-үүдийн IPO-хийж ил тод байдлыг нэмэгдүүлснээр эдийн засгаа тогтворжуулсан. Түүнчлэн томоохон нийтийн үйлчилгээний компаниудад (жишээ нь Tauron, Energa) цөөнхийн хувьцааг борлуулж, хувийн болон стратегийн хөрөнгө оруулагчдыг татан оролцуулсан.

- ❑ Tauron-оос 4.2 тэрбум злот, Energa-гаас 2.4 тэрбум злот босгож, 2008–2011 оны хооронд нийтдээ 52 тэрбум злотын хувьчлалын орлого олсон.
- ❑ Давтан борлуулалт нь хүнд зах зээлийн нөхцөлд бэлэн мөнгө босгох боломж олгож, төрд ногдол ашигтай орлогын эх үүсвэр бий болгосон.



Romania^{4,5,6,7,8}
2012–2014 онд Эрчим хүчний ТӨК-ийг (ОУВС)Тусламжтайгаар хийсэн IPO хийсэн.

• 2008–2009 оны санхүүгийн хямралын дараа өндөр төсвийн алдагдалтай тулгарсан Румын улс ОУВС болон Европын Холбооноос санхүүгийн дэмжлэг авахын тулд эрчим хүчний салбарын ТӨК-үүдийг IPO хийсэн. Энэ хүрээнд таван томоохон компани (Electrica, Romgaz, Nuclearelectrica, Transgaz, Transelectrica)-ийн хувьцааг олон нийтэд санал болгосон.

- ❑ 2012–2014 оны хооронд нийтдээ 1 тэрбум еврогийн хөрөнгө босгож, өрийн дарамтыг бууруулсан.
- ❑ Хувийн хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлж, эрчим хүчний салбарын үр ашгийг дээшлүүлсэн.
- ❑ Үүний зэрэгцээ, ашгийн урсгалаас төр тогтмол ногдол ашиг хүртэх боломжтой болсон.



Aramco-ийн ганц томоохон IPO болон Польш, Румын улсын олон жилийн IPO хөтөлбөрийн туршлагаас харахад ТӨК-үүдийн хувьцааг олон нийтэд санал болгох нь тухайн улсын ДНБ-ий мэдэгдэхүйц хувийг төсвөөс стратегийн хөрөнгө оруулалт руу шилжүүлэх боломжийг бүрдүүлдэг. Ингэснээр төрийн хяналт алдагдахгүйгээр эдийн засгийн тогтвортой байдал, зах зээлийн хөгжил, хөрөнгө оруулалтын урсгалыг зэргэцүүлэн хангах боломжтой болдог.

Footnotes: [1] Aramco sale; [2] Tauron IPO; [3] Energa IPO; [4] Electrica IPO; [5] Romgaz IPO; [6] Nuclearelectrica IPO; [7] Transgaz IPO; [8] Transelectrica IPO.

Бодлогын үндэслэл: Мэргэжлийн чадавх ба стратегийн хөрөнгө оруулалт татах



- ❑ IPO-г стратегийн хөрөнгө оруулагчидтай хослуулах нь технологи, төслийн сахилга бат, дэлхийн зах зээлд нэвтрэх боломжийг бий болгодог.
- ❑ Холимог консорциумын бүтцээр гадаадын ноу-хауг дотоодын өмчлөлтэй уялдуулан улс төрийн болгоомжлолыг саармагжуулах боломжтой.

Кейс судалгаа

Юу нөлөөлсөн бэ

Үр дүн



Indonesia¹
PGE (Pertamina Geothermal Energy) 2023 онд хувьцааны 25%-ийг олон нийтэд санал болгож, АНЭУ-ын Masdar болон Индонезийн INA-тай стратегийн түншлэл байгуулсан.

• Эрчим хүчний салбарт дэлхийн түвшний стратегийн түнш татах байсан бөгөөд IPO энэ боломжийг бүрдүүлсэн.
• Индонезид улсын төсвийн хязгаарлалтаар газрын гүний дулааны хүчин чадлаа гурав дахин нэмэгдүүлэх зорилгоо биелүүлэхийг зорьсон.

- ❑ PGE гадаадын хөрөнгө болон стратегийн түншүүдийг амжилттай татсан. Masdar нь дэлхийн хоёр дахь том гүний дулааны зах зээлд нэвтрэх боломж олж авсан.
- ❑ Гадаадын хөрөнгө, зах зээлийн нөөцийг ашигласан.



UAE²
ADNOC Drilling 2018–2021 онд нийт 16%-ийн хувьцааг олон нийтэд санал болгосон.

• Америкийн *Baker Hughes* компанийн өрөмдлөг, менежментийн дэвшилтэт арга технологийг нутагшуулсан.
• Ажилтнуудад сургалт хийж, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлсэн.
• Хөрөнгийн тодорхой хэсгийг шинэ төслүүдэд хөрөнгө оруулах боломж бүрдүүлсэн.

- ❑ Америкийн *Baker Hughes* компанийн өрөмдлөг, менежментийн дэвшилтэт арга технологийг нутагшуулсан.
- ❑ Ажилтнуудад сургалт олгож, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлсэн.
- ❑ Хөрөнгийн тодорхой хэсгийг мөнгөнжүүлж, шинэ төслүүдэд хөрөнгө оруулах боломж бүрдүүлсэн.



China^{3,4,5,6}
2000-аад оны дунд үед томоохон төрийн банкууд IPO хийхдээ гадаадын стратегийн хөрөнгө оруулагчдыг татан оролцуулсан.

• Банкны салбарт хуримтлагдсан чанаргүй зээлийн дарамтыг бууруулахад дэмжлэг болсон.
• Барууны банкууд эрсдэлийн менежментийн шилдэг туршлагыг нутагшуулсан.
• Гадаадын хөрөнгө оруулагчид засаглалын чанарыг сайжруулж, олон улсын нэр хүндийг нэмэгдүүлсэн.

- ❑ IPO-оос өмнө Хятадын томоохон банкууд гадаадын стратегийн хөрөнгө оруулагчдыг (ж.нь. Bank of America – CCB, Goldman/Allianz/AmEx – ICBC, RBS – BOC) татсан.
- ❑ Давхар дахин хөрөнгөжүүлэлт, муу активын менежментийн компаниудын (AMC) оролцоотойгоор ашгийн чиг баримжаатай соёлыг бий болгосон.
- ❑ 2000-аад оны сүүлчээр чанаргүй зээлийн харьцаа эрс буурч, банкуудын засаглал, санхүүгийн тогтвортой байдал сайжирсан.



Индонез, АНЭУ, Хятадын туршлагаас харахад IPO-ыг гадаадын стратегийн түншлэлтэй хослуулах нь:

- Технологи, менежментийн шилдэг туршлагыг нутагшуулах;
- Үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх;
- Засаглалын чанарыг сайжруулах;

Хөрөнгө босгох үйл явцыг эрсдэл багатайгаар хэрэгжүүлэх боломжийг олгодог.

Footnotes: [1] PGE IPO; [2] ADNOC IPO & BHGE partnership details; [3] Bank of America - China Construction Bank; [4] ICBC strategic partnerships; [5] Royal Bank of Scotland - Bank of China; [6] IMF report.

Бодлогын үндэслэл: Үр ашиг ба ашигт ажиллагааг нэмэгдүүлэх



- IPO хийх нь олон улсын санхүүгийн тайлагналын (IFRS) шаардлага, цөөнхийн хөрөнгө оруулагчдын оролцоог бий болгож, арилжааны зарчмыг тогтоодог
- Судалгааны үр дүнгээс харахад ихэнх салбарт IPO хийсний дараа өрсөлдөөн болон бүтцийн шинэчлэлийн нөлөөгөөр ашигт ажиллагаа сайжирдаг.

Кейс судалгаа

Юу нөлөөлсөн бэ

Үр дүн



Argentina¹

1993 онд үндэсний газрын тосны компани **YPF** нийт хувьцааныхаа 45%-ийг олон нийтэд санал болгосон.

• Ашиггүй, үр ашиг муутай төрийн байгууллагын загвараас хувийн хэвшлийн түвшний гүйцэтгэл рүү шилжсэн.
• Өмнө нь хувийн хэвшлийн газрын тосны удирдлага байсан гүйцэтгэх захирлыг томилж, ажиллагсдын тоог 52,000-аас 10,600 болгон бууруулсан.
• Үндсэн бус үйл ажиллагаа болох нефть боловсруулах үйлдвэр, сургууль, эмнэлэг, агаарын тээврийн компаниудыг салгасан.



India²

1990–2000-аад онд хэд хэдэн төрийн өмчит компанийг хэсэгчлэн IPO хийсэн.

• IPO-ийн дараа борлуулалтын өгөөж, хөдөлмөрийн бүтээмж, хөрөнгө оруулалтын түвшин мэдэгдэхүйц өссөн.
• Зах зээлийн дарамт нь зардал бууруулах, орчин үеийн нягтлан бодох бүртгэлийг нутагшуулах, мэргэжлийн менежерүүдийн бие даасан байдлыг нэмэгдүүлэхэд хүргэсэн.



Kenya³

Kenya Airways 1995 стратегийн түншлэл байгуулсан

- 1995 онд Кени улсын үндэсний агаарын тээврийн компани **Kenya Airways** алдагдалтай ажиллаж байсан тул төр нь **KLM**-ийг стратегийн түншээр татан оруулж, 1996 онд хувьцааны 26%-ийг олон нийтэд санал болгосон.
- KLM-ийн менежментийн туршлага болон хувийн хөрөнгө оруулагчдын оролцоогоор компанийн үйл ажиллагааны үр ашиг мэдэгдэхүйц сайжирсан.



Зах зээлийн дарамт, стратегийн хөрөнгө оруулагчдын оролцоо, IPO-ийн нээлттэй зах зээлийн шаардлага нь ТӨК-үүдийн бүтцийн шинэчлэлд хүчтэй нөлөөлж иржээ. Аргентин, Энэтхэг, Кенийн жишээнээс харахад IPO нь: Үндсэн бус хөрөнгөөс татгалзах; KPI ба орчин үеийн удирдлагын арга барил нэвтрүүлэх; Бүтээмж, үр ашгийг дээшлүүлэх; Эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх бодит хөшүүрэг болж байв.

Footnotes: [1] YPF restructuring success case study; [2] Indian SOE listing performance; [3] Kenya Airways PPP and IPO success story.

Бодлогын үндэслэл: Ил тод байдал ба засаглалыг сайжруулах



- IPO хийх нь аудитлагдсан санхүүгийн тайланг олон нийтэд ил тод болгох, хараат бус удирдах зөвлөлтэй болох, хувьцаа эзэмшигчдийг тэгш эрхтэйгээр хамгаалах нөхцөлийг бүрдүүлдэг.
- Мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх нь улс төрийн нөлөөлөл болон авлигын эрсдэлийг бууруулж, төрийн өмчит компанийн (ТӨК) түвшинд засаглалын стандартыг бүхэлд нь дээшлүүлдэг.

Кейс судалгаа

Юу нөлөөлсөн бэ

Үр дүн



Brazil^{1,2}

Петробрас нь АНУ-ын NYSE хөрөнгийн биржийн бүртгэлийн стандарт болон хараат бус ТУЗ-ийг бий болгосон

• Petrobras-ийн хэсэгчилсэн хувьчлалын дараа санхүүгийн тайлагнал илүү ил тод болж, хувьцаа эзэмшигчдэд хуулийн хариуцлага хүлээлгэх тогтолцоо бий болсон.
• 2014–2015 оны "Car Wash" авлигын дуулиан нь тогтолцооны өөрчлөлтийг өдөөж, ТӨК-ийн тухай хуулийг шинэчлэхэд хүргэсэн. Үүнд удирдах зөвлөлийн болон менежментийн хяналтыг чангатгах, ил тод байдлын болон засаглалын зарчмын шинэ дүрмүүдийг тусгасан.

- "Car Wash" хэрэг болон зах зээлийн дарамтын улмаас Petrobras-ийн үнэлгээ 2010 оны оргил үеэсээ 200 тэрбум ам.доллараар буурсан.
- Энэ үйл явдал Бразилын ТӨК-үүдийн засаглалын хууль тогтоомжийг шинэчлэхэд чухал түлхэц болсон.



Saudi Arabia^{3,4}

Aramco 2019 онд IPO хийж, хувьцааны 1.5%-ийг олон нийтэд санал болгосон.

• IPO-ийн өмнө бүрэн аудитлагдсан санхүүгийн тайлан нийтлэггүй байсан ч 2019 оны бонд, IPO-ийн проспект нь олон улсын IFRS стандартад нийцсэн анхны аудитлагдсан тайлан болсон.
• DeGolyer & MacNaughton компанийн бие даасан газрын тосны нөөцийн гэрчилгээ 2019 оны 1-р сард батлагдаж, ~268.5 тэрбум баррель нөөцтэй болохыг тогтоосон.

- Хөрөнгө оруулагчдын эрсдэлийн ойлголт буурч, итгэл нэмэгдсэн.
- Олон улсын стандартад нийцсэн сайн засаглалын жишиг тогтож, санхүүгийн тайлагнал сайжирсан.



Kazakhstan^{5,6,7,8,9,10,11}

Самрук-Казына (СК) – томоохон ТӨК-ыг удирдах, IPO гаргах зорилгоор байгуулагдсан толгой компани

• 2012 оноос эхлэн Samruk-Kazyna (үндсэн хөрөнгө оруулалтын сан, ТӨК-ийн толгой компани) нь засаглалын шинэчлэл хийж, шат дараалсан IPO хэрэгжүүлсэн.
• Энэ хүрээнд хараат бус удирдах зөвлөлийн гишүүдийг нэмэгдүүлж, ил тод байдлын стандартыг сайжруулсан.
• Жишээ нь: KazTransOil (2012, KASE), KEGOC (2014, KASE), Kazatomprom (2018, LSE/AIX/KASE), Air Astana (2024, KASE/AIX/LSE).
• Эдгээр IPO-оор нийтдээ ойролцоогоор 3.7 тэрбум ам.доллар босгосон.

- Засаглалын шинэчлэл нь хараат бус гишүүдийн тоог нэмэгдүүлэх, мэдээллийн ил тод байдлыг чангатгах, олон нийтэд тайлагнах тогтолцоог бий болгосон.
- Мөн цөөнхийн хувьцаа эзэмшигчдийн оролцоог баталгаажуулж, томоохон ТӨК-үүдийн засаглалын түвшинг дээшлүүлсэн.



Petrobras болон Samruk-Kazyna-ийн туршлагаас харахад IPO болон олон улсын жагсаалтын хатуу шаардлагууд нь нэг талаас хууль эрх зүйн болон удирдах зөвлөлийн шинэчлэлийг түргэтгэж, ил тод байдлыг нэмэгдүүлдэг. Нөгөө талаас шинэчлэлийн өмнөх сул засаглал, мэдээллийн хаалттай байдал нь хөрөнгө оруулагчдад ихээхэн эрсдэл, өртөг авчрах боломжтойг харуулж байна.

Footnotes: [1] Petrobras; [2] SOEs; [3] Aramco; [4] Oil reserves; [5] SK governance; [6] People's IPO; [7] 2016–20 plan; [8] KazTransOil; [9] KEGOC; [10] Kazatomprom; [11] Air Astana.

Бодлогын үндэслэл: Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх ба олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх



- IPO хийх нь хөрвөх чадварыг нэмэгдүүлж, хувийн компаниудад "жишиг нөлөө"-г бий болгодог.
- Мөн жижиглэнгийн багцын санал нь иргэдэд үндэсний өмчид шууд оролцох боломж олгож, хувьцаа эзэмших соёлыг төлөвшүүлдэг.

Кейс судалгаа	Юу нөлөөлсөн бэ	Үр дүн
 Colombia¹ Ecopetrol 2007 онд IPO хийсэн.	• IPO-г иргэдэд хүртээмжтэй байдлаар багцалж, 1,000 ширхэг хувьцааг хэсэгчлэн төлөх нөхцөлтэйгөөр санал болгосон бөгөөд өргөн хүрээний сурталчилгаа хийсэн. • 2011 он гэхэд компанийн зах зээлийн үнэлгээ 88 тэрбум ам.долларт хүрч, Колумбын хөрөнгийн зах зээлийн хамгийн үнэ цэнтэй компаниудын нэг болсон.	□ Компанийн 10%-ийг санал болгож, 2.8 тэрбум ам.доллар босгосон. □ Хөрөнгийн зах зээлд оролцсон иргэдийн тоо 0.5 саяар нэмэгдэж, тэдний ихэнх нь хувьцаа эзэмшигч болж буй анхны тохиолдол болсон. □ Ecopetrol нь Колумбын хөрөнгийн биржид ноёрхох байр сууриа баталгаажуулж, гадаадын хөрөнгө оруулагчдыг татсан.
 Kenya² Safaricom 2008 – 25% stake sold of Govt's 60% (40% held by Vodafone)	• Кени улсын иргэдийн ~860,000 нь хувьцаа худалдан авч, компанийн түүхэнд хамгийн өргөн хүрээний хувьцаа эзэмшигчтэй компани болсон. • Жижиглэнгийн олон тооны хөрөнгө оруулагчид, тэр дундаа хөдөө орон нутгийн иргэд оролцсон. • IPO илүү захиалагдсан нь буцаан олголтын дараалал, мөн залилангийн асуудлыг дагуулсан.	□ IPO-д хэдэн зуун мянган шинэ хөрөнгө оруулагч оролцож, жижиглэнгийн хөрөнгө оруулагчдын тоо 0.8 саяаас 1.7 сая болж хоёр дахин нэмэгдсэн. □ Засгийн газар ирээдүйд нэмэлт хувьцааг олон нийтэд санал болгохын тулд энэ хөрөнгө оруулагчдын суурийг ашигласан.
  Poland³ & Romania⁴ 1990-ээд оноос 2010-аад он хүртэл улсын өмчит компаниудын жагсаалтыг ашиглан хөрөнгийн зах зээлээ эхнээс нь эхлүүлсэн.	• Польш улс хөрөнгийн зах зээлийг бүрэн эхнээс нь хөгжүүлэхдээ ТӨК-үүдийн IPO-д тулгуурлаж, 2014 он хүртэл нийтдээ 148 тэрбум злот (~28 тэрбум ам.доллар)-ын орлого олсон. • Румын улс ОУВС-ийн хөтөлбөрийн хүрээнд таван томоохон эрчим хүчний компанийн IPO хийж, ойролцоогоор 1 тэрбум еврогийн орлого төвлөрүүлсэн бөгөөд үүний үр дүнд зах зээлийн гүнзгийрэл, компанийн засаглалын чанар сайжирсан.	□ Польшийн хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 1991 онд 0 байсан бол 2002 он гэхэд ДНБ-ий 20%-д хүрсэн. □ Шинэ IPO-уудыг хийхэд хөрөнгийн биржид шаардлагатай хөрвөх чадварыг бий болгосон. □ Тэтгэврийн сан болон жижиглэнгийн хөрөнгө оруулагчдын оролцоог дэмжсэн.

Footnotes: [1] Ecopetrol's retail success story; [2] Safaricom IPO details; [3] Ownership Transformation of Polish Economy (1990–2012); [4] IMF-Romania MoU; more detail on slide 17.

IPO хийхэд тулгарах сорилтууд

Бодлогын сорилт	Яагаад үнэ цэнийг алдгуулдаг вэ ?	Улсууд	Бодит жишээ	ЭТТ-д хамааралтай байдал
Салбарын Бодлогын шинэчлэл хийгдээгүй	Татаастай тариф, хоёрдмол үнэ тогтоолт, гэнэтийн экспортын хориг, улс төрийн шийдвэр зэрэг нь IPO-ийн дараах бизнесийг суйруулж болзошгүй.		Бразилын Petrobras: Засгийн газраас тогтоосон дотоодын түлшний үнийн дээд хязгаар (2011–2014) нь Petrobras-д 23 тэрбум ам.долларын татаасны зардал учруулж, компанийн цэвэр өрийг 109 тэрбум ам.долларт хүргэсэн (дэлхийн газрын тосны томоохон компаниудын дундаас хамгийн өндөр). Үүний зэрэгцээ Нью-Йоркийн хөрөнгийн бирж дээрх ADR нь 2014 онд л гэхэд 45% буурсан .	Манай улсад ч "онцгой дэглэмтэй" засаглал, нүүрсний салбарын бодлогын төлөвлөлт, төрийн татаас болон ад-хок (тодорхой зорилгоор) арга хэмжээ авч байгаа нь тогтвортой бус байдлыг бий болгож ирсэн. IPO-ийн дараа эдгээр бодлогын хязгаарлалтыг хэрхэн зохицуулах эсвэл нөхөн олговор олгохыг урьдчилан тодорхой болгох нь зах зээлийн оролцогчдод чухал.
Засаглал ба тайлагналын зөрүү	Хараат бус ТУЗ байхгүй, IFRS-ийн нягтлан бодох бүртгэл болон цөөнхийн хөрөнгө оруулагчдын эрхийг хамгаалах тогтолцоо сул бол хөрөнгө оруулагчид үнэлгээг бууруулдаг.		PetroChina: Дэлхийн газрын тосны том компаниудтай харьцуулахад үнэлгээ нь доогуур арилжаалагдааар ирсэн. Энэ нь төрийн нөлөө, CNPC-тэй өргөн хүрээний харилцан хамааралтай талуудын хэлцэлтэй холбоотой гэж хөрөнгө оруулагчид үздэг. НКЕК-ийн дүрмийн дагуу компани эдгээрийг "үргэлжилж буй харилцан хамааралтай хэлцэл" гэж тайлагнадаг.	ЕТТ-ийн хамгийн сүүлийн баримт бичигт дөрвөн хараат бус ТУЗ-ийн гишүүн бүртгэгдсэн нь ахиц боловч олонх болоогүй. Олон улсын хөрөнгө оруулагчид үнэлгээ хийхдээ хараат бус байдлын харьцаа, аудит/эрсдэлийн хороо, IFRS тайлагналын давтамжийг харгалзан үзэх магадлалтай.
Үнэ тогтоолт ба багцын хуваарилалтын алдаа	IPO-ийг хэт доогуур үнэлэх нь сонгогчдыг баярлуулдаг ч "flip & flee" буюу шууд борлуулж гарах үзэгдэл бий болдог. Харин хэт өндөр үнэлгээ нь хөрөнгө оруулагчдын буймдал, улс төрийн эсэргүүцэл үүсгэж болзошгүй.		Кенийн KenGen (2006): IPO-ийн анхны ханш KSh 11.90 байсан бол анхны өдрийн хаалтын ханш +236% өсөж KSh 40 хүрсэн. Жижиглэнгийн хөрөнгө оруулагчдын эрэлт (4 дахин хэтрүүлэн захиалсан) их байсан ч удалгүй ихэнх нь хувьцаагаа зарж, улмаар ханш IPO-ийн үнээс доош унасан.	1072 хувьцааны схемд 3.4 сая иргэн аль хэдийн оролцсон байгаа. Энэ схемийг IPO-д хамруулах арга (ханш хөрвүүлэлт, түгжих хугацаа, буцаалтын журам) нь анхны өдрийн ханшийн хэлбэлзэл болон улс төрийн уур амьсгалд хүчтэй нөлөөлнө.
ESG ба уур амьсгалын сорилт	Дэлхийн хөрөнгө удирдлагын компаниуд нүүрстөрөгчийн эрсдэлийг улам бүр нарийн шалгаж байна. ESG үзүүлэлтээр шуулт хийдэг хөрөнгө оруулагчид нүүрс, дулааны цахилгаан үйлдвэрлэлийн төсөлд хөрөнгө оруулах сонирхолгүй байдаг. Шилжилтийн тодорхой стратеги дутмаг бол хөрөнгө оруулагчдын хүрээ		Саудын Aramco (2019): Дотоодын хөрөнгийн зах зээлд дээр IPO нь 119 тэрбум ам.долларын эрэлт татсан ч олон улсын зах зээлд бүтэлгүйтэж, олон улсын хөрөнгө оруулагчдын оролцоо сул байсан. ESG-ийн шүүлтүүрээр хөрөнгө оруулалтыг хязгаарласан учир голчлон дотоодын болон бус нутгийн хөрөнгө оруулагчид захиалга өгсөн.	ESG сангуудын ихэнх нь нүүрс болон дулааны эрчим хүчний компаниудад хөрөнгө оруулдгийг зогсоосон. Тиймээс ЕТТ-г IPO хийхдээ нүүрснээс гарах стратеги, уурхайн хаалтын төлөвлөгөө, эсвэл ялгарал бууруулах тодорхой суурь үзүүлэлтэйгээр олон нийтэд танилцуулах шаардлагатай.

Footnotes: [1] Ecopetrol's retail success story; [2] Safaricom IPO details; [3] Ownership Transformation of Polish Economy (1990–2012); [4] IMF-Romania MoU; more detail on slide 17.

IPO хийхэд тулгарах сорилтууд

Бодлогын сорилт	Яагаад үнэ цэнийг алдгуулдаг вэ ?	Улсууд	Бодит жишээ	ЭТТ-д хамааралтай байдал
Дотоодын хөрөнгийн зах зээлийн сул хөгжил	Том хэмжээний хувьцааны санал нь хөгжиж буй, жижиг хөрөнгийн зах зээлд хэт том байж болзошгүй. Хэрэв хөрвөх чадвартай хөрөнгө гадагш шилжвэл дотоодын бодлогын өгөөж алдагдана.		Польш: ТӨК-үүдийн IPO-оос бүрдсэн тогтвортой урсгал нь Варшавын хөрөнгийн биржийн зах зээлийн үнэлгээг 1995 онд 4.6 тэрбум ам.доллараас 2007 онд 212 тэрбум ам.долларт хүргэсэн. Энэ нь тухайн үед ДНБ-ий 46%-тай тэнцэж байсан бөгөөд томоохон хувьчлалуудын өмнө өргөжсөн.	Монголын хөрөнгийн биржийн өдөр тутмын дундаж эргэлт нь ЕТТ-ийн үнэлгээний маш багахан хэсгийг л эзэлж байна. Энэ нь хөрвөх чадварын эрсдэлийг тодорхой харуулж байна.
Институционал хөрөнгө оруулагчдын суурь сул	Тэтгэврийн сан, даатгалын компани, улсын хөрөнгө оруулалтын сангууд сул хөгжсөн нөхцөлд хувьцааны худалдаа тогтворгүй гадаад урсгалаас ихээхэн хамааралтай болж, зах зээлийн уналтын үед үнэлгээг унагадаг.		Дэлхийн банкны 30 жилийн дүгнэлт: ТӨК-ийн IPO-д тэтгэврийн сан, хөрөнгө оруулалтын сан, даатгалын компани зэрэг дотоодын институционал тулгуур хөрөнгө оруулагчид тогтворжуулах чухал үүрэгтэйг онцолжээ.	Монгол улсад тэтгэврийн сан, даатгалын байгууллагуудын оролцоо маш бага хэвээр байна. Энэ нь санхүүгийн системийн тэтгэврийн томоохон багана, даатгалын хөрөнгийн хэмжээ сул хөгжсөнийг илтгэнэ. Иймээс тэднийг эхний үе шатнаас "тулгуур хөрөнгө оруулагч" болгон татах оролцуулах эсвэл тэтгэврийн сангийн шинэчлэлийг хурдасгах нь эрсдэлийг бууруулах чухал алхам байх болно.
Улс төрийн цаг хугацаа ба итгэлцлийн эрсдэл	IPO-ийг хэт доогуур үнэлэх нь сонгогчдыг баярлуулдаг ч "flip & flee" буюу шууд борлуулж гарах үзэгдэл бий болдог. Харин хэт өндөр үнэлгээ нь хөрөнгө оруулагчдын бухимдал, улс төрийн эсэргүүцэл үүсгэж болзошгүй.		Энэтхэгийн LIC IPO: 2021 оноос 2023 он хүртэл хоёр удаа хойшлогдсон. Үнэлгээний өөрчлөгдөж буй тайлбарууд нь хөрөнгө оруулагчдын итгэлийг сулруулж, жижиг хэмжээний хэлцэл болж хувирсан. Үр дүнд нь энэ IPO нь Энэтхэгийн түүхэн дэх хамгийн том үнэлгээтэй гарсан ч захиалга нь дөнгөж 3 дахин л хэтрүүлэн захиалагдсан .	ЕТТ-ийн IPO-г 2010 оноос хойш хэд хэдэн удаа зарлаж, дахин дахин хойшлуулсан нь хөрөнгө оруулагчдын дунд эргэлзээ үүсгэсээр байна. Тиймээс сонгуулийн мөчлөгөөс үл хамаарах, найдвартай цагийн хуваарь боловсруулах нь зайлшгүй бөгөөд ингэснээр "execution discount"-ийн эрсдэлээс зайлсхийх боломжтой.

Footnotes: [1] Poland's market cap of listed companies; [2] World Bank report; [3] LIC IPO review.



О.БАДРАЛ
ШИНЭ СЭРГЭЛТ
ИННОВАЦИЙН ХӨТӨЛБӨР

Ахлах шинжээч

ЭРЧИМ ХҮЧНИЙ НҮҮРС, ГАЗ АШИГЛАДАГ ЭХ ҮҮСВЭРИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ



ЭРЧИМ ХҮЧНИЙ НҮҮРС, ГАЗ АШИГЛАДАГ ЭХ ҮҮСВЭРИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ


1. Судалгааны зорилт

1.1. Хөгжлийн бодлогын төлөвлөлт, шалгуур үзүүлэлт

Монгол Улсын “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын “Эдийн засаг” бүлэгт тэргүүлэх чиглэлд эрчим хүчний салбарыг тусгасан. Шинэ эх

үүсвэрийг барьж, цахилгаан эрчим хүчээр дотоодын хэрэгцээг бүрэн хангасан, эрчим хүч экспортлогч орон болсон байх зорилтыг тусгасан байдаг. Урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинд “Эдийн засаг” бүлэгт эрчим хүчний салбар тусгагдаагүй бөгөөд “Бүс, орон нутгийн хөгжил” хэсэгт эрчим хүчээр хангагдсан хүн амын эзлэх хувь хэмжээг зааж өгсөн байдаг.

Зураг 1. “Алсын хараа 2050” эрчим хүчний төлөвлөлт



Эх сурвалж: Эрчим хүчний яам, 2022

Монгол Улсын дунд хугацааны бодлогын баримт бичиг болох Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл,

мөн Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрүүдэд илүү тухайлсан төсөл хөтөлбөрүүдэд суурилсан баримт бичгүүд байдаг.

Зураг 2. “Алсын хараа 2050” эрчим хүчний төлөвлөлт


№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин			Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Мэдээллийн эх үүсвэр	Мэдээлэл цуглуулах арга зүй	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага
				2025	2030	2050					
БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ											
67	Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын эзлэх хувь	Хувь	-	95.5	100	100	2015 он суурь түвшин	Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн	Эрчим хүчний статистик үзүүлэлт	Жилд нэг удаа	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

1.2. Өнөөгийн нөхцөл байдал, статистик үзүүлэлтүүд

Сүүлийн 10 жилийн хугацаанд эрчим хүчний хэрэглэгчийн тоо 2015 онд 590.3 мянган хэрэглэгч байсан бол 2024 оны жилийн эцэс гэхэд 888.2 мянгад хүрч 50.5%-


аар нэмэгдсэн (зураг 3). Мөн 2015 онд 4'344 сая.кВт.ц цахилгаан эрчим хүчийг хэрэглэгчдэд борлуулсан бол 2024 онд 7'994 сая.кВт.ц эрчим хүчийг борлуулснаар борлуулалт 84%-аар нэмэгдсэн (зураг 4).

Зураг 3. ЦЭХ хэрэглэгчдийн тоо 2015-2024 он



Эх сурвалж: ЭХЗХ статистик тайлан тайланарилгаж, логарифм авсан


Зураг 5. ЦЭХ-ний бүтэц 2015-2024 он



Эх сурвалж: ЭХЗХ статистик тайлан


Эх үүсвэрийн суурилагдсан хүчин чадлыг сүүлийн 10 жилийн хугацаанд авч үзвэл нийт цахилгаан эрчим хүчний бүтцийн 25% нь импортын хамааралтай байна (зураг 5). Дотоодын эрчим хүчний эх үүсвэрийн суурилагдсан хүчин чадлын 81% нь ДЦС, ЦС-уудаас хамааралтай (зураг 6). Эрчим хүчний эрэлт, хэрэгцээ нэмэгдэхэд дотоодын үйлдвэрлэгчид нийлүүлэлтийг бүрэн хангаж чадахгүй, эх үүсвэрийн дутагдлаас улбаалан импортын хэмжээ 2015 онд 1.4 тэрбум.кВт.ц байсан бол 2024 онд 2.9 тэрбум.кВт.ц болж 105% буюу нэг дахин нэмэгдсэн. 2023-2024 оны хугацаанд “Бөөрөлжүүт”-ийн 150 МВт-ын суурилагдсан хүчин чадал бүхий шинэ эх үүсвэр нэмэгдсэн нь эрчим хүчний салбарт урт хугацаанд

Зураг 4. ЦЭХ-ний хэрэглээ 2015-2024 он



Эх сурвалж: ЭХЗХ статистик тайлан


Зураг 6. СХЧ бүтэц 2015-2024 он



Эх сурвалж: ЭХЗХ статистик тайлан


хийгдээгүй шинэ эх үүсвэрийн томоохон бүтээн байгуулалт болсон. 2024 он хүртэлх хугацаанд хатуу түлш ашигладаг суурь горимд ажилладаг эх үүсвэрийн хувьд 2015 оноос хойш 439.2 МВт буюу 43%-аар нэмэгдсэн ч эх үүсвэрийн нэмэлт хэрэгцээ өндөр байсаар байна. Дотоодын үйлдвэрлэлийн ДЦС-уудын суурилагдсан хүчин чадлын ашиглалтын дундаж 2015 онд 62% байсан бол 2024 онд 75% хувьд хүрч (зураг 5) үйлдвэрлэлийн үйл ажиллагааг нэмэгдүүлэн ажилласаар өнөөдрийг хүрчээ. ДЦС-ууд нь эрчим хүчний нийлүүлэлтийг хангахын тулд өөрийн үйлдвэрлэлээ жил бүр нэмэгдүүлснээр аваарын болон бусад шалтгаант зогсолтын тоо (зураг 6) хэмжээ нэмэгдсээр байна.

Зураг 7. СХЧ ашиглалт 2015-2024 он



Эх сурвалж: ЭХЗХ статистик тайлан

Зураг 8. Зуух, турбин зогсолт 2020-2024 он



Эх сурвалж: ЭХЗХ статистик тайлан

1.3. Тулгамдаж буй асуудал

Эрчим хүчний эх үүсвэрийн хүчин чадлын дутагдал нь сүүлийн жилүүдэд хэрэглээний цахилгаан эрчим хүчийг хязгаарлах, цахилгаан эрчим хүчинд холбогдох хүсэлтийг хойшлуулах гэх мэт арга хэмжээнүүдийг авахад хүргэсээр иржээ. 2025 оны эхний хагас жилийн байдлаар Эрчим хүчний яамны мэдэгдсэнээр улсын хэмжээнд 128 цахилгааны техникийн нөхцөлийн хүсэлт ирснээс 15% буюу 19 хүсэлтэд техникийн нөхцөл олгож, 85% буюу 109 хүсэлтэд олгох боломжгүй хариуг хүргүүлсэн. Мөн улсын хэмжээнд дулааны 182 техникийн нөхцөлийн хүсэлт ирснээс 10% буюу 18 хүсэлтэд техникийн нөхцөл олгож, 90% буюу 164 хүсэлтэд олгох боломжгүй гэсэн хариу хүргүүлсэн байна (зураг 9). Хатуу түлш /нүүрс/ ашигладаг шинэ эх үүсвэрийн төслүүд нь урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хэдий ч зорилтод төлөвлөсөн цаг хугацаандаа ашиглалтад орж чадахгүй удааших, сонгон шалгаруулалтын маргаан үүсэх, санхүүгийн бэрхшээл, хөрөнгө оруулалтын саатал, төсөл цуцлагдах гэх мэт хүндрэлүүдтэй тулгарсаар байгаа нь эх үүсвэрийн дутагдалд орох гол шалтгаануудын нэг болоод байна. Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтын хүрэлцээгүй байдлаас үүдэн одоо ажиллаж буй эх

үүсвэрүүдийн өргөтгөл, шинэчлэлийн төслүүд санхүүгийн хүндрэлтэй байдалд байсаар байна. Цахилгаан эрчим хүчний шинэ эх үүсвэрийн төслүүдийг урьдчилсан тооцоо, судалгааны үндэслэл дээр тодорхойлж, саадгүй, ил тод, нээлттэй, цэвэр өрсөлдөөнд суурилан хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх нь энэхүү судалгааны ажлын зорилго болно.

Зураг 9. Техникийн нөхцөл 2025 оны хагас жил

Цахилгаан

Шийдвэрлэлтийн төлөв		Улаанбаатар хотод			Орон нутагт		
		Хүсэлтийн тоо	Хүссэн чадал (Гкал/ц)	Олгосон чадал 2027 он (Гкал/ц)	Хүсэлтийн тоо	Хүссэн чадал (Гкал/ц)	Олгосон чадал 2027 он (Гкал/ц)
Техникийн нөхцөл олгосон	Шинэ	9	23.5	7	5	26.3	7.8
	Сунгалт	22	82.8	24.8	-	-	-
Шийдвэрлээгүй хүсэлт		58	143.60	0	34	83	0
Нийлбэр		89	249.9	31.8	39	109.4	7.8

1. Улаанбаатар хотод 89 хүсэлт ирүүлсэнээс 15.7% буюу 14 хүсэлтэд техникийн нөхцөл олгогдож, 84.3% буюу 58 хүсэлтэд олгох боломжгүй хариу гарсан байна.
2. Орон нутагт 39 хүсэлт ирүүлсэнээс 12.8% буюу 5 хүсэлтэд техникийн нөхцөл олгогдож, 87.2% буюу 34 хүсэлтэд олгох боломжгүй хариу гарсан байна.

Дулаан

Шийдвэрлэлтийн төлөв		Улаанбаатар хотод			Орон нутагт		
		Хүсэлтийн тоо	Хүссэн чадал (Гкал/ц)	Олгосон чадал 2027 он (Гкал/ц)	Хүсэлтийн тоо	Хүссэн чадал (Гкал/ц)	Олгосон чадал 2027 он (Гкал/ц)
Техникийн нөхцөл олгосон	Шинэ	8	23.74	7.07	7	32.82	17.5
	Сунгалт	3	11.87	3.96	-	-	-
Шийдвэрлээгүй хүсэлт		146	398.26	-	18	94.0	-
Нийлбэр		157	433.67	11.03	25	126.82	17.5

1. Улаанбаатар хотод 157 хүсэлт ирүүлсэнээс 7.0% буюу 11 хүсэлтэд техникийн нөхцөл олгогдож, 93.0% буюу 146 хүсэлтэд олгох боломжгүй хариу гарсан байна.
2. Орон нутагт 25 хүсэлт ирүүлсэнээс 28% буюу 7 хүсэлтэд техникийн нөхцөл олгогдож, 72.0% буюу 18 хүсэлтэд олгох боломжгүй хариу гарсан байна.

Эх сурвалж: ЭХЯ


2. Судалгааны хүрээг тогтоох нь

2.1. Эх үүсвэр төсөл шалгаруулах үйл явц / ТХХТ

Манай улсын хувьд эрчим хүчний томоохон төсөл хөтөлбөрүүд нь 100% улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх боломжгүй тул манай нөхцөлд төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх нь бас нэгэн шийдэл болж байгаа. Гэвч төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль 2022 оны 12 сарын 09 өдөр батлагдан 3 жилийн хугацаа өнгөрөхөд эрчим хүчний салбарт тус хуулийн зохицуулалтаар амжилттай хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр хараахан гараагүй байна.

Хувийн хэвшил нь эрсдэлтэй, Эрчим хүчний тухай хууль, Төр хувийн хэвшлийн түншлэл /ТХХТ/-ийн тухай хуулийн зохицуулалтын зөрүү, бусад зүйлээс шалтгаалсан олон шат дамжлагаас үүдэн хөрөнгө оруулалт хийх сонирхолгүй байна. Түншлэлийн гол шаардлага бол улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан байх шаардлагатай. Түншлэлийн төслийг хэрэгжүүлэх хүсэлт гаргахаас эхлээд эцсийн шатны гэрээ байгуулах хүртэлх үйл явц нь хэт хүнээс хамааралтай, олон шат дамжлагатай байна (зураг 10).

Зураг 10. ТХХТ-ийн үйл явц, шат дамжлага



Эх сурвалж: <https://pppc.gov.mn/ongoing-projects>

2.2 Туршлага судлах улсыг тогтоох

Олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэх ажлын хүрээнд хэд хэдэн шалгуурыг ашиглан судалгаанд хамрагдах улсыг тодорхойлов.

- Цаг агаарын эрс тэс байдал
- Хатуу түлш ашигладаг эх үүсвэр /дотоодын эрчим хүчний суурилагдсан хүчин чадлын 50-с дээш хувийг бүрдүүлдэг байх/
- Дулаан, цахилгаан хослон үйлдвэрлэдэг
- Эрчим хүчний зах зээлийн олон талт бодлоготой
- Төрийн байгууллага болон албан хаагчаас хараат бусаар төслийг шалгаруулах
- Оновчтой төлөвлөлт
- Илт тод нээлттэй байдлыг бүрдүүлсэн байх.

Эдгээр шалгууруудаар улс орнуудыг жишин үзсэнээр Бүгд Найрамдах Казахстан Улсыг /БНКУ/ туршлага судлах улсаар сонгон судалгааны ажлыг гүйцэтгэлээ. 2023 оны байдлаар БНКУ-ын нийт эх үүсвэрийн 70%-ийг нүүрсэн эх үүсвэр бүрдүүлсэн байна (зураг 11).

2.2. Туршлага судлах улсыг тогтоох


Олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэх ажлын хүрээнд хэд хэдэн шалгуурыг ашиглан судалгаанд хамрагдах улсыг тодорхойлов.

- Цаг агаарын эрс тэс байдал
- Хатуу түлш ашигладаг эх үүсвэр /дотоодын эрчим хүчний суурилагдсан хүчин чадлын 50-с дээш хувийг бүрдүүлдэг байх/
- Дулаан, цахилгаан хослон үйлдвэрлэдэг
- Эрчим хүчний зах зээлийн олон талт бодлоготой
- Төрийн байгууллага болон албан хаагчаас хараат бусаар төслийг шалгаруулах
- Оновчтой төлөвлөлт
- Илт тод нээлттэй байдлыг бүрдүүлсэн байх.

Эдгээр шалгууруудаар улс орнуудыг жишин үзсэнээр Бүгд Найрамдах Казахстан Улсыг /БНКУ/ туршлага

судлах улсаар сонгон судалгааны ажлыг гүйцэтгэлээ. 2023 оны байдлаар БНКУ-ын нийт эх үүсвэрийн 70%-ийг нүүрсэн эх үүсвэр бүрдүүлсэн байна (зураг 11).

Зураг 11. Казахстан улсын 2023 оны эрчим хүчний үйлдвэрлэл болон хүчин чадлын бүтэц



Эх сурвалж: www.rfc.kz


3. Төлөвлөлт / төлөвлөгөө бэлтгэх нь

3.1. Эрчим хүчний хүчин чадлын 7 жилийн тэнцэл, төлөвлөгөө бэлтгэх

БНКУ нь эдийн засгийн өсөлт, аж үйлдвэрийн үсрэнгүй хөгжлийн энэ үед эрчим хүчний салбарын шаардлагатай эх үүсвэр, дэд бүтцийг цаг алдалгүй шийдвэрлэж байна. Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн эрх бүхий байгууллага буюу Эрчим хүчний яам нь шинэ эх үүсвэрийн төлөвлөлтийг системтэй хэрэгжүүлэх шаардлага үүсдэг бөгөөд “Ирэх 7 жилийн цахилгаан эрчим хүч болон хүчин чадлын урьдчилсан тэнцэл”-ийг боловсруулан жил бүр шинэчлэн баталдаг (Зураг 12). Ирэх 7 жилийн цахилгаан эрчим хүч болон хүчин чадлын урьдчилсан тэнцэл нь Эрчим хүчний сайдын “Цахилгаан эрчим хүч болон хүчин чадлын урьдчилсан тэнцэл боловсруулах дүрмийг батлах тухай” тушаалын дагуу боловсруулагдан хэрэгждэг. Энэхүү дүрэм нь БНКУ-ын Засгийн газрын баталсан “Эрчим хүчний яамны тухай дүрэм”-ийн 322 дахь заалт, мөн “Цахилгаан сүлжээний дүрэм” болон “Архитектур, хот байгуулалт болон барилгын үйл ажиллагааны тухай” хуулийн 60 дугаар зүйлд нийцүүлэн боловсруулагддаг.

Цахилгаан эрчим хүчний хүчин чадлын урьдчилсан тэнцэл нь улсын болон бүс нутгийн түвшинд эрчим хүчний хангамж, хэрэглээний өсөлт, үйлдвэрлэлийн нөөцийн боломж, ирээдүйд үүсэж болзошгүй хүчин чадлын хомсдолыг урьдчилан тодорхойлох үндсэн баримт бичиг болдог. Хүчин чадлын төлөвлөгөө буюу эрчим хүчний чадлын урьдчилсан тэнцлээр ямар төрлийн шинэ эх үүсвэрийг, хаана, ямар хэмжээтэйгээр, ямар хугацаанд, тендер эсвэл аукционы зарчмаар шинэ эх үүсвэрийг барьж ашиглалтад оруулахыг тогтоох төлөвлөлтийн баримт бичиг болдог.

Зураг 12. 2025-2031 оны тэнцэл боловсруулах тушаал



Эх сурвалж: www.gov.kz/ongoing-projects

3.2. Дата мэдээлэл цуглуулах

Урьдчилсан тэнцлийг боловсруулахад ашиглагдах мэдээллийн анхдагч эх үүсвэрийг бөөний зах зээлийн оролцогчид буюу цахилгаан эрчим хүч үйлдвэрлэгч,

дамжуулагч, томоохон хэмжээний хэрэглэгчид (үйлдвэр, уурхай гэх мэт) боловсруулан илгээнэ. Эдгээр байгууллагууд жил бүрийн 8 дугаар сарын 1-ний өдрийн дотор ирэх 7 жилийн хугацаанд цахилгаан ачааллын хэрэглээний урьдчилсан тооцоо болон өөрийн эх үүсвэрийн хүчин чадлаар хангаж чадахгүй үлдэх хүчин чадлын хэмжээг тусгасан “Урьдчилсан хэрэглээний мэдүүлэг”-ийг системийн операторт хүргүүлнэ.

3.3. 7 жилийн урьдчилсан тэнцэл боловсруулах

Урьдчилсан тэнцэл боловсруулахдаа нэгдсэн цахилгаан системийн жилийн хамгийн дээд ачааллын хүчин чадлыг, ашиглалтад байгаа болон шинээр ашиглалтад орох эх үүсвэрүүдийн техникийн боломжит хүчин чадлыг, мөн сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн үйлдвэрлэлийн хэлбэлзлийн нөлөөг харгалзан тооцно. Сэргээгдэх эх үүсвэрүүдийн хувьд үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг нийт үйлдвэрлэлд бүрэн тооцох боловч хүчин чадлын тэнцэлд дараах байдлаар тусгана:

- Далангүй, урсгалаар ажилладаг усан цахилгаан станц – хүчин чадлын 30 хувь
- Салхин цахилгаан станц – хүчин чадлын 20 хувь
- Нарны цахилгаан станц – хүчин чадлын 0 хувь

Зураг 13. 2025-2031 оны урьдчилсан тэнцэл хавсралт

Прогнозный баланс электрической мощности на час совмещенного максимума нагрузок в единой электроэнергетической системе Республики Казахстан на период с 2025 по 2031 годы								
№	Наименование	прогноз						
		2025 г.	2026 г.	2027 г.	2028 г.	2029 г.	2030 г.	2031 г.
1	Потребность	21 310	22 344	23 422	24 644	25 915	27 188	28 484
1.1.	Максимальная электрическая нагрузка	17 944	18 804	19 732	20 766	21 833	22 928	24 045
1.2.	Необходимый резерв мощности	3 366	3 539	3 689	3 878	4 082	4 260	4 439
2	Генерация (располагаемая мощность)	17 883	19 978	20 746	22 196	23 530	23 680	23 685
2.1.	Существующие электростанции	17 735	17 408	17 358	17 224	17 297	17 315	17 320
2.2.	Ввод новых мощностей (реконструкция, расширение, новые станции)	147	2 570	3 388	4 972	6 232	6 364	6 364
3.	Дефицит (+), избыток (-) без учета необходимого резерва	61	-1 174	-1 013	-1 430	-1 697	-752	360
4.	Дефицит (+), избыток (-) с учетом необходимого резерва	3 427	2 366	2 676	2 448	2 385	3 508	4 799
5.	РЕГУЛИРОВОЧНАЯ МОЩНОСТЬ							
5.1.	Требуемый объем регулировочной мощности	2 050	2 223	2 375	2 454	2 977	3 064	3 154
5.2.	Располагаемый объем регулировочной мощности	535	1 384	1 486	1 856	2 456	2 456	2 456
5.3.	Дефицит регулировочной мощности	1 516	839	889	597	521	608	698

Эх сурвалж: www.gov.kz

Системийн оператор бөөний зах зээлийн оролцогчдоос ирүүлсэн мэдээллийг нэгтгэн боловсруулж, цахилгаан сүлжээний өнөөгийн байдал, хэрэглээний өсөлтийн хандлага, шинэ эх үүсвэрүүдийн төлөвлөгдсөн ашиглалтад орох хугацаа зэрэг хүчин зүйлсийг харгалзан ирэх 7 жилийн цахилгаан эрчим хүч болон хүчин чадлын таамаг тэнцлийг 10 дугаар сарын 1-ний дотор гаргана. Тэнцлийн төсөл нь жил бүрийн 10 дугаар сарын 15-наас өмнө Эрчим хүчний яаманд хүргэгдэнэ. Хэрэв тухайн бүсийн жилийн хамгийн их ачааллын таамаг өмнөх онд батлагдсан үзүүлэлтээс өөрчлөгдсөн бол тухайн өөрчлөлтийн үндэслэл, тооцоолол болон тайлбарыг хавсаргана. Эрчим хүчний яам уг төслийг хүлээн авсны дараа 1 сарын дотор “Эрчим хүчний зах зээлийн зөвлөл”-д мэргэжлийн дүгнэлт гаргуулахаар илгээнэ. Тус зөвлөл ажлын 15 өдрийн дотор зөвлөмж, дүгнэлтийг боловсруулж, Эрчим хүчний яаманд хүргэнэ. Эрчим хүчний яам зөвлөлийн саналтай нийцэж байгаа тохиолдолд урьдчилсан тэнцэлд шаардлагатай засвар, нэмэлт өөрчлөлтийг оруулна. Хэрэв санал нийлэхгүй бол үндэслэлтэй тайлбар бүхий хариуг буцаан илгээнэ. Үүний дараа ирэх 7 жилийн цахилгаан эрчим хүч болон хүчин чадлын урьдчилсан тэнцэл Эрчим хүчний яамны зүгээс эцэслэн батлагддаг (Зураг 13). Батлагдсан өдрөөс хойш 10 ажлын өдөрт багтаан Эрчим хүчний яам болон системийн операторын цахим хуудсанд олон нийтэд нээлттэй хэлбэрээр байршуулна.

3.4. Шинэ эх үүсвэр, өргөтгөлийн төслийг төлөвлөх

7 жилийн төлөвлөгөөний тооцооллоор эхний 5 жилд илэрсэн хүчин чадлын дутагдлыг хатуу түлш ашиглах эх үүсвэрийн тендер зохион байгуулах журмаар, харин сүүлийн 3 жилд илэрсэн хүчин чадлын дутагдлыг хийн болон усан эх үүсвэрийн дуудлага худалдааны журмаар сонгон шалгаруулдаг байна. Харин 5 дахь жилийн хувьд үүссэн хомсдолыг суурь горимд ажиллах болон тохируулгын горимд ажиллах шинэ эх үүсвэрийн сонголтыг бусад жилүүдийн эх үүсвэрийн төлөвлөлтэй уялдуулан сонгодог.

4. Суурь горимд ажиллах эх үүсвэрийн тендер зохион байгуулах

4.1. Тендер зохион байгуулах нөхцөл

БНКУ-ын “Цахилгаан эрчим хүчний тухай” хуулийн 15-6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу, мөн 15-1 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасан (зураг 14) тохиолдолд Эрчим хүчний яам хатуу түлш ашигладаг шинээр ашиглалтад орох цахилгаан үйлдвэрлэх байгууламж барих тендерийг зохион байгуулж явуулна. Эрчим хүчний тухай хуульд зааснаар хатуу түлш ашигладаг шинэ эх үүсвэр барих, өргөтгөхтэй холбоотой бүхий л шийдвэр нь 7 жилийн төлөвлөгөөг үндэслэнэ. Хэрэв батлагдсан урьдчилсан тэнцэлд (7 жилийн төлөвлөгөө) нэгдсэн цахилгаан эрчим хүчний системд бүхэлдээ, эсвэл түүний аль нэг бүсэд

15-1.8 хэсэгт

Хэрэв батлагдсан урьдчилсан тэнцэлд нэгдсэн цахилгаан эрчим хүчний системд бүхэлдээ, эсхүл түүний аль нэг бүсэд таамагласан нөхөгдөөгүй цахилгаан чадлын дутагдал (uncovered capacity deficit) нь төсөөллийн **эхний 5 жилийн хугацаанд 100 МВт-аас давсан** бол эрх бүхий байгууллага календарийн 30 өдрийн дотор нөхөгдөөгүй чадлын дутагдал үүсэж болзошгүй талаар мэдэгдэл илгээнэ


таамагласан нөхөгдөөгүй цахилгаан чадлын дутагдал нь төсөөллийн эхний 5 жилийн хугацаанд 100 МВт-аас давсан бол Эрчим хүчний яам календарийн 30 өдрийн дотор нөхөгдөөгүй чадлын дутагдал үүсэж болзошгүй талаар мэдэгдэл илгээнэ.

4.2. Тендер зохион байгуулах бэлтгэх ажил

Тендерээр шинээр ашиглалтад оруулах цахилгаан үйлдвэрлэх байгууламжийн байршил (талбай), түлшний төрөл, ангиллыг Эрчим хүчний яамны захиалгаар боловсруулсан техник-эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) эвсэл урьдчилсан техник-эдийн засгийн үндэслэлийн (УТЭЗҮ) дүгнэлтээр тодорхойлно (зураг 15).

Улсын ач холбогдол бүхий хотууд болон орон нутгийн гүйцэтгэх байгууллага нь ТЭЗҮ эсвэл УТЭЗҮ-д заасан, хатуу түлш ашигладаг шинээр ашиглалтад орох цахилгаан үйлдвэрлэх байгууламж барих зориулалттай газрын хэсгийг, тус улсын Газрын тухай хуулийн 49-2 дугаар зүйлд нийцүүлэн тухайн бүс нутгийн Акимат буюу Бүс, орон нутаг, хотын захиргаа нь тендерийн ялагчид газрын эрх олгох хүртэл хугацаанд нөөцөлнө.

Зураг 15. Шинээр ашиглалтад оруулах эх үүсвэрийн тендер зохион байгуулах алхам



Эх сурвалж: www.adilet.kz

- Хомсдол тогтооно.
- Тендерийн ажлын хэсэг байгуулна.
- Газар талбайн мэдээлэл авна.
- Түлшний төрөл, ТЭЗҮ эсхүл УТЭЗҮ хийлгэж авна.
- ТЭЗҮ-д үндэслэн тендерийн зарын тухай зөвшилцөж, баримт бичгийг батална. 2 ажлын өдөрт
- Цахим системээр тендер зарлана 18 хоногийн өмнө
- Тендерийн ялагч шалгаруулах хурал зохион байгуулж, ялагч шалгаруулна. 15 хоногт
- Цахим хуудсанд үр дүнг мэдээллэнэ. 3 ажлын өдөрт
- Байгууламж барих төсөл илгээж, баталгаажуулна. 5 хоногт
- Ялагчтай "Ашиглалтад шинээр оруулах цахилгаан эрчим хүчний үүсгүүрийн барилгын гэрээ" болон "Цахилгаан чадварыг бэлэн байлгах үйлчилгээ худалдан авах загвар гэрээ" байгуулна. 30 календарь хоног
- Санхүүгийн баталгаа зэрэг нэмэлт баримт бичиг хүргүүлнэ. 30 календарь хоног

4.3. Тендер зохион байгуулах ажлын хэсэг байгуулах

Тендерийг бэлтгэх, зохион байгуулах, дүнг гаргах зорилгоор Эрчим хүчний яам тендерийн ажлын хэсэг байгуулна. Тендерийн ажлын хэсгийг Эрчим хүчний яам дараах бүрэлдэхүүнээс бүрдүүлнэ: Эрчим хүчний яамны төлөөлөгчид, хамаарал бүхий төрийн байгууллагууд, хуулийн этгээдийн нэгдлүүд, төрийн оролцоотой байгууллагууд, төрийн бус байгууллагууд, зураг төслийн болон судалгааны хүрээлэнгүүд, хараат бус шинжээчид багтана. Тендерийн ажлын хэсгийг байгуулахдаа Эрчим хүчний яам ашиг сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлж дараах шаардлагыг хатуу мөрдөнө.

Тендерийн ажлын хэсгийн гишүүнд дараах этгээдийг оруулахгүй:

- Тендерийн журмын үр дүнгээр ашиг хүртэх этгээд,
- Тендерийн оролцогч, түүнтэй холбоотой, харьяа, охин, хараат байгууллагуудтай хөдөлмөрийн харилцаатай этгээд,
- Тендерийн ажлын хэсгийн гишүүд, тендерийн оролцогчдын удирдлага болон тэдний харьяа, охин, хараат байгууллагуудтай ойрын төрөл садан, эсвэл эхнэр/нөхрийн хамааралтай этгээд байхыг хориглоно.

Тендерийн ажлын хэсгийн гишүүдийн тоо дарга, орлогчийг оролцуулан 15-аас цөөнгүй байна. Ажлын хэсэг нь түүнийг байгуулах тухай Эрчим хүчний яамны тушаал хүчин төгөлдөр болсон өдрөөс үйл ажиллагаагаа эхэлж, шинэ тендерийн ажлын хэсэг байгуулах шийдвэр гарсан өдөр үйл ажиллагаагаа зогсооно. Тендерийн ажлын хэсгийн үүрэг нь тендерийн баримт бичгийг тохиролцон батлах, шинээр ашиглалтад оруулах цахилгаан үйлдвэрлэлийн байгууламж барих тендерт оролцох хүсэлтүүдийг хэлэлцэн шийдвэрлэх, тендерийн үр дүнг гаргах юм.

4.4. Тендерийн баримт бичиг

Тендерийн баримт бичгийг Эрчим хүчний яам ТЭЗҮ эсвэл УТЭЗҮ-д тулгуурлан боловсруулна. Тендерийн баримт бичигт дор дурдсан зүйлс орно:

I. Ашиглалтад шинээр оруулах цахилгаан эрчим хүчний үүсгүүрийн шаардлагатай техникийн, чанарын болон ашиглалтын шинж чанарын тодорхойлолт:

- 1.1.** Эх үүсвэрийн төрөл,
- 1.2.** Эх үүсвэрийн үндсэн болон нөөц түлшний төрөл,
- 1.3.** Цахилгаан сүлжээнд холбох цэг, барилгын талбайн байршил (координат), тэдгээрийг ашиглалтад оруулах шаардлагатай огноо (сар, жил),

- 1.4. ТЭЗҮ эсвэл урьдчилсан ТЭЗҮ-д заасны дагуу барилгын талбай дээр байгаа болон байгуулахаар төлөвлөсөн дэд бүтцийн тодорхойлолт,
- 1.5. ТЭЗҮ эсвэл урьдчилсан ТЭЗҮ-д заасны дагуу шинээр барих эх үүсвэр хүртэлх гадна инженерийн дэд бүтцийг хангах нөхцөл,
- 1.6. Сүлжээнд нийлүүлэх шаардлагатай цахилгаан чадлын хэмжээ,
- 1.7. Сүлжээнд нийлүүлэх шаардлагатай дулааны чадлын хэмжээ,
- 1.8. Нэгж цахилгаан эрчим хүчний түлшний зарцуулалтын шаардлага
- 1.9. Нэгж дулааны эрчим хүчний нөхцөлт түлшний зарцуулалтын шаардлага
- 1.10. Азотын исэл (NOx)-ийн нэгж ялгарлын зөвшөөрөгдөх хэмжээ,
- 1.11. Хүхрийн нэгдлийн (SOx) нэгж ялгарлын зөвшөөрөгдөх хэмжээ,
- 1.12. Хатуу тоосонцрын нэгж ялгарлын зөвшөөрөгдөх хэмжээ,
- 1.13. ТЭЗҮ эсвэл урьдчилсан ТЭЗҮ-д заасан цахилгаан чадлын бэлэн байдлыг хангах үйлчилгээний хэмжээ,
- 1.14. ТЭЗҮ эсвэл урьдчилсан ТЭЗҮ-ийн дагуу ашиглалтад шинээр оруулах үүсгүүрийн нийт өртөг,
- 1.15. Тендерийн баримт бичигт нийцүүлэн шаардлагатай санхүү, материаллаг нөөцтэйг нотлох 28-р зүйлд заасан баримт бичгийн жагсаалт,
- 1.16. Ашиглалтад шинээр оруулах эрчим хүч үйлдвэрлэгч байгууллагуудын цахилгаан чадлын бэлэн байдлыг хангах үйлчилгээний хувь тарифын хамгийн дээд зөвшөөрөгдөх хэмжээ,
- 1.17. Дээрх хамгийн дээд зөвшөөрөгдөх хувь тарифыг тооцоолох суурь өгөгдөл,
- 1.18. ТЭЗҮ эсвэл урьдчилсан ТЭЗҮ-д заасан барилгын ажлын хугацаа (үргэлжлэх хугацаа).

II. Ашиглалтад шинээр оруулах цахилгаан эрчим хүчний үүсгүүр барих гэрээний төсөл багтана.

Тендерийн баримт бичгийг эрчим хүчний төрийн байгууллагууд боловсруулан цахим хуудсанд байршуулна. Тендерт оролцох аж ахуй нэгжүүд нь хүсэлтээ битүүмжилсэн дугтуйгаар тендер зохион байгуулах ажлын хэсэгт хүргүүлнэ.

4.5. Тендерт оролцогчийн бүрдүүлэх баримт бичиг

Тендерт оролцох саналд дараах баримт бичгүүдийг багтаана:

- 1) Журамд заасан хавсралтын дагуу, тухайн загвартайгаар бүрдүүлсэн өргөдөл. Тус өргөдөлд тендерийн зар, журам, тендерийн баримт бичиг, Эрчим хүчний тухай хууль болон холбогдох журмуудтай танилцсаныг батлах хэсэг багтсан байдаг. Мөн оролцогч өөрийн санал болгож буй үнийн саналаа тусгасан байна.
- 2) Байгууллагын баримт бичгийн хуулбарууд,
- 3) Тендерийн баримт бичигт заасны дагуу тодорхойлогдох санхүүгийн болон материаллаг нөөцтэйг баталгаажуулах баримт бичгүүд.

4.6. Тендерийн ялагч тодруулах үйл явц

Тендерийн ажлын хэсэг нь баримт бичиг хүлээн авах хугацаа дууссаны дараа сонгон шалгаруулалтыг эхэлж хурал зарлан 16:00 цагт эхэлж, мөн өдрийн 18:00 цаг хүртэл үргэлжилнэ. Ажлын хэсгийн хурлын үеэр ажлын хэсгийн нарийн бичгийн дарга оролцож буй гишүүдийн өмнө тендерийн хүсэлт бүхий дугтуйг дарааллаар нь задлан, өргөдөл гаргагчийн нэр болон дугтуйн агуулгыг дуудаж танилцуулна. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга дугтуй задлан хянан үзэж хүсэлт бүрийг ажлын хэсгийн гишүүдэд дарааллаар нь шилжүүлж, бүрдлийг нь шалгуулна. Бүрдлийг шалгах явц нь оролцогчдоос ирүүлсэн материал тендерийн баримт бичигт нийцэж байгаа эсэхийг л шалгана. Тендерийн ажлын хэсэг нь тендерт оролцохоор ирүүлсэн бүрдэлд нийцсэн материалуудад техникийн аливаа нөхцөл, шаардлагыг үндэслэн үнэлгээ, оноо өгдөггүй.

Тендерт ирүүлсэн баримт бичгийн бүрдлийг шаардлагын дагуу хангасан материалуудыг үнийн саналаар жагсаан хамгийн бага үнийн саналыг ялагчаар тодруулдаг. Хэрэв санал болгосон үнэ ижил тохиолдолд, тухайн ижил үнэтэй хүсэлтүүдийг хүсэлт ирүүлсэн цагийн дардсаар нь нэмэлтээр эрэмбэлнэ. Эрэмбэлсэн жагсаалтыг баталгаажуулсны дараа ажлын хэсэг жагсаалтын эхэнд бичигдсэн хүсэлтийг тогтоож, тэмдэглэлд тусгана. Тендерийн дүнг гаргасны дараа тендерийн ажлын хэсэг хурлын төгсгөл хүртэл хурлын дарга, даргын орлогч, ажлын хэсгийн гишүүд бүгд ажлын хэсгийн нарийн бичгийн даргын бөглөсөн тэмдэглэлтэй (протокол) танилцана. Тэмдэглэлийг хурлын дарга, даргын орлогч, нарийн бичгийн дарга болон хуралд оролцсон ажлын хэсгийн гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

Хурлын тэмдэглэл, тендерт оролцох хүсэлтүүд, тендерийн баримт бичиг, ТЭЗҮ, УТЭЗҮ хамт, мөн ажлын хэсгийн хурлын дүрс дуу бичлэгийг Эрчим хүчний яамнаас шинэ эх үүсгүүрийн гэрээ дуусгавар болсноос хойш дор хаяж таван жил хадгална.

5. Тохируулгын горимд ажиллах эх үүсвэрийн аукцион зохион байгуулах

5.1. Аукцион зохион байгуулах нөхцөл

Шинээр ашиглалтад оруулах зохицуулалтын горимтой генерацийн байгууламжуудын хүчин чадлын хэмжээг тогтооход суурь болгон тухайн төсөөллийн сүүлийн 3 жилд илэрсэн хамгийн их хэмжээтэй зохицуулалтын цахилгаан эрчим хүчний хүчин чадлын хомсдолыг хоёр дахин нэмэгдүүлсэн хэмжээг ашигладаг. Энэ нь өсөлт болон бууралтын чиглэлд зохицуулалтын шаардлагыг хангах зорилготой.

5.2. Аукционы төрөл

Шинээр барьж ашиглалтад оруулах зохицуулалтын горимтой эх үүсвэрийн төслийн сонгон шалгаруулалтыг дараах 3 төрлөөр аукцион буюу үнэ хаялцах/дуудлага худалдааны зарчмаар сонгон шалгаруулалтыг зохион байгуулна:

- 1) Системийн оператораас боловсруулсан техникийн даалгаврын дагуу Эрчим хүчний яамны захиалгаар нэгдсэн худалдан авагчийн бэлтгэсэн УТЭЗҮ, зохицуулалтын горимтой эх үүсвэрийн байршлын төлөвлөгөөнд багтсан талбайд / Аукционы I-р төрөл
- 2) Үйл ажиллагаа явуулж буй эрчим хүч үйлдвэрлэгч байгууллагуудын талбайд / Аукционы II-р төрөл
- 3) Урьдчилсан ТЭЗҮ байхгүй талбайд / Аукционы III-р төрөл

Төрөл	Байршлын мэдээлэл	Урьдчилсан ТЭЗҮ	Газрын мэдээлэл	Аукционы нөхцөл
I-р төрөл	Байгаа	Байгаа	Байгаа	Сонгогдсон байршилд урьдчилсан ТЭЗҮ-ийн дагуу
II-р төрөл	Байгаа	Байхгүй	Байгаа	Үйл ажиллагаа явуулж буй эрчим хүч үйлдвэрлэгч байгууллагын талбайд Зөвхөн тухайн бүс, орон нутагт хамаарах аж ахуй нэгжүүд хамрагдана.
III-р төрөл	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Оролцогч нь өөрийн газартай, гэрчилгээгээ авсан байх, мөн эх үүсвэрийн тоног төхөөрөмжийг ханган нийлүүлэх үйлдвэрлэгчийн баталгаатай

Хэрэв Аукционы II-р төрлийн дуудлага худалдаагаар цахилгаан эрчим хүчний хүчин чадлын бэлэн байдлыг хангах үйлчилгээний хэмжээг бүрэн сонгон шалгаруулаагүй бол, сонгогдоогүй үлдсэн хэмжээг Аукционы 3-р төрлийн дуудлага худалдаагаар худалдан авах арга хэмжээ авна.

5.3. Аукционы бэлтгэл

Эрчим хүчний яам дуудлага худалдаа явуулахаар төлөвлөсөн өдрөөс 6 сараас доошгүй хугацааны өмнө аукцион зохион байгуулах хуваарийг нийтэлнэ. Тус хуваарьт дараах зүйлсийг тусгасан байна:


1. Дуудлага худалдааны огноо
2. Дуудлага худалдааны цаг
3. Дуудлага худалдаанд оролцох баримт бичиг хүлээн авах хугацаа
4. Эх үүсвэрийн байршлыг бүсээр тодорхойлсон бүсийн нэр
5. Эх үүсвэрийн шаардагдах хүчин чадал, МВт
6. Ашиглалтад оруулах шаардлагатай огноо, гэрээний хугацаа

Эрчим хүчний яам дуудлага худалдаа явуулахаар төлөвлөсөн өдрөөс 3 сараас доошгүй хугацааны өмнө дараах нэмэлт мэдээллийг (аукционы төрөл тус бүрээр) Хуваарьт тусгана:

1. Аукционы дээд тарифын хэмжээ, тэнгэ /МВт*сар
2. Дуудлага худалдаанд оролцох хүсэлтийн санхүүгийн баталгааны шаардлагатай хэмжээ
3. Цахилгаан эрчим хүч худалдан авах гэрээний санхүүгийн баталгааны шаардлагатай хэмжээг тусгана.

Зохицуулалтын хүчин чадлын хомсдолыг тогтоосны дараа Эрчим хүчний яам 30 хоногийн дотор муж, улсын чанартай хотууд болон нийслэлийн орон нутгийн захиргаанд хүсэлт илгээж, шаардлагатай дэд бүтцээр хангагдсан бөгөөд нөөцөд авах боломжтой газар ашиглалтын тухай мэдээллийг гаргуулна. Энэ нь Аукционы 1-р төрлийн дуудлага худалдаанд зориулагдана. Захиргааны байгууллагууд 15 хоногийн дотор дээр дурдсан хүсэлтийн дагуу газрын хэсгүүдийн талаар урьдчилсан мэдээллийг Эрчим хүчний яаманд дор хаяж 3 хэсгийн мэдээллийг хүргүүлнэ. Мөн эдгээр газрын хэсгүүдийг дуудлага худалдааны өмнө холбогдох мэдэгдэл автал хадгалж, хамгаална (Зураг 16). Газрын хэсгийн урьдчилсан мэдээллийг авсны дараа Эрчим хүчний яам ажлын 5 өдрийн дотор энэ мэдээллийг нэгдсэн худалдан авагчид хүргүүлж, Аукционы 1-р төрлийн дуудлага худалдааг явуулахад зориулсан УТЭЗҮ

Зураг 16.



Эх сурвалж: www.adilet.kz

боловсруулах ажиллагааг эхлүүлнэ. Эцсийн байдлаар шинээр барьж ашиглалтад оруулах зохицуулалтын горимтой генерацийн байгууламжуудын хүчин чадлын хэмжээ болон газрын хэсэг тус бүрд ашиглалтад оруулах хугацааг нэгдсэн худалдан авагчийн бэлтгэсэн холбогдох УТЭЗҮ-ийн үр дүнд үндэслэн тогтооно. Эрчим хүчний яам байршлын төлөвлөгөөнд тусгагдсан бөгөөд тухайн жилийн Аукционы I-р төрлийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төслүүдийг хэрэгжүүлэх зорилгоор системийн операторт төслийн УТЭЗҮ-ийг боловсруулах техникийн даалгаврыг боловсруулах шаардлагатайг мэдэгдэнэ. Системийн оператор мэдэгдлийг хүлээн авснаас хойш 10 ажлын өдрийн дотор техникийн даалгаврыг боловсруулж, Эрчим хүчний яаманд хүргүүлнэ. Эрчим хүчний яам системийн оператораас техникийн даалгавар авснаас хойш ажлын 2 өдрийн дотор УТЭЗҮ боловсруулах зорилгоор нэгдсэн худалдан авагчид илгээнэ. Нэгдсэн худалдан авагч сонгон шалгаруулалт явуулан УТЭЗҮ боловсруулах төслийн байгууллагыг шалгаруулна.

5.4. Аукционы баримт бичиг

Нэгдсэн худалдан авагч нь системийн оператораас боловсруулсан техникийн даалгаврыг үндэслэн Эрчим хүчний яамны захиалгаар төслийн байгууллага сонгон шалгаруулах баримт бичгийг боловсруулна. Урьдчилсан ТЭЗҮ нь дараах мэдээллийг агуулна:

- 1) Байршил
- 2) Цахилгаан сүлжээнд холбогдох цэг
- 3) Төслийг хэрэгжүүлэх төсөвт өртөг
- 4) Аукционы өрсөлдөөнийг хангах зорилгоор цахилгаан эрчим хүчний хүчин чадлын бэлэн байдлыг хангах үйлчилгээний тариф
- 5) цахилгаан эрчим хүчний хүчин чадлын бэлэн байдлыг хангах үйлчилгээний худалдан авах хугацаа – 15 жил
- 6) Цахилгаан эрчим хүчний хүчин чадлын бэлэн байдлыг хангах үйлчилгээний хэмжээ
- 7) Цахилгаан эрчим хүчний хүчин чадлын хомсдол бүхий бүс
- 8) Аукционы журамд заасан техникийн, технологийн болон ашиглалтын шаардлагатай үзүүлэлтүүдийг багтаасан байна.

5.5. Аукцион зохион байгуулах ажлын хэсэг

Аукционы зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангах зорилгоор ажлын хэсгийг байгуулна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд дараах гишүүд багтана:

- 1) Эрчим хүчний яам
- 2) Системийн оператор
- 3) Нэгдсэн худалдан авагч

- 4) Үндэсний хийн оператор
- 5) Хуулийн этгээдийн нэгдлүүд, бизнес эрхлэгчдийн танхим, мөн хараат бус шинжээчид багтана

Ажлын хэсэг дуудлага худалдаа болох өдрөөс 15 хоноогоос доошгүй хугацааны өмнө оролцогчдын баримт бичгийг шалгаж дуудлага худалдааны баримт бичгийн шаардлагыг хангасан эсэхийг тогтооно. Шаардлагыг хангасан оролцогчид нь дуудлага худалдааны зохион байгуулагчийн цахим системд бүртгүүлэх зөвшөөрөл авна. Энэ нь ажлын хэсгийн холбогдох шийдвэрээр баталгаажна. Харин шаардлагыг хангаагүй оролцогчид цахим системд бүртгүүлэх зөвшөөрөл авч чадахгүй бөгөөд тухайн дуудлага худалдаанд оролцох эрхгүй болно.

5.6. Аукционд оролцогчийн бүрдүүлэх баримт бичиг

Зөвшөөрөл авсан оролцогчид нь зохион байгуулагчийн албан ёсны цахим хуудсаар онлайн бүртгэлд хамрагдаж, дараах баримт бичгийг цахим хэлбэрээр дуудлага худалдаа болох өдрөөс 30 хоноогоос доошгүй хугацааны өмнө хүргүүлнэ:

- 1) Байгууллагын дүрмийн хуулбар,
- 2) Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний лавлагааны хуулбар,
- 3) Хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагыг томилсон холбогдох байгууллагын шийдвэрийн хуулбар,
- 4) Итгэмжлэл (хэрэв хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага оролцоогүй тохиолдолд төлөөлөн оролцох этгээдийг тодорхойлсон байх)
- 5) Хуулийн этгээдийн санхүүгийн мэдээлэл (Банкны мэдээлэл, хаяг, холбоо барих утас, цахим шуудангийн хаяг)

Зураг 16.

Оролцогч хуулийн этгээдийн бүрдүүлэх материал	I-р төрөл	II-р төрөл	III-р төрөл
Байгууллагын дүрмийн хуулбар	✓	✓	✓
Улсын бүртгэлийн лавлагаа	✓	✓	✓
Удирдлагыг томилсон тушаал, шийдвэр хуулбар	✓	✓	✓
Банкны мэдээлэл	✓	✓	✓
Баталгааны хуудас	✓	✓	✓
ЭХЯ-ны цахим хуудсанд байршуулсан баримт бичигтэй танилцсан тухай батламж захидал.	✓	✓	✓
Газрын эрхийн баримт бичгийн хуулбарууд	✗	✗	✓
Цахилгаан сүлжээнд холбогдох хугацааны мэдээлэл, урьдчилсан ТЭЗҮ хуулбар	✗	✗	✓

Эх сурвалж: www.adilet.kz

Аукционд оролцогчдын хувьд бүрдүүлэх материалууд аукционы I болон II төрөлд адилхан байна. Харин аукционы III-р төрөлд оролцох оролцогчдын хувьд газрын эрхийн баримт бичиг болон эх үүсвэрийг барьж байгуулан цахилгаан сүлжээнд холбох хугацаа, урьдчилсан ТЭЗҮ-ийг нэмэлтээр шаарддаг байна (Зураг 17).

Зураг 18. Аукционы үе шатны зураглал

Шалгаруулалтыг зарлах үе	Шалгаруулалтын үе	Үр дүнг цахим хэлбэрээр мэдэгдэх	Үр дүнг оролцогчдод бичгээр хүргүүлэх	Аукционы ялагчид гэрээний төсөл хүргүүлэх	Шалгарсан байгууллагатай гэрээ хийх
6 сар	30 мин + 5 мин хязгааргүй	1 цаг	Дараагийн ажлын өдрийн 18:00 цагаас өмнө	15 хоног	30 хоног
Дуудлага худалдаа болохоос өмнө	Үндсэн дуудлага худалдааны хугацаа 30 мин, үүнээс бага үнийн санал хүлээн авсан тохиолдолд хугацаа 5 мин-р сунгагдана	Хараат бус хяналтын гишүүдийн хамтаар системийн үр дүнг хянах		Хамгийн бага үнэ санал болгосон төслийн оролцогчийг гэрээний хэлцэлд урих	

Эх сурвалж: www.adilet.kz

5.7. Аукционы ялагчийг сонгон шалгаруулах үйл явц

Аукционд оролцож буй байгууллагууд нь сонгогдсон төсөл дээр үндсэн 30 минутын дотор үнэ хаялцан шийдвэрлэгдэнэ. Хэрвээ 30 минут дууссаны дараа 5 минутын дотор дахин бага үнийн санал гарч ирэх бол уг систем 5 минут автоматаар сунгагдан үргэлжилдэг (Зураг 18).

Ялагчийг тодруулахдаа аукционы I-р төрлийн дуудлага худалдаанд хамгийн бага үнийн санал болгосон мэдүүлгээр тодорхойлно. Аукционы II, III-р төрлийн дуудлага худалдаанд ялагчдыг цахим систем дээр санал болгосон тарифын хэмжээгээр эрэмбэлсэн жагсаалтын дагуу дараалсан байдлаар сонгож, санал болгож буй хүчин чадлын хэмжээ нь сонгон шалгаруулалтын хэмжээнд бүрэн багтсан мэдүүлгийг авна. Дуудлага худалдааны зохион байгуулагч тухайн арилжааны систем хааснаас хойш ажлын 1 өдрийн дотор

дуудлага худалдааны явцын алхам бүрийг дэлгэрэнгүй тайлбарласан үр дүнг Эрчим хүчний яам болон нэгдсэн худалдан авагчид илгээнэ. Үүнд, тухайн арилжааны системийн туршид цахим системд бүртгэгдсэн бүх мэдүүлгийн бүрэн мэдээллүүд багтана.

Нэгдсэн худалдан авагч дуудлага худалдааны үр дүнг нэгтгэсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор дуудлага худалдааны ялагчид цахилгаан эрчим хүчний хүчин чадлын бэлэн байдлыг хангах үйлчилгээний худалдан авах гэрээний төслийг илгээнэ. Дуудлага худалдааны ялагч гэрээний төслийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор аукционы үр дүнгээр тогтоогдсон тарифын дагуу 15 жилийн хугацаатай гэрээг байгуулна. Цахилгаан эрчим хүчний хүчин чадлыг худалдан авах гэрээний нөхцөлийг биелүүлэх санхүүгийн баталгааг дуудлага худалдааны ялагч гэрээ байгуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор нэгдсэн худалдан авагчид гаргана.


6. Банкны баталгаа

Эрчим хүчний тендер болон аукционд оролцогчдын хамгийн гол бүрдүүлэх материалын нэг бол банкны баталгаа юм. Энэ нь төрийн ямар ч байгууллагууд тендер, аукционд оролцож байгаа хувийн хэвшлийн санхүүгийн болон эдийн засгийн чадамжийг үнэлэх ажлыг хийдэггүй.

Тухайн үнэлгээг банкны баталгаагаар зохицуулдаг байна. Сонгон шалгаруулалтад оролцохоор бэлтгэж буй аж ахуй нэгжүүдэд банкны баталгаа гаргахдаа бүхий л эдийн засгийн, санхүүгийн шинжилгээ судалгааг хийсний үндсэн дээр тухайн баталгаа хүсэгч байгууллагад төслийг хэрэгжүүлэх чадамжтай хэмээн итгэл үзүүлэн баталгааг олгодог. Баталгаа нь “Банкны баталгаа болон батлан даалтын баталгааг олгох журам”-д нийцсэн эсвэл SWIFT системээр дамжуулсан гэрээний үүргийн баталгааны хэлбэрээр байдаг. Эдгээр баталгааг банкны урт хугацааны гадаад валютын зээлжих зэрэглэл Standard & Poor’s агентлагийн “B” түвшнээс доошгүй, эсвэл Fitch агентлагийн “B-” түвшнээс доошгүй, эсвэл Moody’s

Investors Service агентлагийн “B3” түвшнээс доошгүй банк олгодог байна. Мөн тухайн улсад үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай банкны хувьд 50%-иас дээш хувь эзэмшдэг толгой компанийн зээлжих зэрэглэл нь Standard & Poor’s агентлагийн

Зураг 19. Банкны баталгаа



Эх сурвалж: www.adilet.kz

“BBB”, Fitch агентлагийн “BBB” эсвэл Moody’s Investors Service агентлагийн “Baa2” түвшнээс доошгүй байх шаардлага тавигддаг. Харин тухайн улсад үйл ажиллагаа явуулдаггүй банк баталгаа болон гэрээний үүргийн баталгаа гаргах тохиолдолд тухайн улсад үйл ажиллагаа эрхэлж буй банкаар дамжуулан баталгаажуулах эсвэл тухайн банкны хувьд урт хугацааны гадаад валютын зээлжих зэрэглэл нь Standard & Poor’s агентлагийн “BBB”, Fitch агентлагийн “BBB” эсвэл Moody’s Investors Service агентлагийн “Baa2” түвшнээс доошгүй бол дотоодын банкаар дамжих шаардлагагүйгээр шууд баталгаа болон гэрээний

үүргийн баталгааг гаргаж болдог (Зураг 19). Тендерт ялагч нь гэрээний нөхцөлийг биелүүлэх санхүүгийн баталгаа буюу банкны баталгаа гаргах бөгөөд 1’000’000 (нэг сая) тэнгэ/МВт байна. Энэхүү банкны баталгаа эсвэл гэрээний гүйцэтгэлийн баталгаа нь тендерт, аукционд оролцогчийн хүсэлтээр эргэн татагдахгүй бөгөөд нэгдсэн худалдан авагчийн заавраар бүрэн болон хэсэгчлэн биелүүлэх нөхцөлтэйгөөр олгогдоно. Шинэ эх үүсвэрийг төлөвлөсөн хугацаандаа ашиглалтад оруулан гэрээний нөхцөлийг бүрэн хангасан гэж үзсэн тохиолдолд санхүүгийн баталгааг чөлөөлнө.

7. Дүгнэлт

БНКУ-ын “Эрчим хүчний 7 жилийн хүчин чадлын урьдчилсан тэнцэл боловсруулах журам”, шатах түлш (нүүрс, газ) ашигладаг “Эх үүсвэрийн сонгон шалгаруулалтын журам”-ыг судалсан судалгааны үр дүнд Монгол Улсын эрчим хүчний салбарт шинэ эх үүсвэрт чиглэсэн гадаад, дотоодын хөрөнгө хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд ач холбогдол бүхий сайн туршлагаудыг дурдвал:

- I. 7 жилийн төлөвлөгөө, хүчин чадлын тэнцэл бэлтгэх: Эрчим хүчний салбар нь бусад эдийн засгийн салбаруудын төсөл хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлэх суурь дэд бүтцийг бүрдүүлдэг тул улс, бүсчлэл, аймаг, хотуудын хувьд одоо байгаа нөхцөл байдлыг үнэн бодитоор шуурхай үнэлэн ирээдүйн төлөвлөлтийг жил бүр хийх нь чухал юм. Төлөвлөлтийг хийхдээ бүхий л боломжит эх үүсвэрийн хүчин чадлыг тооцон шаардлагатай бүс, орон нутаг дахь эрчим хүчний хүчин чадлын тэнцлийг боловсруулах юм. Энэхүү хүчин чадлын тэнцлээр ойрын хугацаанд болон дунд хугацаанд үүсэж болох эрэлтээс шалтгаалсан эх үүсвэрийн дутагдлыг тодорхойлж шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авахад оршино. БНКУ-ын туршлагаас 7 жилийн төлөвлөлт хийж байгаа нь эрчим хүчний салбарын хөгжлийн төлөвлөгөө тогтвортой байх үндэс болохоос гадна хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах суурь болох юм. Эрчим хүчний яам нь 7 жилийн хүчин чадлын тэнцлийг жил бүрийн эхэнд батлан өөрийн цахим хуудсандаа нээлттэй байршуулдаг. Тус тэнцэлд аль байршил (бүс, аймаг, хот)-д хэдэн МВт хэмжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагатайг тодорхой зааж өгснөөр дотоодын болон гадаадын хувийн хэвшлийн хөрөнгө оруулагч, эрчим хүчний салбарт үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдүүд нь эх үүсвэрийн төсөлд оролцох бэлтгэлээ хангаж эхэлдэг.

- II. Сонгон шалгаруулалтын үйл явц: Тендерийн буюу

нүүрс ашигладаг эх үүсвэрийн сонгон шалгаруулалтын үе шатанд тендерийн ажлын хэсэг нь оролцогчдоос ирүүлсэн материалд техникийн үнэлгээ хийх, оноо өгөх зарчим ашигладаггүй. Эх үүсвэрийн техникийн нөхцөлийг эрх бүхий байгууллагын бэлтгэсэн шаардлагад тендерт оролцогчдын ирүүлж буй санал нь нийцэж байгаа эсэхийг л шалгана. Оноо өгөх, баримт бичгийн нийцлийг шалгах хоёр нь зарчмын ялгаатай тул тендерт оролцогчдын тоо, өрсөлдөөн нэмэгдэнэ. Материалын бүрэн бүтэн байдал болон шаардлагад нийцсэн байдлыг хянаснаар дараагийн шатанд үнээр эрэмбэлэн хамгийн бага үнэ бүхий саналыг ялагчаар тодруулдаг. Тус шалгаруулалтыг үнээр өрсөлдөн шалгардаг тул хувийн хэвшлийн зүгээс төсөл шалгаруулах үйл явцтай холбоотойгоор хөндлөнгийн оролцоо, шударга бус шалгаруулалт болсон гэх мэт маргаан үүсэх магадлалыг бууруулна. Техникийн шаардлага тавин, үнээр өрсөлдүүлснээр тендерийн шалгаруулалтын үйл ажиллагаа, тендерийн ялагчтай холбоотой маргаан үүсэх, төсөл удаашрах, саатах гэх мэт эрсдэлүүдийг хамгийн бага түвшинд байх нөхцөлийг бүрдүүлсэн байна. Тендерт оролцох сонирхолтой аж ахуй нэгж байгууллагуудын хувьд тухайн шинэ эх үүсвэр, өргөтгөлийн төслийн баримт бичигтэй танилцсан баталгаа болон банкны баталгааг бүрдүүлэх нь чухал ач холбогдолтой. Эрх бүхий байгууллага төслийн баримт бичгийн дагуу тодорхойлсон хүчин чадлын хэмжээнд заасан техникийн нөхцөлөөр барих шаардлагыг оролцогчдод тавьдаг.

- III. Банкны баталгаа: Тендер болон Аукционы төслүүдийг амжилттай хэрэгжүүлэх нэг том хөшүүрэг нь банкны баталгаа болж байна. Төсөлд баталгаа гаргаж буй банкнууд нь олон улсын зээлжих зэрэглэлийн тодорхой үнэлгээг хангасан байх шалгуурыг тавьснаар төслийн хөрөнгө оруулалтын эрсдэлийг төсөл хэрэгжүүлэгч буюу тендер, аукционы ялагч болон баталгаа гаргасан банканд бүрэн хариуцуулдаг. Иймд эх үүсвэрийн төсөл санхүү, хөрөнгө оруулалтын шалтгаантай саатал үүсэх нь бага байдаг.

Дээр дурдсан тендер, аукционы журмаар шинэ төслүүдийг сонгон шалгаруулж хэрэгжүүлснээр эх үүсвэрийн дутагдлыг саадгүй богино хугацаанд шийдвэрлэх, цахилгаан эрчим хүчний дундаж үнийг бууруулах, шинэ инновацлаг технологи нэвтрүүлэх боломжийг бүрдүүлдэг.

Эрчим хүчний салбарт эх үүсвэрүүдийн төслүүдийг улсын хөрөнгө оруулалтаар бүрэн шийдвэрлэх боломжгүй тул улсын хөгжлийн бодлого, үйл ажиллагаа арга хэмжээний хөтөлбөрүүдэд тусгагдсан төслүүдийг хэрэгцээ шаардлага, бэлэн байдал, үр ашгаар үнэлэн цөөн тооны тэргүүлэх төслүүдийг хөгжлийн бодлогын баримт бичигт үлдээх нь зүйтэй. Эрчим хүчний ирэх жилүүдийн /7 хүртэлх жил/ хүчин

чадлын таамаг тэнцлийг боловсруулахад хөгжлийн бодлогод тусгагдсан төслүүдийг хамруулан тооцож нэмэлтээр үүсэх эх үүсвэрийн дутагдлыг хувийн хэвшил хэрэгжүүлэхэд олон шат дамжлагагүй, өрсөлдөөнд суурилсан, сонгон шалгаруулалтыг хэрэгжүүлэх орон зайг бүрдүүлэх нь чухал байна.

Шинэ эх үүсвэрийн төслийг дуудлага худалдааны зарчмаар, үнэ хаялцуулан төслийн ялагчийг шалгаруулснаар төслүүдийн сонгон шалгаруулалтын үе шатыг багасгах, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, шалгаруулалтын үйл явцад хөндлөнгөөс нөлөөлөх байдлыг бууруулах мөн эрчим хүчний төслүүд дээр үүсэж болох хүндрэлтэй асуудлуудаас сэргийлэх гарц, шийдэл болох боломжтой юм.

Хавсаргасан материал:

1. БНКУ-ын эрчим хүчний 7 жилийн урьдчилсан тэнцлийг боловсруулах журам
2. БНКУ-ын ЭХЯ-ны эрчим хүчний системийн 2025-2031 оны цахилгаан эрчим хүч ба чадлын урьдчилсан тэнцлийг батлах тушаал
3. Шинээр ашиглалтад оруулах цахилгаан эх үүсвэрийн тендерийн журам
4. Шинээр ашиглалтад оруулах цахилгаан эх үүсвэрийн тендерийн баримт бичиг батлах журам
5. Шинээр ашиглалтад оруулах цахилгаан үүсгүүрийн байгууламжийн барилгын тендерийн үр дүнг нэгтгэн дүгнэх тендерийн комисс байгуулах тухай журам
6. ЭХЯ-ны 2025 оны 7 сард баталсан ГРЕС-3 тендерийн баримт бичиг
7. Шинээр ашиглалтад орох зохицуулалтын горимтой эх үүсвэрийн дуудлага худалдаа /аукцион/-ы журам
8. ЭХЯ-ны 2025 онд шинээр ашиглалтад орох зохицуулах горимтой эх үүсвэрийн дуудлага худалдаа /аукцион/ зохион байгуулах хуваарийг батлах тухай мэдэгдэл
9. БНКУ-ын Эрчим хүчний зах зээлийн зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм
10. БНКУ-ын Банкны захирлуудын зөвлөлөөс баталсан “Банкны баталгаа болон батлан даалтын олголтын дүрэм”
11. SWIFT системээр гаргадаг банкны баталгаа/ нөөц аккредитивын маягт (Дуудлага худалдаанд оролцох хүсэлтийн санхүүгийн баталгааны маягт)



Б.ОЮУНДЭЛГЭР

ШИНЭ СЭРГЭЛТ
ИННОВАЦИЙН ХӨТӨЛБӨР

Мэргэжилтэн

МОНГОЛ УЛСЫН ХАРИЛЦАА ХОЛБОО, ЦАХИМ ДЭД БҮТЦИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ



ГАРЧИГ

1. МОНГОЛ УЛСЫН ХАРИЛЦАА, ХОЛБОО МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН САЛБАРЫН ТҮҮХ	147
1.1 Телефон ярианы болон үүрэн холбооны хөгжлийн түүх	147
1.2 Интернэтийн хөгжлийн түүх	148
2. ЦАХИМ ШИЛЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	148
3. ДЭД БҮТЭЦ БА ИНТЕРНЭТ ХОЛБОЛТ	149
3.1 Шилэн кабелийн сүлжээний тархац	150
3.2 Хөдөлгөөнт интернэт үүрэн холбоо	150
3.3 Дата төвийн дэд бүтэц	150
4. ИНТЕРНЭТИЙН ХЭРЭГЛЭЭ	151
4.1 Интернэттэй өрх	151
4.2 Интернэтэд холбогдоогүй өрх	152
4.3 Бусад улстай харьцуулсан байдлаар	153
5. ИРГЭДИЙН ЦАХИМ ХАНДЛАГА	155
5.1 Интернэтийн зохистой хэрэглээний талаарх ойлголт, мэдлэг, хандлага	155
5.2 Иргэдийн болон төрийн албан хаагчдын цахим хэрэглээ, ур чадвар	155
6. МОНГОЛ УЛСЫН ЦАХИМ БЭЛЭН БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ	155
6.1 Цахим бэлэн байдлын үнэлгээ - Digital Readiness Index	155
6.2 Сүлжээний бэлэн байдлын индекс - The Network Readiness Index	156
Дүгнэлт	159

МОНГОЛ УЛСЫН ХАРИЛЦАА ХОЛБОО, ЦАХИМ ДЭД БҮТЦИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

ЗОРИЛГО

Монгол Улс дэлхий нийтийн цахим шилжилтийн чиг хандлагад хөл нийлүүлэн төрийн үйлчилгээ болон нийгэм, эдийн засгийн бүх салбарт цахим технологийн нэвтрэлтийг эрчимжүүлж байна. “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, “Цахим үндэстэн” зорилт болон “e-Mongolia” хөтөлбөрийн хүрээнд төрийн үйлчилгээг цахимжуулах, дижитал дэд бүтцийг өргөтгөх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах зэрэг олон талт арга хэмжээнүүд хэрэгжиж байна.

Энэхүү судалгааны зорилго нь Монгол Улсын цахим шилжилт, цахим хөгжлийн өнөөгийн түвшинг үнэлж, мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтэц, интернэт хэрэглээ, төрийн цахим үйлчилгээний хүтээмжийг дүгнэлт гаргахад оршино.

Судалгааны хүрээнд дараах тодорхой зорилтуудыг дэвшүүлэв:

- Харилцаа холбоо, интернэт дэд бүтцийн хөгжил, хүртээмж, чанарын үзүүлэлтүүдийг судлах;
- Интернэт хэрэглэгчдийн бүтэц, дижитал хүртээмжийн ялгааг (нас, хүйс, бүс нутаг, орлогоор) шинжлэх;
- Төрийн цахим үйлчилгээний үр нөлөө, иргэдийн сэтгэл ханамж болон нийгэм эдийн засгийн хэмнэлтийг тодорхойлох;
- Монгол Улсын цахим хөгжлийн үзүүлэлтүүдийг бүс нутгийн болон дэлхийн дундажтай харьцуулан дүгнэх;

1. Монгол улсын харилцаа, холбоо мэдээллийн технологийн салбарын түүх

1.1 Телефон ярианы болон үүрэн холбооны хөгжлийн түүх

Олноо өргөгдсөн Монгол Улсын үе 1913 онд Их хүрээнд 25 хэрэглэгчийн гар ажиллагаатай дотоод телефон станц суурилуулснаар манай улс анх суурин утастай танилцсан түүхтэй. Хүрээний телефон утасны хэрэглэгчдийн тоо аажмаар нэмэгдэж 1923 онд 100 хэрэглэгчтэй МБ-100 станцыг суурилуулсан бол 1927 онд Ардын засгийн шийдвэрээр дээрх станцаас гурвыг байршуулж 300 хэрэглэгчтэй болсон байна.¹

1992 онд анхны тоон АТС /автомат телефон станц/ ашиглалтад орсноор хэрэглэгчид гэрээсээ хот хороонд ярьдаг болсон бол 1993 онд улс хоорондын 100 суваг, хот хоорондын 1000 сувгийн багтаамжтай NEAX-61 станц ашиглалтад орсон 16 улс хоорондын яриаг сансрын холбооны Наран станцын олон улсын гарцаар дамжин шууд хийх боломжтой болсон. Суурин утасны хэрэглэгч 1940 онд 2400 байсан бол 1990 онд 66.4 мянга, 2010 онд 143.2 мянга болж 2020 онд 315 мянга гаруй байсан бол 2024 оны байдлаар 621 мянга гаруй болсон байна.²

Үүрэн холбооны хувьд Монгол Улсад үүрэн холбооны үйлчилгээний тусгай зөвшөөрлийг 1995 онд анх

Мобиком ХХК-д олгож улмаар 1996 онд GSM (Global System for Mobile Communications) стандартын үүрэн холбооны үйлчилгээг нэвтрүүлснээр албан ёсоор Улаанбаатар хотод нэвтэрсэн. Улмаар 1997 онд Эрдэнэт, Дархан хотод нэвтрүүлж байсан бол 1999 онд Скайтел, 2006 онд Юнител, 2007 онд Жи мобайл, 2021 онд Ондо компаниуд үйл ажиллагаагаа эхлүүлсэн. 1999 онд SMS үйлчилгээ, олон улсын роуминг үйлчилгээ нэвтэрч байсан бол 2008 онд үүрэн сүлжээг ашиглаж интернэтэд холбогдох боломжийг олгосон 3G сүлжээ, 2016 онд өндөр хурдны сүлжээ бүхий 4G сүлжээ нэвтэрсэн байна. 2019 онд манай улсад зохиогдсон ICT ехро-ийн үеэр дотоодын харилцаа холбоо, мэдээллийн технологийн Юнител групп монголд анх удаа 5G сүлжээний туршилт хийж 2025 онд 5G сүлжээг албан ёсоор нэвтрүүлэн 44 байршил болон 21 аймгийн төвүүдэд асаасан байна.³

Үндэсний статистикийн хороо 1999 оноос эхлэн улсын хэмжээнд үүрэн утасны хэрэглэгчдийн тоон мэдээллийг цуглуулж эхэлсэн бөгөөд, тухайн үед 48.2 мянга байсан хэрэглэгчдийн тоо тасралтгүй өсөж 2007 онд 1 сая хэрэглэгч, 2009 онд 2 сая, 2012 онд 3 сая, 2024 оны эцсийн байдлаар давхардсан тоогоор 4.9 саяд хүрсэн байна.⁴

¹ (Мэдээлэл харилцаа холбооны салбар түүхэн замнал, дурсгал, 2021)

² (Харилцаа холбооны зохицуулах хороо, 2024)

³ (Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, 2022)

⁴ (Үндэсний статистикийн хороо, 2024)

1.2 Интернэтийн хөгжлийн түүх

Датаком ХХК нь 1994 оноос Монгол улсад имэйлийн үйлчилгээг эхлүүлэн сүлжээний холболтыг эхлүүлж, улмаар 1996 оны нэгдүгээр сарын 17-ны өдрөөс Монгол улс 24 цагийн интернэтийн сүлжээнд холбогдсон юм. Улаанбаатар хот болон АНУ-ын Калифорни мужийн хооронд 128 Kbps сансрын сувгаар дамжуулан интернэт холболтыг хийж Датаком ХХК нь Монголд Улсын хэмжээнд анхны 24 цагийн интернэтийн үйлчилгээ үзүүлэгч ISP (Internet Service Provider) болсон юм. 2010 онд 71 интернэтийн үйлчилгээ үзүүлэгч ажиллаж байсан бол 2021 онд 68 байсан бол 2024 оны байдлаар 59 байна.⁵ Монгол Улсад интернэт хэрэглэгчдийн тоо 1996 онд 5009 гаруй байсан бол 2009 онд 10,000 давж, 2021 онд 4.1 сая байсан бол 2024 оны байдлаар 4.8 сая болж нийт хүн амын 83.9 хувьд хүрсэн байна.⁶

Интернэтийн үйлчилгээний анхны хэрэглэгч нь Монгол банк байсан бөгөөд 1997 онд 115 kbps радио модем ашиглан МУИС, ТИС зэрэг 7 их дээд сургууль интернэтийн сүлжээнд холбогдож байжээ. 2020 онд 19 мянга гаруй байсан бол 2024 оны байдлаар 29 мянга гаруй байгууллага интернэтийн үйлчилгээг ашиглаж байна. Өнөөгийн байдлаар монголчууд интернэтийг физик кабель, үүрэн холбоо, шилэн кабель, сансрын холбооны сүлжээ зэрэг бүхий л төрлийн технологи ашиглан өргөнөөр хэрэглэдэг болжээ.⁷

Монголчууд бид интернэтийн хэрэглэгч болсон нь хүн төрөлхтний мэдээллийн том урсгалд нэгдэж, орон зай, цаг хугацаанаас үл хамааран дэлхийн аль ч өнцгөөс мэдээлэл дамжуулах, хүлээн авах эхлэлийг тавьсан юм. Өнөөдөр Монгол Улс мэдээллийн технологийн ашиг тусыг бүх талаар хүртэж тэр нь хүн, байгууллагын өдөр тутмын ажил, амьдралын салшгүй хэсэг эдийн засгийн тулах дэд бүтцийн нэг болж байна. Монголчууд мэдээллийн технологид суурилсан бизнес загваруудыг амжилттай хөгжүүлж, олон улсын түвшинд өрсөлдөх чадвартайг харуулсан.⁸

2. Цахим шилжилтийн өнөөгийн байдал

Нийгэм, эдийн засгийн бүх салбарт харилцаа холбоо, мэдээллийн технологи, инновацийг нэвтрүүлж, бүтээмж, өрсөлдөх чадвар, үр ашгийг нэмэгдүүлэх замаар хүнд сурталгүй, ил тод нээлтэй байдлыг хангах “Цахим засаглалыг хөгжүүлэх” зорилгын хүрээнд Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12-р сарын 17-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар баталсан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Инновацийн тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хуулийн хүрээнд

Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор 26, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын тушаалаар 33 актыг тус тус батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Нийтийн мэдээллийн дэд бүтцийн бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд Үндэсний дата төвийн сервер, тоног төхөөрөмжийг олон улсын чиг хандлагад нийцүүлэн өргөтгөн сайжруулж төр, хувийн хэвшлийн хамтарсан “mcloud.gov.mn” үүлэн дэд бүтцийг нэвтрүүлэн сүлжээний төхөөрөмжүүдийг виртуалчлан удирдах боломжийг бүрдүүлсэн.

Төрийн мэдээлэл солилцооны систем (ХУР)-д төрийн 142, хувийн хэвшлийн 390 байгууллагын 816 үйлчилгээг амжилттай холбосон байна. Мөн Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia.mn)-ийн үйл ажиллагаанд нэмэлт хөгжүүлэлт хийж, 2023 онд “e-mongolia 3.0” 2024 онд “e-mongolia 4.0”, 2025 онд “e-mongolia 5.0”, хувилбарыг тус тус хэрэглээнд нэвтрүүлсэн бөгөөд тус систем нь e-mongolia.mn - иргэн, e-business.mn -хуулийн этгээд, lavlagaa.e-mongolia.mn -үйлчилгээ үзүүлэх байгууллагууд, operator.e-mongolia.mn -ХУРДАН төрийн үйлчилгээг, ki-osk.e-mongolia.mn -ХУРДАН мобайл аппликейшн гэсэн 6 суваг ашиглан иргэн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлж байна. Тус системд 2.0 сая гаруй хэрэглэгч бүртгүүлж, 87 байгууллагын 1263 орчим үйлчилгээг холбон, 65 сая удаагийн үйлчилгээг амжилттай дамжуулж, 1.3 их наяд төгрөгийн шууд бус зардлыг хэмнэсэн.

Тоон гарын үсгийг түгээх ажлыг эрчимжүүлж, иргэнийг таньж баталгаажуулах зорилготой танилт, нэвтрэлтийн систем (ДАН)-д тоон гарын үсгийн модулийг холбож, иргэн, хуулийн этгээдийг тоон гарын үсгээр дамжуулан таних боломжийг бүрдүүлсэн ба 2024 оны байдлаар уг системд нийт 2.1 сая гаруй хэрэглэгч бүртгүүлж, төрийн 85 байгууллагын 160, хувийн хэвшлийн 244 байгууллагын 279 системийг холбосон. Харин тоон гарын үсгийн гэрчилгээг төрийн 1, хувийн хэвшлийн 5 байгууллагаар дамжуулан нийт 1.4 сая иргэн, хуулийн этгээдэд олгосон. Цахим ардчиллыг хөгжүүлж, төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэд саналаа өгөх, хяналт тавих зэргээр цахимаар оролцох боломжийг бүрдүүлэх зорилготой “petition.parliament.mn” систем, төрийн үйл ажиллагааг хэлэлцэхэд ашиглагдах “e-tanhim.gov.mn”-ийн 2.0 хувилбар болон “e-cabinet”-ийн мобайл хувилбарыг тус тус хөгжүүлэн хэрэглээнд нэвтрүүлсэн. Бизнес эрхлэгчдэд зориулсан e-business.mn платформ 2023 онд хэрэглээнд нэвтэрснээс хойш бизнес эрхлэгчдийн өдөр тутмын үйл ажиллагаанд дижитал өөрчлөлт авчирсаар байна. Хуулийн этгээд үүсгэн байгуулах, зөвшөөрөл авах, сунгах, байгууллагын лавлагаа зэрэг 953 төрлийн үйлчилгээг нэг платформоос авах боломжийг бүрдүүлснээр одоогийн байдлаар 39,940

⁵ (Мэдээлэл харилцаа холбооны салбар түүхэн замнал, дурсгал, 2021)

⁶ (Үндэсний статистикийн хороо, 2024)

⁷ (Харилцаа холбооны зохицуулах, 2024)

⁸ (Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, 2022)

хэрэглэгч нийт 345,365 удаа цахимаар үйлчлүүлээд байна. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлж, албан бичиг солилцооны дундын систем “ДосХ”-ийг хөгжүүлэн, 5000 гаруй байгууллагын ашигладаг 17 албан бичиг боловсруулалтын системтэй холбож, 2413 байгууллага холбогдон 136,888 бичиг 178,328 хавсралтын хамтаар илгээсэн, 165,628 бичиг хүлээн авсан байна. Түүнчлэн хөдөө орон нутаг, алслагдсан сум суурин газрын иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, хөрөнгө оруулагчдыг нэгдсэн мэдээллээр хангах зорилготой “huduu.mn”-ийг хөгжүүлж, 46,295 мэдээллийг тухай бүр шинжлэн, тасралтгүй ажиллагааг хангаж байна.

3. Дэд бүтэц ба интернэт холболт


Монгол Улсын Мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэд салбаруудын мастер төлөвлөгөө, үндэсний хөтөлбөр, төрөөс баримтлах бодлогыг улсын төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж өнөөг хүртэлх орон нутагт мэдээлэл, харилцаа холбооны шинэлэг үйлчилгээ нэвтрүүлэх техник технологийн суурь дэд бүтэц бүрдэж, шилэн кабелийн сүлжээний нийт 52,480 км урттай шилэн кабелийн сүлжээгээр интернэт холболтыг хангаж байгаа бөгөөд энэ нь нийт нутаг дэвсгэрийн ойролцоогоор 23%- ийг хамарч байна.

Зураг 1. 2024 оны байдлаар Монгол Улсын шилэн кабелийн тархац




Хот хоорондын шилэн кабелийн үндсэн сүлжээний 45.95 хувийг төрийн өмчийн Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн сүлжээ бүрдүүлж байгаа бол 24.78 хувийг Скайнэтворкс ХХК, 20.97 хувийг Мобиком нэтворкс ХХК-ийн байгуулсан сүлжээ тус тус бүрдүүлж байна.

График 1. Хот хоорондын шилэн кабелийн сүлжээний эзэмшил



Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 727 ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байр, дотуур байр болон мэргэжил сургалт үйлдвэрлэлийн байрууд шилэн кабелиар өндөр хурдны интернэтэд холбогдсон. Шилэн кабельд холбогдох боломжгүй алслагдсан

График 2. Үүрэн холбооны хэрэглэгчийн зах зээлд эзлэх хувь



¹² <https://mddic.gov.mn/>
¹³ (Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, 2025)

¹⁴ (Харилцаа холбооны зохицуулах хороо, 2024)

сум болон багийн 57 сургуулиудыг СТАРЛИНК төхөөрөмжөөр холбосон. Мөн эрүүл мэндийн салбарын байгууллагуудын дунд 706 байгууллагыг мэдээллийн урсгал, өгөгдөл солилцох сүлжээнд холбосон боловч интернэтийн хурд болон чанар харилцан адилгүй байдаг.

3.1 Шилэн кабелийн сүлжээний тархац

Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид 2023 онд хот хооронд 2612 км, хот суурин газарт 682 км шилэн кабелийн сүлжээ шинээр байгуулснаар Монгол Улсын дамжуулах сүлжээний урт 52 мянган орчим км болж өмнөх оноос 6.8 хувиар нэмэгджээ. Интернэтийн гадаад урсгалын багтаамж өмнөх оноос 20 Гбит/сек-ээр нэмэгдэж 590.5 Гбит/сек хүрсэн ба нийт 54 интернэтийн үйлчилгээ үзүүлэгч 213 Гбит/сек-ийн урсгал гэрээлсэн байна. Тархцын хувьд 2023 оны байдлаар нийт 330 сумын 328 нь шилэн кабельд холбогдсон. Дамжуулах сүлжээний багтаамжаар 2017 онд 12.5 Гбит/с байсан бол 2022 онд 2,112 Гбит/с болж 168 дахин нэмэгдсэн байна. Дамжуулах сүлжээний хэрэглээ 2017 онд 3.8 Гбит/с байсан бол 2022 онд 79.5 Гбит/с болж 20 дахин өсчээ. Интернэт хэрэглээний дундаж үнэ тарифын хувьд 2022 онд 39.5 мянган төгрөг болж 7.4 дахин буурсан байна энэ нь орон нутагт цахим шилжилтийг бодитой хэрэгжүүлэх суурь нөхцөл болдог.

3.2 Хөдөлгөөнт интернэт үүрэн холбоо

Үүрэн холбооны зах зээлд 2022 оноос 5 оператор компани үйл ажиллагаа явуулж эхэлсэн ба 5 дахь оператор 2023 оны сүүлээс бусад сүлжээтэй харилцан холболт хийгдсэнээр хэрэглэгчийн тоо нь нэмэгдэж, зах зээлд эзлэх хувь нь 2 хувиар өсөн байна. Харин давамгайлалч операторуудын зах зээлд эзлэх хувь 1-2 хувиар буурчээ. Нийт дата хэрэглээ 2022 оноос 28 хувиар өссөн. Дата ачааллын хувьд 4G сүлжээн дэх ачаалал 29 хувиар нэмэгдэж 612,279 ТБайт болсон нь хэрэглэгчийн тоонд харьцуулбал нэг хэрэглэгч сард дунджаар 14.8 Гбайт дата хэрэглэсэн байна. /2022 онд энэ тоо 12.8 Гбайт байсан. (Харилцаа холбооны зохицуулах, 2024)

Үүрэн холбооны сүлжээний тархцыг харахад Монгол Улсын нийт 1,637 багаас 4G сүлжээнд 363 баг, 3G сүлжээнд 1,017 баг холбоод байна. Одоогоор 190 баг үүрэн холбооны хөдөлгөөнт сүлжээнд холбогдоогүй байна. 2024 он ЦХИХХЯ-наас “Хөдөөгийн алслагдсан багуудын харилцаа холбооны дэд бүтэц” төслийг хэрэгжүүлэн ажиллажээ. Энэ хүрээнд орон нутгийн алслагдсан 129 багт үүрэн холбооны сүлжээ нэвтрүүлнэ

Зураг 3. 2025 онд сүлжээ оруулах багууд



гэж төлөвлөснөөс 2024 онд 74 багыг, 2025 онд 55 багт энэхүү сүлжээг нэвтрүүлэхээр төлөвлөсөн. Уг төслийн хүрээнд хөдөөгийн алслагдсан багуудад харилцаа холбооны байр, цахим дэд бүтцийг байгуулж, үүрэн холбооны 4G үйлчилгээг нэвтрүүлнэ. Ингэснээр иргэд интернэтийн үйлчилгээг гар утаснаасаа хүлээн авах /мэдээ, мэдээлэл хүлээн авах, цахим сургалтад хамрагдах, эрүүл мэндийн цахим үйлчилгээ/, гамшиг, онцгой байдлын үеийн мэдээ, мэдээллийг цаг алдалгүй шуурхай хүлээж авах, урьдчилан сэргийлэх, төрөөс иргэдэд үзүүлж буй бүх төрлийн цахим үйлчилгээг хүлээн авах боломж бүрдэнэ. Мөн хот хөдөөгийн тоон хуваагдал буурахад томоохон нөлөөлөл үзүүлнэ.

3.3 Дата төвийн дэд бүтэц

Монгол Улсын дата төвийн экосистем нь хиймэл оюуны хөгжлийг дэмжих суурь дэд бүтцийг бүрдүүлж эхэлж байгаа ч өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангахын тулд дэд бүтцээ өргөтгөх, чадавхыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Одоогоор улсын хэмжээнд цөөн тооны дата төв үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд төрийн цахим үйлчилгээ болон “E-Mongolia” системийн үндсэн дэд бүтцийг Үндэсний дата төв бүрдүүлж байна. Гэвч тус төвийн ашиглалт 90%-д хүрсэн нь өсөн нэмэгдэж буй цахим үйлчилгээний эрэлт хэрэгцээг хангахын тулд

¹⁵ (Монголын цахилгаан холбоо ХК, 2024)

¹⁶ (Харилцаа холбооны зохицуулах хороо, 2024)

дата дэд бүтцийг өргөжүүлэх, шинэчлэх зайлшгүй шаардлага байгааг илтгэж байна.

Хиймэл оюуны бэлэн байдлыг хангахад анхаарах чухал чиглэлийн нэг нь өндөр хүчин чадалтай тооцооллын (НРС) дэд бүтцийг бүрдүүлэх явдал юм. Монгол Улсад хиймэл оюуны хэрэглээ болон судалгаа, хөгжүүлэлтэд шаардлагатай GPU нөөц, суперкомпьютер зэрэг тусгай зориулалтын тооцооллын дэд бүтэц одоогоор бүрдээгүй байгаа бөгөөд энэ нь дотоодын инновацийн чадавхыг бэхжүүлэх, гадаад тооцооллын нөөцөд хэт хамааралтай байдлыг бууруулахын тулд хиймэл оюуны чиглэлд зориулсан стратегийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж буй. Засгийн газар хиймэл оюун, их өгөгдлийн хэрэглээнд зориулсан Tier IV түвшний шинэ дата төв байгуулахаар төлөвлөж буйгаа зарласан нь өндөр хүчин чадалтай тооцооллын чадавхыг бүрдүүлэх эрмэлзлээ илэрхийлж байна. Үүнээс гадна, Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй “Ухаалаг засаг II” төсөл нь төрийн одоогийн дата төвүүдийг нэгдсэн үүлэн тооцооллын платформ болгон шинэчилж, цахим үйлчилгээний үр ашиг, уян хатан байдал, цар хүрээг нэмэгдүүлж байна. Эдгээр дэд бүтцийн хөгжлийг хувийн хэвшлийн тогтвортой хөрөнгө оруулалттай уялдуулснаар төр, хувийн хэвшлийн хүрээнд хиймэл оюуны шийдлийг нэвтрүүлэх чадавхыг бэхжүүлэхэд чухал түлхэц болох юм. Одоогийн дэд бүтэц нь хиймэл оюуны анхан шатны хэрэглээг дэмжих суурь нөхцөлийг бүрдүүлж байгаа боловч илүү ахисан түвшний хэрэглээнд шаардлагатай тусгай зориулалтын тооцооллын нөөц дутагдалтай. Иймд хиймэл оюуны чадавхыг бүрэн хэмжээнд хөгжүүлэхийн тулд цаашид энэ чиглэлд анхаарч сайжруулах шаардлагатай.

Үүний зэрэгцээ, дэд бүтцийн хүртээмж, чанар, чадавхын харилцан адилгүй байдал нь орон нутагт хиймэл оюуны үйлчилгээг тогтвортой, тэгш хүргэхэд саад болж болзошгүй юм. Энэ нь 2 дугаар тулгуур чиглэл болох төрийн байгууллагуудын хиймэл оюуны хэрэглээг өргөн хүрээнд нэвтрүүлэх чадавхыг хязгаарлах эрсдэлтэй. Иймд, хиймэл оюуны зориулалттай тооцооллын байгууламж байгуулах зэрэг төлөвлөж буй сайжруулалт нь хиймэл оюуныг үндэсний хэмжээнд хүртээмжтэй, үр дүнтэй нэвтрүүлэх үндсэн нөхцөлийг бүрдүүлэх юм.

4. Интернэтийн хэрэглээ

Олон улсын цахилгаан холбооны байгууллагаас 2020 онд гаргасан цахим хөгжлийг хэмжих тайланд дэлхийн нийт өрхийн 57.0 хувь нь интернэтэд холбогдсон байна. Интернэтэд холбогдсон өрхөөс хотод амьдардаг нийт


өрхийн 72.0 хувь, хөдөө амьдардаг нийт өрхийн 37.0 хувь нь интернэтэд холбогдсон байна.

4.1 Интернэттэй өрх

Суурин интернэт хорбогдсон хэрэглэгчийн тоо

Монгол Улсын хэмжээнд суурин интернэтэд холбогдсон буюу гэрээт хэрэглэгчийн тоо 2023 оны жилийн эцсийн байдлаар 498,889-д хүрч өмнөх оноос 14.3 хувиар өсчээ. Үүний 471,729 нь өрхийн хэрэглэгч бөгөөд улсын хэмжээнд нийт өрхийн 48 орчим хувь нь суурин интернэтэд холбогдсон бөгөөд суурин интернэт хэрэглэгчийг байршлаар нь авч үзвэл 76.03 хувь нь Улаанбаатар хотод, 23.97 хувь нь орон нутагт байна.

График 3. Хот хоорондын шилэн кабелийн сүлжээний эзэмшил



Нийт өрхийн тоотой харьцуулбал Улаанбаатар хотод суурин интернэтийн нэвтрэлт 81.56 хувь, харин орон нутагт дунджаар 23.06 хувь.

Суурин интернэт хэрэглэгчийн 96.1 хувь нь өндөр хурдны шилэн кабелийн сүлжээ, үлдсэн 3.9 хувь нь Wi-Fi, Wi-MAX, DSL -ийн холболттой байна.

Үүрэн холбооны хэрэглэгчийн тоо

Монгол Улсын хэмжээнд үүрэн холбооны идэвхтэй хэрэглэгчийн тоо 2023 оны жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор 4,841,935 болж өмнөх оноос 0.1 хувиар өсчээ.


¹⁷ (Харинцаа холбооны зах зээлийн 2023 статистик эмхэтгэл, 2024)

¹⁸ (Өрхийн мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хэрэглээ, хүртээмжийн судалгааны танилцуулга, 2022)

Үүрэн холбооны 3G сүлжээ Монгол Улсын 345 сум, суурин газарт нэвтэрч, нийт хүн амын 100 хувийг хамарсан бөгөөд 3G хэрэглэгчийн тоо 2023 оны жилийн эцсийн байдлаар 3.5 саяд хүрч, 2022 онтой харьцуулахад 0.44 хувийн өсөлттэй байна. Харин 4G/LTE сүлжээ нийт хүн амын 99 хувийг хамарч, үйлчилгээний хэрэглэгчийн тоо 3.4 саяд хүрч, өмнөх оноос 11.4 хувиар өссөн.

Үүрэн холбооны сүлжээ жил ирэх бүр хүрээгээ тэлж нийт дүнгээр өмнөх оноос 27.83 хувиар нэмэгдэж, нийт бааз станцын 56.88 хувийг 4G сүлжээний, 23.19 хувийг 3G сүлжээний, 19.94 хувийг 2G сүлжээний бааз станц бүрдүүлж байна.

График 4. Үүрэн холбооны бааз станцын эзлэх хувь, технологийн төрлөөр



Улаанбаатарын өрхийн 93.2 хувь, аймгийн төвийн өрхийн 76.2 хувь, сумын төвийн өрхийн 75.3 хувь, хөдөөгийн багийн өрхийн 55.5 хувь нь интернэттэй байна. Улаанбаатарын өрхийн хувьд 68.4 хувь нь суурин интернэтийн үйлчилгээ, 25.5 хувь нь хөдөлгөөнт өргөн зурвасын интернэт (3G, 4G, USB, модем), 6.1 хувь нь газрын утасгүй өргөн зурвасын сүлжээний интернэттэй байгаа бол хөдөөгийн багийн өрхүүдийн 73.1 хувь нь хөдөлгөөнт өргөн зурвасын интернэтийн үйлчилгээ авч байна.


Хүснэгт 2. Интернэттэй өрхийн эзлэх хувь, үйлчилгээний төрөл, суурьшлаар

Сууршил	Улс	Суурин интернэтийн сүлжээ	Газрын утасгүй өргөн зурвасын сүлжээ	Хөдөлгөөнт өргөн зурвасын сүлжээ (3G, 4G, USB, модем)
Улаанбаатар	93.2	68.4	6.1	25.5
Аймгийн төв	76.2	57.6	5.5	36.8
Сумын төв	75.3	37	4.7	58.4
Хөдөөгийн баг	55.5	24.6	2.3	73.1

4.2 Интернэтэд холбогдоогүй өрх

Өрхийн мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хэрэглээ, хүртээмжийн судалгааны танилцуулгаас Монгол Улсын нийт өрхийн 20.0 хувь нь интернэтэд холбогдоогүй байгааг харж болно судалгаагаар интернэтэд холбогдоогүй өрхөөс 49.9 хувь нь интернэт шаардлагагүй, 28.4 хувь нь интернэтийн үйлчилгээ авах боломжгүй газар амьдардаг, 7.2 хувь нь тоног төхөөрөмжийн өртөг өндөр, 6.0 хувь нь үйлчилгээний өртөг өндөр гэж хариулт иржээ.


График 5. Интернэтэд холбогдоогүй өрхийн эзлэх хувь, шалтгаанаар



Улаанбаатарын өрхийн 6.8 хувь, аймгийн төвийн өрхийн 23.8 хувь, сумын төвийн өрхийн 24.7 хувь, хөдөөгийн багийн өрхийн 44.5 хувь нь интернэтэд холбогдоогүй гэсэн мэдээлэл бий.¹⁹

¹⁸ (Өрхийн мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хэрэглээ, хүртээмжийн судалгааны танилцуулга, 2022)

График 6. Интернетэд холбогдоогүй өрхийн эзлэх хувь, байршлаар



4.3 Бусад улс оронтой харьцуулсан байдлаар

Монгол Улсад интернэтийн хэрэглээ сүүлийн жилүүдэд маш хурдацтай нэмэгдэж, дэлхийн дундажтай харьцуулахад харьцангуй өндөр түвшинд хүрээд буй. 2024 оны байдлаар дэлхийн хүн амын ойролцоогоор 67.60% нь интернэт хэрэглэдэг байхад Монголчуудын хувьд 83.9% буюу 2.91 сая хүн интернэт хэрэглэдэг байна.


Интернэтийн хэрэглээгээр дэлхийн дунджаас илүү өндөр түвшинд хүрсэн боловч Бахрейн, Казахстан, Эстони, Япон, Кыргызстан зэрэг дижитал эдийн засгийн өндөр хөгжилтэй орнуудын түвшинд хараахан хүрээгүй.

График 7 Интернет хэрэглээний түвшин 2024 он




Үүрэн холбооны хэрэглээний түвшингээр авч үзвэл дэлхийн нийт хүн амын дундаж хэрэглээ 70.30% байхад Монгол Улсын үзүүлэлт 141%-д хүрч байгаа нь дэлхийн дунджаас бараг хоёр дахин өндөр байна. Бахрейн, Япон зэрэг өндөр хэрэглээтэй орнууд ойролцоо түвшинд байгаа бөгөөд Бахрейн болон Японоос 10-13 хувиар доогуур, харин Кыргызстанаас 13 хувиар өндөр үзүүлэлттэй байна.

График 8 Үүрэн холбооны хэрэглээний түвшин 2024 он



Сошиал хэрэглээний түвшинг харьцуулж үзвэл дэлхийн нийт хүн амын дундаж хэрэглээ 63.80% байхад Монгол Улсын үзүүлэлт 74.40%-д байгаа нь дэлхийн дунджаас 19 хувиар өндөр. Өндөр хөгжилтэй, дижитал хэрэглээ түгээмэл хүн амын насжилт өндөр Япон улс хэрэглээ хамгийн өндөр 78.60% байна.²¹

График 9 Сошиал хэрэглээний түвшин 2024 он



Монгол Улсын 6 ба түүнээс дээш насны иргэдийн дийлэнх нь интернэтийг идэвхтэй хэрэглэж байгаа бөгөөд сүүлийн 10 жилийн хугацаанд интернэт хэрэглээ 34 хувиар нэмэгдсэн байна. Одоогоор хот суурин газрын иргэдийн 4 хүн тутмын 3 нь, хөдөөгийн бүсийн иргэдийн 2 хүн тутмын 1 нь интернэт ашиглаж байна.

²⁰ <https://datareportal.com/reports/digital-2024-october-global-statshot>

Онлайнд өнгөрүүлж буй хугацаагаар нь харахад 18–64 насны өдөрт дунджаар 7 цаг 13 минут интернэт орчинд өнгөрөөдөг бөгөөд дэлхийн дунджаас 4 минутаар өндөр Хятад болон Энэтхэг улсын дундаж хэрэглээнээс илүү үзүүлэлт юм. Мөн нэг өдөрт интернэтээр видео тоглоом тоглох хугацаа өдөрт дунджаар 2 цаг орчим байгаа нь Хятад улсынхаас 37 минутаар, ОХУ-ынхаас 1 цаг 25 минутаар илүү байна.

Монгол Улсын интернэт хэрэглээ, тэр дундаа социал медиа хэрэглээ эрчимтэй өсөж байгааг интернэт хэрэглээний зарим үзүүлэлтийг зарим улсуудтай харьцуулан харуулав. Монгол Улс 100,000 хүн ам тутмын интернэт хэрэглэгчийн тоогоор дэлхийн дунжийг давсан, мобайл сүлжээний дэд бүтцээрээ харьцангуй сайн боловч кибер аюулгүй байдлын индекс, төхөөрөмж, үйлчилгээний хүртээмжтэй байдлаараа бусад хөрш улс орнуудаас харьцангуй бага.

Монголчуудын мэдээлэл авч буй гол эх сурвалж нь социал медиа болон телевиз бөгөөд тэд өдөрт дунджаар 6 цагийг медиа хэрэглээнд зарцуулдаг гэсэн тооцоолол бий. Үүнээс уламжлалт болон дижитал медиа хэрэгслүүд болох сонин, сэтгүүл, FM радио, телевиз болон социал медиад нийт хэрэглээний 25 орчим хувийг зарцуулж байна.

Зураг 3. Монголчуудын медиад зарцуулж буй цаг




Монголчуудын мэдээлэл авах гол суваг нь уламжлалт болон дижитал медиагаар ялгардаг. Уламжлалт медиагийн хувьд хамгийн өндөр хэрэглээтэй суваг нь телевиз бөгөөд хүн амын 86% нь мэдээллээ телевизээр авдаг бол хамгийн бага нь 26% нь мобайл мессежээр мэдээлэл авдаг. Харин дижитал медиагийн хувьд иргэдийн 95% нь мэдээллээ голчлон интернэт болон Facebook, Instagram, YouTube зэрэг социал платформуудаас авдаг бөгөөд хамгийн бага хэрэглээ нь аппликейшнээс ирдэг мэдэгдлүүдээр дамжин хүрдэг байна.

Зураг 4. Монголчуудын мэдээлэл авах гол сурвалж²³



Монголчуудын мэдээлэл авдаг эх сурвалжийг эрэмбэлж үзэхэд хамгийн их хэрэглэгддэг эх сурвалж нь Facebook бөгөөд нийт иргэдийн 69% нь мэдээллээ тус платформуос авдаг. Харин мэдээллийн хамгийн их итгэдэг эх сурвалжийн нэгдүгээрт телевиз жагсаж иргэдийн 52% нь телевизийн мэдээллийг хамгийн найдвартай гэж үздэг байна.

Зураг 5. Монголчуудын мэдээлэл авдаг эх сурвалж



Монголчуудын үе хоорондын ангиллаар авч үзвэл нийгмийн сүлжээ ашиглах хувь болон нийт зарцуулж буй цагийн үзүүлэлтүүд ялгаатай байна. Мөн иргэдийн хамгийн түгээмэл ашигладаг Facebook, Instagram, YouTube платформуудад өдөрт зарцуулдаг хувь болон дундаж хугацааг харьцуулан үзүүлэв. Үеийн бүлгүүдийн дундаас Generation Z буюу 2000–2010 онд төрөгсөд хамгийн их цагийг социал медиа хэрэглээнд зарцуулж байна.

²¹ <https://datareportal.com/reports/digital-2024-october-global-statshot>

²² (Иргэдийн интернэтийн хэрэглээний талаарх суурь судалгааны тайлан, 2021)

²³ MMCG- Монголчуудын медиа хэрэглээ, амьдралын хэв маягийн судалгаа 2025

Зураг 6. Сошиал медиа хэрэглээ

	GENERATION Z 2000-2010	MILLENNIALS 1999-1983	GENERATION X 1982-1968	BOOMERS 1968-ас өмнө
Сошиал хэрэглээ %	100%	99%	94%	75%
Нийт сошиал зарцуулсан буй цаг	5 цаг:01 мин	3 цаг:50 мин	2 цаг:29 мин	2 цаг:04 мин
Өдөр бүр ФБ ордог %	81%	94%	96%	94%
ФБ-д зарцуулсан цаг	1 цаг:46 мин	2 цаг:15 мин	1 цаг:46 мин	1 цаг:31 мин
Өдөр бүр IG ордог %	82%	46%	9%	6%
IG-д зарцуулсан цаг	1 цаг:57 мин	41 мин	4 мин	-
Өдөр бүр Youtube ордог %	59%	42%	22%	15%
Youtube-д зарцуулсан цаг	1 цаг:11 мин	42 мин	12 мин	11 мин

5. Иргэдийн цахим хандлага

5.1 Интернэтийн зохистой хэрэглээний талаарх ойлголт, мэдлэг, хандлага

Иргэдийн мэдээллийн технологийн аюулгүй байдлын талаарх мэдлэг нийтдээ харьцангуй сайн байна. Судалгаагаар 10 хүн тутмын 9 нь онлайнаар төрөл бүрийн сонжоо, таавар, “азаа үзэх” төрлийн үйлдэл аюултай гэдгийг мэддэг бөгөөд 10 хүн тутмын 7 нь Фейсбүүк профайл хуурамч байх боломжтойг мэддэг. Мөн 10 хүн тутмын 6 нь сошиал хаяг болон банкны нууц үг ижил байж болохгүй гэдгийг ойлгодог байна.

Аюулгүй байдлаа хамгаалах илүү нарийн техникийн тохиргооны мэдлэг залуучуудын дунд харьцангуй сайн байгаа бол 45-аас дээш насныхан энэ талаар хангалттай мэдлэггүй бөгөөд хувийн нууцлалыг хамгаалах анхан шатны тохиргоо болох Public/Private тохиргооны ялгааг 10 хүн тутмын 6 нь мэдэхгүй байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм.

18–64 насны иргэдийн 43.1% нь Монгол Улсад +18 сайт болон зохиогчийн эрхийн зөрчилтэй вэбсайтыг хаадаг зохицуулалт үйлчилж байгааг мэддэг байна. Үүнийг хүйсийн хувьд авч үзвэл, эрэгтэйчүүдийн 47.1%, эмэгтэйчүүдийн 39.2% нь уг зохицуулалтын талаар мэдлэгтэй байна. Мөн орон сууцанд амьдардаг болон дээд боловсролтой иргэдийн хоёр хүн тутмын нэг нь энэ талаар мэдэж байна.

Насны бүлгээр авч үзвэл, нас ахих тусам интернэт орчин дахь зохицуулалтын /цахим орчны аюулгүй байдал, ёс зүй, мэдээллийн хамгаалалт, хувийн нууц, зохиогчийн эрх зэрэг асуудлыг хуулиар хянах /талаарх мэдлэг буурах хандлагатай. Тухайлбал, 55–64 насны иргэдийн 4 хүн тутмын 3 нь энэ талаар мэдэхгүй байна.

Нийтдээ 10 хүн тутмын 6 нь хувийн мэдээллээ хамгаалах анхан шатны тохиргоог мэддэггүй бөгөөд ялангуяа 45–54 насныхны 84.6%, 55–64 насныхны 86.9% нь сошиал орчинд (жишээлбэл, Facebook, Instagram) пост оруулахдаа Public/Private тохиргооны ялгааг мэдэхгүй байгаа нь мэдээллийн

аюулгүй байдлын мэдлэгийн түвшин нас ахих тусам буурч буйг харуулж байна. (Иргэдийн интернэтийн хэрэглээний талаарх суурь судалгааны тайлан, 2021)

5.2 Иргэдийн болон төрийн албан хаагчдын цахим хэрэглээ, үр чадвар

Монгол Улсын бичиг үсэг тайлагдалтын түвшин ойролцоогоор 98% байгаа нь өндөр үзүүлэлт боловч хүн амын дунд цахим үр чадвар харилцан адилгүй түвшинд байдаг.

Монгол Улсын өрхийн мэдээлэл, харилцаа холбооны технологийн тоног төхөөрөмжийн байдал, харилцаа холбооны технологийн үйлчилгээний хэрэглээ”-ний 2021 онд хийсэн түүвэр судалгаагаар иргэдийн цахим үр чадвар 43.8 хувьтай гэж гарчээ.

Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн хурдасгуур лабораториос болон Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн 2023 онд хийсэн хамтарсан судалгааны үр дүнгээс харахад, Монгол Улсад цахим үр чадварын түвшинд жендерийн зөрүүтэй байдал ажиглагдаж байгаа бөгөөд эмэгтэйчүүдийн цахим үр чадварын түвшин дээгүүр үзүүлэлттэй гарсан байдаг. Цахим үр чадварын гол чиглэлүүдэд эмэгтэйчүүдийн дундаж оноо эрэгтэйчүүдээс 10.9%- иар өндөр гарсан бөгөөд харилцаа холбоо, мэдээллийн шинжилгээ, контент бүтээх, кибер аюулгүй байдлын чиглэлүүдэд эмэгтэйчүүд 4-9%-иар илүү гүйцэтгэл үзүүлжээ. Энэхүү жендерийн давуу байдал нь хиймэл оюуны салбарт жендерийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн идэвхтэй оролцоог дэмжих боломж байгааг харуулж байна.

6. Монгол улсын цахим бэлэн байдлын үнэлгээ

6.1 Цахим бэлэн байдлын үнэлгээ - Digital Readiness Index

“Digital Readiness Assessment” буюу “Дижитал бэлэн байдлын үнэлгээ”-г Cisco компанийн боловсруулан олон улсын “Digital Readiness Index”-г тодорхойлсон байна. World Economic Forum, ITU, World Bank зэрэг байгууллагуудын мэдээлэлд тулгуурладаг байна.

Дижитал бэлэн байдлын үнэлгээний зорилго нь Монгол Улсын дижитал шилжилтэд шаардлагатай суурь орчин, бодлого, хүний болон технологийн хүчин зүйлсийн бэлэн байдлыг тодорхойлох зорилготой. Үнэлгээ нь олон улсын “Digital Readiness Index” аргачлалд тулгуурлан 20 шалгуур үзүүлэлтээр 1–10 хүртэл оноогоор хэмжигдсэн болно (1 нь сул, 10 нь сайн).

Үзүүлэлтүүд нь дараах дөрвөн үндсэн багцад хуваагдана:

А. Холболт ба дэд бүтэц

- Гар утасны холболт (Mobile connectivity)

- Суурин шугамын хамрах хүрээ (Fixed line coverage)
- Эрчим хүчний хүртээмж (Energy coverage)
- Интернетийн хэрэглээ (Internet usage)
- Өгөгдлийн үнийн боломж (Data affordability)
- Төхөөрөмжийн хүртээмж, үнийн боломж (Quality connection)

Б. Хүний нөөц ба ур чадвар

- Дунд боловсролын эзэмших түвшин (Secondary schooling attainment)
- Ур чадвартай ажиллах хүч (Skilled labour)
- Дижитал бичиг үсэгтэй байдал (Digital literacy)
- Хөдөлмөрийн зах зээлийн үр ашиг (Labour market efficiency)
- Нийгмийн оролцоо, авьяастай хүмүүсийг хадгалах чадвар (Social inclusion/Retention capacity)
- Ажил эрхлэлтийн хүйсийн ялгаа (Gender gap at work)
- Дээд боловсролын байгууллагууд (Higher education institutions)

В. Инноваци ба технологийн экосистем

- Шинэ технологийг дэмжих төрийн бодлого (Government support on new technology)
- Дэвшилтэт технологийн нэвтрэлт (High-tech penetration)
- Патент, барааны тэмдэг бүртгэх боломж (Feasibility of patent and trademark registration)
- Мэдээлэл, харилцаа холбооны зах зээлийн өрсөлдөөн (ICT market competition)
- Стартап санхүүжилт (Start-up financing)

Г. Эдийн засаг, бодлогын орчин


- Татварын дарамт (Tax burden)

Доорх диаграммд Монгол Улсын цахим бэлэн байдлын түвшинг 1-10 хүртэл оноогоор харуулсан бөгөөд Гар утасны холболт (Mobile connectivity), дунд боловсролын эзэмших түвшин (Secondary schooling attainment) зэрэг үзүүлэлтүүд өндөр буюу 10 оноо авсан бол нийгмийн оролцоо, авьяастай хүмүүсийг хадгалах чадвар (Social inclusion/Retention capacity) болон шинэ технологийг дэмжих төрийн бодлого (Government support on new technology) зэрэг үзүүлэлтүүд хамгийн бага буюу 1 оноо үнэлгээтэй байна.

Монгол Улс дижитал холболт, боловсрол, хүний хөгжлийн зарим үзүүлэлтээр сайн түвшинд хүрсэн ч инновацийн экосистем, стартап санхүүжилт болон хөдөлмөрийн зах зээлийн үр ашиг, жендэрийн тэнцвэр зэрэг чиглэлд дэмжлэг шаардлагатай байна.

Цаашдын бодлогод цахим ур чадварыг гүнзгийрүүлэх, төр хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, инновацийн экосистемийн санхүүжилтийн суурийг бий болгох нь чухал.

Зураг 7. Дижитал бэлэн байдлыг үнэлгээ ²⁴




6.2 Сүлжээний бэлэн байдлын индекс - The Network Readiness Index

The Network Readiness Index 2024 онд Portulans Institute санаачлан, Oxford, UK болон Washington DC, USA-аас хамтран гаргасан ²⁵.

Сүлжээний Бэлэн Байдлын Индекс (NRI) нь дэлхий даяарх эдийн засагт мэдээлэл харилцаа холбооны технологи (МХТ)-ийн хэрэглээ болон нөлөөллийг үнэлдэг тэргүүлэх олон улсын үзүүлэлтүүдийн нэг юм. 2024 оны хамгийн сүүлийн хувилбарт NRI тайлан нь 133 улсын сүлжээнд суурилсан бэлэн байдлын өнөөгийн түвшинг дөрвөн тулгуур чиглэлээр Технологи, Хүмүүс, Засаглал, Нөлөөлөл хэмжиж, харьцуулсан байна. Эдгээр тулгуур чиглэл тус бүр нь гурван дэд бүлгээс бүрддэг бөгөөд нийтдээ 54 хувьсагчаар үнэлэгдсэн болно. (Зураг 8)


Зураг 8. Сүлжээний бэлэн байдлын индекс – 2024 загвар



²⁴ <https://www.cisco.com/>

²⁵ The Network Readiness Index (NRI) 2024

Зураг 9. Монгол Улсын дэд үзүүлэлтийн дэлхийн зэрэглэл – нийт болон тулгуур



Дэд үзүүлэлтийн түвшний үзүүлэлт

Дэд үзүүлэлтүүдийн ангиллаар авч үзвэл Монгол Улс хувь хүн, оролцоо, итгэлцэл зэрэг хүн төвтэй чиглэлүүдэд харьцангуй сайн үзүүлэлттэй байна. Харин тогтвортой хөгжлийн зорилтуудын хувь нэмэр, бизнесийн орчин, эдийн засгийн тогтолцоо зэрэг бүтцийн болон үр нөлөөний үзүүлэлтүүдэд сайжруулат шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 3. Монгол Улсын сүлжээний бэлэн байдлын индексийн дэд үзүүлэлтээрх зэрэглэл

Дэд үзүүлэлт	Байр	Дэд үзүүлэлт	Байр
Хувь хүн (Individuals)	52	Ирээдүйн технологи (Future Technologies)	95
Оролцоо (Inclusion)	54	Зохицуулалт (Regulation)	96
Итгэлцэл (Trust)	61	Контент (Content)	100
Хандалт (Access)	73	Тогтвортой хөгжлийн зорилтуудын хувь нэмэр (SDG Contribution)	100
Засгийн газар (Governments)	93	Бизнес (Businesses)	109
Амьдралын чанар (Quality of Life)	93	Эдийн засаг (Economy)	120

Сүлжээний бэлэн байдлын индексийн оноо ба орлогын түвшин

Доорх зурагт Монгол Улсын сүлжээний бэлэн байдлын индексийн түвшин болон нэг хүнд ногдох ДНБ (худалдан авах чадварын тэнцвэр)-ийн хоорондын хамаарлыг дүрсэлсэн болно. Зурагт тусгагдсан трендийн шугам нь тухайн улсын орлогын түвшнээс хамааран хүлээгдэх сүлжээний бэлэн байдлын индексийн түвшинг илэрхийлдэг. Монгол Улсын үзүүлэлт энэ хүлээлтээс доогуур байрлаж буй нь орлогын түвшинтэйгээ харьцуулахад сүлжээний бэлэн байдлын түвшин бүрэн ашиглагдаагүй, боломжит чадавх гүйцэд илрээгүй байгааг илэрхийлж байна. Иймээс орлогын түвшиндээ

нийцүүлэн сүлжээний бэлэн байдлын индексийн үнэлгээг сайжруулах бодлогын орон зай болон хөгжүүлж болох нөөц боломж байгааг харуулж байна.

Зураг 10. Монгол Улсын дэлхийн зэрэглэл – нийт болон тулгуур үзүүлэлтээр



Монгол Улсын үзүүлэлтүүдийг орлогын түвшний бүлэг болон бүс нутгийн дундажтай харьцуулсан байдал Монгол Улсын сүлжээний бэлэн байдлын индексийн дэд багцуудыг дээд дунд орлоготой орнууд болон Ази, Номхон далайн бүсийн дундажтай харьцуулахад улсын дижитал хөгжлийн түвшинд нийтлэг зөрүүтэй харагдаж байна. Нийт сүлжээний бэлэн байдлын индексийн хувьд Монгол хоёр харьцуулалтын дундажаас доогуур үнэлгээтэй байгаа нь технологийн дэд бүтэц, хүний нөөцийн дижитал ур чадвар болон дижитал үйлчилгээний хүртээмж хангалтгүй байгааг илтгэнэ. Технологи болон Хүмүүс гэсэн хоёр үндсэн багцууд хамгийн сул үнэлгээтэй байгаа нь дижитал шилжилтийн гол саад болж байна. Интернэтийн чанар, мэдээллийн технологийн дэд бүтцийн хөгжил, иргэдийн дижитал ур чадварт нэмэлт хөрөнгө оруулалт хийх шаардлагатай байна. Нөгөө талаас, Засаглалын үнэлгээ бүс нутгийн дундажтай ойролцоо, дээд дунд орлоготой орнуудын дундажаас дээгүүр гарсан нь төрийн цахим засаглал, бодлого зохицуулалтын орчин тогтвортой байгааг нотолж байна.

Харин дижитал хөгжлийн эерэг нөлөөллийг хэмждэг "Impact" үзүүлэлт дундажаас доогуур байгаа нь сайн засаглалын бүтэц байгаа ч технологи болон хүний нөөцийн суурь сул учраас бодит эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр өгөөж хангалтгүй байгааг харуулдаг.

Нийтэд нь авч үзвэл, Монгол Улс дижитал засаглалын чиглэлээр харьцангуй сайн ахицтай хэдий ч технологийн хөрөнгө оруулалт болон хүн амын дижитал чадамжийг сайжруулахгүй бол бүс нутгийн өрсөлдөх чадвараас улам холдох эрсдэлтэй байна. Иймд дижитал хөгжлийн бодлого нь дэд бүтэц, хүний нөөц, инновацид чиглэсэн цогц арга хэмжээ шаардаж байна.

Хүснэгт 4. Монголын үзүүлэлтүүдийг орлогын түвшний бүлэг болон бүс нутгийн дундажтай харьцуулсан байдал

Хэмжээс	Монгол	Дээд-дунд орлоготой орнууд/дундаж	Ази ба Номхон далайн бүс/дундаж
Сүлжээний бэлэн байдлын индекс	43.88	47.52	54.25
Технологи	35.81	39.51	49.31
Хүн ам / Хүмүүс	35.78	41.65	48.55
Засаглал	59.69	56.74	60.88
Нөлөөлөл (Impact)	44.25	52.19	58.26

Хамгийн өндөр болон доор үзүүлэлтүүд

Судалгааны үзүүлэлтүүдээс харахад Монгол Улс цахим дэд бүтэц болон хүртээмжийн гол хэмжүүрүүдээр харьцангуй өндөр гүйцэтгэлтэй байна. Тухайлбал, хүн амын 3G сүлжээгээр хамрагдалтын түвшин, цахим төлбөрийн хүртээмж зэрэг үзүүлэлтүүд нь бүс нутаг болон олон улсын жишигтэй харьцуулахад өндөр байна. Насанд хүрэгчдийн бичиг үсэг тайлагдалт өндөр байгаа нь цахим шилжилтийн суурь хүний нөөц хангалттай бүрдэж буйг илтгэнэ.

Нөгөө талд, инноваци, технологийн нутагшуулалт, кибер аюулгүй байдал, гар утасны төхөөрөмжийн үнэ, засгийн газар болон дээд боловсролын судалгаа хөгжлийн зардал зэрэг үзүүлэлтүүд харьцангуй доогуур байгаа. Эдгээр сул талууд нь цахим экосистемийн үр ашигтай өсөлтийг хязгаарлаж, зах зээлийн өрсөлдөх чадвар болон технологийн шилжилтийн хурд саарахад нөлөөлж байдаг. Мөн боловсролын салбар дахь мэдээллийн болон харилцаа холбооны технологийн (МХХТ) ур чадвар, дотоодын зах зээлийн хэмжээ зэрэг хүчин зүйлсийн доогуур үзүүлэлт нь дижитал эдийн засгийн өргөжилтийн чадавхийг хязгаарлаж байна.

Ингэснээр Монгол Улс цахим холболт болон хүртээмжийн суурь нөхцөлөөр хүчтэй байр суурь эзэлж байгаа боловч инновацийн систем, өндөр ур чадвартай хүний нөөц, технологийн шингээлт болон өрсөлдөх чадварын индикаторуудад бодит ахиц шаардлагатай байна.

Хүснэгт 5. Монгол Улсын давуу болон сайжруулах шаардлагатай үзүүлэлтүүд

Хамгийн хүчтэй үзүүлэлтүүд		Хамгийн сул үзүүлэлтүүд	
Үзүүлэлт	Эрэмбэ	Үзүүлэлт	Эрэмбэ
3G хөдөлгөөнт сүлжээгээр хүн амын хамрагдалт	1	Мэдээлэл, харилцаа холбооны патентын мэдүүлэг	79
Цахим төлбөрийн хэрэглээ нийгэм эдийн засгийн ялгаа	6	Цахим худалдааны хууль тогтоомж	87
Насанд хүрэгчдийн бичиг үсэг тайлах түвшин	18	Шинэ технологи нутагшуулах түвшин	95
Онлайн дансанд хандах боломж	20	Засгийн газар, дээд боловсролын судалгаа, хөгжүүлэлтийн зардал	99
Орлогын тэгш бус байдал	27	Боловсролын салбар дахь мэдээлэл технологийн ур чадвар	101
Цахим төлбөрийн хэрэглээний хөдөөний ялгаа	32	Дотоод зах зээлийн хэмжээ	110
Эмэгтэйчүүдийн эдийн засгийн боломж	41	Гар утасны төхөөрөмжийн үнэ	111
Интернет худалдаа	44	Кибер аюулгүй байдал	111
Гар утасны сүлжээ үйлчилгээний төлбөр	47	Амьдралын сонголт хийх эрх чөлөө	111
Виртуал нийгмийн сүлжээг ашиглах	47	Хямд өртөгтэй, цэвэр эрчим хүч	114

Дүгнэлт:

Монгол Улс сүүлийн арван жилд цахим шилжилтийн үндэс суурийг бүрдүүлэх чиглэлээр бодлогын томоохон алхмуудыг хийсэн бөгөөд төрийн цахим үйлчилгээний хүртээмж, харилцаа холбооны салбарын дэд бүтцийн өргөтгөл, хууль эрх зүйн шинэчлэлээрээ бүс нутагт анхаарал татахуйц түвшинд хүрээд байна. “e-Mongolia” платформ, Үндэсний дата төв, Тоон гарын үсэг, Төрийн байгууллагын мэдээлэл солилцооны нэгдсэн систем зэрэг дижитал экосистемийн гол элементүүд нь төрийн үйлчилгээг хялбар, ил тод, хүртээмжтэй болгох нөхцөлийг бүрдүүлжээ. Энэ нь цахим засаглалын хөгжлөөр Монгол Улсыг Төв Азийн зарим улсаас буюу Казахстан, Кыргызстан зэрэг улсуудын адил хурдтай ахиж буй орнуудын нэг болгож байна.

Харилцаа холбооны салбарын хөгжлийн түүхийг харахад Монгол Улс 1990-ээд оноос эхлэн үүрэн холбоо, интернэт технологийг богино хугацаанд нэвтрүүлж, 2024 оны байдлаар үүрэн холбооны хэрэглэгч 4.9 саяд хүрч, хүн амын 83.9 хувь интернэтэд холбогдон, 52,480 км шилэн кабелийн сүлжээ байгуулагдсан нь бүс нутгийн дундаж үзүүлэлттэй харьцуулахад дэвшилттэй тоон үзүүлэлт байна. Ялангуяа шилэн кабелийн сум бүрт хүрсэн байдал нь Казахстан, Кыргызстан, Тажикистан зэрэг улсаас илүү өргөн хүрээг хамарч байгаа нь давуу тал болж байна.

Гэвч цахим шилжилтийн үйл явцад тулгарч буй өргөн хүрээний бэрхшээлүүд нь хөгжлийн ирээдүйн хурдыг хязгаарлах эрсдэл хэвээр байсаар. Нийт өрхийн суурин өргөн зурвасын интернетийн нэвтрэлт улсын дунджаар 23.06 хувьтай байгаа нь Олон улсын холбооны байгууллага (ITU)-ын хөгжиж буй орнуудын дунджаас доогуур үзүүлэлт бөгөөд хот хөдөөгийн цахим тэгш бус байдал гүнзгий хэвээр байгааг харуулж байна. Хөдөө орон нутагт үүрэн холбооны өндөр өртөгтэй интернэт ашиглах шаардлага нэмэгдсэн нь иргэдийн санхүүгийн боломжид дарамт болж буйг анхаарах шаардлагатай.

Мөн Дэлхийн эдийн засгийн форумаас гаргадаг NRI (Network Readiness Index) зэрэг олон улсын үнэлгээнүүдэд Монгол Улс цахимы үйлчилгээтэй холбоотой

үзүүлэлтээр боломжийн амжилттай байгаа ч цахим ур чадвар, инновацийн экосистем, кибер аюулгүй байдал зэрэг хэмжүүрээр бүс нутгийн дундажаас доогуур байна. Энэ нь технологи нэвтрүүлэх хурдаа бодит ашиглалтад шилжүүлэх, өргөн хэрэглээ болгох тал дээр системийн бэрхшээл байгааг илтгэнэ.

Гол асуудлуудын олон улсын харьцуулалттай анализ

1. Дэд бүтцийн хүртээмжийн тэгш бус байдал

- Хот хөдөөгийн цахим ялгаа хамгийн өндөр түвшинд байгаа ч хөдөө орон нутгийн суурин өрхийн интернет 23.06% холболттой байна.
- Монгол Улсад 190 гаруй баг үүрэн сүлжээнд холбогдоогүй байгаа нь цахим үйлчилгээг бүх нийтийн түвшинд тэгш хүргэх боломжийг хязгаарлаж байна.

2. Цахим ур чадварын дутмаг байдал

- Иргэдийн цахим ур чадвар 43.8% байгаа нь Зүүн Европын орнуудын дундажаас доогуур байна.
- Ахмад, орлого багатай иргэдийн дунд цахим үйлчилгээний хэрэглээ бага байгаа нь бусад хөгжиж буй орнуудтай харьцуулахад тэгш хүртээмжийн бодлого хангалтгүй байгааг харуулдаг.

3. Мэдээллийн аюулгүй байдал, хууль эрх зүйн уялдаа

- Кибер аюулгүй байдлын бэлэн байдлын индексээр Монгол Улс бүсийн орнуудаас дунд түвшинд үнэлэгддэг ба хууль, стандартын шинэчлэл удаан байна.
- Эстони, Сингапур зэрэг цахим засаглал өндөр хөгжилтэй улсууд хууль эрх зүйн орчныг байнга шинэчилж шууд хэрэглээтэй байлгадаг бол Монгол Улсад бодлогын уялдаа сул олон байгууллагын үйл ажиллагаа давхцдаг.

4. Инноваци ба хувийн хэвшлийн оролцоо

- Монгол Улсын стартап экосистем хөгжлийн эхэн шатандаа, хөрөнгө оруулалтын хэмжээ бүсийн дундажаас доогуур Казахстантай харьцуулахад 5–7 дахин бага.
- Технологийн бизнесийн экспортыг дэмжих бодлогын механизм бүрэн бүрдээгүй, инновацийн санхүүжилт тогтворгүй байна.



Ө.БАЯСГАЛАН

ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ
ШИНЭЧЛЭЛИЙН ХӨТӨЛБӨР

Төслийн менежер

ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ТАТАХ ТҮЛХҮҮР ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ТАТАХ ТҮЛХҮҮР ҮЗҮҮЛЭЛТҮҮД


1. Гүйцэтгэлийн үнэлгээний түлхүүр үзүүлэлт /KPI/-ийн ерөнхий ойлголт

Судалгааны ажлын тойм

Энэхүү судалгаа нь гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах чиглэлийн мэргэшсэн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг “FDI Center” байгууллагаас боловсруулсан тайланд үндэслэсэн. Тухайн тайлан нь эрдэм шинжилгээний ажлууд, олон улсын байгууллагуудын тайлангийн сан болон дэлхийн 51 орны хөрөнгө оруулалтыг дэмжих агентлагийн гүйцэтгэлийн тайлан, статистик мэдээлэл, хөрөнгө оруулалтын үнэлгээний мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагад тулгуурлан гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах түлхүүр үзүүлэлтүүдийг тодорхойлон гаргасан¹.

Сүүлийн арван жилд гадаадын шууд хөрөнгө оруулалтын үүрэг, үр өгөөжийг хэмжих хандлага ихээхэн өөрчлөгдөж байна (Зураг 1).

Зураг 1. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын нөлөөг хэмжих үзүүлэлтийн өөрчлөлт




Олон улсын хөрөнгө оруулалтыг дэмжих агентлагууд “тооноос илүү чанарт” гэсэн зарчмыг баримтлан ажиллаж байгаа ч “чанартай” хөрөнгө оруулалтыг тодорхойлох нь амаргүй. Учир нь чанарын талаарх тодорхойлолт нь ихэнхдээ субъектив бөгөөд чанарыг хэмжих үзүүлэлтүүд нь тодорхой бус, хэмжихэд хүндрэлтэй байдаг. Иймээс чанартай хөрөнгө оруулалтыг тодорхойлж, татах үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд шалгуур үзүүлэлтүүдийг тогтоож, тухайн үзүүлэлтүүдэд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцоог хэрэгжүүлэх нь зайлшгүй шаардлагатай.

Оновчтой бүтэцтэй хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцоо нь илүү нарийвчилсан судалгаа хийх боломжийг бүрдүүлдэг ба хөрөнгө оруулалт хийсэн компаниудын үр нөлөө, үр ашгийг тодорхойлоход тусалдаг.

Мөн хөрөнгө оруулалт татах асуудал хариуцсан агентлагийн ямар үйлчилгээ хөрөнгө оруулалтын шийдвэрт нөлөөлж байгааг тогтоож, амжилттай ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ (Зураг 2).

Зураг 2. Гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт (KPI)-ын хэрэглээ



ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын Хөрөнгө оруулалтыг дэмжих агентлагуудын 66% нь өмнөх жилийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд үндэслэн өөрсдийн тэргүүлэх чиглэлээ тодорхойлдог байна.

Дэлхийн улс орнууд хөрөнгө оруулагчдыг татахын тулд идэвхтэй өрсөлдөж байна. Орчин үед бодлого тодорхойлогчид үйл ажиллагааны оновчтой стратеги баримтлахын тулд тоон мэдээлэлд (KPI) суурилан шийдвэр гаргах нь давамгайлж байна.

Олон улс оронд төсвийн алдагдал нэмэгдэж, хүүгийн түвшин өсч байгаа нь төрийн зардал буурах магадлалыг илтгэж байна. Дэлхий нийтээр тодорхойгүй байдал нэмэгдэж эдийн засгийн хүндрэлтэй нөхцөлтэй тулгарч буй энэ үед гадаадын шууд хөрөнгө оруулалт нь төрийн санхүүжилтийг тогтвортой байлгахад чухал нөлөөтэй.

Дээрх нөхцөл байдлын улмаар хөрөнгө оруулалтыг дэмжих чиг үүрэг бүхий байгууллагууд олон улсын жишигт нийцсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог нэвтрүүлэх нь зайлшгүй чухал юм.

¹ Эх сурвалж. <https://fdi-center.com/wp-content/uploads/2022/08/FDI-Center-Measuring-Impact-Key-Performance-Indicators-in-FDI-Attraction.pdf>

2. Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах түлхүүр үзүүлэлтүүд

Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах түлхүүр үзүүлэлтийг дөрвөн бүлгээр ангилан, нарийвчлан задалж судалсан бөгөөд үзүүлэлт (indicator) бүрийн олон улсын хэмжээнд гүйцэтгэлийн үнэлгээнд ашиглагдсан хувийг тодруулан гаргасан. Гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтийг дараах дөрвөн ангилалд хуваасан. Үүнд:

- Эдийн засгийн шууд нөлөөг хэмжих үзүүлэлтүүд
- Эдийн засгийн шууд бус нөлөөг хэмжих үзүүлэлтүүд
- Хөрөнгө оруулалтын тогтвортой байдлыг хэмжих үзүүлэлтүүд
- Хөрөнгө оруулалт татах үйл ажиллагааг хэмжих үзүүлэлтүүд

Цаашид дээрх ангилал бүрээр нарийвчлан судалгааг хийж үзүүлэлт бүрийг тодорхойлох боломжит задаргаа, түүний хэрэглээ, юуг илэрхийлэх болон юуг сайжруулж болох саналыг боловсруулав.

1. Эдийн засгийн шууд нөлөөг хэмжих үзүүлэлтүүд

Хөрөнгө оруулалтыг дэмжих, ажлын байр бий болгох, эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулах нь Хөрөнгө оруулалтыг дэмжих агентлагийн гол үүрэг бөгөөд

хамгийн их тайлагнагддаг түлхүүр үзүүлэлтүүд /KPI/ юм. Авч үзсэн нийт тайлангуудын 63% нь хөрөнгө оруулалтын хэмжээг, 57% нь шинэ ажлын байрны тоо, 53% нь хөрөнгө оруулалтын тоог тайлагнасан байна (Зураг 3).

Зураг 3. Эдийн засгийн шууд нөлөөг хэмжих үзүүлэлтүүдийн ашиглагдах байдал



Дээрх эдийн засгийн шууд нөлөөг хэмжих үзүүлэлтүүдийг тус бүрт нь нарийвчилж, боломжит үзүүлэлтийн задаргааг боловсруулж, үр дүнгийн тоон мэдээллийг ашиглах зааврыг хавсаргав:

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	ТАЙЛБАР	БОЛОМЖИТ ҮЗҮҮЛЭЛТИЙН ЗАДАРГАА	ХЭРЭГЛЭЭ / ЮУГ ИЛЭРХИЙЛЭХ ВЭ?
Хөрөнгө оруулалтын хэмжээ	Хөрөнгө оруулалтын хэмжээ мөнгөн дүнгээр	- Төслөөр - Жилээр - Улирлаар	- Эдийн засгийн үр нөлөө - Хөрөнгө оруулагчийн итгэл - Салбарын өсөлт - Хөрөнгө оруулалтын өгөөж/боломж
Ажлын байр	Тодорхой хугацаанд эсвэл тодорхой төслийн үр дүнд үүсэх тооцоологдсон / бодитоор бий болсон ажлын байрны тоо.	- Шинэ ажлын байрны тоо - Шинэ ажлын байр бүтээх зардал = Нийт ХО-ын зардал/ Нийт бүтээсэн ажлын байрны тоо - Гадаад, дотоод ажиллах хүчний харьцаа - Ажлын байранд шаардагдах үр чадвар - Сургалт, хөгжилд оруулж буй хөрөнгө оруулалт	- Гадаадын хөрөнгө оруулалт тухайн улсын хөдөлмөрийн зах зээлд ямар нөлөө үзүүлж буй - Хөрөнгө оруулалт нийгэмд хэр хүртээмжтэй байгаа - Ажиллах хүчний үр чадварыг хэрхэн нэмэгдүүлж байгаа
Хөрөнгө оруулалт орж ирсэн төслийн тоо	Хэрэгжсэн / зарлагдсан хөрөнгө оруулалт орж ирсэн төслийн тоо. Үүнд орж ирсэн эсвэл татагдсан хөрөнгө оруулагчдын тоог багтаана.	- Салбараар - Хөрөнгө оруулагчдын төрөл /дотоод, гадаад/ - Бүс нутгаар - Хугацаагаар	- Хөрөнгө оруулагчдын идэвхийн түвшин - Хөрөнгө оруулагчид зах зээлийг сонирхож буй эсэх - Бодлогын үр нөлөөг үнэлэх - Өсөлтийн чиг хандлагыг тодорхойлох
Салбарын хөрөнгө оруулалт	Хөрөнгө оруулалт салбараар	- Хөрөнгө оруулалтын хэмжээ салбараар - Салбар тус бүрийн ГШХО-ын төслийн тоо - Нийт ГШХО-д тухайн салбарын ХО-ын эзлэх хувь - Нэг төсөл, болон нэг ажилтанд ноогдох хөрөнгө оруулалт - Салбар бүрт оролцож буй дотоодын нийлүүлэгч, түншүүдийн тоо - Салбаруудын технологи дамжуулах боломжийг харуулсан чанарын үнэлгээ	- Стратегийн төлөвлөлт, дэд бүтэц, хүний нөөцийн сургалт - Салбарын хөгжлийн зорилтуудын хяналт шинжилгээ, үнэлгээ - Хөгжөөгүй боловч боломж ихтэй салбаруудыг тодорхойлох - Стратегийн салбаруудад хөрөнгө оруулалт татаж байгаа эсэх - Хөрөнгө оруулалтын агентлагийн зорилтот үр дүнг хэмжих - Эдийн засгийн төрөлжилт, салбарын төвлөрлийг харуулах - Тэргүүлэх салбаруудад хөрөнгө оруулалт орж байгаа эсэх бодлогын шинэчлэл, дэмжлэг хэрэгтэй эсэх - Зах зээлд нэвтрэх саад, өрсөлдөх чадварыг харуулах
Дахин хөрөнгө оруулах /Өргөтгөх	Дахин хөрөнгө оруулах / хөрөнгө оруулалтаа өргөтгөсөн тоо	- Дахин хөрөнгө оруулалт хийсэн төслийн тоо - Дахин хөрөнгө оруулсан нийт хөрөнгийн хэмжээ - Дахин хөрөнгө оруулалтын үр дүнд үйлдвэрлэлийн хүчин чадал, үйлчилгээний хамрах хүрээ нэмэгдсэн эсэх - Нийт хөрөнгө оруулагчдын хэдэн хувь дахин хөрөнгө оруулалт хийж байгаа	- Дахин хөрөнгө оруулалт хийх боломжтой компаниудыг тодорхойлж, тэдэнд чиглэсэн дэмжих стратеги боловсруулах - ГХО-ын орчны тогтвортой байдал, урт хугацааны нөлөөллийг хянах - Өргөжиж буй компаниудыг дэмжих, хүний нөөцийн хөгжлийг чиглүүлэх - Хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр, урамшуулал, үйлчилгээг сайжруулах
Бүс нутгийн хөрөнгө оруулалт	Бүс нутгийн хөрөнгө оруулалтын хуваарилалт	- Бүс нутгийн ХО-ын урсгал, нийт дүн - Бүс нутгийн ГШХО орж ирсэн төслийн тоо - Бүс нутгийн ГШХО татсан салбарын ангилал - Бүс нутгийн дэд бүтцийн бэлэн байдлын үнэлгээ	- Бүс нутгийн урамшуулал, эдийн засгийн тусгай бүс, дэд бүтцийн төслүүдийг төлөвлөх - Хөрөнгө оруулалт багатай бүсүүдийг тодорхойлж, тухайн бүсүүд рүү чиглэсэн сурталчилгаа хийх - Бүс нутгийн хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийг хянах, үнэлэх - Тэнцвэртэй хөгжил, нөөцийн оновчтой хуваарилалтыг дэмжих
Хөрөнгө оруулалт/ Улсаар	Хөрөнгө оруулалтын хэмжээ, төслийн тоог улсаар нь авч үзэх	- Хөрөнгө оруулалт/ улсаар - Herfindahl-Hirschman Index - Эх үүсвэрийн төвлөрлийн индекс - Топ 5 эх үүсвэрийн эзлэх хувь - Цаг хугацааны явцад эх үүсвэрийн бүтцийн өөрчлөлт	- Хөрөнгө оруулалт авах боломжтой бүс нутгаас хөрөнгө оруулалт татах стратеги боловсруулах - Геополитик, эдийн засгийн эрсдэлд өртөх магадлалыг тодорхойлох - ГШХО-ын эх үүсвэрийн төрөлжилтийн ахицыг хянах

2. Эдийн засгийн шууд бус нөлөөг хэмжих үзүүлэлтүүд

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг шууд болон шууд бус нөлөөллөөр дамжуулан үнэлэх боломжтой (Зураг 4). Гадаадын хөрөнгө оруулалтай компаниуд болон дотоодын компаниудын хоорондын холбоо, хамтын ажиллагаа нь бүтээмж, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлдэг. Иймээс гадаадын компаниуд болон дотоодын нийлүүлэгчдийн оролцоотой нийлүүлэлтийн сүлжээг хөгжүүлэх нь оновчтой алхам болно.

Эдийн засгийн шууд бус нөлөөг хэмжих үзүүлэлтүүдийг тус бүрт нь нарийвчилж, боломжит үзүүлэлтийн задаргааг боловсруулж, үр дүнгийн тоон мэдээллийг ашиглах зааврыг хавсаргав.

Зураг 4. Эдийн засгийн шууд бус нөлөөг хэмжих үзүүлэлтүүдийн ашиглагдах байдал



ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	ТАЙЛБАР	БОЛОМЖИТ ҮЗҮҮЛЭЛТИЙН ЗАДАРГАА	ХЭРЭГЛЭЭ / ЮУГ ИЛЭРХИЙЛЭХ ВЭ?
Экспорт	ГХО-тай / хөрөнгө оруулалт хийх сонирхолтой компаниудын экспортолсон бүтээгдэхүүн	- ХО-тай ААН-үүдийн нийт экспортын хэмжээ - Нийт экспортыг ГХО-тай ААН-үүдийн экспортой харьцуулсан хувь - Экспортын өсөлт /тодорхой хугацаагаар/ - Экспорт хийсэн зах зээлийн тоо - Экспортын төрөлжилтийн индекс - ГХО ААН-үүдийн өндөр үнэ цэнэтэй эсвэл өндөр технологийн экспортын эзлэх хувь - ГШХО-той холбоотой дотоодын компаниудын экспортын өсөлт - ГШХО нөлөөлсөн ЖДҮ-ийн экспортын өсөлт	- ГШХО нь худалдааны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж байгаа эсэх - Экспортын өндөр боломжтой салбаруудыг тодорхойлох - Экспортыг дэмжих, хөрөнгө оруулалт татах бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх
Санал тавьсан хамтын ажиллагаа	ГХО-тай / хөрөнгө оруулалт хийх сонирхолтой компаниудын дотоодын компаниудтай хамтран ажиллах санал хүргүүлсэн тоо	- ГХОААН-ээс дотоодын ААН-д хамтран ажиллах санал хүргүүлсэн тоо - Дотоод компаниудыг хөгжүүлэх хөтөлбөрийн тоо - Хамтран ажиллах гэрээ, санамж бичиг байгуулсан тоо - Салбарын арга хэмжээг зохион байгуулсан, ивээн тэтгэсэн тоо - Дотоодын компанид технологи хуваалцсан, лиценз олгосон тоо - Дотоодын компаниудын албан хаагчид зориулсан сургалтын тоо	- Засгийн газраас орон нутгийн хөгжилд ГШХО-ыг хэрхэн дэмжиж болох - Хамтын ажиллагаанд илүү нээлттэй салбар компаниудыг тодорхойлох - Бүс нутаг, салбаруудын хооронд харьцуулалт хийж, шилдэг туршлагыг тодорхойлох
Хамтын ажиллагаа	ГХО-тай / хөрөнгө оруулалт хийх сонирхолтой компаниудын дотоодын компаниудтай хамтран ажиллаж буй тоо	- ГХО-тай ААН-тэй гэрээ байгуулсан дотоодын ханган нийлүүлэгчдийн тоо - ГХО-тай ААН-тэй хамтран ажилладаг дотоодын ААН-ын орлогын өсөлт - Гадаад компани болон дотоод нийлүүлэгчийн хамтын ажиллагааны дундаж хугацаа - Гадаад, дотоодын хамтарсан үйлдвэр түншлэлийн тоо - Дотоодын ААН-ийн ажилтнуудын өсөлт - ОУ-ын нийлүүлэлтийн сүлжээнд нэгдсэн дотоодын ААН	- ГХО нь дотоодын ААН-үүдийн санхүүгийн чадавх, өсөлтөд нөлөө үзүүлж буй эсэх - Дотоодын ААН-үүд олон улсын зах зээлд нэвтэрч, өрсөлдөх чадвар нэмэгдэж буй эсэх - Технологи, ноу-хау, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаа хэр идэвхтэй байгааг харуулах
Дотоодоос хийх худалдан авалт	ГХО-тай / хөрөнгө оруулалт хийх сонирхолтой компаниудын дотоодын бүтээгдэхүүн үйлчилгээний зардал	- ГХО-тай ААН-ийн нийт үйл ажиллагааны зардлын хэдэн хувь дотоодод зарцуулагдсан - Дотоодын ханган нийлүүлэгчдэд олгогдсон гэрээний нийт үнэ - ГШХО-ын дотоодын судалгаа, хөгжүүлэлтэд зарцуулсан хөрөнгө - ГШХО-тай холбогдсон дотоодын бизнесүүдийн орлогын өсөлт	- Орон нутгийн эдийн засгийн өсөлтийг үнэлэх - ЖДҮ -ийн хөгжлийг дэмжих - Орон нутгийн нөөцийг төлөвлөх, бэлтгэх - Дотоодын нөөц ашиглахад урамшууллын бодлого хэрэгжүүлэх - Хүртээмжтэй хөрөнгө оруулалтын стратегийг хэрэгжүүлэх
Шууд бус ажлын байр	ГХО-тай компаниудын зардлаар дотоодын бүтээгдэхүүн, үйлчилгээгээр үүсгэсэн ажлын байр	- ГШХО-ын ААН-тэй хамтран ажилладаг дотоодын ханган нийлүүлэгч компаниудад бий болсон ажлын байрны тоо - ГШХО-ын ААН-ийн худалдан авалттай холбоотой ЖДҮ-ийн ажил эрхлэлтийн өсөлт - ГШХО орсноор үйлчилгээний салбарт (тээвэр, зочид буудал, жижиглэн худалдаа) бий болсон ажлын байрны тоо - ГШХО-той холбоотой дэд бүтэц эсвэл ТХХТ-ийн төслүүдээр бий болсон ажлын байр - Туслан гүйцэтгэгч компаниудын ажилчдын мэргэжлийн сургалтад хамрагдсан тоо - ГШХО орж ирсэн бүс нутагт орон нутгийн иргэдийн ажил эрхлэлтийн түвшний өөрчлөлт	- Эдийн засгийн үр нөлөөг илүү өргөн хүрээнд тодорхойлох - Үр нөлөөгөөр нь салбаруудыг эрэмбэлэх - Орон нутгийн нөөц, ажлын байр бий болгохыг дэмжих - ХО-ыг дотоодын ЖДҮ-тэй түншлэхийг дэмжих - Ханган нийлүүлэлтийн сүлжээ, үйлчилгээ, орон нутгийн хөгжлийг сайжруулах
Татвар	Гадаадын эзэмшлийн компаниудын төлсөн татвар / хөрөнгө оруулалт хийх сонирхолтой компаниудын төлсөн татвар	- ГШХО-тай ААН-үүдийн төлсөн ААНОАТ, НӨАТ, Гаалийн татвар, бусад татварууд - Татварын орлогод оруулж буй хувь - ГХО холбоотой татварын маргаан, шийдвэрийн тоо - Гадаадын болон дотоодын ААН-үүдийн дундаж татварын хувь - ХО-ын хэмжээ /1 сая USD тутамд/ ногдох татварын хэмжээ	- ГШХО санхүүгийн хувьд ашигтай болон тогтвортой эсэх - Татварын урамшууллын бодлого оновчтой эсэх - Ил тод байдлыг хангах - Чанартай, үр нөлөөтэй хөрөнгө оруулалтад чиглэсэн татварын тогтолцоог боловсронгуй болгох

3. Тогтвортой байдлыг хэмжих үзүүлэлтүүд

Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлж эхэлснээр бодлого боловсруулагчид болон хөрөнгө оруулалтыг дэмжих агентлагууд стратегидаа тогтвортой байдлын ойлголтуудыг тусгаж эхэлсэн. Хамгийн ихээр тайлагнадаг үзүүлэлтүүд нь дижитал шилжилтийн хөрөнгө оруулалт, болон инноваци, цэвэр эрчим хүчтэй холбоотой үзүүлэлтүүд байна (Зураг 5).

Тогтвортой байдлыг хэмжих үзүүлэлтүүдийг тус бүрт нь нарийвчилж, боломжит үзүүлэлтийн задаргааг боловсруулж, үр дүнгийн тоон мэдээллийг ашиглах зааврыг хавсаргав:

Зураг 5. Тогтвортой байдлыг хэмжих үзүүлэлтүүдийн ашиглагдах байдал



ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	ТАЙЛБАР	БОЛОМЖИТ ҮЗҮҮЛЭЛТИЙН ЗАДАРГАА	ХЭРЭГЛЭЭ / ЮУГ ИЛЭРХИЙЛЭХ ВЭ?
Дижитал шилжилтийн хөрөнгө оруулалт	Мэдээлэл, харилцаа холбооны технологийн (МХХТ) салбар, гарааны бизнесүүдэд чиглэсэн хөрөнгө оруулалт	- Дижитал салбарын ГШХО-ын хэмжээ - ГШХО-тай холбоотой дижитал төслүүдийн тоо - ГШХО-аар сайжруулсан дижитал дэд бүтэц - Дижитал салбарт ГШХО-аар нэмэгдсэн ажлын байрны тоо - ГХО-лагчид дотоодын технологийн гарааны бизнесүүдтэй хамтран ажилласан тоо - Кибер аюулгүй байдал, хамгаалалтын системд чиглэсэн хөрөнгө оруулалт	- Мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарыг дэмжих бодлого боловсруулах - Хүний нөөцийн төлөвлөлт, үр чадварын сургалт, мэргэжилтэн бэлтгэх стратегийг тодорхойлох - Дижитал салбарт чиглэсэн сурталчилгаа, түншлэл хөгжүүлэх - Дижитал эдийн засгийн хөгжлийн явцыг хянах, олон улсын жишигтэй харьцуулах
Хөрөнгө оруулалтын реформ	Хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах аливаа шинэчлэлд оруулсан хувь нэмэр	- Хөрөнгө оруулалтын бодлогын шинэчлэл хийсэн тоо - Хөрөнгө оруулалтын орчны үнэлгээ сайжирсан байдал /OECD-ийн FDI Qualities Indicators/ - Захиргааны зардал буурсан байдал - Хөрөнгө оруулагчдын гомдол шийдвэрлэсэн тоо - Хөрөнгө оруулагчдыг хууль бус үйлдлээс хамгаалах арга хэмжээ - Тэргүүлэх салбаруудад хийсэн шинэчлэлийн тоо - Бодлогын дэмжлэгийн талаар хөрөнгө оруулагчдаас авсан санал хүсэлтийн тоо	- Бодлогын шинэчлэл үр дүнтэй байгаа эсэхийг үнэлэх - Засгийн газар үр нөлөөнд тулгуурлан тэргүүлэх шинэчлэлийг тогтоох - Олон улсын хөрөнгө оруулалтын орчинд өрсөлдөх чадвартай байх - Хөрөнгө оруулагчдад итгэлцэл, нэр хүндийг бий болгох - Тоон мэдээлэлд суурилсан хяналтын самбар, нөлөөллийн тайлан гаргах
Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж	Хөрөнгө оруулагчийн сэтгэл ханамжийн оноо	- Хөрөнгө оруулагчдын сэтгэл ханамжийн оноо - Үйлчилгээ, шат дамжлага бүрт өгөх оноо (Газар сонгох, зохицуулалтын зөвлөгөө, зөвшөөрөл лиценз олгох, ХО-ын дараах үйлчилгээ) - Хөрөнгө оруулагчид хариу өгөх дундаж хугацаа - Шийдвэрлэсэн гомдлын хувь - Агентлагийн зүгээс хөрөнгө оруулагчтай харилцах давтамж, чанар - Дижитал платформ, санал хүсэлт авах механизмын ашиглалт	- ITA -гийн үйлчилгээний чанарыг олон улсын түвшинд харьцуулах боломж олгох - Хөрөнгө оруулагчдыг дэмжих системийн давуу, сул талыг тодорхойлох - Нөөцийг өндөр үр нөлөөтэй үйлчилгээ рүү чиглүүлэх - Хөрөнгө оруулагчдыг хадгалах, өргөжүүлэх, урт хугацааны харилцаа тогтоох - Зохицуулалтын саад, захиргааны хүндрэлүүдийг тогтоох, арилгах
Сургалт хөгжилд оруулсан хөрөнгө оруулалт	Гадаадын эзэмшлийн /хөрөнгө оруулалт хийх сонирхолтой компаниудын сургалт хөгжилд зориулсан хөрөнгө оруулалтын хэмжээ болон сургалтын тоо	- ГХО-тай компаниудын хэрэгжүүлсэн сургалтын тоо - Сургалтын төрөл: Техникийн, удирдлагын, дижитал, хууль эрх зүйн гм - Сургалтад оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ - Сургалтад хамрагдсан ажилтнуудын тоо - Боловсролын байгууллагуудтай хамтарсан сургалт, дэдлагажуулах хөтөлбөр - Орон нутгийн ажилтнуудад чиглэсэн сургалтын хувь	- ГХО ажиллах хүчний үр чадварыг хэрхэн сайжруулж байгааг харуулах - Ажил эрхлэлтийн чанар, бүтээмжийг дэмжих - Сургалтын хөрөнгө оруулалтыг бүс нутгаар тэгш хуваарилах - Сургалт, хөгжилд анхаардаг ХО-лагчдыг урамшуулах - Орон нутаг, олон нийтэд эерэг хандлагыг бүрдүүлэх
Судалгаа & Хөгжүүлэлт	Гадаадын эзэмшлийн /хөрөнгө оруулалт хийх сонирхолтой компаниудын судалгаа хөгжүүлэлтийн зардал	- ГХО ААН-үүдийн судалгаа шинжилгээний нийт зардал - R&D зардал / нийт орлого*100% - R&D төв болон лабораторитой ААН-үүдийн тоо - ГХО ААН-үүдийн мэдүүлсэн патентын тоо - ГХО ААН-үүдийн шинэ бүтээгдэхүүн, технологийн тоо - Орон нутгийн Их дээд сургууль, судалгааны хүрээлэнтэй хамтран хэрэгжүүлсэн R&D төслүүд - Ахисан түвшний R&D ажилтны хувь	- ГШХО нь инноваци болон өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж байгаа эсэх - Өндөр технологи, мэдлэг шаардсан хөрөнгө оруулалтыг татах бодлогыг боловсруулах - Үр чадварыг хөгжүүлэх, технологийн тархалтаар дамжуулан хүртээмжтэй хөгжлийг дэмжих
Ногоон хөрөнгө оруулалт	"Ногоон" тодорхойлолтод багтах салбаруудад оруулсан хөрөнгө оруулалт	- Ногоон салбарт оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ - Ногоон салбарын хөрөнгө оруулалтын төслийн тоо - Хүлэмжийн хийн буурсан хувь - Сэргээгдэх эрчим хүчний суурилуулсан хүчин чадал (Мвт) - Байгаль орчны гэрчилгээ, ногоон стандартуудыг хангасан төслүүдийн тоо - Шинээр бий болсон ногоон ажлын байрны тоо	- Бодлого боловсруулах: Ногоон хөрөнгө оруулалтыг дэмжих урамшуулал, татаас, татварын хөнгөлөлт боловсруулахад ашиглах - Уур амьсгалын стратегийг нийцүүлэх - Ногоон хөрөнгө оруулалтад чиглэсэн сурталчилгааны салбаруудыг тодорхойлох - Тогтвортой байдлын тайлангийн олон улсын жишигт нийцэх

4. Үйл ажиллагааг хэмжих үзүүлэлтүүд

Энэ ангилалд хөрөнгө оруулалтыг татахад гүйцэтгэсэн үйлчилгээ, үйл ажиллагаатай холбоотой бүх KPI-ууд багтдаг. Хөрөнгө оруулалтыг дэмжих агентлагуудын хувьд үйл ажиллагаанд суурилсан хяналт, үнэлгээний тогтолцоог илүү анхаарч хэрэгжүүлдэг ч өндөр үйл ажиллагааны оноо нь амжилттай гүйцэтгэлийг илтгэдэггүй. Тиймээс үйл ажиллагааны тайланг бодит үр дүнгийн үзүүлэлтүүдээр (өмнөх 3 ангиллын) баяжуулж үр нөлөөг хэмжиж болно (Зураг 6).

Үйл ажиллагааг хэмжих үзүүлэлтүүдийг тус бүрт нь нарийвчилж, боломжит үзүүлэлтийн задаргааг боловсруулж, үр дүнгийн тоон мэдээллийг ашиглах зааврыг хавсаргав:

Зураг 6. Үйл ажиллагааг хэмжих үзүүлэлтүүдийн боломжит нарийвчилсан задаргаа



ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	ТАЙЛБАР	БОЛОМЖИТ ҮЗҮҮЛЭЛТИЙН ЗАДАРГАА	ХЭРЭГЛЭЭ / ЮУГ ИЛЭРХИЙЛЭХ ВЭ?
Үйл ажиллагаа	Хөрөнгө оруулагч талаас ирсэн Лавлагаа, уулзалт, айлчлалын тоо, хариу өгөх хугацаа, хийсэн судалгаа г.м.	- Хөрөнгө оруулагчдаас ирсэн нийт асуулт, хүсэлтийн тоо - Хөрөнгө оруулагчидтай хийсэн уулзалтын тоо - Хөрөнгө оруулагчдад зориулсан талбайн үзлэг зохион байгуулсан тоо - ХО-чдын асуултад хариу өгөх дундаж хугацаа - Асуултаас талбайн үзлэгт шилжсэн хувь - Уулзалтаас хөрөнгө оруулалтын шийдвэр, төслийн саналд хүрсэн хувь - ИТА-ийн үйлчилгээний Net promoter score	- Хөрөнгө оруулагчидтай харилцах харилцааг хэр сайн зохион байгуулж байгааг хянах - CRM систем, дижитал хэрэгслүүдэд хөрөнгө оруулах үндэслэл гаргах - Хариуцлага, ил тод байдлыг нэмэгдүүлэх - Идэвхтэй outreach, чиглүүлэх стратегийг боловсруулах
Арга хэмжээ	Монгол Улсын талаас зохион байгуулсан арга хэмжээ, оролцогчдын тоо Байж болох арга хэмжээ: Хөрөнгө оруулалтын форум, хийсэн айлчлал, Roadshow, Салбарын үзэсгэлэн, B2B уулзалт, Хөрөнгө оруулагчдын дугуй ширээний уулзалт, Вэбинар, цахим хурал,	- Зохион байгуулсан, эсвэл оролцсон арга хэмжээний тоо - Арга хэмжээнд оролцсон хөрөнгө оруулагчдын тоо (улсаар, салбар төрлөөр) - Хөрөнгө оруулагчдын хандлагын тайлан /Investor attitude report/ - Арга хэмжээний дараа нэмэгдсэн ХО-ын санал авсан төслийн тоо - Эхний харилцаанаас хөрөнгө оруулалтын шийдвэр хүртэлх хугацаа - Арга хэмжээнд оролцогчдоос авсан санал хүсэлтийн үнэлгээ	- Аль төрлийн арга хэмжээ илүү үр дүнтэй байгааг тодорхойлох - Дараагийн арга хэмжээг зөв төлөвлөх, нөөцийг зөв хуваарилах - Өмнөх жилүүдийн арга хэмжээтэй харьцуулах - Хөрөнгө оруулагчдын сонирхол, хандлагыг тодорхойлох - ИТА-ын сурталчилгааны үр дүнг харуулах, санхүүжилтийг шийдвэрлэх - Хөрөнгө оруулагчдад ээлтэй, идэвхтэй үлс гэдгээ харуулах
Маркетинг	Нийтлэл, хэвлэлийн мэдээ, ярилцлага, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй харилцах тоо.	- Сурталчилгааны кампанит ажилд оролцсон хөрөнгө оруулагчдын тоо - Хөрөнгө оруулалт хийх сонирхлоо илэрхийлсэн хөрөнгө оруулагчдын тоо - Зорилтот зах зээлд хийсэн кампанит ажлын тоо - Зохион байгуулсан арга хэмжээний тоо - Баталгаажсан хөрөнгө оруулалтын хэмжээ - Улсын нэр хүнд, танигдах байдал нэмэгдсэн эсэх - Олон улсын хэвлэлд дурдагдсан байдал	-Маркетингийн үйл ажиллагааг зорилтот салбар, бүс нутагтай уялдуулах - Төсөв хуваарилалт, кампанит ажлын тэргүүлэх чиглэлийг тодорхойлох - Аль маркетингийн суваг, мессеж илүү үр дүнтэй байгааг тодорхойлох - Хөрөнгө оруулагчдын сонирхлыг нэмэгдүүлэх
Зардал	Нийт зардал эсвэл нэг ажлын байр бий болгоход ногдох зардал.	- Нийт хөрөнгийн зардал Capital expenditure - Үйл ажиллагааны зардал Operating expenditure - Зардлын ангилал (хөдөлмөр, дэд бүтэц, технологи г.м) - Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх зардал - Нийт хөрөнгө оруулалт / Ажлын байрны тоо -Нэг ажлын байр бий болгоход салбараар, бүс нутгаар гаргах - Жил бүрийн ажлын байрны зардлын өөрчлөлт	- Ажлын байрны зардал-үр өгөөжийн харьцаа оновчтой салбаруудад чиглэсэн урамшуулал боловсруулах - ГШХО эдийн засгийн үнэ цэнийг хөрөнгө оруулалтын өгөөжөөр үнэлэх - ГШХО-ын үр ашиг, нөлөөллийг цаг хугацааны интервалаар харах - Тэргүүлэх чиглэл, дэд бүтцийн стратегийг төлөвлөх
Цахим хуудасны хандалт	Цахим хуудасны хандалттай холбоотой хэмжүүрүүд	- Цахим хуудаст хандсан хандалтын тоо (сар, улирал, жил) - Дахин хандсан хандалтын тоо - Зорилтот зах зээлээс хандах хувь - Цахим хуудас дээр зарцуулсан дундаж хугацаа - Холбоо барих хүсэлт бөглөсөн, асуулт илгээсэн хувь - Хөрөнгө оруулалтын гарын авлага, танилцуулга татаж авсан тоо - Төлбөртэй, органик хандалтын чанарын харьцуулалт - Bounce rate /Зочин нэг хуудас үзээд гарах хувь/	- Аль зах зээлээс хөрөнгө оруулалт хийх сонирхолтой байгааг тодорхойлох - Дижитал кампанит ажил үр дүнтэй эсэхийг хэмжих - Вэбсайтын агуулгын хөгжүүлэлтийг сайжруулах, алдааг засах - Мессеж, сурталчилгааны ажлыг илүү нарийвчлан чиглүүлэх

3. Монгол улсын дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн, хөрөнгө оруулалт, худалдаа хариуцсан ажилтнуудын гадаадын хөрөнгө оруулалтыг татах үйл ажиллагааны гүйцэтгэлийн үнэлгээ (kpi)-ний загвар

Ангилал	"Үнэлгээнд эзлэх хувь"	"Үнэлгээнд эзлэх хувь"	Шалгуур үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт	Суурь / одоогийн/ түвшин	Зорилтот түвшин	Гүйцэт гэл	Гүйцэт гэл /хувь/	Тайлбар
Харилцаа тогтоох, хадгалах	10%	5%	Идэвхитэй харилцаатай хөрөнгө оруулагчид	тоо					Стратегийн түвшний, чухал ач холбогдолтой 5 хөрөнгө оруулагчтай тогтвортой харилцааг хадгалж, идэвхитэй хамтран ажиллаж байна.
		5%	ЭСЯ-ы шугамаар танилцсан шинэ хөрөнгө оруулагчид	тоо					 онд нийт 8 шинэ хөрөнгө оруулагчид элчин сайдын яамны шугамаар танилцуулга хийж, стратегийн хамтын ажиллагааны суурийг тавьсан.
Хөрөнгө оруулалтын сурталчилгаа	25%	5%	Хөрөнгө оруулалтын арга хэмжээнд оролцож, илтгэл тавих	тоо					Зохион байгуулагдсан 5 хөрөнгө оруулалтын арга хэмжээнд оролцож МУ-ын хөрөнгө оруулалтын орчин, хөрөнгө оруулалт хийх боломжтой салбар, төслүүдийн талаар илтгэл тавьсан.
		10%	Зохион байгуулсан/дэмжиж ажилласан хөрөнгө оруулалтын арга хэмжээ	тоо					 онд нийт 7 хөрөнгө оруулалтыг дэмжих арга хэмжээг зохион байгуулж, дэмжиж ажилласан.
		5%	Хөрөнгө оруулагчтай уулзалт, танилцуулга хийх	тоо					 онд нийт 15 хөрөнгө оруулагчтай уулзалт хийж, хамтын ажиллагааны боломжуудыг танилцуулсан.
		3%	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэлсэн мэдээ, цахим хуудасны мэдээ	тоо					 онд нийт 25 удаагийн мэдээлэл түгээсэн бөгөөд үүнд 10 пост, 8 хэвлэлийн мэдээ, 7 видео контент бэлтгэсэн.
		2%	Тараасан сурталчилгааны материал	тоо					 онд нийт 120 сурталчилгааны материал тараасан.
		5%	Хөрөнгө оруулагчдын асуулга, лавлагааг хүлээн авч шийдвэрлэх	тоо					 онд нийт 40 хөрөнгө оруулагчийн асуулгад хариу өгч, шаардлагатай мэдээлэл, дэмжлэгийг үзүүлсэн.
Хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах	20%	3%	Хөрөнгө оруулагчийн хүсэлтэд хариу өгөхөд зарцуулсан хугацаа	өдөр					Хөрөнгө оруулагчийн хүсэлтэд хариу өгөх дундаж хугацаа 4 ажлын өдөр байна.
		5%	ХОХГ, болон холбогдох төрийн байгууллагатай боломжит хөрөнгө оруулагчдыг холбосон тоо	тоо					 онд нийт 18 боломжит хөрөнгө оруулагчийг дотоодын оролцогч талууд болон ХОХГ-тай холбосон.
		2%	ХОХГ, болон холбогдох төрийн байгууллагад танилцуулсан/холбосон хөрөнгө оруулагчидтай хамтран ажилласан хувь	хувь					 онд нийт 60 хөрөнгө оруулагчийг ХОХГ-тай холбосноос 45-д нь талууд хариу үзүүлж, хамтран ажилласан. Энэ нь 75% болно.
		5%	Хөрөнгө оруулагчийн сэтгэл ханамжийн үнэлгээ / судалгаа, санал хүсэлт/	оноо/ хувь					"..... онд хөрөнгө оруулагчийн сэтгэл ханамжийн дундаж оноо 4.6/5 байсан. /эсвэл/ Судалгаанд оролцсон хөрөнгө оруулагчдын 88% нь үйлчилгээний чанарт сэтгэл хангалуун байсан."
Зах зээлийн мэдээлэл боловсруулж, тайлагнах	10%	3%	Тухайн улсын зах зээл, салбарын чиг хандлагын талаар бэлтгэсэн тайлан, товч мэдээлэл	тоо					 онд нийторны 4 зах зээлийн тайлан, 8 салбарын товч мэдээлэл боловсруулж ХОХГ, ЭЗХЯ-д хүргүүлсэн.
		2%	Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчны талаарх мэдээллийг шинэчилсэн давтамж	тоо					 онд хөрөнгө оруулалтын орчны талаарх мэдээллийг хагас жил тутам шинэчилж, 2 танилцуулга бэлтгэсэн.
		2%	Монгол Улстай өрсөлдөгч орнуудын хөрөнгө оруулалтын нөхцөлтэй харьцуулсан судалгаа, тайлан	тоо					 онд нийт 3 өрсөлдөгч оронтой харьцуулсан хөрөнгө оруулалтын орчны тайлан боловсруулж, ГХЯ-д танилцуулсан.
		3%	Дотоодын хөрөнгө оруулагчидтай хуваалцсан стратеги, мэдээллийн тоо	тоо					 онд тухайн улсын нийт 5 стратегийн дүгнэлт, зах зээлийн чиг хандлагын талаарх мэдээллийг дотоодын хөрөнгө оруулагчидтай хуваалцсан.
Хамтын ажиллагаа	5%	2%	ЭЗХЯ, ХОХГ болон бусад холбогдох байгууллагын хүсэлтэд ажлын 5 өдрийн дотор хариу өгсөн хувь	хувь					 оны 1-р улиралд нийт 20 хүсэлт хүлээн авснаас 14-д нь 5 ажлын өдрийн дотор хариу өгсөн. Хариу өгсөн хувь: 70%.
		3%	Дотоодын төрийн байгууллагууд, оролцогч талуудтай хийсэн цахим уулзалт, хурлын тоо	тоо					 онд ГХЯ, ЭЗХЯ болон ХОХГ-тай нийт 45 удаагийн цахим уулзалт, хурлыг хийж, мэдээлэл солилцон хамтран ажилласан.
Цахим хандалт/ Вэбсайтын статистик	5%	2%	Вэбсайтын нийт хандалтын тоо	тоо					 оны 1-р улиралд вэб сайтын нийт хандалт 350 удаа бүртгэгдсэн.
		2%	Хөрөнгө оруулалтын гарын авлага татах, асуулга илгээсэн хандалтын хувь	хувь					 оны 1-р улиралд нийт 350 хандалт бүртгэгдсэнээс 42 нь хөрөнгө оруулалтын гарын авлага татаж авсан буюу 12%
		1%	Хөрөнгө оруулагчийн асуулт, бүртгэл, холбоо барих хүсэлтийн нийт тоо	тоо					 онд нийт 50 хөрөнгө оруулагчийн асуулга, 10 мэдээллийн бүртгэл, 8 холбоо барих хүсэлт хүлээн авсан.
Стратегийн үр нөлөө	5%	2%	Хөрөнгө оруулалт хариуцсан байгууллагатай холбосон хөрөнгө оруулагчаас бодит хөрөнгө оруулалт хийсэн хувь	хувь					 онд ЭСЯ-аас МУ-д хөрөнгө оруулах сонирхолтой 14 хөрөнгө оруулагчийг холбож, түүнээс 5 нь бодит хөрөнгө оруулалтын төслийг эхлүүлсэн. Биелэлтийн хувь: 36%
		1%	Тэргүүлэх салбарын хөрөнгө оруулагчдад үзүүлсэн дэмжлэг	тоо					 онд сэргээгдэх эрчим хүчний төсөлд 4 хөрөнгө оруулалтад дэмжлэг үзүүлсэн.
		2%	Хөрөнгө оруулагчдад тулгарсан асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлсэн тоо	тоо					 онд 4 хөрөнгө оруулагчдад виз болон оршин суух зөвшөөрөлтэй холбоотой асуудал тулгарсныг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж ажилласан.
Дотоодын оролцогч талуудад дэмжлэг үзүүлэх	20%	15%	Монголоос очих Бизнесийн групп, яам, эдийн засгийн зочдыг хөрөнгө оруулагчтай уулзуулсан тоо	тоо					 онд МУ-аас 15 Бизнесийн групп, яам, эдийн засгийн зочдыг хүлээн авч хөрөнгө оруулагч нартай уулзуулсан.
		5%	Монгол компаниудад санхүүжилт олоход нь туслас	тоо					 онд 4 Монгол компанид санхүүжилт ороход нь тусласан.
Нийт	100%	100%	Тухайн жилийн гүйцэтгэлийн үнэлгээний хувь						Санал зөвлөмж:


4. Гүйцэтгэлийг тайлагнах

Гүйцэтгэлийн үнэлгээний түлхүүр үзүүлэлтийг сонгох зарчим

Үзүүлэлтүүдийг сонгохдоо хөрөнгө оруулалтыг дэмжих агентлагийн хүрэхийг хүсч буй зорилгод нийцүүлэн сонгоно. Байгууллагын зорилт бүр дор хаяж нэг үзүүлэлттэй уягдсан байх ёстой бөгөөд энэ нь ихэвчлэн тоон үзүүлэлт тул тодорхой байдлыг хангадаг. Олон улсад дараах шалгуураар гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтийг сонгохыг зөвлөдөг (Зураг 7).

Хөрөнгө оруулалт татах чиг үүрэг бүхий байгууллагууд дараах түлхүүр үзүүлэлтүүдээр гүйцэтгэлээ хэмжих, сайжруулах боломжтой.

Зураг 7. Гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтийг сонгох шалгуурууд



ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	ТАЙЛБАР	ОРОЛЦОГЧ ТАЛУУД		
		Яам	Агентлаг	ДТГ
Хөрөнгө оруулалтын хэмжээ	Хөрөнгө оруулалтын хэмжээ мөнгөн дүнгээр	✓	✓	
Хөрөнгө оруулалт/ Улсаар	Шинэ хөрөнгө оруулалт татсан улс	✓	✓	✓
Салбарын хөрөнгө оруулалт	Салбар бүрээр татсан хөрөнгө оруулалт	✓	✓	
Дахин хөрөнгө оруулах/ төслийг өргөтгөх	Хөрөнгө оруулагчид дахин оруулах, эсвэл төслөө өргөтгөн хөрөнгө оруулсан тоо	✓	✓	
Бүс нутгийн хөрөнгө оруулалт	Хөрөнгө оруулалтын бүс нутгийн хуваарилалт	✓	✓	
Хөрөнгө оруулалт орж ирсэн төслийн тоо	Хэрэгжсэн/ зарлагдсан хөрөнгө оруулалтын төслийн тоо	✓	✓	✓
Ажлын байр	Тодорхой хугацаанд эсвэл тодорхой төслийн үр дүнд үүсэн тооцологдсон/ бодитоор бий болсон ажлын байрны тоо	✓		
Цалин, хөлс	Гадаадын эзэмшлийн/ хөрөнгө оруулалт хийх сонирхолтой компаниудын цалингийн хэмжээ	✓	✓	✓
Татвар	Гадаадын эзэмшлийн/ хөрөнгө оруулалт хийх сонирхолтой компаниудын төлсөн татвар	✓		
Санал тавьсан хамтын ажиллагаа	Гадаадын эзэмшлийн / хөрөнгө оруулалт хийх сонирхолтой компаниудын дотоодын компаниудтай хамтран ажиллах санал хүргүүлсэн тоо	✓	✓	
Шууд бус ажлын байр	ХХО-тай компаниудын зардлаар дотоодын бүтээгдэхүүн, үйлчилгээгээр үүсгэсэн ажлын байр	✓		
Экспорт	Гадаадын эзэмшлийн / хөрөнгө оруулалт хийх сонирхолтой компаниудын экспортолсон бүтээгдэхүүн	✓	✓	
Хамтын ажиллагаа	Гадаадын эзэмшлийн / хөрөнгө оруулалт хийх сонирхолтой компаниудын дотоодын компаниудтай хамтран ажиллаж буй тоо	✓	✓	
Дотоодоос хийсэн худалдан авалт	Гадаадын эзэмшлийн / хөрөнгө оруулалт хийх сонирхолтой компаниудын дотоодын бүтээгдэхүүн үйлчилгээний зардал	✓	✓	
Сургалт хөгжилд оруулсан хөрөнгө оруулалт	Гадаадын эзэмшлийн / хөрөнгө оруулалт хийх сонирхолтой компаниудын сургалт хөгжилд зориулсан хөрөнгө оруулалтын хэмжээ болон сургалтын тоо	✓	✓	✓
Судалгаа & Хөгжүүлэлт	Гадаадын эзэмшлийн / хөрөнгө оруулалт хийх сонирхолтой компаниудын судалгаа хөгжүүлэлтийн зардал	✓	✓	
Ногоон хөрөнгө оруулалт	"Ногоон" тодорхойлолтод багтах салбаруудад оруулсан хөрөнгө оруулалт	✓	✓	
Дижитал шилжилтийн хөрөнгө оруулалт	Мэдээлэл, харилцаа холбооны технологийн (МХХТ) салбар, гарааны бизнесүүдэд чиглэсэн хөрөнгө оруулалт	✓	✓	
Хөрөнгө оруулалтын реформ	Хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах аливаа шинэчлэлд оруулсан хувь нэмэр.	✓	✓	
Цахим хуудасны хандалт	Цахим хуудасны хандалттай холбоотой хэмжүүрүүд	✓	✓	✓
Маркетинг	Нийтлэл, хэвлэлийн мэдээ, ярилцлага, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй харилцах тоо.	✓	✓	✓
Арга хэмжээ	Зохион байгуулсан арга хэмжээ, оролцогчдын тоо Байж болох арга хэмжээ: Хөрөнгө оруулалтын форум, хийсэн айлчлал, Roadshow, Салбарын үзэсгэлэн, B2B уулзалт, Хөрөнгө оруулагчдын дугуй ширээний уулзалт, Вэбинар, цахим хурал,	✓	✓	✓
Зардал	Хөрөнгө оруулалтын нийт зардал эсвэл нэг ажлын байр бий болгоход ногдох зардал.	✓	✓	
Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж	Хөрөнгө оруулагчийн сэтгэл ханамжийн оноо	✓	✓	✓
Үйл ажиллагаа	Ирсэн лавлагаа, уулзалт, айлчлалын тоо, хариу өгөх хугацаа, хийсэн судалгаа г.м.	✓	✓	✓

Үнэлгээ өгөх өгөгдөл /дата/ цуглуулах аргууд

Мэдээлэл, датаны хүртээмж муу байх нь гүйцэтгэлийн үнэлгээний түлхүүр үзүүлэлтийн дагуу төлөвлөж, хэрэгжүүлэхэд тулгамдах хамгийн том асуудал юм. Иймээс хяналт-шинжилгээ, үнэлгээнд шаардлагатай мэдээллийг олж авахад дараах аргуудыг хэрэглэж болно (Зураг 8).

Зураг 8. Өгөгдөл цуглуулах аргууд



а. Судалгаа хийх аргыг ашигласан жишээ

Ирланд Улсын Хөрөнгө оруулалтыг дэмжих агентлаг нь тогтвортой хөгжлийн зорилтуудад оруулсан хувь нэмрээ өргөн хүрээнд нарийвчилсан мэдээллээр тайлагнадаг. Үүнд:

1. Ажлын байрны тоо, ажил эрхлэлтийн төрөл, эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт
2. Компаниудын зардлын дэлгэрэнгүй мэдээлэл, үүнд цалин хөлс болон дотоодоос авсан бараа материалын зардал
3. Хамтран ажилласан дотоодын компаниудын борлуулалт, экспорт, нэмэгдсэн өртөг гэх мэт.

Энэ тайлан нь Ирландын Аж үйлдвэр, худалдаа, хөдөлмөрийн яам болон харьяа агентлагуудын эдийн засагт үзүүлж буй үр нөлөөг хэмжих зорилготой. Тайланг боловсруулахын тулд жил бүр “Ажил эрхлэлтийн судалгаа”, “Эдийн засгийн нөлөөллийн бизнесийн судалгаа”-г дөрвөн сарын турш хийдэг.

Засгийн газрын харьяа байгууллагууд болон түнш агентлагууд судалгааны өмнөх үйл явцыг хянаж, мэдээллийн хэрэгцээг шинэчлэн гаргадаг. Гүйцэтгэгч талаас цахим судалгааг боловсруулж, аж ахуй нэгжүүдийн хамрагдалтад хяналт тавьж, үр дүнг нэгтгэн гаргадаг.

Судалгааны нэр	Хамрагдсан ААН	Хамрагдалтын %
Ажил эрхлэлтийн судалгаа	4,200 компани	65%
Эдийн засгийн нөлөөллийн бизнесийн судалгаа	7,000 компани	70%

Энэхүү судалгааны гүйцэтгэлийн төлбөр жилд ойролцоогоор 170,000 евро болдог ч тайлангийн нарийвчилсан үзүүлэлтүүд, үр дүнгүүд нь Хөрөнгө оруулалтыг дэмжих агентлаг, бусад түнш байгууллагууд болон Ирланд Улсын эдийн засгийн бодлогод хүчтэй эерэг нөлөө үзүүлдэг гэж дүгнэдэг. Аж үйлдвэр, худалдаа, хөдөлмөрийн яамнаас судалгааны мэдээллийг ашиглан их дээд сургуулиуд, судалгааны бусад институттэй хамтран төрийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүдэд /government support program/ үнэлгээний судалгааг хийдэг.

б. Түншлэл байгуулах аргыг ашигласан жишээ

Коста Рикагийн Хөрөнгө оруулалтыг дэмжих агентлаг нь сүүлийн хэдэн жилийн турш хамгийн амжилттай агентлагуудын нэгээр үнэлэгдэж ирсэн. Үйлчилгээний чанараас гадна, үйл ажиллагааны тайлагнал нь маш өндөр түвшинд байдаг. Тайлангийн нарийвчилсан үзүүлэлтүүд нь:

1. Ажил эрхлэлт /салбар, хүйс, насны ангиллаар/
2. Бүх хөрөнгө оруулалтын төслийн нарийвчилсан капитал урсгал гэх мэт

Ирландын Хөрөнгө оруулалтын агентлагаас ялгаатай нь тэд мэдээллээ төрийн байгууллагуудтай хамтран өөрсдөө цуглуулдаг. Тухайлбал:

Мэдээллийн аюулгүй байдлын бодлогыг дагаж мөрдөхийн тулд Хөрөнгө оруулалтыг дэмжих агентлаг зөвхөн нэргүйжүүлсэн мэдээлэл авдаг бөгөөд байгууллага хоорондоо компаниудын нэрийн оронд таних код ашиглаж нууцлалыг хадгалдаг.

Хөрөнгө оруулалтыг дэмжих агентлаг анхлан дээрх байгууллагуудад хамтарсан судалгааны төслүүдийг санал болгож, эцэст нь судалгааны түншлэл байгуулсан байна.

Байгууллагын нэр	Хариуцсан дата мэдээлэл
Нийгмийн даатгалын агентлаг	Хөрөнгө оруулалт хийсэн компаниудын ажилтнуудын нарийвчилсан мэдээлэл
Коста Рикагийн төв банк	ААН-үүдийн гадаадын шууд хөрөнгө оруулалтын орлого, зарлагын мэдээлэл

Коста Рикагийн төв банк болон Хөрөнгө оруулалтыг дэмжих агентлаг хамтран “Хөрөнгө оруулалт хийсэн төслүүд дотоодын ААН-үүдэд хэрхэн нөлөөлж буйг тооцох судалгаа”-г хийсэн. Судалгааны үр дүнгээс харахад:

- Гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд нь дотоодын компаниудтай харьцуулахад хамгийн багадаа 58%-аар илүү түүхий эд, эх үүсвэрийг дотоодоос авдаг.
- Гадаадын хөрөнгө оруулалттай компани 100 шинэ ажлын байр бүтээхэд түүнийг дагаж дотоодын ханган нийлүүлэгч компанид шинэ 41 ажлын байр шууд бусаар үүсдэг гэсэн тооцоолол гарчээ.

Олон Улсын Хөгжлийн банк (IDB)-ны мэдээлснээр Коста Рикагийн хөрөнгө оруулалт татах хөтөлбөрт зарцуулж буй 1\$ бүрийн өгөөж нь 41\$-той тэнцэх ГХШО байна.

Өгөгдөл /дата/-ийн чанарыг хэрхэн баталгаажуулах вэ?

Хөрөнгө оруулагч компаниудаас шууд авсан өгөгдөл, мэдээллийг төсөл хэрэгжихээс өмнө цуглуулдаг тул чанарын асуудал тулгардаг. Ялангуяа төрийн дэмжлэг авахын тулд хөрөнгө оруулалтын хэмжээ, ажлын байрны тоог хэтрүүлэн мэдээлэх хандлагатай байдаг. Иймээс өгөгдлийн чанарыг шалгаж, сайжруулахад дараах аргуудыг ашиглана (Зураг 9).

Зураг 9. Өгөгдлийн чанарыг баталгаажуулах аргууд

1.	Хөрөнгө оруулалт хийсний дараа өгөгдлийг баталгаажуулах
Зарим Хөрөнгө оруулалтыг дэмжих агентлагууд төсөл хэрэгжсэний дараа компаниудтай холбогдож, бодит гүйцэтгэлийн тоон мэдээллийг авдаг. Энэ арга нь дараах сул талуудтай:	
- Тухайн оны гүйцэтгэл гарах боломжгүй, мэдээлэл сүүлд нь ирдэг. Агентлагаас хэрэгжүүлэх нөөц, зардал өндөр. - Хөрөнгө оруулалт хийгдсэн тул зарим компани хамтран ажиллах сонирхолгүй байдаг.	
2.	Албан ёсны мэдээллээр давхар баталгаажуулах
Энэ нь албан ёсны статистик мэдээлэлтэй тулгах, бусад төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж мэдээллийг баталгаажуулдаг. Бусад яамд болон салбарын статистик мэдээтэй тулгаж хяналт хийдэг.	
3.	Түүврийн аргаар шалгах
Олон зуун үйлчлүүлэгчтэй Хөрөнгө оруулалтын агентлагийн хувьд дээрх хоёр арга нь зардал, цаг хугацаа ихээр шаарддаг тул түүврийн аргаар өгөгдлийн чанарыг шалгадаг. Ингэхдээ санамсаргүйгээр сонгосон дэд бүлгийн үзүүлэлтүүдийг судалж, бодит дүн ба төсөөллийн зөрүүг тооцдог. Энэ аргыг хэрэгжүүлэхдээ компанийн хэмжээ, хөрөнгө оруулалтын нөлөөг үндэслэн жинлэх нь зүйтэй.	
Жишээ нь: Жижиг ААН-ийн хувьд ажилчдын тоо илүү хэлбэлзэл өндөртэй байдаг тул хазайлт өндөр байх магадлалтай.	

Дүгнэлт

Өнөө үед дэлхий нийтээрээ тодорхойгүй байдалтай тулгарч, шинэчлэл шаардсан нөхцөл байдалд байна.

Гадаадын хөрөнгө оруулагчид шинэ технологи, шинэ мэдлэг дамжуулснаар энэ нөхцөл байдлыг амжилттай давахад хувь нэмрээ оруулдаг.

Зөв хөрөнгө оруулагчдыг татах, тогтвортой хөгжлийг урагшлуулахын тулд Хөрөнгө оруулалтыг дэмжих агентлагууд өөрсдийн стратегид шинжилгээ хийж, үйл ажиллагаагаа сайжруулах шаардлагатай. Үүний тулд гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт / KPI-д суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог нэвтрүүлэх нь чухал юм.

Энэ тайланд бусад улс орнуудын Хөрөнгө оруулалтыг дэмжих агентлагийн ашигладаг хамгийн түгээмлээс эхлээд хамгийн ховор хэрэглэгддэг бүх гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтүүдийг нэгтгэн танилцууллаа.

Дэлхийд үйл ажиллагаагаараа тэргүүлэгч агентлагууд KPI-д суурилсан тогтолцоогоор төлөвлөж, үнэлж, тайлагнадаг бөгөөд ингэснээр оновчтой стратегийн шийдвэр гаргаж, нөөцийг үр дүнтэй зөв хуваарилан, үйл ажиллагааны үр нөлөөг бодитоор хэмжиж чадаж байна.

Санал, зөвлөмж

- Хөрөнгө оруулалтыг дэмжих агентлаг одоогийн гүйцэтгэлийн үнэлгээний тогтолцоог сайжруулахын тулд KPI-д суурилсан тогтолцоог нэвтрүүлэх
- Гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтүүдийг CREAM шалгуураар үнэлж, сайжруулах
 - Байгууллагын зорилго, зорилтуудад уялдуулах
 - Тэргүүлэх чиглэлийг тогтоож үйл ажиллагааг уялдуулах
- Бусад төрийн байгууллагатай хамтран ажиллаж, мэдээлэл солилцох
 - Мэдээллийн нууцлалыг хадгалах
 - Судалгааны хэлтсүүд хамтарсан судалгаа хийх
- Албан ёсны мэдээлэл авах боломжгүй бол ААН-үүдээс судалгаа, санал асуулга авах
- Тогтвортой байдал, хөрөнгө оруулалтын чанарын үзүүлэлтүүдийг KPI-д оруулах
- Гүйцэтгэлийн үр дүнг тогтмол мэдээлж, олон нийтэд түгээх
 - ГШХО-ын нөлөө болон Хөрөнгө оруулалтыг дэмжих агентлагийн үйл ажиллагааны үнэ цэнийг оролцогч талуудад сурталчлах
- Гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтүүдийг харуулах хяналтын самбар /dashboard/ хөгжүүлж, стратегийн шийдвэр гаргалтад ашиглах



Д.ОЮУНБАТ

ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Мэргэжилтэн

“ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛ”- ИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



“ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛ”-ийн ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 104 дүгээр тогтоолоор Эдийн засгийн хөгжлийн зөвлөлийг шинэчлэн байгуулсан. Зөвлөл нь бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, эдийн засгийн төрөлжсөн болон тогтвортой өсөлтийг хангах зорилгоор нотолгоонд суурилсан бодлогын зөвлөмж боловсруулж, төр-хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх гүүр болон ажиллаж байна.

Зөвлөл дараах үндсэн асуудлын хүрээнд бодлогын зөвлөмж гаргах чиг үүрэгтэй. Үүнд:

- Макро эдийн засгийн тогтвортой орчин бүрдүүлэх, эдийн засгийн хөгжилд тулгарч байгаа болон цаашид үүсэж болох дотоод, гадаад эрсдэлт хүчин зүйл, түүнээс урьдчилан сэргийлэх арга замын талаар;
- Монгол Улсын эдийн засгийн бүтэц, өрсөлдөх чадвар, тэдгээрийн давуу талуудыг хөгжлийн гол хүчин зүйл болгон ашиглах боломжийн талаар;
- Дотоодын зах зээл, бизнесийн орчин болон олон улсад хөгжиж байгаа эдийн засгийн шинэ салбар, үйлдвэрлэл, технологи, тэдгээрийг нэвтрүүлэх боломжийн талаар;

- Эдийн засгийн салбарын бүтээмжийг нэмэгдүүлэх талаар;
- Экспортыг нэмэгдүүлэх, гадаад худалдааны бодлогын талаар;
- Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг тогтвортой дэмжих томоохон төсөл, хөтөлбөрийг үр дүнтэй, үр ашигтай хэрэгжүүлэх чиглэлээр авах арга хэмжээний талаар;
- Бизнесийн болон хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, олон улсын бизнесийн сайн туршлагыг нэвтрүүлэх чиглэлээр авах арга хэмжээний талаар;
- Хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй үзүүлэх, үйл ажиллагаанд нь учирч байгаа хүндрэл, бэрхшээлийг шийдвэрлэх, төр, хувийн хэвшлийн түншлэл, бизнес хөгжлийг дэмжих арга хэмжээний талаар;
- Төсөв, санхүү, эдийн засгийн бодлогын төлөвлөлтийг сайжруулах, түүний тайлагналт, ил тод байдлыг хангах, олон нийтийн хяналтыг сайжруулах талаар.

“Эдийн засгийн хөгжлийн зөвлөл”-ийг Монгол Улсын Ерөнхий сайд ахалдаг бөгөөд бүрэлдэхүүнд дараах гишүүд багтдаг:

2	Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд
3	Монгол Улсын Улсын Шадар сайд (Бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал хариуцсан)
4	Монгол Улсын Шадар сайд (Гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан)
5	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
6	Сангийн сайд
7	Хууль зүй, дотоод хэргийн сайд
8	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд
9	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд
10	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
11	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
12	Монгол банкны Ерөнхийлөгч
13	Санхүүгийн зохицуулах хорооны дарга
14	Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Ерөнхийлөгч
15	Монгол Улсын Ерөнхий сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга
16	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх
17	Хөрөнгө оруулалт, худалдааны газрын дарга
18	Гадаад харилцааны яамны Олон улсын худалдаа, эдийн засгийн хэлтсийн дарга
19	Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Ерөнхийлөгч
20	Улаанбаатар хотын Худалдааны танхимын Ерөнхийлөгч
21	Америкийн худалдааны танхимын Гүйцэтгэх захирал
22	Монголын бизнесийн зөвлөлийн ТУЗ-ийн дарга
23	Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн Ерөнхийлөгч
24	Монголын банкны холбооны Гүйцэтгэх захирал

25	Монголын ноос, ноолуурын холбооны Гүйцэтгэх захирал
26	Монголын аялал жуулчлалын мэргэжлийн холбооны Ерөнхийлөгч
27	Монголын барилгын үндэсний ассоциацийн Ерөнхийлөгч
28	"Цагаан алт" ТББ-ын Гүйцэтгэх захирал
29	"Хүнсний хувьсгал" ТББ-ын Гүйцэтгэх захирал
30	Монгол Улсын Их сургуулийн Бизнесийн сургуулийн захирал
31	Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Менежментийн сургуулийн захирал
32	Санхүү, эдийн засгийн их сургуулийн Ахисан түвшний сургуулийн профессор
33	Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал
34	"М-Си-Эс Холдинг" ХХК-ийн Ерөнхий захирал
35	"Шүнхлай Холдинг" ХХК-ийн Ерөнхийлөгч
36	"Монголын алт" ХХК-ийн Ерөнхийлөгч
37	"Монос групп" ХХК-ийн Гүйцэтгэх захирал
38	"Ньюком" группийн Ерөнхий захирал
39	"Макс" группийн Ерөнхийлөгч
40	"Номин холдинг" ХХК-ийн ТУЗ-ийн дарга
41	Монголын жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээний холбооны Гүйцэтгэх захирал
42	Монголын тээвэр зуучлагчдын нэгдсэн холбооны УЗ-ийн дарга
43	Рио Тинто компанийн Монголыг хариуцсан захирал
44	"Юрика" ХХК-ийн Гүйцэтгэх захирал
45	Монголын шинэ эдийн засгийн форум НҮТББ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга
46	Эдийн засгийн хөгжлийн зөвлөлийн Ажлын албаны дарга

“Эдийн засгийн хөгжлийн төв” УТҮГ үндсэн чиг үүрэг үйл ажиллагааны чиглэл

- Эдийн засгийн хөгжлийн төв нь Эдийн засгийн хөгжлийн зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг хавсран гүйцэтгэн ажилладаг бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэн хөгжүүлэхэд чиглэсэн мэргэжлийн судалгаа, шинжилгээ хийх, салбарын оролцогчдын үйл ажиллагааны уялдааг ханган дэмжлэг үзүүлэх үндсэн үүрэгтэй. Судалгаа, шинжилгээ хийх болон хэрэгжүүлэх үйл ажиллагааны гол чиглэлүүд:
- Хөгжлийн урт болон дунд хугацааны бодлогын зорилтуудтай уялдуулан улс орны өрсөлдөх чадвар, давуу тал, тодорхой салбар, бизнест ээлтэй хөрөнгө оруулалтын орчны талаар;
 - Олон улсад шинээр хөгжиж байгаа эдийн засгийн үйл ажиллагааны шинэ салбар, үйлдвэрлэл, технологи, тэдгээрийг дотоодын зах зээл, бизнесийн орчинд нутагшуулах боломжийн талаар;
 - Эдийн засгийн салбарын бүтээмж, экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээний талаар;
 - Төсөв, санхүү, эдийн засгийн бодлогын төлөвлөлтийг сайжруулах, эдийн засгийн хөгжилд тулгарч болох эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар;

- Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын тэргүүлэх салбар, хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг эрэмбэлэх, эдийн засгийг дэмжих томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний талаар;
- Эдийн засгийн хөгжлийн зөвлөлийн хуралдааныг зохион байгуулах, шийдвэрийг албажуулах, гарсан зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлэхтэй холбоотой асуудлуудыг зохион байгуулах;
- Дотоод гадаадын томоохон аж ахуйн нэгж болон шинэ хөрөнгө оруулагчид үйл ажиллагаагаа эхлүүлэх, бизнесээ өргөжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх чиглэлээр бусад байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах, хамтарсан уулзалт зохион байгуулах;
- Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр төрийн болон холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулж, мэргэжлийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх;
- Шинэ сэргэлтийн бодлого, хөтөлбөрийн хөгжлийн төслүүдэд судалгаа, дүн шинжилгээ хийж, оролцогч тал болон холбогдох бусад байгууллагуудын тайлан, мэдээг нэгтгэх, мэдээллийн сан бүрдүүлэх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж ажиллана.

“Эдийн засгийн хөгжлийн зөвлөл”-ийн 2025 оны хуралдаанаар хэлэлцсэн асуудлууд

№	ЭЗХЗ-ИЙН II ХУРАЛДААН 2025.02.18
	ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ
1	Дэлхийн эдийн засгийн 55 дахь удаагийн чуулга уулзалт Монгол Улсын Шадар сайд (Гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн) танилцуулга хийсэн. Дэлхийн эдийн засгийн форумд Монгол Улсын ЗГ-ын төлөөлөл, хувийн хэвшлүүд амжилттай оролцсон. Анх удаа Mongolia House 2025-ыг хувийн хэвшилтэй хамтран зохион байгуулж, бизнес, хөрөнгө оруулалтыг сурталчилсан. ДЭЗФ-д оролцон 3 төрлийн хамтын ажиллагаанд гарын үсэг зурсан. Үүнд: 1. Strategic intelligence platform-оос мэдээллийг авч ашиглах; 2. Салхины батареи хураагууртай төсөл хэрэгжүүлэх; 3. Европын сэргээн босголт, хөгжлийн банкаас 1 тэрбум хүртэлх долларын зээл авах.
2	Бизнес эрхлэх орчны үнэлгээ Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга танилцуулга хийсэн. Дэлхийн өв уламжлалын сангаас гардаг эдийн засгийн эрх чөлөөний индексээр Монгол Улс 190 орноос 81 дүгээр байрт орсон байгаа нь Бизнес эхлүүлэх хууль эрх зүйн таатай орчин бүрдүүлэх, хувийн хэвшил болон төрийн байгууллагуудын хамтын ажиллагааны тэнцвэрийг олох хэрэгтэй байгаа талаар танилцуулав. Уг асуудлын хүрээнд ЭЗХЗ-ийн ажлын албанаас бизнес эрхлэх орчны талаарх гадаад болон дотоодын үнэлгээ, индексийн үзүүлэлтүүд, Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн хэрэгцээ шаардлагын талаар судалгаа боловсруулж Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн.
3	Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилт, асуудал, нэгдсэн систем Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга танилцуулга хийсэн. Зөвшөөрлийн тухай хууль 2022 онд шинэчлэн найруулга батлагдсан нь олон нийтэд сайшаагдаж тодорхой хэмжээнд хүнд суртал, чирэгдлийг багасгасан талаар дурдсан. Гэвч өнгөрсөн хугацаанд 18 төрлийн зөвшөөрөл шинээр нэмэгдсэн бөгөөд 11 хүний бүрэлдэхүүнтэй зөвшөөрлийн зөвлөл ажилдаг бөгөөд түүний бүрэлдэхүүнд хувийн хэвшил давамгайлдаг. Энэхүү зөвлөл нь зөвшөөрлийг батлах эсэхийг шийдвэрлэдэг боловч зөвлөлөөс давж шинээр зөвшөөрөл нэмэгдсээр байна. Зөвшөөрлийн зөвлөл нийт 361 зөвшөөрөл үүнээс 251 тусгай, 130 энгийн зөвшөөрлийг хуралдаж шийдвэрлэсэн. Зөвшөөрлийн хууль яагаад бүрэн хэрэгжихгүй байгаа талаар 2 жил судалж хуульд үнэлгээ хийлгэхэд 100-с бага шат дамжлага дамжиж байгаа зөвшөөрөл бараг байхгүй байгааг харуулсан. Иймд: Хууль, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах шаардлагатай байгаа бөгөөд зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар ажиллаж байна.
4	Татварын хуулийн шинэчлэлийн талаар хувийн хэвшилээс гаргасан санал Улаанбаатар хотын Худалдааны танхимын гүйцэтгэх захирал танилцуулга хийсэн. Татварын хуулийн шинэчлэлтэй холбогдуулан хувийн хэвшил, мэргэжлийн холбоод зэрэг 600 орчим байгууллагын 200 гаруй санал ирсэн. Эцсийн үр дүнд татвар төлөгчдөд ойлгомжтой, давхардалгүй, нээлттэй, тэгш хамрагдалттай, тодорхой байх ёстой гэсэн зарчим дэвшүүлсэн. Хувийн хэвшлийн төлөөлөл дээрх зарчмын хүрээнд 5 зорилго дэвшүүлж хуулийн шинэчлэлд тусгуулах санал гаргасан. Үүнд: • Хувийн хэвшлийг татварын бодлогоор дэмжих замаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх; • Ажлын байр нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих; • Дотоодын ААН хоорондын өрсөлдөх чадварыг сайжруулах, татварын шударга орчныг бий болгох, давхардсан процессыг багасгаж, нэмэлт зардлыг бууруулах; • Далд эдийн засгийг ил болгож, татвар төлөгчдийг тэгш хамруулах; • Эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг хөгжүүлэх татварын бодлогыг хэрэгжүүлэх.
5	Эдийн засгийн бодлогын зөвлөлийг - Эдийн засгийн хөгжлийн зөвлөл болгон өөрчлөн байгуулах Тони Блэйр Институтийн зөвлөхүүд танилцуулга хийсэн. Төр, хувийн хэвшлийн төлөөлөл хэрхэн үр дүнтэй хамтран ажиллах болон бусад улсын ЭЗХЗ-ийн сайн туршлага, бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны хэлбэр, цар хүрээний талаар танилцуулсан.
№	ЭЗХЗ-ИЙН III ХУРАЛДААН 2025.03.24
1.	Татварын хуулийн шинэчлэлийн талаар Сангийн сайд танилцуулга хийсэн. Татварын хуулийн шинэчлэлийг 2025.04.11-ээс хойш УИХ-д танилцуулахаар төлөвлөж байгаа бөгөөд олон нийтийн хэлэлцүүлгүүд хийж санал авах үе шатандаа явж байгаа талаар дурдсан. Энэ удаагийн татварын шинэчлэл нь эдийн засгийн солонгорол бий болгох шаталсан татварын тогтолцоо руу шилжих бодлого баримталж байгаа. Үүнд: • Татварын шаталсан тогтолцоог шинэчилнэ; • Өрхийн орлогыг хамгаална; • Бизнес эрхлэхэд нэмэлт ачаалал үүсгэхгүй, бүх нийтээр төлдөг болно; • Татварын байгууллагын хандлагыг захиргааны төлөвөөс үйлчилгээний төлөвт шилжүүлэх, үүнийг хуульчилж үүрэг болгон өгч байна; • Бүсчилсэн хөгжлийн бодлогоо татварын бодлоготой уяна. Шинэчлэлийн үр дүн: • Хөрөнгө оруулагч ирэхээс нь өмнө зөвлөн тусалдаг, судалгааг нь хийж өгдөг, сэргийлдэг болно; • Эдийн засаг солонгорх бизнес тэлж, татварын бааз суурь нэмэгдэнэ; • 1 сая төгрөг хүртэлх орлоготой иргэн 56 хувийн хөнгөлөлт эдэлнэ; • 3 сая хүртэлх орлоготой иргэд 28 хувийн хөнгөлөлт, 3-аас дээш орлоготой хэсэг 16 хувийн хөнгөлөлт эдлэх боломж бүрдэнэ.

2.	Эдийн засгийн хөгжлийн зөвлөлийн ажлын алба Эдийн засгийн хөгжлийн зөвлөлийн ажлын албаны дарга танилцуулга хийсэн. Гадаадын хөрөнгө оруулагчдад зориулсан бодит мэдээлэл бүхий гарын авлага, боловсруулах зорилгоор ажлын хэсэг байгуулан ажиллаж байгаа талаар танилцуулсан. Ажлын хэсгийн зорилго нь: - Гадаадын хөрөнгө оруулагч нартай элчин сайд, дипломат төлөөлөгчийн газрууд хамгийн ойр ажилладаг тул гадаадын хөрөнгө оруулалт татах боломжтой тэргүүлэх салбарын шаардлагатай бүх мэдээллийг багтаасан гарын авлага бэлтгэх; - Төрийн албан ёсны томоохон гадаад айлчлалын үеэр хөрөнгө оруулалт татахад чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөө, сурталчилгааны материал зэргийг хамтран боловсруулж нэгдсэн санал бэлтгэх, гадагшаа нэг мессеж цацах.
3.	Нийгмийн даатгалын тухай хуулийн шинэчлэл Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд танилцуулга хийсэн. Монгол Улсын Нийгмийн даатгалын шимтгэлийн тогтолцоо 1995 оноос эхлэлтэй. Хуваарилалтын тогтолцоо өнөөг хүртэл үргэлжилж байна. Анх 13,5 байсан шимтгэлийг 6,5 хувиар бууруулж, 7 хувь болгосон. Нийт шимтгэл 20-22 хувь, ажил олгогчийн төлж буй шимтгэл 17,7 хувь байгаа. Монгол хүний дундаж наслалт нэмэгдэж, хүн амд эзлэх ахмад настны тоо нэмэгдсээр байгаа. Нийгмийн даатгалын шинэчлэл хийх ёстой талаар танилцуулсан. Улс төрийн хувьд хамтарсан засгийн газрын үед шинэчлэл хийх хамгийн боломжтой үе таарч байгааг дурдаад НДШ-тэй холбоотой 21 багц санал ирсэн нь дараах агуулгатай. - Олон давхарт тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх; - Суурь тэтгэвэр, нэмэлт, хувийн тэтгэврийн тогтолцоотой болох; - Эрт тэтгэвэрт гарсан болон оюутны нийгмийн даатгалын хамрагдалтыг сайжруулах, хүний нөөцийн асуудлыг шийдэх боломжтой болно.

№	ЭЗХЗ-ИЙН IV ХУРАЛДААН 2025.04.21
1.	Дэлхийн эдийн засагт үүсээд буй нөхцөл байдлын эсрэг авах арга хэмжээ Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд танилцуулга хийсэн. Монгол Улс, БНХАУ-аас экспортын 94% хамааралтай байдаг бөгөөд одоогийн нөхцөл байдалд экспортын орлого өмнөх оноос 1 тэрбум ам.доллараар бага байгаа талаар танилцуулаад эдгээр сөрөг хүчин зүйлсийг бууруулах боломжуудыг судалж байгаа тухай дурдсан. Евро-Азийн чөлөөт худалдааны хэлэлцээрийн хувьд Евро-Азийн зах зээлд 375 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүнийг тарифгүйгээр нийлүүлэхээр яриа хэлэлцээ өрнөж байгаа. Монгол Улсын үндэсний бараа бүтээгдэхүүний өрсөлдөх чадварт сөрөг нөлөө үзүүлэх эсэх талаар тодруулж судалсан. Жишээ нь гурил, хүнсний ногоо, архи, пиво зэрэг 23 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнүүд сөрөг нөлөөлөлд өртөх магадлалтай, 8 нэр төрлийн барааг хасаж, 267 бүтээгдэхүүн дээр хэлэлцээр хийхээр төлөвлөж байгаа талаар танилцуулсан.
2.	Үндэсний баялгийн сангийн зорилго Сангийн яамны төрийн нарийн бичгийн дарга танилцуулга хийсэн. Үндэсний баялгийн сангаар орж ирж байгаа мөнгөн хуримтлалыг дараах 5 санд төвлөрүүлэн удирдаж байгааг танилцуулсан. Үүнд: - Тогтворжуулалтын сан: Зорилго гол нэр төрлийн уул уурхайн бүтээгдэхүүнээс шалтгаалсан орлогын тасалдлыг санхүүжүүлэх; - Ирээдүйн өв сан: 2030 он хүртэл зарцуулахгүй байхаар зохицуулагдсан; - Хуримтлалын сан: Иргэдийн боловсрол, эрүүл мэнд, орон сууцны хэрэгцээнд дэмжлэг үзүүлэх; - Хөгжлийн сан: Мега төслүүдийг санхүүжүүлэх; - Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан: Уул уурхайн орлогыг орон нутагт тэгш хуваарилах зорилготой талаар танилцуулав.
3.	Эрчим хүчний тухай хуулийн шинэчлэл Хувийн хэвшлийн төлөөлөл "Нью-Ком" группийн захирал танилцуулга хийсэн. Хуулийн шинэчлэлтэй холбоотой нийт 270 санал (хувийн хэвшил), МҮХАҮТ-ийн дэргэдэх Эрчим хүчний зөвлөл, Монголын бизнесийн зөвлөлөөс ирсэн. Эрчим хүчний төслийн сонгон шалгаруулалтыг аукционы журмаар хэрэгжүүлмээр байна. Монгол Улсыг Казахстан улстай харьцуулж судалснаа танилцуулав. Казахстан улсын аукцион (үнийн дуудлагын тогтолцоо)-ын журмыг Монгол улсын тендерийн үйл явцтай харьцуулбал: - Тендерийн үнэлгээний хороогүй учир улс төрийн нөлөөлөлд автахгүй; - Үнийн өрсөлдөөнийг дижитал, цахим системээр шалгаруулах тул түргэн, шуурхай, гаднын нөлөөнд автахгүй, гарсан шийдвэрийг шүүхэд өгч сонгон шалгаруулалтыг удаашруулахгүй, - Аукционд оролцогч санхүүгийн хангалттай баталгаа гаргадаг нь уг төслийн хэрэгжилтийг эрсдэлээс хамгаалдаг давуу талуудтай талаар дурдаад цаашид хэрэгжүүлэх боломж бүхий 12 саналыг шийдлийн хамтаар танилцуулсан.

№	ЭЗХЗ-ИЙН V ХУРАЛДААН 2025.05.05
1.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулга Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга танилцуулга хийсэн. 2023 онд батлагдсан худалдан авах ажиллагааны хууль нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, бараа ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, гэрээ байгуулах, тайлагнах, хяналт тавих, гомдол шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг. Энэ хууль 2023 он хүртэл үүргээ биелүүлсэн хэдий ч одоогийн Засгийн газрын хөтөлбөр, мега төслүүдийг хэрэгжүүлэхэд бүрэн хүчин төгөлдөр үйлчилж чадахгүй гэдэг дүгнэлт гарсан. Тиймээс: Худалдан авах ажиллагааны тухай хууль гэсэн нэршилтэйгээр танилцуулж байна. Өнөөдөр намын бүлэг, ЭЗХЗ-д танилцуулж байна. Үүний дараа Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх талаар танилцуулав.
2.	Монгол Улсын хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулга Монгол Улсын хөгжлийн банкны гүйцэтгэх захирал танилцуулга хийсэн. Хөгжлийн банкны тогтвортой байдлыг хангах үүднээс өөрийн хөрөнгө болон дүрмийн санг нэмэгдүүлэх шаардлага тулгамдаж байгаа. Энэ нь банкны эрсдэлийн удирдлагыг сайжруулах, зээл олголтын чадавхыг нэмэгдүүлэх суурь нөхцөл юм. Үүний хүрээнд дараах арга хэмжээг авах шаардлагатай байгаа талаар дурдав. Үүнд: • Эх үүсвэрийн бүтцийн шинэчлэл; • Хууль эрх зүйн шинэчлэл; • Активын чанар, зээлийн эрсдэл; • Санхүүжилтийн шинэ боломжууд; • Засаглалын шинэчлэл; • Эксим банк байгуулах асуудал; • Төсөл дэмжих бодлого; • Хувьцаа эзэмшигчийн хариуцлага.

№	ЭЗХЗ-ИЙН VI ХУРАЛДААН 2025.08.04
1.	Төр-хувийн хэвшилтэй зөвлөлдөх тогтолцоо Эдийн засгийн хөгжлийн зөвлөлийн ажлын албаны дарга танилцуулга хийсэн. Баялаг бүтээгчдийг дэмжих зорилготой Аж ахуйн үйл ажиллагааны эрх чөлөөний тухай хуулийн төслийг танилцуулсан. Уг хуулийн төслийг сайжруулан боловсруулах ажлын хүрээнд ЭЗХЯ-аас Эдийн засгийн эрх чөлөөний тухай анхдагч хуулийн төсөл болгон өөрчлөн найруулан олон нийтийн хэлэлцүүлэг хийсэн. ЭЗХЗ-ийн гишүүд, МҮХАҮТ болон бусад худалдааны танхимуудаас гаргасан саналыг хуулийн төсөлд тусгуулахаар ЭЗХЯ-нд хүргүүлсэн.

№	ЭЗХЗ-ИЙН VII ХУРАЛДААН 2025.08.12
1.	Татварын хуулийн шинэчлэлийн талаар Сангийн сайд танилцуулсан. Энэ удаагийн татварын шинэчлэлийг хамтдаа боловсруулж байна. Сүүлийн хагас жилийн хугацаанд олон нийтийн хэлэлцүүлгүүд хийсэн тухай дурдав. Дөрөв дэх удаагийн татварын шинэчлэлийг УИХ-тай хамтран илүү өргөн хүрээнд хийхээр ажиллаж байгаа. Татварын алдангийн хэмжээг 50-иас хэтрэхгүй байхаар зохицуулалтууд оруулсан. • 13.000 гаруй иргэн болон ААН-ээс нийт 176.000 санал ирсэн. Нийт ирүүлсэн саналын 33 хувь татвар бууруулах тухай санал байна. • Татвар төлөгч гомдол гарвал, хүндэтгэн үзэх шалтгааныг харгалзан татварын албадлагын аргыг зогсооно. Илүү уян хатан болж байгаа талаар тодотгосон. • Татварын хуулийн шинэчлэлийн хүрээнд худалдааны танхимууд, хувийн хэвшлийн төлөөллөөс хуулийн төсөлд тусгахаар ирүүлсэн нийт саналын 52% нь хуулийн төсөлд тусгагдсан бөгөөд нэн чухал 21 саналаас 12 саналыг хуулийн төсөлд тусгасан талаар танилцуулсан.

№	ЭЗХЗ-ИЙН VIII ХУРАЛДААН 2025.12.05
1.	Эдийн засгийн эрх чөлөөний тухай багц хуулийн төсөл Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд танилцуулга хийсэн. Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлсэн “Шинэ итгэл-Эрс шинэчлэл” цогц реформын хүрээнд бизнесийн орчны хууль тогтоомжийг боловсронгуй болгохоор ажиллаж байна. Эдийн засгийн эрх чөлөөний тухай анхдагч хуулийн төсөл боловсруулж дагалдах Хөрөнгө оруулалт, Зөвшөөрлийн тухай болон бусад 100 гаруй хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. Тухайн хуулийн төслийг https://legalinfo.mn/ сайтад 2025.09.15-ны өдрөөс эхлэн 60 хоногийн турш байршуулж, санал авч ажилласан талаар дурдав. Хуулийн төсөлд эцсийн байдлаар санал авч тусгаад УИХ-ын хаврын чуулганаар хэлэлцүүлэхээр төлөвлөж байгаа талаар танилцуулав. Хуулийн төслийн талаар хувийн хэвшлийн санал Улаанбаатар хотын Худалдааны танхимын гүйцэтгэх захирал танилцуулга хийсэн. Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн дагалдах хуулиудад холбоотой 20 гаруй саналыг нэгтгэн танилцуулъя. Хуулийн төсөлд өгсөн саналуудыг нэгтгээд харвал, эдийн засгийн эрх чөлөөг яаж хангах вэ, яагаад хумигдаад байгаа вэ гэдэгт дүн шинжилгээ хийж саналууд бэлтгэсэн. Үүнд: • Хувийн хэвшлийн хийж чадах аж ахуйн үйл ажиллагаануудад төр оролцох, төрийн өмчит компаниар дамжуулан оролцох оролцоог хориглох нь бизнес дэх төрийн оролцоо багасгахад чухал нөлөөтэй; • Төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлж буй албан тушаалтан нь хуульчлан заагаагүй нөхцөлд удирдамжгүй хяналт шалгалт хэрэгжүүлэх, хяналт хийх албан тушаалтан хуульд заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд аж ахуй эрхлэгч нь татгалзах эрхтэй байна; • Хувийн хэвшилд төрөөс учруулсан хохирлыг хэрхэн үнэлж, барагдуулах талаар тодруулга оруулах шаардлагатай байгаа талаар дурдав.

**“Эдийн засгийн хөгжлийн зөвлөл”-ийн хуралдаанаар
2026 онд хэлэлцүүлэхээр санал болгож буй асуудлууд**

№	САЛБАР ХУРАЛДААНЫ ЧИГЛЭЛ	ТАНИЛЦУУЛАХ СЭДЭВ
1	ЭЗХЗ-ИЙН ХУРЛААС ГАРСАН ЗӨВЛӨМЖИЙН ДАГУУ	Төрийн өмчит компанийн үйл ажиллагааны талаар авах арга хэмжээний саналыг танилцуулах
2	УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ТУЛГАМДСАН АСУУДЛЫН ХҮРЭЭНД	Эрдэс баялгийн салбарт тулгамдаж буй асуудал болон Ашигт малтмалын тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн танилцуулга
3		Үндэсний баялгийн сангийн тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн танилцуулга
4	ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИНЭЧЛЭЛИЙН ХҮРЭЭНД	Эрчим хүчний реформ: Эрчим хүчний тухай хууль, Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар хувийн хэвшлийн өгсөн саналын хэрхэн тусгасан талаар
5	ХӨДӨӨ, АЖ АХУЙН ӨСӨЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ХҮРЭЭНД	Ноолуурын салбарын экспортын замын зураглал, бодлогын дэмжлэгийн талаар
6		Үндэсний баялгийн сангийн тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн танилцуулга
7		Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн хуульд нэмэлт өөрчлөлт орж байгаатай холбогдуулан танилцуулга хийх
8	ЭДИЙН ЗАСГИЙН ТӨРӨЛЖИЛТ, ЭКСПОРТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН НӨЛӨӨЛЛИЙН ХҮРЭЭНД	Нийгэм-эдийн засгийн томоохон төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалт, худалдан авалтыг эрэмбэлэх аргагүй, журмын талаар
9		Бүс нутгийг кластераар хөгжүүлэх, хот хөдөөгийн тэнцвэртэй хөгжлийг хангах, эдийн засгийг солонгоруулах стратеги бодлогын талаар
10		Хотын түгжрэл, утаа, орон сууцжуулалт, нийтийн тээврийг хөгжүүлэх оновчтой шийдлийн талаар
11		Эдийн засгийн салбарын өсөлт, гадаад дотоод орчны өөрчлөлт, техник технологи, мэдээллийн технологийн хувьсал өөрчлөлтөд нийцэх ажиллах хүчнийг бэлтгэхэд дээд боловсрол болон мэргэжлийн боловсролын тогтолцоог шинэчлэх мэргэжлийн боловсролд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, гаднаас ажиллах хүч авах үйл явцыг хялбаршуулж, зардлыг бууруулах талаар
12		Хөгжлийн банкны тухай хуулийн төслийн талаар хэлэлцэх
13		Дижитал шилжилт, цахим хөгжил, хиймэл оюун ухаан хөгжүүлэх стартапуудыг дэмжих бодлого, эрх зүйн нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх тухай
14		Экспортыг дэмжих нэгдсэн бодлогын талаар
15	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ ХҮРЭЭНД	Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаар
16		Гадаадын хөрөнгө оруулалтыг татах Хамтын ажиллагааны төлөвлөгөөний талаар
17		Татварын багц хуулийн талаар хэлэлцэх
18		Зөвшөөрлийн тухай хуулийн талаар
19		Нийгмийн даатгалын багц хуулийн талаар
20		Газрын харилцаа: Газар эзэмших, ашиглахад хувийн хэвшил, хөрөнгө оруулагчдад тулгамдаж буй асуудлын талаар
21		Гэрээний эрх зүйн харилцаанд тулгамдаж буй асуудал: хэрэгжилт, маргаан шийдвэрлэж буй практик асуудлуудын талаар
22	ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ХҮРЭЭНД	Банкны тухай хуулийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудлын талаар
23		Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн талаар
24		Төрийн тусгай сангуудын үйл ажиллагаа ба хөндлөнгийн хяналтын тухай
25	БУСАД СЭДВИЙН ХҮРЭЭНД	Төрийн зарим чиг үүргийн ТББ-аар гүйцэтгүүлэх асуудлын талаар
26		Шинжлэх ухааны менежментийг сайжруулах арга замын талаар
27		Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн үзэл баримтлалын талаар

АЛСЫН ХАРАА
2050
МОНГОЛ УЛС

ЭЗХТ Бизнес
Ээлтэй
Монгол

Эдийн засгийн хөгжлийн төв
Mongolia Economic
Development Board EDB

Хаяг:
Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг
Нэгдсэн үндэстний гудамж –
Засгийн газрын 2 дугаар байр

Утас: 70116838
Facebook: EDB- Mongolia.mn